

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

“ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ СЕКТОР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ, 2022

ННА 72
ДАА 001.4
П-183

“Парламент” судалгааны эмхэтгэл (XXXVI боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны
хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл
Ц.Оргилмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш



УИХ-ын Тамгын газар ©
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - XXXVI БОТЬ

ISBN 978-9919-9618-8-6

ГАРЧИГ

БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

1.1	Экспортыг дэмжих гадаад худалдааны бодлого, эрх зүйн орчин: Бусад орнуудын туршлага (СТ-21/226)	6
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл, Д.Халиун, И.Жаргалзаяабямба</i>	
1.2	Франчайзингийн гэрээний эрх зүйн зохицуулалт: Бусад орнуудын туршлага (СТ-21/227)	44
	<i>Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй, Д.Амаржаргал (Ph.D), Б.Туул, П.Уранчимэг</i>	
1.3	Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх бодлого, арга хэмжээ: Бусад орнуудын туршлага (СТ-21/229)	91
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Д.Амаржаргал (Ph.D), Д.Аюуш, Б.Батцэцэг, Ш.Батцэнгэл, О.Билгүүтэй, С.Золжаргал, Р.Оргилмаа, Б.Туул, Д.Халиун</i>	
1.4	Парламентын төсөв санхүүгийн хяналт: Олон улсын туршлага (СТ-21/246)	182
	<i>Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй, Ч.Сарантуяа, Д.Отгонбаатар, С.Төрмөнх</i>	
1.5	Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх эдийн засгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (СТ-21/249)	223
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Г.Оюун-Эрдэнэ</i>	
1.6	Улсын төсвийн тухай хуулийн төсөл хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, ядуурлыг бууруулахад чиглэсэн эсэх шалгуур үзүүлэлтийг шалгах хуудас боловсруулах судалгаа (СТ-21/250)	232
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл, Д.Халиун, М.Солонго</i>	
1.7	Хууль, тогтоомжийн төслийн зардал, үр нөлөөг шинжлэх арга зүй, олон улсын туршлага (СТ-21/251)	269
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл, Р.Нургүл, И.Жаргалзаяабямба, Д.Гэрэлт-Од</i>	

1.8	Монгол Улс дахь уул уурхайн зам, тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, түүний эдийн засагт үзүүлэх нөлөө, үр ашиг (СТ-21/504).....	300
------------	---	------------

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл, Д.Халиун,
Р.Нургэл, И.Жаргалзаяабямба*

1.9	Цар тахлын Монгол Улсын макро эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлсэн нөлөөлөл ба алдагдсан боломжийн зардал (СТ-21/505).....	373
------------	--	------------

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл,
Д.Халиун, О.Билгүүтэй*



ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ АГУУЛГА

- Эдийн засаг
- Гадаад худалдаа
- Франчайзинг
- Ковид-19
- Санхүү, хяналт

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН:
БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл,
Д.Халиун, И.Жаргалзаяабямба*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг.МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГҮҮДИЙН ТАЛААР

- 1.1.Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд гадаад худалдааны чиглэлээр тусгасан зорилт, арга хэмжээнүүд
- 1.2.Засгийн газрын хөтөлбөрүүд
- 1.3.Монгол Улс ба Дэлхийн худалдааны байгууллага
- 1.4.Эдийн засгийн хамтын ажиллагаа

Хоёр.ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭКСПОРТОД ЧИГЛЭСЭН ГАДААД ХУДАЛДААНЫ
БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

- 2.1.1.Эрх зүйн зохицуулалт, хуулийн бүтэц, агуулга
- 2.1.2.Хуулийн онцлох зохицуулалтууд ба түүнийг хэрэгжүүлэх институционал тогтолцоо
- 2.1.3.Экспортыг дэмжих бүтэц зохион байгуулалт, экспортод чиглэсэн бодлого

2.2.БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС


- 2.2.1.Эрх зүйн зохицуулалт
- 2.2.3.Экспортыг дэмжихэд чиглэсэн бодлого, бүтэц зохион байгуулалт

2.3.БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС

- 2.3.1.Эрх зүйн зохицуулалт
- 2.3.2.Экспортыг дэмжихэд чиглэсэн бодлого, бүтэц зохион байгуулалт

ХАВСРАЛТ.МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ КОНВЕНЦ
БОЛОН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад худалдааны асуудлыг тусгасан байдал
 Хүснэгт 2. Гадаад худалдааны асуудлыг төсөл хөтөлбөрүүдэд тусгасан байдал, тэдгээрийн хэрэгжилт
 Хүснэгт 3. Гадаадын зарим улсын худалдаатай холбоотой тойм мэдээ
 Хүснэгт 4. Холбооны Худалдааны хороо, экспортын худалдаанд чиглэгдсэн дэмжлэг, шударга бус өрсөлдөөний арга хэлбэрээс сэргийлэх тухай
 Хүснэгт 5. Экспортыг дэмжих
 Хүснэгт 6. Экспортыг эрчимжүүлэх
 Хүснэгт 7. Зарим ЕХ-ны гишүүн орны экспортод чиглэсэн бодлого, институц
 Хүснэгт 8. БНСВУ-ын Гадаад худалдааны удирдлагын тухай хуулийн бүтэц, агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНДХХ	Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНУХТГ	АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДАБЯ	АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЕХ	Европын холбоо
ЕЧХХ	Европын эдийн засгийн бүсийн Европын чөлөөт худалдааны холбоо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
ОУХК	АНУ-ын Олон улсын худалдааны комисс
ОХУ	Оросын Холбооны Улс
ПХОХА	Польшийн хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
ТХЕХ	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЕС	АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий систем
ШТС	Шатахуун түгээх станц
ШХАБ	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
ЭЗОБ	Эдийн засгийн онцгой бүс
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Экспортыг дэмжих гадаад худалдааны бодлого, эрх зүйн орчин: Бусад орнуудын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэлээ. Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс зэрэг гадаад худалдааны сайн туршлагатай орнууд болон Монгол Улсыг хамруулж, экспортыг дэмжих бодлого, эрх зүйн орчин, институцийн тогтолцоо зэргийг судлав.

Түлхүүр үг: *Экспорт, экспортын дэмжлэг, гадаад худалдаа*

Keywords: *Export, export promotion, foreign trade*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Өнөөдөр Монгол Улсад гадаад худалдааны асуудлыг зохицуулах тусгайлсан хууль байхгүй. Харин гадаад худалдаанд хамааралтай зарим асуудлыг холбогдох зарим хуулиар зохицуулж байна. Мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, гадаад орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүд, Монгол Улсын бодлогын баримт бичгүүд гадаад худалдааны хууль эрх зүйн орчинг бүрдүүлдэг.

Эрх зүйн зохицуулалтын гол зорилго, агуулга нь экспортын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, уул уурхайн бус, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг өсгөх, гадаад худалдааг хялбаршуулах, цахим худалдааг хөгжүүлэх, боловсруулалт хийсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, тээвэр логистикийн дэд бүтцийн хөгжлийг хангах зэрэгт чиглэгдэж байна.

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад (ДХБ)-д гишүүнээр элссэнээр тус байгууллагын гишүүн орнуудтай нэн тааламжтай нөхцөлөөр буюу тарифын хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр худалдаа хийх боломж бүрдсэн. ДХБ-ын гишүүн орнуудын энэхүү хөнгөлөлт таатай нөхцөлийн үр дүнд улс орнууд экспортоо нэмэгдүүлэх, олон төрлийн бараанаас сонголт хийх, үндэсний бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг эерэг таатай олон боломжийг олж авдаг.

2020 оны байдлаар Монгол Улсын экспортын бүтцэд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт давамгайлсан буюу нийт экспортын 80 орчим хувийг эзэлсэн хэвээр байна. Түүнчлэн 2018 онд Монголбанкны гаргасан “Монгол Улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд” тайланд Монгол Улсад хэрэгжүүлж буй гадаад худалдааны бодлого төдийлөн оновчтой биш, төсөл, хөтөлбөрийн боловсруулалт хангалтгүй, хэрэгжүүлэх арга механизм, хэрэгжилтийг хариуцах газар, эзэн тодорхойгүй, шат шатны төр, захиргааны байгууллагуудын уялдаа холбоо сул, экспортын бараа, үйлчилгээний үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа хэт ерөнхий байгаа нь энэхүү нөхцөл байдлыг бий болгоход нөлөөлсөн хэмээн дүгнэжээ.

Иймд Монгол Улсад жишиг болохуйц сайн туршлагатай, эдийн засгийн цогц байдлын индекс (Economic complexity index: тухайн улсын үйлдвэрлэлийн бүтээмжийн чадварыг харуулдаг) өндөртэй, гадаад худалдааны хэмжээгээрээ дэлхийд дээгүүрт ордог, экспортыг амжилттай хөгжүүлсэн Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам зэрэг орнуудын зарим онцлох туршлагуудыг харьцуулан судалсан болно.

Нийтлэг байдлаар авч үзвэл, судалгаанд авагдсан орнуудад бүгдэд нь худалдаа, ялангуяа гадаад худалдаа хариуцсан бие даасан яам, агентлагууд ажиллаж байгаа бөгөөд институцийн тогтолцоогоор дамжуулан экспортыг санхүүжүүлэх гэх мэт гадаад худалдааг дэмжих олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хууль эрх зүйн орчны хувьд судалгаанд авагдсан орнууд худалдаатай холбоотой асуудлыг дараах байдлаар зохицуулж байна.

- **АНУ-д:** Үндсэн хуулиар Конгресс худалдааны асуудлаар хууль тогтоох, тариф ногдуулах, гадаад худалдааны бодлого тодорхойлох онцгой бүрэн эрхтэй байна. Муж улс доторх худалдааг муж улсууд өөрсдөө зохицуулдаг. Экспортыг дэмжихэд чиглэсэн багц хуулиудтай.
- **БНПУ-д:** худалдааны асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй. Тус улсад зөвшөөрөгдсөн бизнесийн хэлбэрийг 2000 онд баталсан Худалдааны компаниудын тухай хууль¹-иар зохицуулж байна. Тус хуулиар худалдааны компани, түүний хэлбэр, эрх зүйн байдал, худалдааны компани байгуулах, нэгтгэх, нийлүүлэх, хуваах өөрчлөх байгуулах, мөн хууль зөрчигчид хариуцлага ногдуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.
- **БНСВУ-д:** гадаад худалдаатай холбоотой Гадаад худалдааны удирдлагын тухай хууль²-иар зохицуулж байна.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд, Гол онцлог нь гадаад худалдаа хариуцсан олон төрлийн байгууллагууд байх ба өөр хоорондоо ажил үүргийн давхардал хийдэлгүй, үр дүнтэй арга хэлбэрээр хамтран ажилладаг.

Институцийн тогтолцооны хувьд: Үндсэн хуулиар худалдааны асуудлаар хууль тогтоох, тариф ногдуулах, гадаад худалдааны бодлого тодорхойлох эрх мэдлийг Конгресст олгосон.

АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар болон бусад олон агентлагууд худалдаа болон олон улсын эдийн засгийн чиг үүргийг хуулиар олгогдсон эрх мэдэл болон захиргааны эрх мэдлийн хүрээндээ гүйцэтгэдэг. АНУ-ын төрийн агентлагуудын хооронд худалдааны бодлогыг уялдуулж, төрийн болон төрийн бус хамаарал бүхий этгээдүүдийн санал, хүсэлтийг нэгтгэх системийг Худалдааны Төлөөлөгчийн газар удирддаг бөгөөд энэ нь олон талын ашиг сонирхлыг тэнцвэржүүлж худалдааны асуудлаарх АНУ-ын төрийн нэгдсэн "дуу хоолой"-г тодорхойлох зорилготой.

АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газрын дарга нь Засгийн газрын гишүүн бөгөөд Ерөнхийлөгчийн худалдааны бодлогын асуудал эрхэлсэн зөвлөх, АНУ-ын худалдааны хэлэлцээрийн ахлах төлөөлөгч, агентлагуудын худалдааны бодлогыг уялдуулан зохицуулах үйл ажиллагааны тэргүүн юм. Тэрбээр жил бүр Ерөнхийлөгчийн худалдааны бодлогын хөтөлбөр болон гадаад худалдаанд тулгарч буй саад бэрхшээлүүдийг Конгресст тайлагнадаг.

Түүнчлэн АНУ-ын гадаад худалдааны зохицуулалтад Худалдааны яам, Гадаад худалдааны үйлчилгээний байгууллага, АНУ-ын үндэсний аюулгүй байдлын газар, Сангийн яам, Төрийн департамент, Хөдөө аж ахуйн яам, Олон улсын худалдааны комисс, АНУ-ын Худалдаа хөгжлийн агентлаг, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг зэрэг төрийн болон төрийн бус олон институц, ассоциациуд оролцдог.

АНУ-ын экспортыг дэмжих бодлого нь гадаад зах зээлд гарах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажиллах хүчин, санхүүжилтийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд чиглэгддэг. Тухайлбал, АНУ-ын Экспорт-импортын банк гадаад худалдааны санхүүжилтэд чухал үүрэг гүйцэтгэдэг бол Гадаад худалдааны үйлчилгээний газар (*United States Foreign Commercial*

¹ Law Of 15 September 2000, The Code Of Commercial Companies, Poland
<<https://www.global-regulation.com/translation/poland/2986292/law-of-15-september-2000%252c-the-code-of-commercial-companies.html>>

² Law On Foreign Trade Management < <http://vbpl.vn/TW/Pages/vbpgen-toanvan.aspx?ItemID=11096>> хандсан 2021.08.23

Service) нь экспортлогчдод гадаад худалдаатай холбоотой дараах үйлчилгээнүүдийг үзүүлдэг. Үүнд:

- Бараа, үйлчилгээг гадаад орнуудад экспортлох бизнес эрхлэгчдэд экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх;
- Түншлэгч улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн боломж, оюуны өмчийн тогтолцоо, хууль эрх зүйн орчны талаарх мэдээллээр хангах, экспортын бүтээгдэхүүний хэв загварын шийдэл, зохицол, гадаад орнуудын ялгаатай соёл, техникийн шаардлагуудыг хангахад чиглэсэн зах зээлийн стратегитай холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах;
- Америкийн экспортлогчдыг гадаад орнуудын Засгийн газар, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдтэй харилцахад нь туслах, экспортыг санхүүжүүлэх үйл ажиллагааны мэдээллээр хангах, нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;
- Холбооны улсын хэмжээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдтэй холбоо тогтооход нь туслах, жижиг бизнесийн санхүүжилт, даатгалын хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх, хөтөлбөрт өргөдөл гаргахад нь туслах, мэдээлэл түгээх;
- Гадаад худалдааны байгууллагын салбар байгуулагдаагүй орнуудад мэдээлэл хүргэх, санхүүжилтийн туршлага, мэдээллээ хуваалцах, ажилтнуудыг сургах, шинэ зах зээлийн боломжийг ашиглахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр экспортыг дэмжихэд бодитой дэмжлэг тусалцаа үзүүлдэг байна.

Польш Улсын хувьд, 2015 онд Хөгжлийн яам байгуулж (2018 оноос Хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн яам), 2016 онд Хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн яамны дэргэд *Польшийн Хөгжлийн санг* байгуулсан байна. Тус сан нь Аж үйлдвэрлэлийн хөгжлийн агентлаг, Үндэсний Аж ахуйн банк, Экспортын зээлийн даатгалын корпораци, Польшийн Хөрөнгө оруулалт-худалдааны агентлаг, Польшийн аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх агентлагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг гүйцэтгэж байна.

Польшийн хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг нь тус улсад экспортыг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд бизнес эрхлэгчдийг дэмжих, тодорхой төслүүдтэй холбоотой захиргааны болон хууль эрх зүйн хүндрэл, чирэгдлийг даван туулахад дэмжлэг үзүүлдэг байна.

Түүнчлэн хууль эрх зүйн шийдлүүдийг боловсруулж, тохиромжтой байршил, найдвартай түнш, ханган нийлүүлэгчдийг хайж олоход туслахын зэрэгцээ инновацлаг жижиг, дунд үйлдвэрийг өргөжүүлэх зорилготой "Польшийн техникийн гүүрүүд" зэрэг экспортыг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлдэг. Мөн Польшийн эдийн засагт тэргүүлэх ач холбогдолтой машин тоног, төхөөрөмж, уул уурхай, химийн үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний салбаруудтай идэвхтэй хамтран ажиллаж, шинэ зах зээлд үйл ажиллагаа явуулахыг хүсч буй компаниудад дэмжлэг үзүүлдэг байна.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хувьд, Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын яамны харьяа Гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг нь экспортыг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татахуйц хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд экспортлогчдыг дэмжих, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулах, зээл санхүүжилт авах таатай нөхцөлийг бүрдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдал, импорт, экспортын тэнцвэрийг хадгалахын тулд санхүүжилтийн болон гадаад валютын уян хатан бодлогыг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, далайн боомт, гаалийн бүрдүүлэлтийн цэгүүдэд импорт, экспортын тээврийн дэд бүтэц, боомтод хөрөнгө оруулах, шинэчлэх, логистикийн

үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, хөрөнгө оруулалт татах зэрэг чиг үүргийг гүйцэтгэн ажилладаг байна.

Вьетнам Улс нь газарзүйн байршил, байгалийн нөөц, ажиллах хүчний давуу байдалдаа түшиглэж жил бүр томоохон хэмжээний хөрөнгө оруулагчдыг татах арга хэмжээ зохион байгуулдаг бөгөөд Зүүн Өмнөд Азид хөрөнгө оруулалтаараа тэргүүлж байгаа улс юм. Энэ нь Вьетнам Улсын экспортыг дэмжихэд томоохон түлхэц үзүүлдэг байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Нэг.МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ТАЛААР³

Монгол Улсад гадаад худалдааны асуудлыг зохицуулах тусгайлсан хууль одоогоор байхгүй бөгөөд гадаад худалдаанд хамаарал бүхий асуудлуудыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах байдлаар зохицуулж байна. Тухайлбал,

- *Гаалийн тухай хуульд* бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд баримтлах зарчим, гаалийн хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зөвлөгөө, гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаар гомдол гаргах, гаалийн бүрдүүлэлт хийх, бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, гаргах, барааг түр хадгалах, бараа мэдүүлэх, гаалийн байгууллагад мэдүүлсэн барааг олгох, барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим, барааг хилийн чанадад гаргах горим, гаалийн баталгаат бүсийн горим, гаалийн баталгаат агуулахын горим, гаалийн баталгаат үйлдвэрийн газрын горим, чөлөөт бүсийн горим, оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг;
- *Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд* барааны ангилал, импортын барааны гарал үүсэл, экспортын болон импортын барааны гаалийн үнийг тодорхойлох, гаалийн татвар тогтоох хэлбэр, бараанд гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх зэрэг гадаад худалдаатай холбоотой харилцааг;
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд* Монгол Улсад импортоор оруулсан болон Монгол Улсаас экспортод гаргасан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах татварын хувь хэмжээний талаарх асуудлыг;
- *Онцгой албан татварын тухай (Шинэчилсэн найруулга) хуульд* Монгол Улсад импортоор оруулсан зарим төрлийн бараанд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээ, мөн уг татвараас чөлөөлөгдөх экспорт, импортын барааны талаарх асуудлыг;
- *Чөлөөт бүсийн тухай хуульд* чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн харилцааг;

³ Э.Анужин, Б.Долгормаа, С.Золжаргал, Р.Нургүл, Д.Халиун “Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны нөхцөл байдлын талаарх тойм мэдээлэл” СТ-20/424, УИХТГ, Судалгааны эмхтгэл №32

- *Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулиар* зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцыг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцын хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгох, **ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааны асуудлыг тус тус зохицуулжээ.**

Түүнчлэн, Иргэний хууль, Компанийн тухай /Шинэчилсэн найруулга/, Шударга өрсөлдөөний тухай (Шинэчилсэн найруулга), Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Газрын тухай зэрэг хуулиуд, мөн банк, харилцаа холбоо, ашигт малтмал, оюуны өмчийн эрхтэй холбоотой бусад хуулиуд болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, гадаад орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүд, Монгол Улсын бодлогын баримт бичгүүдээр Монгол улсын гадаад худалдааны бодлого, хууль эрх зүйн орчин тодорхойлогдож байна. (*Дэлгэрэнгүйг Хавсралтаас үзнэ үү.*)

1.1. Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд гадаад худалдааны чиглэлээр тусгасан зорилт, арга хэмжээнүүд

“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд гадаад худалдааны асуудлыг дараах байдлаар тусгасан байна.

1. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (УИХ-ын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан)⁴ Баримт бичгийн 3-р бүлэг: “эдийн засгийн гадаад харилцааны бодлого” хэсэгт “Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн” гэсэн байдаг.

Энэхүү бодлогын хүрээнд гадаад худалдаанд холбогдох дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- Эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөхийг дэмжих;
- Олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, үйлчилгээг нь олон улсын түвшинд хүргэх, олон улсын сүлжээнд хамрагдах, соёлын бүтээгдэхүүнийг гадаадад борлуулахад дэмжлэг үзүүлэх;
- Гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцөлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэх;

⁴ <https://www.legalinfo.mn/annex/details/3362?lawid=6340>

- Далайд гарцгүй хөгжиж байгаа улсуудын эрх ашгийг нэгдсэн үндэстний байгууллага болон олон улсын бусад байгууллагын хүрээнд хамгаалах ажилд ахиц гаргах, их далайн нөөцөөс ашиглах боломжийг эрэлхийлэх зэрэг болно.

2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан)⁵ -ын 3-р бүлэгт Монгол Улс эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хүрээнд эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтлахаар заасан.

Энэхүү баримт бичигт гадаад худалдаа, интеграцийн бодлогын хүрээнд дараах заалтуудыг тусгасан байна.

- Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.
- Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.
- Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална. Түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, монополь, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ.

Түүнээс гадна дотоодын үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлэхээр тусгажээ.

Мөн гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулах; эскпортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр заасан байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

(УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан)⁶

Хөтөлбөрийн 3-р бүлэгт эдийн засгийн бодлогын талаар зохицуулсан бөгөөд үүнд гадаад худалдаатай холбоотой дараах заалтуудыг оруулжээ.

⁵ <https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>

⁶ <https://www.legalinfo.mn/annex/details/11219?lawid=15586>

Хүснэгт 1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад худалдааны асуудлыг тусгасан байдал.

Чиглэл	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ
Бүлэг 3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО		
Санхүү, төсвийн зохицуулалт	3.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.	3.1.10.Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ. 3.1.17.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана. 3.1.19.Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулна. 3.1.20.Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна.
Уул уурхай, хүнд үйлдвэр	3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ:
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.	3.3.1.Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх. 3.3.3.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. 3.3.6.Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

		3.3.8.Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ. 3.3.10.Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.
Тээвэр, логистик	3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.	3.6.1.Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ: 3.7.13.Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. 3.7.14.Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулна.
Бүлэг 4. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО		
Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого	4.5.Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.	4.5.2.Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Эдгээр бодлогын баримт бичгүүдэд үндэсний үйлдвэрлэл болон экспортыг дэмжих, чөлөөт худалдааны бүс байгуулах, экспорт, импортын барааны хэт хамаарлаас сэргийлэх, эдийн засгаа төрөлжүүлэх, тээвэр логистикийн асуудал, гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлыг нийтлэг тусгасан байна.

1.2.Засгийн газрын хөтөлбөрүүд

Сүүлийн 10 жилийн хугацаанд гадаад худалдааг зохицуулах, дэмжих хүрээнд Засгийн газраас дараах хөтөлбөрүүдийг баталж гаргасан байна.

Хүснэгт 2.Гадаад худалдааны асуудлыг төсөл хөтөлбөрүүдэд тусгасан байдал, тэдгээрийн хэрэгжилт

Хөтөлбөрийн зорилго	Дэвшүүлсэн зорилт	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилт
“Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх” хөтөлбөр (Засгийн газрын 2007 оны 131 тогтоол)			
"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэн Засгийн газар, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад худалдааны үйл ажиллагаанд учирч байгаа саад тотгор,	1. Хөтөлбөрийг нийтэд тайлбарлан таниулах, боловсрол олгох олон талт ажил зохион байгуулах. 2. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	I үе шат: "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг байгуулах бэлтгэл ажил (2007 он). II үе шат: Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн хэлбэр,	Хэрэгжилт хангалтгүй байсан тул “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” (Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоол) хөтөлбөрт дахин тусгасан ⁷ . Хөтөлбөрийн 3.3 дугаар хэсэгт

⁷“Гурван тулгуурт хөгжлийн бодлого” хөтөлбөр, 3-р бүлэг, 3.3.1.6 дугаар зүйл, <https://www.legalinfo.mn/annex/details/8322?lawid=13240>

<p>давхардлыг арилгаж, үргүй зардлыг багасгах замаар бизнесийг хөнгөвчлөх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх.</p>	<p>3. Оролцогч талуудын мэдээллийн технологийн дэд бүтцийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг нягтлан судлах.</p> <p>4. "Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх"-ны үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдуулан техник, эдийн засгийн дүн шинжилгээ хийх.</p> <p>5. Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хамтарсан хуулийн этгээдийн хэлбэр, бүтцийг тогтоох, хөрөнгө оруулагчид, стратегийн түншийг сонгох зэрэг болно.</p>	<p>бүтцийг тогтоох (2008 оны 1-6 дугаар сар) III үе шат: Улсын болон хувийн хэвшлийн түншлэл бүхий хуулийн этгээдийн хэлбэр, бүтцийг тогтоох, хөрөнгө оруулагчид, стратегийн түншийг сонгох (2008 оны 7 дугаар сар)</p>	<p>“3.3.1.6. гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх;” гэж тусгасан байна.</p>
---	--	---	--

“Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа” хөтөлбөр
(Засгийн газрын 2015 оны 474 дүгээр тогтоол)

<p>Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, экспортыг дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гадаад зах зээлийг тэлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад улс төр-дипломатын аргаар дэмжлэг үзүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтөд хувь нэмэр оруулах.</p>	<p>1. гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, шинээр зах зээл нээх;</p> <p>2. үндэсний аж ахуйн нэгжүүдийн экспортод чиглэсэн бизнесийн үйл ажиллагааг дэмжих;</p> <p>3. байгальд ээлтэй дэвшилтэт, цэвэр технологи нэвтрүүлж, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулах;</p> <p>4. гадаадын хөрөнгө оруулалтыг татах.</p>	<p>Хөтөлбөрийг 2015-2020 оны хооронд хэрэгжүүлэхээр заасан байна.</p>	<p>2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 87.14%-тай байна.</p>
---	---	---	--

“Монгол экспорт” хөтөлбөр (Засгийн газрын 2018 оны 278 дугаар тогтоол)

<p>Үйлдвэрлэл, экспортын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх замаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх,</p>	<p>1. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын худалдааны хөрөнгө оруулалт, санхүү, татварын болон хууль, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;</p> <p>2. Уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар экспортыг</p>	<p>I үе шат буюу 2018-2020 онд экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын худалдааны хөрөнгө оруулалт, санхүү, татварын болон хууль, эрх зүйн таатай орчин бүрдүүлж, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг төрөлжүүлнэ.</p>	<p>“Монгол экспорт хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тухай” Гадаад харилцааны яамны танилцуулгад дурдснаар хөтөлбөрийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 92.8% гарчээ. Хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд</p>
--	--	---	--

худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах	төрөлжүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих; 3. Худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх замаар экспортыг нэмэгдүүлэх	II үе шат буюу 2021-2022 онд олон улсын стандартын шаардлага хангасан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, экспортын зах зээлийн хүрээг тэлж, экспортыг нэмэгдүүлнэ.	хийгдэх нийт 65 ажил, арга хэмжээний 43 нь 100% биелсэн, 6 нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%, 4 нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 40%, 12 нь үнэлэх боломжгүй (11 нь одоогоор хэрэгжилтийг үнэлэх хугацаа болоогүй, 1 нь хэрэгжих боломжгүй) байна.
---	--	--	--

Эх сурвалж: Судлаачийн нээтгэл

1.3. Монгол Улс ба Дэлхийн худалдааны байгууллага

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад (ДХБ)-д гишүүнээр элссэн байна. Ингэснээр тус байгууллагын гишүүн орнуудтай үндэстний нэн тааламжтай нөхцөлөөр буюу тарифын хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр худалдаа хийх боломж бүрджээ. Тус байгууллагад элссэнээс хойш дотоодын хууль тогтоомжийг ДХБ-ын гэрээ, хэлэлцээрүүдэд нийцүүлэх арга хэмжээг авсан байна.⁸

Энэ нь манай гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг нээлттэй болгох боломжийг бүрдүүлсэн юм. Ийнхүү гадаад худалдааг чөлөөлснөөр Монгол Улсад импортын бүтээгдэхүүн зах зээлийн нийлүүлэлт давамгайлж, импортын бүтээгдэхүүнээс хэт хамааралтай болсон. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-д үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь төрийн бодлогын нэг чухал чиглэл бөгөөд үүний тулд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх нь чухал болох талаар тодорхойлсон байдаг. Гэтэл манайд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, тэдэнд шаардлагатай хөнгөлөлтүүдийг үзүүлэх, эрх ашгийг нь хамгаалах эрх зүйн зохицуулалт дутагдаж байгаа талаар судлаач М.Уянгын “Дэлхийн худалдааны байгууллагын гэрээний дагуу дотоодын зах зээлийг хамгаалах эрх зүйн арга хэрэгсэл: Хөгжиж буй улсын эрх” сэдэвт илтгэлд тэмдэглэжээ.⁹

Улс орнууд чөлөөт худалдааны зэрэгцээ протекционист (гадаад худалдааг хязгаарлаж дотоодын эдийн засгаа хамгаалах) бодлогоор үндэсний эдийн засгаа хамгаалдаг. ДХБ-ын гишүүн орнуудын гадаад худалдааны бодлого, хууль эрх зүйн орчин нь нэгдэн орсон ДХБ-ын гэрээ, хэлэлцээртэй харшлахгүй байх ёстой.

ДХБ нь гишүүн орнуудынхаа зах зээлд импортын барааг чөлөөтэй нэвтрүүлэх боломжийг бий болгосон. Энэ нь барааны сонголт хийх, гадаадын болон үндэсний бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр дагавраас гадна импортын бараанаас хэт хамааралтай болох, үндэсний үйлдвэрлэл хөгжихгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг авчирдаг. Иймээс ДХБ нь онцгой нөхцөлд, тухайлбал, гадаадын хэт их импортоос болж үндэсний үйлдвэрлэл хохирол амсах тохиолдолд дотоод зах зээлээ хамгаалах эрхийг гишүүн орнуудад мөн олгодог байна. Улс орнууд гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалтаар үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлдэг.

Монгол банкны “Монгол Улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд” сэдэвт судалгааны тайланд манай улс худалдааны хамгаалалтын арга хэрэгслийг идэвхтэй хэрэглэдэггүй ба энэ нь худалдааны нээлттэй байдалд эерэг нөлөөтэй хэдий ч үндэсний

⁸ <http://www.mfa.gov.mn/?p=50277>

⁹ Уянга М. Хууль зүйн судалгааны зарим асуудал /Түүвэр эмхэтгэл/, 2014 он

аюулгүй байдал алдагдах, зарим орны худалдаанаас хэт хараат байдалд орох эрсдэл дагуулдаг болохыг онцолсон байна.¹⁰

1.4. Эдийн засгийн хамтын ажиллагаа

Монгол Улсын хоёр хөрш болон гуравдахь хөршүүдтэй хамтран хэрэгжүүлж буй зарим худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар тоймлон авч үзлээ.

Манай улс худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд урд, хойд 2 хөрш улстай дэлхийн зах зээлийн үнэ болон чөлөөт хөрвөх валют ашиглах, харилцан бие биендээ үндэсний нэн тааламжтай нөхцөл олгох зарчмуудыг тохирсон.

БНХАУ-тай дараах гол гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулсан байна (2018 оны байдлаар).¹¹ Үүнд:

- Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр (1991 он)
- Татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр (1991 он)
- Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээр (1993 он)
- Монгол Улсын Сангийн яам, Хятадын Хөгжлийн банк корпорацийн хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээр (2009 он)
- Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай (2009 он)
- Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр (2014 он)
- Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал (2014 он)
- Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл (2015 он) зэрэг болно.

Түүнчлэн 2011 оноос урд хөрштэй стратегийн түншлэлийн харилцаа тогтоож, 2013 оноос “Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.¹² Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хоёр улсын стратегийн түншлэлийг тасралтгүй бэхжүүлж гүнзгийрүүлэх, бүх салбарын хамтын ажиллагааг төлөвлөгөөтэй, үе шаттай хөгжүүлэх, Монгол, Хятадын хамтын хөгжил, ард түмний сайн сайхныг цогцлоох, бүс нутаг улмаар дэлхий дахины энх тайвныг сахин хамгаалах, тогтвортой байдал, хөгжлийг урагшлуулахад тус дөхөмтэй гэж талууд үзсэн байна.¹³

Харин хойд хөрш **ОХУ-ын хувьд** хоёр улс 2009 оноос Стратегийн түншлэлийг хөгжүүлж эхэлснээр Монгол Улс стратегийн түншлэлийн харилцааг анх ОХУ-тай тогтоосон байна. Хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал байр суурь эзэлдэг “Эрдэнэт”, “Монголпросцветмет” хамтарсан үйлдвэрүүд, хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, эрх зүйн орчиныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.¹⁴

2015 онд “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хооронд хамтын ажиллагааны тухай санамж бичиг” байгуулж, Монгол Улс, Евразийн гишүүн орнуудын

¹⁰ <https://www.mongolbank.mn/documents/press_conference/20180928_01.pdf>

¹¹ Гадаад харилцааны яам, <<http://www.mfa.gov.mn/?p=28018>> хандсан 2021.08.20

¹² Мөн тэнд

¹³ Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр, The Mongolian Mining Journal, 2013 <<http://www.mongolianminingjournal.com/a/51721>> хандсан 2021.08.20

¹⁴ Гадаад харилцааны яам <<http://www.mfa.gov.mn/?p=28018>> хандсан 2021.08.20

бүх талын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, худалдааг хөгжүүлэхэд саад болж буй бэрхшээлүүдийг арилгах чиглэлээр хамтран ажиллаж байна.

2016 онд “Монгол Улс, Оросын Холбооны Улс хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” байгуулж, түүнд хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ, зорилтуудыг тусгажээ.

Манай улс ОХУ-д гаргах мах, сүү, арьс шир болон малын гаралтай бүтээгдэхүүн, сүлжмэл эдлэл зэрэг бүтээгдэхүүний худалдааг нэмэгдүүлэхийн тулд экспортын бүтээгдэхүүнийг ОХУ болон Евразийн эдийн засгийн холбооны зах зээлд хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэх асуудлаар хэлэлцээр байгуулах, ОХУ-ын оролцоотой бүс нутгийн үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн сүлжээнд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэх, харилцан ашигтай түншийн тогтолцоог хөгжүүлэх зорилттой ажиллаж байна.

Түүнчлэн, 2016 онд болсон ШХАБ-ын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн ээлжит хуралдааны үеэр “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт гарын үсэг зурсан. Ингэснээр үйлдвэрлэлийн салбарт өндөр технологи, гадны хөрөнгө оруулалт нэмэгдэж, түүхий эд, эрдэс баялгаа өндөр түвшинд боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж хөрш хоёр орны төдийгүй олон улсын зах зээлд нийлүүлэх боломж бий болох юм.¹⁵

ГУРАВДАХЬ ХӨРШҮҮД-ийн хувьд түнш орнууд, ОУБ-ууд Монгол Улсад Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) олгож ирсний зэрэгцээ, гаалийн болон тарифын таатай орчныг бүрдүүлсэн байна. Тухайлбал, манай улсаас Европын Холбоотой 2007 оноос Хөнгөлөлтийн ерөнхий систем GSP+зохицуулалтын дагуу 7,200 гаруй бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй экспортлох хэлэлцээр¹⁶, Японтой 2016 оноос Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулжээ. Энэ нь далайд гарцгүй Монгол Улсаас дэлхийн бусад оронтой чөлөөт худалдааны зохицуулалт хийх үлгэр загвар болжээ.¹⁷

Монгол Улс, Япон Улсын хоорондын “стратегийн түншлэл”-ийн хүрээнд байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” нь хоёр улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингээсэн экспорт, валютын орлого зэргийг нэмэгдүүлэх, японы тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах, худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулах зорилготой. Монгол Улс Япон Улстай “Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр”-ийг 2016 оноос хэрэгжүүлж байна. Энэ нь Монгол Улсын хувьд анхны чөлөөт худалдааны хэлэлцээр болсноороо онцлог юм.

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр: Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй орнууд болох Энэтхэг, Өмнөд Солонгос, Шри Ланка, Лаос, Бангладеш өөр хоорондоо худалдааны хөнгөлөлт үзүүлэх зорилгоор “Бангкокийн хэлэлцээр”-ийг 1975 онд байгуулсан. БНХАУ 2001 онд тус хэлэлцээрт нэгдэн орсон хийгээд оролцогч талууд хэлэлцээрийн цар хүрээг 2005 онд өргөжүүлсэнтэй холбогдуулан “Бангкокийн хэлэлцээр”-ийг “Ази, Номхон Далайн Худалдааны Хэлэлцээр (АНДХХ)” болгон ёсчилсон.

Хэлэлцээр нь хөгжиж буй гишүүн орнуудын хоорондын худалдааг өргөжүүлж тэдгээрийн эдийн засгийг хөхиүлэн дэмжих, худалдааг харилцан либералчлах, харилцан ашигтай

¹⁵ http://embassymongolia.ru/?page_id=1901

¹⁶ 2017 оноос эхлэн Европын Холбоо (ЕХ)-ны “GSP”+ Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хүрээнд импортын барааны гаалийн татварын хөнгөлөлт эдэлж буй бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлийг цахимжуулж, түүнийг Монгол улс 2020 оны 01 дүгээр сарын 01—ний өдрөөс эхлэн (ЕХ)-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-ийг нэвтрүүлсэн. <<http://tram-mn.eu/европын-холбооны-бүртгэгдсэн-экспортлогчдын-систем-ийг-хэрэгжүүлнэ/>> хандсан 2021.08.26

¹⁷ Д.Даваасамбуу, С.Бадрал, “Монгол Улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчин: өнөөгийн байдал ба хэтийн төлөв”, Монголбанк, ГХЯ, 2019 он
<https://www.mongolbank.mn/documents/press_conference/20190521_02.pdf> хандсан 2021.08.26

хамтын ажиллагааг өрнүүлэх, гишүүн орнууд хоорондын худалдаан дахь тариф, тарифын бус болон худалдаатай холбогдол бүхий бусад саад тотгорыг бууруулах зорилготой.

Монгол Улс АНДХХ-т нэгдэн орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, 366 нэр төрлийн барааг багтаасан үндэсний хөнгөлөлтийн жагсаалтаар хэлэлцээрийн оролцогч талуудтай цуврал хэлэлцээ хийж, улмаар нэгдэн орох нөхцөлийг 2018 оны 9 дүгээр сард хангасан. Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай” хуулийн төслийг соёрхон баталснаар АНДХХ-ийн 7 дахь гишүүн улс болсон бөгөөд хэлэлцээрийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.¹⁸

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр (ТИФА)-ийг 2004 оны 7 дугаар сард байгуулсан. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд Монгол, Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан хороо байгуулагдсан нь талуудын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт болон тарифын болон тарифын бус саад тотгор, оюуны өмчийн эрх, хөдөлмөр, байгаль орчин, ил тод байдал зэрэг өргөн хүрээтэй асуудлаар яриа хэлэлцээ хийх байнгын механизмын үүрэг гүйцэтгэдэг.¹⁹

Монгол Улс, АНУ хоорондын Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр (Ил тод байдлын хэлэлцээр), 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурж, УИХ-аас 2014 оны 12-р сард соёрхон баталсан. Тус хэлэлцээр нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжийн талаар олон нийтэд мэдээлэх, санал авах, хэвлэн нийтлэх, авилгатай тэмцэх зэрэг чиглэлээр харилцан мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлсэн нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэгдэж байна.²⁰



¹⁸ Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр, ГХЯ <<http://mfa.gov.mn/ази-номхон-далайн-худалдааны-хэлэлцээ?preview=true>> хандсан 2021.10.13

¹⁹ “Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль” /Mongolia Third Neighbour Trade Act/-ийн төслийг АНУ-ын Конгрессын нэр бүхий гишүүд санаачлан 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Конгресст дахин өргөн бариад байна.

²⁰ Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр (ТИФА) <<http://mfa.gov.mn/61793-2-copy>> хандсан 2021.10.13

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭКСПОРТОД ЧИГЛЭСЭН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүснэгт 3. Гадаадын зарим улсын худалдаатай холбоотой тойм мэдээ

Улсын нэр	Монгол Улс (2019 он)	БНГУ (2019 он)	БНСУ (2019 он)	ХБНГУ (2019 он)	АНУ (2019 он)
ДНБ хэмжээгээр дэлхийд эзлэх байр	128	21	44	4	1
Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр дэлхийд эзлэх байр	114	57	134	18	8
Нийт экспортын хэмжээгээр дэлхийд эзлэх байр	95	22	20	3	2
Нийт импортын хэмжээгээр дэлхийд эзлэх байр	124	18	20	3	1
Эдийн засгийн цогц байдлын индекс (ЕСI)	125	23	65	4	10
Импортын түншийн тоо ²¹	147	230	97	231	223
Экспортын барааны тоо	78	226	97	232	223
Импортын барааны тоо	3502	4378	4359	4472	4529
Экспортын барааны тоо	1178	4323	3784	4413	4529
Дэлхийн худалдааны байгууллагад элссэн огноо	1997	1995	2007	1995	1995

Хууль тогтоомж

Гадаад худалдааг зохицуулж буй бие даасан хууль	-	-	Гадаад худалдааны удирдлагын тухай хууль ²²	Гадаад худалдааны тухай хууль	Гадаад аж ахуйн тухай хууль
Дотоод худалдааг зохицуулж буй бие даасан хууль	-	-	-	Худалдааны тухай хууль	Худалдааны тухай багц хууль

Эх сурвалж: *World Integrated Trade Solutions, 2019*

Дээрх хүснэгтэд улс орнуудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, гадаад худалдааны хэмжээ, хууль эрх зүйн зохицуулалтын төрлийг харуулав. Монгол Улс гадаад худалдааг зохицуулах бие даасан хуульгүй, экспорт, импортын хэмжээгээр дэлхийд нэлээд доогуур үзүүлэлттэй байгаа юм.

²¹ World Integrated Trade Solutions, WITS <<https://wits.worldbank.org/Default.aspx?lang=en>> хандсан 2021.08.26

²² Ц.Норовдондог, Г.Алтан-Оч, Д.Живаагунсал, Р.Оргилмаа, Р.Нургүл, Ц.Элбэгааяа "Худалдааны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага" СТ-18/204, УИХТГ, Судалгааны эмхтгэл №26

2.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

2019 оны байдлаар Америкийн Нэгдсэн Улс ДНБ-ний хэмжээгээр дэлхийд 1-р байранд, нийт экспортын хэмжээгээр 2-т, нийт импортын хэмжээгээр 1-т, нэг хүнд ногдох ДНБ-ээр 8-д, эдийн засгийн цогц байдлын индекс (Economic Complexity Index – ECI)-ийн үзүүлэлтээрээ 10-т тус тус жагсаж байна.

АНУ-ын гол экспортыг боловсруулсан болон түүхий газрын том, машин, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл бүрдүүлж байгаа бөгөөд дийлэнх бүтээгдэхүүнээ Канад, Мексик, БНХАУ, Япон, ХБНГУ зэрэг улсууд руу экспортолж байна. Америкийн үндсэн импортын бүтээгдэхүүнд машин, тээврийн хэрэгсэл, компьютер, өргөн нэвтрүүлгийн тоног төхөөрөмж, савласан эм зэрэг бүтээгдэхүүн багтаж байгаа бөгөөд импортын дийлэнх хэсгийг нь БНХАУ, Мексик, Канад, Япон, ХБНГУ зэрэг орнуудаас импортолж байна.

2.1.1. Эрх зүйн зохицуулалт, хуулийн бүтэц, агуулга

АНУ-ын Үндсэн хуулиар Конгресс худалдааны асуудлаар хууль тогтоох, тариф ногдуулах, гадаад худалдааны бодлого тодорхойлох онцгой бүрэн эрхтэй байна.²³

Муж улс доторх худалдааг муж улсууд өөрсдөө зохицуулдаг.

АНУ-ын хууль эрх зүй нь эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулах ялгаатай 54 багц зүйл (title)-тэй. Эдгээр 54 багц зүйлийн 15 дахь нь арилжаа, худалдаа (Commerce and Trade)-ны зохицуулж буй гол багц юм.

Үүнээс гадна 12 (Банк), 18 (Гэмт хэрэг), 19 (Гаалийн татвар), 22 (Гадаад харилцаа) буюу АНУ-ын санхүүгийн салбарт гаднын банкууд үйл ажиллагаа явуулах, АНУ-ын банкууд гадаад улсад үйл ажиллагаа явуулах, АНУ-ын Exim банк, хилээр бараа нэвтрүүлэх, гаргахтай холбоотой гэмт хэрэг, гаалийн татвар, гадаад харилцаа зэрэг асуудлыг зохицуулж буй бүлгүүдэд худалдаатай холбоотой асуудлууд тусгагдсан байна.²⁴

15 дахь багц Арилжаа, худалдааг зохицуулах, түүн дотроо экспортыг дэмжихтэй холбоотой зохицуулалт нь дотроо дараах 3 хэсэгтэй.

1. Холбооны худалдааны хороо, экспортын худалдаанд чиглэгдсэн дэмжлэг, шударга бус өрсөлдөөний арга хэлбэрээс сэргийлэх тухай (15 дахь бүлгийн 2-р хэсэг)
2. Экспортыг дэмжих (15 дахь бүлгийн 66-р хэсэг)
3. Экспортыг эрчимжүүлэх (15 дахь бүлгийн 73-р хэсэг)

Дээрх 3 бүрдэл хэсгийг тус бүрд нь товч авч үзье.

1. Холбооны худалдааны хороо, экспортын худалдаанд чиглэгдсэн дэмжлэг, шударга бус өрсөлдөөний арга хэлбэрээс сэргийлэх тухай. (15 дахь бүлгийн 2-р хэсэг) Энэ нь дотроо 3 үндсэн дэд хэсэгтэй.

Хүснэгт 4. Холбооны Худалдааны хороо, экспортын худалдаанд чиглэгдсэн дэмжлэг, шударга бус өрсөлдөөний арга хэлбэрээс сэргийлэх тухай

№	Дэд хэсэг	Дэд хэсгийн агуулга
1	Холбооны худалдааны хороо	Энэ хэсэг нь Холбооны Худалдааны комиссын эрх зүйн байдал, үйл ажиллагаа, баримтлах зарчим зэргийг тусгасан байдаг.
2	Экспортын дэмжлэг	Экспортын худалдаа, монополийн эсрэг хууль тогтоомж, экспортын үйл ажиллагаа эрхэлдэг компанийг худалдаж авах арга, зарчим, экспортын шударга өрсөлдөөн, экспортын компаниудаас авах мэдээлэл, Холбооны Худалдааны хорооны экспортыг дэмжихтэй холбоотой эрх, үүрэг зэргийг зааж өгсөн байна.

²³ Trade Regulation: an overview., Legal Information Institute. Cornell Law School. <https://www.law.cornell.edu/wex/trade_regulation> хандсан 2021.10.13

²⁴ Trade Laws, Office of the United States Trade Representative <<https://ustr.gov/about-us/trade-toolbox/trade-laws>> хандсан 2021.10.15

3	Шударга бус өрсөлдөөний арга хэлбэрээс сэргийлэх тухай	Импортын барааг хязгаарлах гэрээнүүд, импортыг хориглож байгаа орнуудад үзүүлэх хариу арга хэмжээ, дайны үеийн импортын хязгаарлалтад үзүүлэх хариу арга хэмжээ, дайны үед төвийг сахисан Америк иргэнийг ялгаварлан гадуурхах тохиолдол зэргийг зааж өгсөн байна.
---	--	--

Эх сурвалж: <https://www.law.cornell.edu/uscode/text/15>

2. Экспортыг дэмжих (15 дахь бүлгийн 66-р хэсэг)

Энэ хэсэгт экспортын компаниуд, худалдааны холбоод, хяналттай арилжааны гэрээ, экспортыг дэмжих хөтөлбөр зэргийг тусгасан байдаг.

Хүснэгт 5. Экспортыг дэмжих

№	Дэд хэсэг	Дэд хэсгийн агуулга
1	Экспортын худалдааны компаниуд, худалдааны нэгдэл, холбоод	Худалдааны компаниуд, худалдааны танхимын экспорт хариуцсан газар, худалдааны холбоодын талаар тодорхой оруулж өгсөн.
2	Экспортын худалдааны хяналтын гэрчилгээ ²⁵	Экспортыг дэмжих чиглэлээр худалдааны нарийн бичгийн даргын гүйцэтгэх үүрэг, хяналт бүхий экспортын худалдааны гэрчилгээний ач холбогдол, гэрчилгээний нөхцөлийн хэрэгжилтийг тайлагнах, гэрчилгээнд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох нөхцөл, хяналт, хяналтын гэрчилгээгээр олгосон хамгаалалт, мэдээллийн ил тод байдалтай холбоотой зохицуулалт зэргийг агуулсан байна.
3	Экспортыг дэмжих хөтөлбөр ²⁶	Урьдчилсан зөвшөөрлийн шаардлага, худалдааны танхимын шалгуур, бартеры зохион байгуулалт зэргийг тусгасан байдаг.

Эх сурвалж: <https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-66>

3. Экспортыг эрчимжүүлэх (15 дахь бүлгийн 73-р хэсэг)

Энэ хэсэгт бартерын арилжаа болон экспортын худалдааг цогцоор нь дэмжихтэй холбоотой зүйл, заалтуудыг тусгасан.

Хүснэгт 6. Экспортыг эрчимжүүлэх

№	Дэд хэсэг	Дэд хэсгийн агуулга
1	<u>Ерөнхий нөхцөл</u>	Бартер болон барааг, бараагаар солих арилжаа
2	<u>Экспортын дэмжлэг</u>	Америкийн Гадаад худалдааны үйлчилгээний алба, улсын худалдааны зохицуулалт, зах зээлийг өргөжүүлэх, хөгжүүлэх хамтын ажиллагааны хөтөлбөр, Америкийн худалдааны төвүүд, худалдааны үзэсгэлэн, худалдааг дэмжих, зохион байгуулах хороо, хүрээлэн буй орчинд ээлтэй бараа, үйлчилгээний худалдааг дэмжих тухай, холбооны улсын экспортыг дэмжих ажлын хэсэг, экспортын бодлогын хэрэгжилтийн тайлан зэргийг агуулсан байна.

Эх сурвалж: <https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-73>

²⁵ An Export Trade Certificate of Review protects **the holder and the members identified** in the Certificate from State and Federal government antitrust actions and from private treble damage antitrust actions for the export conduct specified in the Certificate and carried out in compliance with its terms and conditions.

²⁶ “export promotion program” means any activity of the Department of Commerce designed to stimulate or assist United States businesses in marketing their goods and services abroad competitively with businesses from other countries

2.1.2.Хуулийн онцлох зохицуулалтууд ба түүнийг хэрэгжүүлэх институционал тогтолцоо

Экспортыг эрчимжүүлэхтэй холбоотой зарим хууль эрх зүйн зохицуулалтуудын тойм (15 дахь бүлгийн 73-р хэсэг)²⁷

Гадаад худалдааны үйлчилгээний Газар (*United States and Foreign Commercial Service*) нь²⁸ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бараа, үйлчилгээ экспортлох боломжтой Америкийн бизнес эрхлэгчдийг олж тогтоох, тэдэнд экспортын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бий болгох чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх;
- Америкийн экспортлогчдыг эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн боломж, улс орнуудын оюуны өмчийн тогтолцоо, хууль эрх зүйн зохицуулалтын орчны талаарх мэдээллээр хангах;
- Америкийн экспортлогчдыг бүтээгдэхүүний хэв загварын шийдэл, зохицол, гадаад орнуудын олон төрлийн соёл, техникийн шаардлагуудыг хангахад чиглэгдсэн зах зээлийн стратегитай холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах;
- Америкийн экспортлогчдыг удирдан чиглүүлж, гадаад улс орнуудтай холбох, танилцуулах;
- Америкийн экспортлогчдод гадаад улс орнуудад найдвартай бизнестэй болоход нь дэмжлэг үзүүлэх;
- Америкийн экспортлогчдод гадаад орнуудын Засгийн газар, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдтэй харилцахад нь туслах;
- Үр ашгийг дээшлүүлэх, хүчин чармайлтын давхардлыг багасгах зорилгоор АНУ-ын бизнесийн ашиг сонирхлыг гадаадад сурталчлах зорилготой төрийн болон орон нутгийн агентлагууд, хувийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад туслах;
- Экспортыг санхүүжүүлэх үйл ажиллагааны талаар АНУ-ын экспортлогчдыг мэдээллээр хангах, экспортлогчдод нэг цонхны үйлчилгээ үзүүлэх, Холбооны аль хөтөлбөр нь тэдэнд хамгийн их тус болж болохыг тодорхойлох, Холбооны зүгээс хэрэгжүүлэх хөтөлбөрүүдтэй холбоо тогтооход нь туслах;
- АНУ-ын экспортлогч, экспортын санхүүгийн байгууллагуудад АНУ-ын Экспорт-Импорт банк, АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорац, Худалдаа хөгжлийн хөтөлбөр, жижиг бизнесийн бүх төрлийн санхүүжилт, даатгалын хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх, хөтөлбөрт хамрагдах өргөдлийг бөглөхөд нь туслах, экспортлогчид болон экспортын санхүүжилтийг олгодог байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр гаргасан өргөдөл учир дутагдалтай зүйлүүд байвал тэдгээрийг засах;
- бага зардалтайгаар мэдээлэл түгээх, гадаад худалдааны байгууллагын салбар байгуулагдаагүй орнуудад мэдээллийг түгээх орчныг бүрдүүлж ажилладаг байна.

Экспорт-Импортын банк болон Америкийн Олон улсын хөгжлийн санхүүгийн корпорац гадаад худалдааны байгууллагыг өөрийн хэрэгжүүлж буй хөтөлбөр болон санхүүжилтийн шилдэг арга туршлагын талаар мэдээллээр хангаж, ажилтнуудыг нь сургадаг байна.

Худалдааны танхимын Ерөнхий хянан шалгагч Гадаад худалдааны байгууллагад 3 жилд доод тал нэг удаа аудит явуулж, үр дүнг нь Конгресст танилцуулдаг. Гадаадад ажиллаж байгаа албан хаагчийн томилгоо, мэдлэг чадвар шинээр тавигдаж буй хэрэгцээ шаардлага, Америкийн экспортлогчдод олдож буй шинэ зах зээлийн боломжийг ашиглах эрх ашгийг хангаж чадаж байгаа эсэхэд үнэлгээ хийдэг.

²⁷ 15 U.S. Code chapter 73-Export enhancement, <<https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-73>> хандсан 2021.10.18

²⁸ U.S. Code: title 15. Commerce and trade <<https://www.law.cornell.edu/uscode/text/15>> хандсан 2021.10.13

Худалдааны сайд Америкийн худалдааг дэмжих агентлагуудтай хамтран ажиллаж, холбооны хэмжээнд үйл ажиллагаа, стратегиа нэгтгэн төлөвлөдөг.

АНУ-ын Гадаад худалдааны үйлчилгээ хариуцсан дарга муж бүрийн хувьд экспортыг дэмжих жил бүрийн стратеги төлөвлөгөөг боловсруулж гаргадаг. Ингэхдээ мужуудын саналыг эш үндэслэл болгодог.

Зах зээлийг хөгжүүлэх хамтын ажиллагааны хөтөлбөр (*Market Development Cooperator Program*)-ийн хүрээнд²⁹ АНУ-ын бараа, үйлчилгээний экспортыг дэмжихдээ, Худалдааны сайд (Худалдааны Нарийн бичгийн дарга) зах зээлийг харилцан уялдаатайгаар хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулдаг. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь АНУ дахь хөдөө аж ахуйн бус бараа, үйлчилгээний гадаадын зах зээлийг хадгалах, бий болгох, өргөжүүлэх явдал байна.

- **АНУ-ын худалдааны төв** (*United States Commercial Centers*)³⁰ Худалдааны сайд нь Худалдааг дэмжих зохицуулах хорооны даргын хувьд АНУ-ын Ази, Латин Америк, Африк дахь худалдааны төвүүдийг нээх, ажиллуулах үүрэгтэй байдаг. Худалдааны төв нь Америкийн экспортлогчдыг дээрх орнуудын зах зээл, үйлдвэрүүд, хэрэглэгчидтэй холбох гүүр болж өгдөг.
- **Худалдааны үзэсгэлэн** (*Trade shows*)³¹ Худалдааны сайд нь Америкийн экспортыг дэмжихийн тулд Америкт худалдааны үзэсгэлэн гаргахад туслах үүрэгтэй бөгөөд үзэсгэлэн нь Америкийн бизнесийн төлөөлөгчид болон Америкаас бараа, үйлчилгээ худалдаж авахыг сонирхож байгаа гадаадын компаниуд, төр, засгийн газрын төлөөлөгчдийг нэг дор цуглуулдаг.
- **АНУ ба Гадаад худалдааны алба Номхон далайн бүсийн санаачилга** (*United States and Foreign Commercial Service Pacific Rim initiative*)³² Америкийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Япон, БНСУ болон Тайвань зэрэгт экспортлох үйл явцад дэмжлэг үзүүлэхийн тулд Америкийн Гадаад худалдааны үйлчилгээний газар хүчин чармайлт гаргаж ажилладаг.
- **Худалдааг дэмжих зохицуулах хороо** (*Trade Promotion Coordinating Committee*)³³-г Ерөнхийлөгч байгуулж, удирдлагыг нь томилох бөгөөд энэхүү хороо нь экспортыг дэмжих болон экспортыг санхүүжүүлэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, Засгийн газраас хэрэгжүүлэх холбогдох стратегийг боловсруулж гаргадаг.
- **Байгаль орчинд ээлтэй худалдааг дэмжих** (*Environmental trade promotion*)³⁴ АНУ-ын байгаль орчинд ээлтэй технологи, бараа, үйлчилгээний экспортыг дэмжих нь АНУ-ын төрийн бодлого юм. Эрх мэдэл, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ АНУ-ын Засгийн газрын холбогдох бүх хэлтэс, агентлагууд энэ төрлийн технологи, бараа, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.
- **Мужийн болон Холбооны экспортыг дэмжих ажлыг зохицуулах ажлын хэсэг** (*State and Federal Export Promotion Coordination Working Group*)³⁵ Жижиг бизнес эрхлэгчдийн экспортыг дэмжих нь АНУ-ын төрийн бодлого юм. Энэхүү бодлогын хүрээнд эрх мэдэл, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Холбооны бүх агентлагууд экспортыг

²⁹ 15 U.S. Code § 4723 - Market Development Cooperator Program

³⁰ 15 U.S. Code § 4723a - United States Commercial Centers

³¹ 15 U.S. Code § 4724 - Trade shows

³² 15 U.S. Code § 4725 - United States and Foreign Commercial Service Pacific Rim initiative

³³ 15 U.S. Code § 4727 - Trade Promotion Coordinating Committee

³⁴ 15 U.S. Code § 4728 - Environmental trade promotion

³⁵ 15 U.S. Code § 4728a - State and Federal Export Promotion Coordination Working Group

дэмжих, экспортыг санхүүжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг муж, орон нутгийн агентлагуудтай бүтээлчээр хамтран ажиллана.

- **Экспортын худалдаа, монополийн эсрэг хууль тогтоомж** (*Export trade and antitrust legislation*)³⁶ Экспортолсон бараа бүтээгдэхүүний үнийг зохиомлоор буюу санаатайгаар өсгөж, бууруулах, экспортын хэмжээг багасгах, АНУ-ын нутаг дэвсгэрт өрсөлдөөнийг мэдэгдэхүйц сулруулах нөлөөтэй аливаа гэрээ, ойлголцол, хуйвалдааны хэлбэрээр хийгдээгүй л бол бараа үйлчилгээний экспорт хууль ёсны хэмээн тунхаглаж болно.
- **Экспортын худалдааны корпорацийн хувьцааг худалдаж авах** (*Acquisition of stock of export trade corporation*)³⁷ Экспортын худалдааг хязгаарлах, эсвэл АНУ-ын бараа үйлчилгээний өрсөлдөх чадварыг мэдэгдэхүйц бууруулах нөлөө үзүүлэхгүй л бол экспортын худалдаа эрхлэх зорилгоор байгуулагдсан аливаа корпорацийн хувьцаа эсвэл бусад хөрөнгийг бүхэлд нь аль эсвэл хувьцаа болон хөрөнгийн ямар нэг хэсгийг эзэмшихийг хориглохгүй.

Экспортыг дэмжихтэй холбоотой зарим хууль эрх зүйн зохицуулалтуудын тойм (15 дахь бүлгийн 66-р хэсэг)³⁸

- **Конгрессын дүгнэлт, зорилгоо тунхаглах** (*Congressional findings and declaration of purpose*)³⁹ 1982 онд батлагдсан Экспортын худалдааны компанийн тухай хуульд⁴⁰ Конгрессоос АНУ-ын экспорт нь АНУ-д үйлдвэрлэлийн салбар дахь есөн ажлын байр тутмын нэгийг бий болгож, хадгалах, АНУ-ын үйлдвэрлэсэн нийт долоон доллар тутмын нэгийг бий болгож байна гэж тогтоосон байна.
- **Худалдааны яамны Экспортын худалдааны алба** (*Office of Export Trade in Department of Commerce*)⁴¹ Худалдааны сайд нь Худалдааны яамны дэргэд Экспортын худалдааны холбоо, экспортын арилжааны компаниудыг бий болгох, үйл ажиллагааг нь дэмжих ажлыг зохион байгуулна. Ийм алба нь сонирхсон хүмүүст мэдээлэл, зөвлөгөө өгч, экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгчид болон экспортын худалдааны үйлчилгээ эрхэлдэг пүүсүүдийн хоорондын харилцааг хялбар болгон хөнгөвчилж, лавлагаа, мэдээллээр үйлчилдэг. Түүнчлэн, экспортын бусад зуучлагчдыг дэмжих, тэдэнд туслах хөтөлбөр боловсруулна.
- **Гэрчилгээ олгох** (*Issuance of certificate of review*)⁴² Экспортын худалдаа, худалдааны үйл ажиллагааны арга хэлбэрийг тодорхойлсон өргөдөл гаргагчдыг хянан үзэж гэрчилгээ олгоно. Гэрчилгээ олгоход АНУ-ын дотоодын өрсөлдөөн мэдэгдэхүйц буурах, экспортлогчийн болон өргөдөл гаргагчийн өрсөлдөгч бизнесийн худалдаа хязгаарлагдах нөхцөл байдал үүсэхгүй байх учиртай.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³⁷ 15 U.S. Code § 63 - Acquisition of stock of export trade corporation

³⁸ 15 U.S. Code chapter 66— Promotion of export trade, <<https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-66>> хандсан 2021.10.18

³⁹ 15 U.S. Code § 4001 - Congressional findings and declaration of purpose

⁴⁰ Export trading company act of 1982, International Trade Administration <<https://www.trade.gov/feature-article/export-trading-company-act-1982>> хандсан 2021.10.13

⁴¹ 15 U.S. Code § 4003 - Office of Export Trade in Department of Commerce

⁴² 15 U.S. Code § 4013 - Issuance of certificate

- **Бартерын тохиролцоо** (*Barter arrangements*)⁴³ Ерөнхийлөгч нь дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Засгийн газраас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийг худалдах боломжгүй тохиолдолд гадаадад үйлдвэрлэсэн газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, үндэсний ашиг сонирхолд чухал ач холбогдолтой бусад бараа, бүтээгдэхүүнээр солилцох;
 - АНУ-д үйлдвэрлэж, АНУ-аас экспортолдог хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг АНУ-ын иргэд гадаадад үйлдвэрлэгдсэн газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон үндэсний ашиг сонирхолд чухал ач холбогдолтой бусад бараа үйлчилгээгээр солилцсон бол худалдаж авах.

2.1.3.Экспортыг дэмжих бүтэц зохион байгуулалт, экспортод чиглэсэн бодлого⁴⁴

АНУ-ын Үндсэн хуулиар Конгресст худалдааны асуудлаар хууль тогтоох, тариф ногдуулах, гадаад худалдааны бодлого тодорхойлох эрх мэдлийг олгодог. Үндсэн хуулийн дагуу зөвхөн Конгресс л гадаад худалдааг зохицуулах, тарифын хэмжээг тогтоох эрх мэдэлтэй боловч Ерөнхийлөгч нэмэлт хуулийн зохицуулалтын хүрээнд тарифын холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрх мэдлийг олж авах боломжтой.

Конгресс хэлэлцээр байгуулах болон түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газартай (Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Засгийн газар гэх мэт) хамтарч ажилладаг. АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар (АНУХТГ) болон бусад олон агентлагууд худалдаа болон олон улсын эдийн засгийн чиг үүргийг хуулиар олгогдсон эрх мэдэл болон захиргааны эрх мэдлийн хүрээндээ гүйцэтгэдэг. АНУ-ын төрийн агентлагуудын хооронд худалдааны бодлогыг уялдуулж төрийн болон төрийн бус хамаарал бүхий этгээдүүдийн санал, хүсэлтийг нэгтгэх системийг Худалдааны Төлөөлөгчийн газар (АНУХТГ) удирддаг бөгөөд энэ нь олон талын ашиг сонирхлыг тэнцвэржүүлж худалдааны асуудлаар АНУ-ын төрийн нэгдсэн “дуу хоолой”-г хүргэх зорилготой.

АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар (*The Office of the U.S. Trade Representative*)⁴⁵

Худалдааны бодлого боловсруулах гол агентлаг болох АНУ-ын Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх алба АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газрын нь тэргүүн нь кабинетын (Засгийн газрын) гишүүн бөгөөд Ерөнхийлөгчийн худалдааны бодлогын асуудал эрхэлсэн зөвлөх, АНУ-ын худалдааны хэлэлцээрийн ахлах төлөөлөгч, агентлагуудын худалдааны бодлогыг уялдуулан зохицуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулагч юм. Тэрбээр жил бүр Ерөнхийлөгчийн худалдааны бодлогын хөтөлбөр болон гадаад худалдаанд тулгарч буй саад бэрхшээлүүдийг тайлагнадаг.

Конгресс нь Худалдааны Төлөөлөгчийн албан тушаалаар АНУ-ын дотоод болон гадаад бодлого, худалдааны асуудал эрхэлсэн олон төрлийн агентлагууд, дотоодын хамаарал бүхий этгээдүүдийн тус тусын эрх ашгийг тэнцвэржүүлэх “шударга зуучлагч” бий болгохыг зорьсон. Жил бүр Ерөнхийлөгчийн өмнөөс АНУ-ын худалдааны хэлэлцээрийн хөтөлбөр болон түүний хэрэгжилтийн талаар Конгресст тайлагнадаг.

⁴³ 15 U.S. Code § 4053 - Barter arrangements

⁴⁴ U.S. Trade Policy Functions: Who Does What?, Congressional Research Service, Updated December 3, 2020 <<https://sgp.fas.org/crs/misc/IF11016.pdf>> хандсан 2021.10.13

⁴⁵ The Office of the U.S. Trade Representative <<https://ustr.gov/about-us/about-ustr>> хандсан 2021.10.13

АНУХТГ нь өөрсдийн хариуцсан чиглэлүүдийн хүрээнд худалдааны бодлогын зохицуулалтыг хийдэг. Үүнд:

- Худалдаа (хоёр талт, олон талт, бус нутгийн) болон хөрөнгө оруулалтын асуудлууд;
- Америкийн бараа, үйлчилгээний бусад зах зээлд нэвтрэх арга замуудыг өргөжүүлэх;
- Олон улсын бараа бүтээгдэхүүний тухай хэлэлцээр;
- АНУ-ын импортын бодлогод нөлөөлөх хэлэлцээрүүд;
- АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий систем (ХЕС);
- 1974 оны Худалдааны тухай хуулийн 301 дүгээр зүйлд үндэслэсэн гадаадын шударга бус худалдааны үйл ажиллагаатай холбоотой гомдол, 201 дүгээр зүйлд заасан импортын хөнгөлөлттэй холбоотой хэрэг, АНУ-ын дотоодын хуулийн 1377 дугаар зүйл болон 337 дугаар зүйлд үндэслэсэн хэргүүд;
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал зэрэг олон улсын байгууллагуудын зохицуулалттай худалдаа, шууд хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний тухай хэргүүд;
- Худалдаатай холбоотой оюуны өмчийг хамгаалах асуудлууд;
- Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-тай холбоотой асуудлууд.

АНУ-ын Худалдааны яам (*The U.S. Department of Commerce*)⁴⁶

Худалдааны яам нь хөдөө аж ахуйн бус худалдааны олон чиг үүргийг гүйцэтгэдэг.

- Олон улсын худалдааны газар (*International Trade Administration*) нь АНУ-ын экспортыг сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор зах зээлийн судалгаа, бизнесийн харилцаа холбоо болон бусад үйлчилгээг үзүүлдэг. Түүнчлэн “шударга бус” гадаад худалдааны үйл ажиллагааны АНУ-ын аж үйлдвэрийн салбарт үзүүлж болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах зорилгоор антидемпинг болон нөхөн төлбөрийн шалгалт явуулдаг бөгөөд гадаад улсууд АНУ-ын худалдааны хэлэлцээрт хэрхэн нийцэж буйг хянадаг.
- Үйлдвэрлэл, аюулгүй байдлын товчоо (*The Bureau of Industry and Security*) нь лиценз олгох, давхар ашиглалттай экспортын бараа бүтээгдэхүүнийг хянах үйл ажиллагаа эрхэлдэг. Түүнчлэн тодорхой импортын бараа бүтээгдэхүүн үндэсний аюулгүй байдалд хор хөнөөл учруулж байгаа эсэхийг шалгадаг (Худалдааг өргөжүүлэх тухай хуулийн 232 дугаар зүйлийн дагуу).
- Эдийн засгийн хөгжлийн газар (*The Economic Development Administration*) нь пүүсүүдэд зориулсан Худалдааг зохицуулах туслалцааны хөтөлбөрийг (Trade Adjustment Assistance) зохион байгуулдаг. Энэ нь пүүсүүдийг импортын өрсөлдөөн болон худалдааны либералчлалд дасан зохицоход дэмжлэг үзүүлдэг.
- Эдийн засгийн шинжилгээний товчоо (*The Bureau of Economic Analysis*) болон Тооллогын товчоо (*Census Bureau*) нь худалдааны мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийдэг.

АНУ-ын Хөдөө аж ахуйн яам (*The U.S. Department of Agriculture*)⁴⁷

Хөдөө аж ахуйн яам нь АНУ-ын хөдөө аж ахуйн худалдааг сурталчлах, зохицуулах болон АНУ-ын худалдааны хэлэлцээрт хөдөө аж ахуйн асуудалд оролцох үүрэгтэй.

- Амьтан, ургамлын эрүүл мэндийн хяналтын хэлтэс (*The Animal and Plant Health Inspection Service*) нь ургамал, амьтны хортон шавьж, өвчлөлийг АНУ-ын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлдэг.

⁴⁶ U.S. Department of Commerce <<https://www.commerce.gov>> хандсан 2021.10.13

⁴⁷ The U.S. Department of Agriculture <<https://www.usda.gov>> хандсан 2021.10.13

- Хүнсний аюулгүй байдал, хяналтын хэлтэс (The Food Safety and Inspection Service) нь АНУ-ын мах, шувуу, өндөгний бүтээгдэхүүнийг (үүнд импортын бүтээгдэхүүн багтана) хянадаг.
- Гадаадын хөдөө аж ахуйн хэлтэс (The Foreign Agricultural Service) нь АНУ-ын хөдөө аж ахуйн экспортын санхүүжилт, туслалцаа, хөдөө аж ахуйн импортын квот, тариаланчдад зориулсан Худалдааг зохицуулах туслалцааны хөтөлбөр зэргийг удирддаг.

АНУ-ын Төрийн департамент (The U.S. Department of State)⁴⁸

Төрийн департамент нь АНУ-ын худалдаа, эдийн засгийн харилцааг өөрийн товчоо, элчин сайдын яамдуудаар дамжуулан хянадаг. Төрийн департамент нь АНУХТ-ийн хамт АНУ-ын Хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээний хөтөлбөрийг удирддаг.

АНУ-ын Сангийн яам (The U.S. Department of Treasury)⁴⁹

Сангийн сайд нь Ерөнхийлөгчийн олон улсын эдийн засгийн бодлогын ахлах зөвлөх юм. АНУ-ын Сангийн яам нь АНУХТГ-ийн хамт худалдааны хэлэлцээрийн валютын заалт болон санхүүгийн үйлчилгээний талаарх хэлцлийг хариуцдаг. Түүнчлэн энэхүү яам нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй хөрөнгө оруулалтыг судалж, Гадаадын хөрөнгө оруулалтын комиссыг удирддаг бөгөөд Гадаад хөрөнгийн хяналтын газраар дамжуулан АНУ-ын хориг арга хэмжээг хэрэгжүүлдэг.

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын яам (The U.S. Department of Homeland Security)⁵⁰

ДАБЯ нь хууль ёсны худалдааг идэвхжүүлэхийн зэрэгцээ АНУ-ын хил хязгаарыг хамгаалахыг эрмэлздэг. ДАБЯ-ны Хил, гааль хамгаалалт нь АНУ-ын нэвтрэх боомтуудаар дамжин өнгөрөх бараа бүтээгдэхүүний урсгалыг зохицуулдаг. Түүнчлэн ДАБЯ нь хил дээр тариф хурааж, худалдааны хуулиудыг хэрэгжүүлдэг.

Экспорт-Импортын банк (Export-Import Bank)⁵¹

Экспорт-Импортын банк нь АНУ-ын дотоодын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор АНУ-ын бараа, үйлчилгээний экспортын санхүүжилт болон даатгалыг үйлчилгээ үзүүлдэг. Үүнийг хувийн хэвшлийнхэн хүсэхгүй, эсвэл хийх боломжгүй тохиолдолд олгохыг зорьдог; мөн гадаад орнуудын санал болгож буй санхүүжилтийг эсэргүүцэх зорилгоор.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (The U.S. Agency for International development)⁵²

Гадаадын тусламжийн агентлаг болох ОУХА нь АНУ болон хөгжиж буй орнуудын харилцаанд нөлөөлөх эдийн засгийн асуудлуудад хандаж ажилладаг. Хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой худалдааны чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг удирддаг.

АНУ-ын Худалдаа хөгжлийн агентлаг (The U.S. Trade and Development Agency)⁵³

ХХА нь хөгжиж буй орнуудад хэрэгжүүлж буй төслүүдийн экспортын боломжийг АНУ-ын пүүсүүдтэй холбож АНУ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой ажилладаг. Түүнчлэн техник эдийн засгийн үндэслэл, төсөл боловсруулах бусад үйл ажиллагаа, болон гадаад худалдан авагчдыг АНУ руу татах худалдааны урвуу үүрэг гэх мэт түншлэлийг бий болгох үйл ажиллагааг санхүүжүүлдэг.

⁴⁸ The U.S. Department of State <<https://www.state.gov>> хандсан 2021.10.13

⁴⁹ The U.S. Department of Treasury <<https://home.treasury.gov>> хандсан 2021.10.13

⁵⁰ The U.S. Department of Homeland Security <<https://www.dhs.gov>> хандсан 2021.10.13

⁵¹ Export-Import Bank <<https://www.exim.gov>> хандсан 2021.10.13

⁵² The U.S. Agency for International development <<https://www.usaid.gov>> хандсан 2021.10.13

⁵³ The U.S. Trade and Development Agency <<https://ustda.gov>> хандсан 2021.10.13

АНУ-ын Олон улсын худалдааны комисс (*The U.S. International Trade Commission*)⁵⁴

АНУ-ын ОУХК нь бие даасан агентлаг бөгөөд антидемпинг болон нөхөн төлбөрийн хэргүүд (Олон улсын худалдааны газрын хамт), “201 дүгээр зүйл” -ийн дагуу “шударга” арилжаалагдсан барааны импортын хэт их өсөлтөөс түр чөлөөлөх хамгаалалтын хэргүүд, АНУ-ын окууны өмчийн эрхийг зөрчсөн (“337 дугаар зүйл”) гэх хэргүүдийг тус тус шалгадаг. Тэд Конгресс, Ерөнхийлөгч, болон АНУХТГ-т зориулж худалдааны дүн шинжилгээ боловсруулдаг ба АНУ-ын тарифын хуваарийг хөтөлдөг.

Худалдааг дэмжих зохицуулах хороо (*The Trade Promotion Coordinating Committee*)⁵⁵

Худалдааг дэмжих зохицуулах хороо нь экспортыг дэмжих засгийн газрын агентлагуудыг зохицуулж, тэргүүлэх чиглэлийг тогтоох үүрэг бүхий агентлаг хоорондын хороо бөгөөд Ерөнхийлөгчид экспортыг дэмжих нэгдсэн төсвийг танилцуулдаг. Засгийн газрын худалдааг дэмжих үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, экспортлогчдод илүү сайн туслах зорилгоор экспорттой холбоотой хөтөлбөр хэрэгжүүлдэг дээр дурдсан 20 гаруй Засгийн газрын яам, агентлагуудыг нэгтгэдэг.

Экспортыг дэмжих арга хэмжээ

Экспортын тусламжийн үйлчилгээ: АНУ-ын засгийн газар экспортлогчдод худалдаатай холбоотой мэдээллийг түгээх, гадаад орны зах зээлийн судалгаа хийх, шинэ болон туршлагатай экспортлогчдод зөвлөгөө өгөх зэрэг экспортын тусламжийн үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн, засгийн газар нь бизнесүүдийг хооронд нь тохируулах үйлчилгээ эрхэлдэг бөгөөд үүнд худалдааны асуудлаарх ажлын айлчлалууд (АНУ-ын Засгийн газрын өндөр албан тушаалтнуудын удирдлага дор гадаад улс орнуудад бизнесийг хөгжүүлэх зорилготой томилолтууд) болон зочид, төлөөлөгч хүлээн авах (АНУ-д гадаадын худалдан авагчдыг авчирч АНУ-ын пүүсүүдтэй уулзуулах) багтдаг. Экспортын шууд тусламжийг олгодог гол агентлагуудад АНУ-ын Хөдөө аж ахуйн яам, Худалдааны яам, Төрийн департамент, Жижиг үйлдвэрийн захиргаа болон Худалдаа хөгжлийн агентлаг багтдаг.

Техник эдийн засгийн үндэслэл: АНУ-ын Засгийн газар АНУ-ын бараа, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх боломжтой гадаад орнуудад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн эдийн засаг, санхүү, техникийн болон бусад асуудлуудад үнэлгээ хийх техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулдаг (АНУ-ын Хөгжлийн агентлаг болон Худалдаа хөгжлийн агентлаг гүйцэтгэнэ).

Экспортын санхүүжилт ба даатгал: АНУ-ын Засгийн газрын агентлагууд хэд хэдэн шалтгааны улмаас гадаад улс орнууд руу чиглэсэн экспортын үйл ажиллагааг санхүүжүүлж, даатгаж болно. Үүнд:

- экспортлогч эсвэл хувийн санхүүгийн байгууллагууд ганцаараа үүрэх боломжгүй арилжаа, улс төрийн эрсдэлийг хүлээх;
- хувийн хэвшлийн экспортын санхүүжилтийн хугацаа болон бусад хязгаарлалтыг даван туулах;
- тухайн улсын засгийн газрын дэмжлэгтэй экспортын зээлийн санхүүжилтийг эсэргүүцэх. АНУ-ын Хөгжлийн агентлаг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын санхүүжилтийг хариуцдаг бол Экспорт, импортын банк нь хөдөө аж ахуйн бус экспортын санхүүжилт, даатгалыг хариуцах агентлаг юм.

Засгийн газар хоорондын сурталчилгаа: Ихэнх тохиолдолд АНУ-ын компаниуд илүү их хэмжээний гадаадын санхүүжилт, татаас болон засгийн газрын бусад хэлбэрийн дэмжлэгтэй гадаадын аж ахуйн нэгжүүдийн шууд өрсөлдөөнтэй тулгардаг. АНУ-ын компаниудыг экспортын зах зээл дээрх гадаадын өрсөлдөгч нартай адил хэмжээний

⁵⁴ The U.S. International Trade Commission <<https://www.usitc.gov>> хандсан 2021.10.13

⁵⁵ The Trade Promotion Coordinating Committee <<https://www.trade.gov/tppc>> хандсан 2021.10.13

боломжоор хангахын тулд АНУ дипломат хэрэгслүүдийг ашиглах боломжтой. Үүнд оролцох гол агентлагууд нь Худалдааны яам, Төрийн Департамент болон АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар юм.

2.2. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС

2019 оны байдлаар Польш Улс ДНБ-ний хэмжээгээр дэлхийд 21-р байранд, нийт экспортын хэмжээгээр 22-т, нийт импортын хэмжээгээр 18-т, нэг хүнд ногдох ДНБ-ээр 57-д, эдийн засгийн цогц байдлын индекс⁵⁶ (Economic Complexity Index-ECI)-ээр 23-т тус тус жагсаж байна.

Импортын дийлэнх хувийг Европын Холбооны гишүүн орнууд болох Герман, Итали, Нидерланд, Франц, Чех зэрэг томоохон түншүүдтэй эрхэлдэг худалдаа бүрдүүлдэг. Харин Европын Холбооны гишүүн бус худалдааны гол түншүүд нь ОХУ, БНХАУ бөгөөд нийт импортын 20 орчим хувийг бүрдүүлж байна.

ЕХ нь худалдааны нэг бүс учир ЕХ-ны гишүүн улсад үйлдвэрлэсэн, эсхүл гаднаас импортолсон бүх бараа (цөөн тооны бараа үүнд хамаарахгүй) чөлөөтэй эргэлдэж болно. ЕХ-ны гишүүн улсуудын гаалийн байгууллагууд нь хил дээр бараа шалгах эрхтэй боловч ЕХ-нд үйлчилдэг нэгдсэн гаалийн хуулиар ЕХ-ны доторх бүх хураамж, саад бэрхшээлийг арилгасан.


ЕХ-ны гаднаас импортолсон бараа бүтээгдэхүүнд тариф ногдуулдаг.

Холбооны гаалийн код⁵⁷ нь ЕХ ба ЕХ-ны гишүүн бус орнуудын хоорондох бараа бүтээгдэхүүний худалдаанд хамааралтай бүх ерөнхий дүрэм, журмыг агуулдаг. Кодыг бүх гишүүн улсад шууд мөрдөгдөх Гаалийн газрын нарийвчилсан журам дагалдана.

Импортын хэмжээ, зарим гол нэрийн бараа: Польш Улсын импортын дийлэнхийг автомашин (11.4 тэрбум ам.доллар), түүхий нефть (10 тэрбум ам.доллар), тээврийн хэрэгслийн эд анги (9.01 тэрбум ам.доллар), савласан эм (5.21 тэрбум ам.доллар), өргөн нэвтрүүлгийн төхөөрөмж (5.11 тэрбум ам.доллар) зэргийг гол төлөв ХБНГУ (69.6 тэрбум ам.доллар), БНХАУ (26.9 тэрбум ам.доллар), Итали (14.9 тэрбум ам.доллар), Нидерланд (13.1 тэрбум ам.доллар), ОХУ (11.8 тэрбум ам.доллар)-аас импортлодог байна.

2019 онд Польш Улс нь дээврийн хавтан (80.3 сая ам.доллар), хаягдал цагаан тугалга (26.6 сая ам.доллар)-ын дэлхийн хамгийн том импортлогч улс болжээ.⁵⁸

Импортын хязгаарлалт: ЕХ-ны гишүүн улсын хувьд Польш Улс нь импортын хувьд хүрээлэн буй орчин, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн, ургамал, амьтны эрүүл мэндийг хамгаалахтай холбоотойгоор дараахыг хориглодог. Үүнд: зохиогчийн эрхийн зөрчилтэй, эсхүл хуурамч бараа, зарим химийн бүтээгдэхүүн, генийн өөрчлөлттэй организм, амьд амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүн орж байна.⁵⁹



⁵⁶ Харвардын Их Сургуулийн профессор Рикардо Хаусман, MIT сургуулийн профессор Хидалго нарын боловсруулсан "Эдийн засгийн цогц байдлын индекс" (Economic Complexity Index). Энэхүү индекс тухайн улсын экспортын цогц байдлын түвшинг үнэлдэг. Тус индекс нь өөрийн стандарттай байх ба утга нь 0 байвал хөгжлийн түвшин нь дэлхийн түвшинтэй адил, эсхүл утга 1 (-1) байвал дэлхийн дунджаас дээгүүр (доогуур) байна гэж үзнэ. Төрөлжилтийн түвшин өндөр байх тусам эдийн засаг төдий хэмжээний нарийн цогц бүтэцтэй байна гэсэн үг юм. Төрөлжилтийн боломжит утга бүрд эдийн засгийн цогц байдлын үзүүлэлт ялгаатай байдаг.

⁵⁷ Regulation (EC) No. 450/2008 of the European Parliament and of the Council of 23 April 2008 laying down the Community Customs Code (Modernised Customs Code) <<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=LEGISSUM%3Aado0001>>

⁵⁸ Observatory of Economic Complexity, <<https://oec.world/en/profile/country/pol>>

⁵⁹ Doing business in Poland 2016, HSBC

<<https://www.business.hsbc.com.cn/-/media/library/markets/poland/pdf/poland-countryguide.pdf>>
<<https://www.trade.gov/knowledge-product/poland-trade-barriers>>

2.2.1. Эрх зүйн зохицуулалт

Эрх зүйн зохицуулалтын хувьд БНПУ-д худалдааны асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй. Тус улсад зөвшөөрөгдсөн бизнесийн хэлбэрийг 2000 онд баталсан **Худалдааны компаниудын тухай хууль**⁶⁰-иар зохицуулж байна. Тус хуулиар худалдааны компани, түүний хэлбэр, эрх зүйн байдал, худалдааны компани байгуулах, нэгтгэх, нийлүүлэх, хуваах өөрчлөх байгуулах, мөн хууль зөрчигчид хариуцлага ногдуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

БНПУ нь 2004 онд Европын холбоо (ЕХ)-нд нэгдэн орсон бөгөөд гишүүн улсын хувьд компани байгуулах журам нь Польш Улсын иргэн болон ЕХ болон Европын эдийн засгийн бүсийн Европын чөлөөт худалдааны холбоо (ЕЧХХ)-ны гишүүдэд нэгэн адил үйлчилнэ.

Польш Улсад дараах бизнесийн эрх зүйн хэлбэрүүд нь ЕХ, ЕЧХХ-ын хөрөнгө оруулагчид болон Польш Улсад оршин суух журмаар зохицуулагдсан этгээдэд нээлттэй байдаг.

- Ганцаар өмчлөл;
- Иргэний нөхөрлөл – хамтарсан хөрөнгө оруулалтын төсөл, эсхүл консорциумууд;
- Бүртгэлтэй нөхөрлөл;
- Хязгаарлагдмал нөхөрлөл;
- Мэргэжлийн нөхөрлөл;
- Хязгаарлагдмал хувьцаат нөхөрлөл;
- Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
- Хувьцаат компани;
- Европын компани;
- Европын эдийн засгийн сонирхлын бүлэг;

Түүнчлэн, гадаадын бизнес эрхлэгчид Польш Улсад салбар, эсхүл төлөөлөгчийн газар хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно.

Ням гарагт бүх төрлийн худалдааг хориглох тухай хууль⁶¹ нь 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Польш Улсад хэрэгжиж эхэлсэн.

Польшийн Католик сүм болон Польшийн үйлдвэрчний эвлэлийн санаачилсан уг хууль нь дэлгүүр, үйлчилгээний газруудын ажилчид Ням гарагт бусдын адил амрах эрхтэй гэх үзэл дээр хэрэгжиж байгаа бөгөөд иргэдийн гэр бүлдээ зарцуулах цагийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Уг хуулиар тогтоосон хязгаарлалтыг 3 жилийн турш шат дараатайгаар нэвтрүүлж байгаа бөгөөд 2018 оноос сар бүрийн хоёр Ням гарагт худалдаа хийхийг, 2019 оноос гурван Ням гараг, 2020 оноос бүх Ням гарагуудад худалдаа хийхийг хоригложээ. Ингэхдээ зөвхөн Зул сарын баяр, Улаан өндөгний баяр зэрэг нийт 7 баярын үеэр таарсан Ням гарагуудад худалдааны газрууд ажиллах юм.

Харин нисэх онгоц болон галт тэрэгний буудал, ШТС дахь дэлгүүр, ТҮЦ, ресторан, эмийн сан, цэцгийн дэлгүүр, талх, нарийн боовны дэлгүүр болон шуудангийн газар, салбаруудад дээрх хууль үйлчлэхгүй юм.

2.2.3. Экспортыг дэмжихэд чиглэсэн бодлого, бүтэц зохион байгуулалт

Балтын тэнгисийн орнуудын хувьд экспортыг дэмжихэд чиглэсэн бодлогууд нь гол төлөв эдийн засгийн хямралын дараа буюу 2011-2012 онуудад боловсруулагдсан байна. Польш Улсын хувьд экспортыг дэмжих бодлого нь үндэсний брендийг хөгжүүлэх, эдийн засаг худалдааны

⁶⁰ Law Of 15 September 2000, The Code Of Commercial Companies, Poland
<<https://www.global-regulation.com/translation/poland/2986292/law-of-15-september-2000%252c-the-code-of-commercial-companies.html>>

⁶¹ <https://www.statista.com/topics/5173/sunday-trading-ban-in-poland/>

хамтын ажиллагааны төрийн айлчлал, гадаад зах зээлүүдийн талаарх мэдээллээр Польшийн компаниудыг хангах, санхүүгийн арга хэрэгсэл гэх 4 үндсэн хүрээнд явагдаж байсан бол 2016 онд гадаад дахь Польш компаниудад дэмжлэг үзүүлэх чиглэл ерөнхий өсөлтийн стратегийн 5 дахь чиглэл болон нэмэгдсэн байна.⁶² Мөн дээрх чиглэлүүд нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан 2017 онд баталсан “Хариуцлагатай хөгжлийн стратеги”⁶³-ийн баримт бичигт тусгагдсан байна.

Дээр дурдсан хямралын дараах бодлогууд нь ЕХ-ны гишүүн бус зах зээлүүд рүү чиглэгдэж байгаагаар онцлог байна. Польш Улсын хөгжлийн бодлогод Ази, Африк, Америкийн шинэ зах зээлүүдийг онцолсон бөгөөд ЕХ-ны гишүүн бус зах зээл дотор БНХАУ хамгийн чухал байр суурийг эзэлж байна.

Хэрэгжүүлж буй бодлогуудтайгаа уялдуулан улс орнууд институц, бүтэц зохион байгуулалтын хувьд мөн томоохон өөрчлөлт шинэчлэлтүүдийг хийсэн байна. Тухайлбал, Польш Улс нь Дэд бүтэц, бүс нутгийн хөгжлийн яам болон Эдийн засгийн яамыг хэсэгчлэн нэгтгэн Хөгжлийн яамыг 2015 онд байгуулсан (2018 оноос Хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн яам), мөн өмнө олон яам, агентлагт худалдаатай холбоотой чиг үүрэг хэрэгжүүлж байсныг нэгтгэн 2016 онд Хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн яамны дэргэд **Польшийн Хөгжлийн санг** байгуулсан байна. Тус сан нь Аж үйлдвэрлэлийн хөгжлийн агентлаг, Үндэсний Аж ахуйн банк, Экспортын зээлийн даатгалын корпорац, Польшийн Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг, мөн Польшийн Аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх агентлагуудын үйл ажиллагааг уялдуулах, зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.

Польшоос гадна Европын Холбооны орнууд ч гэсэн экспортыг дэмжсэн бодлого, хариуцсан агентлаг, санхүүжүүлэгч байгууллагатай байгаа юм. Доорх хүснэгтэд зарим орнуудын талаарх мэдээллийг оруулав.

Хүснэгт 7. Зарим ЕХ-ны гишүүн орны экспортод чиглэсэн бодлого, институц

Улсын нэр	Засгийн газраас экспортыг дэмжихэд чиглэсэн бодлого	Хариуцсан бүтэц, агентлаг	Санхүүжүүлэгч байгууллага (Экспортын зээлийн агентлаг)
Испани	Испанийн эдийн засгийг олон улсын болгох хөтөлбөр	ICEX	CESCE, ICO
Латви	Тусдаа стратеги байхгүй, Үйлдвэрлэлийн хөгжлийн стратегийн нэг хэсэг	LIAA	ALTUM
Литва	Экспортын хөгжил 2016-2020	INVEGA	INVEGA
Польш	Шинэ хөгжлийн стратеги 2016	Польшийн хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг	Польшийн экспортын зээлийн даатгал, батлан даалтын корпорац (KUKE)
Португал	Олон улсын хөтөлбөр	AICEP	COSEC
Словак	Гадаад эдийн засгийн харилцааны стратеги 2014-2020	SARIO	Eximbanka
Унгар	“Дорнодын нээлт”	HIPA, Худалдааны төв	Exim
Чех	Экспортын стратеги 2012-2020	Czech-Trade	CEB, EGAP
Эстони	EAS Strategy 2015–2018	EAS	KredEx

Эх сурвалж: <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=LEGISUM%3A0001>

⁶² Йттетö, Andrea & Antalyczy, Katalin. (2017). Export Promotion Aims and Reality: A Comparison of the Iberian, Baltic and Central European Region. Baltic Journal of European Studies. <https://www.researchgate.net/publication/318396765_Export_Promotion_Aims_and_Reality_A_Comparison_of_the_Iberian_Baltic_and_Central_European_Region> хандсан 2021.08.23

⁶³ The Strategy for Responsible Development for the period up to 2020 (including the perspective up to 2030) – SRD, <https://www.gov.pl › SOR_2017_streszczenie_en> хандсан 2021.10.13

Польшийн хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг-ПХОХА⁶⁴ (*The Polish Investment and Trade Agency*) нь Польшийн бизнесийн гадаад тэлэлт болон Польш руу шууд хөрөнгө оруулалтын урсгалыг дэмжиж чиг үүргийг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг юм. Тус агентлаг нь анх 1992 онд Гадаад хөрөнгө оруулалтын агентлаг нэртэйгээр байгуулагдаж, 2003 онд Польшийн мэдээллийн агентлагтай нэгдэж Польшийн мэдээлэл, гадаад худалдааны агентлаг болсон. Улмаар 2017 онд нэрээ өөрчлөн ПХОХА болсон. ПХОХА нь Польшийн Хөгжлийн сангийн групптэй хамтран ажилладаг бөгөөд Хөгжил, хөдөлмөр, технологийн яаманд харьяалагддаг.

Агентлаг нь мөн Польшийн экспортыг нэмэгдүүлэх зорилготой юм. Бизнес эрхлэгчдийг дэмжиж тодорхой төслүүдтэй холбоотой захиргааны болон хууль эрх зүйн хүндрэл, чирэгдлийг даван туулахад дэмжлэг үзүүлдэг бөгөөд хууль эрх зүйн шийдлүүдийг боловсруулж, тохиромжтой байршил, найдвартай түнш, ханган нийлүүлэгчдийг хайж олоход тусалдаг.

Агентлаг нь инновацлаг жижиг, дунд үйлдвэрийг өргөжүүлэхэд чиглэсэн “Польшийн техникийн гүүрүүд” зэрэг экспортыг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлдэг. Польшийн тэргүүлэх салбаруудтай идэвхтэй хамтран ажиллаж, шинэ зах зээлд хөгжихийг хүсч буй Польшийн компаниудад дэмжлэг үзүүлдэг.

ПХОХА нь гадаадад байршиж буй Польшийн бизнес эрхлэгчдэд шууд туслалцаа үзүүлэх зорилгоор дэлхийн өнцөг булан бүрт дэмжлэг үзүүлэх сүлжээг бий болгож, дэлхийд нийтдээ 70 офис байгуулах юм. ПХОХА-ийн Гадаад Худалдааны офисууд нь гадаадад шинэ боломж хайж буй Польшийн экспортлогч, хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, Польшийн компаниудын хурдацтай өсөж болохуйц алслагдсан зах зээл дээр төвлөрөн ажилладаг.

Экспортын консалтингийн үйлчилгээний хүрээнд дараах, үйл ажиллагаа явуулж, үйлчилгээ үзүүлдэг байна:

- Экспортын боломжит байдлын шинжилгээ;
- Мэдээллийн багц бэлтгэх;
- Сонгосон зах зээлд тэлэх стратеги боловсруулах;
- Боломжит бизнесийн түншүүдийн жагсаалтыг бэлтгэх;
- Бизнесийн түншүүдийн баталгаажуулалт;
- B2B уулзалтуудыг зохион байгуулах;
- Бизнес эрхлэгчдийн 2 талт уулзалтыг зохион байгуулах;
- Төрийн байгууллагуудтай холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх;
- Сургалт зохион байгуулах.

Нэмэлт үйлчилгээ:

- Гадаадад байгаа оффисын өрөө.
- Варшав дахь хурлын төв, албан тасалгааны түрээс.

Польш Улсаас гадаад улсад суугаа ДТГ:⁶⁵ ПХОХА-ийн офисуудаас гадна Польш Улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд (ДТГ)-д худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих үүрэг бүхий нэгжүүд ажилладаг. Эдгээр нэгжүүд нь Эдийн засгийн яаманд харьяалагдах бөгөөд гол төлөв жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихээс гадна Польш бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах, тус улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой гадаадын компаниудад дэмжлэг үзүүлдэг.

⁶⁴ The Polish Investment and Trade Agency, <https://www.paih.gov.pl/about_us/paih> хандсан 2021.10.13

⁶⁵ Polska export promotion portal <<https://www.trade.gov.pl/en/invest-in-poland/help-for-importers/supporting-institutions/1987.supporting-institutions.html>> хандсан 2021.08.23

Эдийн засгийн онцгой бүс гэж (ЭЗОБ)⁶⁶ 1994 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Эдийн засгийн онцгой бүсийн тухай хуульд заасны дагуу эрх зүйн хөнгөлөлттэй нөхцөлөөр бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болох тус улсын нутаг дэвсгэрийн хүн ам оршин суудаггүй, тусгаарлагдсан хэсгийг хэлнэ гэж заажээ.

Эдийн засгийн тусгай бүсүүдийг дараах зорилгоор байгуулна.

- бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг хурдасгах;
- пост-индустриал өмч, дэд бүтцийг удирдах;
- шинэ ажлын байр бий болгох;
- гадаадын хөрөнгө оруулагчдыг Польш руу татах.

БНПУ-д нийт 14 эдийн засгийн онцгой бүс байгаа бөгөөд тэдгээрт:

- Орлогын албан татвараас чөлөөлөх;
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлөх;
- Хөрөнгө оруулалтын зорилгоор өрсөлдөхүйц үнээр бэлтгэсэн талбай;
- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой үнэгүй дэмжлэг зэрэг дэмжлэг, чөлөөлөлтүүдийг олгодог байна.

2.3. БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС

2019 оны байдлаар Вьетнам Улс ДНБ-ний хэмжээгээр дэлхийд 44-р байранд, нийт экспортын хэмжээгээр 20-т, нийт импортын хэмжээгээр 20-т, нэг хүнд ногдох ДНБ-ээр 134-д, эдийн засгийн цогц байдлын индекс (*Economic Complexity Index – ECI*)-ээр 65-т тус тус жагсаж байна.⁶⁷

Импортын хэмжээ, зарим гол нэрийн бараа: Вьетнам Улсын импортын дийлэнхийг микросхем (27.1 тэрбум ам.доллар), телефон утас (13.7 тэрбум ам.доллар), цэвэршүүлсэн нефть (6.92 тэрбум ам.доллар), хөнгөн резинэн сүлжмэл даавуу (5.3 тэрбум ам.доллар), хагас дамжуулагч төхөөрөмж (4.38 тэрбум ам.доллар) зэргийг ихэвчлэн БНХАУ (91.1 тэрбум ам.доллар), БНСУ (47.8 тэрбум ам.доллар), Япон (16.3 тэрбум ам.доллар), Тайланд (11.8 тэрбум ам.доллар), Тайвань (11.4 тэрбум ам.доллар)-аас импортолдог байна.

2019 онд Вьетнам Улс нь хөнгөн резинэн сүлжмэл даавуу (5.3 тэрбум ам.доллар), синтетик судалтай утас нэхмэл даавуу (2.24 тэрбум ам.доллар), наргил модны самрын дэлхийн хамгийн том импортлогч улс болжээ.

Экспортын хэмжээ, зарим гол нэрийн бараа: Экспортын хувьд өргөн нэвтрүүлгийн төхөөрөмж (42.3 тэрбум ам.доллар), (телефон) утас (18.2 тэрбум ам.доллар), микросхем (15.5 тэрбум ам.доллар), нэхмэл гутал (10.6 тэрбум ам.доллар), арьсан гутал (6.43 тэрбум ам.доллар) зэрэг нь гол нэрийн барааг бүрдүүлдэг бөгөөд ихэнх тохиолдолд АНУ (63.7 тэрбум ам.доллар), БНХАУ (50.3 тэрбум ам.доллар), Япон (21.2 тэрбум ам.доллар), БНСУ (20.3 тэрбум ам.доллар), ХБНГУ (8.22 тэрбум ам.доллар) руу тус тус экспортолдог байна.

2019 онд Вьетнам Улс нь кокос, бразил самар, кешью (3.16 тэрбум ам.доллар), түлш мод (2.05 тэрбум ам.доллар), цемент (1.39 тэрбум ам.доллар), металаар бүрсэн бүтээгдэхүүн (1.37 тэрбум ам.доллар), шанцай (175 сая ам.доллар)-н дэлхийн хамгийн том экспортлогч улс болсон байна.

⁶⁶ <https://www.paih.gov.pl/why_poland/Polish_Investment_Zone>, A guide to special economic zones in Poland, <https://www.paih.gov.pl/files/?id_plik=10800> хандсан 2021.08.23

⁶⁷ Observatory of Economic Complexity <<https://oec.world/en/profile/country/vnm>> хандсан 021.08.23

2.3.1. Эрх зүйн зохицуулалт

Вьетнам Улсад гадаад худалдаатай холбоотой асуудлыг “Гадаад худалдааны удирдлагын тухай хууль”⁶⁸-иар зохицуулж байна. Уг хуулийг Вьетнам Улсын Үндэсний Ассамблейгаас 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдөр баталж, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Хууль нь гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмуудыг стандартчилах, демпингийн эсрэг/ хамгаалалтын арга хэмжээг төвлөрсөн механизмын дор авчрахад чиглэсэн байна. Хууль хүчин төгөлдөр болсноор демпингийн эсрэг болон хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой өмнө мөрдөж байсан хэд хэдэн хууль тогтоомжууд хүчингүй болсон байна.

Бүтцийн хувьд Гадаад худалдааны удирдлагын тухай хууль нь 8 бүлэг, 113 зүйлээс бүрдэх бөгөөд дараах бүтэцтэй байна.

Хуулийн зохицуулалтын хамрах хүрээ: Энэ хууль нь гадаад худалдааг удирдах, гадаад худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх холбоотой арга хэмжээ, мөн гадаад худалдааны үйл ажиллагааг ашиглахтай холбоотой маргааныг шийдвэрлэх асуудлыг хамарна.

Хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгохоор заасан байна. Үүнд:

1. *Гадаад худалдааны үйл ажиллагаа* гэж экспорт, импортын хэлбэрээр хийгддэг олон улсын бараа худалдан авах, худалдах үйл ажиллагааг; ре-экспортын зорилготой түр импорт; ре-импортлох зорилготой түр экспорт; хилээр нэвтрүүлэх; транзит мөн хууль болон БНСВУ-ын олон улсын гэрээнд заасны дагуу олон улсын бараа бүтээгдэхүүн худалдан авах, худалдахтай холбоотой бусад үйл ажиллагааг;
2. *Техникийн арга хэмжээ* гэж бүтээгдэхүүн, барааны чанар, стандарт, техникийн зохицуулалт, хүнсний аюулгүй байдал, хэмжилтийн тухай хууль тогтоомжийн дагуу экспорт, импортод хэрэгжүүлэх арга хэмжээг;
3. *Хорио цээрийн арга хэмжээ* гэж ургамал хамгаалал, хорио цээр, амьтны эрүүл мэнд, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуульд заасан амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүний хорио цээр, ургамлын хорио цээр, хилийн эрүүл мэндийн хорио цээрийн арга хэмжээг;
4. *Гаалийн онцгой бүс* гэж Вьетнам Улсын хууль тогтоомж, БНСВУ-ын олон улсын гэрээнд заасны дагуу Вьетнамын нутаг дэвсгэрт дахь газарзүйн бүсийг хэлнэ. Энэ бүсэд гадаад улстай бараа худалдах, солилцох ажлыг экспорт, импортын үйл ажиллагаа гэж үзнэ.
5. Вьетнам Улсад оршин суудаггүй гадаад худалдаа эрхлэгч гэж Вьетнам Улсад хөрөнгө оруулалт, худалдаа, аж ахуйн нэгжийн тухай хууль тогтоомжид заасан хэлбэрээр хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй, мөн Вьетнамд төлөөлөгчийн газар, салбаргүй гадаадын худалдаа эрхлэгчийг хэлнэ гэж тус тус заажээ.

⁶⁸ Law On Foreign Trade Management < <http://vbpl.vn/TW/Pages/vbpgen-toanvan.aspx?ItemID=11096>> хандсан 2021.08.23

Хүснэгт 8. БНСВУ-ын Гадаад худалдааны удирдлагын тухай хуулийн бүтэц, агуулга

Бүлэг	Бүлгийн нэр	Тайлбар ⁶⁹
I	Нийтлэг үндэслэл	Гадаад худалдааны үйл ажиллагааны тодорхойлолт, Вьетнам дахь дотоод болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн импорт, экспортын эрхийг тодорхойлох.
II	Захиргааны арга хэмжээ	Бараа импортлох, экспортлохыг хориглох, түдгэлзүүлэх, тарифын квот, гарал үүслийн гэрчилгээ, ре-импорт/ре-экспорт, дамжин өнгөрөх, шилжүүлэн ачих гэх мэт.
III	Техникийн болон хорио цээрийн арга хэмжээ	Вьетнам Улсаас импортлож, экспортолж буй барааны чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар
IV	Худалдааны хамгаалалтын арга хэмжээ	Демпингийн эсрэг, хамгаалалт, татаасаас хамгаалах арга хэмжээг нэг дээвэр дор авчрах
V	Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь онц байдлыг хянах арга хэмжээ	Гадаад худалдаан дахь гео-политикийн асуудлыг шийдвэрлэх
VI	Гадаад худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ	Зээлийг хөнгөвчлөх, худалдааг дэмжих гэх мэт.
VII	Гадаад худалдааны удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой маргааныг шийдвэрлэх	Бусад улстай олон улсын худалдааны маргааныг шийдвэрлэх
VIII	Хэрэгжүүлэх заалт	Хуулийн төсөл хэрэгжиж эхлэх огноо, өөрчлөгдсөн захирамжууд, шилжилтийн заалтууд

Эх сурвалж: Law on Foreign Trade Management

2.3.2.Экспортыг дэмжихэд чиглэсэн бодлого, бүтэц зохион байгуулалт

Вьетнам Улс нь 2011 онд Экспорт, импортын 2011-2020 оны стратеги, 2030 он хүртэлх Алсын хараа⁷⁰ үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь экспорт, импортыг төрөлжүүлэн хөгжүүлэх, зах зээлийн тогтвортой байдлыг хангах, стратегийн түншлэлийг бий болгон бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн бүтэц, шинэчлэлийг сайжруулах, худалдааны тэнцвэрийг хангах, улс орны ойрын болон урт хугацааны төлөвлөгөөнд эдийн засаг, улс төр-дипломатын ашиг сонирхлыг уялдуулах, олон улсын эдийн засгийн интеграцид бие даах чадварыг хөгжүүлэхэд ач холбогдолтой. Хөтөлбөрт дараах зорилт, чиглэлүүдийг тусгасан байна. Үүнд:

Экспортын чиглэл⁷¹

- Экспортын өсөлтийн тогтвортой хөгжүүлэх, экспортын нэмүү өртгийг сайжруулж, хамрах хүрээг өргөжүүлэх;
- Экспортын бүтцийг үйлдвэржилтийн шинэчлэл рүү чиглүүлж, нэмүү өртөгтэй, сайн боловсруулсан бүтээгдэхүүн, өндөр технологийн болон байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх.

Зах зээлийн хөгжлийн чиг хандлага

- Экспортын зах зээлийг төрөлжүүлэх, Вьетнам Улсын байр суурийг нэгтгэх, өргөжүүлэх, экспортын шинэ, боломжит зах зээлийг өргөжүүлэхэд амжилтыг гаргах;
- Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад Вьетнам Улсын гүйцэтгэх үүрэг, статусыг тодруулах, экспортын зах зээлийг өргөтгөх эдийн засгийн дипломат үйл ажиллагаа, худалдааг дэмжих, агентлагуудын сүлжээг хөгжүүлэх;

⁶⁹ Law on Foreign Trade Management, AHTN 2017 Implementation, and recent developments in trade and customs KPMGT&C Q3/2017 Newsletter, September 2017, <<https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2017/10/tmf-vietnam-oct9-2017.pdf>> хандсан 2021.08.23

⁷⁰ <https://assets.kpmg/content/dam/kpmg/vn/pdf/publication/2021/Investing-in-Vietnam-Mar2021.pdf>

⁷¹ <http://chinphu.vn/portal/page/portal/English/strategies/strategiesdetails?categoryId=30&articleId=10051303>

- Экспортыг нэмэгдүүлэх, Вьетнамын чөлөөт худалдааны гэрээнд экспортын үр ашгийг дээшлүүлэхийн тулд гадаад зах зээлийг боломжийг нээх, тарифын хөнгөлөлтийг бүрэн ашиглах;
- Вьетнамын бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулах, сүлжээг зохион бүтээх, хөгжүүлэх;
- 2020 он гэхэд зах зээлийн бүтэц: Ази 46%, Европ 20%, Америк 25%, Далайн орнууд /Oceania/ 4%, Африк 5% хувь болгох.

Импортын бодлого

- Экспортын үйлдвэрлэлийн материал, түлшний үйлдвэрлэлийг дэмжиж, импортын өсөлт, дотоодын хэрэгцээг хангах, дэмжих үйлдвэрүүдийг хөгжүүлэх, импорт, экспортын хэмжээнээс давсан хэмжээг бууруулах зорилгоор импортыг хатуу хянах.
- Улсын нөөц, үйлдвэрлэлийн хэмжээ, түвшинтэй уялдуулан машин, тоног төхөөрөмж, өндөр технологийг импортлох; эрчим хүч, материал хэмнэх; дотоодын үйлдвэрлэл, ашиглалт үр дүн муутай, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй материал, түлш ашигладаг үйлдвэрлэлийн салбарт импортыг тогтвортой хангах/импортоор орлуулах;
- Импортын зах зээлийг төрөлжүүлэх, Вьетнамын импорт экспортын хэмжээнээс давсан байгаа газарт худалдааны тэнцвэрийг хангаж, сайжруулах.

Импортыг хянах

- Вьетнамын бараа, бүтээгдэхүүн хөрөнгө оруулалтын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, дотоодын хэрэгцээнд зориулан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжихийн сацуу үйлдвэрлэлийн бус салбарын хөрөнгө оруулалтыг багасгах, өрсөлдөхүйц давуу талтай бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Дотоодын эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэлийн стандарт, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, худалдааны тэнцвэрийг зохих түвшинд хангах хангахад Засгийн газрын түвшинд худалдааны түншүүдтэй хэлэлцээ хийж, гэрээ байгуулах;
- Дотоод худалдааг дэмжих үйл ажиллагааг дэмжих, ингэхдээ машин, тоног төхөөрөмж, материал үйлдвэрлэгч болон тухайн бүтээгдэхүүн хэрэглэгчдийг хооронд нь холбох, төсвийн хөрөнгөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авахад дотоодод үйлдвэрлэсэн барааг нэмэгдүүлэх;
- Байгаль орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй чанаргүй барааны импортод хяналт тавих зорилгоор олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу барааны техникийн стандартыг батлах;
- Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын дүрэм, олон улсын үүрэг хариуцлагын дагуу импортын менежментийг чангатгах.

Засгийн газар гадаад худалдааны нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.⁷² Үйлдвэр, худалдааны яам нь гадаад худалдааны удирдлагыг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Гадаад худалдааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хөгжүүлэх, бүс нутгийн болон дэлхийн зах зээлийг хөгжүүлэх, эдийн засгийн интеграцчилах талаар баримтлах стратеги, төлөвлөгөө, бодлогыг хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

Сангийн яам нь экспорт, импортын татвар, хураамжийн талаар хууль эрх зүйн хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд холбогдох байгууллагуудтай уялдуулан боловсруулж, эрх бүхий байгууллагын хэрэгжилтэд хяналт тавих, гадаад худалдааны менежментийн талаар хууль тогтоомж, бодлогыг боловсруулахдаа холбогдох яам, агентлаг,

⁷² <http://trade.ec.europa.eu/doclib/press/index.cfm?id=1437>

байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллах, гаалийн байгууллагад хяналт шалгалт хийх, гаалийн хуулийн дагуу экспорт, импортын статистикийг бүрдүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Яам, агентлагууд үүрэг, эрх мэдлийнхээ хүрээнд гэрээ хэлэлцээр хийх, түншүүд хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавих, экспортод тулгарч буй саад бэрхшээлийг бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцах, зохицуулах, гадаад худалдааг удирдах, үйл ажиллагааг хуулийн дагуу хөгжүүлэх, гадаад худалдааны үйл ажиллагаа, менежментийг удирдах үүргийг хүлээнэ.



**ХАВСРАЛТ.МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН
УЛСЫН ХУДАЛДААНЫ КОНВЕНЦ БОЛОН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД⁷³**

№	Нэр	Байгуулагдсан огноо	Батлагдсан огноо	Монгол Улсын элсэн орсон огноо
1	Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай Нью-Йоркийн конвенц	7/8/1965	6/9/1967	5/11/1966
2	Олон улсын бараа худалдахад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц	6/14/1974	8/1/1988	4/14/1974
3	Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц	6/10/1958	6/7/1959	10/24/1994
4	Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц	4/11/1980	1/1/1988	12/31/1974
5	Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны үр дүнг тусгасан төгсгөлийн баримт бичиг	4/15/1994	1/1/1995	
6	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр	4/15/1994	1/1/1995	12/5/1996
7	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр	10/30/1947	1/1/1948	12/5/1996
8	Эрчим хүчний гэрээ ба эрчим хүчний үр ашигтай байдал болон холбогдох байгаль орчны асуудлын протокол, Эрчим хүчний хэлэлцээрийн худалдаатай холбоотой зүйлд оруулсан нэмэлт, өөрчлөлт	4/16/1998	4/16/1998	7/21/1997
9	Засгийн газар хоорондын байгууллага болох Олон улсын худалдааны мэдээлэл, хамтын ажиллагааны агентлаг байгуулах гэрээ	12/9/2002	6/26/1905	1/5/2005
10	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол /Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр/	11/27/2014	2/22/2017	11/23/2016
11	Монгол улс ба БНСУ-ын хооронд иргэний болон худалдааны асуудлаар харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ	3/31/1999	1/27/2000	
12	Сүлжмэл, нэхмэл эдлэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээр			12/31/1997
13	Монгол Улсын Засгийн газар, Вьетнам Улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	12/13/1999		
14	Монгол Улсын Засгийн газар, БНКуба улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	12/7/1960		
15	Худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг хөгжүүлэх талаар Монгол улсын Засгийн газар болон АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр / TIFA	7/15/2004		
16	Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ хоорондын хэлэлцээр	9/24/2013		
17	Монгол улс, Унгар улсын эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	1/25/2016		
18	Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр	07/1975	2005	9/29/2020

⁷³ Монгол Улсын гадаад худалдааны мэдээллийн сан, <<http://www.mongoliatradeportal.com/index.php?r=site/display&id=191>> хандсан 2021.10.18

Монгол Улсаас гадаад улсуудтай байгуулсан хоёр талт худалдааны хэлэлцээрүүд

Худалдааны хэлэлцээрийн нэр	Батлагдсан огноо
1 Хоёр талын эдийн засгийн гадаад харилцааны тухай Монгол Улс, БНАвстри улс хоорондын хэлэлцээр	12/25/1992
2 Монгол Улс, БНАвстри Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр	6/10/2016
3 Худалдааны харилцааны тухай БНМАУ-ын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1/23/1991
4 Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ хоорондын хэлэлцээр	9/24/2013
5 Монгол Улсын Засгийн газар, Балбын Вант Улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	1/29/1992
6 Монгол Улсын Засгийн газар, БНБеларусь Улсын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	1/24/1992
7 Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай БНМАУ-ын Засгийн газар, БНБолгар Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	5/1/1991
8 Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	11/16/1994
9 Санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	9/21/1998
10 Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНКазакстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	10/27/1992
11 Монгол Улсын Засгийн газар, БНКаз Улсын Засгийн газар хоорондын 1993 оны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	10/27/1992
12 Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНКири Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	7/10/1993
13 Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны тухай Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын комисс байгуулах тухай болон түүнийг үүргийн тухай 1993 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, БНКириУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол	2012
14 Монгол Улсын Засгийн газар, БНКуба Улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	11/9/2001
15 Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	7/30/2007
16 Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комисс байгуулах тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	2/12/1991
17 Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын протокол	2/19/1997
18 1998 оны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын протокол	3/21/1998
19 Худалдаа, эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын 2002 оны протокол	3/25/2002
20 Хүнсний улаан буудай нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	5/26/2004
21 Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр	12/14/2010
22 Худалдаа, төлбөрийн тухай БНМАУ-ын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	4/5/1991
23 Худалдааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	12/21/2004
24 Худалдааны далайн тээврийн асуудлын тухай Монгол Улс, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	7/20/2007
25 Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНТажикистан улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	3/27/2009

26	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНУзбекистан улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	11/5/1993
27	Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	5/19/1992
28	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол, Украины Засгийн газар хоорондын комисс байгуулах тухай 1992 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Украин Улсын Засгийн газар хоорондын протоколоор батлагдсан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол-Украины Засгийн газар хоорондын комиссын журамд өөрчлөлт оруулах тухай протокол	6/26/2011
30	Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай Монгол улс, Унгар улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр	1/25/2016
31	Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр	5/9/1992
32	Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын эскпорт, импортын барааны чанарыг баталгаажуулах, харилцан зөвшөөрөх талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр	4/29/1994
33	Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр	6/19/2008
34	Төмөр замын тээврийн хяналтын тоног төхөөрөмж ылон контэйнерийн хяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх тухай БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт илгээсэн засгийн газар хоорондын захидал	6/4/2013
35	Монгол улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр	8/21/2014
36	Монгол улсын Засгийн газрын зээлийн туслалцааны тухай Монгол улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр	7/14/2016
37	Монгол Улсын Засгийн газар, БНЧехУ-ын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	12/11/1995
38	Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр	9/16/1996
39	БНМАУ-ын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр	3/1/1990
40	БНМАУ, Япон улсын хооронд худалдааг зохицуулах тухай хэлэлцээр	3/1/1990
41	Монгол Улс, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр	5/29/2007
42	2007-2010 оны хөтөлбөрийн тухай Монгол улс, Европын холбооны Харилцан ойлголцлын санамж бичиг	5/29/2007
43	Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын ил тод байдлын тухай Монгол улс, АНУ-ын хэлэлцээр	9/24/2013
44	Чөлөөт худалдааны хэлэлцээр, Монгол Улс, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр	7/8/1905
45	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын комиссын 15 дахь уулзалт. Талууд “Монгол-Хятадын экспо”, бусад үзэсгэлэн, чуулганыг илүү олон зохион байгуулахаар тохиролцов. Хоёр улсын хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол улсаас БНХАУ руу хийх мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр тохиролцов	9/17/2018
46	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын 21 дэх удаагийн хуралдаанаар бүс нутгийн болон хил дамнасан хамтын ажиллагааны тухай Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд гарын үсэг зурав	2/26/2018
47	Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол улсын Засгийн газрын өргөн барьснаар УИХ-ын чуулганаар баталсан	2/5/2016
48	Монгол Улс, Кувейт Улсын Засгийн газар хоорондын худалдаан хэлэлцээрт 2007 оны 7-р сарын 31-нд гарын үсэг зурж УИХ-аар 2008 оны 1-р сарын 29-нд соёрхон баталсан	1/29/2008

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Ц.Норовдондог, Г.Алтан-Оч, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа “Худалдааны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага” СТ-18/204, УИХТГ, Судалгааны эмхтгэл №26
- Э.Анужин, Б.Долгормаа, С.Золжаргал, Р.Нургүл, Д.Халиун “Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны нөхцөл байдлын талаарх тойм мэдээлэл” СТ-20/424, УИХТГ, Судалгааны эмхтгэл №32
- U.S. Code: Title 15. COMMERCE AND TRADE | U.S. Code | US Law | LII / Legal Information Institute (cornell.edu)
- The Code Of Commercial Companies, <https://www.global-regulation.com/translation/poland/2986292/law-of-15-september-2000%252c-the-code-of-commercial-companies.html>
- <https://www.statista.com/topics/5173/sunday-trading-ban-in-poland/>
- Regulation (EC) No. 450/2008 of the European Parliament and of the Council of 23 April 2008 laying down the Community Customs Code (Modernised Customs Code) <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?Uri=LEGISSUM%3Ado0001>
- Observatory of Economic Complexity, <https://oec.world/en/profile/country/pol>
- Doing business in Poland 2016, HSBC <https://www.business.hsbc.com.cn/-/media/library/markets/poland/pdf/poland-countryguide.pdf>
- <https://www.trade.gov/knowledge-product/poland-trade-barriers>
- The Strategy for Responsible Development for the period up to 2020 (including the perspective up to 2030) – SRD, https://www.gov.pl › SOR_2017_streszczenie_en
- The Polish Investment and Trade Agency, https://www.paih.gov.pl/about_us/paih
- http://icps.com.ua/assets/uploads/files/polands_trade_and_exports_promotion_1_.pdf polska export promotion portal, <https://www.trade.gov/pl/en/invest-in-poland/help-for-importers/supporting-institutions/1987,supporting-institutions.html>
- https://www.paih.gov.pl/why_poland/Polish_Investment_Zone, A guide to special economic zones in Poland, https://www.paih.gov.pl/files/?Id_plik=10800
- Law On Foreign Trade Management, <http://vbpl.vn/TW/Pages/vbpqen-toanvan.aspx?Itemid=11096>
- Law on Foreign Trade Management, AHTN 2017 Implementation, and recent developments in trade and customs KPMGT&C Q3/2017 Newsletter, September 2017, <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2017/10/tnf-vietnam-oct9-2017.pdf>
- Observatory of Economic Complexity, <https://oec.world/en/profile/country/vnm>
- Law On Foreign Trade Management, <http://vbpl.vn/TW/Pages/vbpqen-toanvan.aspx?Itemid=11096>
- Law on Foreign Trade Management, AHTN 2017 Implementation, and recent developments in trade and customs KPMGT&C Q3/2017 Newsletter, September 2017
- <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2017/10/tnf-vietnam-oct9-2017.pdf>
- <https://assets.kpmg/content/dam/kpmg/vn/pdf/publication/2021/Investing-in-Vietnam-Mar2021.pdf>
- <http://chinhphu.vn/portal/page/portal/English/strategies/strategiesdetails?CategoryId=30&articleid=10051303>
- <http://trade.ec.europa.eu/doclib/press/index.cfm?id=1437>
- <https://www.lexology.com/library/detail.aspx?G=21d933d9-5053-400c-a1ca-83ffac6d19d9>
<https://assets.kpmg/content/dam/kpmg/vn/pdf/publication/2021/Investing-in-Vietnam-Mar2021.pdf>
<https://www.aseanbriefing.com/news/special-economic-zones-in-asean-opportunities-for-us-investors/>

**ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:
БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

*Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй,
Д.Амаржаргал (Ph.D, Б.Туул, П.Уранчимэ*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

БҮЛЭГ I. ФРАНЧАЙЗИНГИЙН ТӨРЛҮҮД БА ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ

ФРАНЧАЙЗИНГИЙН ТӨРЛҮҮД

ОЛОН УЛСЫН ФРАНЧАЙЗИНГ

ОЛОН УЛСЫН ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭ БА ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

БҮЛЭГ II. МОНГОЛ УЛС ДАХЬ ФРАНЧАЙЗИНГИЙН ХАРИЛЦАА, ЭРХ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ФРАНЧАЙЗИНГ БИЗНЕСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

БҮЛЭГ III. ФРАНЧАЙЗИНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ
ОРНЫ ТУРШЛАГА

НЭГ. КАНАД УЛС

ХОЁР. ИТАЛИ УЛС

ГУРАВ. БРАЗИЛ УЛС

ДӨРӨВ. ХЯТАД УЛС

ТАВ. МАЛАЙЗ УЛС

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Франчайзингийн гэрээний эрх зүйн зохицуулалт: Бусад орнуудын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Олон улсын эдийн засаг, бизнесийн харилцааны түгээмэл хэлбэр болох франчайзинг, франчайзингийн системийн онцлог, франчайзингийн гэрээ, эрх зүйн зохицуулалттай холбоотой олон улсын нийтлэг зохицуулалт болон бусад орнуудын туршлагыг судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд франчайзийн бизнесийг амжилттай хөгжүүлж буй Канад⁷⁴, Хятад⁷⁵, Итали, Бразил⁷⁶, Малайз зэрэг орнуудыг хамруулж, мэдээллийг дараах чиглэлээр нэгтгэн боловсруулсан болно. Үүнд:

- Франчайзийн бие даасан хуультай эсэх, хэрвээ бие даасан хуульгүй бол ямар хууль, журмаар хэрхэн зохицуулдаг;
- Франчайзийн гэрээг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ, хуулийн хариуцлага;
- Франчайзийн гэрээний үндсэн нөхцөл, гэрээнд тавигдах шаардлага;
- Франчайзийн төлбөр, түүний төрөл, хэмжээ, төлөх хэлбэр;

Судалгааны бүтэц: Судалгаа нь нийт 3 бүлэгтэй:

- 1-р бүлэгт, Франчайзингийн систем, франчайзингийн төрөл, хэлбэрүүд болон олон улсын гэрээ, эрх зүйн системийн талаарх мэдээллүүд багтсан.
- 2-р бүлэгт, Монгол Улс дахь франчайзингийн бизнесийн өнөөгийн байдал, эрх зүйн орчны талаарх мэдээллийг оруулсан.
- 3-р бүлэгт, Канад, Хятад, Итали, Бразил, Малайз зэрэг орнуудын франчайзингийн эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг оруулсан.



⁷⁴ Канад даяар ойролцоогоор 1300 франчайз брэнд, 75000 гаруй франчайзийн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулдаг.

⁷⁵ 2019 оны байдлаар 4368 франчайзер бүртгэлтэй байна. <https://www.china-briefing.com/news/franchise-china-guide/#:~:text=As%20of%20January%202019%2C%204%2C368,franchise%20markets%20in%20the%20world>.

⁷⁶ Бразил улсад нийт 2918 франчайзинг үйл ажиллагаа явуулж байна. <https://www.trade.gov/country-commercial-guides/brazil-franchising#:~:text=There%20are%202%2C918%20franchising%20chains,in%20number%20of%20franchise%20chains>.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Франчайзинг нь олон улсын бизнес эдийн засгийн харилцаанд онцлох байр суурийг эзэлдэг бөгөөд орчин үед дэлхий дахинд хүрээгээ тэлж улам бүр даяаршин хөгжиж байна. Олон Улсын Франчайзингийн Нийгэмлэг (IFA)-ийн мэдээллээс үзэхэд, франчайз эрхлэгчдийн тоо, ажиллагсдын тоо, ашиг орлого, ДНБ-д эзлэх хувь хэмжээ зэрэг үзүүлэлтүүд тогтвортой өсөж байгаа бөгөөд 2021 оны байдлаар франчайз эрхлэгчдийн тоо 780,188, тус салбарт ажиллагсдын тоо 8,242,929-д хүрээд байна.⁷⁷

Франчайзинг (зарим орнуудад бизнесийн концесс ч гэж нэрлэдэг) гэдэг нь зах зээлийн харилцаанд оролцогч субъектүүд буюу нэг талаас франчайз шилжүүлэгч тал, нөгөө талаас франчайз хүлээн авагч талууд харилцан тохиролцож, нэг удаагийн төлбөрийн нөхцөлтэйгээр тодорхой нэгэн бизнесийн эрх, түүнийг эрхлэн явуулахтай холбоотой бизнес моделийг шилжүүлэхтэй холбоотой харилцааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, франчайз эрх шилжүүлэгчээс франчайз эрх хүлээн авагчид бүтээгдэхүүн, үйлчилгээний барааны тэмдэгт буюу брэнд нэрээ ашиглуулан бизнес үйл ажиллагаа явуулах буцалтгүй эрх буюу лиценз олгож буй хэлбэр юм.

Өөрөөр хэлбэл “франчайзинг” гэдэг нь барааны тэмдэгт болон тогтож төлөвшсөн бизнесээ “түрээслүүлэх” үйл ажиллагаа бол “франчайз” гэдэг нь франчайз эрх шилжүүлэгчийн шаардлагад нийцүүлэн тухайн бизнесийг эрхлэн явуулахтай холбоотой бүх нөхцөл, талуудын харилцааны асуудлыг бүхэлд нь тодорхойлсон систем юм.

Өнөөгийн байдлаар франчайзингийн харилцааны олон улсын нэгдсэн зохицуулалтын журам байхгүй байгаа бөгөөд дэлхийн улс орнууд өөр өөрийн орны эрх зүйн зохицуулалтын хүрээнд уг асуудлыг зохицуулж байна. Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзэхэд эдгээр орнуудын эрх зүйн актуудын нийтлэг зарчим нь франчайз хүлээн авагч /franchisee/-ийн эрх ашгийг хамгаалах, франчайз шилжүүлэгчийн үүргийг илүү тусгаж өгснөөрөө онцлогтой байх бөгөөд эрх зүйн орчны зохицуулалтыг хийхдээ франчайзийн системийн голлох баримт бичиг болох франчайзийн гэрээ /franchising contract/, франчайзийн системийн мэдэгдэл /franchise offer circular/-ийг илүү тодотгон тусгадаг юм байна.

АНУ бол франчайзингийн эрх зүйн харилцаа өндөр хөгжсөн орнуудын нэг юм. АНУ-ын Холбооны худалдааны комисс буюу FTC (Federal Trade Commission) нь 1978 онд франчайзингийн тухай (The Franchise Rule⁷⁸) дүрмийг баталж франчайз эрх шилжүүлэгч талаас тавигдах шаардлага, нөхцөлүүдийг тодорхойлсон баримт бичгийг загварчлах, түүнийгээ дагаж мөрдөхийг шаардах болсон ба 2007 оноос энэхүү баримт бичгийг FDD (Franchise Disclosure Documents) гэж нэрлэх болсон байна.⁷⁹

Олон улсад франчайзийн гэрээний харилцааг улс орон бүр өөр өөрийн тусгайлсан хууль, журам, дүрмээр зохицуулж байна. Франчайзинг бизнесийн харилцааг Франчайзерын нөхцөлүүдийг тодорхойлсон баримт бичиг (FDD) болон Франчайзингийн гэрээ гэсэн үндсэн 2 баримт бичгээр зохицуулж байна. Монгол Улсын хувьд 2002 онд батлагдсан Иргэний хуулийн 333.1 дүгээр зүйлээр зохицуулж байна.

Судалгаанд авагдсан орнуудаас, БНХАУ 1997 онд “Франчайзингийн тухай” хууль баталж, 2007 онд нэмэлт өөрчлөлт оруулсан.⁸⁰ Түүнчлэн Франчайзингийн удирдлагын журам, Бүртгэлийн тухай захиргааны журам, Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай журам зэрэг эрх зүйн актуудаар нарийвчлан зохицуулдаг. Франчайзингийн удирдлагын журам (Regulations on Administering Commercial Franchises) 2007 оноос хэрэгжиж эхэлсэн ба уг журмаар⁸¹ франчайз

⁷⁷ Судалгааны дэлгэрэнгүй тайлангийн 1-р бүлэг, хуудас 15-16

⁷⁸ <https://www.franchise.org/faqs/legal/what-is-the-ftc-franchise-rule>

⁷⁹ <https://www.investopedia.com/terms/f/franchise-disclosure-document.asp>

⁸⁰ <https://www.china-briefing.com/news/franchise-china-guide/>

⁸¹ “Франчайзингийн удирдлагын журам” 22-р зүйлд

эрх шилжүүлэхтэй холбоотой баримт бичиг, франчайзийн төлбөрийн хэмжээ, төлбөрийн хэлбэр зэрэг асуудлуудыг зохицуулсан. Франчайзийн нээлттэй баримт бичгийн журамд талуудын гэрээ байгуулахаас өмнөх болон гэрээ дууссаны дараах мэдээллийг ил тод болгох, нууцлахтай холбоотой асуудлыг тусгасан бол, Бүртгэлийн тухай захиргааны журмаар Засгийн газраас франчайзийн зах зээлд хяналт тавих, бүртгэхтэй холбоотой асуудлуудыг тус тус зохицуулсан.

Канад Улсад франчайзийн харилцааг мужийн эрх зүйн харилцааны түвшинд зохицуулдаг ба улсын хэмжээнд нэгдсэн хууль тогтоомж байдаггүй байна. Мужуудын эрх зүйн зохицуулалт үндсэндээ ижил бөгөөд мужийн онцлогоос хамаарч зарим нэг нарийвчилсан заалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал, борлуулалтын өмнөх мэдээлэл, шударга хэлцлийн үүрэг, франчайзийн холбоонд нэгдэх эрх, гэрээг цуцлах үед мөрдөх журам зэрэг онцлох харилцаа, талуудын эрх, үүрэг зэргүүдийг онцлон тусгасан.

Франчайзийн зохицуулалт нь франчайзийн харилцааг бүхэлд нь биш, хэсэгчилсэн байдлаар зохицуулж байгаа нь магадгүй, тус бизнес нь өөрөө олон салбарыг хамарч олон чиглэлд хийгддэг, тухайн бизнесээсээ шалтгаалан франчайз шилжүүлэгч /franchiser/-ээс тавигдах нөхцөл нь өөр өөр байдагтай холбоотой гэж зарим судлаачид дүгнэсэн байна.⁸²

Судалгаанд авагдсан Итали, Бразил, Малайз улсуудын хувьд франчайзийн бие даасан хуультай бөгөөд хуулинд нарийвчилсан, тодорхой заалтуудыг оруулснаар франчайзийн үйл ажиллагааг илүү тодорхой болгох, тухайн харилцаанд оролцогч талуудын эрсдэлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал, Малайз Улс 1998 онд, Бразил Улс 2019 онд тус тус Франчайзийн тухай хуулийг баталсан. Итали Улсын хуулинд франчайзийн гэрээний асуудлыг дэлгэрэнгүй хуульчилсан байгаа бол Бразил Улсын хуулинд Франчайзийн системийн мэдэгдлийн /franchise offer circular/ талаар илүү тодорхой тусгасан байна.

Судалгаанаас үзэхэд, франчайзийн хуулийн хариуцлагын хэлбэр нь хууль зөрчсөн тохиолдолд Засгийн газрын эрх бүхий байгууллагаас хуулийн хариуцлага тооцох ба гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээнд заасны дагуу арга хэмжээ авдаг байна. Эрх зүйн орчны хүрээнд нийтлэг байдлаар зохицуулсан гол зохицуулалт нь франчайзийн системийн үндсэн баримт бичиг болох Франчайзийн гэрээ /franchising contract/, Франчайзийн системийн мэдэгдэл /franchise offer circular/-тэй холбоотой зохицуулалтууд байна.

Судалгаанд авагдсан орнуудын эрх зүйн зохицуулалттай холбоотой онцлох туршлагуудыг хүснэгтээр хураангуйлан танилцуулж байна.

(Мэдээллийн дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү)



⁸² Д. Байгалмаа, Г. Гэрэл, " Гадаадын зарим орны франчайзийн хуулийн давуу болон сул талууд" харьцуулсан судалгаа. УИХТГ, Судалгааны төв, СТ-13/223

Хүснэгт 1. Судалгаанд авадгсан орнуудын франчайзингийн эрх зүйн орчны зарим мэдээлэл

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	КАНАД	ХЯТАД	ИТАЛИ	БРАЗИЛ	МАЛАЙЗ
Эрх зүйн акт	Мужийн хуулиар зохицуулдаг. Франчайзингийн тухай хууль, Franchises act. 9 бүлэг 22 зүйлтэй. Бритиш Колумб, Альберта, Манитоба, Онтарио, Принс Эдвардын арал, Нью Брунсвик мужууд бие даасан франчайзийн хуультай.	Тусгайсан хууль, холбогдох журмуудаар зохицуулдаг. Үүнд: Франчайзингийн тухай хууль 1997 -Франчайзингийн удирдлагын журам (2007/485) -Франчайзийн бүртгэлийн тухай захиргааны журам (2011) -Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай захиргааны журам (2012)	Тусгайсан хууль, холбогдох журмуудаар зохицуулдаг. Үүнд франчайзийн тухай хууль (2004/129). Хууль нь 9 зүйлтэй -Франчайзийн журам (2005/204)	Тусгайсан хуулиар зохицуулдаг. -Brazilian Franchise Law, №13.966/26, 2019	Тусгайсан хуулиар зохицуулдаг. 1998 онд Франчайзийн тухай хуулийг баталж 2012 онд хуульд (нэмэлт өөрчлөлт) оруулсан. (Franchises act) Тус хууль 8 бүлэг 61 зүйлтэй.
Франчайзийн хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага	<u>Хамтын хариуцлага</u> -хуулийн заалтыг хамтдаа зөрчсөн гэж үзсэн хүмүүс хариуцлагыг хамт хүлээнэ. Гэрээг цуцлах. Франчайз эрх шилжүүлэгчийн буруугаас гэрээг цуцлах тохиолдолд франчайз хүлээн авагч талд цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор франчайзийн үйл ажиллагаанаас үүдэлтэй цэвэр алдагдлыг нөхөн олгох ёстой.	Гэрээг зөрчсөн тохиолдолд: -торгох гэрээг цуцлахаар зохицуулсан..	Франчайзийн тухай хуулийн 8-р зүйлд зааснаар гэрээг цуцлах. "хэрэв талууд хуурамч мэдээдэл, баримт бичиг гарган танилцуулсан бол, франчайз хүлээн авагч нь гэрээг цуцалж болох ба учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ."	Хариуцлагын тогтолцоог тусгаагүй. Хуулийн 7.§1-т "Франчайзийн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлүүлэхээр талууд арбитраж хандаж шүүхэд болно" гэж заасан.	<u>Торгох</u> - аж ахуйн нэгж байууллага бол 250,000 RM-ээс хэтрэхгүй торгууль, давтан үйлдсэн тохиолдолд 500,000 RM-ээс хэтрэхгүй торгууль; -иргэн бол 100,000 RM -ээс хэтрэхгүй торгууль, давтан үйлдсэн бол 250,000 RM -ээс хэтрэхгүй торгууль. Хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу: -франчайзийн гэрээг хүчингүй болгох; -франчайз эрх шилжүүлэгч франчайз хүлээн авагчаас авсан төлбөрийг буцааж өгөх; -шинээр франчайзийн гэрээ байгуулах, эзэмшигч томилохыг хориглох.

<p>Франчайзийн төлбөрийн хэмжээ, хэлбэр, нөхцлүүд -Франчайз хүлээн авагчид оюуны өмчийн эрх олгох, -Франчайз эрх шилжүүлэгчийн зүгээс үзүүлэх дэмжлэг, талуудын эрх, үүрэг, хариуцлага -Франчайзийн хугацаа ба хугацааг сунгах нөхцөл, -Франчайзийг цуцлах нөхцөл, Франчайзийн үйл ажиллагаа дууссаны дараах шаардлага, үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, зар сурталчилгаа, маркетингийн үүрэг хариуцлага, дизайн ба засварын ажил -даатгал, нөхөн төлбөр, осол гамшгийн үед хэрхэх талаар заасан байна.</p>	<p>-Франчайзийн гэрээг бичгээр байгуулна. -Зайлшгүй тусгах ёстой 11 зүйлийн шаардлагыг тусгасан. -Франчайз хүлээн авагч нь гэрээг дангаараа цуцлах асуудлыг заавал тусгах.</p>	<p>-Франчайзийн гэрээг бичгээр хийх -Франчайз эрх шилжүүлэгч нь мэргэшсэн бизнесийн загвартай байх, -Зайлшгүй тусгах ёстой 7 зүйлийн шаардлагыг тавьсан.</p>	<p>Франчайзийн гэрээнд дараах асуудлуудыг тусгах: Талуудын стандартын дагуу ажиллах үүргүүд; Франчайзийн гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээг сунгах нөхцөл; анхны төлбөрийн нөхцөл; төлөвлөсөн нутаг дэвсгэрийн онцлог; зар сурталчилгаа, маркетингийн үүрэг; Франчайз хүлээн авагчид патент болон оюуны өмчийн эрхийг олгосон байх; даатгалын шаардлага.</p>	<p>-Франчайзийн гэрээ нь зөвхөн Португал хэл дээр бичигдэх, -Олон улсын Франчайзингийн гэрээг Португал хэл дээр бичих, эсхүл баталгаажсан Португал хэлний орчуулгатай байх</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч гэрээнд гарын үсэг зурахаасаа өмнө мэдээллийг тодруулахад шаардагдах 14 хоногийн хугацаа өгөх ёстой. Хэрэв Франчайз эрх шилжүүлэгч гэрээнд томоохон өөрчлөлт оруулахыг хүсвэл Франчайз хүлээн авагч нь гарын үсэг зурахаасаа өмнө гэрээг хянаж үзэхэд 7 хоногийн хугацааг өгөх гэх мэт</p>
<p>Франчайзерын нөхцөлүүдийг тодорхойлсон баримт бичиг</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчийг Франчайзийн мэдэгдэл /FOC/-ээр хангах ба энэхүү мэдэгдэл нь тодорхой, ойлгомжтой, байх ба хуульд заасан заагаад 23 нөхцөлийг тусгасан байна.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгчийн 6 үүргийг нээлттэй баримт бичигт тусгасан. Мөн нээлттэй баримт бичигт гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчид гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчид гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>
<p>Франчайзийн гэрээнд тааилгах шаардлагууд</p>	<p>“Франчайзингийн удирдлагын журам”-ын “Нээлттэй бичиг” гуравдугаар бүлгийн 21 дүгээр эрх Франчайз шилжүүлэгч Франчайзийн гэрээ байгуулахаас 30-аас доошгүй өдрийн өмнө Франчайз хүлээн авагчид журмын 22 дугаар зүйлд заасан нээлттэй баримт бичгийг загварыг гэрээний загварыг бичгээр гарган өгч танилцуулах үүрэгтэй.” гэж заасан.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчид гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчид гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчид гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгч Франчайз хүлээн авагчид гурван жилийн шүүх, арбитртай холбоотой тодорхойлолтыг хавсаргах, Франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг үүрэгжүүлсэн.</p>

<p>Франчайзийн төлбөр, төрөл, хэмжээ, төлөх хэлбэр</p>	<p>Гэрээнд франчайзийн төлбөр, франчайз ашигласны хураамж болон бусад нэмэлт зардлын талаар нарийвчлан тодорхойлсон байна. Франчайз эрх шилжүүлэгчид төлөх төлбөрийн хугацаа хэтэрсэн тохиолдолд шимтгэл төлөх хуваарь мөн орсон байна. Франчайзингийн эхний төлбөр 5000-75000 долларын хооронд ихэвчлэн хэлбэлздэг. Явцын роялти төлбөр нийт борлуулалтын 0-20 хувьтай тэнцдэг.</p>	<p>Франчайзингийн удирдлагын журам"-ын 11.3-т "франчайзийн төлбөрийн төрөл, хэмжээ, төлбөрийн хэлбэрийг заана"</p>	<p>-Хуулийн 3.4.1-т "франчайзийн үйл ажиллагааг эхлэхээс өмнө франчайз хүлээн авагчийн төлөх анхны төлбөр болон хөрөнгө оруулалтын нийт хэмжээ"</p> <p>-3.4.2-т "франчайз эрх шилжүүлэгчид төлөх ёстой роялти болон төлбөрүүдийг тусгана" гэж заасан.</p>	<p>Хуулийн "Франчайз авагчаас эрх шилжүүлэгч болон 3-дагч эдгээдэд төлөх хугацаатай төлбөрүүд болон бусад төлбөр тооцооны тухай мэдээллийг тооцоололд үндэслэн тус тусад нь нарийвчлан тодорхой заана"</p>	<p>Франчайзийн тухай хуульд төлбөр төлөхтэй холбоотой тодорхой зохицуулалт байхгүй бөгөөд талууд дараах зүйлсээс зайлсхийх ёстой гэсэн ерөнхий заалт байдаг. Үүнд:</p> <p>Төлбөр, хураамжийг үндэслэлгүй тогтоох, хэт өндөрөөр үнэлэх; нэг талд давуу эрх олгохгүй байх, гэх мэт ; Хэрэв төлбөр хураамж нь үндэслэлгүй өндөр байвал улсын бүртгэгч гэрээг батлахаас өмнө франчайз хүлээн авагчаас нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулан авах эрхтэй.</p>
--	--	--	---	--	---

Түлхүүр үг: Франчайзинг, Франчайзинг бизнес, Франчайз эрх шилжүүлэгч, Франчайз эрх хүлээн авагч, Франчайзийн гэрээ

Keywords: Franchising, Business format franchise, franchisor, franchisee, franchising contract



СУДАЛГААНЫ ХЭСЭГ**БҮЛЭГ I. ФРАНЧАЙЗИНГИЙН ТӨРЛҮҮД БА ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ****ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Франчайзинг- гэдэг нь нэг талаас франчайз шилжүүлэгч тал, нөгөө талаас франчайз хүлээн авагч талууд харилцан тохиролцож, тодорхой төлбөрийн нөхцөлтэйгээр бизнесийн эрх, түүнийг эрхлэн явуулахтай холбоотой бизнес моделийг шилжүүлэхтэй холбоотой харилцааг хэлнэ. Өөрөөр хэлбэл, франчайзераас франчайзид бүтээгдэхүүн, үйлчилгээний барааны тэмдэгт буюу брэнд нэрээ ашиглуулан бизнесийн үйл ажиллагаа явуулах буцалтгүй эрх буюу лиценз олгож буй хэлбэр юм.

Энгийн үгээр, франчайзинг гэдэг бол барааны тэмдэгт болон тогтож төлөвшсөн бизнесээ “түрээслүүлэх” үйл ажиллагаа. Франчайз гэдэг нь франчайзерийн шаардлагад нийцүүлэн тухайн бизнесийг эрхлэн явуулахтай холбоотой нөхцөл, талуудын харилцааны асуудлыг бүхэлд нь тодорхойлсон систем юм.

Франчайзингийн үндсэн шинж нь нэг талаас бараа үйлчилгээний зах зээл дээр тод имиж, нэр хүндийг олж авсан компани франчайз хүлээн авагчид бусдаас ялгарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, барааны тэмдэгт, загвар, бизнесийн технологи болон тухайн бараа, үйлчилгээний зах зээл дэх байр суурийг тогтвортой хадгалах, өсгөхөд чиглэсэн мэдээллийг шилжүүлэхэд оршино. Иймд эрх шилжүүлж буй компанийн зүгээс тухайн бизнесийг хөл дээр нь босгох, зах зээлд байр сууриа олоход нь техникийн болон зөвлөх үйлчилгээний дэмжлэг тусалцаа үзүүлж ажиллах шаардлагатай болдог.

Франчайзингийн системд дараах асуудлуудыг чухалчлан авч үздэг.

- Франчайзер өөрийн барааны тэмдэгт, ноу-хау ашиглуулсны төлөө төлбөр авах ба түүхий эд, бусад шаардлагатай орц материалаар хангах, ажилтнуудыг сургаж дадлагажуулах үүрэг хүлээнэ.
- Франчайзий нь франчайзерийн боловсруулсан схемээр бизнес эрхлэх эрхийг худалдан авч төлбөр (шимтгэл) төлөх ба тухайн бизнесийг эхлүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, цаашид хэвийн авч явахтай холбоотой зардлаа хариуцна.
- *Эхлэлтийн төлбөр* (нэг удаагийн)- гэдэг нь франчайз худалдан авахад нэг удаа төлөх эхлэлтийн төлбөр юм. Эхлэлтийн төлбөрийг үйл ажиллагаа эхлүүлэх нийт зардлын 9-11%-иар тогтоодог жишиг байна. Энэхүү төлбөрт бизнесийн ном (бүтээгдэхүүн, үйлчилгээний зааварчилгаа), брэндийн ном (брендийн загвар, хийц, реклам суртчилгааны журам), хүний нөөцийн сургалт, удирдлагын заавар, борлуулалт-худалдааны аргачлал, бүтээгдэхүүний технологи болон рецепт, нягтлан бодох бүртгэл, тайлагналын гарын авлага зэрэг заавар, зааварчилгаануудын үнэ орно.
- *Роялти*-гэж франчайзерын барааны тэмдэгт, патент болон оюуны өмчийн бусад эрхийг ашигласны төлөө сар бүр төлөх төлбөрийг хэлнэ. Роялти төлбөрийн хэмжээ нь ойролцоогоор борлуулалтын нийт орлогын 2-6%, эсхүл тогтмол хэмжээтэй байж болно.

ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭ

Франчайз шилжүүлэхтэй холбоотой асуудлыг талууд гэрээгээр харилцан тохиролцоно. Гэрээнд франчайз ашиглалтын төлбөрийн хэлбэр, хэмжээг зайлшгүй тусгах ба энэ нь тодорхой хугацаанд нэг удаа төлөх, борлуулалтын хувиар төлөх, тогтмол хэмжээгээр төлөх аль нэгэн хэлбэртэй байж болно. Гэрээгээр франчайзер төлбөр авахгүй байхаар тохирч болох ба энэ тохиолдолд франчайз хүлээн авагч нь франчайзераас тодорхой хэмжээний бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үүрэгтэй байхаар гэрээнд тусгаж болно.

Гэрээнд түүнчлэн барааны тэмдэгт, брэнд нэрийг ашиглахтай холбоотой нөхцлийг тодорхой

Гэрээнд түүнчлэн барааны тэмдэгт, бренд нэрийг ашиглахтай холбоотой нөхцлийг тодорхой зааж өгнө. Жишээ нь, франчайз хүлээн авагч нь тодорхой салбарт брэнд нэрийг ашиглах эрхтэй бөгөөд франчайзераас тавьсан стандарт шаардлагад нийцүүлэн дэлгүүр, үйлчилгээний байгууламжаа тоноглох үүрэгтэй гэх мэт.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Франчайз: франчайз эрх эзэмшигч, франчайз хүлээн авагч хоёрын хоорондын гэрээний харилцааг илэрхийлдэг, франчайзийн хяналт, дэмжлэг, барааны тэмдэг, төлбөрийн нөхцөлийг агуулсан лиценз юм.

Франчайз эрх шилжүүлэгч-Franchisor: барааны тэмдэг, худалдааны тэмдгээ ашиглуулж, уг бизнесийн эрхийг франчайз хүлээн авагчид шилжүүлж буй хувь хүн эсвэл компани.

Франчайз хүлээн авагч-Franchisee: франчайз эзэмшигчийн барааны болон худалдааны тэмдгийг ашиглан бизнес эрхлэх эрх авсан хувь хүн эсвэл компани.

Франчайзинг: төлбөр төлж барааны тэмдэг болон худалдааны тэмдгийн лиценз аваад, франчайз эрх шилжүүлэгчийн хяналт, дэмжлэгтэйгээр уг бизнесийг эрхлэх, бизнесээ өргөтгөх арга.

Франчайзын гэрээ: талуудын харилцаа, эрх үүрэг, шаардлагыг тодорхойлсон, франчайзер, франчайз эрх эзэмшигч хоёрын хооронд хуулийн дагуу байгуулсан гэрээ.

ФРАНЧАЙЗИНГИЙН ТӨРЛҮҮД

Түгээмэл хэрэглэгддэг дараах 3 төрлийн үндсэн франчайзинг байдаг.⁸³ Үүнд:

- Үйлдвэрлэлийн франчайзинг (Manufacturing franchise)
- Бүтээгдэхүүн/ түгээлтийн франчайзинг (Product franchise, or Single operator franchise)
- Бизнесийн форматтай франчайзинг (Business format franchise)

Үйлдвэрлэлийн франчайзинг	Бүтээгдэхүүн/ түгээлтийн франчайзинг	Бизнесийн форматтай франчайзинг
<p>Үйлдвэрлэлийн франчайз гэж эрх шилжүүлэгч буюу франчайзерын олгосон эрхийн дагуу тодорхой бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахад чиглэдэг бөгөөд франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид өөрийн барааны тэмдгээр үйлдвэрлэх, худалдан борлуулах зөвшөөрөл олгодог.</p>	<p>Франчайз эрх шилжүүлэгчийн (Franchisor) үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, барааны тэмдгээр тэмдэглэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах эрхийг бүтээгдэхүүн түгээлтийн франчайзинг гэнэ. Бүтээгдэхүүнийг бизнесийн формат, сургалт, дэмжлэг дагалдах боловч нарийвчилсан зааварчилгаа болон хориог гэрээгээр тогтоодоггүй тул франчайз хүлээн авагч (franchisee) нь бизнесийн үйл ажиллагааг харьцангуй бие даасан байдлаар явуулах боломжтой байдаг. Гэхдээ бүтээгдэхүүний франчайз хүлээн авагч нь зөвхөн тус компанийн бүтээгдэхүүнийг зарж борлуулах, өрсөлдөгч компаний бүтээгдэхүүнийг зарж түгээхгүй байх гэсэн шаардлагууд тавигддаг. Шилжүүлж буй үндсэн эрх нь франчайзерын барааны тэмдгийг ашиглах эрх учраас франчайз эрх эзэмшигчийн зүгээс бөөний болон жижиглэнгийн худалдааг явуулахдаа тасралтгүй эргэх холбоотой ажиллах шаардлагатай. Франчайз хүлээн авагч нь брэндийн нэр хүнд, бүтээгдэхүүний таних тэмдгийг ашиглаж байгаагийн хувьд хураамж төлдөг.</p>	<p>Бизнесийн форматтай франчайз хүлээн авагч нь брэндийн нэр болон бүтээгдэхүүний шошгыг ашиглаад зогсохгүй бизнесийн үйл ажиллагааны системийн бүхлээр нь ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид хүргэдэг. Франчайз эрх шилжүүлэгч нь бизнес эрхлэгчийн нөөц боломжийг ашиглан өөрийн брэндийн хүрээг тэлэх зорилготой бөгөөд брэндийн нэр хүнд, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг алдахгүйн тулд бизнесийн бүхий л үйл ажиллагаанд нарийвчилсан төлөвлөгөөний дагуу салбар нээгдэхийн өмнөх болон дараах сургалт, шаардлагатай дэмжлэгээр хангах үүрэгтэй. Энэ төрлийн франчайзингийн ашигтай тал нь франчайз хүлээн авагч нь хэзээ ч сургалт зөвлөгөө, дэмжлэг авах боломжтой байдаг тул бизнесээ амжилттай явуулахад нь дөхөм болдог.</p>

ФРАНЧАЙЗИНГИЙН БУСАД ТӨРЛҮҮД

Менежментийн франчайзинг (Management franchise)

Франчайз эрх эзэмшигч нь өөрийн карьер, ажлын туршлага дээрээ тулгуурлан удирдлагын мэргэжилтэн хийх, бизнесийн формат болон үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Мөн чадварлаг хүмүүсийг ажилд авч, сургах, бизнест хяналт тавих зэргээр ажиллана. Энэ төрлийн франчайзингид ихэвчлэн зуучлалын үйлчилгээ, зардлын менежментийн үйлчилгээ, цэвэрлэгээ, ажилд зуучлах, спорт заал, жижиглэнгийн худалдаа гэх мэт бизнесийн төрлүүд хамаарна.

Хөрөнгө оруулалтын франчайзинг (Investment franchise)

Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай зочид буудлын цогцолбор, дээд зэрэглэлийн ресторан гэх мэт том хэмжээний төслүүдэд ашиглагддаг. Франчайз хүлээн авагч нь нэг бол өөрөө удирдлагын багийг ажиллуулж, эсвэл франчайз эрх шилжүүлэгчид үйл ажиллагааг нь даатган хөрөнгө оруулалтаасаа өгөөж хүртдэг.

⁸³ <https://fantasticfranchise.com/blog/3-basic-types-of-franchise-systems/>

Ажлын франчайзинг (Job franchise)

Энэ нь голдуу гэрээс ажиллах боломжтой, эсвэл бага хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг, ганцаарчлан ажиллах боломжтой жижиг бизнест ашиглагддаг франчайзингийн төрөл юм. Франчайз хүлээн авагч нь ихэвчлэн багахан хэмжээний тоног төхөөрөмж худалдан авах ба бүтээгдэхүүн, үйлчилгээний нөөц нь хязгаарлагдмал байдаг. Жишээлбэл аялал жуулчлалын агентлаг, кофе зардаг ачааны машин, зүлэг арчлах үйлчилгээ, бохирын усны цэвэрлэгээ, гар утасны дагалдах хэрэгсэл болон засвар, үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ, усан сангийн арчилгаа, байгууллагын тэмдэглэлт үйл явдлыг төлөвлөх, хүүхдэд үзүүлэх үйлчилгээ гэх зэрэг нь ажлын франчайзингад багтдаг.

Хөрвөх франчайзинг (Conversion Franchise)

Ямар нэгэн чиглэлээр бизнес эрхэлдэг компани тухай салбартаа олонд танигдсан брэндийн франчайзинг руу шилжихийг хэлнэ. Ингэснээр франчайз хүлээн авагч нь брэндийн нэр, маркетинг болон сурталчилгааны программ, сургалтын систем болон хэрэглэгчдэд үйлчлэх стандартыг ашиглах боломжтой болж ашиг орлогоо нэмэгдүүлж чадах юм. Нэгэнт үйл ажиллагаа явуулж байсан бизнес тул франчайз эрх шилжүүлэгч нь маш богино хугацаанд роялти хураан авах, мөн дахин салбар нээх боломжтой болдог. Хөрвүүлэх франчайзингийг өргөн ашигладаг салбарууд нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, цэцэгчин, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд, сантехникч, цахилгаанчин, агааржуулагч гэх мэт (FranchiseCity).

Франчайзингийн гэрээний төрлүүд (Classification of franchising agreements)

Бизнес эрхлэгчдэд зориулсан олон янзын франчайзингийн хэлэлцээрийн хувилбарууд байдаг.⁸⁴ Үүнд:

- Нэг нэгжтэй франчайз (Single unit franchise)
- Олон нэгжтэй франчайз (Multi-unit franchise)
- Бүс нутгийг хөгжүүлэх франчайз (Area development franchise)
- Мастер франчайз (Master franchise)

Эдгээр тохиролцооны хувилбаруудаас жишээ нь, мастер франчайз эрх хүлээн авагч нь өөрийн эзэмшилд хэд хэдэн салбарыг нээн үйл ажиллагаа явуулах эрхтэй болоод зогсохгүй тухайн бүс нутагт франчайзинг нээх эрхийг өөр бизнес эрхлэгчид зарж болдоороо давуу талтай. Мастер франчайз эрх шилжүүлэгч нь сургалт, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, шимтгэл болон роялтиг хураан авах эрхтэй байдаг.

Дистрибьютор болон лицензийн эрх франчайзингаас юугаараа ялгаатай вэ?

Дистрибьютор ба Франчайзингийн ялгаа	Лиценз ба Франчайзингийн ялгаа
Дистрибьютор нь орон нутгийн зах зээл болон хэрэглэгчдээ сайн мэддэг, нийлүүлэгч, үйлдвэрлэгчдээс гадна олон компаниудтай бизнесийн харилцаатай байдаг. Франчайз эрх эзэмшигчийн адил нийлүүлэгч, үйлдвэрлэгчдээс гэрээний дагуу тусламж, сургалт хүлээн авахгүй байж болно. Зарим дистрибьюторын гэрээ франчайзтай төстэй байдаг. Бизнесээ хэрхэн явуулах тал дээр маш их эрх чөлөөтэй байгаа франчайз хүлээн авагч нь бие даасан дистрибьютортой нэлээд төстэй. Нийлүүлэгч болон үйлдвэрлэгчийн хатуу хяналтанд байгаа дистрибьютор франчайзтай төстэй болж эхэлдэг. Дистрибьютор зөвхөн тухайн барааг худалдаж аваад үнэ нэмж зардаг ⁸⁵ .	Лиценз гэдэг нь тодорхой нэг барааны тэмдгийг ашиглах эрхийг төлбөр төлж авахыг хэлнэ. Франчайзаас ялгаатай нь франчайзерын зүгээс франчайз эрх эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихад ихээхэн анхаарах ба бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөс илүүтэйгээр лиценз ашиглалтыг шалгаж, төлбөр хураамж авах сонирхолтой байдаг.

⁸⁴ <https://www.thefranchisebuilders.com/2013/09/20/types-franchise-agreements/>

⁸⁵ Н.Учрал: Монголыг гадаад ертөнцтэй холбох гүүр нь Франчайзинг

ОЛОН УЛСЫН ФРАНЧАЙЗИНГ


Олон Улсын Франчайзийн холбоо (IFA)-ноос гаргасан мэдээллээр, 2021 оны байдлаар нийт франчайз эрхлэгчдийн тоо 780,188 буюу өмнөх жилээс 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.⁸⁶ Франчайзийн салбарт хөдөлмөр эрхлэгчдийн тоо 8,252,929 болсон нь өмнөх оноос 10.2 хувиар өссөн байна. Мөн 2021 оны байдлаар 780 тэрбум долларын үр дүнтэй (output) ажиллаад байна. Олон улсын Франчайзингийн холбоо болон АНУ-ын Жижиг дунд бизнесийн холбооны тайланд дурдсанаар Даваагаас Баасан гариг хүртэлх ажлын таван өдөр, 8 минут тутамд шинэ франчайзингийн бизнесүүдээ нээдэг бөгөөд тэдгээрийн гэрээний дундаж хугацаа 10 жил байдаг тухай ЛокалВокс сайт дурджээ.

Хүснэгт 2. 2017-2020 оны франчайз бизнесийн эдийн засгийн үзүүлэлт

Franchise Business Economic outlook:2017-2021 (Франчайзийн бизнес-эдий засгийн тойм)

	2017	2018	2019	2020	2021
<i>Шинээр байгуулагдсан (өөрчлөлт %-уар) Establishments</i>	748,752	760,476	773,603	753,770	780,188
<i>Ажиллагсдын тоо Employment</i>	7,975,179	8,207,599	8,434,090	7,491,456	8,242,929
<i>Орлого %-уар Outputs (\$billions)</i>	\$720.4	\$760.3	\$787.5	\$670.0	\$780.0
<i>ДНБ %-уар GDP (\$billions)</i>	\$427.5	\$452.1	\$473.4	\$446.3	\$477.4
<i>Percentage change</i>					

Олон улсын франчайзийн холбооноос гаргасан франчайзингийн эдийн засгийн төлөв байдлын судалгаанаас үзвэл, франчайз бизнес эрхлэгчдийн тоо, ажиллагсдын тоо болон үйлдвэрлэлийн хэмжээ гэсэн 3 үзүүлэлт цар тахлын улмаас 2020 оноос эхлэн зарим салбарын хувьд бага зэрэг буурсан ч гэлээ зарим салбарын хувьд ашиг хүртэн салбартаа илүү тэлэлтийг хийсэн байна. Жишээ нь “Commercial& Residential services” буюу арилжаа ба орон сууцны үйлчилгээний салбарыг хамгийн ашигтай ажилласан франчайзийн салбараар нэрлэсэн байна. Учир нь цар тахлын үед ихэнх хүмүүс гэртээ байгаа тул барилга орон сууцны засвар, цэвэрлэгээний үйлчилгээ эрэлттэй байна. 2021 оны таамаглалаар уг салбарт франчайз бизнес эрхлэгчдийн тоо 3.4 хувиар, ажил эрхлэлтийн тоо 48,000 ажлын байр, үйлдвэрлэлтийн хэмжээний хувьд 53.3 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна гэж судлаачид тооцжээ.



⁸⁶ Олон улсын франчайзын холбоо https://www.franchise.org/sites/default/files/2021-02/Economic%20Outlook%202021_web2.pdf

Хүснэгт 3. 2021 оны франчайз бизнесийн эдийн засгийн урьдчилсан төлөв

Franchise Economic Outlook by Industry 2021 Forecast									
	Establishments (Байгууллагын тоо)			Employment (Ажилчид)			Output (\$Billion) (Орлого)		
	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
Commercial & residential service	67,226	73,116	75,627	252,803	253,682	301,706	\$45	\$49	\$53
Real State	65,307	6,332	68,657	262,130	245,437	285,820	\$55	\$48	\$60
Retail food, Product & service	155,649	157,538	162,669	1,061,686	1,014,127	115,571	\$118	\$121	\$127
Business Service	106,936	107,789	110,241	650,489	588,475	650,591	\$106	\$93	\$105

Source: International finance association Economic outlook 2021

ОЛОН УЛСЫН ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭ БА ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Франчайзинг бизнесийн харилцааг зохицуулах дараах үндсэн 2 баримт бичиг⁸⁷ байна.

- Франчайзторын нөхцөлүүдийг тодорхойлсон баримт бичиг
- Франчайзингийн гэрээ

Франчайз эрх шилжүүлэгчийн нөхцөлүүдийг тодорхойлсон баримт бичиг (FDD) 1960 оноос хойш франчайзинг бизнес хэт эрчимтэй хөгжсөнөөс үүдэн зарим франчайз эрх шилжүүлэгч компаниуд худал сурталчилгаа явуулан, маш муу загварчлагдсан системийг худалдаж байжээ. Үүнээс үүдэн 1968 онд Калифорни муж анхлан франчайзингийн хуулийн төслийг боловсруулжээ. Үүний дараагаар FTC (Federal Trade Commission) буюу Холбооны худалдааны комисс нь 1978 онд франчайзингийн тухай (The Franchise Rule⁸⁸) дүрмийг батлан франчайзоруудыг тавигдах шаардлага, нөхцөлүүдээ тодорхойлсон баримт бичгийг загварчлах, түүнийгээ дагаж мөрдөхийг шаардах болжээ. Үүнийг UFOC (Uniform Franchise Offering Circular) гэж нэрлэдэг байсан ба 2007 оноос FDD (Franchise Disclosure Documents) гэж нэрлэх болсон. Уг багцад нийт 23⁸⁹ баримт бичиг байдаг ба бүрэн эхээр нь доорх холбоосоор үзэх боломжтой.⁹⁰ Үүнд:

1. Франчайз эрх шилжүүлэгч талын мэдээлэл /The Franchisor And Any Parents, Predecessors, And Affiliates/
2. Компанийн туршлага /Business Experience/
3. Шүүхийн шийдвэр Франчайз эрх шилжүүлэгчийн дампуурсан болон шүүхээр орж байсан хэргүүдийн түүх /Litigation/
4. Банкны тайлан /Bankruptcy/
5. Эхэнд авах төлбөр /Initial Fees/
6. Бусад төлбөр /Other Fees/
7. Тооцоолсон анхны хөрөнгө оруулалт /Estimated Initial Investment/

⁸⁷ <https://www.epgdllaw.com/what-is-the-difference-between-franchise-agreements-and-franchise-disclosure-documents/>

⁸⁸ <https://www.franchise.org/faqs/legal/what-is-the-ftc-franchise-rule>

⁸⁹ <https://www.franchise.org/what-information-does-a-franchise-disclosure-document-fdd-contain>

⁹⁰ Franchise rule <https://www.ftc.gov/system/files/documents/plain-language/bus70-franchise-rule-compliance-guide.pdf>

8. Бүтээгдэхүүн, үйлчилгээний хязгаарлалт /Restrictions On Sources Of Products And Services/
9. Франчайз хүлээн авагчийн эрх үүрэг /Franchisee's Obligations/
10. Санхүүгийн мэдээлэл /Financing/
11. Франчайз эрх шилжүүлэгчийн тусламж, сурталчилгаа, компьютерийн систем, сургалт /Franchisor's Assistance, Advertising, Computer Systems, And Training/
12. Байрлал, газар нутаг /Territory/
13. Барааны тэмдэг /Trademarks/
14. Патент, зохиогчийн эрх, хувийн өмчийн мэдээлэл /Patents, Copyrights, And Proprietary Information/
15. Франчайз бизнесийн үйл ажиллагаанд оролцох үүрэг /Obligation To Participate In The Actual Operation Of The Franchise Business/
16. Франчайз хүлээн авагчийн худалдааны хязгаарлалт /Restrictions On What The Franchisee May Sell/
17. Шинэчлэх, цуцлах, шилжүүлэх, маргаан шийдвэрлэх тухай /Renewal, Termination, Transfer, And Dispute Resolution/
18. Олон нийтийн мэдээлэл /Public Figures/
19. Санхүүгийн гүйцэтгэлийн танилцуулга /Financial Performance Representations/
20. Борлуулалт, франчайз хүлээн авагчийн мэдээлэл /Outlets And Franchisee Information/
21. Санхүүгийн тайлан /Financial Statements/
22. Гэрээ /Contracts/
23. Баримт /Receipts/ зэрэг 23 баримт бичиг багтдаг.⁹¹

Франчайзийн гэрээ

Франчайзийн харилцааны эрх зүйн голлох баримт бичиг нь:

- Франчайзийн системийн мэдэгдэл (Franchise Offering Circular)
- Франчайзийн гэрээ (franchising contract)

Франчайзийн системийн мэдэгдэл /FOC/-ийн зорилго нь франчайз шилжүүлэгчийн тухай болон франчайзийн системийн танилцуулга, мөн албан ёсны болгож гарын үсэг зурах ёстой гэрээний тухай мэдээллээр франчайз хүлээн авагчдыг хангах явдал юм.

Франчайзийн системийн мэдэгдэлд нийтлэг байдлаар дараах мэдээллийг багтаадаг. Үүнд:

- франчайз шилжүүлэгч, түүний харьяа компаниуд
- компанийн удирдах ажилтнууд
- франчайзийн системийн үйл ажиллагаа
- франчайзийн туршлага
- франчайзийн эхлэлтийн болон байнгын төлбөр
- шаардлагатай хөрөнгө оруулалт ба худалдан авалт
- нутаг дэвсгэрийн эрх
- франчайз шилжүүлэгч, франчайз хүлээн авагчийн үүрэг
- тухайн франчайзийн системийг ашиглаж байгаа бусад франчайз хүлээн авагчид
- мэдээллийг олгох хугацаа
- бусад шаардлагатай заалт

⁹¹ Disclosure basic BASICS-TRACK-Disclosure-Basics.pdf

Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэгч нь өөрийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.⁹²

Франчайзийн гэрээнд Франчайз шилжүүлэгчийн үүрэг нилээд чухал байдаг. Ерөнхийдөө гэрээнд дараах заалтууд зайлшгүй тусгагдсан байна. Үүнд:

- Франчайз шилжүүлэгчийн эрх үүрэг
- Франчайз хүлээн авагчийн эрх үүрэг
- Франчайз авагчид шилжүүлсэн эрх, онцгой эрх, хөнгөлөлт
- Франчайз хүлээн авагчаас төлөх төлбөр
- Гэрээний үргэлжлэх хугацаа
- Гэрээг сунгах үндэслэл
- Франчайзийн үйл ажиллагаанд нэгдэн орох зорилгоор хийсэн хөрөнгө оруулалтыг эргэн төлөгдөхөд хангалттай байх
- Франчайз хүлээн авагчийн санаачлагаар Франчайзаа худалдах буюу шилжүүлэх, энэ тохиолдолд гэрээг Франчайз шилжүүлэгчийн санаачилгаар битүүмжлэх эрхийн талаарх заалт
- Франчайзийг ашиглах тухай заалт
- Франчайзийн тогтолцоонд Франчайз шилжүүлэгчийн зүгээс өөрчлөлт хийх, шинэлэг арга нэвтрүүлэх эрх
- Гэрээг цуцлах нөхцөлүүд
- Гэрээг цуцласны дараа Франчайз шилжүүлэгчийн буюу бусад өмчлөгчийн мэдэлд буй оюуны болон бусад хөрөнгийг шилжүүлэх тухай заалт


Франчайзийн гэрээний үндсэн зарчим бол эрх шилжүүлэгчийн ноу хау-г (know-how) эрх хүлээн авагчийн хөрөнгө мөнгөтэй уялдуулж шилжүүлэхэд оршино. Франчайзлагдсан систем гэдэг нь бараа худалдах, үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах нэг буюу хэд хэдэн барааны тэмдэг, хуулийн этгээдийн нэр, бүтээгдэхүүний загвар, шинэ бүтээл, зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлүүд, ноу хау, бизнесийн нууцад хамаарах оюуны өмчийн систем юм. Энэ утгаараа оюуны өмчтэй зайлшгүй холбогддог бөгөөд франчайзинг нь бүхэлдээ оюуны өмчийг ашиглах хэлбэр байдаг.⁹³

Франчайзийн гэрээнд:

- Оюуны өмчид харьяалагдах зүйлс буюу шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр, үйлчилгээний тэмдэг зэрэг үйлдвэрлэлийн эрхүүд.
- Худалдааны эрх буюу хууль ёсны дагуу үйлдвэрлэсэн зүйлсээ зарж борлуулах эрх.
- Бизнес систем буюу тухайн барааг үйлдвэрлэх, боловсруулах болон үйлчилгээ үзүүлэх тогтсон арга, хадгалах систем, удирдлагын систем, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн систем, эд хөрөнгийн хяналт болон худалдаа үйлчилгээний нэгдмэл бодлого гэх мэт зүйлсийг багтаадаг байна.

⁹² Монгол Улсын Иргэний хуулийн 333.1 дэх заалт

⁹³ <https://www.globalnegotiator.com/en/international-franchise-contract-template>



Эх сурвалж: *Franchising: Hybrid organisational arrangement for firm growth and national development*

Франчайзийн гэрээнд франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагч талуудын эрх үүргийг нарийвчлан зааж өгөх шаардлагатай.⁹⁴ Үүнд:

- Гэрээ байгуулах талууд;
- Нэр томъёоны тодорхойлолт;
- Франчайзинг систем – бүтээгдэхүүн болон брэнд нэрийг ашиглах;
- Барааны тэмдгийн стандарт болон шаардлага;
- Бүтээгдэхүүн болон үйл ажиллагааны стандарт болон шаардлага;
- Ажилтан болон хяналтын стандарт, түүнд тавих шаардлага;
- Хамрагдах газар нутаг;
- Талуудын эрх үүрэг: стандарт, үйл ажиллагаа, сургалт, зааварчилгаа,
- Сурталчилгаа гэх мэт;
- Франчайзийн хугацаа болон хугацааг сунгах;
- Франчайз эзэмшигчээс франчайзорт төлөх шимтгэл;
- Франчайзингийг зогсоох эсвэл шилжүүлэх эрх;
- Маргаан шийдвэрлэх;
- Зөрчлийг шийдвэрлэх болон гэрээг цуцлах;
- Гэрээг дуусгавар болгосны дараах үүрэг;
- Ерөнхий нөхцөл.

Зарим тохиолдолд хуулинд заасан эдгээр эрх үүргүүдээр хязгаарлагдахгүй, талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд нэмэлтээр эрх үүргүүдийг тусгаж болдог.

Олон улсын Франчайзийн эрх зүйн зохицуулалт

Олон Улсын франчайзийн зохицуулалт нь тухайн улсын хуулинд тодорхой тусгагдаагүй тохиолдолд олон улсын худалдаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудаар

⁹⁴ <https://www.franchisedirect.ie/information/the-franchisees-rights-and-responsibilities>

зохицуулагдана.⁹⁵ Олон улсын зохицуулалт нь өөр өөр орнуудад, франчайз шилжүүлэгч болон франчайз хүлээн авагч талуудын аль аль талд давуу эрх олгох, эсхүл сул тал үүсгэхгүй байхад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, аливаа улсын хууль тогтоомжийн онцлогоос зайлсхийж, маргаан гарсан тохиолдолд, эсхүл тухайн улсын хуулинд заагдаагүй зохицуулалтын шинжтэй маргаан гарсан тохиолдолд олон улсын зохицуулалтын журмаар шийддэг байна. Жишээ нь Олон улсын худалдааны гэрээ (International Commercial Contracts) Unidroit Principles⁹⁶-ний зарчмуудыг дурдаж болно. UNIDROIT бол Засгийн газар хоорондын байгууллага бөгөөд олон улсын эрх зүйг (Private law) нэгдсэн дүрэм журам, олон улсын конвенц, загвар хууль, чиглэл гаргах замаар нэгтгэх зорилготой байгууллага юм. UNIDROIT-н 2007 онд гаргасан Мастер франчайзийн гэрээ, түүнд холбогдох бусад гэрээ хэлэлцээрийн зохицуулалтыг тусгасан зөвлөмж, чиглэл (guide) байдаг ба энэ нь нийт 20 бүлэгтэй.⁹⁷

	GUIDE TO INTERNATIONAL MASTER FRANCHISE ARRANGEMENT 2007
БҮЛЭГ 1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	A. Мастер франчайзийн гэрээ, зөвшөөрөл B. Бусад улсад франчайзийг өргөжүүлэх хэлэлцээр
БҮЛЭГ 2 ТАЛУУДЫН ХАРИЛЦАА, ЭРХ	A. Зөвшөөрөгдсөн зүйл B. Лицензтэй хөрөнгийг хэрхэн ашиглах талаар C. Эрх D. Онцгой байдал болон Онцгой бус байдал E. Франчайзийн мастерын зохицуулалтын гурван шатлалт бүтэц F. Гэрээний шууд харилцаа
БҮЛЭГ 3 ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, СЭРГЭЭХ НӨХЦӨЛ	A. Гэрээний хугацаа B. Шинэчлэх нөхцөл C. Гэрээг шинэчлэх хэлэлцээр
БҮЛЭГ 4 САНХҮҮГИЙН ХАРИЛЦАА	A. Орлогын хуваарь B. Франчайз шилжүүлэгчийн орлогын эх үүсвэр C. Дэд франчайз шилжүүлэгчийн орлогын эх үүсвэр D. Төлбөр тооцоо, журам E. Төсвийн асуудал
БҮЛЭГ 5 ФРАНЧАЙЗ ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ	A. Мэдээлэл өгөх үүрэг B. Сургалт C. Гарын авлага материал D. Тусламж болон бусад үйлчилгээ E. Бусад үүрэг F. Франчайз шилжүүлэгчийн эрх
БҮЛЭГ 6 ДЭД ФРАНЧАЙЗЕРЫН ҮҮРЭГ	A. Туршилтын ажиллагаа B. Хөгжлийн хуваарь C. Хөгжлийн хуваарийг шинэчлэх D. Үйл ажиллагааны үүрэг E. Хэлний асуудал
БҮЛЭГ 7 ДЭД ФРАНШИЗИЙН ГЭРЭЭ	A. Заасан стандартын гэрээний дүрмийг дагаж мөрдөх B. Зарим заавал дагаж мөрдөх заалтууд
БҮЛЭГ 8 РЕКЛАМ, ЗАР СУРТАЛЧИЛГАА	A. Зөвшөөрөл, зар сурталчилгааны материалыг ашиглах B. Орчуулга C. Санхүүгийн асуудал
БҮЛЭГ 9 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАНГАМЖ	A. Нийлүүлэлтийн эх үүсвэр B. Франчайзер/дэд франчайзерын харилцаа C. Нийлүүлэлтийн харилцааны зохицуулалт D. Гэрээний заалтууд

⁹⁵ ICC model international franchising contract

⁹⁶ UNIDROIT is an intergovernmental organization whose objective is to harmonize international private law across countries through uniform rules, international conventions, and the production of model laws, sets of principles, guides and guidelines.

⁹⁷ <https://www.unidroit.org/publications/106-unidroit-publications/97-guide-to-international-master-franchise-arrangements-second-edition-2007>

БҮЛЭГ 10 ОЮУНЫ ӨМЧ	А. Барааны тэмдэг В. Зохиогчийн эрх
БҮЛЭГ 11 ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ НУУЦ	А. Франчайзийн гэрээнд ноу-хаугийн функциональ үүрэг В. Ноу-хау, Худалдааны нууц etc
БҮЛЭГ 12 СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ	А. Франчайзийн харилцааны өөрчлөлт В. Өөрчлөлтийг хийх нөхцөл
БҮЛЭГ 13 ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ	А. Шилжүүлэг хийх нөхцөл В. Дэд франчайз шилжүүлэгч хязгаарлалтгүйгээр шилжүүлэг хийхээс урьдчилан сэргийлэх
БҮЛЭГ 14 ХАРИУЦЛАГА, БА ДААТГАЛ	А. Нөхөн төлбөр В. Даатгал
БҮЛЭГ 15 ХОРИГЛОХ ЖУРАМ	А. Түр хугацаанд цуцлах В. Цуцлах
БҮЛЭГ 16 ГЭРЭЭНИЙ ТӨГСГӨЛ	А. Мастер франчайзийн харилцаа үүсч, дуусах арга замууд
18 -Р БҮЛЭГ БУСАД ЗААЛТУУД	А. Гэрээний төгсгөлтэй холбоотой заалтууд
БҮЛЭГ 19 БАРИМТ БИЧИГ	А. Жилийн эцсийн баримт бичиг
БҮЛЭГ 20 ЗОХИЦУУЛАЛТ	А. Лиценз ба зөвшөөрлийн шаардлага В. Зөвшөөрөл зэмшигч

Бусад орнуудын франчайзийн хуулиуд

Олон улсад франчайзийн гэрээний харилцааг тухайн улс орон бүр өөр өөрийн тусгайлсан хууль, журам, дүрмээр зохицуулж байна. 2019 онд Global Franchise Regulation⁹⁸ тайланд зохицуулалтын эрх зүйн актуудыг дараах байдлаар эмхэтгэн гаргасан байна.

Европын холбооноос гаргасан журам	Мэдээлэл хамгаалах ерөнхий журам (The European General Data Protection Regulation (GDPR) (2018.05.25) (Европын холбооны (ЕХ) оршин суугчдын хувийн мэдээллийг хамгаалахыг Франчайзор ба Франчайз эзэмшигч компаниудаас шаарддаг. ⁹⁹)
	Худалдааны нууцлалын журам (Trade secrets) (2018.06.69) (ЕХ-оос худалдааны нууцлалыг хамгаалах стандартыг тогтоосон ба гишүүн орнууд 2 жил дагаж мөрдөнө.
	Франчайзийн тайлан (Franchise report) (2017.05.17) (ЕХ-ны парламент ЕХ-ны франчайзингийн нөлөөг судлах, шударга бус арилжааг судлах, өрсөлдөөний тухай хууль франчайзингийн нөлөө "зах зээлийн бодит байдал"-ыг тусгасан эсэхийг үнэлэх тайлан гаргах тухай оруулсан. ¹⁰⁰ EU Vertical Block Exemption (VBER) Evaluation European Franchise Federation
Australia	Франчайзингийн талаарх парламентын лавлагаа (Parliamentary Inquiry into Franchising 2018.03) Австралийн Хэрэглэгчийн тухай хууль-Шударга бус гэрээний нөхцөл (2016.11.12) Австралийн шударга бизнес эрхлэх тухай хууль (2017.10.27)
Камбож	Франчайзийг хамгаалах тухай хууль (Franchise Protection Law 2017.05.05)
Канад	Британи Колумбын баримт бичгийн тухай хууль British Columbia Disclosure Law (Effective February 1, 2017).
Египет	Египетийн франчайзийн тухай хууль Revised Proposed Egyptian Franchise Law (January, 2019).

⁹⁸ Global Franchise Regulation Update by Carl E.Zwisler 2019

⁹⁹ THE EUROPEAN GENERAL DATA PROTECTION REGULATION (GDPR)

¹⁰⁰ https://www.europarl.europa.eu/doceo/document/TA-8-2017-0322_EN.html

Франц	El Khomri Law Franchise Provisions Repealed (Labor Law of August 8, 2016) Decree No. 2017- 773 Civil Code Amendments (Ordinance N°2016-131 of February 10, 2016 for the Reform of Contract Law. Effective October 1, 2017)
Герман	Franchise Disclosure Requirements Discussed Франчайзийн баримт бичгийн тухай хууль
Хонгконг	Өрсөлдөөний комиссын зөвлөмж Competition Commission Advisory (April 9, 2018)
Ирак	Арилжааны агентлагийн тухай хууль Commercial Agency Law Amended (Effective November 13, 2017)
Япон	Франчайзийн гэрээг зөрчсөн тохиодолд цуцлах тухай арга хэмжээ Clarifies remedies for breach of contract and specifically only permits franchise agreements to be terminated for material violations of a contract.
Кувейт	Арилжааны агентлагийн тухай хууль Commercial Agencies Law (Enacted March, 2016; Amended April 23, 2017)
Намиби (Namibia) (Өмнөд Африк)	Франчайзийн тухай хуулийг боловсруулах тухай хууль Desire for Development of Franchise Laws (Winter, 2017)
Нидерланд	Draft Legislative Proposal regarding Special Regulation on Franchise Agreements Issued for Comment (December 12, 2018)
Шинэ Зеланд	Department of Economic development, Science and Innovation Rejects Proposal to Exempt Franchises from Cartel Legislation (October, 2018)
Катар	Арилжааны агентлагийн тухай хууль Commercial Agency Law Amended (Effective 2016)
Солонгос	Франчайзийн тухай хууль Amendments to Franchise Act (Proposed Summer, 2017)
Испани	Update–Franchise Registration Requirements Cancelled (Effective December 7, 2018)
Вьетнам	Гадаадын франчайз эзэмшигчийн бүртгэлд тавигдах шаардлага Registration Requirements for Foreign Franchisors (Amended September, 2017)
Америк	Federal Trade Commission (FTC) / Department of Justice (DOJ) Antitrust Division-emorandum on Anti-poaching (of employees) Agreements (October, 2016). Small Business Administration Franchise Finance Reform (Effective January 1, 2018). California AB 525-Franchise Relationships (Effective January, 2016). State Franchise/Independent Contractor Laws. FTC Franchise Rule Review. State Franchise Relationships.



БҮЛЭГ II. МОНГОЛ УЛС ДАХЬ ФРАНЧАЙЗИНГИЙН ХАРИЛЦАА, ЭРХ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ФРАНЧАЙЗИНГ БИЗНЕСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсад 2001 онд MCS групп нь анх үйлдвэрлэлийн франчайз эрхийг Coca Cola компаниас авч энэ төрлийн бизнес форматыг эх орондоо нэвтрүүлсэн.¹⁰¹ Үүнийг даган франчайзингийн гэрээний ойлголтыг 2002 онд Монгол Улсын Иргэний хуульд шинээр нэмж оруулсан. Монгол Улсын аж ахуйн нэгжүүд гадаад барааны тэмдэг, худалдааны нэрийг ашиглах бүтээгдэхүүн үйлчилгээний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн франчайзингийн систем бүрдэж эхэлж байгаа ба 2013 оноос хойш “Coffee bean”, “Tom N Toms” зэрэг франчайзингууд нээгдсээр байна. Сүүлийн жилүүдэд Монголд бизнесийн форматын төрлөөр амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа “E-Mart” нь худалдаа үйлчилгээний салбарт шинэ дэвшил авчирч байна.

Хүснэгт 4. Монголд үйл ажиллагаа явуулж буй зарим бизнесийн форматтай франчайзинг

Франчайз	Үүсгэн байгуулагдсан хот/Улс	Нийт салбарын тоо	Монгол дахь салбарын тоо	Монголд нээгдсэн он	Франчайз эрх эзэмшигч компани
KFC	1952, Kentucky, USA	22'621	12	2013	Таван богд групп
Pizza Hut	1958, Kansas, USA	17'149	13	2014	Таван богд групп
Roundtable pizza	1959 California, USA	450	1	2012	
Burger King	1954, Florida Usa	17'796	9	2015	Макс групп
Littlesheep hotpot	1999, Inner Mongolia, China	300	2	2017	Таван богд групп
Hard Rock	1971, London, England	185	1	2017	
Bd's barbeque	1992, USA	21	1	2005	Модерн номадс
Lotteria	1979, Korea	1500	2	2007	Южинтек Монголиа
BBQ chicken	1995, Korea	4000	5	2017	
Шоколадница	1964, Russia	332	332		Номин холдинг
Re/Max	1973, Denver, Colorado, USA	140 гаруй улсад салбартай ¹⁰² 1200 гишүүнтэй		2018	
CU	1990, Korea	13'500	100 гаруй салбартай ¹⁰³	2018	Цэнтрал Экспресс Си Ви Эс
Circle K	1951 USA	16'000 ¹⁰⁴		2018	
Gs 25	1990 Korea	13899 ¹⁰⁵	50	2021 ¹⁰⁶	Шунхлай групп

¹⁰¹ Ноолуурын бүтээгдэхүүнийг экспортлох франчайзийн судалгаа Б.Алтанбуян 2020

¹⁰² <https://en.wikipedia.org/wiki/RE/MAX>

¹⁰³ <http://cumongol.mn/about>

¹⁰⁴ <http://www.circlek.mn/3/about/Circle-K-%D0%91%D1%80%D1%8D%D0%BD%D0%B4>

¹⁰⁵ <https://en.wikipedia.org/wiki/GS25>

¹⁰⁶ <https://gs25.mn/gs25-overview#>

Монгол Улсад түргэн хоол болон рестораны чиглэлийн бизнесийн форматын франчайзингаас гадна гадны томоохон кофе шоп болон зочид буудлуудын франчайзинг салбарууд нээгдэн үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

ФРАНЧАЙЗИНГИЙН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дэлхийд 33¹⁰⁷ улс франчайзийг зохицуулсан тусгайлсан хуультай байх ба ихэнхи орнууд энэхүү харилцааг Иргэний хууль, Худалдааны хууль, Оюуны өмчийн тухай хууль болон бусад хуулийн хүрээнд зохицуулдаг байна.¹⁰⁸ Тухайлбал, Япон Улсад Дунд болон жижиглэнгийн худалдааг дэмжих тухай акт (Act No. 110 of 1973)-аар зохицуулдаг. БНХАУ-д Франчайзийн тухай хуулийг анх 1997 онд баталсан бөгөөд 2007 онд дахин шинэчлэн баталсан. Герман улсад Франчайзийг зохицуулсан хууль буюу тусгайлсан акт байхгүй боловч франчайзийн гэрээ байгуулахтай холбоотой харилцааг Иргэний хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Арилжааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, болон Шударга бус худалдааны тухай хуулиар зохицуулдаг.

Монгол Улсад ын Франчайзтай холбоотой эрх зүйн түүхэн товчооны хувьд 1926 оны БНМАУ-Иргэний хуульд аливаа иргэний хэргийн учраа харилцан эдлэх ба хүлээх эрх үүргийн тухай (8, 9 р бүлэг) тусгаснаас эхлэлтэй ба уг хуульд нэмэлт өөрчлөлт орсоор 1994 оюуны үнэт зүйлийг ашиглах түүний нийтлэг үндэслэл үүргийн талаар тусгасан байдаг. Энэ нь франчайзийн гэрээний талаарх эрх зүйн үндэс болсон ба 2002 онд Иргэний хуулийн 333.1 зүйлд албан ёсоор Франчайзийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг тусгасан.¹⁰⁹

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛИЙН 29-Р БҮЛЭГ

Франчайз, Мерчандайз

333 дугаар зүйл. Франчайзийн гэрээ

333.1. Франчайзийн гэрээгээр **эрх шилжүүлэгч** нь өөрийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг **эрх хүлээн авагчид** олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

Мөн уг хуулинд гэрээний талуудын эрх үүрэг, Франчайзийн гэрээний хэлбэр, хугацаа, талуудын хүлээх хариуцлага, өрсөлдөөнийг хязгаарлахтай холбоотой зүйлүүдийг тус тус тусгасан байна.¹¹⁰

334 дүгээр зүйл. Гэрээний талуудын үүрэг

334.1. Эрх шилжүүлэгч дараахь үүрэгтэй:

334.1.1. хамтын ажиллагааны хөтөлбөрийг гуравдагч этгээдийн оролцооноос хамгаалах;

¹⁰⁷ <https://thelawreviews.co.uk/title/the-franchise-law-review/the-regulation-of-franchising-around-the-world>

¹⁰⁸ Франчайзийн гэрээний эрх зүйн зохицуулалт (Монгол өмгөөлөгч хууль зүйн фирм) 2016

¹⁰⁹ /Энэ бүлгийн гарчигт 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

¹¹⁰ <https://www.legalinfo.mn/law/details/299>

- 334.1.2.хөтөлбөрийг байнга боловсронгуй болгох;
- 334.1.3.эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах;
- 334.1.4.эрх хүлээн авагчид техникийн туслалцаа үзүүлэх;
- 334.1.5.эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах.
- 334.2.Эрх хүлээн авагч дараахь үүрэгтэй:
- 334.2.1.гэрээгээр хүлээж авсан эрх, эд хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах;
- 334.2.2.зохих шагнал, хураамж, орлогын тодорхой хувийг тогтоосон хугацаанд төлөх;
- 334.2.3.гэрээнд заасан бол шилжүүлэн авсан эрх, эд хөрөнгийг эрх шилжүүлэгчид ашигтайгаар даатгуулах;
- 334.2.4.эрх шилжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр лиценз болон франчайзийн гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;
- 334.2.5.гэрээнд заасан бол эрх шилжүүлэгчээс хэрэгжүүлж байгаа сургалтад ажиллагсдыг хамруулах, холбогдох зардлыг төлөх;
- 334.2.6.эрх шилжүүлэгчийн барааны болон ажил үйлчилгээний тэмдгийг хэрэглэхдээ лицензээр хэрэглэж байгаа тухай харилцагч болон үйлчлүүлэгчид заавал мэдэгдэх.
- 334.3.Талууд гэрээ байгуулахдаа шаардлагатай бүхий л мэдээллийг шударгаар харилцан солилцох, гэрээ байгуулагдахгүй тохиолдолд мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

335 дугаар зүйл. Франчайзийн гэрээний хэлбэр

335.1.Хуульд өөрөөр заагаагүй бол франчайзийн гэрээг бичгээр хийнэ.

/Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

335.2.Франчайзийн гэрээнд гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээ цуцлах, хугацаа сунгах журам, талуудын хүлээх үүрэг бусад гол нөхцөлүүдийг заахын зэрэгцээ франчайзийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг бүрэн тусгана.

336 дугаар зүйл. Франчайзийн гэрээний хугацаа

336.1.Франчайзийн гэрээний хугацааг тухайн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний эрэлт хэрэгцээ, борлуулалтын зах зээлээс шалтгаалан талууд тохиролцон тогтооно.

336.2.Франчайзийн гэрээг арван жилээс дээш хугацаагаар байгуулсан нөхцөлд 10 жил өнгөрсний дараа, хугацааг гэрээгээр тодорхойлоогүй бол талуудын аль нэг нь гэрээг цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш нэг жилийн дотор цуцалж болно.

336.3.Гэрээнд заасан хугацаа дууссан боловч аль нэг талын санаачилгаар талууд харилцан итгэлцэх, хамтран ажиллах зарчмыг удирдлага болгон ажил хэргийн харилцаа дуусгавар болох хүртэл гэрээгээ тодорхой буюу тодорхой бус хугацаагаар тухайн буюу шинэчилсэн нөхцөлөөр сунгаж болно.

337 дугаар зүйл. Өрсөлдөөнийг хязгаарлах

337.1.Эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээ дуусгавар болсны дараа эрх хүлээн авагчийг тодорхой нутаг дэвсгэрт өөртэйгээ өрсөлдөхийг нэг жил хүртэл хугацаагаар хориглох эрхтэй.

337.2.Энэ хуулийн 337.1-д заасан хориг нь эрх хүлээн авагчийн үндсэн үйл ажиллагаанд ноцтой хохирол бий болгож байвал эрх шилжүүлэгч түүнд зохих мөнгөн төлбөр төлөх үүрэгтэй.

338 дугаар зүйл. Талуудын хүлээх хариуцлага

338.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл болон өгсөн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

338.2.Эрх хүлээн авагч франчайзийн гэрээний үүрэгтэй холбоотой эрх шилжүүлэгчид учруулсан хохирол, зардлыг түүнд нөхөн төлөх үүрэгтэй.

338.3.Эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээний үр дүнд эрх хүлээн авагчийн олох орлогын талаар баталгаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй.

338.4.Эрх хүлээн авагчийн гэм буруутай үйл ажиллагаанаас болж үйлчлүүлэгчид учирсан хохирлыг эрх шилжүүлэгч хариуцахгүй.

338¹ дүгээр зүйл. Мерчандайзийн гэрээ

338¹.1.Мерчандайзийн гэрээгээр бие хүний нэр, төрх, дуу хоолой болон утга зохиол, урлагийн бүтээл, эд зүйлийн дүр, зургийг бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах эрхийг өмчлөгч, эзэмшигчээс үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь өмчлөгч, эзэмшигчид борлуулалтын орлогоос нэр, төрх, дуу, хоолой, дүр, зургийг ашигласны төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

338¹.2.Хуульд өөрөөр заагаагүй бол мерчандайзийн гэрээг бичгээр хийнэ.

/Дээрх 3381 дүгээр зүйлийг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

Мөн түүнчлэн **Хөрөнгө оруулалтын тухай** хуулийн 5 дугаар зүйлд хөрөнгө оруулалтын хэлбэр хэсэгт санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх талаар тусгасан байдаг.¹¹¹

Манай улсын тухайд франчайзийн гэрээний зохицуулалтыг ерөнхий зохицуулсан тул франчайзийн гэрээ байгуулах талууд франчайзийн гэрээндээ нарийвчлан тодорхой тусгах шаардлагатай. Жишээ нь төлбөр, торгууль, гэрээ цуцлах, хохирлыг барагдуулах, маргааныг шийдвэрлэх зэрэг нь дээрх иргэний хуульд тусгагдаагүй тул франчайзийн гэрээндээ тусгадаг байна.¹¹²

БҮЛЭГ III. ФРАНЧАЙЗИНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**НЭГ. КАНАД УЛС**

Канад Улс нь хүчтэй эдийн засагтай, байршлын хувьд АНУ-тай ойр байрладаг тул франчайз эрх шилжүүлэгч компаниуд олон улсын зах зээлд бизнесээ өргөжүүлэхдээ юуны өмнө Канад руу ихээхэн чиглэдэг байна. Канадад ойролцоогоор 1300 франчайз брэнд, 75000 гаруй франчайзийн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд жижиглэн худалдаа, аялал жуулчлал, автомашин, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг эдийн засгийн 50 гаруй салбарт франчайзинг нэвтрээд байна. Канад Улсын дотооддоо зарцуулж буй 5 доллар тутмын 1 нь франчайзингийн бизнест зарцуулагддаг бөгөөд энэ салбар нь жилд 96 тэрбум долларыг тус улсын ДНБ-д нэмэрлэдэг.¹¹³

Франчайзингийн эрх зүйн зохицуулалт

Канад Улсад франчайзийг мужийн түвшинд зохицуулдаг ба улсын хэмжээнд зохицуулсан нэгдсэн хууль байдаггүй. Одоогийн байдлаар Канад Улсын 6 муж

¹¹¹ <https://www.legalinfo.mn/law/details/9491>

¹¹² Grata International хуулийн Фирм <https://gratanet.com/laravel-filemanager/files/3/Mongolia-Legal%20Article-Franchise%20MN.pdf>

¹¹³ <https://gowlingwlg.com/en/insights-resources/guides/2020/doing-business-in-canada-franchise-law/>

франчайзийн тухай бие даасан хуультай байна. Үүнд Бритиш Колумб, Альберта, Манитоба, Онтарио, Принс Эдвардын арал, Нью Брунсвик орж байна.

Мужуудын Франчайзингийн тухай хууль тогтоомжууд үндсэндээ ижил байдаг бөгөөд зарим мужийн онцлогоос хамаарч зарим нэг нарийвчилсан заалтууд тусгагдсан байдаг. Эрх зүйн зохицуулалт нь үндсэндээ эрх шилжүүлэхийн өмнөх бэлтгэл хангах ажиллагаа, франчайзийн гэрээний дагуу эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтад чиглэдэг. Хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах асуудлуудыг авч үзсэн.¹¹⁴

1. Эрх шилжүүлэхийн өмнө мэдээллийг ил тод болгох үүрэг
Франчайз эрх шилжүүлэгч нь франчайзтай холбоотой аливаа гэрээнд гарын үсэг зурахаас 14 -өөс доошгүй хоногийн өмнө франчайз эрх эзэмшигчид франчайзийн мэдээллийг ил тод болгох баримт бичгийг ("FDD- franchise disclosure document") өгөх ёстой. Уг баримт бичигт мэдээллийг задруулахгүй байхыг заахаас гадна, үйл ажиллагаа явуулах газар нутгийг заасан гэрээ байна. Мөн франчайз хүлээн авагч түнш нь франчайзерын тогтоосон аливаа төлбөрийг төлөх ёстой. Гэхдээ франчайзийн хураамж дээд тал нь 100,000 доллар буюу франчайзингийн төлбөрийн 20 хувиас хэтрэхгүй байна. Франчайзийн мэдээллийг ил тод болгох баримт бичиг нь франчайз хүлээн авагчаас франчайзийг худалдан авах шийдвэр гаргахад шаардлагатай бүх баримтуудыг багтаасан байх ёстой.
2. Шударга хэлцлийн үүрэг: Франчайзийн гэрээнд оролцогч талууд франчайзийн гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэхдээ хууль ёсны заалтын дагуу шударга ажиллах үүрэгтэй. Шударга худалдааны үүрэг нь сайн санааны зарчимд суурилсан байх ба арилжааны стандартад нийцүүлэн боломжит үнэ тогтоох үүргийг багтаасан байна.
3. Холбоонд нэгдэх эрх: Франчайз хүлээн авагч нь франчайз хүлээн авагчдын холбоо байгуулах, бусад франчайз хүлээн авагчидтай эвлэлдэн нэгдэх хууль ёсны эрхтэй. Энэ үйл ажиллагаанд франчайз эрх шилжүүлэгч хөндлөнгөөс ямар нэг байдлаар оролцохыг хориглодог.
4. Татгалзахгүй байх: Канадын франчайзийн тухай бүх хууль тогтоомжид франчайзийн гэрээнд оролцогч талуудыг мужийн франчайзийн дүрмээр олгогдсон аливаа эрх, үүргээсээ татгалзахыг хориглодог.
5. Цуцлах эрх: Франчайз хүлээн авагч дараах тохиолдолд ямар нэг үүрэг, торгууль хүлээлгүйгээр франчайзийн гэрээг цуцлах эрхтэй. (а) FDD баримт бичиг дутуу, эсхүл хуулийн шаардлагад нийцээгүй байвал баримт бичгийг хүлээн авсанаас 60 хоногийн дотор гэрээг цуцлах эрхтэй. (б) франчайз эрх шилжүүлэгч нь гэрээ байгуулсанаас хойш FDD баримт бичгийг огт гаргаж өгөөгүй бол хоёр жилийн дотор цуцлах эрхтэй.

Альберта мужийн Франчайзингийн тухай хууль

(Franchises act, statutes of Alberta¹¹⁵)

Энэ хууль нь франчайз эрх шилжүүлэгчид шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь ил болгох үүрэг хүлээлгэж, франчайз хүлээн авагчдад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нь туслах, энэхүү хуулийг зөрчсөн тохиолдолд иргэний зүгээс арга хэмжээ авахад нь туслах, мөн франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчид бие даан үйл ажиллагаа явуулах, талуудын хоорондын шударга харилцааг дэмжихэд чиглэнэ. Энэ хууль нь 9 бүлэг 22 зүйлтэй.

¹¹⁴ <https://iclg.com/practice-areas/franchise-laws-and-regulations/canada>

¹¹⁵ <https://www.qp.alberta.ca/documents/Acts/F23.pdf>

1. Тодорхойлолт
- I. Хуулийн зорилт ба хамрах хүрээ
 2. Хуулийн зорилт
 3. Хуулийн хэрэглээ
- II. Мэдээллийг ил тод болгох баримт бичиг
 4. Баримт бичгийг франчайз хүлээн авагчид өгөх
- III. Чөлөөлөлт
 5. Хуулийн дагуу чөлөөлөх
 6. Нэмэлт чөлөөлөлт
- IV. Шударга худалдаа
 7. Шударга худалдаа хийх
- V. Эвлэлдэн нэгдэх эрх
 8. Франчайз хүлээн авагчдын эвлэлдэн нэгдэх эрх
- VI. Хохирол барагдуулах, цуцлах болон бусад эрх
 9. Мэдээллийг ил тод болгох баримт бичигт буруу мэдээлэл өгөх
 10. Хариуцлага хүлээхгүй байх нөхөцлүүд
 11. Нэгдэх эрхийг зөрчих
 12. Дундын болон хэд хэдэн хариуцлага
 13. Мэдээллийг ил тод болгох баримт бичгээр хангаагүй
 14. Цуцлах
 15. Бусад арга хэмжээ
 16. Альбертагийн хууль
 17. Шүүхийн шийдвэрийг хязгаарлах
 18. Эрхээс түдгэлзэх
 19. Нотлох баримт
- VII. Ерөнхий журам
 20. Журам
- VIII. Бие даасан удирдлага
 21. Бие даан удирдах
- IX. Хууль хэрэгжилт
 22. Хууль хэрэгжиж эхлэх хугацаа

Франчайз хүлээн авагчид мэдээллийг ил тод болгох бичиг баримт өгөх

Франчайз эрх шилжүүлэгч нь нь франчайз хүлээн авагч болох гэж буй хүнд мэдээллийг ил тод болгох баримт бичгийн хуулбарыг өгөх ёстой.

Энэхүү баримт бичгийг франчайз хүлээн авагч доорх хугацаанаас дор хаяж 14 хоногийн өмнө хүлээн авах ёстой.

- (а) франчайзтай холбоотой аливаа гэрээнд гарын үсэг зурах
 - (б) франчайзтай холбоотой аливаа төлбөрийг төлөх
- Мэдээллийг ил тод болгох баримт бичигт дараах зүйлс агуулагдах ёстой.
- (а) франчайзийн журамд заасан шаардлагыг дагаж мөрдсөн байх
 - (б) франчайзийн гэрээний хуулбар
 - (в) журамд заасны дагуу санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг агуулсан байх

Франчайз эрх шилжүүлэгч нь уг баримт бичигт өөрчлөлт орвол тайлбарыг франчайз хүлээн авагчид бичгээр мэдэгдэх ёстой. Үүнийг доорх хугацаанаас өмнө хийж гүйцэтгэнэ.

(а) франчайз хүлээн авагч франчайзтай холбоотой аливаа гэрээнд гарын үсэг зурах

(б) франчайз хүлээн авагчийн аливаа төлбөрийг төлөх. Энэ төлбөрт бүрэн буцаан олгох хадгаламжийн төлбөрийг тооцохгүй. Бүрэн буцаан олгох хадагаламж нь журамд заасан хэмжээнээс хэтрэхгүй байх ба, ямар ч суутгалгүйгээр буцаан олгогдох ёстой бөгөөд франчайз эзэмших эсэхтэй ямар ч холбоогүй байна. Өөрөөр хэлбэл франчайзийн гэрээг заавал байгуулах албагүй байна.

Чөлөөлөлт

Мэдээллийг ил тод болгох баримт бичгээр хангахаас дараах тохиолдолд чөлөөлөгдөнө.

- Франчайз хүлээн авагч нь франчайз эрх шилжүүлэгчийн түнш, захирал, ажилтан бол;
- Худалдаа нь франчайз хүлээн авагчийн хувийн дансанд зориулагдсан бол;
- Мастер франчайзийн тохиолдолд франчайз бүхэлдээ зарагдсан бол;

Бусад чөлөөлөлт

Салбарын сайд холбогдох эрх бүхий байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахгүй гэж үзвэл дараах субъектүүдийг энэ хуульд заасан ямар нэг заалтаас чөлөөлж болно.

- аливаа хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүс
- аливаа ангиллын франчайз болон түүний борлуулалт

Шударга хэлцэл

Франчайзийн гэрээгээр талууд шударга хэлцэл хийх үүрэг хүлээнэ.

Эвлэлдэн нэгдэх эрх

Франчайз хүлээн авагч ба түүний түнш холбоо байгуулах эсхүл бусад байгууллагатай холбоо тогтооход франчайз эрх шилжүүлэгч ямар нэг байдлаар саад учруулахыг хориглоно.

Франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчийг дээр заасан үйл ажиллагаанд оролцсоных нь төлөө шууд болон шууд бусаар шийтгэхийг хориглоно.

Хохирол барагдуулах, цуцлах болон бусад эрх

Мэдээллийг ил тод болгохдоо баримт бичигт буруу мэдээлэл өгөх

Мэдээллийн баримт бичигт буруу ташаа мэдээлэл өгснөөс үүдэлтэйгээр франчайз хүлээн авагч алдагдал хүлээвэл дараах субъектүүд хохирлыг барагдуулахыг шаардах эрхтэй.

- франчайз хүлээн авагч
- мэдээллийг ил тод болгох баримт бичигт гарын үсэг зурсан хүн бүр

Хариуцлага хүлээлгэхгүй байх нөхцөлүүд

- Хэрэв франчайз хүлээн авагч нь худал мэдээлэл гэдгийг мэдсээр байж франчайз худалдаж авсан болох нь нотлогдвол
- Мэдээллийг ил тод болгох баримт бичгийг франчайз эрх шилжүүлэгчийг мэдээгүй байхад, зөвшөөрөлгүйгээр авсан болох нь нотлогдвол
- Мэдээллийг ил тод болгох баримт бичгийг өгсөний дараа франчайз хүлээн авагч франчайзийг худалдаж авахаасаа өмнө уг баримт бичигт ямар нэгэн буруу мэдээлэл оруулсныг мэдээд франчайз эрх шилжүүлэгч зөвшөөрлөө цуцалж, татгалзсан тохиолдолд

Шинжээчийн дүгнэлтээр баримт бичгийн дараах зүйлс үндэслэлгүй гэж итгэх үндэслэл үүсвэл:

- буруу мэдээлэл өгсөн
- баримт бичгийн хэсэг нь шинжээчийн тайлан, санал, дүгнэлтийг шударгаар илэрхийлээгүй
- баримт бичгийн хэсэг нь шинжээчийн дүгнэлт, мэдэгдлийн баттай хуулбар биш

Дараах тохиолдолд зааснаас бусад үед франчайз эрх шилжүүлэгчээс өөр хүн мэдээллийг ил тод баримт бичгийн аль нэг хэсэгт хариуцлага хүлээхгүй.

- буруу мэдээлэл өгөөгүй гэдгийг нотлох хангалттай шалтгаангүй
- ташаа мэдээлэл өгсөн гэх үндэслэлтэй

Эвлэлдэн нэгдэх эрхэд саад болох

Хэрэв франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагч болон түүний түншийг эвлэлдэн нэгдэхэд нь саад учруулбал хохирол барагдуулахыг шаардах эрхтэй.

Хамтын хариуцлага

Энэ хуулийн заалтыг хамтдаа зөрчсөн гэж үзсэн хүмүүс хариуцлагыг цуг хүлээнэ.

Мэдээллийг ил тод болгох баримт бичгээр хангаагүй байх

Франчайз эрх шилжүүлэгч нь мэдээллийг ил тод болгох баримт бичгийг заасан хугацаанд өгөөгүй бол франчайз хүлээн авагч аль нэг дараах хугацаанд багтан франчайзийг цуцлах мэдэгдэл өгөх эрхтэй.

- Мэдээллийг ил тод болгох баримт бичгийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор
- Франчайз хүлээн авагчид франчайзийн эрх олгосноос хойш 2 жилийн дотор

Цуцлах

Франчайз эрх шилжүүлэгчийн буруугаас гэрээг цуцлах тохиолдолд франчайз хүлээн авагчаас цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор франчайзийн үйл ажиллагааг явуулахад гарсан цэвэр алдагдлыг нөхөн олгох ёстой.

Бусад арга хэмжээ

Франчайз эрх шилжүүлэгч эсвэл франчайз хүлээн авагч хуулиар олгогдсон бусад эрхийг хасч болохгүй.

Альбертагийн хууль

Франчайзийн гэрээнд Альбертагийн хууль үйлчилнэ.

Шүүхийн шийдвэрийг хязгаарлах

Франчайзийн гэрээнд заасан аливаа заалт нь Альбертагийн хуулийг хэрэгжүүлэхэд саад учруулбал уг гэрээ хүчингүй болно.

Эрх хасах

Энэ хуульд заасны дагуу франчайз хүлээн авагчийн эрхийг хасах нь хүчин төгөлдөр бус байна.

Нотлох баримт

Энэхүү хуулийн дагуу аливаа үйл ажллагааг явуулахдаа нэхэмжлэгч өөрөө нотлох баримтаа бүрдүүлнэ.

Ерөнхий журам

Мужийн засаг дарга журам гаргаж болох ба дараах зарчмыг баримтална.

- Мэдээллийг ил тод болгох баримт бичгийн хэлбэр, агуулгыг хүндэтгэх;
- Мэдээллийг ил тод болгох баримт бичигт оруулах шаардлагатай санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн хэлбэр, агуулгыг хүндэтгэх;
- Санхүүгийн тайлан болон түүний шаардлагыг хүндэтгэх;
- Бүрэн буцаан олгох хадгаламжийг өөрчлөхгүй байх;
- Аливаа чөлөөлөлтийг хязгаарлах.

Бие даасан удирдлага

Мужийн засаг дарга франчайзийг удирдах, франчайз эрх шилжүүлэгч ба франчайз хүлээн авагчдын хоорондын шударга харилцааг дэмжих зорилготой байгууллагыг томилж болно.

Томилогдсон байгууллага нь корпораци байх ёстой бөгөөд франчайз эрхэлдэг хүмүүсийг удирдах, франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчдын хоорондын шударга харилцааг дэмжих чадвартай байх ёстой.

Засаг дарга журамдаа дараах зүйлсийг зааж болно.

- уг байгууллагын удирдлагын тоог заах;
- томилогдсон байгууллагын эрх мэдэл, чиг үүргийг хүндэтгэх;
- франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчдыг франчайз бизнес эрхлэхийн тулд томилогдсон байгууллагын гишүүн байхыг шаардах;
- франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчийн хооронд шударга харилцааг тогтоох үүднээс томилогдсон байгууллагаас гаргасан дүрэм журмыг хүндэтгэх;
- хураамж авах эрхийг томилогдсон байгууллагад олгох;
- томилогдсон байгууллагын санхүүгийн бодлого, удирдлага, аудитыг хүндэтгэх;
- энэ хэсгийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг хүндэтгэх.

Хураамжийг ногдуулахдаа томилогдсон байгууллагын удирдлагын зардал, журмын дагуу олгогдсон чиг үүргийн гүйцэтгэл, зардлыг нөхөн төлөх зорилгоор тогтооно. Хураамжийн үйл ажиллагааг салбарын сайдын зөвшөөрсөн хэлбэр хэмжээгээр явуулна.

Франчайзийн гэрээ

Франчайзийн гэрээ нь франчайз эрх шилжүүлэгч ба франчайз хүлээн авагчийн хоорондын харилцааны үндэс суурь бөгөөд энэ харилцааг зохицуулдаг хууль ёсны баримт бичиг юм.¹¹⁶ Гэрээнд талуудын эрх, үүрэг, төлбөр, үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, үргэлжлэх хугацаа зэрэг үндсэн нөхцөлийг тодорхойлдог.

Франчайзийн гэрээнд франчайз эрх шилжүүлэгч ба франчайз хүлээн авагчийн хүлээх үүргийг тусгасан байдаг тул хоёр тал бүх заалтуудын талаар бүрэн ойлголттой байх нь туйлын чухал юм. Франчайзийн гэрээ нь нэлээд стандартчиллагдсан байдаг ч зарим франчайз эрх шилжүүлэгчид гэрээний заалтаа хэлэлцэхэд нээлттэй байдаг.

Канад Улсад хийгдэж буй франчайзийн гэрээнд тусгадаг нийтлэг элементүүд:

Төлбөр. Франчайзийн төлбөр, франчайз ашигласны хураамж болон бусад нэмэлт зардлын талаар нарийвчлан тодорхойлсон байна. Франчайз эрх шилжүүлэгчид төлөх төлбөрийн хугацаа хэтэрсэн тохиолдолд шимтгэл төлөх хуваарь мөн орсон байна.

¹¹⁶<https://www.franchisedirectcanada.com/information/thefranchiseesperspective/checklistthefranchiseeagreement/118/541/>

Франчайзингийн эхний төлбөр 5000-75000 долларын хооронд ихэвчлэн хэлбэлздэг. Энэ төлбөр нь сургалт, байрлын анализ, салбарын нээлт зэрэгт зарцуулагддаг. Явцын роялти төлбөр нийт борлуулалтын 0-20 хувьтай тэнцдэг. Энэ төлбөр нь франчайз хүлээн авагчийн зүгээс явцын сургалт хийхэд зориулагддаг.¹¹⁷

Оюуны өмчийн эрхийг олгосон байх. Франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид лого, барааны тэмдэгт, бизнесийн үйл ажиллагааны системээ тодорхой хугацаанд ашиглах лиценз олгосон байна. Гэрээнд эдгээр тэмдгийг хэрхэн ашиглах талаар нарийвчлан тусгана.

Сургалт ба үйл ажиллагаа эрхлэх. Франчайз эрх шилжүүлэгчийн зүгээс ямар сургалт явуулах, үүнд франчайз хүлээн авагч ямар хариуцлага хүлээхийг заасан байна. Үүнээс гадна уг франчайзийн бизнес эрхлэхэд тавигдах шаардлага, хязгаарлалтын талаар хөндөх болно. Франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид ямар төрлийн тасралтгүй дэмжлэг өгч болохыг гэрээнд оруулсан байна.

Франчайзийн хугацаа ба хугацааг сунгах нөхцөл. Тухайн франчайзийн нээлт хийх огноо, үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг тодорхойлсон байна. Мөн франчайзийн хугацааг сунгахад ямар шаардлагыг хангасан байх ёстойг дурдсан байна.

Франчайзийг цуцлах нөхцөл. Франчайз эрх шилжүүлэгчийн зүгээс муу гүйцэтгэл болон бусад шалтгаанаар франчайзийн эрхийг цуцлах нөхцөл ямар байхыг тусгах ба франчайз хүлээн авагчид зөрчлөө арилгах арга зам бий эсэхийг тодруулж өгсөн байна.

Франчайзийн үйл ажиллагаа дууссаны дараах шаардлага. Гэрээний хугацаа дууссаны дараа франчайз хүлээн авагчийн авах шаардлагатай алхмуудыг оруулсан байна. Эдгээр алхмуудад ихэвчлэн нууцлалтай материалыг буцааж өгөх, оюуны өмчийг ашиглахаа зогсоох, үлдэгдэл төлбөр төлөх зэрэг орно. Мөн гэрээ дуусгавар болсон франчайз хүлээн авагчийг нэр заасан компаниудад тодорхой хугацаанд ажиллахыг хориглосон өрсөлдөөнт бус хугацааг зааж болдог.

Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр. Франчайз хүлээн авагчид үйл ажиллагаа явуулах тодорхой нутаг дэвсгэр заасан эсэх, мөн франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчтай хэр ойр байхаас шалтгаалалгүйгээр хүссэн газраа салбар нээх эрхтэй эсэхийг тусгасан байна. Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг хүн амын тоо эсвэл газарзүйн зураглалаар тодорхойлох аргачлалыг оруулна.

Зар сурталчилгаа, маркетинг. Франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчийн зар сурталчилгаа, маркетингийн ажилд хувь нэмэр оруулах үүрэг хариуцлагыг тус тусад нь заасан байна.

Дизайн ба засварын ажил. Франчайз хүлээн авагчид франчайз эрх шилжүүлэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулах байршлын засвар, шинэчлэлтийг хийх ёстой. Гэрээнд франчайз эрх шилжүүлэгч нь тодорхой засвар үйлчилгээний байгууллагыг заах тохиолдол байна. Зарим тохиолдолд засвар хийх нь гэрээг сунгах нөхцөл болдог.

Шаардлагатай бол гүйцэтгэлийн хамгийн бага шаардлага. Гэрээнд гүйцэтгэлийн түвшний доод шаардлагыг тавьсан байх ба ямар хугацаанд хэр хэмжээтэй орлого олохыг заасан байна. Гүйцэтгэлийн хамгийн бага зорилтыг биелүүлээгүй бол гэрээг цуцлах, гэрээг сунгахгүй байх зэрэг үр дагаврыг тусгасан байна.

Даатгалын шаардлага. Франчайз хүлээн авагчид нь тухайн бизнест шаардлагатай бүх даатгалд орох үүрэгтэй. Хэрэв франчайз хүлээн авагч зохих даатгалд хамрагдаагүй бол

¹¹⁷ https://cfa.ca/wp-content/uploads/sites/5/2018/10/CFA-Guide_Tutorials_June2018.pdf

франчайз эрх шилжүүлэгч өмнөөс нь даатгалд хамруулж нөхөн төлбөрийг франчайз хүлээн авагчаас нэхэмжилж болно.

Нөхөн төлбөр: Франчайз хүлээн авагч франчайз эрх шилжүүлэгчийн брэндэд хохирол учруулсан аливаа үйлдлийнхээ төлөө нөхөн төлбөр төлх аргачлалыг тусгасан байна.

Осол гамшиг. Франчайз хүлээн авагчийн бизнесийн байршилд осол гамшиг гарсны улмаас байнгын үйл ажиллагаанд нөлөөлөх хохирол амссан тохиолдолд юу хийх ёстой талаар тодорхой заасан байна.

Нас барсан эсвэл хөдөлмөрийн чадваргүй болсон үед. Бүх бизнес эрхлэгчид гэнэтийн нөхцөл байдал, аюул учирсан тохиолдлыг төлөвлөх ёстой. Хэрэв франчайз хүлээн авагч нас барвал гэр бүлийн бусад гишүүн бизнесийг үргэлжүүлэн хийж болох эсэх талаар оруулна.

ХОЁР. ИТАЛИ УЛС

Итали Улс нь 2004 онд анх Франчайзийн тухай хуулийг баталсан ба энэ хууль нь 2005 оноос хэрэгжиж эхэлсэн. Франчайзийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль, эрх зүйн зохицуулалтад доорх хууль, журмууд багтана:

Франчайзийн тухай хууль¹¹⁸, Хууль №129, 2004 оны 5 сарын 6. /Act No. 129 (Rules on commercial franchising, the Franchising Act)/

- Хууль нь 2004 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдаж улмаар 2004 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь нийт 9 зүйлтэй ба хуулийн нэр томьёо, тодорхойлолт, хуулийн хүрээ, франчайзийн гэрээний загвар, нөхцөл, франчайз эрх шилжүүлэгчийн үүрэг, франчайз хүлээн авагчийн үүрэг, гэрээ байгуулахаас өмнөх үүрэг, эвлэрэл, гэрээ цуцлах, бусад зүйл заалт зэрэг франчайзийн хүрээний харилцааны үндсийг хуульчилжээ.

“Франчайзийн журам”¹¹⁹, Засгийн газрын тогтоол №204 /Ministerial Decree No.204 (Regulation on Commercial franchising ,the Franchising Regulation)/

- “Франчайзийн журам” нь Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн тогтоолоор батлагдаж, 2005 оны 10 сарын 19-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Журам нийт 3 зүйлтэй, нэгдүгээр зүйлд өргөдөл, хоёрдугаар зүйлд нээлттэй баримт бичиг буюу гадаадад үйл ажиллагаа явуулдаг франчайз эрх шилжүүлэгчийн танилцуулах шаардлагатай нээлттэй баримт бичиг, гуравдугаар зүйлд бусад зүйл заалтыг тусгасан байна.

Франчайзийн тухай хууль. Итали Улсын Франчайзийн тухай хуулиар франчайзийн гэрээнд түгээмэл шаардагдах зүйл заалтуудыг тусгасан байдаг ба франчайз хүлээн авагчийн эрхийг хамгаалах асуудлыг түлхүү оруулсан байна.

Франчайз эрх шилжүүлэгчийн эрх, үүрэг. Франчайзийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд франчайз эрх шилжүүлэгчийн үүргийг зааж өгсөн байна.

Франчайз эрх шилжүүлэгч дараах үүрэгтэй:

1. Франчайз эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээнд гарын үсэг зурахаас 30-аас доошгүй өдрийн өмнө тухайн франчайз хүлээн авагчид гэрээний загварыг нээлттэй баримт бичгийн хамт гарган өгч танилцуулна. Нээлттэй баримт бичиг нь дараах мэдээллүүдээс бүрдэнэ. Үүнд:

¹¹⁸The Franchising Act, 2004/129

[https://www.gazzettaufficiale.it/eli/id/2004/05/24/004G0161/sg#:~:text=L'affiliazione%20commerciale%20\(franchising\),industriale%20c%20intellettuale%20relativi%20a](https://www.gazzettaufficiale.it/eli/id/2004/05/24/004G0161/sg#:~:text=L'affiliazione%20commerciale%20(franchising),industriale%20c%20intellettuale%20relativi%20a)

¹¹⁹ Ministerial Decree 204/2005, Regulation on Commercial franchising.

- a) франчайз эрх шилжүүлэгчийн хууль ёсны нэр, компанийн хөрөнгө болон франчайз хүлээн авагчийн хүсэлтийн дагуу сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан, хэрэв франчайз эрх шилжүүлэгч тухайн үйл ажиллагааг явуулаад гурван жил хүрээгүй бол байгуулагдсанаас хойшхи санхүүгийн тайлан;
- b) франчайзийн системд хэрэглэж буй барааны тэмдэг, болон бүртгэлийн талаарх мэдээлэл, депозит, эсвэл гуравдагч тал болох барааны тэмдэгийг эзэмшигчээс франчайз эрх шилжүүлэгчид олгосон зөвшөөрөл, эсвэл барааны тэмдгийн бодит хэрэглээг илэрхийлсэн баримт бичиг;
- c) бизнесийн үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон товч тодорхойлолт;
- d) франчайзийн системд оролцогч талуудын явуулж буй үйл ажиллагааны жагсаалт;
- e) сүүлийн гурван жилийн хугацаанд оролцогч талуудын тоо, байршил, төрлийг жил жилээр нь гаргасан мэдээллийг тодорхойлсон байх, хэрэв франчайз эрх шилжүүлэгч тухайн үйл ажиллагааг явуулаад гурван жил хүрээгүй бол байгуулагдсанаас хойшхи мэдээллийг тодорхойлсон байх;
- f) сүүлийн гурван жилийн шүүх, арбитрын үйл ажиллагааны талаарх тодорхойлолт.

Франчайз эрх шилжүүлэгчийн үүргийг тусгахдаа нээлттэй баримт бичигт тусгахдаа нөхцөлүүдээр үүрэгжүүлсэн ба мэдэгдэл өгөх хугацааг 30 хоногоор тогтоож өгсөн нь франчайз хүлээн авагчийн хувьд шийдвэр гаргах, бусад шаардлагуудыг биелүүлэх, мэдээллийг баталгаажуулах зэрэг боломжуудийг бий болгосон байна. Мөн нээлттэй баримт бичигт тусгах ёстой мэдээлэлд сүүлийн гурван жилийн шүүх, арбитрын үйл ажиллагааны талаарх тодорхойлолт байхаар тусгасан нь франчайз хүлээн авагчийг үнэн зөв мэдээллээр хангах ач холбогдолтой.

Франчайз хүлээн авагчийн эрх, үүрэг. Франчайзийн тухай хуулийн 5 дугаар зүйлд франчайз хүлээн авагчийн үүргийг, 8 дугаар зүйлд эрхийг зааж өгсөн байна. Үүнд:

1. франчайз эрх шилжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр тухайн худалдааг шилжүүлэхийг хориглох;
2. бизнесийн нууцыг хадгалах үүрэгтэй;
3. Франчайзийн тухай хуулийн гэрээ цуцлах гэсэн 8 дугаар зүйлд зааснаар, хэрэв талууд худал хуурамч мэдээдэл, баримт бичиг гарган танилцуулсан бол, франчайз хүлээн авагч нь гэрээг цуцалж болох ба учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Хуулийн 8 дугаар заалт нь франчайз хүлээн авагчийн хувьд эдлэх эрхийг зааж өгсөн ганц заалт бөгөөд энэ нь франчайз хүлээн авагчийн эрсдэлийг бууруулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар тусгасан байна.

Франчайзийн системийн үндсэн баримт бичгүүд (Франчайзийн гэрээ). Хуулийн 3 дугаар зүйлд франчайзийн гэрээний загвар, нөхцөлийг заасан.

1. франчайзийн гэрээг заавал бичгээр хийх ба бичгээр хийгээгүй тохиолдолд хүчингүйд тооцно;
2. франчайз эрх шилжүүлэгч нь салбар сүлжээгээ байгуулахын тулд зах зээл дээр туршлагатай мэргэшсэн бизнесийн загвартай байх ёстой;
3. франчайзийн гэрээний хугацаа гурваас доошгүй жил байна;
4. франчайзийн гэрээнд доорх нөхцөлүүдийг тусгана:
 - франчайзийн үйл ажиллагааг эхлэхээс өмнө франчайз хүлээн авагчийн төлөх шаардлагатай анхны төлбөр болон хөрөнгө оруулалтын нийт хэмжээ;

- франчайз эрх шилжүүлэгчид төлөх ёстой рояалти болон төлбөрүүд;
- нутаг дэвсгэрийн онцгой эрх /хэрэв байвал/;
- франчайз хүлээн авагчид шилжүүлэх арга ажиллагаа (know-how);
- франчайз хүлээн авагчид нэмэлт шаардлагатай арга ажиллагааны (know-how) танигдсан шалгуур;
- франчайз эрх шилжүүлэгчээс үзүүлэх ажил үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт;
- гэрээний шинэчлэлт, гэрээ дуусгавар болох, гэрээг шилжүүлэх.

Хариуцлага. Франчайзийн тухай хуулийн гэрээ цуцлах гэсэн 8 дугаар зүйлд зааснаар, хэрэв талууд худал хуурамч мэдээдэл, баримт бичиг гарган танилцуулсан бол, франчайз хүлээн авагч нь гэрээг цуцалж болох ба учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ гэж заасан байна. Энэ заалт нь нэг талаас франчайз хүлээн авагчийн эрхтэй холбогдож байгаа бол нөгөө талаас франчайз эрх шилжүүлэгчид хариуцлага тооцох боломжийг бий болгосон гэж үзэж болно.

Франчайзийн журам. Франчайзийн журам нь тусгайлан Итали Улсын нутаг дэвсгэрийн гадна үйл ажиллагаа явуулж буй франчайз эрх шилжүүлэгчид хамааралтай. Энэ журманд гадаадын франчайз эрх шилжүүлэгчийн нээлттэй баримт бичгийн өмнө гүйцэтгэх шаардлагатай үүргүүдийг голчлон тусгасан байна. Үүнд:

1. гэрээ байгуулахаас 30-аас доошгүй өдрийн өмнө тухайн франчайз хүлээн авагчид гэрээний бүх баримт бичиг болон хавсралт баримт бичгүүдийн хамт хүргүүлэх шаардлагатай. Мөн түүнчлэн энэ хугацаанд франчайз эрх шилжүүлэгч нь муж, хот тус бүрт үйл ажиллагаа явуулж буй франчайз хүлээн авагчдын жагсаалт болон тэдний худалдаатай холбоотой мэдээллүүдийг франчайз хүлээн авагчид хүргүүлнэ.
2. тухайн франчайз хүлээн авагчийн хүсэлтийн дагуу франчайз эрх шилжүүлэгч нь 20-оос доошгүй тооны үйл ажиллагаа явуулж буй франчайз хүлээн авагчдын холбоо барих мэдээлэл болон шүүх үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг франчайз хүлээн авагчид хүргүүлнэ.

Тухайн франчайз хүлээн авагчийн хүсэлтийн дагуу франчайз эрх шилжүүлэгч нь гэрээтэй холбоотой бүх мэдээлэл, бусад хавсралт баримт бичгүүдийн хуулбарыг Итали хэл дээр франчайз хүлээн авагчид хүргүүлнэ.

ГУРАВ. БРАЗИЛ УЛС

Бразил Улс 1994 (№8.955) онд Франчайзийн тухай бие даасан хуулийг баталсан бөгөөд 2019 (№13.966)¹²⁰ онд шинэчлэн баталсан байна. Хууль нь 10 заалттай бөгөөд тус улсын франчайзийн систем болон түүнтэй холбогдох асуудлуудыг зохицуулдаг.

Франчайз эрх шилжүүлэгчийн эрх, үүрэг. Тус хуулинд франчайз эрх шилжүүлэгчийн үүргийн талаар 2 дахь заалтад тусгасан байна. Үүнд:

- “Франчайз эрх шилжүүлэгч нь франчайзийн системийг хэрэгжүүлэхээр сонирхож байгаа бол франчайз хүлээн авагчийг франчайзийн системийн тухай мэдэгдэл /FOC/-ээр хангах ба энэхүү мэдэгдэл нь тодорхой, ойлгомжтой, бичгийн хэл дээр доорх мэдээллийг заавал багтаасан байна” гэж заагаад 23 зүйлээр тодорхойлон тусгасан байна.
- “§1-т Франчайзийн системийн тухай мэдэгдэл /FOC-Franchise Offering circular/ нь франчайзийн гэрээ, дэд гэрээний гүйцэтгэлээс өмнө болон франчайз хүлээн

¹²⁰ Brazilian Franchise Law, №13.966/26, 2019. http://www.planalto.gov.br/ccivil_03/_ato2019-2022/2019/lei/L13966.htm

авагчаас франчайз эрх шилжүүлэгч, эсвэл тэдгээртэй холбоотой компани, хувь хүнд төлбөр төлөхөөс 10-аас доошгүй өдрийн өмнө хүргэгдэнэ.” гэж үүрэгжүүлсэн байна.

Франчайз хүлээн авагчийн эрх, үүрэг. Заалт 2-ын §2-т “§1 заалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд франчайз хүлээн авагч нь нэхэмжлэл гаргаж, франчайз эрх шилжүүлэгчид төлсөн мөнгөө буцааж өгөхийг шаардаж болно.” франчайз хүлээн авагчийн эрхтэй холбоотой ганц заалт тусгагдсан.

Франчайзийн системийн үндсэн баримт бичгүүд

Франчайзийн гэрээ: Франчайзийн гэрээтэй холбоотой асуудлыг 7 дугаар зүйлд тусгаж өгсөн байна. Үүнд: Франчайзийн гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна.

1. Франчайзийн гэрээ нь зөвхөн Португал хэл дээр бичигдэх бөгөөд Бразилийн хууль тогтоомжоор зохицуулагдана.
2. Олон улсын франчайзингийн гэрээг Португал хэл дээр бичих, эсхүл баталгаажсан Португал хэлний орчуулгатай байх бөгөөд гэрээнд оролцогч талууд хэлэлцээр хийхдээ аль нэгийг нь сонгох боломжтой.

“Франчайзийн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэхийн тулд талууд арбитрын шүүхэд хандаж болно. Олон улсын франчайзингийн гэрээ гэдэг нь түүнийг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын харьяалал, оршин суугаа газар, түүний объектын байршлын нөхцөл байдлын талаарх олон хууль, эрх зүйн холбоосыг агуулсан гэрээ гэж ойлгоно” гэсэн байна.

Франчайзийн системийн мэдэгдэл: Хуулийн 2 дугаар зүйлд Франчайзийн системийн мэдэгдэл /FOC/-ийн шаардлага, нөхцөлүүдийг зааж өгсөн.

БРАЗИЛЫН ФРАНЧАЙЗИЙН ХУУЛЬ¹²¹

(Brazilian Law No.13.966/26)

/Албан бус орчуулга/

1 дүгээр зүйл. Энэ хууль нь франчайзийн гэрээний дагуу франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид барааны тэмдэг болон оюуны өмчөөр хамгаалагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах, үйлдвэрлэх, түгээхтэй холбоотой франчайзийн системийг зохицуулдаг. Франчайз гэдэг нь франчайз эрх шилжүүлэгчээс франчайз хүлээн авагчид худалдааны тэмдэг, патент ашиглах эрх, бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн бүрэн болон хэсэгчилсэн онцгой эрх, түүнчлэн үйл ажиллагааны хэрэгжүүлэлт, бизнесийн удирдлагын технологи, франчайз эрх шилжүүлэгчийн үйл ажиллагааны зарчмыг ашиглах эрх зэргийг шилжүүлэхдээ ямар нэг хөдөлмөрийн харилцаанд үндэслэхгүйгээр шууд ба шууд бус дэмжлэгтэй оролцдог агуулга бүхий тогтолцоо юм.

§ 1. Франчайз хүлээн авагч нь франчайзийн гэрээний дагуу оюуны өмчөөр хамгаалагдсан бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглахын тулд франчайз эрх шилжүүлэгчид өргөдөл гаргасан байх ёстой.

§ 2. Франчайзийн эрхийг хувийн компани болон төрийн өмчих компани, ашгийн бус байгууллага авч болно.

¹²¹ Brazilian Franchise Law, №13.966/26, 2019. http://www.planalto.gov.br/ccivil_03/_ato2019-2022/2019/lei/L13966.htm

2 дугаар зүйл. Франчайз эрх шилжүүлэгч нь франчайзийн системийг хэрэгжүүлэхээр сонирхож байгаа бол франчайз хүлээн авагчийг франчайзийн системийн тухай мэдэгдэл /ФОС/-ээр хангах ба энэхүү мэдэгдэл нь тодорхой, ойлгомжтой, Португал хэл дээр доорх мэдээллийг заавал багтаасан байна.

1. Франчайзийн түүх;
2. Франчайз эрх шилжүүлэгч болон түүнтэй холбоо бүхий компаниудын талаарх мэдээлэл, улсын бүртгэлийн дугаар;
3. Франчайз эрх шилжүүлэгч корпорацын өмнөх 2 жилийн тайлан баланс, санхүүгийн үзүүлэлтүүд;
4. Франчайз эрх шилжүүлэгчийн хуулиар эзэмшиж буй эрхийн үнэн зөв тайлбар, үйл ажиллагаатай холбоотой хяналтын компаниуд, худалдааны тэмдэг, патент, зөвшөөрөгдсөн эрх эзэмшигчид болон тэдгээрийн дэд франчайз эрх эзэмшигч, франчайз системийн тулгамдаж буй асуудал эсвэл дээрх эрхэд хориг саад болж байгаа үйл ажиллагааны талаар;
5. Франчайзийн дэлгэрэнгүй тайлбар, франчайз хүлээн авагчийн хэрэгжүүлэх бизнес, үйл ажиллагааны ерөнхий тайлбар;
6. Франчайз хүлээн авагчийн туршлага, боловсролын түвшин, бусад шинж чанарын талаар заах шаардлагатай бол энэ талаарх шаардлага;
7. Үйл ажиллагаа болон бизнесийн удирдлагад франчайз хүлээн авагчийн шууд оролцооны талаарх шаардлага;
8. Техникийн үзүүлэлтүүд:
 - a) Эрх худалдан авах, франчайзийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах анхны хөрөнгө оруулалтын тооцоо
 - b) Анхны гишүүнчлэлийн төлбөрийн хэмжээ болон франчайз, бондын төлбөр
 - c) Ажлын байр, тоног төхөөрөмж болон анхны нөөц хөрөнгийн төсөөлсөн өртөг, түүнчлэн төлбөрийн нөхцөлүүд.
9. Франчайз хүлээн авагчаас франчайз эрх шилжүүлэгч болон 3-дагч эдгээдэд төлөх тогтмол хугацаатай төлбөрүүд болон бусад төлбөр тооцооны тухай тодорхой мэдээллийг тооцоололд үндэслэн тус тусд нь тэдгээрийн зорилго, шинж, онцгойлсон байдал зэрэг төстэй байдлаар нь мэдээллийг нарийвчлан тодорхой заана. Үүнд:
 - a) Франчайзийн систем, худалдааны тэмдэг ашиглах хугацааны, эсвэл франчайз эрх шилжүүлэгчээс франчайз хүлээн авагчид үзүүлж байгаа үр ашигтай үйлчилгээ үзүүлсний төлбөр
 - b) Тоног төхөөрөмж болон ажлын байрны түрээс
 - c) Зар сурталчилгаа, түүнтэй адилтгах төлбөр
 - d) Даатгалын хамгийн доод хэмжээ
10. Тухайн сүлжээг ашиглаж байгаа, өмнөх 24 сарын туршид тус сүлжээг ашиглаж байсан бүх франчайз хүлээн авагч, дэд франчайз хүлээн авагч, дэд франчайз эрх шилжүүлэгчдийн нэр, хаяг, утасны дугаар бүхий иж бүрэн жагсаалт;
11. Газар нутгийн хувьд тодорхойлогдсон байх ёстой мэдээллүүд нь:
 - a) Франчайз хүлээн авагчийн онцгой нөхцөлд франчайз эрх шилжүүлэгчээс баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагааны нутаг дэвсгэрт хөнгөлөлт үзүүлэх зэрэг ямар нөхцөлд байгаагаас хамаарах;
 - b) Франчайз хүлээн авагч нь тухайн нутаг дэвсгэрээс гадагш бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй, эсвэл франчайз хүлээн авагч нь экспортын зөвшөөрөлтэй эсэх;
 - c) өмчлөлийн болон франчайз эрх бүхий нэгжийн хоорондох нутаг дэвсгэрийн өрсөлдөөний дүрэм, журамтай байдаг эсэх.

12. Франчайзийн хэрэгжилт, үйл ажиллагаа, удирдлагад шаардагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх олж авах франчайз хүлээн авагчийн үүргийг тодорхой, нарийвчлан заасан мэдээлэл, франчайз эрх шилжүүлэгчээс заасан бэлтгэн нийлүүлэгчээс франчайз хүлээн авагчийг хангах бэлтгэн нийлүүлэгчийн дэлгэрэнгүй мэдээлэл
13. Франчайз эрх шилжүүлэгчээс франчайз хүлээн авагчид санал болгосон холбогдох тайлбарт:
- a) дэмжлэг
 - b) сүлжээний хяналт
 - c) үйлчилгээ
 - d) технологийн шинэчлэлийг франчайз компаниудад нэвтрүүлэх
 - e) франчайз хүлээн авагч талын ажиллагсдад хийх сургалт, хугацаа, агуулга, зардал
 - f) франчайзийн гарын авлага
 - g) франчайзийг суурьлуулахад хамрах ажлын талбарын сонголт, шинжилгээ хийх тусламж
 - h) Франчайз хүлээн авагчийн ажлын байрны зохион байгуулалтын схем болон архитекторын зураглал
14. Бразилын Үйлдвэрлэлийн Өмчийн Үндэсний Институтэд бүртгүүлэх нөхцөлүүд – /худалдааны тэмдэг, патентыг хэн ашиглаж байгаа бүртгэл/
15. Франчайзийн гэрээ дуусгавар болсны дараах франчайз хүлээн авагчийн нөхцөл байдал:
- a) франчайзийг ашигласны үр дүнд хүртэх боломжтой ноу-хау болон бүтээгдэхүүн, үйл явц, менежментийн технологи, нууц мэдээлэл, үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа, санхүү, бизнесийн нууц
 - b) Үйл ажиллагааны хэрэгжүүлэлт нь франчайз эрх шилжүүлэгчийн үйл ажиллагаатай өрсөлдөхүйц
16. Стандарт гэрээний загвар болон хэрвээ энэ нь франчайз эрх шилжүүлэгчээс батлагдсан стандарт франчайзийн дэд гэрээтэй тохиолдолд гэрээг дан бичвэр /full text/-ээр хийж, нэмэлт хавсралтууд болон хугацааг оруулна.
17. Шилжүүлэх, залгамжлах эрх байгаа эсэх, хэрэв байхгүй хэрхэн шийдвэрлэх;
18. Өөрчлөлт орсон;
19. Өөрчлөлт орсон;
20. Өөрчлөлт орсон;
21. Өөрчлөлт орсон;
22. гэрээний хугацаа, сунгах нөхцөлийг нарийвчлан заана,
23. Өөрчлөлт орсон;

§1. Франчайзийн системийн тухай мэдэгдэл /FOC/ нь франчайзийн гэрээ, дэд гэрээний гүйцэтгэлээс өмнө болон франчайз хүлээн авагчаас франчайз эрх шилжүүлэгч, эсвэл тэдгээртэй холбоотой компани, хувь хүнд төлбөр төлөхөөс 10-аас доошгүй өдрийн өмнө хүргэгдэнэ.

§2. §1 заалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд франчайз хүлээн авагч нь нэхэмжлэл гаргаж, франчайз эрх шилжүүлэгчид төлсөн мөнгөө буцааж өгөхийг шаардаж болно.

3 дугаар зүйл. Франчайз эрх шилжүүлэгч нь франчайз эзэмшиж буй худалдааны цэгээ франчайз хүлээн авагчид түрээслүүлсэн тохиолдолд талуудын аль нэг нь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээг сунгах санал гаргах эрхтэй. Түрээсийн гэрээ эсхүл франчайзийн гэрээг зөрчсөнөөс бусад тохиолдолд сунгах асуудалтай холбоотой дэд түрээсийн гэрээг хийхийг хориглоно.

4 дүгээр зүйл. Өөрчлөлт орсон;

5 дугаар зүйл. Өөрчлөлт орсон;

6 дугаар зүйл. Хүчингүй болгосон.

7 дугаар зүйл. Өөрчлөлт орсон;

8 дугаар зүйл. Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхдээ тухайн улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа оюуны өмчийн тухай хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөнө.

9 дүгээр зүйл. 1994 оны 12 -р сарын 15 -ны өдрийн 8.955 дугаар хуулийг (Франчайзийн тухай хууль) хүчингүй болсонд тооцов.

10 дугаар зүйл. Энэ хууль нь нийтлэгдсэн өдрөөс хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

ДӨРӨВ. ХЯТАД УЛС

БНХАУ нь эдийн засгийн хувьд хурдацтай хөгжиж буй томоохон зах зээлтэй улсуудын тоонд ордог ба түүнчлэн сүүлийн жилүүдэд франчайзийн систем хамгийн их хөгжсөн улсуудын нэгд тооцогдох болсон. БНХАУ-д анх 1987 онд гадаадын КФС түргэн хоолны сүлжээ нээгдсэнээс хойш холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтын орчин аажмаар хөгжин сайжирсаар байна.

Эрх зүйн зохицуулалт: Франчайзийн үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн зохицуулалтад дараах тогтоол, журмууд багтана:

- “Франчайзингийн удирдлагын журам”¹²² (*Regulations on Administering Commercial Franchises* - 中华人民共和国国务院令)

“Франчайзингийн удирдлагын журам” нь Төрийн зөвлөлийн 2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 167 дахь хурлын 485 дугаар тогтоолоор батлагдаж улмаар 2007 оны 5 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус тогтоол нь нийт таван бүлэг, 34 зүйлтэй ба нийтлэг үндэслэл, франчайзийн үйл ажиллагаа, нээлттэй баримт бичигтэй танилцах, хуулийн хариуцлага, бусад зүйл заалт зэрэг франчайзийн хүрээний харилцааны үндсийг зохицуулжээ.

- “Франчайзийн бүртгэлийн тухай захиргааны журам”¹²³ /шинэчилсэн найруулга/ (*Administrative Rules for the Record-filing of Commercial Franchises* - 中华人民共和国商务部令)

Энэхүү журам нь 2011 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Худалдааны яамны 56 дахь хурлаар батлагдаж, 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус журам нь нийт 21 зүйлтэй ба франчайзийн үйл ажиллагааны удирдлагыг сайжруулах, франчайзийн зах зээлийн хэв журмыг стандартжуулах зорилгоор “Франчайзингийн удирдлагын журам”-ын холбогдох зүйл заалтанд үндэслэн тус журмыг гаргасан байна.

¹²² Франчайзингийн удирдлагын журам, 2007/485. http://www.gov.cn/zhengqce/content/2008-03/28/content_4179.htm

¹²³ Франчайзийн бүртгэлийн тухай захиргааны журам, 2011. http://www.gov.cn/ffq/2011-12/21/content_2025612.htm

- “Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай захиргааны журам¹²⁴ /шинэчилсэн найруулга” /*Administrative Rules on Commercial Franchise – Information Disclosure*-
中华人民共和国商务部令/

Энэхүү журам нь 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Худалдааны яамны 60 дахь хурлаар батлагдаж, 2012 оны 4 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус журам нь нийт 12 зүйлтэй, ба эрх шилжүүлэгч болон эрх хүлээн авагч хоёр талын хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор “Франчайзийн удирдлагын журам”-д үндэслэн тус журмыг гаргасан байна.

Франчайз хурдацтай хөгжиж байгаа хэдий ч франчайзийн үйл ажиллагаанд янз бүрийн эрсдэл, асуудлууд үүсч байдаг. Жишээлбэл, зарим франчайзийн эрх шилжүүлэгч тохирох шаардлага, нөхцөлүүдийг хангадаггүй, эрх шилжүүлэгч болон эрх хүлээн авагчийн хуулийн дагуу эдлэх эрхийг хамгаалах баталгаа байхгүй байх, франчайзийн үйл ажиллагааны нэрээр луйвар хийх, хуурч мэхлэх зэрэг хууль зөрчсөн асуудлууд байнга үүсдэг. Эдгээр үүсч болох асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дээрх тогтоол, журмыг батлаж гаргасан байна. Тухайлбал:

Франчайз эрх шилжүүлэгчид тавигдах шаардлагыг “Франчайзийн удирдлагын журам”-д тодорхой тусгасан байна. Үүнд:

- журмын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар, “Франчайзийн үйл ажиллагаанд эрх шилжүүлэгч нь зөвхөн байгууллага байх ба бусад нэгж, хувь хүн байж болохгүй.”
- журмын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, “Франчайзийн үйл ажиллагаа явуулж буй франчайз эрх шилжүүлэгч нь зайлшгүй боловсронгуй бизнесийн загвартай байх ёстой ба түүнчлэн франчайз хүлээн авагчид үйл ажиллагаа явуулах зааварчилгаа, техникийн туслалцаа үзүүлэх болон бизнес явуулах сургалт зэрэг үйлчилгээг байнга үзүүлэх ёстой.”
- журмын 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар, “Франчайзийн үйл ажиллагаа явуулахын тулд франчайз эрх шилжүүлэгч нь 2-оос дээш шууд салбартай байх ёстой ба түүнчлэн нэгээс дээш жил үйл ажиллагаа явуулсан байх шаардлагатай.”

Эдгээр заалтуудыг тусгаж өгснөөр франчайзийн нэрээр байгууллага болон хувь хүн, нэгж луйвар хийхээс сэргийлж чадна. Мөн франчайз эрх шилжүүлэгчийн шууд салбар нь тодорхой үлгэр дуурайлал үзүүлэх боломжтой тул бусад үйл ажиллагаа явуулах салбаруудад тухайн барааны тэмдэг, бизнесийн загвар болон үйл ажиллагааны нөхцөл байдлыг ойлгож танилцахад давуу тал болно.

Нээлттэй баримт бичиг. Франчайз эрх шилжүүлэгчийн нээлттэй баримт бичгийг танилцуулснаар франчайз хүлээн авагч цаг хугацаанд нь, бүрэн бүтэн, үнэн зөв холбогдох нөхцөл байдлын талаар ойлголттой болох баталгаа өгдөг. Франчайз хүлээн авагч бүрэн бүтэн, хангалттай мэдээлэлд тулгуурлан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргаснаар, хууран мэхлэлтэнд өртөхөөс сэргийлэхэд чухал нөлөөтэй байдаг. Тиймээс аливаа франчайзийн хууль, эрх зүйн зохицуулалттай улсуудад нээлттэй баримт бичиг нь чухал ач холбогдолтой гэж үздэг.

БНХАУ-ын “Франчайзийн удирдлагын журам”-д нээлттэй баримт бичгийн талаар тусгайлсан бүлэг байдаг. Мөн түүнчлэн “Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай захиргааны журам”-ыг франчайзийн хоёр талын эрх ашгийг хамгаалахаар гаргасан байна. Үүнд:

¹²⁴ Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай захиргааны журам, 2012. http://www.gov.cn/ffq/2012-03/06/content_2084101.htm

“Франчайзийн удирдлагын журам”-д:

1. журмын “Нээлттэй баримт бичиг” гэсэн гуравдугаар бүлгийн 21 дүгээр зүйлд зааснаар “франчайз эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээ байгуулахаас 30-аас доошгүй өдрийн өмнө франчайз хүлээн авагчид журмын 22 дугаар зүйлд заасан нээлттэй баримт бичгийг бичгээр мөн гэрээний загварыг бичгээр гарган өгч танилцуулах шаардлагатай.”
2. журмын 22 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид дараах мэдээллийг багтаасан нээлттэй баримт бичгийг гарган өгнө:
 - франчайз эрх шилжүүлэгчийн нэр, хаяг, хуулийн төлөөлөгч, бүртгэлтэй хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагаа явуулах хүрээ болон франчайзийн үйл ажиллагааны үндсэн мэдээлэл;
 - франчайз эрх шилжүүлэгчийн бүртгүүлсэн барааны тэмдэг, байгууллагын марк, патентын эрх, арга ажиллагаа (know-how) болон бизнесийн загварын үндсэн мэдээлэл;
 - франчайзийн төлбөрийн төрөл, хэмжээ болон төлөх хэлбэр;
 - франчайз хүлээн авагчид бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, тоног төхөөрөмжийн үнэ, нөхцөлийг гарган өгөх;
 - франчайз хүлээн авагчид бизнесийн зааварчилгаа, техникийн туслалцаа үзүүлэх, бизнесийн сургалт зэрэг үйлчилгээний нарийвчилсан агуулга, үйлчилгээ үзүүлэх арга хэлбэр, болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг тасралтгүй өгөх;
 - франчайз хүлээн авагчийн бизнесийн үйл ажиллагаанд зааварчилгаа өгөх болон хяналт тавих бодитой арга хэмжээнүүд;
 - франчайзийн сүлжээнд зориулсан хөрөнгө оруулалтын төсөв;
 - БНХАУ-ын газар нутагт франчайз хүлээн авагчийн тоо, газарзүйн байршил, тархалт болон бизнесийн нөхцөл байдлын үнэлгээ;
 - сүүлийн 2 жилийн Санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайлан (аудит хийсэн байх), аудитын хураангуй тайлан, тэнцэлийн дүгнэлт;
 - сүүлийн 5 жилийн доторх франчайзтай холбоотой шүүх үйл ажиллагаа болон арбитрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
 - франчайз эрх шилжүүлэгч болон бусад хуулийн төлөөлөгчийн хууль зөрчсөн бизнесийн үйл ажиллагааны талаарх тэмдэглэл;
 - Засгийн газрын Худалдааны яамнаас шаардсан бусад мэдээлэл.
3. журмын 23 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид гарган өгсөн нээлттэй баримт бичиг нь зайлшгүй үнэн зөв, бодитой, бүрэн бүтэн байх шаардлагатай ба холбогдох мэдээллийг нуун дарагдуулж эсвэл худал мэдээлэл гарган өгч болохгүй.
 - франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид гарган өгсөн нээлттэй баримт бичигт томоохон өөрчлөлт гарвал, франчайз хүлээн авагчид цаг хугацаанд нь мэдэгдэх ёстой;
 - франчайз эрх шилжүүлэгч холбогдох мэдээллийг нуун дарагдуулсан эсвэл гарган өгсөн нээлттэй баримт бичиг нь худал хуурамч бол франчайз хүлээн авагч нь франчайзийн гэрээг цуцалж болно.
4. журмын 17 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчаас хураан авсан реклам, зар сурталчилгааны төлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах ёстой. Реклам, зар сурталчилгааны

төлбөрийг ашигласан мэдээллийг цаг тухайд нь франчайз хүлээн авагчид танилцуулна.

5. журмын 18 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр, франчайз хүлээн авагч нь бусдад франчайзийн эрхийг шилжүүлж болохгүй. франчайз хүлээн авагч нь франчайз эрх шилжүүлэгчийн бизнесийн нууцыг бусдад задлах эсвэл ашиглахыг зөвшөөрч болохгүй.

“Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай захиргааны журам”-д:

6. журмын 9 дүгээр зүйлд зааснаар “франчайз эрх шилжүүлэгчийн мэдээллийг нуун дарагдуулснаас эсвэл худал хуурамч нээлттэй баримт бичиг танилцуулснаас болж франчайзийн гэрээний гүйцэтгэлд нөлөөлсөн, мөн түүнчлэн гэрээний зорилго биелэгдэх боломжгүй болсон тохиолдолд, франчайз хүлээн авагч нь франчайзийн гэрээг цуцалж болно.”
7. журмын 7 дугаар зүйлд зааснаар “франчайз эрх шилжүүлэгч нь франчайз хүлээн авагчид нээлттэй баримт бичгийг танилцуулахын өмнө, франчайз хүлээн авагчид мэдээллийн нууцыг хадгалах хэлэлцээрт гарын үсэг зурах шаардлага тавих эрхтэй.
 - франчайзийн гэрээ байгуулсан, байгуулаагүй аль ч тохиолдолд, франчайз хүлээн авагч гэрээ байгуулах явцад олж авсан бизнесийн мэдээллийн нууцыг задруулах эсвэл зохисгүй ашиглаж болохгүй;
 - франчайзийн гэрээ дуусгавар болсны дараа, гэрээ дуусгавар болсны дараах нууц хадгалах хэлэлцээрийг байгуулаагүй байсан ч, франчайз хүлээн авагч нь гэрээний харилцаанд олж авсан бизнесийн нууцыг хадгалах үүрэгтэй;
 - франчайз хүлээн авагч нь дээр дурдсан хоёр заалтыг зөрчин бизнесийн нууцыг задруулснаас эсвэл зохисгүй ашигласнаас үүдэн франчайз эрх шилжүүлэгчид болон бусдад хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нөхөн барагдуулах ёстой.

Бүртгэлийн тогтолцоо. Франчайзийн үйл ажиллагааг явуулах нь хувь хүний иргэний эрхийн асуудал боловч Засгийн газраас зах зээлийн хэв журмыг сахиулахын тулд тухайн бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавих шаардлагатай байдаг. Худалдааны яаманд франчайз эрх шилжүүлэгчийн талаар холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь олж авах, франчайз эрх шилжүүлэгчийн бизнесийг стандартчилах, үйл ажиллагаанд хяналт тавих зэрэгт хялбар дөхөм байх үүднээс “Франчайзийн удирдлагын журам”-ын 8, 9, 10 дугаар зүйлд франчайз эрх шилжүүлэгчийн бүртгэлийн тогтолцоог тусгасан байна. Үүнд зааснаар:

1. журмын 8 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгч нь франчайзийн гэрээг анх байгуулсан өдрөөс эхлэн 15 өдрийн дотор Худалдааны яаманд бүртгүүлэх ёстой. Франчайз эрх шилжүүлэгч нь худалдааны яаманд бүртгэл хийлгэхдээ дараах шаардлагатай баримт бичиг, материалуудыг бүрдүүлэн өгнө:
 - үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хуулбар, эсвэл байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - франчайзийн гэрээний загвар;
 - франчайзийн үйл ажиллагааны гарын авлага;
 - зах зээлийн төлөвлөгөө;
 - журмын 7 дугаар зүйлд заасан хэсгийн бичгээр гаргасан амлалт болон холбогдох тодорхойлолт материалууд;

- Засгийн газрын Худалдааны яамнаас шаардсан бусад баримт бичиг материалууд.
- 2. журмын 9 дүгээр зүйлд зааснаар, Худалдааны яам нь франчайз эрх шилжүүлэгчийн бүрдүүлэн өгсөн журмын 8 дугаар зүйлд заасан баримт бичиг, материалуудыг хүлээн авснаас хойш 10 өдрийн дотор бүртгэл хийх ба франчайз эрх шилжүүлэгчид мэдээлнэ. Франчайз эрх шилжүүлэгчийн бүрдүүлэн өгсөн баримт бичиг, материал бүрэн бус бол Худалдааны яамнаас 7 өдрийн дотор нөхөн бүрдүүлж өгөхийг шаардаж болно.
- 3. журмын 10 дугаар зүйлд зааснаар, Худалдааны яам нь бүртгэл хийлгэсэн франчайз эрх шилжүүлэгчийн нэрсийн жагсаалтыг Засгийн газрын вэб хуудсанд нийтлэх ба цаг тухайд нь шинэчилнэ.

Франчайзийн гэрээ. Франчайзийн гэрээнд франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчийн хоорондын эрх, үүргийг тодорхой тусгах нь зүйтэй. Франчайзийн үйл ажиллагаанд үүсдэг ихэнх асуудал, маргаан нь франчайзийн гэрээний стандартчилал хангалтгүй байгаатай шууд холбоотой байдаг. Тиймээс “Франчайзийн удирдлагын журам”-д доорх заалтуудыг тусгаж өгсөн нь давуу тал болсон гэж үзэж байна.

1. журмын 11 дүгээр зүйлд зааснаар, франчайзийн үйл ажиллагаанд оролцогч франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагч нь франчайзийн гэрээг бичгээр байгуулна. Франчайзийн гэрээнд дараах гол гэрээний нөхцөлүүдийг оруулсан байх шаардлагатай:
 - a) франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчийн үндсэн мэдээлэл;
 - b) франчайзийн агуулга/утга болон гэрээний үргэлжлэх хугацаа;
 - c) франчайзийн төлбөрийн төрөл, хэмжээ болон төлөх хэлбэр;
 - d) бизнесийн зааварчилгаа, техникийн туслалцаа үзүүлэх болон бизнесийн сургалт зэрэг үйлчилгээний бодит агуулга болон үйлчилгээ үзүүлэх хэлбэр;
 - e) бараа бүтээгдэхүүн болон ажил үйлчилгээний чанар, стандартын шаардлага болон баталгаа өгөх арга хэмжээ /guarantee measures/;
 - f) бараа бүтээгдэхүүн болон ажил үйлчилгээний борлуулалтын урамшуулал болон реклам, зар сурталчилгаа;
 - g) франчайзийн үйл ажиллагааны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болон хохирлыг барагдуулах/нөхөн төлбөр төлөх хариуцлага;
 - h) франчайзийн гэрээнд өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болох;
 - i) гэрээг зөрчихөд тооцох хариуцлага;
 - j) маргааныг шийдвэрлэх арга зам;
 - k) франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагчийн хооронд тохиролцсон бусад зүйлс.
2. журмын 12 дугаар зүйлд зааснаар, франчайз хүлээн авагч нь франчайзийн гэрээг байгуулснаас хойш тодорхой хугацаанд дангаараа гэрээг цуцалж болно гэсэн заалтыг франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагч франчайзийн гэрээнд заавал тохиролцон тогтооно.
3. журмын 13 дугаар зүйлд зааснаар, франчайз хүлээн авагч зөвшөөрснөөс бусад тохиолдолд, франчайзийн гэрээнд франчайзийн үйл ажиллагааны хугацааг 3-аас доошгүй жил байхаар заана. франчайз эрх шилжүүлэгч болон франчайз хүлээн авагч нь франчайзийн гэрээг шинэчилсэн бол дээрх заалтыг мөрдөхгүй.

Хариуцлага. Журамд тусгасан зүйл заалтуудыг үнэн зөв мөрдүүлэх зорилгоор, франчайз эрх шилжүүлэгч нь франчайзийн үйл ажиллагааг явуулахад тохирох нөхцөлийг хангаагүй, тогтоосон журмын дагуу Худалдааны яаманд бүртгүүлээгүй, франчайз эрх шилжүүлэгч нь холбогдох стандартжуулалтыг зөрчсөн, нээлттэй баримт бичгийг танилцуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн зэрэг тохиолдолд, чанга хатуу хуулийн хариуцлагыг авах талаар журмын дөрөвдүгээр бүлэгт тодорхой тусгасан байна. Тухайлбал:

1. журмын 4 дүгээр бүлгийн 24 дүгээр зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгчид энэ журмын 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангахгүйгээр франчайзийн үйл ажиллагаа явуулж байгаа бол Худалдааны яамнаас зөрчлийг арилгуулахыг шаардах ба хууль зөрчиж олсон ашгийг хураан авч, 100,000-аас 500,000 хүртэлх юаниар торгох ба энэ талаар олон нийтэд зарлана.
 - франчайзийн үйл ажиллагаанд франчайз эрх шилжүүлэгч нь байгууллагаас бусад нэгж, хувь хүн бол, Худалдааны яамнаас хууль зөрчсөн бизнесийн үйл ажиллагааг зогсоохыг шаардах ба хууль зөрчиж олсон ашгийг хураан авч, 100,000-аас 500,000 хүртэлх юаниар торгоно.
2. журмын 25 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгч нь энэ журмын 8 дугаар зүйлд зааснаар Худалдааны яаманд бүртгэл хийлгээгүй бол, Худалдааны яамнаас тодорхой хугацаа зааж бүртгэл хийлгэхийг шаардах ба 10,000-аас 50,000 хүртэлх юаниар торгоно. Заасан хугацаа өнгөрсөн ч бүртгүүлээгүй тохиолдолд, 50,000-аас 100,000 хүртэлх юаниар торгох ба энэ талаар олон нийтэд зарлана.
3. журмын 28 дугаар зүйлд зааснаар, франчайз эрх шилжүүлэгч нь энэ журмын 21 болон 23 дугаар зүйлийг зөрчсөнийг франчайз хүлээн авагч нь Худалдааны яаманд мэдэгдэн шалгуулж үнэн зөв болох нь тогтоогдсон тохиолдолд, Худалдааны яамнаас зөрчлийг арилгуулахыг шаардах ба 10,000-аас 50,000 хүртэлх юаниар торгоно. Хэрэв нөхцөл байдал хүнд тохиолдолд, 50,000-аас 100,000 хүртэлх юаниар торгох ба энэ талаар олон нийтэд зарлана.

ТАВ. МАЛАЙЗ УЛС

Малайзчууд "пава" гэж нэрлэгддэг франчайзийн системтэй төстэй ойлголтыг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсээр иржээ. Энэхүү систем нь хөдөө аж ахуй, үржлийн аж ахуй эрхлэх эрхийг олгодог. Энэхүү системээр дамжуулан газрын эзэн/газар өмчлөгч нь тариаланчдад газар тариалан эрхлэх болон тэнд мал үржүүлэх эрхийг олгодог байв. Хоёр тал харилцан ойлголцож эсхүл албан бус гэрээнд үндэслэсэн түншлэлийнхээ хувийг хүртдэг. Энэ "пава" систем нь бичгээр хийсэн гэрээнд тулгуурладаггүй байв. Орчин үед Малайз Улсын Засгийн газар франчайзинг бизнесийг идэвхтэй дэмжигч орны нэг болжээ.

Дотоодын худалдаа, хэрэглэгчийн асуудал хариуцсан яамны Франчайз хөгжүүлэх хэлтэс нь франчайзийн зөвшөөрөл, бүртгэл, салбарын хөгжлийг хянах зэрэг асуудлыг зохицуулдаг төрийн байгууллага юм.

Гадаадын эрх шилжүүлэгч, ялангуяа франчайзийн өвөрмөц загвар, ойлголтыг Малайзын зах зээлд идэвхтэй дэмжиж уриалж байна. Малайзад янз бүрийн салбараас франчайз үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлсэн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна. 2020 оны байдлаар бүртгэлтэй франчайз бизнес эрхлэгчдийн тоо ойролцоогоор 1.57 хувиар өссөн гэсэн үг юм.

Малайзын Засгийн газар дотоодын франчайзийн өсөлтийг идэвхтэй дэмжих үүднээс Дотоодын худалдаа, хэрэглэгчийн асуудал хариуцсан яам (MDTCA)-ны төрийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, бизнесийн боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Франчайз хөгжүүлэх хөтөлбөр

1992 оны сүүлээр Засгийн газраас Ерөнхий сайдын дэргэд хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийг байгуулж Франчайз хөгжүүлэх хөтөлбөр (FDP)-ийг нэвтрүүлсэн. Энэ нь үйлдвэрлэлийг идэвхжүүлэхэд түлхэц болсон юм. Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний зорилтуудын нэг болох Bumiputera нь бизнес эрхлэгчдийг дэмжихийн тулд франчайз бизнес эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх, ахуйн үйлдвэрлэл, гар урлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг франчайз бизнес болгон хөгжүүлэх талаар зорилт тавин ажилласан.

Малайзын франчайзийн холбоо (MFA) нь 1994 онд байгуулагдсан бөгөөд гишүүнчлэлийн өргөн баазтай бөгөөд үүнд франчайзингийн салбар, нягтлан бодогч, франчайзийн зөвлөх, банкир гэх мэт үйлчилгээ үзүүлэгчид, төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Бүх гишүүд холбооны ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх ёстой ба холбооны гишүүнээр элсэх нь давуу тал болдог байна.¹²⁵

Малайзын франчайзийн холбооны гишүүн болсноор дараах давуу талуудтай. Үүнд:

1. Бүс нутгийн франчайзийн холбооны гишүүн гэж хүлээн зөвшөөрөгдөх;
2. Малайзын франчайзийн холбооны логоог бизнесийн зар сурталчилгаанд ашиглах эрхтэй;
3. Маркетинг, сурталчилгааны хөтөлбөрөөр дамжуулан олон улсын франчайз экспо, вебсайт, сургалт, сурталчилгаа хийх;
4. Засгийн газрын агентлагууд, дэмжигч байгууллагууд болон бусад олон улсын оролцогчидтой санал солилцох, мэдээлэл авах;
5. *Засгийн газар болон дэмжигч байгууллагуудаас олон төрлийн урамшуулалд хамрагдах, санхүүгийн туслалцаа авах;*
6. Малайзын франчайзийн холбооны шагнал болох *Franchise International Malaysia* хүртэх, сургалт, семинар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах арга хэмжээнд хамрагдах;
7. *Хөтөлбөрөөр дамжуулан бизнесийн хэтийн төлөвлөгөөгөө хөгжүүлэх;*
8. Малайзын франчайзийн холбоогоор дамжуулан *мэргэжлийн зөвлөгөө өгч, маргааныг шийдвэрлэхэд туслах;*
9. *Франчайзийн талаарх судалгаа, шинжилгээний үр дүнтэй танилцах;*
10. *Франчайзийн асуудлаар өөрийн дуу хоолойг хүргэх;*
11. *Франчайзийн мэдээ, мэдээлэл боломжуудын талаар цаг алдалгүй мэдээлэл авах*

Эрх зүйн зохицуулалт¹²⁶

1998 онд Франчайзийн тухай хуулийг баталж 2012 оны Франчайзийн (нэмэлт өөрчлөлт) тухай хуулийг баталж 2013 оны 1-р сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон.

Франчайзийн тухай хууль нь франчайзийн гэрээний нөхцөлийг хянадаг төдийгүй франчайз эрх хүлээн авагчийг бүртгэх системийг хэрэгжүүлдэг болсон тул франчайзийн салбарын хөгжилд ихээхэн ач холбогдолтой болсон. Франчайзийн (нэмэлт өөрчлөлт) тухай хуульд гурван шинэ заалт оруулж, хорин хоёр зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн хоёр заалтыг хүчингүй болгосон.

¹²⁵ <http://www.mfa.org.my/newmfa/benefits/>

¹²⁶ <https://www.mondaq.com/franchising/1071046/the-franchise-amendment-act-2020>

Малайзын бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг дунд бизнес эрхлэгчдэд илүү үр өгөөжтэй, тодорхой хамгаалалт болж чадсан гэж үздэг.

- Хууль хүчин төгөлдөр болсноор франчайз эрх шилжүүлэгч, франчайз эрх хүлээн авагчид бизнест орохоосоо өмнө анализ хийж, шийдвэрлэх ёстой үндсэн асуудлуудын талаар мэдлэг мэдээлэлтэй болсон;
- Тус хууль батлагдсанаар хууран мэхлэх, хууран мэхлэх оролдлого хийх, ялгаварлан гадуурхах хэлбэрээр үйлдсэн буруутай үйлдлүүдийг таслан зогсооход ач холбогдолтой болсон. Иймэрхүү байдалд хяналт тавихгүй бол франчайз бизнесийн нэр хүндийг унагах эрсдэлтэй.
- Энэхүү хууль нь систем, франчайз эрх шилжүүлэгчийн зохиогчийн эрхийг хуулбарлахаас хамгаалах, итгэмжлэгдсэн этгээдийн хариуцлага хүлээх зэрэг бизнесийн сайн туршлагыг дэмждэг.

Франчайз хүлээн авагчид мэдээллийг ил тод болгох баримт бичиг

Франчайз эрх шилжүүлэгч нь нь франчайз хүлээн авагч болох гэж буй хүнд мэдээллийг ил тод болгох баримт бичгийн хуулбарыг өгөх ёстой. Энэхүү баримт бичгийг франчайз хүлээн авагч доорх хугацаанаас дор хаяж 10 хоногийн өмнө хүлээн авах ёстой.

Мэдээллийг ил тод болгох баримт бичиг нь их хэмжээний мэдээлэл агуулдаг бөгөөд ба дараах зүйлийг багтаасан болно.

- нэр, хаяг, бизнесийн төрөл, франчайз эрх шилжүүлэгчийн бизнесийн туршлага;
- франчайз эрх хүлээн авагчид олгосон оюуны өмчийн эрхийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- франчайзтай холбоотой төлбөрийн төрөл, хэмжээ;
- зар сурталчилгаа, сургалт, үйлчилгээний төлбөр гэх мэт санхүүгийн бусад үүрэг;
- франчайзийн журамд заасан шаардлагыг дагаж мөрдсөн байх;
- франчайз эрх эзэмшигчид олгосон нутаг дэвсгэрийн эрх, өөрчлөх нөхцөл байдал;
- франчайзийн хугацаа, франчайз эрх эзэмшигч эсхүл франчайз гэрээг сунгах, цуцлах нөхцөл, цуцлах үед талуудын хүлээх үүрэг;
- журамд заасны дагуу аудит хийсэн санхүүгийн тайлан, таван жилийн санхүүгийн урьдчилсан мэдээг ирүүлэх ёстой.

Мэдээллийг ил тод болгох баримт бичгийг зөрчсөн тохиолдолд

Баримт бичгийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд франчайз эрх эзэмшигч франчайз эрх хүлээн авагчийн эсрэг Франчайзийн бүртгэлийн газарт гомдол гаргаж болно.

Хэрэв баримт бичигт тусгасан буруу ташаа мэдээллээс үүдэлтэй франчайз эрх хүлээн авагч алдагдал хүлээвэл хохирлыг барагдуулахыг шаардах эрхтэй.

Тус хуульд оруулсан зарим гол нэмэлт, өөрчлөлтийн талаар дурдвал:

Франчайз эрх хүлээн авагчийн бүртгэл

Франчайз эрх хүлээн авагч нь бүртгэгчид заавал бүртгүүлэх ёстой. Франчайз эрх хүлээн авагчийн эрх авахаар бүртгүүлэгүй тохиолдолд тус хуулийн 58-р зүйлд заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн буюу хариуцлага хүлээх болно.

Гадаадын франчайз эрх хүлээн авагч болон франчайз эрх шилжүүлэгчийн бүртгэл

Малайз Улсын иргэнтэй франчайзийн гэрээ байгуулах гэж буй гадаадын иргэн Франчайз хөгжүүлэх хэлтсээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай. Франчайз эрх хүлээн авагч нь Франчайзийн гэрээ, тодруулгын баримт бичгийг тодорхой заасан нөхцөл, холбогдох баримтуудыг бүрдүүлэн бичгээр ирүүлнэ.

Франчайз эрх хүлээн авагчийн бүртгэл хийгдэж 14 хоногийн дотор гэрээнд гарын үсэг зурснаар баталгаажина.

Бүртгүүлэх өргөдлийг зөвшөөрөх эсхүл татгалзах

Бүртгүүлэх өргөдлийг хүлээн авсны дараа тус хуулийн 7-р хэсэгт заасны дагуу шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг бүртгэгч хянан үзэж өргөдлийг зөвшөөрч эсхүл татгалзаж болно.

Франчайз эрх хүлээн авагчийн бүртгэл хүчин төгөлдөр болох

Франчайз эрх хүлээн авагчийн бүртгэлийг зөвшөөрсөн бол бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

Бүртгэлээс хасах

Франчайз эрх хүлээн авагч нь франчайзийн хугацаа дууссаны дараа бүртгэлийг цуцлуулахаар бүртгэгчид хандана.

- Харин бүртгэгч нь франчайзийн бүртгэлийг дараах тохиолдолд хүчингүй болгож болно. Үүнд:
- Франчайз эрх хүлээн авагч жилийн тайлангаа ирүүлээгүй;
- Төлбөрийн чадваргүй болсон;
- франчайзийн эрхээ өгөхөөс татгалзсан бол.

Торгууль

Хуулийн 6-р зүйлд зааснаар франчайз эрх авахаар бүртгүүлээгүй тохиолдолд дараах торгууль ногдуулдаг.

- Аж ахуйн нэгж, байгууллага бол 250,000 RM-ээс хэтрэхгүй торгууль, хоёр дахь болон давтан үйлдсэн тохиолдолд 500,000 RM-ээс хэтрэхгүй торгууль;
- Хэрэв иргэн бол 100,000 RM -ээс хэтрэхгүй торгууль, хоёр дахь удаагаа үйлдсэн бол 250,000 RM -ээс хэтрэхгүй торгууль.

Дээр дурдсан 6-р зүйлд заасан гэмт хэрэгт оногдуулсан торгуулиас гадна хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу шийтгэнэ.

- франчайзийн гэрээг цуцлах;
- франчайз эрх шилжүүлэгч франчайз эрх хүлээн авагчаас авсан төлбөрийг буцааж өгөх;
- шинэ франчайзийн гэрээ байгуулах, эзэмшигч томилохыг хориглох.


Хуулийн 54-р хэсэгт Малайз Улсын иргэнтэй франчайзийн гэрээ байгуулах гэж буй гадаадын иргэн Франчайз хөгжүүлэх хэлтсээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай. Франчайз хүлээн авагч нь Франчайзийн гэрээ, тодруулгын баримт бичгийг тодорхой заасан нөхцөл, холбогдох баримтуудыг бүрдүүлэн бичгээр ирүүлнэ.

Франчайзийн тухай хууль¹²⁷

Тус хуулийн зорилго нь Малайз дахь франчайзийн эрх зүйн орчныг сайжруулах, бүртгэлийн системийг боловсронгуй болгох, зохицуулах явдал юм. Энэхүү хууль нь үйл ажиллагааны стандартчилал, дүрэм журмыг багтаасан 8 бүлэг 61 зүйлтэй.

¹²⁷ <https://www.kpdnhep.gov.my/images/dokumen/awam/perundangan/AktaBI/8-bi-Franchise-Act-1998-as-at-1-1-2013.pdf>

- I. Удиртгал
 1. Гарчиг
 2. Эхлэл
 3. Өргөдөл гаргах
 4. Тайлбар
- II. Франчайз бүртгэлийн газрын томилгоо
 5. Бүртгэлийн ажилтныг томилгох
 6. Франчайз эрх шилжүүлэгчийн бүртгэл
 - 6а. Гадны франчайз эрх шилжүүлэгч болон франчайз эрх хүлээн авагчийн бүртгэл
 - 6б. Франчайз эрх хүлээн авагчийн бүртгэл
 7. Бүртгүүлэх өргөдөл
 8. Бүртгүүлэх өргөдлийн шийдвэрлэх
 9. Франчайз бүртгэх хүчин төгөлдөр болгох
 10. Хүчинтэй хугацаа
 11. Баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах
 12. Бүртгэлийг цуцлах болон түдгэлзүүлэх
 13. Бүртгэлээс хасах
 14. Франчайз зуучлагчийн бүртгэл
 15. Шаардлагатай баримт
 16. Тайлан
 17. Бүртгэгчийн шийдвэрт заргалдах
- III. Франчайзийн гэрээ
 18. Франчайзийн гэрээний шаардлага
 19. Франчайз эрх хүлээн авагчийн төлбөр
 20. Ялгаварлан гадуурхалтын хориглох
 21. Роялти төлбөр
 22. Сурталчилгааны сан
 23. Урамшууллын төлбөр
 24. Бараа үйлчилгээний тэмдэгтийн бүртгэл
 25. Франчайзийн нэр томьёо
 26. Нууцлал
 27. Ижил төстэй бизнес явуулахыг хориглох
 28. Татвараас зайлсхийх
- IV. Талуудын франчайзийн гэрээг цуцлах
 29. Талуудын үйл ажиллагаа
 30. франчайз эрх шилжүүлэгч ба франчайз эрх хүлээн авагчийн үүрэг
 31. Франчайзийн гэрээг цуцлах
 32. Франчайзийн гэрээг сунгахгүй байх
 33. Франчайзийн гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
 34. Франчайзийн гэрээний хугацааг сунгах
- V. Франчайзийн үйлчилгээг зөвлөх зөвлөл
 35. Франчайз эзэмшигчийн зөвлөл
 36. Зөвлөлийн чиг үүрэг
- VI. Зөрчил ба торгууль
 37. Зөрчил гаргах
 38. Офицерт нөлөөлөх
 39. Шийтгэл
 40. Байгууллагын зөрчил
 41. Зөрчлийг хүчингүй болгох



- VII. Хэрэгжилт
 - 42. Эрх бүхий албан тушаалтан
 - 43. Мөрдөн шалгах эрх мэдэл
 - 44. Баримт бичгийн шалгалт
 - 45. Зөвшөөрөлгүй шалгалт хийх
 - 46. Эмэгтэй хүнийг зөвшөөрөлгүй шалгах
 - 47. Цахим мэдээллийн шалгалт
 - 48. Эд зүйлсийг хураах
 - 49. Албан тушаалтны эрх мэдэл
 - 50. Хэрэгтэй танилцсан тэмдэглэл
 - 51. Нэмэлт эрх мэдэл
 - 52. Прокурор
- VIII. Бусад арга хэмжээ
 - 53. Бүртгэгчийн зөвшөөрөлгүй франчайз эрх эзэмших
 - 54. Гадаадын иргэн франчайз эрх эзэмших
 - 55. Хүчингүй болсон
 - 56. Баримт бичигт хяналт шалгалт хийх
 - 57. Хүчингүй болсон
 - 58. Чөлөөлөх
 - 59. Офицерын эрх
 - 60. Дүрэм
 - 61. Шилжилтийн заалт

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Франчайзийн удирдлагын тухай тогтоол”. БНХАУ-ын засгийн газрын тогтоол. /Regulations on Administering Commercial Franchises/. 2007. http://www.gov.cn/zhengce/content/2008-03/28/content_4179.htm
- “Франчайзийн бүртгэлийн тухай захиргааны журам”. БНХАУ-ын журам. /Administrative Rules for the Record-filing of Commercial Franchises/. 2011. http://www.gov.cn/flfg/2011-12/21/content_2025612.htm
- “Франчайзийн нээлттэй баримт бичгийн тухай захиргааны журам.” БНХАУ-ын журам. /Administrative Rules on Commercial Franchise – Information Disclosure/. 2012. http://www.gov.cn/flfg/2012-03/06/content_2084101.htm
- “Франчайзийн тухай хууль”. Итали улсын хууль №129, (Rules on commercial franchising, the Franchising Act/. 2004. [https://www.gazzettaufficiale.it/eli/id/2004/05/24/004G0161/sg#:~:text=L'affiliazione%20commerciale%20\(franchising\),industriale%20o%20intellettuale%20relativi%20a](https://www.gazzettaufficiale.it/eli/id/2004/05/24/004G0161/sg#:~:text=L'affiliazione%20commerciale%20(franchising),industriale%20o%20intellettuale%20relativi%20a)
- “Франчайзийн тухай тогтоол”. Итали улсын Засгийн газрын тогтоол №204. /Regulation on Commercial franchising ,the Franchising Regulation/. 2005. <http://www.unidroit.org/english/guides/2007franchising/country/italy.htm>
- Brazilian Franchise Law, №13.966\26, 2019. http://www.planalto.gov.br/ccivil_03/_ato2019-2022/2019/lei/L13966.htm
- Гадаадын зарим орны Франчайзийн хуулийн давуу болон сул тал Д.Байгалмаа, Г.Гэрэл 2013
- (2012 оны 12 15). Монголыг гадаад ертөнцтэй холбох гүүр нь франчайзинг. (Н.Учрал, Ярилцагч)
- <https://www.china-briefing.com/news/franchise-china-guide/#:~:text=As%20of%20January%202019%2C%204%2C368,franchise%20markets%20in%20the%20world.>
- <https://www.trade.gov/country-commercial-guides/brazil-franchising#:~:text=There%20are%202%2C918%20franchising%20chains,in%20number%20of%20franchise%20chains.>
- <https://www.franchise.org/blog/the-history-of-modern-franchising>
- <https://www.maineFranchiseowners.org/about-us/history-of-franchising/>
- <https://www.vocabulary.com/dictionary/enfranchise>
- <https://fantasticfranchise.com/blog/3-basic-types-of-franchise-systems/>
- <https://www.thefranchisebuilders.com/2013/09/20/types-franchise-agreements/>
- <https://www.franchise.org/faqs/legal/what-is-the-ftc-franchise-rule>
- Franchise rule <https://www.ftc.gov/system/files/documents/plain-language/bus70-franchise-rule-compliance-guide.pdf>
- Disclosure basic BASICS-TRACK-Disclosure-Basics.pdf
- <https://www.franchisedirect.ie/information/the-franchisees-rights-and-responsibilities>
- Global Franchise Regulation Update by Carl E.Zwisler 2019
- https://www.europarl.europa.eu/doceo/document/TA-8-2017-0322_EN.html
- Ноолуурын бүтээгдэхүүнийг экспортлох франчайзийн судалгаа Б.Алтанбуян 2020
- <https://en.wikipedia.org/wiki/RE/MAX>
- <http://cumongol.mn/about>
- <http://www.circlek.mn/3/about/Circle-K-%D0%91%D1%80%D1%8D%D0%BD%D0%B4>

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДАРААХ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ БОДЛОГО, АРГА
ХЭМЖЭЭ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Амаржаргал (Ph.D), Д.Аюуш,
Б.Батцэцэг, Ш.Батцэнгэл, О.Билгүүтэй,
С.Золжаргал, Р.Оргилмаа, Б.Туул, Д.Халиун*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

БҮЛЭГ 1.ОНОЛ, АРГА ЗҮЙ

1.1.Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, сувгууд

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1.“Ковид-19” цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, эрх зүйн орчны тойм

2.1.1.Эрх зүйн орчны тойм

2.1.2.Эдийн засгийг сэргээхтэй холбоотой онцлох гол зохицуулалтууд

2.1.3.Төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээ

2.2.Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал

2.2.1.2020 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүд /2019 онтой харьцуулсан байдлаар/

2.2.2.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (2021 оны эхний хагас жилийн байдлаар)

БҮЛЭГ 3. ДЭЛХИЙ ДАХИНЫ ЦАР ТАХЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СУРГАМЖ

Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах зарчим, бүс нутаг, улс орнуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

БҮЛЭГ 4.КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДАРААХ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

4.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”

“Америкийн ажлын байр хөтөлбөр”

“Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”

Ногоон эдийн засаг

4.2.БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

БНХАУ-ын Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө (2021-2025)

БНХАУ-ын эдийн засгийн урт хугацааны чиглэл

4.3.БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛС

4.4.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

4.5.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

ХБНГУ-ын Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө

4.6.ТАЙВАНЬ

4.7.ЯПОН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Судалгаанд авагдсан улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, 2020 он
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан орнуудын хууль, эрх зүйн орчны тойм
Хүснэгт 3. Ковидтой холбоотой эрх зүйн орчин
Хүснэгт 4. Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээний хураангуй
Хүснэгт 5. Ковид-19 ба зарим эпидемийн нөлөө
Хүснэгт 6. Өмнөх эпидемиудийн эдийн засагт үзүүлсэн нөлөө
Хүснэгт 7. ЕХ-ны 2021-2027 оны төсөв болон “Европын Холбооны дараагийн үе” хөтөлбөрийн хуваарилалт (зарлагын ангиллаар)
Хүснэгт 8. “Шинэ эриний ЕХ” хөтөлбөрийн зарцуулалт
Хүснэгт 9. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг үр нөлөөллийг бууруулахад авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ
Хүснэгт 10. БНХАУ-ын эдийн засгийн төлөв, Дэлхийн банк.
Хүснэгт 11. Ковид-19 цар тахлын үед ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээ: БНХАУ
Хүснэгт 12. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд /2018-2022* он/
Хүснэгт 13. Ковид-19-өөс шалтгаалсан экспорт, импортын хязгаарлалт, арга хэмжээ
Хүснэгт 14. Арилжааны банкуудын санхүүжилтийн багц (NTD-тайвань доллар)

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. “Ковид-19”-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөлийн боломжит суваг
Зураг 2. Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл
Зураг 3. ЗГ-аас Цар тахлын нөлөөг бууруулах чиглэлээр нийгмийн хамгааллын чиглэлд авсан арга хэмжээ
Зураг 4. Макро эдийн засгийн гүйцэтгэл
Зураг 5. Дэлхийн зарим орнуудад цар тахлын өмнөх үед нэг хүнд ногдох ДНБ-ний түвшинд хүрэн хугацаа, жилээр
Зураг 6. ЭЗХАХБ-ын зарим орнуудад ажил эрхлэлтийг бүрэн сэргэлтийн төсөөлөл, улирлаар
Зураг 7. Хөрөнгө оруулалт, шинэтгэлийг явуулахыг хөхиүлэн дэмжиж буй салбар, чиглэлүүд
Зураг 8. Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангийн зорилтот салбарууд
Зураг 9. Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас ЕХ-ны гишүүн орнуудад олгох буцалтгүй тусламжийн дээд хэмжээ (тэрбум евро)
Зураг 10. Дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлт (2018-2021 он)
Зураг 11. Хятад Улсын ажилгүйдлийн түвшин (2020.10-2021.07)
Зураг 12. Хятад Улсын инфляцийн түвшин (2020.10-2021.07)
Зураг 13. Засгийн газрын төлөх өрийн хэмжээ (2010-2020 он)
Зураг 14. Хятад Улсын худалдааны тэнцэл (2020.10-2021.07)
Зураг 15. БНХАУ-ын эдийн засгийн замын зураг (14 дэх удаагийн 5 жилийн төлөвлөгөө 2021-2025 он)
Зураг 16. Ковид-19 цар тахлын нийт бүртгэгдсэн тохиолдол /2020.02.05-2021.09.04-ны байдлаар/

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕАЭЗХ	Евразийн эдийн засгийн холбоо
ЕХ	Европын холбоо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОПЕК	Газрын тос экспортлогч орнуудын байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮНО	Үндэсний нийт орлого
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХАХБ	Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага

УДИРТГАЛ

Захиалгын дагуу “КОВИД-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх бодлого, эрх зүйн орчны талаарх бусад орны туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэлээ. Сэдвийн хүрээнд АНУ, БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Ирланд Улс, ХБНГУ, Япон, Тайвань зэрэг орнуудын макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн орчны хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, ковидын дараах эдийн засгийг сэргээн босгох бодлого, эрх зүйн орчныг харьцуулан судаллаа.

Түлхүүр үг: Ковид-19 цар тахал, эдийн засгийн сэргэлт

Keyword: Covid-19 pandemic, economic recovery

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанаас үзэхэд 21-р зуунд халдварт өвчний цар тахлын давтамж тогтмолжих зүй тогтол ажиглагдаж байгаа бөгөөд сүүлийн 18 жилийн хугацаанд 5-6 жилийн давтамжтайгаар SARS-CoV коронавирус (2002-2004 он), гахайн томуу (2009-2010 он), Эбола (2014-2015 он), коронавирсийн тахал SARS-CoV-2 (2020 он) дэгдээд байна. “Ковид-19” цар тахлын үргэлжилсэн хугацааны түүхэн хандлага давтагдана гэж үзвэл дэгдэлт эхэлсэн 2019 оны төгсгөлөөс хойш 3 жилийн хугацаатай үргэлжилж 2022 оны сүүлээр намжих хандлага харагдаж байна.

“Ковид-19” цар тахал нь эдийн засагт эрэлтийн, нийлүүлэлтийн, санхүүгийн зах зээлийн, гадаад хүчин зүйлийн гэсэн 4 төрлийн сувгаар дамжин нөлөөлж байгааг Пакистаны “Superior” коллежийн шинжлэх ухааны тэнхимийн эрдэмтэн судлаач Мухамед С.Мео онолын хувьд тайлбарласан байдаг¹²⁸. Тэрээр “Ковид-19” цар тахлын үед экспортыг тогтвортой түвшинд хадгалах, нэмэгдүүлэх, нэр төрлийг нь олшруулах, гадаад валютыг хүрэлцэхүйц түвшинд нөөцлөх, дотоодын үйлдвэрлэл, ялангуяа хүнсний салбарын болон жижиг дунд бизнесийг дэмжих, нөөцийн болон дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, иргэдийн ажил эрхлэлтийн найдвартай байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, санхүүгийн байгууллага болон зээлдэгчдийн төлбөрийн чадвартай байдалд дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглэгдсэн татвар, төсөв, мөнгөний бодлогыг явуулах, зээл тусламжийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай болохыг цаагуураа зөвлөсөн байна.

Дэлхийн улс орнуудын төр, засгийн газраас цар тахалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Дэд бүтэц, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжих;
- Татварын дэмжлэг үзүүлэх;
- Зээлийн хөнгөлөлт, хойшлуулалтыг хэрэгжүүлэх, хүртээмжийг өсгөх;
- Экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх;
- Төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлийг хөнгөвчлөх;
- Засгийн газрын хөрөнгө оруулалтын зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Төсвийн алдагдлыг бууруулах;
- Иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх;
- Банк, санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хангах;
- Ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэх;

Дэлхий нийтэд авч хэрэгжүүлж байгаа дээрх арга хэмжээний чиглэл, зорилтуудаас үзэхэд ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэхийг чухалчлан үзэж байгаа нь

¹²⁸ Muhammad S.Meo, Addressing the challenges of COVID-19 pandemic outbreak: Pakistan's preparations and response, (2020), <<https://onlinelibrary.wiley.com/doi/epdf/10.1002/pa.2430>> хандсан 2021.09.09

энэ удаагийн цар тахлын дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээний бас нэгэн онцлох чиглэл болж байна. Учир нь байгаль орчны доройтол, агаарын бохирдол, хоол хүнсний аюулгүй байдалтай холбоотой олон асуудлууд дэлхий нийтийн тулгамдсан асуудал болж байгаа, мөн түүнчлэн шинжлэх ухаан, технологийн давуу талыг ашиглан хүн төрөлхтний амьдралын хэмнэл, аж байдлын соёлыг өөрчлөх хэрэгцээ шаардлага бий болж байгаа учраас дэлхий даяар дээрх зорилтыг шинээр дэвшүүлэн тавьж, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал, төрийн үйлчилгээг цахим болгож хялбаршуулах, боловсролын салбарт цахим сургалтыг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй, хямд төсөр зардалтай дэд бүтэц, эрчим хүч, техник, технологийг хөгжүүлэх зорилтуудыг дэлхийн ихэнхи улс орнууд цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх бодлого хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд, “Ковид-19” цар тахлын тархалтыг тогтоон барих, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэсэн санхүүгийн тусламж, нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсээр байгаа бөгөөд 2020 оны 4-р сараас 2021 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд 3.27 их наяд төгрөгийн төсвийн нэмэлт зарлага, 1.9 их наяд төгрөгийн төлөвлөсөн орлогын хөнгөлөлт, чөлөөлөлт, 649 тэрбум төгрөгийн төсвийн гадуурх санхүүжилт зэрэгт нийт **5.1 их наяд** төгрөгийг “Ковид-19” цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулаад байна. Монгол Улсын ковидтой холбоотой нийт санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь 14% орчим байгаа бол дэлхийн хэмжээнд энэ үзүүлэлт дунджаар 16.3%¹²⁹ орчим байна.

Бусад орнуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний жишиг, судалгаанд авч үзсэн цар тахлын нөлөөллийн сувгийг тайлбарласан онол арга зүйг удирдлага болгон ковидын сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Монгол Улсад авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийг тоймлон авч үзвэл дараах дүр зурагтай байна. Үүнд:

Дэд бүтэц, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээр

- ✓ Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоо болон банкуудын чөлөөт эх үүсвэрийг ашиглан ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 3.0 их наяд төгрөг хүртэлх зээл олгох;
- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох;
- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой, ажилгүй, гэртээ хүүхэд асарч буй иргэн, хөдөлмөрийн насны халамж хүртэгчдэд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх;
- ✓ “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлж, аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг

Татварын дэмжлэг үзүүлэх чиглэлээр

НДШ-ийн хөнгөлөлт, ХХОАТ-ын хөнгөлөлт, ААНОАТ, түрээсээ бууруулсан түрээслэгчдийн татварын хөнгөлөлт, ААНОАТ, НДШ хоцорч төлсний алданги хөнгөлөх, НӨАТ-ын хөнгөлөлт (эрүүл мэнд, хүнсний барааны импорт), нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хуулийг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг;

Зээлийн хөнгөлөлт, хойшлуулалт, хүртээмжийг өсгөх чиглэлээр: Зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээх, банкууд гүйлгээний шимтгэлээ бууруулахыг дэмжих, долларын хадгаламжийг даатгалаас гаргаж хадгаламжийн долларжилтыг бууруулах,

¹²⁹ [An Analysis of the Worldwide Response to the COVID-19 Pandemic: What and How Much? \(EWP No 626\) \(adb.org\)](https://www.adb.org)

ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлж, хойшлуулах, банкны системийн нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх, Монгол банкны олгож байгаа репо санхүүжилтийн нийт эх үүсвэр, нэг зээлдэгчид олгох хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг;

Экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх чиглэлээр: Төмөр замын боомтоор гарах экспортын бараа эргэлтийг нэмэгдүүлэх, улс хоорондын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, хилийн ачаа тээврийн боомтын үйл ажиллагааг сэргээж, хүчин чадлыг нэмэгдүүлэн экспорт, импортын үйл ажиллагааг ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэм дор зохион байгуулж гадаад худалдааны бараа эргэлтийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг;

Засгийн газрын хөрөнгө оруулалтын чиглэлээр: Тэргүүлэх чиглэлийн 100 төсөл, арга хэмжээг Засгийн газрын 100 хоногт багтаан зарлан хэрэгжүүлэх, Зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгож ажиллах зэрэг арга хэмжээг;

Иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр: Хүүхдийн мөнгө, эрүүл мэндийн зардал, малчдад олгох тусламж, халамжийн тэтгэвэр, хүнсний талон, залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцах, халамжийн тэтгэвэр, хүүхдийн мөнгө, шахмал түлшний үнийг үе шаттай бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, хүнс, түлш, шатахуун, малын тэжээл, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн үнийн зохиомол өсөлтөөс сэргийлэх, эрчим хүчний салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, малжуулах хөтөлбөр зэрэг арга хэмжээг;

Банк, санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хангах чиглэлээр

- ✓ Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж актив худалдан авах, хөнгөлөлттэй зээл олгох
- ✓ Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 25 хувь байсныг 20 хувь болгох
- ✓ Банкуудын нөөц хөрөнгийг дэмжих үүднээс репо санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх зэрэг арга хэмжээг;

Ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр: дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг төрийн худалдан авалтаар дэмжих арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Түүнчлэн зарим тодорхой салбарын үйл ажиллагааг бодлогоор дэмжихээр төлөвлөж байгаа бөгөөд үүнд төмөр зам, агаарын тээвэр, автотээвэр, гол нэрийн хүнс, түлш, шатахуун, малын тэжээл, газар тариалан, ноолуур, соёлын үйлдвэрлэл, шинжлэх ухаан, инновацийн бүтээгдэхүүн, алт, хүнсний үйлдвэрлэл, барилгын салбарууд хамаарч байна.

Одоогоор “Ковид-19”-той холбоотойгоор төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлийг хөнгөвчлөх, төсвийн алдагдлыг бууруулах чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлээгүй байгаагаас гадна ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ тусгагдаагүй байдалтай байна.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын хувьд, цар тахал нь глобал эдийн засгийн нийт өсөлтийг 2020 онд -3.4%-өөс -7.6%-иар сааруулсан байна. ОУВС-гийн шинжээчид дэлхийн эдийн засаг 2021 онд 4.2%-5.6%-иар сэргэх төлөвтэй байгаа ба дараагийн 2-оос 3 жилийн дотор цар тахлын өмнөх байдалд эргэн орох боловч цар тахалтай тэмцэх, түүний нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулсан төсвийн хөрөнгө, зээлийн эргэн төлөлттэй холбоотой хүндрэлүүд эдийн засгийн өсөлтийн хурдыг

сааруулна хэмээн дүгнэсэн байна.¹³⁰ 2020 онд дэлхийн хэмжээнд 95 сая хүн туйлын ядууралд өртсөн, 80 сая хүн шим тэжээлийн дутагдалд орсон байгаагаас гадна эдийн засгийн хямралаас улбаатай орлогын тэгш бус байдал нэмэгдсэн, **үйлдвэрлэлийн идэвх буурсан, үйлчилгээний салбар хумигдсан, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ багассан, бондын хөрөнгө оруулалтын өгөөж буурсан, аялал жуулчлалын орлого хумигдсан зэрэг сөрөг нөлөөллүүд илэрч байна.**

Ковидын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг даван туулах бодлого, хөтөлбөр боловсруулахдаа улс орнууд дараах зарчмуудыг баримталж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цар тахалтай холбоотойгоор эдийн засгийг дэмжихэд чиглэсэн бодлого арга хэмжээ нь системийн шинжтэй, тодорхой зорилтуудад чиглэгдсэн байх ёстой бөгөөд бодлогын зорилтуудын төлөвлөлт, хэрэгжилт нь нээлттэй, ил тод байх, цогц байх, өөрчлөх боломжтой байх, уян хатан байх, дэмжлэг авах нөхцөл, механизм нь хүртээмжтэй, тохиромжтой, энгийн байх гэх мэт зарчмуудыг баримтлах нь зүйтэй хэмээн олон улсын байгууллагуудаас зөвлөж байна. Түүнчлэн *санхүүгийн арга хэрэгслийг сонгохдоо эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн үе шатны зорилтуудыг харгалзан үзэх нь чухал бөгөөд “хямрал, сэргэлт, хямралаас гарах, тогтворжилт, эдийн засгийн өсөлтийг хангах” гэсэн үе шатуудыг дамжин хэрэгжинэ гэж үзсэн байна.*

2020 оны хоёрдугаар хагасаас эхлэн улс орнууд төсвийн хөрөнгө оруулалтад чиглэсэн томоохон хэмжээний эрчимжүүлэх багц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр нь нүүрстөрөгчөөс ангид эдийн засагт шилжих, дижитал шилжилт, эрүүл мэндийн тогтолцоо болон нийгмийн дэд бүтцийг бэхжүүлэх зэрэг тэргүүлэх салбаруудад голлон төвлөрч байна. Европын холбооны гишүүн орнуудад “Европын эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан”-гаас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн 37% нь уур амьсгалын зорилтуудыг, 20% дижитал шилжилтийг нь тус тус дэмжсэн байх ёстой гэсэн шаардлагыг тавьж байна.

Евразийн эдийн засгийн холбооноос 2020 оны 4-р сарын 10-ны өдөр “Ковид-19” цар тахал тархаж буйтай холбогдуулан эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээний тухай” 6 дугаар тушаалыг баталсан бөгөөд бүс нутгийн нийгэм, эдийн засаг, дижитал эдийн засгийн инновацийн хөгжлийг дэмжих, дэлхийн цаг уурын өөрчлөлттэй тэмцэх заалтуудыг тусгасан байна.

Судалгаанд авагдсан орнуудын эдийн засгийн нөхцөл байдлын хувьд:

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, 2020 он¹³¹

	ДНБ, тэрбум ам.долл ар	ДНБ-ний жилийн өөрчлөлт, %	Инфляцын түвшин, %	Ажилгүйдлийн түвшин, %	Улсын төсвийн өөрчлөлт, ДНБ-д эзлэх хувиар	ЗГ-ын өр/ДНБ-д эзлэх хувь
АНУ	20937	+12.20%	5.40%	5.20%	-14.90%	107.60%
БНХАУ	14723	+7.90%	1.00%	5.10%	-3.70%	66.80%
Ирланд	419	+21.60%	2.20%	6.40%	-5.00%	59.50%
ОХУ	1484	+10.30%	6.68%	4.50%	-3.80%	17.80%
ХБНГУ	3806	+9.40%	3.90%	3.60%	-4.20%	69.80%
Тайвань	611	+7.43%	2.36%	4.36%	-4.50%	28.20%
Япон	5065	+7.60%	-0.30%	2.80%	-12.60%	266.20%
Монгол	13	+6.30%	7.40%	8.40%	-11.50%	55.00%

Эх сурвалж: <https://tradingeconomics.com>

¹³⁰ M. Szmigiera, Impact of the coronavirus pandemic on the global economy - Statistics & Facts Aug 3, 2021 <https://www.statista.com/topics/6139/covid-19-impact-on-the-global-economy/>

¹³¹ <https://covid19.who.int/table>, <https://www.worldometers.info/coronavirus/>

Хүснэгтээс харахад Монгол Улс ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээгээр АНУ, Япон, Хятад, Герман зэрэг өндөр хөгжилтэй орнуудыг эс тооцвол судалгаанд авагдсан шилжилтийн эдийн засагтай, хөгжиж байгаа орнууд (ОХУ, Тайвань)-аас өндөр байгаагаас үзэхэд ковидын сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийг сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний төсөв, санхүүгийн хүндрэл бэрхшээл тулгарахаар байна.

Судалгаанд авагдсан улс орнуудын цар тахалтай тэмцэх эрх зүйн орчны хувьд:

Судалгаанд авагдсан нийт 7 орноос 3-т (АНУ, ХБНГУ, Тайвань) нь Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээхэд чиглэсэн бие даасан хуулиудыг баталсан бол Ирланд Улсад цар тахал дэгдсэн үеэс хойш хариу арга хэмжээний хүрээнд нийт 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээрээс зарим онцлох туршлагуудыг тоймлон танилцуулбал:

БНХАУ-ын хувьд эдийн засгийг сэргээхэд чиглэсэн зорилтуудыг Хятадын 14 дэх таван жилийн төлөвлөгөө (2021-2025)-нд дараах байдлаар тусгасан байна:

- 2035 онд эдийн засгийн хөгжлийг дунд шатанд хүргэх;
- Дотоодын эрэлтийг ихэсгэхэд анхаарах;
- 2060 онд нүүрстөрөгчийн ялгарлыг бага хэмжээнд хүргэх (low-carbon economy);
- 2035 онд гэхэд тээврийн хэрэгслийн 50%-ийг цахилгаан болон хосолсон (hybrid) хөдөлгүүртэй болгох;
- Аж үйлдвэрийн нийлүүлэлтийг шинэчлэх;
- Инноваци ба технологийн бие даасан байдал бий болгох;
- Дэд бүтцийг сайжруулах;
- Экспортыг нэмэгдүүлэх;
- Эдийн засгийг нээлттэй болгох.

ОХУ-ын хувьд Холбооны Засгийн газраас цар тахлын хямралыг даван туулах зорилгоор дараах бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө

- Ажил эрхлэлт, хүн амын орлогыг сэргээх, эдийн засгийн өсөлт, эдийн засагт урт хугацааны бүтцийн өөрчлөлтийг хангах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (2020-2021 он).¹³²

Ерөнхийлөгчийн зарлиг: 2024 он хүртэл эдийн засгийн өсөлтийг хурдасгах ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 5-р сарын 7-ны өдрийн 204 дугаар зарлигийг ОХУ-ын Холбооны хурлаар хэлэлцэн 2020 оны 1-р сарын 15-ны өдөр баталсан бөгөөд хямралын дараах эдийн засгийг сэргээх Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг үүгээр баталсан.

Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 434 дүгээр тогтоолын дагуу цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртсөн эдийн засгийн салбаруудын жагсаалтыг баталж, нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр шинэчилж байна.

¹³² “Общенациональный план действий, обеспечивающих восстановление занятости и доходов населения, рост экономики и долгосрочные структурные изменения в экономике”, 2020
http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_333667/

АНУ-ын хувьд 2020 онд дараах 4 удаагийн санхүүгийн багц тусламжийн тухай хуулийг баталсан. Үүнд:

- Коронавирусийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нэмэлт хөрөнгө төсөвлөх тухай хууль;
- Гэр бүлүүд тэргүүн ээлжинд - Коронавирусийн эсрэг хариу арга хэмжээний тухай хууль;
- Коронавирусийн эсрэг тусламж дэмжлэг, эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль;
- Нэгдсэн төсөвт хөрөнгийн тухай хууль.

Мөн 2021 онд АНУ-д эдийн засгийг сэргээн хөгжүүлэх “Илүү сайнаар бүтээе” дараах гурван дэд хэсэг бүхий хөтөлбөрийг санаачлан боловсруулсан байна.¹³³

- “Америкийг хямралаас гаргах хөтөлбөр” нь жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих, үйл ажиллагааг нь тогтворжуулах, иргэдийг вакцинжуулалтад бүрэн хамруулах, сургууль цэцэрлэгүүдийг нээх, ажилгүй болсон иргэд, айл өрхүүдэд амьжиргааны тэтгэмж олгох, хүүхдийн татварын хөнгөлөлтөд хамруулах, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах зэрэг ажил эрхэлдэг гэр бүлүүд рүү түлхүү анхаарсан.
- “Америкийн ажлын байр хөтөлбөр” дэд бүтцийг сайжруулах, сая сая ажлын байр бий болгоход чиглэсэн.
- “Америкийн гэр бүлүүд хөтөлбөр” дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилго бүхий иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд асрах үйлчилгээнд чиглэж байна.

ХБНГУ-ын хувьд Ковид-19 цар тахал дэгдсэнээс хойш цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд дараах хууль тогтоомжуудыг баталж, холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулах тухай хууль (Covid-19 Mitigation Act);¹³⁴
- Ковид-19 цар тахлын үед эмнэлгүүдэд үзүүлэх тусламжийн тухай хууль,
- Улсын хэмжээнд тархсан цар тахлын үед ард иргэдийг хамгаалах тухай хууль (Drittes Gesetz zum Schutz der Bevölkerung bei einer epidemischen Lage von nationaler Tragweite).¹³⁵

Мөн ХБНГУ-ын Бундестагаас Халдварт өвчнөөс хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох тухай хууль, Эмнэлгийн санхүүжилтийн тухай хууль, Эмийн тухай хууль, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль, Эмнэлгийн төлбөрийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Тайванийн хувьд Ковид-19 цар тахал дэгдэхээс өмнө 2003 оны SARS өвчний туршлагаараа хууль эрх зүйн хувьд, институтын хувьд, нийгмийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, туршлага цуглуулсан байна. Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор 2020 онд “Ковид-19-ийн тусгай хууль” буюу “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх,

¹³³ 2021 оны 8 дугаар сарын 1-ний байдлаар эдгээр дэд хөтөлбөрөөс зөвхөн “Америкийг хямралаас гаргах хөтөлбөр” нь хууль болон батлагдсан бол “Америкийн ажлын байрын хөтөлбөр”-т туссан арга хэмжээнүүд Сенатаас баталсан “Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон ажлын байрны тухай хууль”-д тусгагдсан байна.

¹³⁴ <https://www.ioneday.com/en/insights/2020/04/act-to-mitigate-the-consequences-of-the-covid19-pandemic-under-germanys-civil-insolvency-and-criminal-procedure-law-of-2>

¹³⁵ <https://perma.cc/L4S4-N7MB>

тусламж үзүүлэх, нөхөн сэргээх тухай тусгай хууль”-ийг баталсан. 2021.05.31-нд хуулийн хугацааг дахин 1 жил буюу 2022.06.30-ыг хүртэл сунгасан.

Уг хуульд нийт зарцуулах төсвийг 840 тэрбум тайвань доллар (30.37 тэрбум ам.доллар)-аар баталж зорилтот бүлэг (7.3 сая хүн-хүн амын 30 хувь)-т түлхүү чиглүүлэх, Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэхэд Засгийн газрын тусламж, нөхөн олговор олгох, эдийн засгийг дэмжихэд зарцуулагдахаар заасан. Хуульд дараах асуудлуудыг тусгасан:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хянах, эмнэлгийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж үзүүлж буй эмнэлгийн ажилтнуудад тэтгэмж, урамшуулал олгох (2-р зүйл);
- Гэрийн тусгаарлалт, гэрийн хорио цээр, бүлгийн тусгаарлалт, бүлгийн хорио цээрийн дэглэмд хамрагдсан хүмүүс, түүнчлэн тэдгээр хүмүүсийг асран халамжилж буй гэр бүлийн гишүүдэд нөхөн төлбөр, цалинтай чөлөө олгох тухай (3-р зүйл);
- Мөн эдийн засгийн багц арга хэмжээг авахаас гадна үнийн өсөлт, ташаа мэдээлэл өгөх, тусгаарлалт, хорио цээрийн дэглэм зөрчсөн тохиолдолд авах шийтгэл болон нөхөн олговрын асуудлыг тусгасан. (7, 9, 12-16-аар зүйл).

Ирланд Улсын хувьд цар тахал дэгдсэнээс хойш хариу арга хэмжээ авахтай холбоотойгоор нийт 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас 11 хуульд эдийн засагтай холбоотой арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль (Онцгой байдлын үеийн хамгаалал)
- Нийтийн эрх ашгийн хамгаалах арга хэмжээний тухай хууль
- Бичил бизнесийн зээлийн сангийн тухай хууль
- Санхүүгийн зохицуулалтын тухай хууль (Онц байдалд ажилгүйдлийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн Европын Холбооноос хэрэгжүүлж буй “SURE” хөтөлбөрт хамрагдах)
- Зээлийн батлан даалтын тухай хууль
- Орон сууцны үнэлгээний тухай хууль
- Санхүүгийн зохицуулалтын тухай хууль, дугаар 2
- Компанийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Санхүүгийн тухай хууль
- Хөгжил төлөвлөлт, орон сууцны түрээсийн тухай хууль.

Нийтлэг байдлаар авч үзвэл судалгаанд хамрагдсан орнууд цар тахлын нийгэм эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах, иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн салбарыг бэхжүүлэх чиглэгдсэн татвар, төсөв, мөнгөний бодлогыг явуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

НҮБ-аас Ковид-19 цар тахлын дараах хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон дүн шинжилгээнд¹³⁶ цар тахлын хямрал эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогууд хангалтгүй болсныг тодорхой болголоо. Бүтээмж ба эдийн засгийн өсөлт хоорондын уялдаа холбоо суларч, олон улс орны хувьд эдийн засгийн өсөлт нь уур амьсгалын өөрчлөлт, орлогын тэгш бус байдал зэрэг асуудлуудтай харьцуулахад тэргүүлэх ач холбогдол багатай болж байгааг тэмдэглэжээ. Тус дүн шинжилгээнд коронавирусийн дараах хөгжлийн зургаан мега чиг хандлагыг тогтоосон бөгөөд үүнд дижитал шилжилт, хиймэл оюун ухаанд суурилсан эдийн засаг; эрүүл мэнд, амьдралын

¹³⁶ Future Possibilities Report, Unated Nationals Organization, 2020
<https://www.un.org/sites/un2.un.org/files/20200720_un75_uae_futurepossibilitiesreport.pdf> хандсан
2021.10.18

чанарт чиглэсэн хүмүүсийн сайн сайхан байдлын эдийн засаг; бага нүүрстөрөгчийн эдийн засаг; ногоон эрчим хүч; хаягдалгүй үйлдвэрлэл; биологийн өсөлтийн эдийн засаг; өмчлөл/хэрэглээнээс мэдрэмжид шилжсэн эдийн засаг орж байна.¹³⁷

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд цар тахлын дараах буюу дунд, урт хугацааны бодлогууд нь мөн дээрх чиг хандлагуудтай уялдаж байгаа буюу гол төлөв ногоон эдийн засаг, өндөр технологи, цахим шилжилтийг түргэсгэхэд чиглэгдэж байна.

¹³⁷ **The Exabyte Economy: Hyperconnected devices, data and people** As computing power and storage become cheaper and more efficient, and 5G technology is rolled out, future rises in connectivity will be driven more by devices than people. The resulting flow of data will further improve the capacity of AI-based systems to optimise processes and services and disrupt business models across a range of sectors. The Exabyte Economy could deliver possibilities with an estimated total economic value of up to USD 8 trillion by 2025.

The Wellbeing Economy: Redefining health Interest in physical and mental wellbeing is already huge and is set to grow considerably as new approaches to wellbeing are embedded at individual, organisational and community level. There will be multiple opportunities in this sector, particularly in high-income but also middle- and lower-income countries. The combined value of Wellbeing possibilities, including preventative health, self-improvement coaching, organisational and educational programmes, fitness, diet, health and beauty, travel and real estate, could reach USD 7 trillion within a few years.

The Net Zero Economy: Scalable low-carbon solutions Emerging markets and data processing are increasing demand for energy, while countries are setting targets to reduce carbon emissions in greater numbers. Innovation in technologies, investment models and markets can be expected from battery technologies, electric vehicles, energy-efficient buildings and hydrogen-powered fuel cells. Growing demand for renewable energy could yield over USD 2.3 trillion of possibilities by the mid-2020s.

The Circular Economy: Waste not, want not Growing public awareness of the need to reduce environmental impact will continue to open up new possibilities across value chains based on optimising the use of resources and reducing waste. The circular economy, recycling and upcycling will become more mainstream as new technological solutions become available. By some estimates, leveraging the Circular Economy could open market possibilities totalling up to USD 4.5 trillion.

The BioGrowth Economy: New agriculture and biomaterials Arguably the lowest-profile of the six transformational trends, the BioGrowth Economy is still set to open new market possibilities in some of the biggest global sectors. Rapid progress in biomaterials, plant science and synthetic biology will lead to breakthroughs in areas such as biodegradable materials, resilient crops, fuel refining from agricultural waste and animal protein substitutes. BioGrowth-related possibilities could be worth USD 1 trillion by 2025.

The Experience Economy: From ownership to usership

The desire to “experience”, rather than to consume, is trickling down from high-end markets to mass markets. Chatbots will increasingly enable service personalisation, and 3D printing will expand opportunities to customise products. “Experience tourism” accounts for a growing share of the global travel market, and virtual reality is becoming more sophisticated and affordable. Together these trends could build an Experience Economy worth up to USD 6.5 trillion by 2025.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан орнуудын хууль, эрх зүйн орчны тойм

Улс орнууд/ зарцуулсан хөрөнгө	Ковид-19-ийн үед эдийн засгийг сэргээх чиглэлээр баталсан хууль	Ковид-19-ийн дараах эдийн засгийг сэргээх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн тэргүүлэх чиглэлүүд
АНУ 2021 онд “Илүү сайнаар бүтээе” сайнаар бүтээе” хөтөлбөрт 1,844 тэрбум ам.д (ДНБ-ний 8.8%) баталсан.	2020 онд 4 удаагийн санхүүгийн багц тусламжийн тухай хуулийг баталсан. Үүнд: 1.Коронавирусын бэлэн байдал, хариу арга хэмжээ, нэмэлт хөрөнгө төсөвлөх тухай хууль 2020 (Coronavirus Preparedness and Response Supplemental Appropriations Act 2020) 2.Гэр бүлүүд тэргүүн ээлжинд - Коронавирусын эсрэг хариу арга хэмжээний тухай хууль (Families first Coronavirus Response Act 2020) 3.Коронавирусын эсрэг тусламж дэмжлэг, эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль (Coronavirus Aid, Relief, and Economic Security Act 2020 (CARES Act)) 4.Нэгдсэн төсөвт хөрөнгийн тухай хууль (Consolidated Appropriations Act 2020) зэрэг болно.	2021 онд “Илүү сайнаар бүтээе” гурван хэсэг хөтөлбөрийн хүрээнд дараах 3 дэд хөтөлбөрийг санаачилсан. 1.“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр” хуулийг боловсруулан баталж 1.9 их наяд ам.доллар зарцуулах; 2.Дэд бүтцийг сайжруулах, сая сая ажлын байр бий болгохоор төвлөсөн 2 их наяд ам.долларын төсөв шаардагдах “Америкийн ажлын байр хөтөлбөр” – үүнд Ногоон эдийн засаг: “2030 он хүртэл хүлэмжийн хийн бохирдлыг бууруулах зорилт” багтаж байна; 3.Дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилго бүхий иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд асрах үйлчилгээнд 1.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах “Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”.
2020 онд Нэгдсэн төсөвт хөрөнгийн тухай хуулиар 868 тэрбум ам.д (ДНБ-ний 4.1%) баталсан.		Эдийн засгийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд 4.8 их наяд юанийн ДНБ-ий 4.7 хувь) төсвийг зарцуулж голлон дараах арга хэмжээг авсан байна. Үүнд: ¹³⁹ 1) Тархалтаас урьдчилан сэргийлэх, хяналт тавихад зарцуулах зардлыг нэмэгдүүлэх; 2) Эмнэлтийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх; 3) Ажилгүйдлийн даатгалын нөхөн олговрыг түргэсгэх, цагаач ажилчдад олгох; 4) Татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх; 5) Төсвөөс нэмэлт хөрөнгө гаргах зэрэг арга хэмжээ авсан. Шаардлагатай үед автомагараар хэрэгжиж эхлэх ёстой тогтворжуулах хөтөлбөрүүд нь төсвийн зардлыг улам бүр нэмэгдүүлдэг. Төсвөөс бусад төрийн нийт дэмжлэг улмаар илүү их байх төлөвтэй байна. Жишээлбэл, төсвийн бус дэмжлэгт ЖДҮ эрхлэгчдэд 400 тэрбум юанийн (ДНБ-ий 0,4 хувь) нэмэлт зээлийн батлан даалт, зам, боомт.
БНХАУ 4.9 их наяд буюу ДНБ-ний 4.7 хувьтай тэнцэх санхүүгийн арга хэмжээг зарласан бөгөөд үүнээс 4.2 их наяд юанийг 2020 онд зарцуулсан. ¹³⁸		

¹³⁸ <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid-19/Policy-Responses-to-COVID-19#C>

¹³⁹ Цар тахлын үед дэлхийн улс орнуудын Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авсан арга хэмжээ Э.Эрдэнэчимэг 2020

<p>цахилгаан ашигласны төлбөр ба тарифын хөнгөлөлтийн 900 тэрбум юань (ДНБ-ний 0.9 хувь) багтана.</p>	<p>Ирланд Ирланд Улсад цар тахал 2020 оны 3 дугаар сард дэгдсэнээс хойш цар тахлын хариу арга хэмжээ авахтай холбоотойгоор нийт 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас дараах 11 хуульд эдийн засагтай холбоотой арга хэмжээг тусгасан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн тухай хууль (Онцгой байдлын үеийн хамгаалал) • Нийтийн эрх ашгийн хамгаалах арга хэмжээний тухай хууль • Бичил бизнесийн зээлийн сангийн тухай хууль • Санхүүгийн зохицуулалтын тухай хууль • Зээлийн батлан даалтын тухай хууль • Орон сууцны үнэлгээний тухай хууль • Санхүүгийн зохицуулалтын тухай хууль, дугаар 2 • Компанийн тухай хууль • Нийгмийн халамжийн тухай хууль • Санхүүгийн тухай хууль • Хөгжил төлөвлөлт, орон сууцны түрээсийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. 	<p>ОХУ -</p> <p>2020 онд цар тахал түүний сөрөг үр дагаврыг бууруулахад 2,8 их наяд рубль зарцуулсан. (төсвийн нийт зарлагын 12.5%)¹⁴⁰</p> <p>Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө өрхлөлт, хүн амын орлогыг сэргээх, эдийн засгийн өсөлт, эдийн засагт угацааны бүтцийн өөрчлөлтийг хангах үндэсний үйл ажиллагааны төгөө.</p> <p><u>Ерөнхийлөгчийн зарлиг</u>: ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2018.05.07-ны өдрийн 204 дугаар зарлигаар Эдийн засгийн өсөлтийг хурдастах шинэ саналуудыг гаргаж, ОХУ-ын Холбооны хурлаар 2020.01.15-ны өдөр баталсан. Үүнд хямралын дараах эдийн засгийг сэргээх зорилгоор Засгийн газраас дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанууд тусгагдсан байна. 2020.01.31-нээс 2021.06.29-ны хооронд авсан санхүүгийн арга хэмжээнүүдийн 2020 оны төсвийн багцын нийт өртөг нь ДНБ -ий 3.5</p>
---	---	--

¹⁴⁰ <https://ach.gov.ru/news/covid-i-ekonomika-sistema-zdravookhraneniya-i-mery-sotsipodderzhki-sp-na-forume-sotsialnykh-innovatsi>

<p>ХБНГУ</p> <p>2020-2021 онд нийт 346 тэрбум евро (ДНБ-ний 10.3%) нэмэлт төсөв баталсан. Шинээр байгуулагдсан Эдийн засгийн тогтворжуулалтын сан (WSF) болон Сэргээн босолтын банк (KfW)-аар дамжуулан 757 тэрбум евро буюу ДНБ-ний 24%-тай тэнцэх зээлийн батлан даалт гаргана.</p>	<p>Ковид-19 цар тахал дэгдсэнээс хойш цар тахлын хариу арга хэмжээ авахтай холбоотойгоор дараах хууль тогтоомжуудыг баталж, холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ковид-19 цар тахлын үр нөлөөг бууруулах тухай хууль (Covid-19 Mitigation Act); • Ковид-19 цар тахлын үед эмнэлгүүдэд үзүүлэх тусламжийн тухай хууль; • Улсын хэмжээнд тархсан цар тахлын үед ард иргэдийг хамгаалах тухай хууль (Drittes Gesetz zum Schutz der Bevölkerung bei einer epidemischen Lage von nationaler Tragweite) тус тус баталж, Нэмэлт, өөрчлөлт: • Халдварт өвчнөөс хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Төлбөрийн чадваргүй байдлын тухай хууль, Эмнэлгийн санхүүжилтийн тухай хууль, Эмийн тухай хууль, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тухай хууль, Нийлмийн хамгааллын тухай хууль, Эмнэлгийн төлбөрийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ. 	<p>орчим хувьтай тэнцсэн ба 2021 оны төгсгөл гэхэд энэ өртөг ДНБ-ний 1.5 орчим хувьтай тэнцэхээр байна. (2020 онд иргэд, бизнест дэмжлэг үзүүлэх, ажлын байр хадгалахад 2.5 их наяд рубль зарцуулсан¹⁴¹)</p> <ul style="list-style-type: none"> - 2020 оны 3-р сард 156 тэрбум евро (ДНБ-ний 4.7 хувь), - 2020 оны 6-р сард 130 тэрбум евро (ДНБ-ний 3.9 хувь), - 2021 оны 3-р сард 60 тэрбум евро (ДНБ-ний 1.7 хувь). <p>Европын Комисс Германы Эдийн засгийг сэргэх, тогтворжуулах төлөвлөгөөнд эерэг үнэлгээ өгч 25.6 тэрбум еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилт үзүүлсэн. Төлөвлөгөө нь эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах, боловсрол, сургалтыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зорилтуудыг дэвшүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөөний 42%-ийг уур амьсгалын зорилтыг дэмжсэн хөрөнгө оруулалт, шинэтгэл эзэлж байна. • Төлөвлөгөөний нийт хөрөнгө оруулалтын 52% нь дижитал шилжилттэй холбоотой зорилтын дэмжлэгүүд эзэлж байна. <p>Ковид-19-ийн “Тусгай” хууль хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тусгай төсвийг 150 тэрбум тайвань доллараар тэлж, нийт 210 тайвань доллар болсон байна (7.1 тэрбум ам.доллар). 2021.05.31-нд хуулийн хугацааг дахин 1 жил буюу 2022 оны 6-р сарын 30 хүртэл сунгаж, Ковид-19-ийн тусгай төсвийг Тайванийн зорилтод бүлгийн 7.3 сая (нийт хүн ам 23.8 сая) хүн амд хүргэх зорилгоор өргөжүүлсэн бөгөөд төсвийн нийт хэмжээг 840 тэрбум тайвань доллар (30.37 тэрбум ам.доллар) байхаар тооцжээ.</p>
<p>Тайвань</p> <p>840 тэрбум тайвань доллар (буюу ДНБ-ний 4.5%)</p>	<p>1.Халдварт өвчинтэй тэмцэх тухай хууль (CDC Act) болон түүнийг дагалдах журмууд;</p> <p>2.Ковид-19-ийн “Тусгай” хууль (Special Act on COVID-19 Prevention, Relief and Restoration)-ийг 2020.02.25-нд баталсан.</p>	<p>Ковид-19-ийн “Тусгай” хууль хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тусгай төсвийг 150 тэрбум тайвань доллараар тэлж, нийт 210 тайвань доллар болсон байна (7.1 тэрбум ам.доллар). 2021.05.31-нд хуулийн хугацааг дахин 1 жил буюу 2022 оны 6-р сарын 30 хүртэл сунгаж, Ковид-19-ийн тусгай төсвийг Тайванийн зорилтод бүлгийн 7.3 сая (нийт хүн ам 23.8 сая) хүн амд хүргэх зорилгоор өргөжүүлсэн бөгөөд төсвийн нийт хэмжээг 840 тэрбум тайвань доллар (30.37 тэрбум ам.доллар) байхаар тооцжээ.</p>

¹⁴¹ <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#R>

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ


БҮЛЭГ 1.ОНОЛ, АРГА ЗҮЙ

1.1.Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, сувгууд

Цар тахал юуны өмнө Засгийн газрын болон иргэдийн эрүүл мэндийн зардлыг өсгөнө. Түүнчлэн төрөөс цар тахалтай холбогдуулан хөл хорио тогтоож, иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийснээр тээвэр, худалдааны салбарын борлуулалтыг эхний ээлжинд бууруулах нөлөө үзүүлнэ. Борлуулалтын бууралт нь бусад салбарын бараа үйлчилгээний худалдан авалтыг багасгаж, улмаар иргэдийн цалин, орлого хумигдах, ядуурлын үзүүлэлтүүд нэмэгдэх шалтгаан болно.

Ийм үр дүн богино хугацаанд мэдрэгдэх бөгөөд бусад хүчин зүйлс тогтмол байхад цар тахлын сөрөг үр нөлөө хэвээр байсаар байвал, урт хугацаанд эдийн засгийн энгийн нөхөн үйлдвэрлэл багасч, дотоодын нийт бүтээгдэхүүн агшина. Энэ нь төсвийн орлого буурах, төсвийн орлого буурснаар төсвийн зардал багасах, эрүүл мэндийн зардлын өсөлтийн нөлөөгөөр төсвийн бусад санхүүжилт хумигдах, улмаар урт хугацаанд боловсрол, дэд бүтэц зэрэг нийгмийн үйлчилгээний зардлыг бууруулах нөлөөг үзүүлж болно. Доор үзүүлсэн зураг 1-ээс тайлбарыг харна уу.¹⁴²

Зураг 1. “Ковид-19”-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөлийн боломжит суваг




Эх сурвалж: <https://www.cgdev.org/blog/economic-impact-covid-19-low-and-middle-income-countries>

¹⁴² <https://documents1.worldbank.org/curated/en/295991586526445673/pdf/The-Potential-Impact-of-COVID-19-on-GDP-and-Trade-A-Preliminary-Assessment.pdf>

Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг цогц байдлаар доорх зурагт харуулав.¹⁴³

Зураг 2. Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл



Эх сурвалж: <https://onlinelibrary.wiley.com/doi/full/10.1002/pa.2430>

“Ковид-19” буюу цар тахал нь эдийн засагт эрэлтийн, нийлүүлэлтийн, санхүүгийн зах зээлийн, гадаад хүчин зүйлсийн гэсэн 4 сувгаар дамжин нөлөөлж байна.

ЭРЭЛТИЙН СУВАГ

Аялал жуулчлал, зочлохуйн үйлчилгээ, агаарын болон бусад тээврийн үйлчилгээний эрэлт буурах бөгөөд эсрэгээрээ эрүүл мэндийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өснө. Нөгөө талаас иргэдийн хүнсний, ялангуяа уураглаг хүнсний бүтээгдэхүүний эрэлт өсөн нэмэгдэнэ. Энэ нь худалдан авагч өөр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ худалдаж авах эрэлт буюу зардлын төсвийг багасгах нөлөө үзүүлнэ.

Зарим тохиолдолд улс хооронд шилжих хөдөлгөөн ч хийгдэж болзошгүй. Энэ нь тухайн улсын бараа, үйлчилгээний нийт эрэлтийг багасгадаг. Түүнчлэн цар тахалтай холбоотойгоор гадаад орнуудын дотоодын бараа үйлчилгээний худалдан авалт буурснаар экспортын орлого багасгах нөлөөлөл бий болно.

НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУВАГ

Нийлүүлэлтийг үйлдвэрлэл бус борлуулалт талаас нь харж болно. Эрэлтийн бууралт нь цаг хугацааны нөлөөгөөр дамжиж борлуулалт, үйлдвэрлэлийг багасгах нөлөө үзүүлнэ. Энэ нь ялангуяа аялал жуулчлал, зочлохуйн үйлчилгээ, агаарын болон бусад тээврийн үйлчилгээ, худалдааны салбарт шууд мэдэгдэнэ. Эрэлт буурснаас шалтгаалж орлого нь хумигдсан салбаруудын зардал багасгах бөгөөд тоо хэмжээний бууралт, тогтмол зардлын нөлөөгөөр ашгийн хэмжээ нь багасна. Зардал багасгах нь бусад салбарын борлуулалт буурах шалтгаан болж, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд доголдол гарах үйл явц

¹⁴³ <https://www.cgdev.org/blog/economic-impact-covid-19-low-and-middle-income-countries>

ажиглагдах бол ашгийн бууралт нь эдийн засаг дахь хуримтлалыг багасгах нөлөө үзүүлнэ. Орлогын бууралт өрсөлдөх чадвар харьцангуй бага байдаг онцлогтой жижиг дунд бизнесүүдэд илүү мэдрэгдэх боломжтой юм. Гэтэл аливаа улс оронд хөдөлмөрийн нөөцийн дийлэнх хэсгийг жижиг дунд бизнесүүд шингээж байдаг.

Шууд болон шууд бус хэлбэрээр орлого, ашиг нь багассан эдийн засгийн бодит салбарын бизнесүүдийн хувьд ажилчдаа цомхотгох шаардлагыг ч бий болгож болзошгүй. Орлого, ашгийн энэхүү бууралт санхүүгийн зах зээлд төвлөрүүлэх мөнгөн хуримтлалыг багасгаж, улмаар бизнесүүдийн бодит хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг бууруулах, банк, санхүүгийн байгууллагуудыг цөөн тооны томоохон харилцагчтай буюу эмзэг байдалтай болох нөхцөл рүү түлхэж болно.

Цар тахлын үед төрөөс түлхүү анхаарвал зохих салбар бол хүнсний салбар юм. Хөл хорио, агаарын болон далайн, хуурай газрын тээврийн хязгаарлалтаас шалтгаалж хүн амын хүнсний үндсэн хэрэгцээг хангаж байдаг мал, аж ахуй, газар тариалангийн салбарын нийлүүлэлт тасалдах үйл явц бий болно. Нөгөө талаас хүнс, хөдөө аж ахуйн салбар нь улирлын нөлөөлөл харьцангуй өндөртэй, ажилчдыг түр зуурын ажлын байраар хангадаг онцлогтой. Иргэдийн шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь хүний нөөц хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн доголдол, тасалдлыг бий болгоно. Түүнчлэн ажиллах хүчний эрүүл мэндийн байдал, халдвар авсан тохиолдол зэрэг нь энэ сөрөг нөхцөл байдлыг хөхиүлэн дэмжинэ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний түүхий эдэд түшиглэн үйлдвэрлэл эрхэлдэг хүнсний бусад салбарын үйлдвэрүүдийн орлогод ч дээрх байдал нийлүүлэлтийн тасалдал гинжин хэлхээ хэлбэрээр сөргөөр нөлөөлнө. Ерөнхийдөө нийлүүлэлтийн суваг нь эдийн засгийн нийт мөнгөн орлого, төсөвт төвлөрүүлэх татварыг бууруулах бөгөөд төсвийн орлого багассанаар Засгийн газрын хэрэглээ болон хөрөнгө оруулалт агшихад хүрнэ.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУВАГ

Санхүүгийн зах зээлийн суваг нь хүү, ханш, хөрөнгийн үнэ, зээлийн гэсэн сувгуудтай. Эдгээрийг мөнгөний бодлоготой холбож товч авч үзье.

Хүүний суваг: Мөнгөний хатуу бодлого явуулж, зээлийн хүү өсөхөд хөрөнгө оруулалтын зардал, эрэлт буурна. Улмаар үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ багасна.

Ханшийн суваг: Мөнгөний бодлого чангарахад дотоод валютаар илэрхийлэх бодит зээлийн хүү өснө. Дотоод валютын ханш чангарна. Дотоодод үйлдвэрлэгдсэн барааны үнэ гадаад зах зээлд үнэтэй болж экспорт буурч, импорт нэмэгдэнэ. Нийт эрэлт багасна. Үйлдвэрлэл буурна.

Хөрөнгийн үнийн суваг:

- Тобины Q

Мөнгөний хатуу бодлогын үед үнэт цаас худалдаж авах эрэлт буурна. Энэ нь хувьцаат компаниудын үнэ цэнийг багасгана. Шинэ хувьцааны худалдан авалт саарна. Эдийн засагт нийлүүлэх боломжтой байсан бүтээгдэхүүн, үйлчилгээ тасалдаж, алдагдсан боломжийн зардал нэмэгдэнэ.

- Баялгийн нөлөө: Мөнгөний хатуу бодлогын үед үнэт цаасны үнэ буурна. Энэ нь хөрөнгө оруулагчдын орлогын эх үүсвэрийг бууруулна. Хэрэглээ багасна. Энэ нь бизнесүүдийн борлуулалтыг багасгах нөлөө үзүүлнэ. Эдийн засгийн өсөлт харьцангуй буурах нөлөөлөл бий болно.

Зээлийн суваг:

- Банкны зээлийн суваг: Мөнгөний хатуу бодлого нь зээлийн хүүг өсгөнө. Бизнесүүдийн зээлжих боломжийг багасгана. Хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтөд сааралт гарна
- Балансын суваг: Мөнгөний бодлого чангарахад хүү өсөх бөгөөд бизнесүүдийн зээлийн эргэн төлөлт муудна. Энэ нь зээлийн нийт нийлүүлэлтийг сааруулна. Эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөлөл бий болно.

ГАДААД СУВАГ

Гадаад суваг нь экспорт, импорт, санхүүгийн хөрөнгийн орох гарах урсгал, валютын ханшаар дамжин эдийн засагт нөлөөлнө. Экспорт буурахад дотоод валютын ханш сулрах, гадаад валютын ханш өсөх нөлөөлөл бий болно. Энэ үед импортын бараа үйлчилгээ манай улсын хувьд өмнөхөөсөө үнэтэй болох, худалдан авагчдын хэрэглээний зардал өсөх, иргэд, аж ахуйн нэгжүүдийн хуримтлал буурах сөрөг нөлөөлөл гардаг.

Иймд манай улс “Ковид-19” цар тахлын үед экспортыг тогтвортой түвшинд хадгалах, нэмэгдүүлэх, нэр төрлийг нь олшруулах, гадаад валютыг хүрэлцэхүйц түвшинд нөөцлөх, дотоодын үйлдвэрлэл, ялангуяа хүнсний салбарын болон жижиг дунд бизнесийг дэмжих, нөөцийн болон дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, иргэдийн ажил эрхлэлтийн найдвартай байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, зээлдэгчдийн төлбөрийн чадвартай байдалд дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглэгдсэн татвар, төсөв, мөнгөний бодлогыг явуулах, гадаадын зээл тусламжийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх учиртай юм.

Дээр дурдсан онол, арга зүйг чиг баримжаа болгон Монгол Улс болон дэлхийн бусад улс орнууд Ковид-19 цар тахалтай холбогдуулан эдийн засгийг сэргээх ямар хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа болохыг тогтоох, хууль эрх зүйн болон бодлого арга хэмжээний хувьд харьцуулсан дүгнэлт гаргахын тулд дараах үзүүлэлтүүдийг харгалзаж үзэх нь зүйтэй гэж үзлээ. Эдгээр нь:

- Дэд бүтэц, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжих;
- Татварын дэмжлэг үзүүлэх;
- Зээлийн хөнгөлөлт, хойшлуулалт, хүртээмжийг өсгөх;
- Экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх;
- Төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлийг хөнгөвчлөх;
- Засгийн газрын хөрөнгө оруулалтын зорилтот арга хэмжээ юу юу байгааг тодорхойлох;
- Төсвийн алдагдлыг бууруулах;
- Иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх;
- Банк, санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хангах;
- Ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүд болно.

Дээрх арга хэмжээнүүд нь татвар, зээлийн бодлого, төрийн үйлчилгээний энгийн бөгөөд хүртээмжтэй байдал, засгийн газрын хөрөнгө оруулалт зэрэг төрийн эдийн засгийн бодлогын арга хэрэгсэл, дэд бүтэц, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, экспортыг төрөлжүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах, иргэдийн орлогыг дэмжих, ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэх зэрэг төрийн эдийн засгийн зорилтот арга хэмжээ гэсэн хоёр чиглэлд хуваагдаж байгаагаараа иж бүрдлийн хувьд бүрэн болж байгаа юм. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй болохыг эдийн засгийн нийт эрэлт, нийт нийлүүлэлтээр илэрхийлдэг ДНБ-ний тэнцвэрийн Кейнсийн загварыг ашиглан товч тайлбарлая.

$$\begin{aligned} \text{Aggregate expenditure} &= C + I + G + (X - M) = C + S(p) + S(g) + Tax \\ &= \text{Aggregate supply} \end{aligned}$$

Үүнд:

<i>C</i>	Өрхийн эцсийн хэрэглээ
<i>I</i>	Хувийн хөрөнгө оруулалт
<i>G</i>	Засгийн газрын зардал
<i>X</i>	Экспорт
<i>I</i>	Импорт
<i>S</i>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<i>Tax</i>	Татвар
<i>GDP</i>	ДНБ

Татвар, мөнгөний бодлого нь эрэлт, нийлүүлэлтийн зохистой тэнцвэрээр дамжуулан инфляц, валютын ханшны тогтвортой түвшнийг бүрдүүлэн орлого хуваарилалтын жигд бус байдлыг багасгах, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгддэг. Дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл нь эдийн засгийн өсөлттэй холбоотой. Экспорт нэмэгдвэл ДНБ өснө. Импортын хэмжээ мөн нэмэгдэх боломжтой. Эдийн засаг өсөлттэй байвал төсвийн зарлагыг санхүүжүүлдэг татварын орлого өндөр байна. $Tax = GDP * tax\ rate$

Татварын орлого өндөр байвал төсвийн алдагдал бага, төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардал нэмэгдэх боломж бүрдэнэ. Иргэдийн орлогыг ажлын байрыг нэмэгдүүлж чадах үйлдвэрлэлийн салбаруудыг дэмжин хөгжүүлснээр өсгөх боломжтой бөгөөд энэ нь ДНБ-ний хэмжээ өндөр буюу өсөлттэй, ЖДҮ-үүд хөгжсөн тохиолдолд биелнэ. Түүнчлэн цар тахал болон эдийн засгийн хямралын үед төсвийн урсгал зардлаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээ авах аргууд дэлхийн улс орнуудад байдаг.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг чухалд үзэх хандлага улам бүр нэмэгдэж байна. Ялангуяа төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, цахим болгож хялбаршуулах, боловсролын салбарт цахим сургалтыг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй, хямд төсөр зардалтай дэд бүтэц, эрчим хүч, техник, технологийг хөгжүүлэхийг чухалчилж байгаа нь улс орнуудын цар тахлын үеийн эдийн засгийг сэргээхэд хувь нэмрээ оруулах нь дамжиггүй юм.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. “Ковид-19” цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, эрх зүйн орчны тойм

“Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах асуудлаар Монгол Улсын Их Хурлаас 1 хууль, 5 тогтоол гараад байна. Засгийн газраас 53 тогтоол, Улсын Онцгой Комиссоос 12 тогтоол, 50 тушаал, 5 албан даалгавар тус тус гарчээ.

2.1.1. Эрх зүйн орчны тойм

Төрөөс 2020 оны 1-р сарын 1-нээс 2021 оны 9-р сарын 8 хүртэлх хугацаанд гаргасан эрх зүйн бичиг баримтуудын тоймыг хүснэгтэд харуулав.

Эрх зүйн акт		Тоо
Улсын Их Хурал		
1	Хууль	1
2	Тогтоол	5
Засгийн газар		
1	Тогтоол	54
2	Засгийн газрын агентлаг, зөвлөл, хорооны тушаал, шийдвэр	4
Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрүүд		
1	Тогтоол	12
2	Албан даалгавар	5
3	Бусад шийдвэр	50
Мэргэжлийн байгууллагуудаас гаргасан шийдвэрүүд (Тушаал, түр журам, заавар, харьяа байгууллагын зөвлөмж, албан даалгавар, зааварчилгаа)		
1	ЭМЯ	49
2	Боловсрол, шинжлэх ухааны яам	11
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	16
4	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдэрийн яам	1
5	Зам, тээврийн хөгжлийн яам, Цагдаагийн Ерөнхий газар	2

Эх сурвалж: Коронавирусийн халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл лавлагаа, УИХ-ын ТГ-ын Парламентын судалгааны хүрээлэн, 2020

Түүнчлэн “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-өөс 1 зөвлөмж, Ерөнхийлөгчөөс 1 зарлиг, 1 уриалга тус тус гарсан байна.

2.1.2. Эдийн засгийг сэргээхтэй холбоотой онцлох гол зохицуулалтууд

Хууль: Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсад анхны коронавируст халдвар илэрсэний дараахан 2020 оны 4 дүгээр сард “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” гарган мөрдөж, дотоодод коронавируст халдвар эрчимтэй нэмэгдсэний дараахан 2020 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хууль нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

УИХ-ын тогтоол: УИХ-аас 5 удаагийн тогтоол гаргаж УИХ-ын чуулганы хэвийн ажиллах нөхцөл боломж, цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай багц арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна. Түүнчлэн “Ковид-19” цар тахлын эсрэг хуулийн биелэлтийг хангах, хяналт тавих зорилготой түр хороог байгуулсан.

УИХ-ын 2020 оны 21 болон 32-р тогтоолуудад иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх, малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах арга хэмжээнүүдийн чиглэлийг тусгасан.

Түр хорооны үйл ажиллагаа: Улсын Их Хуралд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулсан. Түр хороо байгуулагдсан цагаас хойш 2020.11.03, 2021.03.31-нд 2 удаа хуралдаж Засгийн газар, УОК, холбогдох яам зэрэг байгууллагуудаас мэдээлэл сонсож, асуулга асууж, Засгийн газар болон УОК-т чиглэл өгсөн.

2.1.3. Төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээ

2020 онд төрөөс дараах 4 төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.¹⁴⁴

1) Монгол Улсын Засгийн газрын “КОВИД-19” цар тахлыг тогтоон барихтай холбоотой арга хэмжээ

- ✓ Хил хаах хил дамнансан зорчигч тээврийн бүх хэлбэрийг 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зогсоов.
- ✓ Монгол-Хятадын хилээр нэвтэрч буй ачааны машины жолооч нарын халдвар авах эрсдэлийг бууруулах зорилготой экспортыг зогсоох;
- ✓ Боловсролын үйл ажиллагааг зогсоох;
- ✓ Үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээг хязгаарлах;
- ✓ 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр анхны дотоод тохиолдол бүртгэгдсэнээр хатуу хөл хорионы дэглэмд шилжих;
- ✓ Хөл хорионы дэглэмийг Улаанбаатар хотод түр сулруулсны дараа 12 дугаар сарын 14-ний өдрөөс дахин чангаруулах.

2) Монголбанкнаас “КОВИД-19” цар тахлын нөлөөг зөөлрүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- 2020 оны 3, 4, 9, 11 дүгээр сарын хурлаас бодлогын хүүг 11 хувиас 6 хувь хүртэл тууштай бууруулав.
- Банкуудын нөөц хөрөнгийг дэмжих үүднээс репо санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэв.
- Банкны системийн нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх үүднээс 2020 оны 3 дугаар сард төгрөгийн эх үүсвэрийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 4.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэв.
- Валютын хадгаламжийн хүүг бууруулах, банкны эх үүсвэрийн долларжилтыг багасгах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэр гаргав.
- Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийв.
- Актив худалдан авах, хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авав.
- 2020 оны 3 дугаар сараас эхлэн Активын ангиллын журамд өөрчлөлт оруулж зээлдэгчид зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээхээр болов.
- Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 25 хувь байсныг 20 хувь болгов.
- Банкууд гүйлгээний шимтгэлээ бууруулахыг дэмжих, долларын хадгаламжийг даатгалаас гаргаж хадгаламжийн долларжилтыг бууруулах арга хэмжээ авав.

¹⁴⁴ [Mongolia-Economic-Update-From-Relief-to-Recovery \(1\).pdf](#)

- Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлж 6 сараар (дараа нь дахиад 8 сараар) хойшлуулахыг зөвшөөрөв.
- Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрийг үргэлжлүүлэн олгохоор болов.

3) Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээ

2020 онд Ковид цар тахлын нөлөөг сааруулахад чиглэсэн төсвийн арга хэмжээ нь татвар, хураамжийн хөнгөлөлт, нэмэлт зардлууд гэсэн үндсэн хоёр төрлийн зориулалттай байсан байна.

Хүснэгт 3. Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээний хураангуй

Татвар, хураамжийн хөнгөлөлтийн хүрээнд (ДНБ-ний 3 хувь)	Нэмэлт зардлууд (ДНБ-ний 6 орчим хувь)
<ul style="list-style-type: none"> ▪ НДШ-ийн хөнгөлөлт ▪ ХХОАТ-ын хөнгөлөлт ▪ ААНОАТ ▪ Түрээсээ бууруулсан түрээслэгчдийн татварын хөнгөлөлт ▪ ААНОАТ, НДШ хоцорч төлсний алданги хөнгөлөх ▪ НӨАТ-ын хөнгөлөлт (эрүүл мэнд, хүнсний барааны импорт) 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүүхдийн мөнгө ▪ Эрүүл мэндийн зардал ▪ Малчдад олгох тусламж ▪ Халамжийн тэтгэвэр ▪ Ажлын байрыг хадгалахад ▪ ЗГ-ын онцгой байдлын сан ▪ Ноолуурын салбарын дэмжлэг ▪ Хүнсний талоныг 2 дахин нэмэх

Эх сурвалж: Монгол Улсын эдийн засгийн тойм “Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд”, дэлхийн банкны тайлан, 2021 оны 2-р сар

1) “КОВИД-19” цар тахлын нөлөөг бууруулах чиглэлд Засгийн газраас авсан арга хэмжээ (нийгмийн хамгааллын чиглэлд)

Зураг 3. ЗГ-аас Цар тахлын нөлөөг бууруулах чиглэлээр нийгмийн хамгааллын чиглэлд авсан арга хэмжээ

Хөтөлбөрийн нэр	Шардлага	Үндсэн дүн (сард, төг)	Нэмэгдүүлсэн дүн (төг)	Хүчинтэй хугацаа	Хамрагдсан иргэдийн тоо
1 “Хүүхдийн мөнгө” хөтөлбөр (ХМХ)	0-18 насны хүүхэд	20,000	100,000	2020.04.01-2021.07.01	1,144,630
2 Халамжийн тэтгэмж (дараах бүлгийн иргэдэд олгоно):	(1) НД-с тэтгэвэр авдаггүй ахмад настан, Эм55+/Эр60+	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	3,140
	(2) 16 насанд хүрсэн одой иргэн	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	106
	(3) 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	36,486
	(4) 18 нас хүрээгүй бүтэн өнчин хүүхэд	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	14,219
	(5) 4 болон түүнээс олон 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	12
3 Байнгын асаргаа шардлагатай 16 хүртэлх насны хүүхэд	Байнгын асаргаа шардлагатай 16 хүртэлх насны хүүхэд	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	10,243
4 Хүнсний талон хөтөлбөр	(1) Ядуу өрхийн гишүүн том хүн	16,000	32,000	2020.05.01-	118,748
	(2) Ядуу өрхийн гишүүн хүүхэд	8,000	16,000	2020.05.01-2020.11.01	123,189

Эх сурвалж: Монгол Улсын эдийн засгийн тойм “Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд”, дэлхийн банкны тайлан, 2021 оны 2-р сар

Түүнчлэн 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 42 дугаар тогтоол гарч “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөг баталсан байна. Эдийн засгаа сэргээх зорилгын хүрээнд дараах дэмжлэгүүдийг үзүүлэхээр төлөвлөжээ.¹⁴⁵

- ✓ Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 3.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгох
- ✓ Иргэдийг орон сууцжуулах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлээр хэрэгжүүлж, төрөөс газар, дэд бүтэц, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн нэмэгдүүлж, барилгын салбар, түүний дагалдах салбарыг идэвхжүүлэхэд чиглүүлэх талаар Төв банктай хамтран ажиллах
- ✓ Мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн Монголбанкны олгож байгаа репо санхүүжилтийн нийт эх үүсвэр, нэг зээлдэгчид олгох хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Төвбанктай хамтран ажиллах
- ✓ Хөдөө аж ахуйн салбарт хаврын тариалалт, ноолуур, ноос, арьс шир бэлтгэл болон малчдын үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийг Хөгжлийн банк, арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх
- ✓ Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх
- ✓ “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлж, аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй малгүй болон цөөн малтай иргэн, гэрээт малчин өрхийг малжуулахад санхүүгийн зохих дэмжлэг үзүүлэх
- ✓ Өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй даван туулахад зориулж малчин өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох
- ✓ Зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгож ажиллах
- ✓ Тэргүүлэх чиглэлийн 100 төсөл, арга хэмжээг Засгийн газрын 100 хоногт багтаан зарлан хэрэгжүүлэх
- ✓ Хилийн ачаа тээврийн боомтын үйл ажиллагааг сэргээж, хүчин чадлыг нэмэгдүүлэн экспорт, импортын үйл ажиллагааг ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэм дор зохион байгуулж гадаад худалдааны бараа эргэлтийг нэмэгдүүлэх
- ✓ Улаанбаатар хот руу гаалийн хяналтад илгээх нөхцөлийг бүрдүүлэх, Замын-Үүд-Эрээн, Эрээнцав-Соловьевск төмөр замын боомтоор гарах экспортын бараа эргэлтийг нэмэгдүүлэх
- ✓ Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлж, Оросын талтай “Ногоон гарц” түр журмыг тохиролцон хэрэгжүүлж эхлэн улс хоорондын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх
- ✓ Алтны олборлолтыг дэмжиж, алт тушаалтыг нэмэгдүүлэх
- ✓ Хүнсний үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон газар тариалангийн үйлдвэрлэлд нэн хэрэгцээт үр,

¹⁴⁵ <https://www.legalinfo.mn/annex/details/11611?lawid=16094>

- бордоо, ургамал хамгааллын бодис, тоног төхөөрөмж, ургацын дотоодын болон улс хоорондын тээвэрлэлтийг халдвар, хамгааллын дэглэм дор зохион байгуулах
- ✓ Барилгын материал, түүхий эд, газар тариалангийн тоног төхөөрөмжийн улс хоорондын тээвэр зохицуулалтыг халдвар хамгааллын дэглэм дор шуурхай зохион байгуулах
 - ✓ Дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг төрийн худалдан авалтаар дэмжих
 - ✓ Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн санхүүгийн байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний үнийг үе шаттай бууруулах
 - ✓ Цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцах ажлын зохион байгуулалтыг сайжруулж, хэрэгжүүлэх
 - ✓ Халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгож буй амьжиргаа дэмжих тэтгэмж болон хүүхдийн мөнгөн тэтгэмжүүдийг нэмэгдүүлэн олгох шийдвэрийг хэрэгжүүлэх
 - ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй, гэртээ хүүхэд асарч буй иргэн, хөдөлмөрийн насны халамж хүртэгчид өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах
 - ✓ Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хуулийг хэрэгжүүлэх
 - ✓ Хот хоорондын нийтийн зорчигч тээвэр болон агаарын зорчигч тээврийн хуваарьт нислэгийн үйлчилгээг эхлүүлэх
 - ✓ Иргэдийг дархлаажуулалтад хамруулсны дараа улс хоорондын төмөр зам, агаарын тээвэр, автотээврийн зорчигч тээвэрлэлтийг үе шаттайгаар нээх ажлыг зохион байгуулах
 - ✓ Гол нэрийн хүнс, түлш, шатахуун, малын тэжээл, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн үнийн зохиомол өсөлтөөс сэргийлэх
 - ✓ Тариалалт, уринш боловсруулалт, арчилгаа, ургац хураалтын үйл ажиллагааг технологит хугацаанд нь гүйцэтгэх
 - ✓ Эрчим хүчний салбарын нарийн мэргэжлийн ажилтны хүний нөөцийг бүрдүүлэх
 - ✓ Иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаад улсын хандив, хүмүүнлэгийн тусламжийг ил тод, хүртээмжтэй байдлаар зорилтот бүлэгт хүргэх ажлыг зохион байгуулах
 - ✓ Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийн шилдэг санаа, инновацийн бүтээгдэхүүнийг дэмжиж соёл, урлагийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, уран бүтээлчдийг дэмжих
 - ✓ Шинжлэх ухаан, инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, шинэ санаа, санаачилгыг дэмжин нийгмийн үйлчилгээнд нэвтрүүлж, бүх талын хамтын ажиллагааг дэмжих

Төлөвлөгөө зарлагдсанаас хойш буюу 8-р сарын 27-ны өдрийн байдлаар 18,000 иргэн, 5000 гаруй аж ахуйн нэгжид 1,823.6 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Тухайн зээлүүдийн ард 125 мянган ажлын байр хамгаалагдсан байна. Ажлын байр дэмжих зээлд төсөвлөсөн хоёр их наяд төгрөгийн санхүүжилт дуусч байгаа ч зээлийн эрэлт их байгаа учраас гурван хувийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлж үргэлжлүүлэн олгох шийдвэрийг гаргаад байна.

Нийт дүнгээр нь авч үзвэл, Монгол Улсын хувьд 2020 оны 4-р сараас 2021 оны 6 дугаар сарын хооронд 3.27 их наяд төгрөгийн төсвийн нэмэлт зарлага, 1.9 их наяд төгрөгийн төсөвлөсөн орлогын хөнгөлөлт, чөлөөлөлт, 649 тэрбум төгрөгийн төсвийн гадуурх

санхүүжилт зэрэгт 5.1 их наяд төгрөгийг “КОВИД-19” цар тахлыг ковидын сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулаад байна. Төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг ангилан өмнөх бүлэгт тайлбарласан онолын хүрээнд системтэйгээр ангилан авч үзье.

▪ **Дэд бүтэц, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжих**

- ✓ Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 3.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгох
- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох
- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй, гэртээ хүүхэд асарч буй иргэн, хөдөлмөрийн насны халамж хүртэгчид өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх
- ✓ “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлж, аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх

▪ **Татварын дэмжлэг үзүүлэх**

- ✓ НДШ-ийн хөнгөлөлт
- ✓ ХХОАТ-ын хөнгөлөлт
- ✓ ААНОАТ
- ✓ Түрээсээ бууруулсан түрээслэгчдийн татварын хөнгөлөлт
- ✓ ААНОАТ, НДШ хоцорч төлсний алданги хөнгөлөх
- ✓ НӨАТ-ын хөнгөлөлт (эрүүл мэнд, хүнсний барааны импорт)
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хуулийг хэрэгжүүлэх

▪ **Зээлийн хөнгөлөлт, хойшлуулалт, хүртээмжийг өсгөх**

- ✓ 2020 оны 3 дугаар сараас эхлэн активын ангиллын журамд өөрчлөлт оруулж зээлдэгчид зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээхээр болов.
- ✓ Банкууд гүйлгээний шимтгэлээ бууруулахыг дэмжих, долларын хадгаламжийг даатгалаас гаргаж хадгаламжийн долларжилтыг бууруулах арга хэмжээ авав.
- ✓ Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлж 6 сараар (дараа нь дахиад 8 сараар) хойшлуулахыг зөвшөөрөв
- ✓ Банкны системийн нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх үүднээс 2020 оны 3 дугаар сард төгрөгийн эх үүсвэрийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 4.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэв.
- ✓ Мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн Монголбанкны олгож байгаа репо санхүүжилтийн нийт эх үүсвэр, нэг зээлдэгчид олгох хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Төвбангтай хамтран ажиллах

▪ **Экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх**

- ✓ Улаанбаатар хот руу гаалийн хяналтад илгээх нөхцөлийг бүрдүүлэх, Замын-Үүд-Эрээн, Эрэнцав-Соловьевск төмөр замын боомтоор гарах экспортын бараа эргэлтийг нэмэгдүүлэх
- ✓ Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлж, Оросын талтай “Ногоон гарц” түр журмыг тохиролцон хэрэгжүүлж эхлэн улс хоорондын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх

- ✓ Хилийн ачаа тээврийн боомтын үйл ажиллагааг сэргээж, хүчин чадлыг нэмэгдүүлэн экспорт, импортын үйл ажиллагааг ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэм дор зохион байгуулж гадаад худалдааны бараа эргэлтийг нэмэгдүүлэх
- *Төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлийг хөнгөвчлөх*
- **Засгийн газрын хөрөнгө оруулалтын зорилтот арга хэмжээ**
 - ✓ Тэргүүлэх чиглэлийн 100 төсөл, арга хэмжээг Засгийн газрын 100 хоногт багтаан зарлан хэрэгжүүлэх
 - ✓ Зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгож ажиллах
- *Төсвийн алдагдлыг бууруулах*
- **Иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх**
 - ✓ Хүүхдийн мөнгө
 - ✓ Эрүүл мэндийн зардал
 - ✓ Малчдад олгох тусламж
 - ✓ Халамжийн тэтгэвэр
 - ✓ Ажлын байрыг хадгалахад
 - ✓ ЗГ-ын онцгой байдлын сан
 - ✓ Ноолуурын салбарын дэмжлэг
 - ✓ Хүнсний талоныг 2 дахин нэмэх
 - ✓ Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх
 - ✓ Цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хог хаягдлын төлбөр хураамжийг төрөөс хариуцах ажлын зохион байгуулалтыг сайжруулж, хэрэгжүүлэх
 - ✓ Халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгож буй амьжиргаа дэмжих тэтгэмж болон хүүхдийн мөнгөн тэтгэмжүүдийг нэмэгдүүлэн олгох шийдвэрийг хэрэгжүүлэх
 - ✓ Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн санхүүгийн байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний үнийг үе шаттай бууруулах
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах
 - ✓ Гол нэрийн хүнс, түлш, шатахуун, малын тэжээл, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн үнийн зохиомол өсөлтөөс сэргийлэх
 - ✓ Эрчим хүчний салбарын нарийн мэргэжлийн ажилтны хүний нөөцийг бүрдүүлэх
 - ✓ Малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй малгүй болон цөөн малтай иргэн, гэрээт малчин өрхийг малжуулахад санхүүгийн зохих дэмжлэг үзүүлэх

- **Банк, санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хангах**
 - ✓ Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж актив худалдан авах, хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авав.
 - ✓ Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 25 хувь байсныг 20 хувь болгов.
 - ✓ Банкуудын нөөц хөрөнгийг дэмжих үүднээс репо санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэв.
- **Ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэх зэрэг арга хэмжээ**
 - ✓ Дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг төрийн худалдан авалтаар дэмжих

Тодорхой салбарын үйл ажиллагааг дэмжих

- ✓ Иргэдийг дархлаажуулалтад хамруулсны дараа улс хоорондын төмөр зам, агаарын тээвэр, автотээврийн зорчигч тээвэрлэлтийг үе шаттайгаар нээх ажлыг зохион байгуулах
- ✓ Гол нэрийн хүнс, түлш, шатахуун, малын тэжээл, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн үнийн зохиомол өсөлтөөс сэргийлэх
- ✓ Тариалалт, уринш боловсруулалт, арчилгаа, ургац хураалтын үйл ажиллагааг технологит хугацаанд нь гүйцэтгэх
- ✓ Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийн шилдэг санаа, инновацийн бүтээгдэхүүнийг дэмжиж соёл, урлагийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, уран бүтээлчдийг дэмжих
- ✓ Шинжлэх ухаан, инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, шинэ санаа, санаачилгыг дэмжин нийгмийн үйлчилгээнд нэвтрүүлж, бүх талын хамтын ажиллагааг дэмжих
- ✓ Алтны олборлолтыг дэмжиж, алт тушаалтыг нэмэгдүүлэх
- ✓ Хүнсний үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон газар тариалангийн үйлдвэрлэлд нэн хэрэгцээт үр бордоо, ургамал хамгааллын бодис, тоног төхөөрөмж, ургацын дотоодын болон улс хоорондын тээвэрлэлтийг халдвар, хамгааллын дэглэм дор зохион байгуулах
- ✓ Хөдөө аж ахуйн салбарт хаврын тариалалт, ноолуур, ноос, арьс шир бэлтгэл болон малчдын үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийг Хөгжлийн банк, арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх
- ✓ Барилгын материал, түүхий эд, газар тариалангийн тоног төхөөрөмжийн улс хоорондын тээвэр зохицуулалтыг халдвар хамгааллын дэглэм дор шуурхай зохион байгуулах
- ✓ Иргэдийг орон сууцжуулах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлээр хэрэгжүүлж, төрөөс газар, дэд бүтэц, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн нэмэгдүүлж, барилгын салбар, түүний дагалдах салбарыг идэвхжүүлэхэд чиглүүлэх талаар Төв банктай хамтран ажиллах

2.2. Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал

2.2.1.2020 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүд /2019 онтой харьцуулсан байдлаар/

Цар тахал Манай Улсын эдийн засагт дараах 4 үндсэн сувгаар нөлөө үзүүлж байна.¹⁴⁶

- a) Халдварыг тогтоон барих Засгийн газрын арга хэмжээ нь жижиг бизнес болон өрхийн орлогод шууд сөргөөр нөлөөлж нэгэнт суларч байсан эдийн засгийн дотоод идэвхжлийг сааруулах
- b) Эдийн засгийн нийт үйлдвэрлэлд уул уурхайн салбар давамгайлсан орны хувьд халдвараас шалтгаалан гадаад хил хаагдаж, түүхий эдийн үнэ унахад эдийн засагт гарах сөрөг нөлөөлөл
- c) Цар тахлыг хязгаарлах арга хэмжээ нь худалдаа, үйлчилгээний сектор (аялал жуулчлал, тээвэр ороод)-т үзүүлэх сөрөг нөлөө
- d) Төсвийн орлого тасалдаж эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зардал өсөн нэмэгдсэн нь төсвийн дарамтыг улам даамжруулах зэрэг болно.

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд¹⁴⁷

ДНБ-ний бүрдэл хэсэг болох худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарууд эрсдэлтэй нөхцөл байдалд байсаар байна. 2019 онтой харьцуулахад 2020 онд ДНБ 5.3 хувиар буурчээ. Эдийн засгийн өсөлтийг бууруулахад нөлөөлсөн салбарууд нь уул уурхай, олборлолт, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, болон үйлчилгээний бусад үйл ажиллагаа зэрэг байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний эцсийн ашиглалтаарх тооцооллоос эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлсэн гол бүрдэл хэсэг нь эцсийн хэрэглээ, цэвэр экспортын хэмжээ байсан бол хөрөнгийн нийт хуримтлалын хэмжээний бууралт сөрөг нөлөө үзүүлсэн байгаа нь харагдаж байна.

Инфляцын түвшин 2020 онд 2.3 хувь байсан буюу ерөнхийдөө нам дор түвшинд хадгалагджээ. Энэ нь хэрэглээний сагсанд ордог бараа, үйлчилгээний үнэ харьцангуй тогтвортой байсантай холбоотой байна. Түүнчлэн төгрөгийн болон валютын харилцах дансанд байрших мөнгөний хэмжээ буурсан, эсрэгээрээ төгрөгийн болон хадгаламжийн нэмэгдсэн байна. Мөнгөний нийт нийлүүлэлтийн хэмжээ өссөн хэдий ч мөнгөний эргэлтийн хурд буюу нэрлэсэн ДНБ-нийг нийт мөнгөний нийлүүлэлтийн хэмжээнд харьцуулсан харьцаа 2019-2020 онд 1.83-аас 1.67 болж буурсан байна. Энэ нь зээл олголтын хэмжээ багассан, бизнес эрхлэгчдийн орлого тасалдаж мөнгөний эргэлтийн хурд саарсантай холбоотой.

Гадаад валютын ханш рублээс бусад гадаад валютуудын хувьд бага зэрэг өсчээ. Манай улсын хувьд гадаад валютын ханш жил тутам нэмэгдэж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн болон гадаад өрийн өсөлт, гадаад валютын нийлүүлэлтээс давсан эрэлттэй үндсэндээ холбоотой байдаг. 2020 онд гадаад валютын ханш ерөнхийдөө өссөн нь мөнгөний нийт нийлүүлэлт 16 хувиар буюу гадаад валютын албан нөөцийн өсөлтөөс өндрөөр нэмэгдсэн, төв банкнаас нийлүүлсэн гадаад валютын нийлүүлэлтээс зах зээлийн эрэлт давсантай холбоотой юм.

Хязгаарлалт хорио цээрийн нөхцөл байдал үргэлжилбэл ажилгүй иргэдийн тоо өсөх, худалдан авалт, эрэлт буурах, улмаар эдийн засгийн идэвхжил сулрах, худалдан авалт, борлуулалтын хэмжээ багассанаар ДНБ-ний хэмжээ агших үйл явц үргэлжлэх эрсдэлтэй.

¹⁴⁶ Монгол улсын эдийн засгийн тойм, 2021, 2-р сар.

¹⁴⁷ Цар тахлын Монгол Улсын макро эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлсэн нөлөөлөл, алдагдсан боломжийн зардал, Ш.Батцэнгэл, Д.Халиун, О.Билгүүтэй, 2021

Нөгөө талаас цар тахалтай холбоотой эрүүл мэндийн зардал өсч, иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ хэвээр байгаад байвал төсвийн орлого хумигдахын хажуугаар төсвийн зардал өсөх эрсдэл бий болно. Энэ нь засгийн газрын өрийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх шалтгаан болж болзошгүй байна. 2020 онд өмнөх онтой харьцуулахад төсвийн алдагдлын хэмжээ 3.9 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Засгийн газар эрэлтийг дэмжих, бодит секторын нийлүүлэлтийг өсгөх чиглэлээр гаргасан хүчин чармайлтаа үргэлжлүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл нь цар тахлын хэмжээ хумигдахгүй байгаа байдал болж байна. Бараа, үйлчилгээний нийлүүлэлт тасалдах бодит нөхцөл байдал үүсвэл үнийн түвшин өсөх, худалдан авах чадвар хумигдах, амьжиргааны түвшин буурах сөрөг үр дагавруудыг бий болгоно.

Цаашид Засгийн газар гадаадаас нэмэлт эх үүсвэр татаж өрийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөл байдал үүсвэл түүнийг ажлын байрыг бий болгох, дэд бүтэц, нөөцийн болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлд зарцуулах нь илүү оновчтой байна.

Санхүүгийн зах зээлийн орчин

2020 онд *арилжааны банкуудын* нийт зээлийн үлдэгдэл 16.4 их наяд орчим төгрөг болсон нь 2019 онтой харьцуулахад 1.3 их наяд орчим төгрөгөөр багассан үзүүлэлт болж байна. Энэ нь 2020 онд цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн орчны тодорхой бус байдал нэмэгдэж, зээл олголт буурсантай холбоотой.

Иргэд, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого жигд бус болж тасалдсанаас нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ арилжааны банкуудын хувьд 1.6 орчим хувиар нэмэгдсэн бол *ХЗХ-ны* чанаргүй зээл 2019-2020 онд 4.04%-4.53% болж өсчээ.

ББСБ-ын нийт зээлд эзлэх чанаргүй зээл 2020 оны 4-р улиралд 11.16 хувь болсон нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2.06 хувиар нэмэгдсэн үр дүн болж байна. Чанаргүй зээлийн өсөлт нь мөнгөний өртөг буюу зээлийн хүүгийн хэмжээг өсгөхөд хүргэж болзошгүй, дотоодын хуримтлалд мөн сөрөг нөлөөтэй болохыг санхүүгийн байгууллагууд бодолцож эрсдэлийн удирдлагын чанарыг дээшлүүлэх, эдийн засагт эерэг нөлөөллийг бий болгох үйлдвэр аж ахуйн газруудыг зээлийн санхүүжилтээр хангах, Сангийн яамтай хамтран ажиллах, бодлого үйл ажиллагаагаа уялдуулах үйл явцаа сулруулахгүй, харин ч богино хугацаанд эрчимжүүлэх шаардлагатай болж байна.

Даатгалын салбарын сүүлийн 5 жилийн нийт хураамжийн дундаж өсөлт 12.8 хувь байгаа бөгөөд цар тахалтай холбоотойгоор 2020 онд 2.5 хувь болж буурсан байна. Даатгалын салбарын хөрөнгө, орлогын өсөлтийн хувь буурсан хэдий ч эдгээр үзүүлэлтүүдийн нэрлэсэн дүн өсөлттэй гарчээ. Үүнд даатгалын хураамжийн орлогын нэлээд хэсгийг заавал даатгуулах даатгал буюу жолоочийн хариуцлагын даатгал, жил тутам тоо нь нэмэгдэж байгаа авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээнээс бүрдүүлж байгаа нь нөлөөлсөн гэж үзэж болно.

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ өнгөрсөн онтой харьцуулахад 12.5 хувиар өсөж 3,029.7 тэрбум төгрөг болсон нь 2020 онд дийлэнх томоохон хувьцаат компаниуд борлуулалтын орлогоо жигд тогтвортой байлгаж чадсантай холбоотой. Харин цар тахлаас шалтгаалж хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхийг тодорхойлогч үзүүлэлт болох хувьцааны хөрвөх чадвар 3.2 нэгжээр буурч 1.8 хувьд хүрчээ.

Хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого


Хөдөлмөр эрхлэгчдийн тоо 2019 онд 1,188,440 байсан бол 2020 онд 1,124,564 болж буурчээ. 2019-2020 онд нийт ажиллагсдын ажиллах хүчинд эзлэх хувь 0.92-с 0.84 болж багассан байна.

Өрхийн мөнгөн орлого 2019 онд 1,375,080 байсан бол 2020 онд 1,424,598 болж өөрчлөгджээ. Нэрлэсэн дүнгээрээ өрхийн орлого нэмэгдсэн ч энэ нь чанартай өсөлт хараахан биш юм. Учир нь орлого хуваарилалтыг харуулдаг үзүүлэлт болох Жинийн индекс 2019-2020 онд 32.5-с 32.83 болж өссөн буюу орлогын тэгш бус байдал нэмэгдсэн, нөгөө талаас бодит дотоодын нийт бүтээгдэхүүн нэрлэсэн ДНБ-ний бууралтаас ихээр буурсан, хэрэглээний үнийн индекс нам дор түвшинд тогтвортой байсан хэдий боловч хэрэглээний сагсанд ордоггүй олон төрлийн бараа, үйлчилгээний үнэ өссөн, засгийн газраас өрхийн орлогыг дэмжихэд чиглэгдсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн зэрэг нь үүнийг нотолж байна.

Коронавирусийн тархалт, хөл хорионоос шалтгаалан өрхүүд бизнесийн үйл ажиллагаагаа зогсоосон, үйл ажиллагаа нь тасалдсан, үйлчлүүлэгчийн тоо буурсан зэрэг нь орлого буурахад голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Малчин болон газар тариалан эрхлэгч өрхүүдийн 70 хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого буурсан байна.
- Коронавирусийн сөрөг нөлөөнд цалинтай хөдөлмөр эрхэлдэг хүн ам харьцангуй бага өртсөн хэдий ч гурван өрх тутмын нэгийг нь цалингийн орлого буурсан байна.

Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь



Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2019 онд 63 хувь байсан бол 2020 онд 74 хувь болж өсчээ.

2.2.2.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (2021 оны эхний хагас жилийн байдлаар)

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг 2021 оны эхний 6 сарын байдлаар харуулвал дараах байдалтай байна.¹⁴⁸

¹⁴⁸https://mof.gov.mn/files/uploads/article/%D0%B6%D0%B8%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%82%D0%BE%D0%B9%D0%BC_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0_08132021.pdf

Дотоодын нийт бүтээгдэхүүн

2021 оны эхний улиралд 9.2 их наяд төгрөгт хүрч (оны үнээр тооцсон), эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд вакцинжуулалтыг шуурхай эхлүүлсэн, өрхийн орлогыг хамгаалахад чиглэсэн нийгмийн халамжийг үргэлжлүүлсэн, ААН-үүдэд зээл олгож ажлын байрыг хадгалсантай холбоотой байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт

2021 оны эхний хагас жилд 7.4 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 39.4 хувиар өссөн нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эдийн засагт үзүүлсэн огцом шокийн нөлөө аажмаар буурч байгааг харуулж байна. Экспорт өмнөх оны мөн үеэс 45.4 хувиар өсөж 4.1 тэрбум ам.долларт, импорт өмнөх оны мөн үеэс 32.6 хувиар өсөж 3.3 тэрбум ам.долларт тус тус хүрснээр гадаад худалдааны тэнцэл 850.2 сая ам.долларын ашигтай гарлаа.

Инфляц

2021 оны 6 дугаар сарын байдлаар 6.6 хувийн өсөлттэй гарлаа. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр эдийн засаг дахь эрэлт саарсантай холбоотойгоор 2020 онд инфляц нам дор түвшинд хадгалагдаж байв. Харин шатахууны үнэ (суурь оны бууралтын нөлөө), сайжруулсан шахмал түлшний үнэ (өвлийн улиралд 75 хувиар бууруулсан байсан), мөн хүнсний бүлгийн үнэ өссөнтэй холбоотойгоор сүүлийн саруудад инфляцад богино хугацааны өсөлт ажиглагдлаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого

2021 оны эхний 6 сарын байдлаар 7,106.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 471.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,747.4 тэрбум төгрөг буюу 63.0 хувиар өссөн үзүүлэлт юм

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардал

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Нийт зарлага ба цэвэр зээлийг 13,944.9 тэрбум төгрөгөөр баталсныг коронавируст халдварын тархалттай холбоотой цаг үеийн шаардлагаар 12.9 хувиар буюу 1,803.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 15,748.3 тэрбум төгрөг болгон тодотгосон. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7,498.2 тэрбум төгрөг буюу 47.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээрх үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 60.4 хувьтай тэнцэж байсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа юм. Тус харьцаа 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 61.3 хувьтай тэнцэхээр хүлээгдэж байгаа бөгөөд Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 30.9 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Зураг 4. Макро эдийн засгийн гүйцэтгэл

Макро эдийн засгийн төсөөлөл	х/нэгж	2020 гүйц.	2021.06 сар, гүйц.	2021 ХБГ**	2022 төс.
ДНБ, оны үнээр	их наяд төгрөг	37.0	9.2*	42.1	45.7
Эдийн засгийн өсөлт	хувь	(5.3)	15.7*	6.5	4.6
уул уурхайн	хувь	(9.4)	34.1*	13.7	(6.7)
уул уурхайн бус	хувь	(4.3)	11.1*	4.7	7.7
Инфляц	хувь	2.3	6.6	7.2	6.0
Дундаж ханш	төгрөг	2,813.8	2,849.1	2,861.0	3,070.0
Гадаад худалдааны нийт эргэлт	тэрбум ам.доллар	12.9	7.4	14.5	15.3
Нийт экспорт	тэрбум ам.доллар	7.6	4.1	8.2	8.7
Нийт импорт	тэрбум ам.доллар	5.3	3.3	6.3	6.6
Гадаад худалдааны тэнцэл	тэрбум ам.доллар	2.3	0.8	1.9	2.1

Эх сурвалж: Сангийн яам (mof.gov.mn)

БҮЛЭГ 3. ДЭЛХИЙ ДАХИНЫ ЦАР ТАХЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СУРГАМЖ

Цар тахал нь дэлхий нийтийн эдийн засгийн өсөлтийг 2020 онд -3.4%-өөс -7.6%-иар сааруулсан бол 2021 онд 4.2%-5.6%-иар сэргэх төлөвтэй байна.¹⁴⁹ Дэлхийн худалдаа 2020 онд 5.3%-иар буурсан бол 2021 онд 8.0%-иар сэргэх төлөвтэй байна. Олон улсын байгууллагуудаас гаргасан төсөөллүүдийг нэгтгэн харвал 2020 онд эдийн засгийн өсөлт анх тооцоолж байснаас бага буурсан бөгөөд үүнд улс орнуудын авч хэрэгжүүлсэн төсөв, мөнгөний бодлого нөлөөлжээ.

Зарим хөгжингүй улс орнуудын эдийн засаг сэргэж байгаа ч төв банкууд болон үндэсний засгийн газрууд инфляцын болзошгүй дарамтаас сэргийлж мөнгөний болон төсвийн дэмжлэгийг бууруулахаар судалж байна. Дэлхийн эдийн засгийн 60%-ийг бүрдүүлж буй томоохон хөгжингүй улс орнууд хамгийн багадаа 2024 хүртэл үйлдвэрлэлийн боломжит түвшингээсээ доогуур ажиллах төлөвтэй байгаа нь цар тахлын өмнөх үеийнхтэй харьцуулахад улс орнуудын болон иргэдийн эдийн засгийн нөхцөл байдал ерөнхийдөө сул байхыг илтгэж байна.¹⁵⁰

2020 оны энхий хагас жилийн жигд бууралттай харьцуулбал 2020 оны 3-р улирлаас эхэлж аж үйлдвэржсэн, хөгжингүй орнуудын эдийн засгийн сэргэлт хурдсах, хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт удаашрах хандлага ажиглагдаж байна.


2021 оны 8 дугаар сарын байдлаар АНУ-ын ДНБ-ний хэмжээ хямралын өмнөх түвшнээс аль хэдийн 0.8 хувиар өндөр байгаа бол Евро бүсийн ДНБ нь цар тахлын өмнөх үеийнхээс 3 хувиар, ЕХ-ны орнуудад 2.6 хувиар доогуур хэвээр байна.¹⁵¹

¹⁴⁹ M. Szmigiera, Impact of the coronavirus pandemic on the global economy - Statistics & Facts Aug 3, 2021 <https://www.statista.com/topics/6139/covid-19-impact-on-the-global-economy/>

¹⁵⁰ Global Economic Effects of COVID-19, Congressional research service, Updated July 9, 2021 <https://sgp.fas.org/crs/row/R46270.pdf>

¹⁵¹ News Release: OECD GDP growth, Paris, 30 August 2021 https://www.oecd.org/sdd/na/gdp-growth-second-quarter-2021-oecd.htm?utm_term=PAC&utm_source=twitter&utm_medium=social&utm_content=

Зураг 5. Дэлхийн зарим орнуудад цар тахлын өмнөх үед нэг хүнд ногдох ДНБ-ний түвшинд хүрэн хугацаа, жилээр ¹⁵²




Эх сурвалж: ЭЗХАХБ

ОУВС-гийн шинжээчид дэлхийн эдийн засаг 2-оос 3 жилийн дотор цар тахлын өмнөх байдалд эргэн орно гэсэн дүгнэлтийг гаргахын сацуу цар тахалтай тэмцэх, цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг буруулахад зарцуулсан төсвийн хөрөнгө, зээлийн эргэн төлөлттэй холбоотой хүндрэлүүд нь эдийн засгийн өсөлтийн хурдыг сааруулна гэж үзжээ. (Зураг 5)

Дээрх судалгаа, тооцооллууд нь тодорхой бус байдал, цар тахлын шинэ хувилбарууд зэрэг хүчин зүйлээс үүдэн нь зөвхөн ерөнхий дүр зургийг харуулж байна. ¹⁵³

Зураг 6. ЭЗХАХБ-ын зарим орнуудад ажил эрхлэлтийг бүрэн сэргэлтийн төсөөлөл, улирлаар ¹⁵⁴



Тэмдэглэл: Цар тахлын өмнөх суурь түвшин нь 2019 оны 4 улирлын дундаж үзүүлэлт юм. *Хямралын өмнөх түвшин 2024 оны 4-р улиралд сэргээгүй байна.

Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны статистик мэдээлэл, Эдийн засгийн төлөв байдлын мэдээллийн сан, ЭЗХАХБ-ын тооцоолол

¹⁵² OECD Economic Outlook 109 database; and OECD calculations.

¹⁵³ World Economic Outlook, IMF, April 2021

<https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2021/03/23/world-economic-outlook-april-2021>

¹⁵⁴ OECD (2021), OECD Employment Outlook 2021. <https://www.oecd.org/employment-outlook/>

Цар тахлын улмаас хүний амь нас эрсдэж байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд эргэлт буцалтгүй нөлөөлөх бөгөөд үүнд дээр ядуурлын түвшин нэмэгдэж, амьдралын түвшин буурахад нөлөөлж байна. Зарим тооцоогоор 2020 онд 95 сая хүн туйлын ядууралд өртсөн байж болзошгүй бөгөөд тахлын өмнөх үеийнхээс 80 сая хүн шим тэжээлийн дутагдалд орсон байна.¹⁵⁵

Хүснэгт 5. Ковид-19 ба зарим эпидемийн нөлөө¹⁵⁶

Эпидеми	Нас баралт	Халдвар хамгааллын арга хэмжээ/ нөхцөл байдал	Санхүүгийн шокийн дамжих нөлөөлөл	Бодит шокийн дамжих нөлөөлөл	Нөхцөл байдал
Ковид-19, 202.03.01	2996	Ухань/Ломбардид хөл хорио тогтоосон	Зах зээлийн	Нийлүүлэлтийн сүлжээний тасалдал	
Ковид-19, 202.04.08	82200	Дэлхий нийтийн хөл хорио тогтоосон	Санхүүгийн нөхцөл байдлыг чангатгах	Нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, эрэлт огцом тасрах	Даяаршсан эдийн засаг; Нийлүүлэлт/зээлийн сүлжээ;
Ковид-19, 202.10.09	1.06 сая	Дэлхий нийтийн хөл хориог сулруулсан	Санхүүгийн зах зээл тогтвортой хэдий ч банкуудын дарамт нэмэгдсэн	ААН, компаниудын үйл ажиллагаа доголдох	Олон оронд ДНБ-д эзлэх үйлчилгээний хувь өндөр

Эх сурвалж: BIS Working Papers No 959, Macroeconomic effects of Covid-19: a mid-term review, August 2021

Үе үеийн цар тахлуудын эдийн засгийн нөлөө

Эрдэмтэд **Испанийн томуугийн** эдийн засгийн үр дагаврын талаар одоог хүртэл нэгдсэн дүгнэлтэд хүрээгүй байна. 1918-1919, 1920-1921 онд дэлхийн эдийн засаг хоёр удаа хямралд өртсөн боловч ихэнх шинжээчид цар тахлын эдийн засгийн үр дагаврыг тухайн үеийн Дэлхийн нэгдүгээр дайн, Европ тивд олноор өрнөж байсан иргэний дайн зэргийн үр дагавраас салгаж тооцох нь хүндрэлтэй гэж үзэж байна.

SARS-ийн анхны тохиолдол 2002 оны 11 дүгээр сард Хятадын өмнөд хэсэгт бүртгэгдсэн. Дараа нь өвчин БНХАУ-ын бусад хэсэгт, Хонконг, Сингапур, Вьетнам, Тайланд улсуудад тархжээ. Азийн бүс нутгаас гадна Канад, АНУ хоёр SARS-т хамгийн түрүүнд өртсөн. 2003 онд SARS нийт 29 оронд тархаж, нийт 8 мянга гаруй тохиолдол бүртгэгдсэнээс 774 хүн нас баржээ. Эпидемийн хурдацтай тархалт нь эдийн засагт мөн адил хурдацтай боловч богино хугацаанд нөлөөлсөн байна. Эпидемийн үед Хонконгийн ДНБ-ний хэмжээ 2.5%, БНХАУ-ын ДНБ 1%, Сингапур 0.7%-иар буурчээ. SARS-ийн Ази тивд тархсаны гол цохилтыг үйлчилгээний салбар хүлээн авч - аялал жуулчлал, зочид буудлын бизнест ихээр нөлөөлсөн байна. 2018 онд Английн “Халдварт өвчний сэтгүүл”-ийн мэргэжилтнүүд SARS-аас үүдэлтэй шууд зардлыг 40 тэрбум ам.доллар гэж тооцжээ.

SARS-аас гадна мөн онд *шувууны томуу* дэгдсэн бөгөөд вирус хурдацтай хувьсан өөрчлөгдөж нийт 25 хувилбар бүртгэгдсэнээс 3 нь хүний үхэлд хүргэж байсан. Европын холбоо шувууны томууны тархалттай тэмцэх санг байгуулж 1 тэрбум еврог зарцуулсан байна.

2003-2006 оны хооронд шувууны томуугийн дэгдэлтээс үүдэн Хонконг, Хятадаас Европ, Америк хоорондын нислэгийг 20%-иос 75%-иар хязгаарлаж байсан. Эдийн засагчид

¹⁵⁵ Global Economic Effects of COVID-19, Congressional research service, Updated July 9, 2021 <https://sgp.fas.org/crs/row/R46270.pdf>

¹⁵⁶ BIS Working Papers No 959, Macroeconomic effects of Covid-19: a mid-term review, August 2021, <https://www.bis.org/publ/work959.pdf>

2003-2006 он хүртэл шувууны томуугийн нийт хохирол, түүний эсрэг тэмцэхэд зарцуулсан хөрөнгийг 1.5 их наяд ам.доллар буюу дэлхийн ДНБ-ний 3 хувьтай тэнцсэн гэж тооцсон. 2013 он хүртэл үргэлжилсэн шувууны томуугийн дэгдэлтийн хамгийн том алдагдлыг ДНБ-нийхээ 2.6 хүртэлх хувийг алдсан Ази, Номхон далайн бүс нутаг хүлээсэн байна. Эдгээр нь гол төлөв хөдөө аж ахуй, аялал жуулчлал, зочид буудлын салбарт ногдож байв.

Зөвхөн Тайландад 2004-2006 онд 64 сая толгой шувуу (голдуу тахиа), Вьетнамд 50 сая, Индонезид 17 сая, Египтэд 36 сая толгой устгагдсан байна. Латин Америк дахь ДНБ-ний алдагдал 4.4%, Карибын тэнгисийн орнуудад 4.4%-тай байсан байна.

SARS болон шувууны томууны дэлхийн эдийн засагт үзүүлсэн нөлөөг тооцоолоход эдийн засгийн бусад үйл явцаас тусад тооцоход хүндрэлтэй байгааг мэргэжилтнүүд тэмдэглэжээ. Учир нь 2001 оны террорист халдлагын үр дагавраас 2001-2003 онд агаарын тээвэр, аялал жуулчлалын зах зээл дэх идэвхжил эрс буурсан, дэлхийн эдийн засаг сэргэж чадаагүй хэвээр байсан юм.

Гахайн ханиад: 2009-2010 онд дэлхий дахинаа "амьтны" гаралтай томуугийн шинэ дэгдэлт гарсан бөгөөд энэ удаад H1N1 вирус гэрийн тэжээвэр гахайнаас хүнд халдварлаж Мексик Улс халдварын голомт болсон. Янз бүрийн эх сурвалжийн мэдээллээр дэлхий даяар 700 саяас 1.4 тэрбум хүртэл хүн халдвар авсан нь Испанийн томуугийн цар тахлыг (1918) давсан байна. Нас баралтын хувь харьцангуй бага байсан учир тус халдвараар 20 мянга орчим хүн нас барсан байна.

Зарим эдийн засагчид гахайн ханиадны үр дагаврыг 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын үр дагавраас салган тооцохыг анхааруулдаг. Гахайн ханиадад хамгийн ихээр өртсөн орнууд болох Мексик, АНУ, Канад, Төв ба Өмнөд Америкийн нийт алдагдлыг жилийн ДНБ-ний 0.5-1%-тай тэнцэнэ гэж тооцсон байна. Тухайлбал, Канад Улсын хувьд нийт зардлыг 2 тэрбум канад доллар (1.4 тэрбум ам.доллар) гэж тооцсон бөгөөд үүнд өвчтэй хүмүүсийг эмчлэх зардал, сургуулиудыг хэсэгчлэн хаах, гахай олноор нядлах, сэг зэмийг устгах зардал орсон. Аялал жуулчлалын салбар ч мөн хохирол амссан: нислэгүүд цуцлагдсанаас агаарын тээврийн компаниудын алдагдал хэдэн зуун сая доллараар үнэлэгдсэн.

Цар тахлын хэмжээнд хүрээгүй хэдий ч 2014-2016 онд Африкийн **Эбола** вирусийн тархалт нэлээд олон хүний амьнд хүрсэн. Үүнээс Африк тивийн баруун хэсгийн улсууд болох Гвиней, Либер, Сьерра Леон хамгийн их хохирол амссан. Түүнчлэн энэ өвчин Нигери, Мали, Сенегал, АНУ болон Европын зарим оронд тархсан. Нийтдээ Эбола вирусийн тархалтын үеэр 28.6 мянган тохиолдол бүртгэгдэж, 11.3 мянган хүн нас баржээ. Эбола вирусийн эдийн засгийн хохирол зөвхөн Баруун Африкийн бүс нутгаар хязгаарлагдсан бөгөөд эдгээр орнуудад эдийн засгийн идэвхжил буурсантай холбоотойгоор татвар, тарифаас төсөвт төвлөрүүлэх орлого мэдэгдэхүйц буурсан. Тухайлбал, Либер Улсад 2015 онд төсвийн алдагдал (орлогоос давсан зарлага) 8.5%-д хүрсэн байна. Мөн онд Сьерра Леон Улсад төсвийн алдагдал 4.8%, Гвинейд 9.4%-д тус тус хүржээ. Английн “Халдварт өвчний сэтгүүл”-ийн шинжээчдийн тооцоолсноор Эбола вирусийн халдварын өртөг 53 тэрбум долларт хүрсэн байна.¹⁵⁷

¹⁵⁷ "Деньги". Приложение №11 от 23.04.2020, стр. 16, <https://www.kommersant.ru/doc/4307954>

Хүснэгт 6. Өмнөх эпидемиудийн эдийн засагт үзүүлсэн нөлөө¹⁵⁸

Эпидеми	Нас баралт ¹⁵⁹	Тайлан (огноо), аргачлал	Эдийн засгийн алдагдал *ppt: parts-per-thousands
Цар тахал 1918 он	50 сая	Улс хоорондын панел регрессийн загвар	ДНБ-ний өсөлт 6 ppt, хэрэглээний өсөлт 6 ppt буурсан.
		АНУ-ын мужуудын тоо мэдээ	Нас баралтаас үүдэн дараагийн 10 жилийн эдийн засгийн өсөлт буурсан
		АНУ-ын мужуудын тоо мэдээ	Үйлдвэрлэлийн идэвхжил жилд 18% буурсан; илүү хатуу хязгаарлалт нь нөлөөллийг зөөлрүүлсэн.
SARS 2003 он	774	CGE загвар	2003 онд дэлхийн ДНБ-ний 0.1% алдагдсан
		Хятад, санал асуулга	Хятадад ДНБ-ний өсөлт 1-2 хувиар буурсан байна.
H5N1 2003-2019 он	455	Нийгэм, эдийн засгийн дүн шинжилгээ хийх, зохион байгуулалттай ярилцлага	Нигерийн хот, хөдөөгийн шувууны аж ахуй, хүнсний аюулгүй байдал, амьжиргаанд ноцтой аюул заналхийлсэн. Шувууны аж ахуйн 75% нь захиалга өгөхөө зогсоож, өрхийн 80% нь худалдан авалт, хэрэглээгээ зогсоосон.
		Оролт/гаралт IO болон CGE загвар	Дотоодын хэрэглээг бууруулснаар бодит ДНБ-д үзүүлэх хохирол 0.1%~0.4%, ажиллах хүчний эрэлт 4.9%~6.4% буурсан.
		Дэлхийн банкны тооцоолол	Дэлхийн ДНБ-ний жилийн 0.1%-ийн алдагдал Азийн хувьд 0.4%
Эбола 2014-2019 он	11323	Ашгийн бус, ТББ, ЗГ болон бусад байгууллагаас гаргасан судалгаа	ДНБ-ний алдагдал, дэгдэлтийн эдийн засгийн ачаалал 2.8-аас 32.6 тэрбум ам.доллар байна.
		CGE загвар	Дэгдэлтийн эхний жилд Гвинейд ДНБ-ний өсөлт 2.16 ppt, Либерид 3.4 6 ppt, Сьерра Леонд 3.3 6 ppt буурсан.
H1N1	18449	Ecomod нэг орны CGE загвар	ДНБ-ний алдагдал бага зэргийн цар тахлын үед ДНБ-ний ойролцоогоор 0.5%-тай, хүнд хэлбэрийн цар тахлын үед 2%-тай тэнцэнэ.
		Нэг шугаман регресс	Мексикийн аялал жуулчлал, гахайн махны салбар ойролцоогоор 2.8 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн. H1N1-ийн улмаас гахайн махны худалдааны алдагдал 27 сая ам.долларт хүрсэн.
MERS	780	Харилцан уялдаатай салбарын дүн шинжилгээ	ДНБ ойролцоогоор 0.2%-иар буурсан, аялал жуулчлалаас 2.6 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн
Зика	3489	Шугаман регрессийн загвар	Аялал жуулчлал буурсантай холбоотойгоор ДНБ дундаж өгөөжид 1.6% болон -0.90%-д хүрсэн.

Эх сурвалж: <https://www.ncbi.nlm.nih.gov/>

ОУВС-ийн судлаачид¹⁶⁰ SARS (2003), H1N1 (2009), MERS (2012), Эбола (2014), Зика (2016) гэсэн таван том халдварт өвчний эдийн засгийн үр дагаварт дүн шинжилгээ хийж, тус бүрийн дараа таван жилийн хугацаанд халдварын тархалт орлогод хэрхэн

¹⁵⁸ A Statistical Analysis of Impact of COVID19 on the Global Economy and Stock Index Returns, 2021 <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7796698/>

¹⁵⁹ Center for disease control and prevention, <https://www.cdc.gov>

¹⁶⁰ Davide Furceri, Prakash Loungani, Jonathan D. Ostry, How Pandemics Leave the Poor Even Farther Behind, MAY 11, 2020 <https://blogs.imf.org/2020/05/11/how-pandemics-leave-the-poor-even-farther-behind/>

нөлөөлснийг тооцож үзэхэд тэгш бус байдлын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэмжигдэхүүн болох Жини коэффициент¹⁶¹ аажмаар нэмэгдсэн болохыг тогтоожээ. Цар тахлын нөлөөг бууруулахын тулд засгийн газраас орлогыг ядуу, эмзэг бүлэгт дахин хуваарилахаар оролдсон хэдий ч тэгш бус байдал улам бүр нэмэгдсэн болохыг тогтоосон байна. Ийнхүү таван жилийн дараа цэвэр Жини коэффициент бараг 1.5 хувиар өссөн нь тэгш байдалд ихээхэн нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Цар тахлын урт хугацааны энэхүү үр дагаврыг ажлын байраа алдах, орлогод нөлөөлөх бусад цочрол (ажилчдын гуйвуулгын хэмжээ буурах гэх мэт), ажил эрхлэх боломж буурсантай холбон тайлбарлаж байна. Цар тахал нь ялгаатай боловсролын түвшний хүн амын хөдөлмөр эрхлэлтэд асар их ялгаатай нөлөө үзүүлсэн байна. Энэ нь боловсролын түвшин өндөр хүн амын ажил эрхлэх боломжид бараг нөлөөлөөгүй бол боловсролын түвшин доогуур түвшний ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 5 жилийн дараагаар 5-аас дээш хувиар буурсан байна.

Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн эдийн засагт гарч буй сөрөг үр дагаврууд:

Цар тахалтай холбогдуулан томоохон банкууд болон бусад санхүүгийн байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх таамаглалаа бууруулсан. Тухайлбал, Хятадын ДНБ-ний өсөлт 4.9% байхаар тооцжээ. Энэ нь өмнөх оны хүлээлтээс 5.7 пунктээр доогуур үзүүлэлт юм.

Үйлдвэрлэлийн идэвх буурсан

Хятад Улсад үйлдвэрлэлийн салбар нь цар тахлын улмаас ихээхэн хохирол амссан. Үйлдвэрлэлийн идэвх 40.3 болж рекорд түвшинд хүрч буурсан (50-аас доош уналт нь агшилтыг хэлнэ). Цар тахал Вьетнам, Сингапур, Өмнөд Солонгост мөн адил сөрөг нөлөө үзүүлсэн.

Үйлчилгээний салбар хумигдсан

Цар тахлын улмаас хүн амын орлого буурч, зарим иргэд ажилгүй болсон. Энэ нь жижиглэн худалдаа, агаарын тээвэр, рестораны бизнест сөргөөр нөлөөлсөн. Цар тахал нь Орос, АНУ зэрэг ихэнх орнуудын үйлчилгээний салбарт ийм нөлөө үзүүлсэн.

Газрын тосны өртөг буурсан

Үйлдвэрлэлийн идэвхжил буурсан нь газрын тосны эрэлтэд нөлөөлсөн. Эрэлт буурсны улмаас газрын тосны үнэ даган буурсан. “ОПЕК +”-ийн орнууд газрын тос олборлох тухай шинэ хэлэлцээрийн талаар санал нэгдэж чадаагүй, үнийн бууралт цар тахлаас өмнө эхэлсэн бөгөөд үүний явцад өртөг нь сөрөг болсон байна.

Хөрөнгийн зах зээлийн асуудал

Цар тахалтай холбоотой эрсдэл, айдас нь хөрөнгө оруулагчдын сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж, томоохон зах зээл дэх хувьцааны ханш огцом буурахад нөлөөлж байна.

Цар тахал нь хөрөнгийн зах зээлд гурван хэлбэрээр нөлөөлж болно.

- бизнесийн идэвх буурах;
- дотоодын зах зээл дэх идэвхжил буурах;
- санхүүгийн зах зээл дэх стресс.

¹⁶¹ ЖИНИ КОЭФФИЦИЕНТ нь хүн амын зардлын тэнцүү бус хуваарилалтыг илэрхийлсэн коэффициент юм. Жини коэффициент нь 0-1-ийн хооронд утга авна. Жини коэффициент нэг гэсэн утганд ойртох тутам зардлын тэнцүү биш байдал өндөр байгааг илтгэнэ. Харин энэ коэффициент нь 0-тэй тэнцүү бол зардлын хуваарилалтад ялгаа бараг байхгүй байгааг илэрхийлнэ.

Бондын орлого буусан

Цар тахал тархах вий гэсэн айдас бондын өгөөжийг бууруулсан байна. АНУ-ын эрдэнэсийн санг тогтворгүй байдал, тодорхой бус байдлын үед хөрөнгө оруулагчдын илүүд үздэг найдвартай актив гэж үздэг. Америкт бондын өгөөж 7 хоногийн дотор 1%-иас доош буурсан нь урь өмнө тохиолдож байгаагүй юм. 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 0.3%-д хүрсэн.

Дэлхийн аялал жуулчлал буурсан

Дэлхий даяар аялал жуулчлалын салбараас 5.7 их наяд ам.долларын орлого олдог бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын бараг 10% нь энэ салбарт ажилладаг. Тус салбар цар тахлын улмаас хамгийн их хохирол амссан салбар юм.

Хил хааж, хөл хорио тогтоож, аялахаа больсны улмаас аялал жуулчлал ихээхэн буурсан байна. Энэ нь зөвхөн аялал жуулчлалын компаниуд төдийгүй тээврийн үйлчилгээ эрхлэгч нарт нөлөөлж байна.

Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах зарчим, бүс нутаг, улс орнуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Аливаа хямрал, түүний дотор өнөөгийн цар тахлын үед төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах зарчмууд (ЭЗХАХБ)¹⁶², зарим нэг улс орны (ОХУ) эдийн засгийн хямралыг даван туулах арга хэмжээ зэрэг нэгтгэж үзвэл дараах нийтлэг зарчмуудыг тодорхойлж болох юм.¹⁶³

Нэгдүгээрт, арга хэмжээ нь системийн шинжтэй, **тодорхой зорилтуудад чиглэсэн байх** ёстой. Улс орнуудын засгийн газар хямралын эдийн засгийн үр дагаврыг даван туулах төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй бөгөөд ингэхдээ түүний үр шимийг хүртэгчдийн тоон үзүүлэлтийг тодорхойлох; бэлтгэсэн төлөвлөгөөний үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тусгах нь чухал юм. Түүнчлэн, дэмжлэгүүдийн талаарх мэдээлэл **нээлттэй, ил тод** байх нь чухал юм. Ингэснээр үр шимийг хүртэгчид, улсын санхүүгийн хяналтын байгууллагууд болон олон нийтэд засгийн газрын үйл ажиллагааны үр дүнг тооцох, хянах боломжийг олгож, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ. Мөн энэ тохиолдолд гүйцэтгэх засаглалын зүгээс боловсруулсан хямралын эсрэг төлөвлөгөөний үр дүнгийн хариуцлага нэмэгдэх юм.

Хоёрдугаарт, төрийн санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээ нь хямралыг даван туулах ерөнхий үр дүнд чиглэсэн **цогц байх** ёстой бөгөөд юун түрүүнд мөнгөний болон төсвийн бодлого хоорондын уялдаа холбоотой байх ёстой юм. Ийнхүү хөрвөх чадвартай холбоотой асуудлыг шийдвэрлэх, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ЭЗХАХБ-ын бүх гишүүн орнууд төв банкны бодлогын хүүг бууруулж, зээлийн төлбөрийн хүүг бууруулахад татаас олгосон.

Гуравдугаарт, төрийн санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тааруулан **өөрчлөх боломжтой байх** ёстой. Энэ нь хямралын хэмжээ, байгууллагын үйл ажиллагааны тодорхой төрөл, чиглэлд үзүүлэх нөлөөг харгалзан засгийн газраас нэмэлт арга хэмжээ авах боломжтой эсэхээр тодорхойлогдоно. Хямралын дараах хугацаанд зөвхөн хямралд нэрвэгдсэн ААН, байгууллага, салбаруудад төрөөс баталгаа, татаас олгох арга хэмжээ авахаас гадна үндэсний эдийн засгийн үсрэнгүй хөгжлийг

¹⁶² Government support and the COVID-19 pandemic, Version 14 April 2020, <https://www.oecd.org/coronavirus/policy-responses/government-support-and-the-covid-19-pandemic-cb8ca170/>

¹⁶³ L.D. Sanginova, Measures of the government financial support: rules, experience and efficiency increasing, Управленческие науки в современном мире, Сборник докладов Восьмой Международной научно-практической конференции. Санкт-Петербург, 2021

хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулах нь зүйтэй юм. Үүнд: мэдээллийн технологийн салбар, биоинженерийн салбар, телемедицин, ногоон эдийн засаг, инновац зэрэг орж болох юм.

Дөрөвдүгээрт, төрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ **уян хатан байх** нь ашиг хүртэгчдийн ашиг сонирхол, хямралын сөрөг нөлөөллийн хэмжээг харгалзан нөхцөл, журмыг өөрчлөх боломжтой байх ёстой юм.

Тавдугаарт, үр шимийг хүртэгчдийн хувьд төрөөс **санхүүгийн дэмжлэг авах нөхцөл, механизм нь хүртээмжтэй, тохиромжтой, энгийн байх** ёстой. Үүнийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, түүнийг хүлээн авахад тавигдах шаардлагын талаарх мэдээлэл хүртээмжтэй, мэдээлэл түгээх платформтай, дэмжлэг авах шаардлагууд нь энгийн байх шаардлагатай юм.

Зургадугаарт, төрийн санхүүгийн дэмжлэг үр дүнтэй байх нөхцөл бол **санхүүгийн арга хэрэгслийг сонгохдоо эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн үе шатыг харгалзах** явдал юм. Энэ нь “хямрал, сэргэлт, хямралаас гарах, тогтворжилт, эдийн засгийн өсөлтийг хангах” гэх үе шатуудаас бүрдэнэ. Тиймээс эдийн засгийн хямралын үед хямралаас хамгийн их хохирол амссан салбар, байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх бол хямралаас гарахын хэрээр дэмжлэгийн арга хэмжээ нь урамшууллын хэлбэрт шилжих юм.¹⁶⁴

Бүс нутаг, улс орнуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тойм

Ковид-19 цар тахлын тархалтыг бууруулах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор дэлхийн дийлэнх улс орон хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоохын сацуу нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Цар тахал, түүнтэй тэмцэх үндэсний засгийн газруудын тэмцлийн үр дагавар нь бүх улс орны эдийн засагт нөлөөлж байна.¹⁶⁵

Засгийн газрууд ААН, өрх болон эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд асар их хөрөнгө зарцуулсан. 2020 оны 3 дугаар сараас хойш дэлхийн хэмжээнд санхүүгийн дэмжлэгт 7.8 их наяд ам.долларын нэмэлт зардал, алдагдсан орлого, 6 их наяд ам.долларыг өөрийн хөрөнгө, зээл, батлан даалтад, нийт 13.8 их наяд ам.доллар зарцуулсан байна. Энэ нь 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын үед үзүүлсэн хэмжээнээс хамаагүй их юм. Олон улс орон, болон Европын Холбоо нь хямралын тэргүүлэх чиглэлүүд болох эрүүл мэнд, ЖДҮ, эмзэг бүлгийн хүн ам, ялангуяа хямралд нэрвэгдсэн бүс нутгуудыг дэмжиж шинэ санхүүжилт, төсвийн санхүүжилтийг хуваарилж байна.

Дэлхийн эдийн засгийн энэхүү цаг үеийн онцлог нь эрэлтийн хямрал, нийлүүлэлтийн тасалдлаар илэрхийлэгдэж байна. Ийм нөхцөлд түр зуурын бэрхшээл, бэлэн мөнгөний хэрэгцээтэй байгууллагад дэмжлэг үзүүлэх шаардлага үүсэх юм. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь төсвөөс шууд санхүүжилт (татаас, буцалтгүй тусламж) олгохоос гадна төлсөн татварыг буцааж олгох, татварын хувь хэмжээ, даатгалын шимтгэлийг бууруулах, татвар, даатгалын шимтгэлээс чөлөөлөх, төр (орон нутгийн) өмчийг ашигласны (түрээсийн) төлбөрөөс чөлөөлөх, эсхүл бууруулах зэрэг багтаж болно. Дээрх арга хэмжээ нь байгууллагын зардлыг бууруулж, хөрвөх чадварын хямралыг арилгахад нөлөөлдөг. Эдгээр арга хэрэгслүүд нь цар тахлын хямралын нөхцөлд дэлхийн дахинаа өргөнөөр хэрэглэгдсэн. Татвар, даатгалын хураамж, түрээсийн төлбөрийг хойшлуулах,

¹⁶⁴ О мерах по преодолению кризисных процессов в экономике России. – М.: Издание Государственной Думы, 2015. – 320 <http://duma.gov.ru/media/files/Rx9q8OtxoYAibYrJ5VDmteeAu6Aeugyj.pdf>

¹⁶⁵ Baldwin R., Weder di Mauro B. Economics in the time of COVID-19 // VoxEU.org eBook, CEPR Press, 2020. <https://voxeu.org/article/economics-time-covid-19-new-ebook>.

эсхүл чөлөөлөх нь зардлыг бууруулдаг. Хямралын үед эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж үзүүлэх арга хэмжээг цөөнгүй улс хэрэгжүүлсэн. Тухайлбал, АНУ-д урьд нь төлсөн татварын буцаан олголт, татаас зэрэг нь байгууллагуудын хэд хэдэн зайлшгүй зардлыг санхүүжүүлэх юм. БНСУ-д жижиг худалдаа эрхлэгчдэд цалингийн татаас өгч, БНХАУ-д бизнес эрхлэгчдийг нийгмийн даатгалын шимтгэлээс түр чөлөөлсөн. Түүнчлэн вирусийн эсрэг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх үйлдвэрлэлийн чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэгийн багцыг олгосон нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн юм. Түүнчлэн, тээвэр, нийтийн хоол, зочлох үйлчилгээ, аялал жуулчлал, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл зэрэг хамгийн их өртсөн салбаруудад татварын буцаан олголтыг олгосон. Цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдсон вирусийн эсрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон гарааны бизнес эрхлэгчдэд зээлийн төлбөрийн нэмэлт татаасыг үзүүлсэн.¹⁶⁶

Төрөөс үзүүлэх санхүүгийн шууд дэмжлэгүүд нь ажлын байр хадгалах, ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэх, эмзэг бүлгийн иргэдэд чиглэж байсан бол 2020 оны хоёрдугаар хагаст улс орнууд төсвийн хөрөнгө оруулалтад чиглэсэн томоохон хэмжээний эрчимжүүлэх багцуудыг зарлаж эхэлсэн. Эдгээр хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх багцууд нь нүүрстөрөгчөөс ангид эдийн засагт шилжих, дижитал шилжилт, эрүүл мэндийн тогтолцоо болон нийгмийн дэд бүтцийг бэхжүүлэх зэрэг тэргүүлэх салбаруудад голлон төвлөрч байна.

Хямралын дараах эдийн засгийг сэргээх стратеги нь засгийн газруудад тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих, эдийн засгийн үйл ажиллагааны нүүрстөрөгчийн идэвхийг бууруулах арга хэмжээ авах онцгой боломжийг бий болгож байгаа юм. Гэвч ЭЗХАХБ болон ЭЗХАХБ-ын гол түнш орнуудын эдийн засгийг эрчимжүүлэх багцуудад хийсэн дүн шинжилгээгээр “ногоон сэргэлт”-д төсөвлөсөн 340 тэрбум ам.доллар нь ЭЗХАХБ-ын улс орнуудын эдийн засгийн эрчимжүүлэхэд тусгасан төсвийн 17%, цар тахалтай тэмцэхэд чиглэх буй нийт төсвийн 2%-ийг эзэлж байгаа нь хангалтгүй дүн юм.¹⁶⁷

Харин Европын холбооны хувьд гишүүн орнуудад “Европын эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан”-аас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн 37% нь уур амьсгалын зорилтуудыг, 20% дижитал шилжилтийг нь тус тус дэмжсэн байх ёстой гэсэн шаардлагыг тавьж байна.

Бүс нутгийн байгууллагуудын түвшинд:

Европын холбооны хувьд¹⁶⁸

Европын холбоо нь урт хугацааны төсөв болон Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг эрчимжүүлэх түр арга хэрэгсэл болох “Шинэ эриний Европын холбоо” (NextgenerationEU)¹⁶⁹ хөтөлбөрийн хамт ***ЕХ-ны эдийн засгийг сэргээхэд нийтдээ 2.018 их наяд евро*** зарцуулах бөгөөд тус бүс нутагт хэрэгжүүлж буй хамгийн том санхүүгийн арга хэмжээний багц болох юм.

Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх, эрчимжүүлэх “Шинэ эриний Европын холбоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **806.9 тэрбум евро** зарцуулахаар

¹⁶⁶ Supporting people and companies to deal with the COVID-19 virus. OECD, 2020. <http://www.oecd.org/coronavirus/policy-responses/supporting-people-and-companies-to-deal-with-the-covid-19-virus-options-for-an-immediate-employment-and-social-policy-response-d33dffe6/>.

¹⁶⁷ OECD Policy Responses to Coronavirus (COVID-19) The territorial impact of COVID-19: Managing the crisis and recovery across levels of government 10 May 2021, <https://www.oecd.org/coronavirus/policy-responses/the-territorial-impact-of-covid-19-managing-the-crisis-and-recovery-across-levels-of-government-a2c6abaf/#section-d1e326>

¹⁶⁸ <https://ru.euronews.com/next/2021/02/10/recovery-and-resilience-facility-real-economy>

¹⁶⁹ https://ec.europa.eu/info/strategy/recovery-plan-europe_en, https://ec.europa.eu/info/strategy/recovery-plan-europe_en#nextgenerationeu

хөтөлбөрийн хуваарилалт (зарлагын ангиллаар)

	Урт хугацааны төсөв	“Шинэ эриний ЕХ” хөтөлбөр
1. Нэг зах зээл, инноваци ба дижитал хувьсал	149.5 тэрбум евро	11.5 тэрбум евро
2. Эв нэгдэл, уян хатан байдал, үнэт зүйлс	426.7 тэрбум евро	776.5 тэрбум евро
3. Байгалийн нөөц ба байгаль орчин	401 тэрбум евро	18.9 тэрбум евро
4. Шилжилт хөдөлгөөн ба хилийн удирдлага	25.7 тэрбум евро	-
5. Аюулгүй байдал ба батлан хамгаалах	14.9 тэрбум евро	-
6. Хөрш ба дэлхий	110.6 тэрбум евро	-
7. Европын төрийн удирдлага	82.5 тэрбум евро	-
Нийт	1210.9 тэрбум евро	806.9 тэрбум евро

Эх сурвалж: Европын Комисс

Уг хөтөлбөрийн цөм хэсэг нь нийт **672.5 тэрбум евро** бүхий “Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан” (Recovery and Resilience Facility-RRF)¹⁷⁰ бөгөөд уг сангийн талаарх улс төрийн шийдвэрийг Европын Комисс болон Европын Парламент 2020 оны 12 дугаар сард гаргасан бол 2021 оны 2 дугаар сард Европын Парламентаас албан ёсоор баталж, 2021 оны 2 дугаар сарын 19-нөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах санг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжүүлэх юм.¹⁷¹

Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан нь дараах зургаан тулгуурт бүтэцтэй:

- ногоон шилжилт;
- дижитал хувьсал;
- эдийн засгийн нэгдмэл байдал, бүтээмж, өрсөлдөх чадвар;
- нийгэм болон нутаг дэвсгэрийн нэгдмэл байдал;
- эрүүл мэнд, эдийн засаг, нийгэм болон институциудын уян хатан байдал;
- хойч үеийнхэнд зориулсан бодлого.

Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан нь эрчим хүчний хувьд цэвэр технологи болон сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх, барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй хотын тээврийг хөгжүүлэх, цэнэглэх станцууд барьж байгуулах, дижитал холболтыг сайжруулах, төрийн албыг цахимжуулах, дижитал бүрэлдэхүүн хэсгүүд болон үүлэн технологийн боломжуудыг нэмэгдүүлэх, дижитал ур чадварыг эзэмшүүлэх, давтан сургах, дэмжих зэрэгт голлон чиглэж байгаа юм. (Зураг 7)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁷⁰https://ec.europa.eu/info/business-economy-euro/recovery-coronavirus/recovery-and-resilience-facility_en

¹⁷¹ https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_21_423

Зураг 7. Хөрөнгө оруулалт, шинэтгэлийг явуулахыг хөхиүлэн дэмжиж буй салбар, чиглэлүүд



Эх сурвалж: Европын Комисс

Дээрх Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан нь ЕХ-нд 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг зогсоох (climate neutrality) зорилтыг биелүүлэх, дижитал хувьсалд шилжих, ажлын байр бий болгож, өсөлтийг дэмжихэд чиглэж байна.

Дээрх сангаас санхүүжилт авахад Евопын холбооны гишүүн орнууд өөрсдийн эдийн засгийг сэргээх төлөвлөгөөг боловсруулна.

ЕХ-ны гишүүн улс орнуудын эдийн засгийг сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардлуудын хамгийн багадаа **37% нь уур амьсгалын зорилтуудыг**, хамгийн багадаа **20% дижитал шилжилтийг** нь тус тус дэмжсэн байх ёстой гэсэн шаардлагыг тавьж байна. (Зураг 8)

Зураг 8. Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангийн зорилтот салбарууд



Эх сурвалж: Европын Комисс

ЕХ-ны гишүүн улс орнууд өөрсдийн эдийн засгийг сэргээх зорилт, хүрэх түвшин зэргийн нарийвчлан тусган боловсруулах бөгөөд Европын Комисс эдгээр төлөвлөгөөг тусгай шалгуурын дагуу үнэлж, Европын Зөвлөл төлөвлөгөөг улс тус бүрээр эцсийн байдлаар баталснаар тухайн улсад олгох нийт санхүүжилтийн 13% хүртэл урьдчилсан санхүүжилт олгох буцалтгүй тусламж, зээлийн гэрээнд гарын үсэг зурах боломжтой болно.

2021 оны 7 дугаар сарын 28-ны байдлаар Австри, Бельги, Дани, Франц, ХБНГУ, Грек, Итали, Латви, Люксембург, Португал, Словак, Испани, Хорват, Кипр, Литва, Словени зэрэг 16 улс “Эдийн засгийг сэргээх төлөвлөгөөгөө” батлуулаад байна.¹⁷²

“Шинэ эриний Европын холбоо” хөтөлбөрт тусгасан **806.9 тэрбум еврог** дараах байдлаар зарцуулах юм.

Хүснэгт 8. “Шинэ эриний Европын Холбоо” хөтөлбөрийн зарцуулалт

Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сан	723.8 тэрбум евро
Үүнээс: буцалтгүй тусламж	338.0 тэрбум евро
Үүнээс: зээл	385.8 тэрбум евро
ReactEU	50.6 тэрбум евро
Horizon Europe (Судалгаа болон инновацид)	5.4 тэрбум евро
InvestEU	6.1 тэрбум евро
Rural Development (Хөдөө орон нутгийн хөгжил)	8.1 тэрбум евро
Just Transition Funds (JTF) (Цаг уур болон дижитал хувьсалд)	10.9 тэрбум евро
RescEU	2 тэрбум евро
Нийт	806.9 тэрбум евро



¹⁷² <https://www.consilium.europa.eu/en/policies/eu-recovery-plan/>

Зураг 9. Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас ЕХ-ны гишүүн орнуудад олгох буцалтгүй тусламжийн дээд хэмжээ (тэрбум евро)¹⁷³

	For 70% of the amount available	For 30% of the amount available	Total
Belgium	3.6	2.3	5.9
Bulgaria	4.6	1.6	6.3
Czechia	3.5	3.5	7.1
Denmark	1.3	0.2	1.6
Germany	16.3	9.3	25.6
Estonia	0.8	0.2	1.0
Ireland	0.9	0.1	1.0
Greece	13.5	4.3	17.8
Spain	46.6	22.9	69.5
France	24.3	15.0	39.4
Croatia	4.6	1.7	6.3
Italy	47.9	21.0	68.9
Cyprus	0.8	0.2	1.0
Latvia	1.6	0.3	2.0
Lithuania	2.1	0.1	2.2
Luxembourg	0.1	0.0	0.1
Hungary	4.6	2.5	7.2
Malta	0.2	0.1	0.3
Netherlands	3.9	2.0	6.0
Austria	2.2	1.2	3.5
Poland	20.3	3.6	23.9
Portugal	9.8	4.1	13.9
Romania	10.2	4.0	14.2
Slovenia	1.3	0.5	1.8
Slovakia	4.6	1.7	6.3
Finland	1.7	0.4	2.1
Sweden	2.9	0.4	3.3
EU 27	234.5	103.5	338.0

Эх сурвалж: Европын Комисс

Европын Холбооны урт хугацааны төсөв болон “Европын Холбооны дараагийн үе” хөтөлбөрийн санхүүжилт

Европын Холбооны урт хугацааны төсвийг Европын Холбооны төсвийн орлогын дараах эх үүсвэрээр үргэлжлүүлэн санхүүжүүлнэ. Үүнд:

- Гаалийн татвар;
- Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) дээр үндэслэсэн гишүүн орнуудын хувь нэмэр;
- Үндэсний нийт орлого (ҮНО)-д үндэслэсэн шимтгэл;
- Мөн, 2021 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дахин боловсруулаагүй хуванцар сав баглаа боодлын хаягдалд суурилсан үндэсний шинэ татварыг Европын Холбооны төсвийн орлогын эх үүсвэр болгон нэвтрүүлж байна.

¹⁷³ Recovery and Resilience Facility – Grants allocation per Member State, https://ec.europa.eu/info/files/recovery-and-resilience-facility-grants-allocation-member-state_en

“Шинэ эриний Европын Холбоо” хөтөлбөрийг санхүүжүүлэхэд Европын Комисс Европын Холбооны нэрийн өмнөөс гишүүн орнуудаас илүү таатай нөхцөлөөр зээл авч, дахин хуваарилалт хийх юм.

Европын Комисс нь 4 хөтөлбөрийн хүрээнд ЕХ болон гуравдагч орнуудад олгох зээлийг санхүүжүүлэхэд бонд гаргаж байгаа бөгөөд үүнд 100 тэрбум еврогийн санхүүжилт бүхий ажлын байрыг дэмжих, хүмүүсийг ажилтай байлгах баталгаатай SURE (Support to mitigate Unemployment Risks in an Emergency) хөтөлбөр багтаж байна.

Евразийн эдийн засгийн холбоо¹⁷⁴

Цар тахлын үед ЕАЭЗХ-ноос гаргасан гол шийдвэрүүд, хэрэгжүүлсэн арга хэмжээ

Евразийн комисс нь цар тахлын халдварын тархалтад шуурхай хариу арга хэмжээ авч байна. ЕАЭЗХ-ны эдийн засгийн байдлыг тогтворжуулах, сэргээхэд чиглэсэн шийдвэрүүд нь гишүүн орнуудад чухал ач холбогдолтой бөгөөд түр зуурын болон дунд хугацааны арга хэмжээнүүдийг хамаарч байна.

2020 оны 4-р сарын 14-нд Ковид-19 цар тахалтай холбогдуулан Евразийн эдийн засгийн дээд зөвлөлийн гишүүдийн хамтарсан мэдэгдэл гаргаж гишүүн орнуудын төрийн тэргүүнүүд цар тахлын сөрөг үр дагаврыг арилгах, интеграцийн хамтын ажиллагааны хүрсэн түвшинг хадгалах, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын эдийн засгийн цаашдын хөгжлийг хангах, нийгэм, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нягт уялдаа холбоотой ажлаа үргэлжлүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын засгийн газар, төв (үндэсний) банкууд болон Евразийн эдийн засгийн комисст цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах дотоод зах зээл, түүний дотор хүнсний салбар, ЕАЭЗХ-ны орнуудын иргэд, аж ахуйн нэгжүүдийг цар тахлын сөрөг үр дагаврыг даван туулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр нэгдсэн арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

Гишүүн орнуудын цар тахлын тархалтын сөрөг үр дагаврыг бууруулах хамгийн чухал хамтарсан баримт бичиг бол Евразийн Засгийн газар хоорондын зөвлөлийн 2020 оны 4-р сарын 10-ны өдрийн "Ковид-19 цар тахал тархаж буйтай холбогдуулан эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад ЕАЭХ-ны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" дугаар бтусаал¹⁷⁵ юм. Гишүүн орнууд эдийн засгаа сэргээх, цаашид хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх олон арга хэмжээг баталсан. Үүнд: худалдааг дижитал хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх; макро эдийн засаг, санхүүгийн

¹⁷⁴ ЕАЭЗХ нь гишүүн улсуудын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа, өрсөлдөөний орчныг сайжруулах, улсуудын амьжиргааны түвшинг дээшлүүлэн иж бүрэн, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор 2014 онд байгуулагдсан.

Евразийн эдийн засгийн холбооны дээд байгууллага нь гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын уулзалт болох бөгөөд Евразийн эдийн засгийн холбооны интеграцчиллын өдөр тутмын үйл ажиллагааг Евразийн комиссоос удирдаж байна. Комиссын бүрэлдэхүүнд Армения, Беларусь, Казахстан, ОХУ, Киргизийн төлөөлөгчид ордог.

Евразийн эдийн засгийн холбоо нь 2015.1.15-аас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Мөн Евразийн эдийн засгийн холбооны бүрэлдэхүүнд мөн Евразийн Өндөр технологийн төв, Евразийн биотехнологийн улс хоорондын хөтөлбөр, Евразийн хямралын эсрэг сан, Евразийн хөгжлийн банк багтдаг.

Евразийн эдийн засгийн холбоо нь нийт 20 сая гаруй км2 газар нутагтай буюу хуурай газрын газрын 15%-ийг хамарч, энд 182,1 сая хүн амьдарч, 2 411,2 тэрбум ам. долларын ДНБ, түүний дотор 1,3 их наяд ам.долларын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, байгаа бол тэдний худалдааны эргэлт 2014 онд 877,6 тэрбум ам. доллар байжээ.

<http://mfa.gov.mn/монгол-улс-евразийн-эдийн-засгийн-хол>

¹⁷⁵ Распоряжение Евразийского межправительственного совета 10 апреля 2020 года № 6 «О предпринимаемых в рамках Евразийского экономического союза мерах, направленных на обеспечение экономической стабильности в условиях развития пандемии коронавирусной инфекции COVID-19», https://docs.eaeunion.org/docs/ru-ru/01425377/ico_16042020_6

тогтвортой байдлын асуудлаар үндэсний (төв) банкуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх; үнийн үндэслэлгүй өсөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хянах, шуурхай арга хэмжээ авах; Холбооны гуравдагч орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийх талаарх яриа хэлэлцээрийг түргэсгэх, хэрэгжүүлэх; Евроазийн тогтворжилт, хөгжлийн сангаар дамжуулан гишүүн орнуудын макро эдийн засгийг тогтворжуулахад зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх, Евразийн хөгжлийн банкнаас гишүүн улс орнуудтай хамтран цар тахлын халдвартай тэмцэх төслийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгсөн.

Дээрх хүрээнд ЕАЭЗХ-ноос 2020 оны 4-5 дугаар сард гишүүн орнууд болон ЕАЭЗХ-ны хөгжлийн төсөөллийг эдийн засгийн рецесс (цар тахал 2020 онд үргэлжлэх) мөн эдийн засгийн депресс/уналт (цар тахлын үргэлжлэх хугацаа удаан, шинэ голомт үүсэх) хувилбартайгаар, авч хэрэгжүүлэх болох хариу арга хэмжээний хамт боловсруулсан. Үүний зэрэгцээ “Өөрийн хүч чадлын төв” (*Собственный центр силы*) хувилбарыг боловсруулж, ЕАЭЗХ-г 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд ЕАЭЗХ-ны газар нутагт “хүч чадлын төв” буюу инновац, хөрөнгө оруулалт, өндөр мэргэшсэн боловсон хүчинг татан төвлөрүүлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх төв болох зорилтыг дэвшүүлээд байна.

ЕАЭЗХ-ны зүүс "Өөрийн хүч чадлын төв" хувилбарыг амжилттай хэрэгжүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг нь олон улсын хамтын ажиллагаа болохыг онцолж, энэ хүрээнд ЕАЭЗХ болон БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилгыг холбохыг тэргүүний зорилтоор тодорхойлсон байна. Хятад нь ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын худалдаа, эдийн засгийн стратегийн түнш болохын хувьд талуудын илүү нягт хамтран ажиллах сонирхлыг нэмэгдүүлж байна.¹⁷⁶

2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр БНХАУ-ын дарга Ши Жиньпин “Дорнын эдийн засгийн форум”-д оролцоходоо “Нэг бүс, нэг зам” санаачилга болон ЕАЭЗХ-ын хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэсэн. Мөн тэрээр “Бид (мөн) дижитал эдийн засгийн инновацийн хөгжлийг дэмжих, дэлхийн цаг уурын өөрчлөлттэй хамтдаа тэмцэх, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих хэрэгтэй.” гэжээ.¹⁷⁷

Хүснэгт 9. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг үр нөлөөллийг бууруулахад авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ¹⁷⁸

	Армени	Беларусь	Казахстан	Киргиз	ОХУ
I. Эрүүл мэндийн тогтолцоог дэмжих чиглэлээр					
Эрүүл мэндийн тогтолцооны үйл ажиллагааг хангах	v	v	v	v	v
Эрүүл мэндийн ажилчдад олгох зорилтот төлбөр ба энэ салбарыг дэмжих бусад арга хэмжээ	v	v	v	v	v
Биотехнологи, олон нийтийн хамгааллын хөтөлбөрүүд	v	v			v
II. Иргэдийн орлогыг дэмжих чиглэлээр					
Зорилтот бүлэгт чиглэсэн дэмжлэг (нийгмийн хамгаалал)	v		v	v	v
Санхүүгийн дэмжлэг (нэг хүнд ногдох "суурь орлого")	v		v	v	v
Хөнгөлөлттэй зээл, зээлийн хугацааг сунгах	v		v	v	v

¹⁷⁶ Место ЕАЭС в мире стратегических изменений: сценарий «Собственный центр силы» на основе научно-технологического прорыва - долгосрочный ответ на вызовы глобального экономического кризиса, вызванного пандемией; АНАЛИТИЧЕСКИЙ ДОКЛАД, Москва, октябрь 2020, <https://eec.eaeunion.org/upload/medialibrary/f98/Doklad-Mesto-EAES-v-mire.pdf>

¹⁷⁷ <https://www.aa.com.tr/en/asia-pacific/eurasian-economic-union-belt-and-road-initiative-need-to-deepen-cooperation-china/2354500>

¹⁷⁸ Мөн тэнд

Хоол хүнс болон бусад шууд тусламжийн хөтөлбөрүүд	v	v	v	v	v
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээгээр дамжуулан дэмжлэг үзүүлэх (давтан сургах, ажлын байраар хангах гэх мэт)	v		v		v
III. Бодит салбарын дэмжлэг					
Санхүүгийн дэмжлэг (хөнгөлөлттэй зээл, зээлийн хугацааг сунгах гэх мэт)	v	v	v	v	v
Татварын хөнгөлөлт үзүүлэх	v	v	v	v	v
Төсвийн шууд дэмжлэг (түрээсийн хөнгөлөлт, чөлөөлөлт, "үндсэн орлого" гэх мэт)	v	v	v	v	v
Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих	v	v	v	v	v
Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих	v	v	v	v	v
IV. Санхүүгийн салбарын дэмжлэг					
Түргэн хөрвөх чадварыг хангах	v		v	v	v
Зохистой бодлогын арга хэмжээ	v	v	v	v	v

Эх сурвалж: ЕАЭЗХ

БҮЛЭГ 4.КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДАРААХ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

4.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Эдийн засгийн нөхцөл байдал

Ковид-19 цар тахлын улмаас АНУ-ын эдийн засгийн өсөлтөд урьд өмнө гарч байгаагүй хэлбэлзэл бий болсон хийгээд эдийн засаг бүхэлдээ 3.5%-аар буурчээ. 2020 оны эцсийн байдлаар тус улсад ажлын байр цар тахлын өмнөх үеийнхээс ойролцоогоор 10 саяар цөөрч, ажиллах хүчний оролцооны түвшин 63.3%-аас 61.4% болж буурчээ. Цар тахлын хөл хорионы улмаас эмэгтэй ажилтнууд давамгайлсан үйлдвэр, үйлчилгээний газрууд хаагдан, сургууль цэцэрлэгүүд хаалгаа барьсны улмаас гэртээ хүүхдээ асрах шаардлагатай болсноор өнгөрсөн нэг жилийн хугацаанд 2 сая гаруй эмэгтэйчүүд ажлаас гарсан байна.

2021 оны 3 дугаар сарын байдлаар эдийн засгийн өсөлт нэмэгдсэн нь иргэдийг вакцинжуулалтад эрчимтэй хамруулснаар хөл хориог сулруулж, бизнесүүд үүд хаалгаа нээн, хэрэглэгчдийн зарцуулалт нэмэгдсэнтэй шууд холбоотой байна. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 1983 оны 12 дугаар сараас хойших дээд хэмжээнд хүрч, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаа 1990-ээд оны сүүл үеэс хамгийн дээд түвшинд хүрсэн гэж Хангамжийн удирдлагын хүрээлэн (Institute for Supply management)-ээс мэдээлсэн байна.

Жижиглэн худалдааны зарцуулалтын зардал нь (2021 оны 3 дугаар сарын байдлаар) өмнөх сараас бараг 10%-аар өссөн бөгөөд энэ нь айл өрхүүдэд чиглэсэн Холбооны санхүүжилтийн (Federal financial) багц тусламжууд нэмэгдэн эдийн засаг сэргэж эхэлж байгаатай холбоотой гэж үзэж байна. 1 сая ажлын байр бий болж, ажилгүйдлийн түвшин 2 дугаар сард 6.2% байсан бол 6% болж буурчээ. Эдийн засаг сэргэж, хэвийн байдалдаа эргэн орохоор чармайж байгаа ч нийлүүлэлт хязгаарлагдмал байгаа нөхцөлд үнийн өсөлтийг бий болгож, инфляцыг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Хөдөлмөрийн алба (Labor Department)-аас мэдээлснээр вакцинжуулалт нэмэгдэж, Холбооны засгийн газраас хэрэгжүүлсэн санхүүгийн багц тусламж иргэдийн гар дээр очсоноор хэрэглээний түвшин төдий хэмжээгээр нэмэгдэж, 2012 оны 8 дугаар сараас хойш тогтвортой байсан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг 0.6%-аар нэмэгдүүлсэн байна. Гэвч энэхүү үнийн өсөлт нь түр зуурын шинжтэй гэж үзэж байгаа юм.

Вакцинжуулалтын ажил хурдацтай явагдаж, Холбооны засгийн газраас хэрэгжүүлж буй санхүү, мөнгөний тэтгэмжийн тусламжтайгаар АНУ-ын эдийн засаг 2021 онд 6.5%-аар өснө гэж Холбооны нөөцийн алба (Federal Reserve)-наас үзэж байна. Гэвч АНУ-ын эдийн засаг бүхэлдээ сэргэх хүртэл нэлээдгүй хугацаа шаардлагатай байгаа бөгөөд 2021 оны 3 дугаар сарын байдлаар 27 болон түүнээс дээш долоо хоногийн хугацаанд ажилгүй байсан иргэдийн тоо өмнөх сард 4.1 сая байснаас 4.2 сая болж нэмэгдсэн байна. Бага цалинтай иргэд ажилгүйдэлд илүү өртөж байна. 15 сая гаруй иргэд орон байрны түрээсийн төлбөрөө төлөх боломжгүй, 24 сая насанд хүрэгчид болон 12 сая гаруй хүүхэд хоол тэжээлийн хомсдолд, 80 сая гаруй иргэн өрхийн энгийн хэрэглээний зардлаа нөхөх боломжгүй байна.¹⁷⁹

Хууль, бодлогын баримт бичгүүд

Эдийн засгийг сэргээх, тогтворжуулахад шаардлагатай улс орныг бүхэлд нь хамарсан төрийн бодлогыг шат дараатай хэрэгжүүлсээр байна. Үүнд, 2020 онд 4 удаагийн санхүүгийн багц тусламжийн тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн байна. Эдгээр багц тусламжууд нь нийт дүнгээрээ 4 их наяд ам доллар болжээ:

1. Коронавирусийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нэмэлт хөрөнгө төсөвлөх тухай хууль 2020 (Coronavirus Preparedness and Response Supplemental Appropriations Act 2020)
2. Гэр бүлүүд тэргүүн ээлжинд Коронавирусийн эсрэг хариу арга хэмжээний тухай хууль (Families first Coronavirus Response Act 2020)
3. Коронавирусийн эсрэг тусламж дэмжлэг, эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль (Coronavirus Aid, Relief, and Economic Security Act 2020 (CARES Act))
4. Нэгдсэн төсөвт хөрөнгийн тухай хууль (Consolidated Appropriations Act 2020) зэрэг болно.

2021 онд Ерөнхийлөгч Жое Байден АНУ-ын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх **“Илүү сайнаар бүтээ”** (Build Back Better)¹⁸⁰ гурван хэсэг хөтөлбөрийг санаачлан боловсруулсан байна. Хөтөлбөрийн эхний хэсэг **“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”** (American Rescue Plan Act) хуулийг боловсруулан баталж, 1.9 их наяд ам долларын санхүүгийн багц тусламжийг хэрэгжүүлж эхлээд байна.¹⁸¹ Хөтөлбөрийн 2 дахь хэсэг болох дэд бүтцийг сайжруулах, сая сая ажлын байр бий болгохоор төлөвлөсөн 2 их наяд ам долларын төсөв шаардагдах **“Америкийн ажлын байр хөтөлбөр”** (American Jobs plan)-ийг боловсруулсан байна.¹⁸² Хөтөлбөрийн 3 дахь хэсэг дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилго бүхий иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд асрах үйлчилгээнд 1.8 тэрбум ам долларын хөрөнгө оруулалт шаардагдах **“Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”** (American families plan)-ийг боловсруулсан байна.¹⁸³

“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”

2021 оны Гуравдугаар сард **“Америкийг хямралаас гаргах хөтөлбөр”** (American Rescue Plan Act) хуулийг боловсруулан баталж, 1.9 их наяд ам долларын санхүүгийн багц тусламжийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ нь 2020 оны төсвийн 8.8%-ийг эзэлж байна. Энэхүү багц тусламжийг жижиг бизнес эрхлэгчдийг дамжих, үйл ажиллагааг нь тогтворжуулах, иргэдийг вакцинжуулалтад бүрэн хамруулах, сургууль цэцэрлэгүүдийг нээх, ажилгүй болсон иргэд, айл өрхүүдэд амьжиргааны тэтгэмж олгох,

¹⁷⁹ https://www.cepal.org/sites/default/files/news/files/c2100263_web.pdf

¹⁸⁰ <https://www.whitehouse.gov/build-back-better/>

¹⁸¹ <https://www.whitehouse.gov/american-rescue-plan/>

¹⁸² <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/03/31/fact-sheet-the-american-jobs-plan/>

¹⁸³ <https://www.whitehouse.gov/american-families-plan/>

хүүхдийн татварын хөнгөлөлтөд хамруулах, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах зэрэг ажил эрхэлдэг гэр бүлүүд рүү түлхүү анхаарсан зохицуулалтуудыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тус хөтөлбөр нь доорх бүтэцтэй байна:

- Муж, орон нутгийн засаг захиргааны байгууллагад үзүүлэх тусламж;
- Иргэдийн гарт шууд олгох тэтгэмж;
- Татварын орлогоос олгох тэтгэмж;
- Ажилгүйдлийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох;
- Жижиг бизнесийг дэмжих;
- Эрүүл мэнд, иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээнд олгох тэтгэмж;
- Medicaid/Medicare эрүүл мэндийн улсын даатгалын санхүүжилт;
- Хүнс тэжээлийн тусламж;
- Улсын аюулгүй байдалд;
- Хөдөө аж ахуйд;
- Тээвэр, дэд бүтцийн салбарт;
- Боловсролын салбарт;
- Хүрээлэн буй орчныг хамгаалахад;
- Цахилгаан, эрчим хүч, усны хэрэглээний үнийг бууруулахад;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад;
- Иргэдийг орон байр, түрээсийн байранд хамруулахад;
- Ахмад дайчдад олгох тэтгэмж;
- Технологи, цахим орчны хурд, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд зэрэг болно.

Эдгээрээс онцлох зохицуулалтуудыг авч үзвэл:

- Жилийн 75000\$ ам доллароос бага орлоготой иргэд болон тэдгээрийн асран хамгаалагчдад 1400\$ ам доллар хүртэлх тэтгэмжийг шууд олгоно. Жилдээ 75000\$ ам доллароос илүү орлоготой иргэдэд тэтгэмжийн дүнг бууруулж олгоно. Жилдээ 100000\$ ам доллароос илүү орлоготой иргэдийг энэхүү тэтгэмжид хамруулахгүй.
- Хүүхдийн татварын хөнгөлөлтийн жилийн дээд хязгаар 6-17 насны хүүхдэд 2000\$ ам доллар байсныг 3000\$ ам доллар болгож, 6 наснаас доош хүүхдэд 3600\$ ам доллар болгон нэмэгдүүлсэн байна. Энэхүү нэмэгдэл дүнгээр ирэх жил мөн олгох бөгөөд жилдээ 150000\$ ам долларын орлого бүхий өрхийг болон жилдээ 112500\$ ам долларын орлого бүхий өрх толгойлсон иргэдийг энэ тэтгэмжид хамруулахгүй.
- 2021 оны Есдүгээр сарын 06-ыг хүртэл сунгасан ажилгүйдлийн өргөтгөсөн даатгалаар долоо хоногт нэг хүнд 300\$ ам долларын ажилгүйдлийн тэтгэмж олгоно.
- Жилийн 150000\$ ам доллараас бага орлоготой өрхүүдэд 10200\$ ам долларын тэтгэмж олгох бөгөөд энэхүү тэтгэмжийг холбооны татвараас чөлөөлнө. Гэрлэсэн хосууд хоёулаа хүсэлт гаргасан тохиолдолд тэтгэмжийн дүнг 2 дахин нэмэгдүүлэн олгоно.
- Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг эхлүүлэх, жигдрүүлэхэд зориулж 130 тэрбум ам долларын санхүүжилт олгоно.
- Дээд боловсролын санхүүжилтэд 39 тэрбум ам долларыг төсөвлөсөн.
- Ковид-19 халдвараас сэргийлж иргэдийг вакцинжуулах, оношлох, өвчний явцыг хянах, оношлуур болон хувийн халдвар хамгааллын хэрэгслийн хангамж, нөөцийг бүрдүүлэх зэрэг Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих төвийн үйл ажиллагаанд зориулж 55.5 тэрбум ам долларыг төсөвлөсөн.

- Ковид-19 цар тахлын улмаас орон байраа алдсан иргэдийг “Коронагийн эсрэг тусламжийн сан”-аар дамжуулан нэн яаралтай түрээсийн байранд хамруулах, орон гэргүй иргэдийг 2030 он хүртэл нэн яаралтай болон урт хугацаанд орон сууцжуулах зэрэг үйл ажиллагаанд 27.4 тэрбум ам долларыг төсөвлөсөн байна.
- Жижиг бизнес эрхлэгчдэд буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулж 25 тэрбум ам долларыг төсөвлөсөн.
- Хүүхэд асрах үйлчилгээнд зориулж 40 тэрбум ам долларыг төсөвлөсөн бөгөөд үүнээс 15 тэрбум ам долларыг хүүхэд асрах туслах үйлчилгээнд, 25 тэрбум ам долларыг хүүхэд асрах үйлчилгээ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа тасалдуулахгүй үргэлжлүүлэн гүйцэтгэх болон цаг хугацаанд нь ажилчдынхаа цалин хөлсийг тавихад зориулан төсөвлөсөн.
- Агаарын тээврийн салбарт ажиллагсдыг дэмжих зорилгоор 15 тэрбум ам долларыг төсөвлөсөн.

“Америкийн ажлын байр хөтөлбөр”

2021 оны Гуравдугаар сард Ерөнхийлөгч Жое Байден 8 жилийн хугацаанд 2 их наяд ам долларын төсвөөр хэрэгжүүлэх “Америкийн ажлын байр хөтөлбөр”-г боловсруулан танилцуулсан байна. Энэ нь АНУ-д ирэх 10 жилийн хугацаанд жил бүр 2 сая ажлын байрыг шинээр бий болгох, дэд бүтцийг шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох зэрэг томоохон асуудлуудыг хамарч дараах салбаруудад санхүүжилт олгохоор төлөвлөжээ.

- Ажиллах хүчний хөгжил
- Үйлдвэрлэл, жижиг бизнес
- Шинэ техник, технологийн судалгаа шинжилгээ, зохион бүтээх, үйлдвэрлэх, ажлын байрны сургалт
- Улсын сургууль, коллеж
- Ахмад дайчдын эмнэлэг
- Иргэдийн байр, орон сууц
- Эрчим хүчний дэд бүтэц/Цэвэр эрчим хүч
- Өндөр хурдны интернэт
- Усны систем/Цэвэр ундны ус
- Байгаль орчны нөхөн сэргээлт
- Нийтийн тээвэр
- Ачаа тээвэр/агаарын болон усан зам, төмөр замын тээвэр/ зэрэг болно.

Эдгээр салбарын санхүүжилтийг “Америкт үйлдвэрлэв татварын хөтөлбөр” (Made in America Tax Plan)-өөр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Татварын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2036 он хүртэл 2 их наяд ам доллар бүрдүүлэх төлөвлөгөөтэй байна.

Үүнд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн:

- Аж ахуйн нэгжийн татварын хэмжээг 21%-аас 28% болгон нэмэгдүүлэх
- АНУ-ын үндэстэн дамнасан корпорациудад дэлхийн татварын доод хэмжээг тогтоох;
- Татвараас зайлсхийж байгаа улс орнуудад санхүүгийн урамшуулал олгох замаар дэлхийн аж ахуйн нэгжийн орлогын доод татварыг дэмжих;
- Америкт байрладаг гадаадын компанитай нэгдсэн томоохон корпорациудаар холбооны орлогын албан татвар төлүүлэх;
- Оффшор дахь ажлын байрны татварын хөнгөлөлтийг цуцлах, АНУ-д ажиллахыг урамшуулах;

- Жилийн 100 сая доллараас дээш ашигтай томоохон корпорациудын ашгийн татварыг 15 хувиар доогуур тогтоох;
- Түлшийг татварын хөнгөлөлтөөс чөлөөлж, хүрээлэн буй орчноо бохирдуулж буй үйлдвэрүүдээс нөхөн сэргээх зардлын төлбөрийг “Superfund”-д төлүүлэх;
- Татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, корпорациуд болон өндөр орлоготой иргэдийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг хийх зэргээр татвараас санхүүжилтийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

“Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”

2021 оны Дөрөвдүгээр сард АНУ-ын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх “Илүү сайнаар бүтээе” (Build Back Better) багц хөтөлбөрийн 3 дахь нь буюу “Америкийн гэр бүлүүд хөтөлбөр”-ийг танилцуулсан байна. Тус хөтөлбөрөөр ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийх, чанартай, өндөр цалинтай ажлын байр бүхий дундаж давхаргынхныг бий болгоход түлхүү анхаарч боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд асрах үйлчилгээ зэрэгт нэлээдгүй хөрөнгө оруулахаар төлөвлөжээ.

- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс боломжийн өртөгтэй болгох:
 - Олон сая Америкчуудад зориулан Олон нийтийн коллежид 2 жил төлбөргүй сурах боломжийг олгох;
 - Нийт 3-4 настуудыг сургуулийн өмнөх чанартай сургалтад хамруулах;
 - Бага болон дунд орлоготой өрхийн оюутнуудын сургалтын төлбөрийг хөнгөлөх;
 - Оюутнуудыг сургуулиа төгсөх боломжоор хангах;
 - Багш бэлтгэх, багшийн хомсдлыг арилгах, өнгөт арьстай багш нарын тоог нэмэгдүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зэрэгт зориулан 9 тэрбум ам долларын санхүүжилт олгох.
- Айл өрхүүдийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах:
 - Мужийн дундаж орлогын 150%-аас доогуур орлоготой иргэн орлогынхоо 7-оос дээш хувийг хүүхэд асрах үйлчилгээнд зарцуулахгүй байхад анхаарах;
 - Ажил эрхлэгчдэд шинээр төрүүлсэн хүүхдээ асрах, өөрөө өвдөх, гэр бүлийн гишүүд нь өвдөх зэрэгт цалинтай чөлөө олгох;
 - Хоол хүнсний тусламжийг нэмэгдүүлэх, Сургуулийн хоолны хөтөлбөр болон Зуны хоол тэжээлийн хөтөлбөрт хүүхэд болон айл өрхүүдийг хамруулах;
 - Эхийн эрүүл мэндэд 3 тэрбум ам долларын хөрөнгө оруулалт хийх.
- Ажил эрхлэгч иргэд болон айл өрхүүдийн татварын хөнгөлөлтийг өргөжүүлэх зэрэг болно.

Тус хөтөлбөрийн тодорхой хэсгийг “Америкт үйлдвэрлэв татварын хөтөлбөр”-ийн дагуу өндөр орлоготой Америк иргэд болон хөрөнгө оруулагчдад ногдуулах татварын өсөлтөөс олсон орлогоор санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна. Тодруулбал, орлогын албан татварын дээд хэмжээг 2017 оноос өмнөх түвшинд буюу 39.6% болгох, жилийн 1 сая ам доллароос илүү орлоготой иргэдийн орлогын албан татварыг ойролцоогоор 2 дахин нэмэгдүүлэх, өвлөгдсөн хөрөнгөнөөс татвар авахгүй байх тухай татварын хуулийн заалтыг хасах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Ногоон эдийн засаг

Ерөнхийлөгч Байден 2021 оны 4 дүгээр сард “2030 он хүртэл хүлэмжийн хийн бохирдлыг бууруулах зорилт” (2030 Greenhouse Gas Pollution Reduction Target)¹⁸⁴-ыг дэвшүүлсэн байна. Тодруулбал, 2030 он хүртэл АНУ-ын хэмжээнд хүлэмжийн хийн бохирдлыг 2005 оны түвшингээс 50-52% хүртэл бууруулах зорилтыг тавьжээ. Урт хугацаандаа буюу 2050 он гэхэд АНУ нь дотооддоо болон гадаадад уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэн, улс орон даяар хүлэмжийн хийн бохирдлыг 0 түвшинд хүргэж, дэлхийн дулаарлыг 1.5 С-ийн хэмээр бууруулна гэсэн зорилтыг тавьжээ. Энэ нь “Америкийн ажлын байр хөтөлбөр”-ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, шаардлагатай дэд бүтцийг сэргээн засварлах, үүнийг дагаад өндөр цалинтай, үйлдвэрчний эвлэлд харьяалагддаг олон сая ажлын байрыг бий болгох, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, байгаль орчинтой зөв харьцах, АНУ даяар иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулах зорилтын нэг хэсэг болж байгаа юм. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Дэд бүтэц, инновацад хөрөнгө оруулан, цаашид ашиглаж болох цэвэр технологийг үйлдвэрлэх, ашиглах;
- Ажлын байр бий болгох эдийн засгийг сэргээх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих;
- Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, АНУ-д үйлдвэрлэсэн, байгальд ээлтэй, цэвэр эрчим хүчний бүтээгдэхүүнээр дэлхийг хангах.
 - 2035 он гэхэд 100% нүүрстөрөгчийн бохирдолгүй цахилгаан үйлдвэрлэх;
 - эрчим хүчний зардлыг бууруулах дэвшилтэт технологийг байр, орон сууцнуудад нэвтрүүлэх
 - зам тээврийн салбар дахь нүүрстөрөгчийн бохирдлыг бууруулах;
 - үйлдвэрлэлийн үйл явц дахь нүүрстөрөгчийн бохирдлын асуудлыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зориод байна.

4.2. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

Ковид-19 цар тахал дэгдсэнээс хойш дэлхийн улс орнууд нийгэм, эдийн засгийн хохирол амсаж буй энэ үед улс бүрийн засгийн газар өөрийн боломж, нөөцөд тулгуурлан иргэд, аж ахуйн нэгж, макро эдийн засгаа дэмжих бодлого явуулахаас гадна хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор төсвийн орлого зарлагыг тодотгож цар тахалтай тэмцэхэд нэмэлт хөрөнгийг зарцуулж байна.

Өнөөгийн нөхцөл байдал

БНХАУ-д 2021 оны 9 дүээр сарын 1-ний өдрийн байдлаар Ковид-19-ийн өвчлөлийн 94,898 тохиолдол батлагдаж 89602 өвчтөн эдгэж 4,636 хүн нас барсан¹⁸⁵. Цар тахал энх дэгдсэнээс хойш Засгийн газраас Хубэй мужид хорио цээр тогтоох, улсын хэмжээнд хөдөлгөөнийг хязгаарлах, бөөгнөрлийг хориглох, буцаж ирсэн цагаач ажилчдыг 14 хоног тусгаарлах зэргийг багтаасан хатуу хориг арга хэмжээ авсан. Эдгээр хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засаг 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 6.8 хувиар буурчээ.¹⁸⁶


Дотоодын нийт бүтээгдэхүүн: Хятадын ДНБ 2021 оны эхний улиралд 0.4 хувь байсан бол 7 дугаар сард 1.3 хувь болж өссөн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 хувиар өссөн байна. 2020 оны 1 дүгээр сард Хятад Улсад цар тахалтай холбоотой хориг арга хэмжээнээс үүдэлтэй ДНБ -9.3 хувь болж буурсан бол 7 дугаар сараас эргэн өссөн байна.

¹⁸⁴ <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/04/22/fact-sheet-president-biden-sets-2030-greenhouse-gas-pollution-reduction-target-aimed-at-creating-good-paying-union-jobs-and-securing-u-s-leadership-on-clean-energy-technologies/>

¹⁸⁵ <https://www.worldometers.info/coronavirus/country/china/>

¹⁸⁶ <https://qz.com/1839062/china-gdp-contracts-6-8-percent-in-first-quarter-due-to-coronavirus/>


Зураг 10. Дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлт (2018-2021 он)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдэл: БНХАУ-ын хот суурин газрын ажилгүйдлийн түвшин өмнөх сар буюу 2021 оны 6 сард 5.0 хувьтай байсан бол 7 дугаар сард 5.1 хувь болж өссөн байна. 16-24 насны хүн амын ажилгүйдлийн түвшин зургадугаар сард 15.4 хувь байсан бол 7 дугаар сард 16.2 хувь болж өсжээ. Хятадын хот суурин газрын ажилгүйдлийн түвшинг түүвэр судалгаагаар тооцдог бөгөөд энэ нь хотын ажилгүй хүн амыг ажил эрхэлж буй хүн амын тоон дээр нэмж ажилгүй иргэдтэй харьцуулсан харьцаа юм.


Зураг 11. Хятад Улсын ажилгүйдлийн түвшин (2020.10-2021.07)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

Инфляцийн түвшин: БНХАУ-ын жилийн инфляцын түвшин 2021 оны 7-р сард өмнөх оны мөн үеийн 1.1% хувиар 1.0% болж буурсан байна. Энэ нь 4-р сараас хойших хамгийн доод түвшинд хүрсэн үзүүлэлт ба хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом буурсан байна. Харин хүнсний бус бүтээгдэхүүний үнэ 7 дугаар сард 1.7%-иар өссөн нь байна. Инфляцид хамгийн ихээр өртсөн салбарт тээвэр, харилцаа холбооны салбар, хувцас үйлдвэрлэл, түрээс, түлш, нийтийн үйлчилгээний зардал, эрүүл мэнд, гэр ахуйн бараа, үйлчилгээ, боловсрол, соёлын салбар орж байна.


Зураг 12. Хятад Улсын инфляцын түвшин (2020.10-2021.07)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын төлөх өрийн хэмжээ: БНХАУ 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 66.80 хувьтай тэнцэх Засгийн газрын өрийг бүртгэжээ.


Зураг 13. Засгийн газрын төлөх өрийн хэмжээ (2010-2020 он)



Эх сурвалж: ОУВС

Хятад Улсын худалдааны тэнцэл: Хятадын гадаад худалдааны ашиг 2021 оны 7 -р сард 56.58 тэрбум ам.долларт хүрсэн бол өнгөрсөн оны мөн үед 60.5 тэрбум ам.долларын ашигтай ажиллаж байсан байна. Энэ нь (7 дугаар сарын гадаад худалдаа) түүхий эдийн үнийн өсөлт, коронавирусийн шинэ хэлбэрийн тархалт, цаг агаарын эрс тэс байдлаас шалтгаалан дэлхийн эрэлт буурсантай холбоотойгоор 1 дүгээр сараас хойш хамгийн том худалдааны ашиг болсон. Экспорт өмнөх оны мөн үеэс 19.3-хувиар өсөж 282.66 тэрбум ам.долларт хүрсэн бол импорт 28.1 хувиар өсөж 226.08 тэрбум болжээ.

Зураг 14. Хятад Улсын худалдааны тэнцэл (2020.10-2021.07)



Эх сурвалж: БНХАУ-ын Гаалийн ерөнхийн газар

Хүснэгт 10. БНХАУ-ын эдийн засгийн төлөв, Дэлхийн банк.

БНХАУ-ын эдийн засгийн төлөв China Economic Outlook	2018	2019	2020F	2021F	2022F
ДНБ-ний өсөлт Real (%) GDP growth	6.6	6.1	2.0	7.9	5.2
Хэрэглээний үнийн индекс (% өөрчлөлт, дундаж) Consumer Price Index	2.1	2.9	2.5	1.8	2.0
Урсгал дансны үлдэгдэл (ДНБ-ний %) Current account balance	0.4	1.1	1.8	1.3	1.1
Төсвийн нэмэгдсэн тэнцэл (ДНБ-ний %) Augmented fiscal balance ^a	-4.6	-6.4	-11.8	-7.8	-6.4

Эх сурвалж: Дэлхийн банк (From Recovery to Rebalancing China economy in 2021)
F-Урьдчилсан таамаг

(a) Төсвийн нэмэгдсэн тэнцэл- Дэлхийн банкны тооцоогоор төсвийн санхүүжилт, засгийн газрын сангийн төсөв, улсын хөрөнгийн менежментийн сангийн төсөв, нийгмийн хамгааллын сан багтсан байдаг.

Эдийн засгийг сэргээх арга хэмжээ

2020 оны 2 дугаар сарын дунд үеэс эхлэн Засгийн газар шилжилт хөдөлгөөн болон үйл ажиллагааны хязгаарлалтыг аажмаар бууруулж, зайлшгүй шаардлагатай салбар, бүс нутаг, хүн амын бүлгүүдэд анхаарал тавьж, эрсдэлийг тасралтгүй үнэлж байна. Улсын хэмжээнд ихэнх аж ахуйн нэгж, сургууль дахин нээгдсэн боловч хүн хоорондын зай баримтлах дүрэм мөрдөгдөж, гадаадаас импортлох барааг хязгаарласан хэвээр байна. Шинжилгээ, эрүүл мэндийн QR кодыг вирусийн замыг тодорхойлох, дэгдэлтийг хумихад өргөн ашигладаг. Эдийн засгийн үйл ажиллагаа хэвийн болсноор ДНБ-ний хэмжээ 2 дугаар улиралд 3.2 хувиар (өмнөх оны мөн үеэс) сэргэж, 3 дугаар улиралд 4.9 хувиар нэмэгдсэн байв. Эдийн засгийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд 4.8 их наяд юанийн (ДНБ-ний 4.7 хувь) төсвийг зарцуулж голлон дараах арга хэмжээг авсан байна. Үүнд¹⁸⁷

- 1)Тархалтаас урьдчилан сэргийлэх, хяналт тавихад зарцуулах зардлыг нэмэгдүүлэх;
- 2) Эмнэлгийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх;

¹⁸⁷ Цар тахлын үед дэлхийн улс орнуудын Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авсан арга хэмжээ Э.Эрдэнэчимэг 2020

- 3) Ажилгүйдлийн даатгалын нөхөн олговрыг түргэсгэх, цагаач ажилчдад олгох;
- 4) Татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх;
- 5) Төсвөөс нэмэлт хөрөнгө гаргах зэрэг арга хэмжээ авсан. Шаардлагатай үед автоматаар хэрэгжиж эхлэх ёстой тогтворжуулах хөтөлбөрүүд нь төсвийн зардлыг улам бүр нэмэгдүүлдэг. Төсвөөс бусад төрийн нийт дэмжлэг улмаар илүү их байх төлөвтэй байна. Жишээлбэл, төсвийн бус дэмжлэгт ЖДҮ эрхлэгчдэд 400 тэрбум юанийн (ДНБ-ний 0,4 хувь) нэмэлт зээлийн батлан даалт, зам, боомт, цахилгаан ашигласны төлбөр ба тарифын хөнгөлөлтийн 900 тэрбум юань (ДНБ-ий 0.9 хувь) багтана.

Хятад Улс 1953 оноос эхлэн Эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөг боловсруулж ирсэн. 14 дэх удаагийн эдийн засгийн төлөвлөгөө (2021-2025) 5 дугаар чуулганы үер буюу 2020 оны 10 сард боловсруулсан ба 2021 оны 3 сард Бүх ард түмний 3 дугаар хуралдаанаар эцэслэсэн байна.¹⁸⁸

БНХАУ-ын Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө (2021-2025)

Эдийн засгийг хөгжүүлэх 14 дэх удаагийн 5 жилийн төлөвлөгөө голлох зорилтууд:

Эдийн засаг

- 2035 онд эдийн засгийн хөгжлийг дунд шатанд хүргэх
- Дотоодын эрэлтийг ихэсгэхэд анхаарах

Байгаль орчин

- 2060 онд нүүрстөрөгчийн ялгарлыг бага хэмжээнд хүргэх (low-carbon economy);
- 2035 онд гэхэд тээврийн хэрэгслийн 50%-ийг цахилгаан болон хосолсон (hybrid) хөдөлгүүртэй болгох;

Дотоод эргэлт

- Аж үйлдвэрийн нийлүүлэлтийг шинэчлэх
- Инноваци ба технологийн бие даасан байдал бий болгох
- Дэд бүтцийг сайжруулах

Гадаад эргэлт

- Экспортыг нэмэгдүүлэх
- Эдийн засгийг нээлттэй болгох

**Зураг 15. БНХАУ-ын эдийн засгийн замын зураг
(14 дэх удаагийн 5 жилийн төлөвлөгөө 2021-2025 он)**



¹⁸⁸ China's Economy: Recovery and Rebalancing Chris Kashlis, CFA March 2021

БНХАУ-ын эдийн засгийн урт хугацааны чиглэл

Хотжилт

- Хятад Улс 2019 оны байдлаар дэлхий дээрх хамгийн том буюу 843 сая иргэнтэй хотжилтыг үүсгээд байгаа ба энэ тоо цаашид өсөх хандлагатай байна.
- Жил бүр 10 сая хүн орон нутгаас шилжилт хийдэг бол мөн өөр 10 сая иргэн хотод ирж хотжилтыг улам тэлдэг байна.¹⁸⁹

Дэд бүтэц

- Авто зам, төмөр замаас эхлээд метроны систем, ус, хоолой, хог хаягдлыг цэвэрлэх, агаарын бохирдлыг бууруулах, боомт, нисэх онгоцны буудал зэрэг дэд бүтцийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх
- Дэд бүтцийг хөгжүүлэх нь БНХАУ-ын гадаад дотоод эргэлтийн гол түлхүүр хэмээн үзэж байна.

Дундаж давхаргыг нэмэгдүүлэх

- Хятад Улсад дундаж давхаргын иргэд 2005 онд 65 сая хүрсэн бол 2020 онд 700¹⁹⁰ саяыг давсан байна.

Санхүү болон мөнгөний бодлогын арга хэмжээ

Хятадын Төв банк нь мөнгөний бодлогын дэмжлэг үзүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалах чиглэлээр үр дүнтэй ажилласан. Гол арга хэмжээнд дараах зүйлс орно:¹⁹¹

- 1) Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар (урвуу репо ба дунд хугацааны зээлийн хэрэгслүүд) дамжуулан банкны системийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх;
- 2) Эмнэлгийн тоног төхөөрөмж болон өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч, бичил жижиг дунд үйлдвэрлэгч, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор 1.8 их наяд юанийн дахин зээл олгох, хөнгөлөлт үзүүлэх хэрэгслийг өргөжүүлэх. Хангамжийг сайжруулах үүднээс өдөр тутмын хэрэгцээт зүйлсэд зориулан дахин санхүүжилтээр 2020 оны 6 дугаар сарын сүүлчээр 0.8 их наядыг олгосон ба зээлийн хүүг 50 суурь пунктээр бууруулж мөн 25 суурь пунктээр өмнөх зээлд хөнгөлөлт үзүүлэхээр болсон;
- 3) 7 ба 14 хоногийн урвуу репо арилжааны хүүг 30 суурь пунктээр бууруулж, 1 жилийн дунд хугацааны зээлийн хэрэгслийн (MLF) хүү болон MFF-ийн зорилтот хүүг 30 ба 20 пунктээр тус тус бууруулсан;
- 4) Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд ашигтай, хүртээмжтэй санхүүжилтийн шалгуурыг хангасан том, дунд банкуудад хөрөнгө оруулалтын доод өгөөжийн шалгуурыг 50-100 суурь пунктээр бууруулах, шаардлага хангасан хамтарсан байгууллагуудад нэмэлт 100 пунктээр, хувьцаат банкуудад, ЖДҮ-ийг дэмжих зорилгоор жижиг, дунд банкуудад 100 суурь пунктээр тус тус бууруулав;
- 5) Илүүдэл нөөцийн хүүг 72-оос 35 суурь пункт болгон бууруулах;
- 6) Бодлогоор компани болон ЖДҮ-д нээх банкны зээлийн шугамыг 350 тэрбум юаниар өргөтгөх;

¹⁸⁹ China's Economy: Recovery and Rebalancing Chris Kashlis, CFA March 2021

¹⁹⁰ Ibid page 4

¹⁹¹ Э.Эрдэнэчимэг, Цар тахлын үед дэлхийн улс орнуудын Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авсан арга хэмжээ 2020

- 7) ЖДҮ-д зээлийн олголтыг дэмжих шинэ хэрэгслийг нэвтрүүлэх Үүнд: орон нутгийн банкуудын шинээр барьцаагүй олгох зээлийн 40 хувийг санхүүжүүлэх зорилгоор 400 тэрбум юанийн хүүгүй эх үүсвэрийг нийлүүлэх арга хэмжээг авсан.

Санхүүгийн нөхцөл байдлын хүндрэл бэрхшээлийг хязгаарлах олон арга хэмжээ, түүний дотор зээлийн эргэн төлөлт нь сааталтай тулгарсан айл өрх, корпорац, бүс нутгуудад санхүүгийн тусламж үзүүлэх зорилгоор тодорхой төлбөрийг хойшлуулах зэрэг олон арга хэмжээг тус улсын засгийн газар авсан. Үндсэн арга хэмжээг дурдвал:

- 1) ЖДҮ-ийн зээлийг хөхиүлэн дэмжих, үүнд орон нутгийн банкуудаас олгох барьцаагүй зээлийг дэмжих, томоохон банкуудын ЖДҮ-д өгөх зээлийн өсөлтийг 30 хувиас 40 хувьд хүргэх, банкуудын ЖДҮ-д зээл олгох үнэлгээний системийг бий болгох;
- 2) Зээлийн төлбөрийг хойшлуулах, хугацааг 2021 оны 3 дугаар сарын эцэс хүртэл сунгаж, онлайн зээлийн хэмжээний хязгаарлалтыг зөөлрүүлэх, шаардлага хангасан ЖДҮ эрхлэгчид болон өрхүүдэд зээлийн дэмжлэг үзүүлэх бусад арга хэмжээ;
- 3) Чанаргүй зээлийн эрсдэлийн сангийн шимтгэл байгуулах шаардлагуудыг зөөлрүүлэх;
- 4) ЖДҮ-ийн зээлийг санхүүжүүлэх зорилгоор санхүүгийн байгууллагуудаас бонд гаргахад дэмжлэг үзүүлэх;
- 5) Корпорацуудын бонд гаргалтыг нэмэгдүүлэх замаар корпорацуудад нэмэлт санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, үүнд даатгалын компанид бондын хөрөнгө оруулалтыг хийхэд тавигдах шаардлагыг багасгах;
- 6) Зээлийн баталгаанд татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх;
- 7) Хөрөнгийн менежментийг хэрэгжүүлэх уян хатан байдлыг хангах зэрэг арга хэмжээ авсан.

Ковид-19 цар тахлын үед ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээ

Дэлхийн банкнаас 2020 оны 4 дүгээр сард нийтэлсэн “Ковид-19 цар тахлын үед ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээ” судалгаанаас БНХАУ-д авч хэрэгжүүлсэн арга хэмжээг түүвэрлэн доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 11. Ковид-19 цар тахлын үед ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээ: БНХАУ

Төрөл	Авсан арга хэмжээ	Тайлбар
Бизнесийн орчин	Түүхий эдийн (intermediate goods) инпортийг нэмэгдүүлэх хориг арга хэмжээг багасгах	<ul style="list-style-type: none"> • Арилжааны даатгалын компаниуд богино хугацааны экспортын зээлийн даатгал санал болгож, шимтгэлийн хүүг бууруулахад дэмжлэг үзүүлсэн. • Импорт, экспортын барааны боомтын барилгын төлбөрийг чөлөөлж, бусад засгийн газрын боомтын хураамжийг 2020 оны 3-р сарын 1-ээс 2020 оны 6-р сарын 30 хүртэл 20%-иар бууруулсан. • Компаниудын эмнэлгийн хэрэгсэл, өдөр тутмын эмийн хэрэгцээг хангах бараа бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх, дэмжих.
	Валютын зохицуулалтыг хялбаршуулах	<ul style="list-style-type: none"> • Гадаад валют солилцох, хэлбэрийг хялбаршуулсан.
Зээл өрийн асуудал	Зээлийн төлөлтийн төлөх дүнг дахин бодож төлөх хуваарийг өөрчлөх	<ul style="list-style-type: none"> • Банкууд КОВИД-19-ийн улмаас хүндрэлтэй байгаа бизнес эрхлэгчдээс богино хугацаанд эргэн төлөлт авахгүй байх. • Жижиг дунд бизнес эрхлэгчид болон өрхийн хувиараа бизнес эрхлэгчид жижиг дунд бизнесүүд болон бичил фирмүүд 2020 оны 1-р сарын 25-наас 6-р сарын 30-ны хооронд төлөх үндсэн хүү болон

		хүүгийн зардлыг хойшлуулах хүсэлтээ банкуудад гаргаж болно.
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Хөдөлмөрийн сургалтын тэтгэмжийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> Тэмдэглэлт өдрүүдэд нарийн мэргэжлийн сургалтад хамрагдах бол тэтгэмж үзүүлэх. Компаниудад мэргэжлийн ур чадварын онлайн сургалт явуулахыг дэмжих орон нутгийн иргэдэд урамшуулал олгох (жишээ нь Хэбэй, Жэжян). Хятад улс ажилгүйдлийн даатгалын сангаас аж ахуйн нэгжүүдэд, ялангуяа ЖДҮ эрхлэгчдэд цар тахлын үед цалин хөлс, ажлын байрны тэтгэмж өгсөн. Орон нутгаас хамаарч тэтгэмжийн хэмжээ өөр ба жишээ нь Нанжин хотод нэг ажилчинд өдөрт 100 юань тэтгэмж өгсөн байна. Бүх ажилчид, ялангуяа өвчтэй эсвэл хорио цээрийн дэглэмд байгаа хүмүүсийн цалинг бүтэн олгосон. Шинээр нээгдсэн аж ахуй нэгжид (Start up companies) тусгай сангаас дэмжлэг үзүүлэх.
Татвар	Аж ахуйн нэгжийн татвар – хүү бууруулах кредит, чөлөөлөх, хойшлуулах	<ul style="list-style-type: none"> Аялал жуулчлал, технологийн аж ахуй нэгжүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 2025 он хүртэл татвараас чөлөөлнө. Жижиг хэмжээний татвар төлөгчдийг татвараас хөнгөлж, НӨАТ-ын хураамжийн хэмжээг 1% (одоогоор 3%) болгон бууруулав. 8 аас дээш үйл ажиллагаа явуулсан цар тахлын үед үйл ажиллагаа нь зогссон салбаруудыг дэмжих (тээвэр, хоолны салбар, буудал, аялал жуулчлал) Хувь хүн/Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дээд хэмжээ 15% болгох. 2, 3-р сард ажиллаагүй бизнесийн үйл ажиллагааны татварын хугацааг сунгах 2020 оны 1-р сарын 1-ээс 2022 оны 12-р сарын 31 хүртэл логистикийн аж ахуйн нэгжүүдийн эзэмшдэг бөөнөөр хадгалах агуулахуудын хот суурин газрын газар ашиглалтын татварыг 50% чөлөөлөх. Буудал, нийтийн хоолны жижиг дунд бизнес эрхлэгчдийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх. Өргөн хэрэглээний олон төрлийн үйлчилгээг улсын хэмжээнд НӨАТ-аас чөлөөлөх (эмнэлгийн үйлчилгээ, нийтийн хоол, байрны үйлчилгээ гэх мэт) Томоохон компаниуд нийгмийн даатгалын шимтгэлийн 50%-ийг төлөх. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг 3%-иас 1% хүртэл бууруулах. Жижиг хэмжээний татвар төлөгчид нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх. ЖДҮ эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлээс түр хугацаагаар чөлөөлөх.

4.3. БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛС

2020 онд Ковид-19 цар тахалтай тэмцэхэд дараалласан олон хязгаарлалтын арга хэмжээ хэрэгжүүлснээс Ирланд Улсын эдийн засаг хүндхэн нөхцөл байдалтай тулгарсан. Үндэстэн дамнасан корпорациудын тогтвортой ажиллагаанаас шалтгаалан ДНБ-ний тэргүүлэх үзүүлэлт эерэг хэвээр байгаа боловч хувийн хэрэглээ эрс буурсан байна. Ирландын эрх баригчид 2020, 2021 онуудад 24.5 тэрбум еврогийн санхүүгийн иж бүрэн багцыг зарласан нь Ирландын түүхэн дэх хамгийн өндөр дүн юм.

ОУВС-ийн тооцоолсноор төсвийн алдагдал 2021 онд ДНБ -4.7%, 2022 онд ДНБ -2.5% болж буурна гэж үзэж байна. Улсын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2019 онд ДНБ-ний 57.4%

байсан бол 2020 онд ДНБ-ний 59.8% болж, 2021-2022 онд 63.2% болж өсөх төлөвтэй байна. 2019 оны 0.9%-тай тэнцэж байсан инфляц 2020 онд дефляц болж -0.5%, 2021 онд 1.6%, 2022 онд 1.9% болж өсөх төлөвтэй байна. Ирланд Улс нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, ногоон эдийн засаг, дижитал шилжилтийг хөнгөвчлөх зорилгоор 2023 оныг дуустал Европын Холбооны Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас тус улсын ДНБ-ний 5%-тай тэнцэх буцалтгүй тусламж, зээл авахаар төлөвлөн ажиллаж байна.

Хууль эрх зүйн зохицуулалт

Ирланд Улсад цар тахал 2020 оны 3 дугаар сард дэгдсэнээс хойш цар тахлын хариу арга хэмжээ авахтай холбоотойгоор нийт 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас 11 хуульд эдийн засагтай холбоотой арга хэмжээг тусгасан байна.

- Эрүүл мэндийн тухай хууль (Онцгой байдлын үеийн хамгаалал) (The Health (Preservation and Protection and other Emergency Measures in the Public Interest) Act 2020)¹⁹² /2020.03.20/
- Нийтийн эрх ашгийн хамгаалах арга хэмжээний тухай хууль (The Emergency Measures in the Public Interest Act 2020)¹⁹³ /2020.03.27/
- Бичил бизнесийн зээлийн сангийн тухай хууль (The Microenterprise Loan Fund (Amendment) Act 2020)¹⁹⁴ /2020.07.10/
- Санхүүгийн зохицуулалтын тухай хууль (The Financial Provisions (Covid-19) Act 2020)¹⁹⁵ -/2020.07.17/
- Зээлийн батлан даалтын тухай хууль (The Credit Guarantee (Amendment) Act 2020)¹⁹⁶-/2020.07.24/
- Орон сууцны үнэлгээний тухай хууль (The Residential Tenancies and Valuation Act 2020)¹⁹⁷- /2020.08.01, 2020.10.24/
- Санхүүгийн зохицуулалтын тухай хууль, дугаар 2 (The Financial Provisions (Covid-19) (No. 2) Act)¹⁹⁸- /2020.08.01/
- Компанийн тухай хууль (The Companies (Miscellaneous Provisions) (Covid-19) Act 2020)¹⁹⁹-/2020.08.01/
- Нийгмийн халамжийн тухай хууль (The Social Welfare (Covid-19) (Amendment) Act 2020)²⁰⁰-/2020.08.05/
- Санхүүгийн тухай хууль (The Finance (Miscellaneous Provisions) Act 2020)²⁰¹- /2020.12.16, 2020.12.19/

¹⁹² The Health (Preservation and Protection and other Emergency Measures in the Public Interest) Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/1/enacted/en/html>

¹⁹³ The Emergency Measures in the Public Interest (Covid-19) Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/2/enacted/en/html>

¹⁹⁴ The Microenterprise Loan Fund (Amendment) Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/3/enacted/en/html>

¹⁹⁵ The Financial Provisions (Covid-19) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/4/enacted/en/html>

¹⁹⁶ The Credit Guarantee (Amendment) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/5/enacted/en/html>

¹⁹⁷ The Residential Tenancies and Valuation Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/7/enacted/en/html>

¹⁹⁸ The Financial Provisions (Covid-19) (No. 2) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/8/enacted/en/html>

¹⁹⁹ The Companies (Miscellaneous Provisions) (Covid-19) Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/9/enacted/en/html>

²⁰⁰ The Social Welfare (Covid-19) (Amendment) Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/12/enacted/en/html>

²⁰¹ The Finance (Miscellaneous Provisions) Act 2020

<http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/25/enacted/en/print.html>



- Хөгжил төлөвлөлт, орон сууцны түрээсийн тухай хууль (The Planning and Development and Residential Tenancies Act 2020)²⁰²- /2020.12.19 /тус тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Засгийн газраас баталсан хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих - Хөрөнгө оруулалт нь 30%-иар буурсан ажил олгогчдод нэг ажилтанд долоо хоног бүр 203 евро хүртэлх хэмжээний хөнгөлөлт үзүүлэх;
- Цар тахлын үеийн ажилгүйдлийн төлбөр - тахал өвчний улмаас ажилгүй болсон хүмүүст долоо хоногт 350 евро олгох;
- Цар тахлын үеийн хязгаарлалт хийгдсэн хэд хэдэн салбарт (орон байр, хоол хүнс, урлаг, амралт, зугаа цэнгэлийн газар) өртсөн аж ахуйн нэгжүүдэд 10-аас 5 хувийн эргэлтийн хөрөнгийн нөхөн олговрыг олгох;
- Сургалт, боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, ажилд зуучлах, ажилд авах татаас, ажил хайх, туслах арга хэмжээнд 200 сая еврогийн нэмэлт хөрөнгө оруулалт хийж, ажилгүй болсон хүмүүст шинэ ажил хайх, дахин сургах, эсвэл шинэ ур чадвараа хөгжүүлэх, ялангуяа шинээр ажилд орох хүмүүст туслах;

ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээний хүрээнд:

- Аж ахуйн нэгжийг дахин эхлүүлэхэд зориулсан буцалтгүй тусламж (550 сая евро);
- Арилжааны хүүгээс татгалзах;
- Зээлийн баталгааны схем: 10,000 еврогоос 1 сая еврог хүртэл 6 жилийн хугацаатай олон төрлийн зээлийн бүтээгдэхүүний засгийн газрын 80%-ийн баталгаа гаргах;
- Бичил Санхүүгийн Ирланд ба Орон нутгийн аж ахуйн нэгжийн арга хэмжээ: бичил болон жижиг бизнесийн зээлийн хүүг бууруулах зорилгоор хөрвөх чадвар, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын 55 сая еврогийн арга хэмжээний багц;
- Европын Хөрөнгө Оруулалтын Банктай хамтран хийх ирээдүйн өсөлтийн зээлийн схем (500 сая евро), ингэснээр 499 хүртэл ажиллагсадтай бизнесүүд өрсөлдөх чадвартай хүүгээр урт хугацаанд хөрөнгө оруулах боломжтой болно.

Аялал жуулчлалын салбарыг дэмжих арга хэмжээний хүрээнд:

- 2021 оныг дуустал түр НӨАТ-ын хүүг 13.5-аас 9 хувь хүртэл бууруулах;
- Татварын хөнгөлөлт эдлэх замаар урамшуулалд үлдэх ба зарцуулах;
- Аялал жуулчлалын салбарыг дэмжих сангийн 10 сая еврог дахин эхлүүлэх;
- Соёлын салбарын 10 сая еврогийн гүйцэтгэлийг дэмжих схем нь Ковид-19-ийн хүрээнд авах арга хэмжээг төлөвлөхөд туслах болно.

Татварын арга хэмжээний хүрээнд:

- НӨАТ-ын стандартын хувь хэмжээг 2021 оны 12-р сараас 31 хүртэл 23-21 хувиар бууруулах;
- Хямралд өртсөн бизнес эрхлэгчдийн татвар, өр төлбөрийг хойшлуулах, хүү, торгууль төлөхгүйгээр төлбөрөө төлж, НӨАТ-ын өрийг тодорхой хэмжээгээр хэсэг хугацаанд хойшлуулах;
- Татварын бүх өрийг тохиролцсон эргэн төлөлтөд хамруулж, зээлийн хүүг 3% хүртэл бууруулах;

²⁰² The Planning and Development and Residential Tenancies Act 2020
<https://oxcon.ouplaw.com/view/10.1093/law-occ19/law-occ19-e19#law-occ19-e19-note-11>

- Өмнө нь ашигтай ажиллаж байсан компаниудад мөнгөн урсгалын дэмжлэгийг нэн даруй үзүүлэхийн тулд арилжааны алдагдлыг эрт буцаан олгохыг зөвшөөрөх бөгөөд ингэснээр татвар төлсөн корпорацийн татварын зарим хэсгийг эсвэл бүх хэсгийг нэн даруй буцаан олгох боломжтой болно;
- Эмийн чухал бүтээгдэхүүн, эмийг гаалиар чирэгдэлгүйгээр нэвтрүүлж, импорт, нийлүүлэлтийг тасралтгүй үргэлжлүүлэх болно.

2021 оны 6-р сарын 1-нд Засгийн газар бизнесийн болон өрхийн орлогыг дэмжих ихэнх дэмжлэгээ 2021 оныг дуустал сунгаж, 3.5 тэрбум евро (ДНБ-ний 1%) байхаар төлөвлөж, ЕХ-ны эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас 1 тэрбум еврог зарцуулахаар болсон. Үүнд:

- Долоо хоног бүр 350 евро хүртэлх төлбөрийг өгдөг цар тахлын ажилгүйдлийн төлбөрийг 2022 оны 2-р сар хүртэл сунгах;
- Цалингийн татаас олгох схем 2021 оныг дуустал үргэлжлэх бөгөөд Засгийн газар уг схемийн үйл ажиллагааг 4-р улиралд өөрчлөх боломжийг нээлттэй үлдээх;
- Татвар, худалдааны хүүгээс чөлөөлөх хугацааг 2021 оны эцэс хүртэл сунгах;
- Аялал жуулчлалын НӨАТ-ын хувь хэмжээ 2022 оны 9-р сар хүртэл 9% хэвээр байлгах;
- ЖДҮ-ийг дахин нээхэд хамгийн ихдээ 30,000 еврогийн буцалтгүй тусламж олгох зэрэг төлөвлөгөө багтсан болно.

Ирландын Төв Банкнаас (СБИ) зарласан нэмэлт арга хэмжээнд:

- Мөчлөг сөрсөн нэмэлт капиталгаас чөлөөлөх 1%-иас 0% хүртэл бууруулна;
- Ковид-19 туссан үйлчлүүлэгчдэд зориулсан орон сууцны зээл, хувийн болон бизнесийн зээлийн төлбөрийн хөнгөлөлтийг 3-6 сар хүртэл сунгах;
- Төлбөрийн тасалдал нь зээлдэгчийн зээлийн бүртгэлд нөлөөлөхгүй бөгөөд Зээлийн төв бүртгэлд бүртгүүлэх ажлыг тохируулах;
- Ковид-19-ийн яаралтай тусламжийн үеэр нүүлгэн шилжүүлэх, түрээсийн үнийг 6 сараас доош хугацаатай түрээсийн мэдүүлгийн хугацааг 90 хоног болгон нэмэгдүүлсэн байна.

3. Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө (National Recovery and Resilience Plan NRRP)

Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө нь нийгэм, эдийн засгийн сэргэлт, ажлын байр бий болгохтой зэрэгцэн ногоон, дижитал шилжилтийг шийдвэрлэх гурван тэргүүлэх чиглэлийг хамарсан хорин таван хөрөнгө оруулалтын төсөл, шинэчлэлийн арга хэмжээнд үндэслэсэн болно. Үндэсний эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөөг Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө (Economic Recovery Plan), Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний (National Development Plan)²⁰³ гэсэн 2 үндсэн төлөвлөгөөнд уялдуулан хийж Засгийн газар 20.5 тэрбум еврогийн шууд дэмжлэг, 4 тэрбум еврогийн шууд бус дэмжлэгийг багтаасан 24.5 тэрбум еврогийн санхүүгийн иж бүрэн багцыг зарласан байна.

Шууд дэмжлэг

- Татварыг хойшлуулах (2.9 тэрбум евро)
- Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих (11.4 тэрбум евро)
- Эрүүл мэндийн салбарын чадавхыг сайжруулах (2 тэрбум евро)
- Бизнесийг дэмжих (1.5 тэрбум евро)
- Капитал бүрдүүлэх (0.5 тэрбум евро)

²⁰³ National Development Plan
<https://www.gov.ie/en/policy-information/07e507-national-development-plan-2018-2027/>

Европын Холбооны Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангаас Ирланд Улсын Үндэсний сэргээн босголтын төлөвлөгөөг санхүүжүүлэх 915 сая еврогийн томоохон хөрөнгө оруулалт хийнэ.

4. Ногоон эдийн засгийг дэмжих – 503 сая евро
5. Дижитал шинэчлэл, өөрчлөлтийг өргөжүүлэх – 295 сая евро
6. Нийгэм, эдийн засгийн сэргэлт, ажлын байр бий болгох – 181 сая евро зарцуулахаар төлөвлөөд байна.

Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө²⁰⁴

2020 оны 3-р сард Ковид-19 цар тахал эхэлснээс хойш дотоодын эдийн засагт маш хүнд нөлөөлж аж ахуйн нэгжүүдийн тоо 2020 онд 10 орчим хувиар хумигдаж, ажилгүйдэл 25 хувь хүртэл нэмэгдсэн байна. Эдийн засгийг сэргээх төлөвлөгөө нь 4 үндсэн тулгуур зорилготой болно.

1. Төрийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах;
2. Хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэгийг өргөжүүлэх;
3. Аж ахуйн нэгжүүдийг бодлогын тусламжтайгаар дэмжиж сэргээн босгох;
4. Бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Төрийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах²⁰⁵

2021 онд ЭЗХАХБ-тай олон улсын татварын хувьд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, дижитал хэлбэрт шилжүүлэх талаар хэлэлцээр хийх зорилго тавин ажиллаж байна. Энэхүү хэлэлцээр нь олон улсын татварын тогтолцоонд тогтвортой байдлыг бий болгоно гэж үзэж байна.

Олон улсын татвар

- Инновацийн өсөлтийг үргэлжлүүлэн дэмжих;
- Татвар төлөгчид болон хөрөнгө оруулагчдад санхүүгийн баталгаа гаргаж өгөх;
- Татварыг хөнгөвчлөх

Урт хугацааны татвар болон халамжийн бодлого

Эдийн засгийг сэргээх үйл ажиллагааны хүрээнд ажил эрхлэлтийг дэмжих татвар халамжийн хороог байгуулсан. Тус хороо нь төрийн үйлчилгээ, дэмжлэгийн зардлыг дунд болон урт хугацаанд хангах хангалттай эх үүсвэр байгаа эсэхийг баталгаажуулах зорилготой юм.

2. Хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэгийг өргөжүүлэх²⁰⁶

Засгийн газрын 2021-2025 оны хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэг нь хүмүүсийг хөгжүүлэх, чадавхыг дээшлүүлэх, тогтвортой ажлын байраар хангах, дахин мэргэшүүлж хуучин ажлын байранд нь ажилд оруулах, шинээр өсөн нэмэгдэж байгаа ажлын байранд дэвшүүлэн томилох тал дээр илүү дэмжлэг үзүүлнэ. Мөн нийтийн хөдөлмөр эрхлэлтийн чадавхыг өргөжүүлж, дижитал технологи, нийтийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхыг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн цалин тэтгэмж, цар тахлын үеийн ажилгүйдлийн төлбөрийг сайжруулах, цалингийн татаас олгоно. Ажил эрхлэлтийн цалингийн татаас олгох схемийг 2021 оны 6-р сарын 30-наас 2021 оны 12-р сарын 31 хүртэл сунгах болно.

²⁰⁴ Economic Recovery Plan

file:///Users/uurtsaikh/Downloads/136523_03f31f12-10eb-4912-86b2-5b9af6aed667.pdf

²⁰⁵ Ensuring Sustainable Public Finance <https://www.gov.ie/en/publication/d4dcc-sustainable-public-finances/>

²⁰⁶ Pathways to Work 2021-2025 <https://www.gov.ie/en/publication/90e59-pillar-2-helping-people-back-into-work/>

- Хөдөлмөр эрхлэлт цалин хөлсний татаас олгох;
- Цар тахлын ажилгүйдлийн төлбөр олгох;
- 50,000 боловсрол, сургалтын байрны ашиглалтыг нэмэгдүүлэх.

3. Аж ахуйн нэгжүүдийг бодлогын тусламжтайгаар дэмжиж сэргээн босгох²⁰⁷

2024 гэхэд хямралын өмнөх үеийнхээс ажил эрхлэлтийн түвшинг ахиулах, 2,5 сая хүнийг ажлын байртай болгохыг зорьж ажиллана. ЖДҮ эрхлэгчид дотоодын аж ахуй нэгжүүдийн 99,8%-ийг нийт ажил эрхлэлтийн 68%-ийг эзэлдэг байна. Тиймээс бүтээмж, экспортын үйл ажиллагаа, интернационалчлал, дижиталчлал, бизнесийн бусад салбарын динамик байдлыг сайжруулахын зэрэгцээ бусад салбар дахь бизнесийг идэвхжүүлэх, олон улсын болгох, дижитал болгох, бизнесийн эрч хүчийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд:

- Засгийн газрын дижитал, ногоон эдийн засгийг хослуулж эдийн засгийг сэргээх;
- Бизнесийн үйл ажиллагааг дижитал хэлбэрээр өөрчлөх;
- Шинэ менежмент, шинэ технологи нэвтрүүлэх;
- Хүний болон биет капиталд хөрөнгө оруулах;
- Автоматжуулалт, алсын зайны ажлыг нэвтрүүлэх;
- ЖДҮ-ийг дэлхийн зах зээлд нэвтрүүлэх, экспортлох боломжийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх;
- 2025 он гэхэд 3000 гаруй нэмэлт бичил болон гарааны аж ахуйн нэгжүүдийг экспортлогч болгох;
- Шинээр бизнес эрхлэгчдийг дэмжих төлбөрийн дэмжлэгийг 10,000 евро болгон нэмэгдүүлэх дээд тал нь 30,000 евроны дэмжлэг үзүүлэх;
- Хязгаарлалтын үр дүнд орлого нь мэдэгдэхүйц буурсан аж ахуйн нэгжүүдэд буцалтгүй тусламж олгох;
- Арилжааны үнээс 2021.06.30-09 сарын сүүл хүртэл чөлөөлөх;
- Татварыг хойшлуулах арга хэмжээг 2022 оны эцэс хүртэл сунгах;
- Ажилтны цомхотгол хийх нэхэмжлэл гаргах хугацааг 2021.09.30 болтол сунгах;
- Аялал жуучлалын салбарын НӨАТ-ын 9%-ийг чөлөөлөх, амралт зугаалгын газар, нисэх онгоц, усан онгоц зэрэг хохирол их амссан салбарт дэмжлэг үзүүлэх;
- Хүнсний боловсруулах үйлдвэрт зориулсан хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх;
- Аж ахуйн нэгжийн санг дэмжих үйл ажиллагааг үргэлжлүүлэх.

4. Тэнцвэртэй хүртээмжтэй сэргэлт²⁰⁸

Засгийн газраас ард түмэн, бүс нутгийнхаа тэнцвэртэй байдлыг хангах хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх үүрэг хүлээдэг. Иймд стратегийн хөрөнгө оруулалт, бүс нутгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, ногоон эдийн засаг, дижитал шилжилт нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Тэнцвэртэй бүс нутгийн хөгжил

Үндэсний төлөвлөлт 2040 төслийн хүрээнд:

- Жил бүр 33,000 орон сууцыг зорилтот бүлэгт хамруулах;
- Хямд өртөгтэй орон сууцны зээлийг эрсдэлийн схемээс хасах;
- Үйлдвэрийн өмнөх 33 сая га газрыг нөхөн сэргээх;

²⁰⁷ Rebuilding Sustainable Enterprises <https://www.gov.ie/ga/foilsuichan/d28d9-pillar-3-re-building-sustainable-enterprises/>

²⁰⁸ A Balanced and Inclusive Recovery <https://www.gov.ie/en/publication/bbd3b-inclusive-and-balanced-recovery/>

- Орон нутгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх 20 сая еврогийн голын сав газрын менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Хил орчмын цар тахлын нөлөөнд их өртсөн орон нутгийг хөгжүүлэх, сэргээх 1 тэрбум еврогийн нөхөн сэргээлт хийх.

Амьжиргааны түвшинг дээшлүүлэх

Ажил олгогчид болон үйлдвэрчний эвлэлүүдтэй зөвшилцөн төлөвлөгөө боловсруулж, Хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн форумыг зохион байгуулж, зорилтот шинэчлэл хийснээр ажил эрхлэлт, амьжиргааны түвшин, нөхцөлийг сайжруулах болно.

- Хуулиар тогтоосон өвчтэй цалин хөлсийг нэвтрүүлэх тухай олон нийтийн хэлэлцүүлгийг хийсний дараа хуулийн төслийн ерөнхий схемийг нийтэлж, 2021 оны эцэс гэхэд батлах;
- Амьжиргааны доод түвшинг хэрхэн тогтоох боломжтойг судалж, судалгааг он дуусахад дуусгасан байх;
- 2022 оны эхээр бүх нийтийн үндсэн орлогыг тогтоох арга замыг судалж байна.
- Иргэдийн хурлаар дамжуулан жөндөрийн тэгш байдлыг дэмжих, Жөндөрийн цалингийн зөрүүтэй холбоотой мэдээллийн тухай хууль тогтоомжийг цаг алдалгүй гаргах;
- Платформын эдийн засгийн зохистой зохицуулалт хийх зэрэг ажлуудыг төлөвлөгөөнд тусгасан байна.

4.4.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ дэлхийн ихэнх улс орнуудын адил цар тахлын эсрэг хорио цээрийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь коронавирусийн өвчлөлийн улмаас үүсэх нас баралтыг бууруулж, эрүүл мэндийн тогтолцоонд үзүүлэх ачааллыг хөнгөвчлөх боломж олгосон боловч эдийн засгийн гүн хямралыг дагуулсан. ОХУ-д 2020 оны жилийн эцсийн байдлаар ДНБ 5%-иар буурч, ядуусын тоо 18 саяас 20-21 сая болж өссөн байна. Ийм нөхцөл байдалд сүүлийн арван жилийн хугацаанд Оросын эдийн засагт олон жилийн турш хуримтлагдсан асуудлууд улам хурцадсан. Цар тахлын хямрал нь өмнөх арван жилд хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх "цонх үе"-ийг үүсгэж байна.

ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн зогсонги байдал, дэлхийд эзлэх байр суурь суларч байгаа энэ үед нийгэм-экологийн шинэ загварт шилжих нь цорын ганц боломжит хувилбар болж байна. Тиймээс цар тахлын энэ үед эдийн засгийг шинэчлэх системтэй бодлого хэрэгтэй байна.²⁰⁹

Тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралын үр дагаврыг даван туулах чиглэлээр гаргасан хууль эрх зүйн баримт бичгүүд

ОХУ-ын Засгийн газраас цар тахлын хямралыг даван туулах зорилгоор дараах бодлогын баримт бичгүүдийг авч хэрэгжүүлж байна.

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө

Ажил эрхлэлт, хүн амын орлогыг сэргээх, эдийн засгийн өсөлт, эдийн засагт урт хугацааны бүтцийн өөрчлөлтийг хангах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (2020-2021 он)

²⁰⁹ Aganbegyan, A. G., Klepach, A. N., Porfiryev, B. N., Uzyakov, M. N., & Shirov, A. A. (2020). Post-pandemic recovery: The Russian economy and the transition to sustainable social and economic development. *Studies on Russian Economic Development*, 31(6), 599-605.

Ерөнхийлөгчийн зарлиг: ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 5-р сарын 7-ны өдрийн 204 дугаар зарлигаар Эдийн засгийн өсөлтийг хурдасгах шинэ саналуудыг гаргаж, ОХУ-ын Холбооны хурлаар 2020 оны 1-р сарын 15-ны өдөр баталсан. Үүнд хямралын дараах эдийн засгийг сэргээх зорилгоор Засгийн газраас дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанууд тусгагдсан байна.

Эдгээр төлөвлөгөө, арга хэмжээнүүд нь 2020 онд ДНБ-ний бууралтыг 1.0–1.5 хувиар бууруулах зорилготой байв. Гэсэн хэдий ч уг арга хэмжээнүүд дангаараа хямралаас үүссэн эдийн засгийн алдагдлыг саармагжуулж, эдийн засгийн тогтвортой өсөлт рүү шилжихэд хангалтгүй юм. Учир нь одоо байгаа үндэсний төслүүд ДНБ-ний дунд хугацааны өсөлтийг 0.6-аас дээш хувиар нэмэгдүүлж чадахгүй байгаа ба цаашид тогтвортой хэрэгжүүлсэн ч ОХУ-ын эдийн засгийн өсөлт жилд 3%-иас хэтрэхээргүй байгаа нь дэлхийн динамикаас доогуур үзүүлэлттэй байна. Тиймээс ДНБ-нийг 5-8%-иар нэмэгдүүлж, өргөн хүрээний идэвхитэй эрчимжүүлэлтийг дэмжихийн тулд төсвийн зарцуулалтын дүрмийг шинэчлэх хэрэгтэй болсоныг харуулж байна.

Цар тахлын үед авсан санхүүгийн арга хэмжээ

ОХУ-д коронавирусийн халдварын анхны тохиолдол 2020 оны 01 сарын 31-д бүртгэгдсэн ба үүнээс хойш 2021 оны 06 сарын 29 хүртэл авсан санхүүгийн арга хэмжээнүүдийн үр дүнд 2020 оны төсвийн багцын нийт өртөг нь ДНБ-ний 3.5 орчим хувьтай тэнцсэн ба 2021 оны төгсгөл гэхэд энэ өртөг ДНБ-ний 1.5 орчим хувьтай тэнцэхээр байна. Үүнд доорх арга хэмжээнүүд орж байна.²¹⁰

- Халдварын эсрэг тэмцэж буй эмнэлгийн ажилтнууд, эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахиулагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн. Ерөнхий сайдын 2021 оны 8-р сарын 10-ны өдрийн 2204-р тоот тушаалаар тус ажилчдад нэмэлтээр 46.3 тэрбум рубль хуваарилахаар гарын үсэг зуржээ. Уг хөрөнгийг Засгийн газрын нөөц сангаас гаргах ба 2021 оны 11-р сар хүртэл олгох юм.²¹¹
Мөн Засгийн газрын 2021 оны 08 сарын 07-ны 2185 тоот тушаалаар коронавирусийн халдвартай өвчтөнүүдийг гэрээр эмчлэх үйлчилгээг хангахын тулд 127.6 сая рубль хуваарилсан ба энэ нь явуулын багт ажиллаж буй эмч сувилагчдын нэмэгдэл цалин, томилолтын зардалд зориулагдах юм. Уг үйл ажиллагаа халдварын тохиолдол хамгийн ихтэй бүс нутгуудад явагдаж байгаа бөгөөд багт эрчимт эмчилгээ, халдварт өвчин, амьсгал зүрх судасны өвчин, мэдээгүйжүүлгийн эмч мэргэжилтнүүд багтаж байна.²¹²
- Хорио цээрийн дэглэмд хамрагдсан иргэд 2020 оныг дуустал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний тэтгэмж авсан.
- 2020 оны 3-р сарын 1-ээс хойш ажилгүй болсон иргэд, хувиараа бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү ажилгүйдлийн тэтгэмж олгосон.
- 3 хүртэлх насны бүх хүүхдэд 3 сарын хугацаанд хүүхдийн тэтгэлгийг нэмэгдүүлсэн; 3-15 насны бүх хүүхдэд нэг удаагийн тэтгэмж олгосон; 16-аас доош насны бүх хүүхдэд эцэг эх нь ажилгүй болсон тохиолдолд 6 сарын хугацаатай нэмэгдэл тэтгэмж олгосон; Бүх сургуулийн сурагчдад нэг удаагийн нэмэлт тэтгэмж олгож, өрх толгойлсон эцэг эхтэй гэр бүлийн хүүхдүүдэд олгох тэтгэмжийг нэмэгдүүлсэн.

²¹⁰ International monetary fund. Policy responses to COVID-19. <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#R>

²¹¹ Засгийн газрын тогтоолын мэдээ. <http://government.ru/news/42992/>

²¹² Засгийн газрын тогтоолын мэдээ <http://government.ru/news/42980/>

ЖДҮ болон стратегийн чухал ач холбогдолтой аж ахуйн нэгжийн зээлийн хүүг хөнгөлсөн. Засгийн газрын 2021 оны 07 сарын 28-ны 2078-р тушаалаар Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгоход дахин 2.04 тэрбум рубль хуваарилсан. Ийнхүү уг дэмжлэгийн арга хэмжээ цар тахал эхэлсэнээс хойш нийтдээ 5.94 тэрбум рубль болох юм. Ийм хөнгөлөлттэй зээлийн хүү дунджаар жилд 2.6% байдаг ба хүлээн авсан байгууллагын ажилчдын цалин хөлс, ажлын байр, тоног төхөөрөмжийн түрээс, түүхий эд, материал худалдаж авахад нь дэмжлэг болох юм. Уг дэмжлэг 2021 оны 12-р сарын 31 хүртэл үргэлжилнэ.²¹³

- Цар тахлын нөлөөнд өртсөн компаниудын татварын хугацааг сунгасан.
- Цар тахлын нөлөөнд өртсөн салбарын ЖДҮ эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сараар хойшлуулж гурван сараар дахин сунгасан.
- ЖДҮ эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчид, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг ТББ-уудад 2020 оны 2-р улирлын бүх татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлсөн. Мөн Засгийн газрын 2021 оны 07 сарын 31-ний 2127-р тогтоолоор жижиг, дунд бизнес эрхлэгчид болон нийгмийн ажил хийдэг ТББ-уудад буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор 8 тэрбум рубль хуваарилжээ. Үүнийг хорио цээрийн дэглэмийн улмаас түр хугацаанд сул зогсолт хийсэн байгууллагууд хүлээн авах боломжтой бөгөөд нөхөн олговрын хэмжээ нь нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхээр байна. Хорио цээрийг сунгасан тохиолдолд тэтгэмж олгох хугацааг ч мөн нэмэгдүүлнэ.²¹⁴
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчээр бүртгүүлсэн хүмүүст 2019 онд хураасан татварыг буцаан олгож, 2020 оны татварыг хэсэгчлэн буцаан олгосон; хувиараа бизнес эрхлэгчээр бүртгүүлэх эрхийг 18 наснаас олгодог байсныг 16 болгож бууруулсан.
- Хувиараа бизнес эрхлэгчид нийгэмд хувь нэмрээ оруулсан бол төлсөн татвараас нь хэсэгчлэн буцаан олгосон.
- 2020 оны эцэс хүртэл бүх шатанд улсад төлөх түрээсийн төлбөрийг хойшлуулсан
- Цар тахлын нөлөөнд өртсөн салбарын ЖДҮ эрхлэгчдэд нэг ажилтанд ногдох цалингийн доод хэмжээг хоёр сарын хугацаанд бодож тэтгэмж олгосон, мөн ажлын байрыг хадгалах нөхцөлтэйгээр ресторан, зочид буудал, энтертаймент салбарын аж ахуйн нэгжүүдэд 2021 оны турш ажлын байрыг хадгалсан нөхцөлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 сарын хугацаанд бодож хөнгөлөлттэй зээл олгосон.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн импортын татварыг тэглэсэн.
- Цар тахлын нөлөөнд өртсөн ЖДҮ болон үйлдвэрүүдэд баталгаатай зээл олгосон.
- Агаарын тээврийн компаниуд, нисэх онгоцны буудлууд, автомашин үйлдвэрлэгчдэд хөнгөлөлт олгосон.
- Төрийн өмчит банк, агаарын тээврийн компаниуд болон хөгжлийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийсэн.
- Иргэдийн ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрхийг нэмэгдүүлсэн.

Цар тахлын үеийн эдийн засгийн хямралын онцлогтой үйлдүүлэн цаашид авах эдийн засгийн арга хэмжээ

Энэ нөхцөл байдалд эдийн засгийн бодит салбар дахь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээх гол үзүүлэлтүүд нь шууд дэмжлэг бус харин микро болон макро түвшинд эрэлтийг тодорхойлогч үзүүлэлтүүдийг сайжруулах явдал юм.

²¹³ Засгийн газрын тогтоолын мэдээ <http://government.ru/news/42925/>

²¹⁴ Засгийн газрын тогтоолын мэдээ <http://government.ru/news/42949/>

Одоогоор нүүрлээд буй цар тахлын үеийн эдийн засгийн хямралын онцлог нь төрийн албанд ажилладаггүй, орлогын дундаж түвшин бүхий хүн амын хэсэгт хамгийн хүнд туссан явдал юм. Эдгээр хүмүүс нь голчлон үйлчилгээний салбарт ажилладаг бөгөөд хямралын үед зочид буудал, рестораны үйлчилгээ, агаарын болон төмөр замын тээврийн салбар хамгийн их өртсөнтэй холбоотой. Тиймээс уг бүлэг хүмүүсийн нөхцөл байдлыг зөвхөн эдийн засгийн өсөлтийг өргөн хүрээнд эхлүүлж байж сайжруулна. Ялангуяа бодит салбарын ашиг орлогыг нэмэгдүүлснээр үйлчилгээний салбарт тогтвортой сэргэлт үүснэ. Ингэхдээ дараах үндсэн хоёр чиглэлд анхаарах нь чухал.

Нэгдүгээрт улсын, бүс нутгийн, хотын хэмжээнд үйлчилгээний бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтын системээр дамжуулан үндсэн эрэлтийг хангах.

Хоёрдугаарт, дотоодод үйлдвэрлэсэн өргөн хэрэглээний барааг худалдан авах, орон сууцны зээл авахад хөнгөлөлт үзүүлэх. Мөн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх замаар хөрөнгө оруулалтын идэвхжилтийг сэргээх нь чухал юм.

Эдийн засгийн тогтвортой хөгжих явцыг сэргээх

Дунд болон урт хугацаанд ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангахад дараах зорилгод чиглэсэн бүтцийн өөрчлөлтийг хийх нь чухал.

- 1) Хүний капиталын хурдацтай хөгжил, эрүүл мэндэд суурилсан орчин үеийн эдийн засаг
- 2) Технологид суурилсан дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай шинэлэг эдийн засаг
- 3) Нийгэмд чиглэсэн эдийн засгийн хөгжүүлж, өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцсэн нийгмийн сайн сайхан байдлыг үүсгэхэд зорих

Энэхүү цогц бүтцийн өөрчлөлтийн хүрээнд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх төрийн менежментийн аргачлалыг хөгжүүлэхээс гадна нийгэм эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч хүний капиталын хөрөнгө оруулалт хийж, технологид суурилсан эдийн засгийг эрчимжүүлэхээс гадна дараах салбарт ач холбогдол өгөх шаардлагатай.

Одоо төрөөс авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг мэдлэгийн эдийн засагт (судалгаа шинжилгээ, боловсрол, мэдээлэл ба харилцаа холбооны технологи, биотехнологи, эрүүл мэнд) суурилан хөгжүүлэхийн зэрэгцээ цар тахлын улмаас үүссэн урт хугацаанд үүсэх био-нийгмийн эрсдэлийг тооцон нэн тэргүүнд эрүүл мэндийн салбарын хөгжлийг тэргүүлэх чиглэл болгох ёстой. Үүнд анагаах ухааны суурь шинжлэх ухаан, биоанагаах ухаан, эмнэлгийн тоног төхөөрөмж, технологийн хэрэглээний судалгааны хөгжил буюу биотехнологи, мэдээлэл харилцаа холбоо, эмнэлгийн ажилтнуудын чадавхижуулалт орно.

ОХУ-д ДНБ дэх эрүүл мэндийн салбарын эзлэх хувь дэлхийн тэргүүлэгч орнуудаас 2.5-3 дахин бага байгаа ба энэ талын санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд 2020-2025 онуудад эрүүл мэндийн салбарын ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлэхдээ эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах хувь 5.1 байсныг 6.5, судалгаа, шинжилгээнд 1.1 хувь байсныг 1.7 хувь, боловсролд 4 хувь байсныг 5.5 хувь, мэдээлэл харилцаа холбооны технологи 4.9 хувь байсныг 5.8 хувь болгож нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ба үүнд жил бүр дор хаяж 2 их наяд рубль шаардлагатай болох юм.

Өрсөлдөх чадвартай үндэсний эдийн засгийн хөгжүүлэх салбарууд

ОХУ-ын эдийн засгийг сэргээхэд нийгмийн тогтвортой байдлыг хангах чиглэлийн арга хэмжээнүүд буюу ядууралтай тэмцэх, тэтгэврийг амьжиргааны түвшинд хүргэх, шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх, төрийн албаны өндөр ур чадвартай ажилтнуудын тэгш нөхцөлийг бүс нутаг хамааралгүйгээр хангах зэрэг тал дээр үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай байна. 2024 он гэхэд тэтгэврийг дундаж цалингийн 32%-40%, урт хугацаандаа 60-70% болгож, 55-60 насандаа

тэтгэвэрт эрт гарах боломжийг олгох хэрэгтэй байна. Мөн ОХУ-д ажиллаж буй хууль ёсны цагаачдыг ажиллаж амьдрахад нь зохих нөхцөлийг бүрдүүлэн, тэдний нийгмийн хамгааллыг хангах шаардлагатай. Хямралын үед нэмэгдсэн ажилгүйдлийн асуудлыг харгалзан үзэж, ажилгүйдлийн тэтгэмжийн түвшинг амьжиргааны доод түвшин хүртэл нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Өрсөлдөх чадвартай үндэсний эдийн засгийг бүрдүүлэхтэй холбоотой дараах цогц хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай.

- Нөөцийн үйлдвэрлэлд чиглэсэн суурь салбаруудын технологийн шинэчлэл
Тус улсын эдийн засгийн хөгжлийн зогсонги байдал нь үндсэндээ нөөцийн үйлдвэрлэлд чиглэсэн суурь салбарууд ба дэд бүтцийн технологийн хоцрогдлоос үүдэлтэй. Үүнийг шинэчлэх асуудлыг үндэсний төлөвлөгөөнүүдийн хүрээнд үндсэн дэд бүтцийг хөгжүүлэх цогц төлөвлөгөөнд тусгасан болно. Уг төлөвлөгөөний гол зорилго нь ирэх 15 жилийн хугацаанд үндсэн хөрөнгийн гуравны хоёрыг орчин үеийн технологид суурьлан шинэчлэх бөгөөд энэ нь эдийн засгийн бодит секторыг шинэчлэхэд чиглэгдэх ёстой. Энэ нь хөдөлмөрийн бүтээмжийг гурав дахин нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн эрчим хүчний ашиглалтыг хоёр дахин бууруулах, өндөр хөгжилтэй орнуудад хүрч үйлчилснээр үр ашгийг дээд зэргээр нэмэгдүүлэх боломжийг олгох юм.

Тооцооллоос харахад нийт хөрөнгө оруулалтын гуравны хоёроос доошгүй хувийг технологийн шинэчлэлтийн асуудлыг шийдвэрлэхэд зориулах ёстой бөгөөд жил бүр шаардлагатай хөрөнгө оруулалтын өсөлт 10%-иас багагүй байх ёстой. Үүний зэрэгцээ эрчим хүчний хэмнэлттэй машин, тоног төхөөрөмжийн зардлын эзлэх хувь хөрөнгө оруулалтын бүтцэд аажмаар нэмэгдэх ёстой бөгөөд ингэснээр үйлдвэрлэлийн өртгийг бууруулах, чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг шинэчлэх боломжтойн дээр байгаль орчинд учруулах ачааллыг бууруулж, амьдралын чанарыг сайжруулна.

- Өндөр технологийн үйлдвэржилтийг хөгжүүлэх
Ирэх 15 жилд улс орны эдийн засагт өндөр технологийн салбарын эзлэх хувийг гурваас дөрөв дахин нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр газрын тос, байгалийн хийн олборлолтын орлоготой дүйцэх хэмжээний орлогын эх үүсвэрийг бий болгох шаардлагатай байна. Үүнд механикийн инженерчлэл, хагас дамжуулагч, компьютерийн тоног төхөөрөмж үйлдвэрлэл, мэдээлэл, харилцаа холбооны технологи, багаж хэрэгслийн инженерчлэл, орчин үеийн эмнэлгийн төхөөрөмж, эм, генетик, биологийн технологи, орчин үеийн нийлэг материал, химийн өндөр технологи, сансрын болон цөмийн технологи, түлшний эсүүд, квант технологи, хиймэл оюун ухааны хэрэглээ орно.

- "Ногоон" технологи
Цар тахлын дараа байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд эрчим хүч, аж үйлдвэр, байгаль орчны тоног төхөөрөмж (ус, агаар, хог хаягдлыг цэвэрлэх), байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн болон үйлдвэрлэлийн байрны ногоон стандарт, модон байшин барих орчин үеийн технологийг ашиглах орно. Хөдөө аж ахуйн салбарт цаг агаарт тэсвэртэй ургамлын сорт сонгох, био нэмэлт, эрдэс бордоо, органик бүтээгдэхүүн, ургамал, амьтан хамгаалах бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд онцгой анхаарал хандуулах ёстой. Мөн ногоон технологи нь тус улсын байгалийн давуу тал болох ус, ой, хөрсний нөөцийг үр ашигтай ашиглах арга юм. Үүнтэй холбоотойгоор ирэх 2-4 жилд өндөр технологийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг 15% хүртэл нэмэгдүүлэхийг мэргэжилтнүүд зөвлөж байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд засгийн газар үндэсний корпорациудтай гэрээ байгуулж, инженерийн чиглэлийн судалгааны ажлыг хамтран санхүүжүүлж, хувийн хэвшил ба төрийн хамтарсан хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна.

Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын томоохон нэмэлт эх үүсвэр нь банкнуудын төлбөрийн чадвараа дээшлүүлэхэд нь зарцуулагдаж болох бөгөөд энэ нь банкны хөрөнгө оруулалтын зорилгоор олгох зээлийн хувийг нэмэгдүүлж чадах юм. Тус улсын бүх банкны системийн 60-70%-ийг төрийн өмчит банкууд эзэлдэг. Тухайлбал Сбербанк 30 их наяд гаруй рублийн хөрөнгөтэй бөгөөд энэ нь тус улсын төсвөөс 1.5 дахин их юм. Тиймээс төрийн банкууд хөрөнгө оруулалтын зээлийг дор хаяж гурав дахин нэмэгдүүлэх боломжтой юм.

Шинэ хүчин чадлыг бий болгоход зориулагдсан зээл буюу өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт зээл олгохдоо 10-12 жилийн хугацаанд оруулсан хөрөнгө оруулалтын дундаж нөхөн төлөлтийг харгалзан жилийн бодит дүнгээр 1.5%-иас хэтрүүлэхгүй байх ёстой. Нөхөн төлөлт нь 20-25 жилийн хугацаатай дэд бүтцийн төслүүдийн хувьд хөрөнгө оруулалтын зээлийн бодит хүүг бараг тэг хувьтай тэнцэх хэмжээнд хүртэл бууруулах ёстой.

Одоо явагдаж байгаа үндэсний төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх чухал нөхцөл бол тахлын хямрал дууссаны дараа төв банкны үндсэн хүүг бодит утгаар нь 1% хүртэл бууруулах явдал юм.

ОХУ-д бусад орнуудын жишгээр урт хугацаатай банкны бус эх үүсвэр буюу тэтгэврийн сан, даатгалын компаниуд, корпорацийн бонд, хувьцаа болон бусад өрийн хэрэгслийн зах зээлийг бий болгох цаг болсон. Тиймээс төр өрөө нэмэгдүүлж, уг эх үүсвэрээ нэмэлт хөрөнгө оруулалтын зээл хэлбэрээр олгох боломжтой. Өрийн дарамтын босгыг тогтоохдоо гадаад өр ДНБ-ний 60 хүртэлх хувийг эзлэхэд хүлээн зөвшөөрдөг боловч ийм их гадаад өр тус улсад шаардлагагүй юм. Гэсэн хэдий ч урт хугацаанд гадаад өрийг ДНБ-ний 30-40% хүртэл аажмаар нэмэгдүүлбэл, эдийн засгийн өсөлт, хүн амын сайн сайхан байдлыг сайжруулах явцыг хурдасгах боломжтой юм.

Татварын ачааллыг бууруулах

Дотоодын санхүүгийн тогтолцоонд томоохон шинэчлэл хийх шаардлагатай байгаа бөгөөд юун түрүүнд аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг бууруулж, татварын тогтолцоог зөвхөн төсвийн орлогоор хязгаарлалгүйгээр дахин хуваарилах чиг үүргийг нь тодотгох шаардлагатай байна. Томоохон хэмжээний үндэсний төслүүдэд оролцож буй аж ахуйн нэгжүүдийг хөрөнгө оруулалтын татвараас чөлөөлөх, эсхүл татварын хөнгөлөлт үзүүлэх ёстой. Уг арга хэмжээний дүнд тэд ашгаа нэмэгдүүлэх, ашгийнхаа нэлээд хувийг хөрөнгө оруулалтад оруулах сонирхолтой байх болно. Ийм арга хэмжээ нь жилд дор хаяж 1 их наяд рубль нэмэлт хөрөнгө оруулалт бий болгох тооцоолол бий.

Хөнгөлөлтийн хугацааг 1.5-2 дахин бууруулж, хөнгөлөлтийн бодлогыг өөрчлөх шаардлагатай байна. Энэ арга нь хөнгөлөлтийн санг нэмэгдүүлэх бөгөөд хөрөнгө оруулалтыг жилд 1 их наяд рублиэр нэмэгдүүлж, тоног төхөөрөмж, технологио шинэчлэх нэмэлт хөшүүрэг болно.

Хүний капиталд хөрөнгө оруулалт хийх

Хүний капиталд хөрөнгө оруулалт хийх нь дунд болон урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хурдасгадаг. Хувь хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхгүйгээр хүний капиталыг хөгжүүлэх боломжгүй бөгөөд гол бэрхшээл нь хүн амын ихэнх хэсэг орлогын түвшин багатай байдаг оршино. Үүнтэй холбогдуулан хувь хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийхдээ нэн тэргүүнд орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах нь зүйтэй.

Хэрэв 2024 он хүртэл төлөвлөсөн өндөр технологийн болон хүний капитал дахь хөрөнгө оруулалтын чиг хандлага 2030-2035 он хүртэл үргэлжилбэл мэдлэгийн эдийн засгийн ДНБ-д эзлэх хувь 30-35% хүртэл өсөх магадлалтай. Ингэснээр 2030 онд эдийн засгийн хөгжлийн шилжилтийн үе эхлэх ба ОХУ нь Баруун Европын орнуудын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн түвшинтэй эн зэрэгцэх боломжтой болох юм.

4.5.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС²¹⁵

ХБНГУ Ковид-19-ийн анхны батлагдсан тохиолдлыг 2020 оны 1-р сарын 27-нд бүртгэж 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ЕХ-ны хил хязгаар дотроо Франц, Люксембург, Дани, Австри, Швейцар улсуудтай хилийн ихэнх хэсгийг хааж, хатуу хяналтын дор бараа бүтээгдэхүүн, зайлшгүй ажиллах хүчнийг оруулж байсан.

Холбооны Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаас, цар тахлын улмаас учирч буй эдийн засгийн хохирол, нийгмийн сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн олон чухал шийдвэр гаргасан. Тухайлбал, 5 хүртэл тооны ажилтантай ААН-д 3 сарын хугацаанд 9000 евро хүртэл, 10 хүртэл тооны ажилтантай ААН-д 15000 евро хүртэл хэмжээтэй нэг удаагийн санхүүгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Мөн цар тахлын үед Герман Улсад халдвар хамгаалал, эмнэлгийн багаж хэрэгсэл дутагдалтай байсны улмаас Герман Улсын Холбооны Эрүүл мэндийн яам, Дотоод хэргийн яамны хамтарсан штабаас 2020 оны 3 дугаар 4-ний өдрийн хуралдаанаас, амны хаалт, бээлий, хамгаалах өмсгөл зэрэг халдвараас сэргийлэх эмнэлгийн хэрэгслийг гадагш экспортлохыг хориглосон шийдвэрийг гаргаж байсан.

Засгийн газар хилийн боомт, сургууль, зарим бизнесийн салбарыг хаах, тусгаарлалт, хязгаарлалт, амны хаалт хэрэглэх, олон нийтийн цугларалтыг хориглох зэрэг вирусийн тархалтыг бууруулах чиглэлээр олон арга хэмжээ авсан.

Бодлогын зохицуулалт

Парламент дахь сөрөг хүчний намууд 2020, 2021 оны төвлөрсөн төсвийн тодотголыг үндэслэлгүй, бодит шаардлагаас хэтэрсэн гэж шүүмжилсэн, тус улсын Сангийн сайд зардлыг үлэмж хэмжээгээр өссөнийг хүлээн зөвшөөрсөн боловч чухамхүү энэ үед л хөрөнгө гаргахгүй бол ирээдүйд үүнээс илүү хөрөнгийг элгээрээ хэвтсэн аж ахуй нэгжүүдэд өгөх татаас, ажилгүйчүүдэд олгох халамж хэлбэрээр зарцуулахыг онцолсон байна. Ковид-19 хямралтай тэмцэх, дараа нь эдийн засгийн сэргэлтийг дэмжихийн тулд Холбооны засгийн газар дараах гурван нэмэлт төсвийг баталсан.

- 2020 оны 3-р сард 156 тэрбум евро (ДНБ-ний 4.7 хувь),
- 2020 оны 6-р сард 130 тэрбум евро (ДНБ-ний 3.9 хувь),
- 2021 оны 3-р сард 60 тэрбум евро (ДНБ-ний 1.7 хувь).

Нэмэлт төсөвт 2020 оны 11 дүгээр сараас хойш доод тал нь гурван сарын турш орлого нь хоёр дахин буурсан ААН-д дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан. Шалгуурыг хангасан ААН-д бэлэн мөнгөний тусламж авах эрх үүсэх ба орлогынхоо 70-аас дээш хувийн алдагдалтай ажиллаж байгаа ААН-д түрээс, цахилгаан, дулааны зардлын нөхөн төлбөрийг авах боломжтой байна.

Эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-д Ковид-19 цар тахал дэгдсэнээс хойш цар тахлын хариу арга хэмжээ авахад зориулан дараах хууль тогтоомжуудыг баталж, холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

²¹⁵ <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#G>

- Халдварт өвчнөөс хамгаалах тухай хууль (Infectious Diseases Protection Act);²¹⁶
- Ковид-19 цар тахлын үр нөлөөллийг бууруулах тухай хууль (Covid-19 Mitigation Act);²¹⁷
- Ковид-19 цар тахлын үед эмнэлгүүдэд үзүүлэх тусламжийн тухай хууль,
- Улсын хэмжээнд тархсан цар тахлын үед ард иргэдийг хамгаалах тухай хууль (Drittes Gesetz zum Schutz der Bevölkerung bei einer epidemischen Lage von nationaler Tragweite).²¹⁸

Ковид-19 тахлын үед эмнэлгүүдэд үзүүлэх тусламжийн тухай хууль болон **Улсын хэмжээнд тархсан цар тахлын үед ард иргэдийг хамгаалах тухай хуулийг** ХБНГУ-ын Бундестагаас 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр тус тус баталж 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Мөн **Ковид-19 цар тахлын үр нөлөөллийг бууруулах тухай хуулийг** 2020 оны 3 дугаар сарын 27-нд баталсан байна.

2021 оны 4 дугаар сарын 23-ны өдөр Халдварт өвчнөөс хамгаалах тухай хуульд Ковид-19 цар тахлын тархалт, хариу арга хэмжээ авахтай холбоотой агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулсан.

2020 оны 3 дугаар сард ХБНГУ-ын Бундестагаас Халдварт өвчнөөс хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Төлбөрийн чадваргүй байдлын тухай хууль, Эмнэлгийн санхүүжилтийн тухай хууль, Эмийн тухай хууль, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль, Эмнэлгийн төлбөрийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Халдварт өвчнөөс хамгаалах тухай хуульд мал эмнэлгийн хэрэгслийг ашиглах замаар лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ковид илрүүлэх шинжилгээ хийх, эрсдэлтэй бүс нутгаас ирсэн иргэдэд тавигдах нэгдсэн шаардлага, вакцинжуулалтын хөтөлбөр, урьдчилан сэргийлэх төвүүдийг бэлтгэх, тахлын улмаас цэцэрлэг, сургууль нь хаагдсан эцэг эхчүүдийн орлого алдагдсаны нөхөн төлбөр, Ковид-19 өвчилсөн өвчтөнүүдэд эрчимт эмчилгээний ортой байлгахын тулд бусад эмчилгээ үйлчилгээг хойшлуулах, эмнэлгүүдэд нөхөн төлбөр болон эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулах зэрэг үйлчилгээг тусгасан байна.

Халдварт өвчнөөс хамгаалах тухай хуулийн²¹⁹ 28а зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтөөр халдварт өвчний тархалтыг бууруулахын тулд улсын хэмжээний тархалтын үед авч болох арга хэмжээг тусгасан болно. Мөн тус хуульд халдварын тохиолдлын хэмжээнд тааруулан үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна. (7 хоногийн хугацаанд 100.000 хүн ам тутамд бүртгэгдэх тохиолдолд тоо 35-аас доош, 35-аас дээш, 50-аас дээш гм)

Цар тахлын үед Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Ажлын байр, ажилчдын орлогыг хадгалах зорилгоор богино хугацааны ажлын («Курцарбайт») татаасыг өргөтгөх, бага насны хүүхэдтэй, бага орлоготой эцэг эхчүүдэд хүүхдийн асран хамгаалах мөнгө олгох, хувиараа хөдөлмөр

²¹⁶ <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2020-11-24/germany-amendments-to-infectious-diseases-protection-act-enter-into-force/>

²¹⁷ <https://www.jonesday.com/en/insights/2020/04/act-to-mitigate-the-consequences-of-the-covid19-pandemic-under-germanys-civil-insolvency-and-criminal-procedure-law-of-2>

²¹⁸ <https://perma.cc/L4S4-N7MB>

²¹⁹ <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2020-11-24/germany-amendments-to-infectious-diseases-protection-act-enter-into-force/>

эрхлэгчдийн орлогыг хэвээр үлдээх анхан шатны санхүүгийн дэмжлэгийг авахыг хялбар болгосон.

- Ноцтой хохирол амссан жижиг бизнес эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 50 тэрбум еврогийн буцалтгүй тусламж олгох, татвар төлөх хугацааг торгуулийн хүүгүй хойшлуулах, 2020 оны 3 сараас эхлэн орлого буурсан, төрийн байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь бүрэн буюу хэсэгчлэн хаагдсан жижиг, дунд үйлдвэрлэгч, нэг ажилтантай компани, хувиараа хөдөлмөр эрхлэгч, чөлөөт уран бүтээлч болон нийтэд үйлчлэх тусламжийн байгууллагуудад буцалтгүй тусламж үзүүлж 2020 оны 3 дугаар сараас эхлэн 30, 50, 70%-иар орлого буурсан шатлалаар тухайн саруудын өмнөх оны дундаж орлогын 40, 60, 90%-ийг тус тус олгосон. Энэхүү татаасыг 2021 оны 6 дугаар сарыг дуустал хэрэгжүүлэхээр төсөвт тусгасан ба татаасны дээд хэмжээг 50,000 еврогоос 200,000 евро хүртэл нэмэгдүүлсэн байна.
- Ажилгүйдлийн тэтгэмж болон төрсний дараах эцэг эхийн тэтгэмжийн хугацааг сунгах; 6 дугаар сарын урамшууллын багцад НӨАТ-ын түр хөнгөлөлт, гэр бүлийн орлогын дэмжлэг, цар тахлын нөлөөнд шууд болон шууд бусаар өртсөн татвар төлөгчдийн татварыг 2021 оны 6 дугаар сарын 30 хүртэл хойшлуулах, ЖДҮ-д буцалтгүй тусламж, орон нутгийн засаг захиргаанд үзүүлэх санхүүгийн дэмжлэг, экспортлогч болон экспортыг санхүүжүүлэгч банкуудын зээлийн батлан даалтыг өргөжүүлэх, ногоон эрчим хүч, дижитал шинэчлэлд татаас олгох, хөрөнгө оруулалт хийх зэрэг орно. 8 дугаар сард Засгийн газар нь богино хугацааны ажлын тэтгэмж олгох хугацааг 12-24 сар болгон сунгасан.
- Шинээр байгуулагдсан эдийн засгийн тогтворжуулалтын сан (WSF) болон Сэргээн босголтын банк (KfW)-аар дамжуулан Засгийн газар нь салбар бүрийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, зээлдэгч нарын шинэ зээлд эрсдэлийн үнэлгээ хийлгэхгүйгээр буюу эрсдэлийг Холбооны улс бүрэн даан зээлийн батлан даалт гаргаж 3 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай 300,000 евро хүртэл шуурхай зээл авах боломжийг олгож байна. Энэхүү хөнгөлөлттэй зээлийн нийт хэмжээг хамгийн багадаа 757 тэрбум еврогоор (ДНБ-ийг 24 хувиар) тогтоосон. Холбооны улсын СББ-нд 95,000 өргөдөл ирж, зөвшөөрөгдсөн зээлийн хэмжээ 46 тэрбум еврод хүрсэн ба үүний 95% нь Герман Улсын эдийн засгийн суурь үндэс болсон ЖДҮ-д очих юм. Эдийн засгийн тогтворжуулалтын сан, Сэргээн босголтын банк бодлогодоо стратегийн ач холбогдол бүхий компаниудын хувьцааг худалдаж авах механизмыг багтаасан болно.

Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Холбооны Засгийн газрын төсвөөс гадна олон орон нутгийн засаг захиргаа эдийн засгаа дэмжих арга хэмжээ авахаа мэдэгдэж, **141 тэрбум еврогийн шууд дэмжлэг**, ойролцоогоор **70 тэрбум еврогийн зээлийн батлан даалтыг** санал болгож байна.
- Хоёр дахь давлагаатай тэмцэх шинэчилсэн хатуу хөл хориотой зэрэгцэн Засгийн газар нь бизнес эрхлэгчдийг дэмжих үүднээс төсвийн нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлж, одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сайжруулж, тэр дотроо орлогын нөхөн олговор (75 хүртэлх хувь), түүнчлэн улсын зээлийн баталгаа, үндсэн орлогын доод хэмжээний баталгаажуулалтыг оруулсан байна.

ХБНГУ-ын Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөө²²⁰

Европын Комисс Германы Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах төлөвлөгөөнд эерэг үнэлгээ өгч **25.6 тэрбум еврогийн буцалтгүй тусламж**ийн санхүүжилт үзүүлсэн. Ковид-19 тахалын улмаас удааширсан эдийн засгийг сэргээх, тогтворжуулах санхүүжилтийн хүрээнд 2026 он хүртэл Германаас ЕХ-ны нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах, боловсрол, сургалтыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох юм.

Ногоон эдийн засаг болон дижитал шилжилтрүү шилжих, эдийн засгийг бэхжүүлэх замаар нийгмийн уян хатан байдал ба нэгдсэн зах зээлийг бий болгох юм.

Энэхүү төлөвлөгөө нь эдийн засгийн томоохон хэмжээний дэмжлэг үзүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй шинэчлэл хийх, төрийн захиргааг цахимжуулах, боловсрол, сургалтыг сайжруулахад оршино.

Ногоон эдийн засгийн шилжилтийг хангах арга хэмжээ

Төлөвлөгөөний **42%**-ийг уур амьсгалын зорилтыг дэмжсэн хөрөнгө оруулалт, шинэтгэл эзэлж байна.

- Ногоон технологи: бүх үе шатанд ногоон эдийн засагт хөрөнгө оруулах нүүрсхүчлийн хийг бууруулахад 1.5 тэрбум евро;
- Цахилгаан хөдөлгүүрт машиныг дэмжих: 800,000 гаруй автомашинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулахад 2.5 тэрбум евро
- Орон сууцны барилгын эрчим хүчний хэмнэлт: Орон сууцны эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор засварын хөтөлбөр, барилга байгууламжид 2.5 тэрбум евро

Дижитал хувьслыг дэмжих арга хэмжээ

Төлөвлөгөөний нийт хөрөнгө оруулалтын **52%** нь дижитал зорилтын дэмжлэгүүд эзэлж байна.

- Микроэлектроник ба харилцаа холбооны технологид оруулах хөрөнгө оруулалт;
- Европын холбооны хэмжээнд хэрэгжүүлж буй электроникийн зохион бүтээх чадавх, эрчим хүч бага зарцуулдаг дараагийн үеийн процессоруудыг боловсруулж, нэвтрүүлэх санаачилгын дэмжлэгт 1.5 тэрбум евро;
- Дараагийн үеийн үүлэн технологийн дэд бүтцийн үйлчилгээ: Европын холбооны хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон санаачилга болох шинэлэг, ухаалаг шийдлүүдийг ашиглах томоохон хувь нэмэр оруулах аж үйлдвэрийг дэмжих, түүний аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлттэй, мэдээллийн хамгаалалттай байдлыг бүрдүүлэхэд 750 сая евро;
- Төрийн үйлчилгээг цахимжуулах: 2022 он гэхэд 115 гаруй холбооны болон 100 бүс нутгийн нийтийн үйлчилгээг тоон хэлбэрт шилжүүлэхэд 3 тэрбум евро.

Эдийн засгийг бэхжүүлэх арга хэмжээ

- Холбооны болон бүс нутгийн түвшинд хөрөнгө оруулалтын саад тотгорыг арилгахад хамтран ажиллах хөтөлбөр: үйл ажиллагааны хэрэгжүүлэх захиргааны төлөвлөлт, зөвшөөрлийн журмын нөхцөлийг уян хатан болгох, санхүүжилтийн татаас авах хүсэлтийг стандартчилах, хурдасгах, орон сууцны барилгад хөрөнгө оруулах, бизнесийн үйл ажиллагааг дараагийн үед шилжүүлэхийг дэмжих, тоог нэмэгдүүлэх;


²²⁰ https://ec.europa.eu/info/system/files/germany-recovery-resilience-factsheet_en.pdf

- Хүүхэд харах үйлчилгээний хөрөнгө оруулалтын хөтөлбөр: нэмэлтээр 90,000 хүүхдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хүүхэд харах үйлчилгээний газруудыг шинээр барьж, тохижуулах хүүхэд асрах газруудад 500 сая евро;
- Хямралын үед сурагчдад үзүүлэх дэмжлэг: сургалтын байгууллагуудыг дэмжих, дадлагажигч ажилчдыг ажлын байраар хангахад 725 сая евро;
- Эмнэлгийг шинэчлэх хөтөлбөр: Эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулах, орчин үеийн стандартад нийцүүлэх, дижитал дэд бүтэц, яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах, телемедицин, робот техник, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын хангах ажиллахад 3 тэрбум евро;
- Оюутнуудад зориулсан боловсролын дэмжлэг: Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүссэн сургалтын хоцрогдлыг арилгах, нэмэлт сургалт давтлага зөвлөгөө өгөх чиглэлээр ялангуяа эмзэг бүлгийн сурагчдад тусламж үзүүлэх.

4.6. ТАЙВАНЬ

“Ковид-19” цар тахлын нөхцөл байдал

Зураг 12. Ковид-19 цар тахлын нийт бүртгэгдсэн тохиолдол²²¹ /2020.02.05-2021.09.04-ны байдлаар/



Тайвань нь “Ковид-19” цар тахал дэгдсэнээс хойш зөөвөрлөгдсөнөөс бусад тохиолдлын халдварын тоог “тэг” хэвээр хадгалсан амжилтыг дэлхийн нийтэд тогтоогоод байсан. Харин 5 дугаар сарын дунд үеэс 6 дугаар сарын сүүл хүртэл коронавирусийн мутацлагдсан хувилбар эрчимтэй тархаж, хамгийн оргил үедээ (2021.5.19) өдөрт 543 шинэ тохиолдолд бүртгэгдэж, 37 нас баралт бүртгэгдээд байсан. Одоо өдөрт 10 хүрэхгүй тохиолдол бүртгэгдэж, нийт 16013²²² тохиолдол бүртгэгдсэн нь харьцангуй бага бөгөөд дэлхийн 200 орчим орноос 151 дүгээрт жагсаж байна.

²²¹ Дэлхийн статистикийн мэдээ. <https://www.worldometers.info/coronavirus/country/taiwan/> 2021.09.04-нд хандсан.

²²² 2021.09.04-ний байдлаар

Эдийн засгийн нөхцөл байдал

Хүснэгт 13. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд²²³ /2018-2022* он/

	Гол үзүүлэлтүүд	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	ДНБ (тэрбум.доллар)	608.13	612.17	668.51	759.1	810.67
2	Эдийн засгийн өсөлт, ДНБ	2.7	3	3.1	4.7	3
3	Нэг хүнд ноогдох ДНБ (доллар)	25	25e	28	32	34
4	Төсвийн алдагдал (in % of GDP)	-1.9	-1.9	-4.5	-2.8	-1.6
5	Засгийн газрын нийт өр (in % of GDP)	34	32.7	33.7	32.5	31
6	Инфляцийн түвшин (%)	1.5	0.5	-0.2	0.9	1.2
7	Ажилгүйдлийн түвшин (%)	3.7	3.7e	3.9	3.8	3.8
8	Current Account (тэрбум.доллар)	70.84	65.16	94.28	109.78	116.77
9	Current Account (in % of GDP)	11.6	10.6	14.1	14.5	14.4

2019 онд Тайванийн эдийн засгийн өсөлт Хятад АНУ-ын хоорондын “худалдааны дайн”-ы хурцадмал байдал зэргээс шалтгаалан харьцангуй бага буюу 3%-тай байсан байна. Мөн Ковид-19 тахлын үед буюу 2020 онд 3.1%-иар өссөн нь дэлхийн²²⁴ хамгийн сайн үр дүнгүүдийн нэг болсон байна. ОУВС-ийн сүүлийн урьдчилсан мэдээгээр, цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийг харгалзан 2021 онд 4.7% болж өсөж, 2022 онд 3% хувь болж тогтворжино гэж таамаглажээ.²²⁵

Тайванийн төсөв 2019 онд -1.9%-ийн алдагдалтай байсан бөгөөд Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд -4.5% болж өссөн байна. Харин төсвийн алдагдал 2021 онд -2.8%, 2022 онд 1.6% болж буурах тооцоолол гаргажээ. Засгийн газрын нийт өр нь 2020 онд ДНБ-нийхээ 33.7% байгаа бол 2021 онд 32.5%, 2022 онд 31% болно гэж мөн тооцоолжээ.

Хууль, эрх зүйн орчин

Тайвань нь 2003 онд дэлхий даяар SARS буюу H1N1 вирусийн амьсгалын замын цочмог хам шинж өвчин дэгдэхэд хувь хүний эрх чөлөөг хязгаарласан үйл ажиллагаа явуулсан, албадан үзлэг хийсэн, цагдан хорьсон гэдэг асуудал үүссэн. Энэ хэрэг эцэстээ Тайванийн Үндсэн хуулийн шүүхийн асуудал болж хувирсан. Тайванийн Үндсэн хуулийн шүүх тухайн үед үйлчилж байсан SARS урьдчилан сэргийлэх түр хууль (2004 онд хүчингүй болсон), Халдварт өвчинтэй тэмцэх тухай хууль (CDC Act) үндсэн хууль зөрчөөгүй байна гэж үзсэн. Харин халдварт өвчинтэй тэмцэх тухай хуульд нарийвчилсан зохицуулалтуудыг илүү тодорхой болгох, нөхөн олговрын асуудлыг тусгаж өгөхийг зөвлөсөн.²²⁶ Тайванийн Үндсэн хуулийн шүүхийн зөвлөмжийн дагуу тус хуульд томоохон өөрчлөлт оруулсан бөгөөд 2019 онд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ нь Ковид-19 цар тахал дэгдэхээс өмнө Тайвань 2003 оны SARS өвчний туршлагаараа хууль эрх зүйн хувьд, институтын хувьд, нийгмийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, туршлага цуглуулсан байна.

Ковид-19 цар тахлын эсрэг эрх зүйн орчин:

1. Халдварт өвчинтэй тэмцэх тухай хууль (CDC Act) болон түүнийг дагалдах журмууд;

²²³ World Economic Outlook Database, April 2021, https://santandertrade.com/en/portal/analyse-markets/taiwan/economic-outline?actualiser_id_banque=oui&id_banque=0

²²⁴ Дэлхийн банк. <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD.ZG> 2020 оны ДНБ, улс орнуудаар

²²⁵ Тайваний эдийн засгийн тойм https://santandertrade.com/en/portal/analyse-markets/taiwan/economic-outline?actualiser_id_banque=oui&id_banque=0 2021.09.04-нд хандсан.

²²⁶ Тайваны Ковид-19 ийн эсрэг тэмцэл: Үндсэн хууль, хууль тогтоомж, Вэн Чен Чан, 2020.02.21 <https://verfassungsblog.de/taiwans-fight-against-covid-19-constitutionalism-laws-and-the-global-pandemic/>

2. Ковид-19-ийн “тусгай” хуульд үндэслэн үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой байна. (Уг хуульд төсөвлөсний дагуу эдийн засгийг сэргээх төлөвлөгөө)

1. Халдварт өвчинтэй тэмцэх тухай хууль (CDC Act²²⁷)

Уг хууль нь 1944 онд батлагдсан, 7 бүлэг 77 зүйлтэй бөгөөд хуулиар халдварт өвчний хяналт, нийгмийн эрүүл мэндийн яаралтай тусламжийн үед авах засгийн газрын үйл ажиллагааны хүрээг гаргаж өгсөн байна. Мөн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах бодлого, төлөвлөгөө боловсруулах, орон нутгийн эрх бүхий байгууллагуудыг хянах, удирдах, удирдан чиглүүлэх, үнэлэх эрх мэдлийг зааж өгсөн. Орон нутгийн эрх бүхий байгууллагууд дээрх төлөвлөгөөний дагуу халдварт өвчинтэй тэмцэх бодлого, төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх ёстойг тусгаж өгсөн. Хуулийн бүтцийн хувьд дараах бүлгүүдтэй байна.

- 1-р бүлэг. Ерөнхий зарчим
- 2-р бүлэг. Өвчний хяналтын систем
- 3-р бүлэг. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
- 4-р бүлэг. Өвчний хяналтын үйл ажиллагаа
- 5-р бүлэг. Хорио цээрийн үйл ажиллагаа
- 6-р бүлэг. Хариуцлага
- 7-р бүлэг. Нэмэлт заалт

2. Ковид-19-ийн “тусгай” хууль²²⁸

Тайванийн хууль тогтоох байгууллага 2020 оны 2 дугаар сарын 25-нд 19 зүйл, заалт бүхий “Ковид-19”-ийн тусгай хууль (Special Act on COVID-19 Prevention, Relief and Restoration)-ийг баталсан бөгөөд анхны тусгай төсвийг 60 тэрбум Тайвань доллар (2 тэрбум ам.доллар) байхаар тооцжээ. Дэлхий даяар цар тахал даамжрахын хэрээр уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тусгай төсвийг 150 тэрбум тайвань доллараар тэлж, нийт 210 тайвань доллар болсон байна (7.1 тэрбум ам.доллар).

2021 оны 5 дугаар сарын 31-нд хуулийн хугацааг дахин 1 жил буюу 2022 оны 6-р сарын 30 хүртэл сунгаж, Ковид-19-ийн тусгай төсвийг Тайванийн зорилтод бүлгийн 7.3 сая (нийт хүн ам 23.8 сая²²⁹) хүн амд хүргэх зорилгоор өргөжүүлсэн бөгөөд төсвийн нийт хэмжээг 840 тэрбум тайвань доллар (30.37 тэрбум ам.доллар) байхаар тооцжээ.²³⁰

Уг хуульд тусгагдсан төсөв нь Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэхэд засгийн газрын тусламж, нөхөн олговор олгох, эдийн засгийг дэмжихэд зарцуулагдахаар заасан. Хуульд зааснаар:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хянах, эмнэлгийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж үзүүлж буй эмнэлгийн ажилтнуудад тэтгэмж, урамшуулал олгох (2-р зүйл);
- Гэрийн тусгаарлалт, гэрийн хорио цээр, бүлгийн тусгаарлалт, бүлгийн хорио цээрийн дэглэмд хамрагдсан хүмүүс, түүнчлэн тэдгээр хүмүүсийг асран халамжилж буй гэр бүлийн гишүүдэд нөхөн төлбөр, цалинтай чөлөө олгох тухай (3-р зүйл);

²²⁷Халдварт өвчинтэй тэмцэх тухай хууль (1944 он) хамгийн сүүлд 2019.06.19-нд нэмэлт өөрчлөлт орсон <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=L0050001> 2021.09.04 хандсан.

²²⁸ “Ковид-19” тусгай хууль <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=L0050039> 2021.09.04 хандсан.

²²⁹ Дэлхийн статистикийн мэдээ. <https://www.worldometers.info/world-population/population-by-country/> 2021.09.04 хандсан.

²³⁰ Өнөөдрийн Тайвань сайт. <https://taiwantoday.tw/news.php?unit=2&post=201560> 2021.09.04 хандсан.

- Мөн эдийн засгийн багц арга хэмжээг авахаас гадна үнийн өсөлт, ташаа мэдээлэл өгөх, тусгаарлалт, хорио цээрийн дэглэм зөрчсөн тохиолдолд авах шийтгэл болон нөхөн олговрын асуудлыг тусгасан. (7, 9, 12-16-аар зүйл).

“Ковид-19”-ийн тусгай хуулийн дагуу төсөвлөсөн 210 тэрбум тайвань доллараас 137.6 тэрбум тайвань долларыг эдийн засгийг дэмжихэд, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд 37.4 тэрбум тайвань доллар, аялал жуулчлал болон агаарын тээврийн салбарт 9.8 тэрбум тайвань долларыг хуваарилсан байна.

Эдийн засгийг сэргээх арга хэмжээ

1. ДЭД БҮТЭЦ, ЖИЖИГ ДҮНД БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

Тайванийн Засгийн газар Ковид-19-ийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2020 оны 6 дугаар сарын 22-нд дараах хөтөлбөрийг баталсан байна. Үүнд:

Гурвалсан урамшууллын ваучерын хөтөлбөр

Тайванийн Засгийн газар Ковид-19-ийн дараа орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх зорилготой "Гурвалсан урамшууллын /Tripe stimulus/ эрхийн бичгийн хөтөлбөр"-т зориулж 51.1 тэрбум тайвань доллар төсөвлөсөн байна.

Үндсэн арга хэмжээ

Хөтөлбөр нь Тайванийн иргэд болон тэдний гадаадын харьяат эхнэр, нөхөрт 3000 тайвань долларын эрх бүхий эрхийн бичгийг 1000 тайвань доллараар худалдаж авах боломжийг олгосон. Эрхийн бичгийг дор дурдсанаас бусад бүх зардалд ашиглаж болно.

- Ус, цахилгааны төлбөр;
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн үндсэн төлбөр, хүү, зээлийн картын үлдэгдэл болон бусад үйлчилгээний төлбөрийг төлөх;
- Хувьцаа, компанийн бонд, опцион, даатгал болон бусад санхүүгийн бүтээгдэхүүн худалдан авах
- Засгийн газрын торгууль, хураамж, татвар, нийгмийн даатгалын шимтгэл болон хуульд заасан бусад өр төлбөр төлөх;
- Тамхи, бараа (эсхүл үйлчилгээний) эрхийн бичиг болон бусад урьдчилгаа төлбөртэй зээл худалдаж авах;

Тайлбар

- Голчлон жижиглэн худалдаа, үйлчилгээний салбар болон бизнесийн бусад салбарууд

2. ТАТВАРЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ²³¹

Тайванийн Засгийн газар Ковид-19-ийн эсрэг хариу арга хэмжээний хүрээнд өргөн хүрээний татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг авч байна. Нөхцөл байдлаас шалтгаалан арга хэмжээний байдал өөрчлөгдөж байгаа тул 2020.09.30-ны байдлаарх мэдээллийг оруулав.

Татварын төлбөрийг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлөх

2020 оны 3-р сарын 25-ны өдөр Тайванийн Сангийн яам татвар төлөхөд хүндрэлтэй байгаа татвар төлөгчдөд татварын төлбөрөө хойшлуулах, эсхүл сар бүр хэсэгчлэн хувааж төлөх хүсэлт гаргах тусгай удирдамж гаргасан.

²³¹ Тайванийн Ковид-19-ийн эсрэг засгийн газар болон байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/taiwan-government-and-institution-measures-in-response-to-covid.html> 2021.09.04 хандсан.

Хамаарах хугацаа

Тусгай удирдамж нь 2020 оны 01-р сарын 15-наас 2021 оны 6-р сарын 30-ны хооронд төлөх татварын төлбөрт хамаарна. (Дээрх зохицуулалтын үйлчлэх хугацааг 2022 оны 6-р сарын 30-ны өдөр болгож сунгасан.)

Хамаарах татвар төлөгчид

Ковид-19-ийн улмаас татварын төлбөрийг хуульд заасан хугацаанд татвар төлөхөд бэрхшээлтэй байгаа татвар төлөгчид татварын төлбөрийн хоцроож төлсний торгуульгүйгээр 12-36 сарын хугацаанд сар бүр хэсэгчлэн төлөх хүсэлт гаргаж болно. Энэхүү хүсэлт гаргахдаа дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

Аж ахуйн нэгжийн хувьд:

- Холбогдох эрх бүхий байгууллагаас заасан Ковид-19 тусгай тусламж, сэргээн босголтын холбогдох журмын дагуу дэмжлэг авах эрх нь үүссэн;
- Бизнесийн орлого мэдэгдэхүйц буурсан байх. Жишээ нь: сүүлийн 6-12 сарын дундажтай харьцуулахад 2020 оны 01-р сараас хойш хоёр сарын хугацаанд барааны эргэлт 15% ба түүнээс дээш хувиар буурсан.

Хувь хүмүүсийн хувьд:

- Холбогдох эрх бүхий байгууллагаас заасан Ковид-19 тусгай тусламж, сэргээн босголтын холбогдох журмын дагуу дэмжлэг авах эрх нь үүссэн;
- Коронавируст халдвар (Ковид-19)-ийн нөхцөл байдалд нэрвэгдсэн ажил олгогчийн хэрэгжүүлж буй цалинтай, эсхүл хэсэгчилсэн цалинтай чөлөө олгох хуваарийн дагуу орон нутгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагад урьдчилан мэдэгдсэн;
- Ковид-19-ийн улмаас амьдралын нөхцөл хүндэрсэн (Тухайлбал, цалингаа хасуулах, ажлаас халах, эсхүл сарын ажлын өдрүүд нь хоёр ба түүнээс дээш сарын хугацаанд 50%-иар цөөрсөн).

Ковид-19 цар тахалд нэрвэгдсэн аж ахуйн нэгжийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлөхөөс чөлөөлсөн. Үүнд:

Хувь хүний орлогын албан татвар, амины орон сууц, газрын гүйлгээний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, бараа бүтээгдэхүүний татвар, архи, тамхины татвар, тусгайлан сонгосон бараа, үйлчилгээний татвар, байшингийн татвар, газрын албан татвар, тээврийн хэрэгслийн лицензийн татвар болон эдгээр татварын холбогдох хүү, торгууль орно.

Хамаарах хугацаа

Энэхүү шийдвэр нь 2020 оны 01-р сарын 15-наас 2021 оны 6-р сарын 30-ны хооронд төлбөл зохих ёстой аж ахуйн нэгжийн 2020 оны орлогын албан татварт хамаарна.

Хамаарах татвар төлөгчид

Дээрх шийдвэр нь дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан аж ахуйн нэгжүүдэд хамаарна.

- Холбогдох эрх бүхий байгууллагаас заасан Ковид-19 тусгай тусламж, сэргээн босголтын холбогдох журмын дагуу дэмжлэг авах эрх нь үүссэн;
- Бизнесийн орлого мэдэгдэхүйц буурсан байх. Жишээ нь: сүүлийн 6-12 сарын дундажтай харьцуулахад 2020 оны 1-р сараас хойш хоёр сарын хугацаанд барааны эргэлт 15% ба түүнээс дээш хувиар буурсан.

Цалингийн тодорхой зардалд зориулах зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 200 хувиар хасах

Ковид-19-ийн нийгэм, эдийн засагт учруулж буй нөлөөг бууруулах зорилгоор 2020 оны 2-р сарын 25-нд зарласан Ковид-19-ээс урьдчилан сэргийлэх, тусламж, сэргээн босгох тухай тусгай хуулийн нэг хэсэг болгон Тайванийн Сангийн яам 2020 оны 3-р сарын 10-ны өдөр татварын тогтоол гаргасан. Уг тогтоолд компаниуд Ковид-19-д өртсөн ажилчдын цалингийн нэмэлт зардлыг татвараас хэрхэн хасах талаар зааврыг тусгажээ.

Хамаарах хугацаа

Тусгай хууль нь 2020 оны 01-р сарын 15-аас 2021 оны 6-р сарын 30 хүртэл хүчинтэй байна. (Дээрх зохицуулалтын үйлчлэх хугацааг 2022 оны 6-р сарын 30-ны өдөр болгож сунгасан.)

Холбогдох зардал

Хуулиар дараах шалтгааны аль нэгэнд хамаарах ажилчдын цалин хөлс, үйлчилгээний хөлс болон бусад тогтмол нөхөн олгохоор заасан. Үүнд:

- Эрүүл мэндийн болон, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээрийн дэглэм буюу тусгаарлах захиргааны актын дагуу;
- Хорио цээрийн дэглэмд байгаа болон тусгаарлагдсан хүмүүсийн гэр бүлийн хараат хүмүүсийг асран халамжлахаар бол;
- Засгийн газрын тархварын эсрэг командын төвөөс (УОК-той төстэй) тусгай заавар авсны дараа.

Бусад дэмжлэгийн арга хэмжээ

Дээрх арга хэмжээнээс гадна Тайванийн Засгийн газар Ковид-19-ийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан сул зогссон хугацаанд байшингийн татвар, тээврийн хэрэгслийн лицензийн татварыг түр хөнгөлөх бусад хөнгөлөлтийн бодлогыг гаргасан байна. Үүнд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогссон хугацаанд тусгай үнэлгээний журмаар татвар төлөгчдийг НӨАТ, баяр, ёслолын татвараас хувь тэнцүүлэн чөлөөлөх зэрэг багтсан.

3. ЗЭЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ, ХОЙШЛУУЛАЛТ, ХҮРТЭЭМЖИЙГ ӨСГӨХ

Санхүүгийн тусламж

Төрийн банкуудын үзүүлэх гурван арга хэмжээ

1. Бодлогын зээлийн багц: Бизнес эрхлэхийн тулд ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжих.
2. Зээлийн сунгалт: Компаниуд эсхүл хувь хүмүүс үндсэн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, эсхүл зээлээ сунгах хүсэлт гаргаж болно.
3. Зээлийн картын төлбөрийг хойшлуулах: Хувь хүмүүс торгууль, хүүгүйгээр картын төлбөрөө хойшлуулах хүсэлт гаргаж болно.

Төрийн банкуудын зээлийн хүүг бууруулах арга хэмжээ

- Орон сууцны зээл (бүх зээлийн хувьд): 2020.09.30-наас 0.25%-иар бага
- Хэрэглээний зээл (бүх зээлийн хувьд): 2020.09.30-наас хойш 0.25%-иар буурсан (зээлийн карт, барьцаагүй зээл, автомашины зээл орно)

Түрээс ба концессийн зохицуулалт

- Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг хойшлуулах: Ковид-19 цар тахал өвчинд нэрвэгдсэн төрийн өмчийн хэрэглэгчид 2020 оны эцэс хүртэл түрээсийн төлбөрөө хойшлуулах боломжтой.

- Түрээсийн төлбөр/роялтийн төлбөрийг хойшлуулах, Цар тахлын нөлөөнд өртсөн дэд бүтцийн төслүүдийн барилга байгууламж, ашиглалтын хугацааг сунгах: Цар тахлын нөлөөнд өртсөн дэд бүтцийн төслүүдэд хувийн хэвшлийн оролцоог дэмжих хувийн байгууллагууд түрээсийн төлбөр/роялтийн төлбөрийг хойшлуулах, төлбөрийг хэсэгчлэн төлөх, барилга, ашиглалтын хугацааг сунгах хүсэлт гаргаж болно.

4. ЭКСПОРТЫГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, НЭМЭГДҮҮЛЭХ

Аж үйлдвэрийн гол салбарууд²³²

Хөдөө аж ахуйн салбар ДНБ-д маш бага хувийг эзэлж (албан ёсны статистикийн байгууллагын мэдээллээр 2020 онд ойролцоогоор 2%-тай тэнцэж байна), ажиллах хүчний 5% орчим нь тус салбарт ажилладаг. Тайванийн гол тариа бол будаа, чихрийн нишингэ, жимс жимсгэнэ, хүнсний ногоо юм. Тайвань нь байгалийн баялаг хязгаарлагдмал байдаг.

Хоёрдогч салбар нь ДНБ-ний 36 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд ажиллах хүчний 35 орчим хувийг ажиллуулдаг. Төмөр, ган, химийн бодис, машин механизм үйлдвэрлэл гэх мэт уламжлалт салбарууд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний бараг тал хувийг эзэлдэг боловч шинэ салбарууд илүү динамик байдаг. Тайвань бол хагас дамжуулагч, компьютер, гар утас нийлүүлдэг дэлхийн хамгийн том нийлүүлэгчдийн нэг юм.

Үйлчилгээний салбар нь ДНБ-ний 62.7%-ийг эзэлж, ажиллах хүчний 59.7% тус салбарт ажилладаг. Хөдөлмөр их шаарддаг томоохон үйлдвэрүүдийг зардал багатай орнууд руу үргэлжлүүлэн шилжүүлэх асуудал тулгараад буй Тайваньд илүү дэвшилтэт технологи, үйлчилгээнд суурилсан эдийн засагт шилжихийн тулд шинэлэг өөрчлөлт хийх шаардлага тулгарч байна.

Ковид-19-ийн үеийн экспорт, импортын хязгаарлалт, арга хэмжээ

Хүснэгт 14. Ковид-19-өөс шалтгаалсан экспорт, импортын хязгаарлалт, арга хэмжээ²³³

Төрөл	Бүтээгдэхүүн	Хэмжих	Худалдаанд үзүүлэх нөлөө	Хэмжилтийн байдал	Эхлэх огноо	Дуусах огноо
Тарифыг бууруулах	этилийн спирт	Химийн гаралтай этилийн спиртийн импортын татварыг түр хугацаанд бууруулах.	Чөлөөлөх	Цуцалсан	2/27/20	8/26/20
Экспортын хориг	гар ариутгагч ба ариутгагч бодис	75%-ийн спирттэй гар ариутгагч, ариутгагч бодис экспортлохыг хориглосон.	Хязгаарлах	Цуцалсан	5/1/20	6/15/20
Экспортын хориг	амны хаалт	Дотоодын хэрэгцээг хангах хүртэл эмнэлгийн хэрэгсэл, мэс заслын маск экспортлохыг хориглов	Хязгаарлах	Цуцалсан	3/24/20	6/1/20
Гэрчилгээжүүлэх шаардлага	түр гэрчилгээ	COVID-19 тахлын үед мал эмнэлгийн болон ургамлын гаралтай эрүүл мэндийн анхны гэрчилгээг танилцуулах түр хувилбарууд.	Чөлөөлөх	Цуцалсан	3/31/20	8/31/20

²³² https://santandertrade.com/en/portal/analyse-markets/taiwan/economic-outline?actualiser_id_banque=oui&id_banque=0

²³³ <https://www.macmap.org/covid19>

Тарифыг бууруулах	амны хаалт	COVID-19 тахлын улмаас маскны импортын тарифыг (7.5%-аас) түр зуур арилгаж, нэхмэл материалын 94% ба түүнээс дээш хувийн үр ашигтай шүүлтүүрийн үр ашгийг (HS 6307.90.50) хасав.	Чөлөөлөх	Цуцалсан	2/27/20	5/26/20
Зарим бүтээгдэхүүнийг импортлох зөвшөөрлийн шаардлага	эмнэлгийн амны хаалт	Эмнэлгийн маск импортлох зөвшөөрөл авахын тулд урьдчилан хүсэлт гаргах ёстой.	Хязгаарлах	Идэвхтэй	9/16/20	---
Тарифыг бууруулах	эмийн спирт	Эмийн согтууруулах ундааны орчны импортын татварыг түр хөнгөлөх.	Чөлөөлөх	Идэвхтэй	2/27/21	8/26/21

5. АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Хөдөлмөрийн зах зээлийн дэмжлэг

Хөдөлмөрийн яам одоо байгаа арга хэмжээг хянаж, өргөжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн шинэ арга хэмжээг нэмж оруулав.

• Ажлын цагийг багасгах

- Сургалтын хөтөлбөр: 18,960 тайвань доллар хүртэлх сургалтын тэтгэлэг
- Хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө: 11,000 тайвань доллар хүртэлх цалингийн тэтгэмж
- Шуурхай ажлын төлөвлөгөө: 12,640 тайвань доллар хүртэл цалингийн тэтгэмж

• Ажилгүйдлийн

- Ажилгүйдлийн тэтгэмж: Даатгалыг сарын дундаж цалингийн 60% хувиар
- Хүүхдүүдийн сургалтын төлбөрийн тэтгэмж /ажилгүй хүн/: Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 6000 тайвань доллар хүртэл/ их сургууль, коллежийг 24,000 тайвань доллар хүртэл

• Байгууллагын

- Ажлын орчныг сайжруулахад зориулсан тэтгэмж: 2 сая тайвань доллар хүртэлх тэтгэмж олгох /аюулгүй байдал, эрүүл ахуйн тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр/
- Ажилчдын амьдралын тэнцвэрийг хангах тэтгэмж: асран хамгаалах ажил эрхлэгчдийн цагийн цалин 200,000 тайвань доллар хүртэл
- Хөдөлмөрийн даатгалын шимтгэл, тэтгэврийн шимтгэлийг хойшлуулах: торгуульгүйгээр төлбөрийг хойшлуулах
- Сургалтын хөтөлбөр: 3 сая тайвань доллар хүртэлх сургалтын хөтөлбөрийн тэтгэмж

6. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫГ ХАНГАХ

Арилжааны банкуудын санхүүжилтийн хоёр багц

- 100 тэрбум долларын багц (Нөлөөлөлд өртсөн бүх бизнес)
 - 10 тэрбум тайвань долларын төсөл
 - Банк 100 тэрбум тайвань долларын зээл олгох
 - Зээл ба үнэлгээний харьцаа /LTV/ харьцаа 80%~ 100%
- Хүүгийн тусламжийн багц (Зөвхөн цар тахлын нөлөөлөлд өртсөн ЖДҮ эрхлэгчдийн хувьд)
 - Өргөтгөсөн зээл
 - Бизнесийн зээл
 - Бизнесийг нөхөн сэргээх зээл

Хүснэгт 15. Арилжааны банкуудын санхүүжилтийн багц (NTD-тайвань доллар)

	100 тэрбум NTD	Хүүгийн татаас	
	(Баталгааны шимтгэл авахгүй)	Зээлийн хүү	хугацаа
Сунгасан зээл	Анхны баталгааны хувь	0.81%	1 жил
		220,000 NTD хүртэл (хүсэлт бүрт)	
Бизнесийн зээл (Зөвхөн цалин ба түрээс) (ажлаас чөлөөлөөгүй нөхцөлд)	Баталгааны хувь 100%	1.845%	6 сар
		55,000 NTD хүртэл (хүсэлт бүрт)	
Бизнесийг нөхөн сэргээх зээл	Баталгааны хувь 80%~90%	0.845%	1 жил
		220,000 NTD (хүсэлт бүрт)	

4.7.ЯПОН

Ковид-19 тахлын улмаас үүссэн дэлхийн эдийн засгийн хямрал ихээхэн нөлөө үзүүлж, 2020 онд тус улсын ДНБ -4.8% хүртэл буурчээ.²³⁴ Энэхүү уналтад нөлөөлсөн гол хүчин зүйлүүдийн нэг нь дотоодын хэрэглээ огцом буурсан явдал гэж үзэж байна. Японы Засгийн газраас **1 их наяд орчим ам.доллартай** тэнцэх төсөв бүхий **Эдийн засгийг эрчимжүүлэх багц хуулийг** баталсан бөгөөд энэ нь Японы ДНБ-ний 20 гаруй хувьтай тэнцэж байгаа нь 2008 оны санхүүгийн хямралын үед авч хэрэгжүүлсэн хөшүүргийн багцаас хоёр дахин их юм.

Япон улсад Ковид-19 тахлын улмаас эдийн засгийн идэвхжил мэдэгдэхүйц буурч, улсын санхүү суларч8 ОУВС-гийн 2021 оны 4-р сарын шинэчилсэн тооцоогоор 2020 онд улсын өр ДНБ-ний 256.2%-д хүрсэн байна.

Түүнчлэн, нийгмийн зардал нэмэгдэхийн хэрээр хямралын нөлөөг намжаах арга хэмжээний улмаас засгийн газрын алдагдал харьцангуй өссөн байна. Японы төсвийн алдагдал 2020 онд -11.3% байсан бол 2021 онд -8.5%, 2022 онд -3.6% болж буурах төлөвтэй байна.

Японы Ерөнхий сайд Ёшихидэ Суга 2020 оны 12 -р сард Японы эдийн засгийг эрчимжүүлэх шинэ төлөвлөгөөг зарласан. 73.6 их наяд иений (708 тэрбум доллар) багцад 2050 он гэхэд нүүрстөрөгчийн саармагжуулалтыг дэмжихэд 19.2 тэрбум доллар, тоон хувиргалтыг хурдасгахад 9.6 тэрбум доллар, тахлын улмаас худалдааны цагаа богиносгосон зоогийн газруудыг дэмжихэд 14.4 тэрбум долларын татаас өгөхөөр төлөвлөсөн байна.

²³⁴ <https://santandertrade.com/en/portal/analyse-markets/japan/economic-political-outline>

Түүнчлэн тэтгэвэр тэтгэмж, эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах зардлаа үргэлжлүүлэн өсгөх хандлагатай байна.

Эдийн засгийг сэргээх төлөвлөгөөний тойм

Сэргээх төлөвлөгөө:²³⁵ Ковид-19-ийг даван туулах эдийн засгийн яаралтай арга хэмжээ

Төсөв: 234.2 их наяд иен

Мэдэгдэл: 2021 оны 4-р сарын 20 (1 -р багц), 2021 оны 5-р сарын 27 (2 -р багц)

Үндсэн чиглэл: аялал жуулчлал, тээвэр, хувийн бизнес гэх мэт.

Япон Улсад²³⁶ 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр дотоодын анхны халдварын тохиолдолд батлагдсанаас хойш гаднаас халдварт өвчин дамжин орж ирэхээс сэргийлэх талаар анхааран ажиллаж, хилийн хорио цээрийн хяналт шалгалтыг улам сайжруулах, Халдварт өвчин судлалын үндэсний төвд хийж буй шинжилгээг Бүс нутгийн ариун цэвэр, эрүүл ахуй судлалын төвд хийх боломжоор хангах, иргэдийг хурдан шуурхай үнэн зөв мэдээллээр хангах зэргээр дотоодод халдвар тархахаас сэргийлэн ажиллахыг Ерөнхий сайд Шинзо Абэ холбогдох сайдуудад үүрэг болгосон.

Засгийн газраас 2020 оны 02 дугаар сарын 13-нд шинэ хэлбэрийн короновирусийн эсрэг хэрэгжүүлэх анхдугаар арга хэмжээг тогтоож, нийт 15 тэрбум 300 сая иен зарцуулахаар шийдвэрлэж, эх орондоо буцаж ирэгсдэд 3 тэрбум иенийн тусламж үзүүлэх, дотоодод халдварлах эрсдэлийн эсрэг 6 тэрбум 500 сая иен, хилийн хорио цээрийн шалгалтыг сайжруулахад 3 тэрбум 400 сая иен зарцуулах зэрэг арга хэмжээ авчээ.

Улмаар Хорио цээрийн хуулийн 34 дүгээр зүйлд халдварт өвчний төрөлд тооцох Япон Улсын Засгийн газрын тогтоол (2020 оны Засгийн газрын 28 дугаар тогтоол) болон Хорио цээрийн хуулийг хэрэгжүүлэх тогтоолд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоол (2020 оны Засгийн газрын 29 дүгээр тогтоол)-д тулгуурлан шинэ төрлийн короновирусийн халдвар тээгчийг Япон Улсад нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх үүднээс Хорио цээрийн хуульд заасны дагуу хил нэвтрэх үед өвчний сэжигтэй болон шинж тэмдэг илрээгүй өвчин тээгчийг ч мөн адил шинэ төрлийн короновирусийн халдварт өвчтөнд тооцохоор заасан байна.

02 дугаар сарын 25-ны өдөр Засгийн газраас Шинэ төрлийн коронавирус өвчний эсрэг авах арга хэмжээний үндсэн бодлогыг баталж, үйлдвэр, аж ахуйн газрууд халуурах зэрэг шинж тэмдэг илэрч буй ажилчдыг амраах, ажилчдыг нийтээр ажиллуулалгүй цагийн хуваарийн дагуу ээлжээр ажиллуулах, шаардлагагүй бол олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлсэн байна. Ерөнхий сайд Абэ улс даяар бага, дунд, ахлах, тусгай сургуулиудыг 3 дугаар сарын 2-ны өдрөөс хаврын амралт хүртэл амраахаар шийдвэрлэсэн. Мөн “Дэлхийн эдийн засгийн хандлагыг анхааралтай ажиглаж, түүнд зохицуулж эдийн засаг, төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ” хэмээн мэдэгдэв. Засгийн газрын хуралдааны шийдвэрээр шинэ төрлийн коронавирус нь БНХАУ-аас гадна дэлхийн бусад улс орнуудад хурдацтай тархаж буй нөхцөл байдлын улмаас хилийн хяналт шалгалтыг улам чангатгах арга хэмжээг Япон улсын Засгийн газар холбогдох яам, тамгын газруудтай хамтран хэрэгжүүлэхээр болов.

Японы Төв банк 3 дугаар сарын 16-ны өдөр яаралтай хуралдаж, нэмэлт санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Үүнд, Биржийн арилжааны санд (ETF) жилд 6 их наяд иенийг худалдан авдаг байсныг 12 их наяд иен болгон өсгөх нэмэлт санхүүжилт

²³⁵ <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/japan-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

²³⁶ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон улсын харилцааны хүрээлэн Судалгаа, мэдээ 2020

хийхээр тогтов. Шинэ төрлийн корона вирусийн тархалтын улмаас эдийн засаг, банк санхүүгийн зах зээлд хямрал үргэлжлэх хугацаанд, хангалттай хөрөнгө нийлүүлэх болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахын тулд корпорацын бонд болон аж ахуйн нэгжийн барьцаагүй өрийн бичгийг худалдаж авахад зориулсан хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг нэвтрүүлэхээр шийдвэрлэжээ.

3 дугаар сарын 24-ний өдөр Олон Улсын Олимпийн Хорооноос Токиогийн Олимпийн наадмыг 1 жилээр хойшлуулах шийдвэр гаргахтай зэрэгцэн Япон улсын Хууль зүйн яамнаас улсын хилээр нэвтрүүлэхээс татгалзсан бүс нутгуудын жагсаалтыг нэмэлтээр баталж, Хорио цээрийн хяналт шалгалтыг чангатгах тухай (Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам), Визний хязгаарлалт (Гадаад хэргийн яам) хийх ажлыг холбогдох яамд зохион байгуулан ажиллажээ. Засгийн газар болон мэргэжлийн байгууллагын хуралдаанаар халдварын тохиолдлын тоо 2, 3 хоногийн хугацаанд маш хурдацтайгаар тархах эрсдэлтэйг таамаглаж, тийм нөхцөл байдалд Токио, Осака зэрэг халдварын тархалт өндөр байгаа хотууд, бүс нутагт сургуулиудыг нийтээр амраахаар шийдвэрлэх зэрэг арга хэмжээг авахаар тогтов. Ерөнхий сайд Абэ, 4 дүгээр сарын 07-ноос 5 дугаар сарын 06-ны хооронд 1 сарын хугацаатай Сайтама, Чиба, Токио, Канагава, Осака, Хёого, Фукуока гэсэн 7 мужид Онцгой байдал зарлан энэ хурдаар бол сарын дараа 80,000 хүн халдвар авах магадлалтай", "хүмүүс хоорондын харилцааг 70-80% бууруулж чадвал халдвар авсан хүмүүс 2 долоо хоногийн дараа дээд цэгт хүрч түүнээс хойш халдварын тоо буурах болно", "Зөв мэдээлэлд үндэслэсэн болгоомжтой арга хэмжээ авах" хэрэгтэй, энэ удаад "дайны дараах хамгийн том хямралыг даван туулах" шаардлагатай Япон Улс нүүр тулж буй талаар мэдэгдэв. Үүний зэрэгцээгээр бизнесийн үйл ажиллагаанд 108 их наяд иен, төсвийн зардалд 39.5 их наяд иений эдийн засгийн яаралтай арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн зарласан юм.

Улмаар Засгийн газрын хуралдаанаар “Шинэ коронавирусийн халдварын эсрэг хэрэгжүүлэх эдийн засгийн яаралтай арга хэмжээ” хэмээх бодлогын баримт бичгийг батлав. Үүнд, Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эх орондоо эргэн ирж буй иргэдийг хүлээн авах тогтолцоог сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчилгээний эм болон вакциныг судалгаа туршилтаар гаргаж үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагааг хурдавчлах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байрыг хадгалах талаар дэмжлэг үзүүлэх, дэмжлэг үзүүлэх шаардлагатай айл өрх, иргэдийг дэмжих, татварын талаар уян хатан бодлого хэрэгжүүлэх, халдвар тархаж буй орнуудад яаралтай тусламж үзүүлэхэд оруулсан хувь нэмэр зэрэг олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх гэх мэт өргөн хүрээтэй үйл ажиллагааг явуулахаар тогтоод байна. Коронавирусийн шинэ халдварын эсрэг авах арга хэмжээг чангатгах зорилгоор Засгийн газар томуугийн эсрэг тусгай арга хэмжээний тухай хуулийг баталсан бөгөөд 2-р сарын Рэйвагийн 3-р жил буюу 2021 оны 2-р сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Гол арга хэмжээ

Эдийн засгийн арга хэмжээний үндсэн ойлголтууд

Төрөл бүрийн арга хэмжээг стратегийн дагуу хэрэгжүүлэх хугацааг харгалзан хоёр үе шаттайгаар тогтоосон.

- Эхний үе шат "Яаралтай тусламжийн үе шат" нь халдварын төгсгөл хүртэл үргэлжилнэ.

- Хоёрдахь үе шат "V хэлбэрийн нөхөн сэргээх үе шат" нь халдварт өвчин дууссаны дараа эрэлт хэрэгцээг өдөөж, нийгмийн бүтцийн өөрчлөлтийг сайжруулах замаар идэвхтэй сэргэлтийг хангах үе шат юм.

Засгийн газар шаардлагатай үед шийдвэртэй арга хэмжээ авч, Ковид-19-ийн тархалт, түүний эдийн засаг, өдөр тутмын амьдралд үзүүлэх нөлөөг сайтар хянах.

Яаралтай тусламжийн үе шатны гол арга хэмжээ

- Засгийн газар Ковид-19-ийн халдварын дараа эдийн засгаа сэргээх найдвартай суурийг бий болгохын тулд ажил эрхлэлт, бизнес, өдөр тутмын амьдралд нь дэмжлэг үзүүлэх.
- Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, эмчилгээний зориулалттай бүтцийг бий болгох, эм бэлдмэлийг хөгжүүлэх арга хэмжээ:
 - Ажил эрхлэлтийг хамгаалах, бизнесийг тогтвортой байлгах.
 - Өрхүүдэд үзүүлэх яаралтай тусламж: Япон улсын бүх оршин суугчдад бэлэн мөнгө олгох, Хүүхдийн арван мянган иен дээр нэмэлт мөнгө, хүндрэлтэй өрхүүдэд яаралтай бичил зээл олгох, бага орлоготой өрхийн түрээсийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах, чөлөөлөх гэх мэт.
 - ЖДҮ эрхлэгчдэд үзүүлэх яаралтай тусламж гэх мэт: ЖДҮ эрхлэгчид болон хувиараа бизнес эрхлэгчдэд бэлэн мөнгө өгөх, ЖДҮ эрхлэгчдэд барьцааны зээл өгөхгүй байх, Орон нутгийн өмчийн татварыг бууруулах, чөлөөлөх гэх мэт.

V хэлбэрийн нөхөн сэргээх үе шатны гол арга хэмжээ

- Нөлөөлөлд өртсөн салбаруудын хэрэглээ, түүнчлэн дижиталчлал, алслагдсан технологийг ашиглах зэрэг ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг идэвхжүүлснээр хүчирхэг сэргэлтэд хүрэх үе шат.
- Дараагийн үе шат болох төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар дамжуулан эдийн засгийн үйл ажиллагааг сэргээх;
 - Аялал жуулчлал, тээвэр, хүнс, зугаа цэнгээний бизнес гэх мэт нөлөөлөлд өртсөн салбаруудыг дэмжих: холбогдох хэрэглээний зардлыг үнийн хөнгөлөлт, ваучер, онооны шагнал гэх мэт хэлбэрээр урамшуулах.
 - Бүс нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх: Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйг дэмжих, дотоодын аялал жуулчлалыг стратегийн үе шаттай идэвхжүүлэх гэх мэт.
- Эдийн засгийн бүтцийг илүү уян хатан болгох
 - Нийлүүлэлтийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх;
 - Хилийн чанад дахь бизнесийг хөнгөвчлөх, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас загасан бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний экспорт, дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг бэхжүүлэх;
 - Алсын технологийг ашиглан дижитал хувиргалтыг хурдасгах;
 - Төсвийн хөрөнгө оруулалт.

Татварын асуудлаар авч буй арга хэмжээ ²³⁷

Засгийн газрын төсвийн урамшууллын зардал нь цар тахлын дэгдэлтийн эдийн засгийн нөлөөллийг зөөлрүүлэх гол хэрэгсэл болно. Засгийн газар эрүүл мэндийн хямралд өртсөн ажлын байрыг хадгалахын тулд татаасаа мэдэгдэхүйц өргөжүүлж байна.

²³⁷ <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/japan-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

Бүртгүүлэх/төлбөрийн эцсийн хугацааг сунгах

Автомат банкны шилжүүлэг ашигладаг татвар төлөгчдийн 2019 оны татварын тайланг төлөх хугацааг дараах байдлаар сунгана.

- Хувь хүний орлогын албан татвар, сэргээн босголтын орлогын албан татвар төлөх хугацаа 2020 оны 5-р сарын 15.
- Хувь хүний хэрэглээний татвар, орон нутгийн хэрэглээний татвар төлөх хугацааг 2020 оны 5-р сарын 19.
- Хэрэглээний татвар төлөгчдийн төлбөр төлөх хугацаа нь 2020 оны 5-р сарын 19-ний өдөр.

2020 оны 4-р сарын 30-ны өдөр Коронавирусийн (COVID-19) тахлын эсрэг татвар, эдийн засгийн арга хэмжээг багтаасан хууль баталсан бөгөөд дараах татварын хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

- Тухайн хугацаанд татвар төлөгчийн орлого 20 хувиар буурсан бол 2020 оны 02 -р сарын 01-ээс 2021 оны 01-р сарын 31-ний хооронд татварын нэг жилийн хөнгөлөлттэй хугацаа өгөх;
- Татварын алдагдлыг буцаах замаар татварын буцаан олголтыг 1 тэрбум иенээс бага хөрөнгөтэй компаниудад олгох (100 сая иенээс бага).
- Жижиг, дунд компаниудын хөрөнгө оруулалтын татварыг бууруулах.
- Цар тахлын улмаас цуцлагдсан соёл, урлаг, спортын арга хэмжээнд оролцохдоо төлсөн мөнгөө буцаан авах хүсэлтээ гаргасан тохиолдолд буцаан олгох;
- Орон сууцны зээлд хамрагдах тусгай хөнгөлөлтийн шаардлагыг харгалзан үзэх;
- Хэрэглээний татварын тусгай дүрмүүд тогтоох;
- Төрийн болон хувийн санхүүгийн байгууллагуудтай байгуулсан гэрээг татвараас чөлөөлөх;
- Орон нутгийн татварын хөнгөлөлтийн арга хэмжээнүүд (тухайлбал, татвар хураах хөнгөлөлтийн хугацаа, жижиг, дунд аж ахуйн нэгжийн өмчлөлд байгаа зарим эд хөрөнгийн үл хөдлөх хөрөнгийн татварыг бууруулах гэх мэт) байдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- A Statistical Analysis of Impact of COVID19 on the Global Economy and Stock Index Returns, 2021 <<https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7796698/>> хандсан 2021.09.08
- Baldwin R., Weder di Mauro B. Economics in the time of COVID-19 // VoxEU.org eBook, CEPR Press, 2020. <<https://voxeu.org/article/economics-time-covid-19-new-ebook.>>
- BIS Working Papers No 959, Macroeconomic effects of Covid-19: a mid-term review, August 2021, <<https://www.bis.org/publ/work959.pdf>> хандсан 2021.09.08
- Center for disease control and prevention, <<https://www.cdc.gov>> хандсан 2021.09.08
- Davide Furceri, Prakash Loungani, Jonathan D. Ostry, How Pandemics Leave the Poor Even Farther Behind, MAY 11, 2020 <<https://blogs.imf.org/2020/05/11/how-pandemics-leave-the-poor-even-farther-behind/>> хандсан 2021.09.07
- Global Economic Effects of COVID-19, Congressional research service, Updated July 9, 2021 <<https://sgp.fas.org/crs/row/R46270.pdf>> хандсан 2021.09.08
- Government support and the COVID-19 pandemic, Version 14 April 2020, <<https://www.oecd.org/coronavirus/policy-responses/government-support-and-the-covid-19-pandemic-cb8ca170/>> хандсан 2021.09.07
- IMF, (2021), World Economic Outlook, <<https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2021/03/23/world-economic-outlook-april-2021>> хандсан 2021.09.08
- L.D. Sanginova, Measures of the government financial support: rules, experience and efficiency increasing, Управленческие науки в современном мире, Сборник докладов Восьмой Международной научно-практической конференции. Санкт-Петербург, 2021
- M. Szmigiera, Impact of the coronavirus pandemic on the global economy - Statistics & Facts
- OECD (2021), OECD Employment Outlook 2021. <<https://www.oecd.org/employment-outlook/>> хандсан 2021.09.08
- Supporting people and companies to deal with the COVID-19 virus. OECD, 2020. <<http://www.oecd.org/coronavirus/policy-responses/supporting-people-and-companies-to-deal-with-the-covid-19-virus-options-for-an-immediate-employment-and-social-policy-response-d33dffe6/>> хандсан 2021.09.08
- Европын Комиссын цахим хуудас, <https://ec.europa.eu/info/business-economy-euro/recovery-coronavirus/recovery-and-resilience-facility_en> хандсан 2021.09.08
- Европын Комиссын цахим хуудас, Европын Эдийн засгийг сэргээх, тогтворжуулах сангийн талаар, <<https://www.consilium.europa.eu/en/policies/eu-recovery-plan/>> Европын Комиссын цахим хуудас, хандсан 2021.09.08
- Место ЕАЭС в мире стратегических изменений: сценарий «Собственный центр силы» на основе научно-технологического прорыва - долгосрочный ответ на вызовы глобального экономического кризиса, вызванного пандемией, АНАЛИТИЧЕСКИЙ ДОКЛАД, Москва, октябрь 2020, <<https://eec.eaeunion.org/upload/medialibrary/f98/Doklad-Mesto-EAES-v-mire.pdf>> хандсан 2021.09.08
- Монгол Улсын Гадаад харилцааны яам, <<http://mfa.gov.mn/монгол-улс-евразийн-эдийн-засгийн-хол>> хандсан 2021.09.08
- "Деньги". Приложение №11 от 23.04.2020, стр.16, <<https://www.kommersant.ru/doc/4307954>> хандсан 2021.09.08
- О мерах по преодолению кризисных процессов в экономике России. – М.: Издание Государственной Думы, 2015. – 320 <<http://duma.gov.ru/media/files/Rx9q8OtxoYAibYrJ5VDmteeAu6Aeugyj.pdf>> хандсан 2021.09.06
- Распоряжение Евразийского межправительственного совета 10 апреля 2020 года № 6 «О предпринимаемых в рамках Евразийского экономического союза мерах, направленных на обеспечение экономической стабильности в условиях развития пандемии коронавирусной инфекции COVID-19», <https://docs.eaeunion.org/docs/ru-ru/01425377/ico_16042020_6> хандсан 2021.09.06

- <https://documents1.worldbank.org/curated/en/295991586526445673/pdf/The-Potential-Impact-of-COVID-19-on-GDP-and-Trade-A-Preliminary-Assessment.pdf>
- <https://www.google.com/search?Q=channels+of+corona+impact+on+economy>
- <https://www.cgdev.org/blog/economic-impact-covid-19-low-and-middle-income-countries>
- <https://onlinelibrary.wiley.com/doi/full/10.1002/pa.2430>
- Коронавирусийн халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл лавлагаа, УИХ-ын ТГ-ын Парламентын судалгааны хүрээлэн, 2020
- [Mongolia-Economic-Update-From-Relief-to-Recovery \(1\).pdf](#)
- Монгол Улсын эдийн засгийн тойм “Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд”, дэлхийн банкны тайлан, 2021 оны 2-р сар
- <https://www.legalinfo.mn/annex/details/11611?Lawid=16094>
- Монгол Улсын эдийн засгийн тойм, 2021, 2-р сар.
- https://mof.gov.mn/files/uploads/article/_%D0%B6%D0%B8%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%82%D0%BE%D0%B9%D0%BC_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0_08132021.pdf
- Сангийн яам (mof.gov.mn)

АНУ

- American Rescue Plan
- <https://www.whitehouse.gov/briefing-room/legislation/2021/01/20/president-biden-announces-american-rescue-plan/>
- American Rescue Plan summary
- <https://www.hklaw.com/media/files/insights/publications/2021/03/americanrescueplankeyprovisions.pdf?la=en>
- American Jobs Plan summary
- <https://www.naco.org/resources/featured/naco-executive-summary-american-jobs-plan>
- American Family Plan American-Families-Plan-Fact-Sheet-FINAL.pdf (whitehouse.gov)
- Clean energy plan
- FACT SHEET: President Biden Sets 2030 Greenhouse Gas Pollution Reduction Target Aimed at Creating Good-Paying Union Jobs and Securing U.S. Leadership on Clean Energy Technologies | The White House
- US Covid-19 Stimulus and Relief
- <https://www.investopedia.com/government-stimulus-efforts-to-fight-the-covid-19-crisis-4799723>
- Economic Indicator <https://tradingeconomics.com/united-states/indicators>
- Covid-19 Economic Relief Bill
- <https://www.ncsl.org/ncsl-in-dc/publications-and-resources/covid-19-economic-relief-bill-stimulus.aspx>
- The Coronavirus Aid, Relief, and Economic Security Act (CARES)
- <https://www.ncsl.org/ncsl-in-dc/publications-and-resources/coronavirus-stimulus-bill-states.aspx>
- Families First Coronavirus Response Act
- https://www.ncsl.org/documents/statefed/Corona_Virus_FYI_032020.pdf

БНХАУ

- Ковид-19 Олон улсын нөхцөл байдал, цорилт үр дагавар, хандлага 2020
- Цар тахлын үед дэлхийн улс орнуудын Засгийн газраас эдийн засгаа сэргээх, мөнгө болон санхүүгийн бодлогын хүрээнд авсан арга хэмжээ Э.Эрдэнэчимэг 2020
- <https://www.worldometers.info/coronavirus/country/china/>
- <https://qz.com/1839062/china-gdp-contracts-6-8-percent-in-first-quarter-due-to-coronavirus/>
- <https://tradingeconomics.com/>
- China's Economy: Recovery and Rebalancing Chris Kashlis, CFA March 2021
- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

ХБНГУ

- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#G>
- <https://www.worldometers.info/world-population/germany-population/>
- <https://www.worldometers.info/coronavirus/country/germany/>
- <https://tradingeconomics.com/>
- <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2020-11-24/germany-amendments-to-infectious-diseases-protection-act-enter-into-force/>
- <https://www.jonesday.com/en/insights/2020/04/act-to-mitigate-the-consequences-of-the-covid19-pandemic-under-germanys-civil-insolvency-and-criminal-procedure-law-of-2>
- <https://perma.cc/L4S4-N7MB>
- <https://www.ibanet.org/article/6AC928DD-58FB-4A55-822B-F0FE5F277F2F>
- <https://www.ibanet.org/article/6AC928DD-58FB-4A55-822B-F0FE5F277F2F>
- <https://www.jonesday.com/en/insights/2020/04/act-to-mitigate-the-consequences-of-the-covid19-pandemic-under-germanys-civil-insolvency-and-criminal-procedure-law-of-2>
- https://ec.europa.eu/info/system/files/germany-recovery-resilience-factsheet_en.pdf
- <https://www.imf.org/en/News/Articles/2021/07/13/na071521-beyond-the-pandemic-five-charts-on-germanys-economic-recovery-plan>

ОХУ

- Коронавирусийн халдварын тохиолдлын үзүүлэлтүүд.
- https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?#countries хандсан 2021.09.07
- Макро эдийн засгийн үзүүлэлтүүд. <https://tradingeconomics.com/> хандсан 2021.09.07
- Aganbegyan, A. G., Klerpach, A. N., Porfiryev, B. N., Uzyakov, M. N., & Shirov, A. A. (2020). Post-pandemic recovery: The Russian economy and the transition to sustainable social and economic development. *Studies on Russian Economic Development*, 31(6), 599-605.
- International monetary fund. Policy responses to COVID-19.
- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#R> хандсан 2021.09.07
- Засгийн газрын тогтоолын мэдээ. <http://government.ru/news/42992/> хандсан 2021.09.08
- Засгийн газрын тогтоолын мэдээ <http://government.ru/news/42980/> хандсан 2021.09.08
- Засгийн газрын тогтоолын мэдээ <http://government.ru/news/42925/> хандсан 2021.09.08
- Засгийн газрын тогтоолын мэдээ <http://government.ru/news/42949/> хандсан 2021.09.08

Ирланд

- The Health (Preservation and Protection and other Emergency Measures in the Public Interest) Act 2020 <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/1/enacted/en/html>
- The Emergency Measures in the Public Interest (Covid-19) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/2/enacted/en/html>
- The Microenterprise Loan Fund (Amendment) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/3/enacted/en/html>
- The Financial Provisions (Covid-19) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/4/enacted/en/html>
- The Credit Guarantee (Amendment) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/5/enacted/en/html>
- The Residential Tenancies and Valuation Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/7/enacted/en/html>
- The Financial Provisions (Covid-19) (No. 2) Act
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/8/enacted/en/html>
- The Companies (Miscellaneous Provisions) (Covid-19) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/9/enacted/en/html>
- The Social Welfare (Covid-19) (Amendment) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/12/enacted/en/html>
- The Finance (Miscellaneous Provisions) Act 2020
- <http://www.irishstatutebook.ie/eli/2020/act/25/enacted/en/print.html>

- The Planning and Development and Residential Tenancies Act 2020
- <https://oxcon.oup.com/view/10.1093/law-occ19/law-occ19-e19#law-occ19-e19-note-11>
- National Development Plan
- <https://www.gov.ie/en/policy-information/07e507-national-development-plan-2018-2027/>
- Economic Recovery Plan
- file:///Users/uurtsaikh/Downloads/136523_03f31f12-10eb-4912-86b2-5b9af6aed667.pdf
- Ensuring Sustainable Public Finance <https://www.gov.ie/en/publication/d4dcc-sustainable-public-finances/>
- Pathways to Work 2021-2025 <https://www.gov.ie/en/publication/90e59-pillar-2-helping-people-back-into-work/>
- Rebuilding Sustainable Enterprises <https://www.gov.ie/ga/foilsuichan/d28d9-pillar-3-rebuilding-sustainable-enterprises/>

Тайвань

- Дэлхийн статистикийн мэдээ. <https://www.worldometers.info/coronavirus/country/taiwan/> 2021.09.04-нд хандсан.
- *World Economic Outlook Database, April 2021*, https://santandertrade.com/en/portal/analyse-markets/taiwan/economic-outline?actualiser_id_banque=oui&id_banque=0
- Дэлхийн банк. <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD.ZG> 2020 оны ДНБ, улс орнуудаар
- Тайваний эдийн засгийн тойм https://santandertrade.com/en/portal/analyse-markets/taiwan/economic-outline?actualiser_id_banque=oui&id_banque=0 2021.09.04-нд хандсан.
- Тайваний үндсэн хууль 1947.01.01 <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0000001>
- Тайваны Ковид-19 ийн эсрэг тэмцэл: Үндсэн хууль, хууль тогтоомж, Вэн Чен Чан, 2020.02.21 <https://verfassungsblog.de/taiwans-fight-against-covid-19-constitutionalism-laws-and-the-global-pandemic/>

ПАРЛАМЕНТЫН ТӨСӨВ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

*Ц.Норовдондог (Ph.D), О.Билгүүтэй,
Ч.Сарантуяа, Д.Отгонбаатар, С.Төрмөнх*

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ТУРШЛАГА, ЗӨВЛӨМЖ

1.1 ОУПХ (IPU), НҮБХХ (UNDP): ДЭЛХИЙН ПАРЛАМЕНТЫН ТАЙЛАН-2017, ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ (Global Parliamentary report-2017: Parliamentary oversight)

1.2 ЭЗХАХБ: ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ОРОЛЦОО (Budgeting and Public Expenditures in OECD 2019)

1.3. ДЭЛХИЙН БАНК: ТӨРИЙН САНХҮҮД ПАРЛАМЕНТЫН ҮҮРЭГ РОЛЬ (World Bank: The role of parliament in public finance)

БҮЛЭГ 2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1 АНУ-ЫН КОНГРЕССЫН ТӨСВИЙН АЛБАДУУД

2.2 БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ТӨСВИЙН АЛБА

2.3 ГҮРЖИЙН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД

2.4 КАНАДЫН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН АЛБА

2.5 ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО (PAC – The public accounts committee) ИХ БРИТАНИ, АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД

2.6 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХБТБ	Хараат бус төсвийн байгууллага
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

УДИРТГАЛ

“Парламентын төсөв санхүүгийн хяналт: Олон улсын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэн, Хяналт шалгалт үнэлгээний газар хамтран гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Парламентын төсөв санхүүгийн хяналтын бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо ба арга механизмуудыг олон улсын зөвлөмж, бусад орнуудын туршлагын хүрээнд харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ:

Олон улсын зөвлөмж, нийтлэг зохицуулалтын хүрээнд: 2017 онд Олон Улсын Парламентын Холбоо (IPU) болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) хамтран дэлхийн 150 орны парламент болон парламентын гишүүдийг хамруулан парламентын хяналт шалгалтын бүрэн эрх, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар явуулсан судалгааны тайлан, зөвлөмж (1), Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага(OECD)-аас 2019 онд гаргасан “Төсвийн үйл явц дахь парламентын оролцоо” судалгааны тайлан (2), Дэлхийн банкнаас гаргасан “Төсөв санхүү дахь улс орнуудын парламентын үүрэг” судалгааны тайлан (3) зэрэг дэлхийн улс орнуудыг өргөн хүрээтэй хамруулсан судалгааны тайланд дурдагдсан парламентын төсвийн хяналтын бүрэн эрх, түүний хэрэгжилтийн талаарх практик туршлага, зөвлөмжүүдийг судалсан.

Гадаад орнуудын парламентаас төсөв санхүүгийн хяналтыг хэрэгжүүлж буй туршлагыг судлах хүрээнд: АНУ, БНСУ, Гүрж, Вестминистерийн загварын²³⁸ улсууд буюу Их Британи Канад, Шинэ Зеланд зэрэг орнуудын парламентын төсөв санхүүгийн хяналтын бүрэн эрх парламент ба түүний ажлын албан дахь төсөв санхүүгийн хяналтын чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх туршлагаудыг судалсан болно.

Судалгааны бүтэц: Судалгааны мэдээллийг дараах 2 бүлэг асуудлын хүрээнд боловсруулсан:

1-р бүлэг. Парламентаас төсвийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой олон улсын нийтлэг туршлага, зөвлөмж

2-р бүлэг. Гадаадын зарим орнуудын парламентаас төсөв санхүүгийн хяналтыг хэрэгжүүлж буй туршлага

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанаас үзэхэд, сүүлийн үед дэлхийн улс орнуудын парламентууд төсөв хэлэлцэн батлах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих чадавх бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байгаа нь харагдаж байна.

Учир нь хууль тогтоох байгууллагын зүгээс Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд өөрчлөлт оруулах, эрх бүхий зарим байгууллагыг төсвийн хувьд Засгийн газраас хараат бус байлгах, улс орныхоо хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн төсвийн төсөлд судалгаа, дүн шинжилгээ хийх, төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, төсөв батлагдсаны дараах хяналтыг хэрэгжүүлэх гэх мэт функциональ үйл ажиллагаануудыг парламент болон парламентын ажлын албаны тодорхой бүтцийн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг байна.

Парламентаас төсөв санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэхэд дараах нийтлэг бэрхшээлүүд тулгарч байгаа нь судалгаанаас харагдаж байна. Үүнд: парламентад өөрт нь төсвийн

²³⁸ **Вестминистерийн загвар** (Westminster system) Британийн парламент болон засгийн газрын институцийн үндсэн шинж чанарыг илэрхийлэх бөгөөд энэхүү загварыг олон шинж Канад, Австрали, Шинэ Зеланд болон Ази, Африк, Кариб дахь Британийн колони байсан олонхи улсад хэрэглэдэг байна.

хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлэх мэргэшсэн албад хангалтгүй байх, ялангуяа техник зохион байгуулалт, мэргэжил, арга зүй, судалгаа шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг нэгж байхгүй, эсвэл чадавх сул байх зэргээс шалтгаалан Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийг тооцоо судалгаагүйгээр батлах, эсвэл үндэслэл тооцоогүйгээр өөрчлөлт оруулах, оруулсан өөрчлөлтийн үндэслэл тодорхойгүй байх, батлагдсан төсвийг хэрхэн зарцуулж байгаад парламентаас хяналт тавих техник, зохион байгуулалтын боломж бүрдээгүй байх зэрэг бэрхшээлүүд харагдаж байна.

ОУПХ, НҮБХХ-ийн хамтарсан “Дэлхийн парламентын хяналт-2017” судалгааны тайланд дурьдсанаар, дэлхийн 100 парламентын танхимаас авсан судалгаагаар төсвийн хяналтын дараах арга механизмуудыг ашиглаж байна:

- төсвийн төслийг боловсруулахаас өмнө Парламент дээр төсвийн тэргүүлэх чиглэлийг хэлэлцдэг - 40%;
- төсвийн төсвийг Парламентаар хэлэлцэн батлахаас дор хаяж 3 сарын өмнө хүлээж авдаг - 30%;
- төсвийн төслийг 1 ба түүнээс олон хороогоор нягтлан шалгадаг - 80%;
- төсвийн төсөлд жендэрийн нөлөөллийн анализ хийдэг - 20%;
- Парламент өөрөө төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй - 40%;
- төсвийн жилийн туршид Парламентад төсвийн орлого, зарлагын талаарх мэдээллийг тодорхой хугацааны үечлэлээр тогтмол ирүүлдэг - 50%;
- Үндэсний аудитын байгууллагаас Парламентад төсвийн талаарх тайлан ирүүлдэг - 90%;
- уг тайланг Парламентаар нарийвчлан хэлэлцэх тодорхой журам тогтоодог - 60%;
- төсвийн дүн шинжилгээ хийх чадавхтай дотоод бүтцийн нэгжтэй - 60%.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, парламентыг төсвийн хяналтыг сайжруулах асуудлыг хараат бус мэдээлэл, дүн шинжилгээгээр хангах чадавхитай бие даасан, мэргэшсэн нэгж байгуулах замаар шийдэж буй туршлага түгээмэл байна. Тухайлбал, Бельги, Канад, Унгар, Солонгос, Нидерландад РВО / Parliamentary Budget office)- 100 орчим хүнтэй, Австри, Шведэд Fiscal Council, АНУ-д СВО (Congressional budget office)- 235 хүнтэй гэх мэт алба, нэгжүүд томоохон бүтэцтэйгээр бие даан ажилладаг байна. Энэхүү албанд макро эдийн засгийн шинжээч, татварын шинжээч, төсвийн шинжээч, Засгийн газар хариуцсан шинжээч, тойрог хариуцсан шинжээч, аналитик шинжээчид, программ хангамж, мэдээлэл технологи хариуцсан ажилтан гэх мэт мэргэшсэн ажилтнууд, өндөр түвшний экспертүүд ажилладаг байна.

Хууль тогтоох байгууллагаас төсвийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай нөхцөл бол төсвийн дүн шинжилгээний чадавхитай байх явдал гэж үздэг байна. Шаардлага хангасан боловсон хүчнийг хороодод авч ажиллуулах, экспертүүдтэй зөвлөлдөх, ажиллах боломжоор хангах, хараат бус судалгаа, дүн шинжилгээний чадавхийг бэхжүүлэх зэрэг нь хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал хоорондын чадавхын тэнцвэртэй байдлыг хангах томоохон хүчин зүйл болдог байна.

Түлхүүр үг: Улсын төсөв, Санхүүгийн хяналт, Төсөв боловсруулах, төсвийн зарлага, Төсөв дахь парламентын үүрэг

Keywords: State budget, Financial scrutiny, Budgeting and Public Expenditures, Parliament's role in budgeting,

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ТУРШЛАГА, ЗӨВЛӨМЖ

1.1 ОУПХ (IPU), НҮБХХ (UNDP): ДЭЛХИЙН ПАРЛАМЕНТЫН ТАЙЛАН-2017, ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ (Global Parliamentary report-2017: Parliamentary oversight)

2017 онд Олон Улсын Парламентын Холбоо (IPU) болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) хамтран дэлхийн 150 орны парламент ба парламентын гишүүдийг хамруулан парламентын хяналт шалгалтын эрх мэдэл, түүнийг практикт хэрэгжүүлж буй байдлын талаар өргөн хүрээтэй судалгаа явуулж, парламентаас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, парламентын хяналтыг үр ашигтай явуулахад шаардагдах нөхцөл, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарах асуудлуудаар 6 бүлэг, 28 зүйл бүхий зөвлөмж гаргасан байна. Энэхүү зөвлөмжийн 2-р бүлэгт парламентын хяналтын мандатын бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан байх ба үүнд төсвийн хяналтын чадавхыг сайжруулах асуудал ч мөн хамаарч байна. Үүнд:

- Парламентын Засгийн газарт хяналт тавих эрхийг хуульд тодорхой тусгаж баталгаажуулах;
- Парламент нь хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах бие даасан санхүүгийн, захиргааны болон хүний нөөцийн чадавхтай байх;
- Чуулганы нэгдсэн хуралдаанаар парламентын хяналттай холбоотой асуудлыг хэлэлцэх тусгайлсан цагтай байх;
- Байнгын хороодын холбогдох журам, үйл ажиллагаа нь парламентын хяналтыг дэмжсэн байх;
- Парламентаас төсвийн хяналтыг хэрэгжүүлэх бүрэн эрх, процедур болон чадавхыг бүрдүүлсэн байх;
- Парламентын хяналтын бүхий л үйл ажиллагаанд жөндөр, хүний эрхийн асуудлыг хамтатган хянадаг байх;
- Парламентын хяналтын чухал хэрэгсэл болох судалгаа, дүн шинжилгээний тусгайлсан чадавхыг хөгжүүлэх;
- Хяналтын ур чадварыг хөгжүүлэх, сонгуулийн дараах сөрөг нөлөөллийг хязгаарлах;
- Гаднаас техник, арга зүйн туслалцаа авах.

Парламентын хяналтын үр ашигтай зохицуулалтын механизмыг бүрдүүлэх хүрээнд төсвийн хяналтыг сайжруулахтай холбоотой гаргасан зөвлөмж

1.3.4	Төсвийн хяналт (Oversight of the budget)	<p>Парламент нь төсвийн орлого бүрдүүлэлтээс гадна төрийн санхүү, төсвийн зарцуулалтыг хянах эрхтэй. Засгийн газраас парламентад төсвийн зарцуулалтын саналаа ирүүлэх ба Парламентаас Засгийн газар төсвийн орлогоо хэрхэн бүрдүүлж, хэрхэн зарцуулах гэж байгаа, төсөв зарцуулах тэргүүлэх салбар нь юу байх, олон нийтийн эрэлт хэрэгцээнд энэ хуваарилалт нийцэж байгаа эсэхийг хянаж, төсвийг аль болох иж бүрэн, ил тод, үндэслэл тооцоотой байлгахыг хичээнэ.</p> <p>Парламентаас төсвийн хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Төсвийн шинжилгээ маш чухал. Энэхүү чадавхыг бүрдүүлснээр Парламентаас төсвийн хувилбаруудыг тооцоолох, Засгийн газраас хараат бусаар төсөв хэлэлцэх чадавх бүрддэг гэж үзэж байна. Парламентын хувьд төрийн санхүүгийн менежмент, төсвийн циклийг хянах асуудал нь мөрдөн шалгах, судалгаа дүн шинжилгээ хийх ур чадварыг шаардах тул улс орнуудын Парламент янз бүрийн түвшинд олон асуудлуудтай тулгарсаар байна.</p>
-------	--	---

Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх боломжууд		<p>Дэлхийн 100 парламентын танхимд төсвийн хяналтын дараах арга механизмуудыг ашиглаж байна:</p> <ul style="list-style-type: none"> • төсвийн төслийг боловсруулахаас өмнө Парламент дээр төсвийн тэргүүлэх чиглэлийг хэлэлцдэг - 40%; • төсвийн төсвийг Парламентаар хэлэлцэн батлахаас дор хаяж 3 сарын өмнө хүлээж авдаг - 30%; • төсвийн төслийг 1 ба түүнээс олон хороогоор нягтлан шалгадаг - 80%; • төсвийн төсөлд жендэрийн нөлөөллийн анализ хийдэг - 20%; • Парламент өөрөө төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй - 40%; • төсвийн жилийн туршид Парламентад төсвийн орлого, зарлагын талаарх мэдээллийг тодорхой хугацааны үечлэлээр тогтмол ирүүлдэг- 50%; • Үндэсний аудитын байгууллагаас Парламентад төсвийн талаарх тайлан ирүүлдэг - 90%; • уг тайланг Парламентаар нарийвчлан хэлэлцэх тодорхой журам тогтоодог - 60%; <p>төсвийн дүн шинжилгээ хийх чадавхтай дотоод бүтцийн нэгжтэй байх - 60%.</p>
Төсвийн дүн шинжилгээ хийх чадавх бүрдүүлэх		Төсвийн дүн шинжилгээ хийх нь мэргэшсэн ур чадвартай экспертийн ажил. Гишүүдийн хувьд төсвийн концепц болон арга зүйг ерөнхийд нь мэдэх шаардлагатай бол Парламентын ажлын албаны мэргэшсэн шинжээчид нарийвчилсан анализ хийх чадвартай байх. Бусад орнуудын туршлагаас үзвэл энэ чиглэлээр гишүүд болон ажилтнууд тусгайлсан сургалтууд авч байна.
Мэдээлэл цуглуулах, дата сан бүрдүүлэх		Төсвийн хяналт шинжилгээ хийхэд дата сан бүрдүүлэх нь асуудал чухал. Парламентаас ТХЗ-2030 зорилтуудыг хангах, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх хүрээнд ҮСХ-той хамтран ажиллаж ямар мэдээллийг, ямар аргачлалаар, ямар эх үүсвэрээс, хэрхэн бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх.
Парламентын Төсвийн шинжилгээний алба		<p>2008 оны дэлхийн хямралаас хойш ихэнх Парламентууд дүн шинжилгээний чадавхаа бэхжүүлэхэд анхаарч Төсвийн шинжилгээний алба (ТША)-ыг дотоод бүтцэдээ байгуулж эхэлсэн, хөндлөнгийн ТША-ны үйлчилгээг ч авч эхэлсэн. ТША нь олон улсын болон үндэсний зохицуулалтад нийцүүлэн төсөвт мониторинг, дүн шинжилгээ хийх, төсвийн техникийн нарийн мэдээллүүдийг хялбаршуулан танилцуулах зэрэг үүрэг хүлээнэ. Италийн туршлагаас үзэхэд, ТША нь макро-эдийн засгийн бодлого, төсвийн төсөөлөлд анализ хийх, төсвийн хэрэгжилтийг ЕХ болон үндэсний хууль тогтоомжуудад нийцүүлэн мониторинг хийх, Хороодын захиалгын дагуу төсөвтэй холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийх үүрэгтэй.</p> <p>Бусад орнуудын туршлагаас үзэхэд, хүчин чадал сайтай Парламентуудын ТША илүү мэргэшсэн, иж бүрэн төсвийн анализ хийх чадавхтай байгаа бол жижиг орнуудын хувьд санхүү, хүний нөөц хомс байх тул Үндэсний аудитын газрыг төсвийн шинжилгээний чиглэлээр Парламентад зөвлөх, хараат бус дүн шинжилгээ гаргаж өгөх хөндлөнгийн мэргэшсэн байгууллага гэж үздэг.</p>
Жендэрийн мэдрэмжтэй төсөв батлах		Ихэнх орнууд төсвийн төсөлд жендэрийн мэдрэмжийн анализ хийдэг.

1.2 ЭЗХАХБ: ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ОРОЛЦОО (Budgeting and Public Expenditures in OECD 2019)

ЭЗХАХБ-ын Төсвийн засаглалын талаарх зөвлөмж (OECD, 2015)-д "Парламент нь төсвийн шийдвэр гаргах, Засгийн газарт хариуцлага тооцох үндсэн үүргийг гүйцэтгэдэг бол Засгийн газрууд нь Парламент ба түүний хороодтой төсвийн мөчлөгийн бүхий л үе

шат (үүнд урьдчилсан/*ex ante* болон гүйцэтгэлийн/*ex post*)-нд төсвийн үйл явцтай холбоотой асуудлаар хамтран ажиллаж, төсвийн төслийн талаар хүртээмжтэй, оролцоотой, бодитой мэтгэлцээн өрнүүлэх боломж бүрдүүлэх ёстой" гэж заажээ.

ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудын²³⁹ парламентууд өөр өөрийн хууль эрх зүйн орчны онцлог, процедур, ёс заншил, уламжлалд захирагддаг боловч дийлэнх олонх нь "төсөвт нөлөөлөх" чадвартай буюу гүйцэтгэх засаглалаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, буцаах эрх зүйн чадамжтай байна.

Төсвийг батлах үе шат нь ихэнх парламентын хувьд төсвийн оролцооны голлох үе шат хэвээр байгаа боловч парламентын зүгээс төсөвт жилийн турш тасралтгүй санхүүгийн хяналт тавих хандлага нэмэгдсээр байна.

Хууль тогтоох байгууллагын төсвийн хяналтын соёлд Үндсэн хууль дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, улс төрийн нам болон сонгуулийн тогтолцоо, Засгийн газрыг бүрдүүлдэг уламжлал/практик (ихэвчлэн олонхын Засгийн газар бүрддэг үү, эсхүл эвслийн Засгийн газар бүрддэг үү), мөн төсвийн дүрмийн хязгаарлалтууд, төсвийн орчил зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна. Учир нь парламент бол нэг цул институт бус төсвийн үйл явцад олон янзын хувьсан өөрчлөгдөх стратеги, хөшүүрэгтэйгээр оролцдог оролцогчдын нийлбэр юм.

1. ТӨСВИЙН ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ДЭМЖИХ

Төсвийн талаарх бодитой мэтгэлцээний явцад дунд болон урт хугацааны төсвийн ерөнхий хязгаарлалтыг харгалзан үздэг. Төсвийн хэлэлцүүлгийн явцад төсвийн бодлого, ялангуяа дунд хугацааны төсвийн бодлогын талаар хууль тогтоогчдод хангалттай мэдээлэл өгч зөвлөлдөх боломжоор хангах, төсөв боловсруулах үе шатанд хууль тогтоох байгууллагын санал бодлыг харгалзан үздэг байх, ил тод байдлыг хангасан байх, төсвийн шийдвэр гаргах үйл явцыг хариуцлагатай байлгах нөхцлийг бүрдүүлэх, үүнийг дэмжсэн тогтолцоо тогтолцоо, нөхцлийг бүрдүүлсэн байхын хэрээр төсөв батлах үе шатанд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага багасдаг.

2. ТӨСВИЙН ӨМНӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгаанаас үзэхэд (OECD, 2019) ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентууд Засгийн газраас жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнөх үе шатанд төсвийн бодлогын чиглэл, тэргүүлэх чиглэл, харилцан тохиролцооны асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх хандлага нэмэгдэж байна. Засгийн газраас төсвийн өмнөх тайлан (*pre-budget report*)-г хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлдэг улс орнуудын тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байгаа (2012 онд - 19 улс, 2018 онд - 22 улс) хэдий ч хууль тогтоох байгууллага нь төсвийн өмнөх хэлэлцүүлэг хийдэг улс орнуудын тоо 2012 онд гурав (3) байсан бол 2018 онд арван гурав (13) болж нэмэгджээ. Эдгээр парламентуудын 50 орчим хувь нь төсвийн өмнөх хэлэлцүүлгийн үр дүнг Засгийн газарт тайлан болгон илгээдэг байна.

Үүний нэг жишээ **Швед Улсын Риксдаг нь** хоёр шатлал бүхий хууль тогтоох процесстэй бөгөөд Засгийн газраас хавар 4-р сард өргөн мэдүүлдэг Төсвийн бодлогын тухай хуулийн төсөл нь төсвийн бодлогын талаар илүү ерөнхий хэлэлцүүлэг хийх боломжийг олгодог бол 9-р сард өргөн мэдүүлдэг Төсвийн төсөлд Засгийн газрын дараа жилийн төсвийн зардлын нарийвчилсан саналуудыг тусгадаг байна. Судалгаанд авагдсан хэд хэдэн парламентууд чуулганы нэгдсэн хуралдаанаар албан ёсны хэлэлцүүлэг хийдэггүй

²³⁹ ЭЗХАХБ-ын 38 гишүүн орон: Австри, Австрали, Бельги, Канад, Чили, Колумб, Коста Рика, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Израиль, Итали, Япон, Солонгос, Латви, Литва, Люксембург, Мексик, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Польш, Португал, Словак, Словени, Испани, Швед, Швейцарь, Турк, Их Британи, АНУ.

ч гэлээ Төсвийн хороо нь төсвийн өмнөх үе шатанд оролцож хэлэлцүүлэг хийдэг талаар мэдээлсэн байна.

Бүгд Найрамдах Чех Улсад Төсвийн хороо нь төсвийн өмнөх хэлэлцүүлэг хийж, төсвийн стратеги, нэгдмэл байдлыг хангах талаар тогтоол баталдаг байна.

Ирланд Улсад шинээр байгуулагдсан Төсвийн хяналтын хороо нь төсвийн тэргүүлэх чиглэлийн талаар төсвийн урьдчилсан сонгол хийж, тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулдаг байна.

Израил Улсад Санхүүгийн хороо нь заримдаа төсвийн төслийг боловсруулах явцад өөрсдийн сонирхлоо илэрхийлэх зорилгоор төсвийн өмнөх хэлэлцүүлгийг зохион байгуулсан байдаг байна.

Хүснэгт 1. Хууль тогтоох байгууллага төсвийн өмнөх хэлэлцүүлгийг хийдэг эсэх


Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулдаг эсэх	Улсын тоо	Улсын нэр
Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулж, тайланг Засгийн газарт хүргүүлдэг	6	Канад, Франц, Грек, Итали, Словени, Швед
Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулдаг боловч тайлан гаргадаггүй	7	Дани, Испани, Нидерланд, Португал, Швейцар, Шинэ Зеланд, Эстони
Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулдаггүй	17	АНУ, Австри, Австрали, Бельги, БНСУ, Исланд, ИБУИНХУ, Норвег, Латви, Люскембург, Словак, Турк, Унгар, Польш, ХБНГУ, Чили, Япон
Бусад	4	Ирланд, Израил, Финланд, Чех
Нийт	34	

Эх сурвалж: <https://www.oecd.org/gov/budgeting/Parliament-role-in-budgeting.pdf>

3. ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНД ПАРЛАМЕНТААС ТАВИХ ХЯНАЛТ

Төсвийн ихэнх арга хэмжээ нь жилийн төсвөөс давсан үр дагавар бүхий арга хэмжээнүүд байдаг. Өдгөө ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувьд дунд хугацааны төсвийн хүрээнд парламентын зүгээс хяналт тавьдаг нийтлэг практик тогтсон байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хорин дөрвөн (24) парламентад дунд хугацааны төсвийн хүрээний хэлэлцүүлэг хийдэг бөгөөд эдгээрийн арван гурав (13) нь дунд хугацааны төсвийн хүрээг албан ёсоор баталдаг байна.

Зураг 1. Парламент дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцдэг эсэх, (хувиар)



Хүснэгт 2. Парламент дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцэн баталдаг эсэх

ДХТХ-г хэлэлцдэг, баталдаг эсэх	Улсын тоо	Улсын нэр
Хэлэлцэж баталдаг	13	Австри, Грек, Испани, ИБУИНХУ, Исланд, Израил, Итали, Канад, Латви, Словени, ХБНГУ, Финланд, Швед
Хэлэлцдэг	11	Австрали, Бельги, Дани, БНСУ, Нидерланд, Португал, Словак, Турк, Чех, Эстони, Япон
Хэлэлцдэггүй	6	АНУ, Люксембург, Норвег, Унгар, Франц, Шинэ Зеланд
Бусад	4	Ирланд, Польш, Чили, Швейцар


Эх сурвалж: (OECD, 2019)

4. УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ПАРЛАМЕНТААС ТАВИХ ХЯНАЛТ

Дунд хугацааны дүн шинжилгээ нь урт хугацааны дүн шинжилгээний үндэс болдог бөгөөд төрийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, нийгэмд учирч болохуйц эрсдэл, тохиролцоо/буултыг илэрхийлэх чухал хэрэгсэл юм. ЭЗХАХБ-ын гишүүн ихэнх орнуудад нийгэм хөгширч, үе дамжсан/үе хоорондын шилжилтийг хамарсан хөтөлбөрүүдийн нөлөөлөл өргөжих тусам урт хугацааны дүн шинжилгээний ач холбогдол улам бүр нэмэгдсээр байна.

Independent Fiscal Institution (IFI) буюу Хараат бус төсвийн институтууд нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентуудад урт хугацааны (ихэвчлэн 10-50 жил) дүн шинжилгээний чухал мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлж өгдөг.

Зураг 2. Парламент урт хугацааны тогтвортой байдлын дүн шинжилгээг хүлээн авдаг эсэх, (хувиар)



Хүснэгт 3. Парламент урт хугацааны тогтвортой байдлын дүн шинжилгээг хүлээн авч, хэлэлцдэг эсэх

Парламент урт хугацааны тогтвортой байдлын дүн шинжилгээг хүлээн авч, хэлэлцдэг эсэх	Улсын тоо	Улсын нэр
ХБТБ-аас дүн шинжилгээ хүлээн авдаг	3	Испани, ИБУИНХУ, Люксембург
ХБТБ болон ЗГ-аас дүн шинжилгээ хүлээн авдаг	9	Австрали, Канад, Дани, Франц, Грек, Итали, БНСУ, Нидерланд, Швед
Зөвхөн ЗГ-аас дүн шинжилгээ хүлээн авдаг	6	Австри, Норвег, Турк, Шинэ Зеланд, Эстони, Япон
Дүн шинжилгээ хүлээн авдаггүй	10	Бельги, Чех, ХБНГУ, Унгар, Исланд, Израил, Латви, Португал, Словак, Словени
Бусад	6	АНУ, Ирланд, Польш, Финланд, Швейцар, Чили

Эх сурвалж: (OECD, 2019)

5. ТӨСӨВ БАТЛАХ ҮЙЛ ЯВЦ

Хоёр танхимтай парламент

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентуудын тал хувь нь хоёр танхимтай бөгөөд дээд танхимууд төсөв батлахад илүү хязгаарлагдмал үүрэгтэй, эсхүл огт үүрэг гүйцэтгэдэггүй байна. Хоёр танхимтай парламентуудын дийлэнхийн хувьд төсөв болон санхүүгийн бусад саналтай холбоотой дүрэм журам нь дээд, доод танхимуудад ялгаатай байдаг. Тухайлбал, дээд танхимуудад төсвийг хэлэлцэх хугацаа богино байдаг ба төсвийн хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, буцаах эрхгүй байдаг.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудаас зөвхөн дөрвөн (4) парламентад дээд ба доод танхимууд (**АНУ, Итали, Чили, Швейцар**) төсөвтэй холбоотойгоор тэгш эрх эдэлдэг байна. Харин төсвийн үйл явцад доод танхим онцгой эрх эдлэх нь түгээмэл. Тухайлбал, **Нидерланд** Улсад зөвхөн доод танхим нь төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой байдаг бол дээд танхим нь зөвхөн санал нийлэх, эсхүл санал нийлэхгүй байх боломжтой.


Хүснэгт 4. Төсвийн үйл явцад танхим бүрийн гүйцэтгэх үүрэг

Төсвийн үйл явцад танхим бүрийн гүйцэтгэх үүрэг	Улсын тоо	Улсын нэр
Дээд доод танхим ижил эрхтэй	4	АНУ, Итали, Чили, Швейцар
Доод танхим онцгой эрхтэй	8	Австрали, Канад, Испани, Франц, Ирланд, Япон, Нидерланд, Польш
Зөвхөн доод танхим төсвийн үйл явцад оролцдог	5	Австри, Бельги, Чех, ИБУИНХУ, Словени
Нэг танхимтай	17	БНСУ, Грек, Дани, Исланд, Израил, Люксембург, Латви, Норвеги, ХБНГУ, Финланд, Португал, Словак, Турк, Унгар, Шинэ Зеланд, Швед, Эстони

6. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУГАЦАА

Хууль тогтоох байгууллага болон тэдгээрийн хороодод төсвийн баримт бичгийг хянах, хэлэлцэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах, тэдгээрийг хэлэлцэхэд тодорхой хугацаа шаардагддаг. ЭЗХАХБ-ын Төсвийн ил тод байдлын сайн туршлага (2002)-д “гүйцэтгэх засаглал төсвийн төслөө санхүүгийн жил эхлэхээс 3-аас доошгүй сарын өмнө парламентад өргөн мэдүүлэх, мөн парламент жил бүрийн төсвийн тухай хуулийг санхүүгийн жил эхлэхээс өмнө баталж байхыг” зөвлөсөн байна. ЭЗХАХБ-ын орнуудын 60 орчим хувь нь өмнөх зөвлөмжийг, дийлэнх олонх нь сүүлийн зөвлөмжийг хангаж байна. Харин Вестминстер загварын парламентууд төсвийг санхүүгийн жил эхэлснээс хойш баталдаг байна (**Канад, Ирланд, Шинэ Зеланд, Их Британи** зэрэг). Харин **Ирланд Улс** нь албан ёсны хууль тогтоомжоор (Зарцуулалтын тухай хуулиар) төсвийн зарцуулалтыг хуваарилахдаа төсвийн жил дууссаны дараа буюу мөнгө зарцуулагдсаны дараа хийдэг цорын ганц улс юм.

Зураг 3. Төсвийн төслийг хэлэлцдэг хугацаа



Эх сурвалж: (OECD, 2019)

7. ТӨСВИЙН НИЙТ ДҮНГЭЭР САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ

Өмнө дурдсан практикаас гадна төсөв батлах үйл явцад парламентаас эхний ээлжинд нэгдсэн төсвийн нийт дүнг баталснаар хуваарилалтын сонголт, боломжит нэмэлт, өөрчлөлтийн талаарх дараагийн хэлэлцүүлгийг явуулах хатуу хүрээг тогтоож өгөх замаар төсвийн хариуцлагыг нэмэгдүүлэх, тэргүүлэх чиглэлд анхаарлаа хандуулах боломж бүрдүүлдэг. ЭЗХАХБ-ын зарим гишүүн орнуудын парламентууд тухайн жилийн төсвийн орлого, зарлагыг тооцохоос өмнө төсвийн нэгдсэн дүнг тогтоосон тусдаа хууль тогтоомж батлах замаар дээрх асуудлыг шийдвэрлэж байна.

Төсвийн хороо нь төсвийн нийт дүн, салбарын төсвийн хуваарилалтыг тогтоож, дагаж мөрдүүлэхийг хариуцдаг, харин салбарын асуудал эрхэлсэн хороод нь баталсан нийт дүнгийн хүрээнд санхүүжилтийг хуваарилдаг практикаар дээрх зарчмыг өргөжүүлэн бэхжүүлж болох юм.


ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентуудын гуравны хоёр нь төсвийг нийт дүнг (төсвийн зарлагын нийлбэр ба дээд хязгаар) батлах санал хураадаг байна.

8. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЭРХ МЭДЭЛ

Нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдэл нь хууль тогтоох байгууллагын төсөвт нөлөөлөх гол хэрэгсэл юм. Улс орнуудын хувьд дээрх байдал нэлээд ялгаатай байна. Тухайлбал, **АНУ**-ын Конгресс нь Засгийн газрын санал болгож буй төсвийг шинэчлэн батлах, өөрчлөх эрх мэдэлтэй, үүнийгээ практикт хэрэгжүүлдэг бол **Ирланд Улсын** хууль тогтоох байгууллага зөвхөн өргөн мэдүүлсэн төсвийг батлах, эсхүл батлахаас татгалзах эрхтэй.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын талаас илүү хувьд нь нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдэлд ямарваа нэгэн хязгаарлалт тогтоодоггүй байна. Хоёр дахь нийтлэг практик бол хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалаас оруулж ирсэн төсвийн нийт дүнгийн хүрээнд төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой байдаг явдал юм. Тухайлбал, **Шинэ Зеланд Улсад** хууль тогтоох байгууллага нь төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болох хэдий ч Засгийн газраас оруулсан төсвийн нийт дүнд бага зэргийн нөлөө үзүүлэх байсан ч үүнд гүйцэтгэх засаглал хориг тавих эрхтэй байна. **Турк Улсад** Төсөв, төлөвлөгөөний хороо төсвийн төсөлд ямар ч өөрчлөлт хийх боломжтой боловч чуулганы нэгдсэн хуралдааны үед хууль тогтоох байгууллага зарлага нэмэгдүүлэх, орлогыг бууруулах боломжгүй. **Чили Улсад** хууль тогтоох байгууллага нь зөвхөн зардлыг бууруулах боломжтой. **Австрали Улсад** хууль тогтоох байгууллага зөвхөн шинээр нэвтрүүлж буй бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой. **БНСУ**-д хууль тогтоох байгууллагаас санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийг гүйцэтгэх засаглал батлах ёстой байдаг байна.

Зураг 4. Гүйцэтгэх засаглалын санал болгосон төсөвт өөрчлөлт оруулах хууль тогтоох байгууллагын албан ёсны эрх мэдэл, хувиар



Хүснэгт 5. Гүйцэтгэх засаглалын санал болгосон төсөвт өөрчлөлт оруулах хууль тогтоох байгууллагын албан ёсны эрх мэдэл

Төсөвт өөрчлөлт оруулах хууль тогтоох байгууллагын эрх мэдэл	Улсын тоо	Улсын нэр
ЗГ-аас тогтоосон хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй	7	Исланд, Итали, Испани, Польш, Франц, Словени, Эстони
Зөвхөн бууруулах	1	Чили
Төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй	2	Ирланд, Канад
Хязгаарлалт байхгүй	18	Австри, Бельги, Дани, Израил, Люксембург, Латви, Мексик, Нидерланд, Норвеги, Португал, Словак, Унгар, Финланд, ХБНГУ, Швейцар, Чех, Швед, Япон
Бусад	6	Австрали, БНСУ, Грек, ИБУИНХУ, Турк, Шинэ Зеланд

Эх сурвалж: (OECD, 2019)

Гэхдээ албан ёсны нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдлийн дүр зургийг бүрэн харуулж чадахгүй байна. Бодит байдал дээр ЭЗХАХБ-ын ихэнх парламентууд гүйцэтгэх засаглалаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд зөвхөн бага зэргийн өөрчлөлт оруулдаг. Олонхын Засгийн газар байгуулагдсан тохиолдолд төсөвт төдийлөн их өөрчлөлт оруулдаггүй. Төсвийн дүрэм, зайлшгүй зардал зэрэг нь хууль тогтоох байгууллагын зүгээс аливаа томоохон нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг хязгаарлаж болзошгүй юм. Мөн төсөв боловсруулах үе шатанд сайтар зөвшилцөх, хэлэлцэх зэрэг нь төсвийг батлах үе шатанд хууль тогтоох байгууллагаас нэмэлт, өөрчлөлт оруулах явдлыг бууруулж болох юм. Мөн олон улс оронд төсвийн талаарх санал хураалт нь Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудалд тооцогддог тул энэ нь хууль тогтоох байгууллагын зүгээс нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдлийг хязгаарлаж байдаг.

Хэдийгээр өөрчлөлтүүд нь бага байж болох ч энэ нь нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдэл чухал биш гэсэн үг биш юм. Нэмэлт, өөрчлөлт оруулах идэвх дунд зэрэг байсан ч парламентын хяналтыг нухацтай авч үзэх шаардлага байгаа талаар гүйцэтгэх засаглалд дохио өгч буй хэрэг юм.

Хүснэгт 6. Төсөвт өөрчлөлт оруулах хууль тогтоох байгууллагын албан ёсны бүрэн эрхийг үл харгалзан төсвийн талаарх санал хураалтыг Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх гэж үздэг эсэх

Төсвийн санал хураалт нь ЗГ-г итгэл үзүүлэх эсэх гэж тооцогддог	Улсын тоо	Улсын нэр
Тийм	18	Австрали, Бельги, Чили, Испани, ИБУИНХУ, Грек, Ирланд, Израил, Канад, Люксембург, Латви, Мексик, Норвеги, Турк, Финланд, Шинэ Зеланд, Швед, Эстони
Үгүй	14	Австри, Швейцар, Чех, ХБНГУ, Франц, Унгар, Исланд, БНСУ, Нидерланд, Польш, Португал, Словак, Словени, Япон
Бусад	2	Дани, Итали

9. ХОРООДЫН ЭРХ, ҮҮРЭГ

Хууль тогтоох байгууллагын "хөдөлгүүрийн хэсэг" гэж тодорхойлогддог хороодод илүү гүнзгий, нарийвчилсан, мэргэжлийн хяналт хийх боломжийг олгож, Засгийн газрын яам, агентлагуудтай "хариуцлагатай яриа хэлэлцээ"-г тасралтгүй явуулах боломжоор хангадаг.

Хүчтэй төсвийн хороо нь хууль тогтоох байгууллагын төсвийн үйл ажиллагааны уялдаа холбоо, тууштай байдал, төсвийн сахилга батыг дэмждэг бол салбарын асуудал эрхэлсэн хороодыг татан оролцуулах нь яамдын зарлагын төлөвлөгөөг холбогдох хороод өөрсдийн туршлагад тулгуурлан хянан хэлэлцэх боломжоор хангадаг.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хууль тогтоох байгууллагуудын гуравны хоёрт нэг төсвийн хороо нь төсвийн ерөнхий хяналт, салбарын хороодын саналыг зохицуулах үүрэгтэй байна. Найман (8) улсад төсвийн хороо нь төсвийн нийт дүнг авч үздэг бол салбарын хороод нь салбарын зардлуудыг авч хэлэлцдэг байна. Зөвхөн **Австрали, Их Британи** улсуудад төсвийн хороотой дүйцэх бүтэц байдаггүй байна. Австрали Улсад Парламентын доод танхимын хороод нь бараг үүрэг гүйцэтгэдэггүй гэж хэлж болох бөгөөд төсвийн хяналтыг Сенатад үнэлгээний сонсголоор голчлон явуулдаг байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын дийлэнх нь гүйцэтгэлийн мэдээллийг төсөв боловсруулахдаа ашигладаг байна. Холбогдох асуудлаар ихээхэн туршлага хуримтлуулсан салбарын асуудал эрхэлсэн хороод өөрсдийн эрхэлсэн асуудлын төсвийн багцын гүйцэтгэлийн мэдээллийг хянаж үзэхэд илүү тохиромжтой байдаг. Харин **ХБНГУ**-ын Төсвийн хорооны илтгэгчийн тогтолцоо (*Budget Committee's rapporteur system*) нь салбарын асуудал эрхэлсэн хороодын оролцоогүйгээр төсвийн хороо нь төсвийн талаар ихээхэн мэдлэг, туршлага хуримтлуулж болдгийг харуулж байна. Өдгөө ЭЗХАХБ-ын гишүүн 21 хууль тогтоох байгууллагад төсөвт хавсаргасан гүйцэтгэлийн мэдээллийг хянах үндсэн үүргийг Төсвийн хороо/эсхүл Төсвийн хорооны дэд хороо хүлээдэг байна. Зөвхөн 11 улсад салбарын асуудал эрхэлсэн хороод тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг байна. (Эдгээрийн дотор **Грек, Итали** улсууд Төсвийн хороо болон салбарын асуудал эрхэлсэн хороод хоёулаа тэргүүлдэг байна).

Хяналтын хорооны даргын суудлыг сөрөг хүчинд өгөх нь тус хороог аль нэг намаас ангид, зөвшилцлийн үндсэн дээр ажиллуулах амлалт өгч байгаа хэрэг юм. Энэ нь Вестминстер загварын парламентуудын төрийн хариуцлагын хороодын нийтлэг практик юм. Үүнтэй ижил төстэй уламжлалыг **Франц, Герман, Унгар, Португал, Испани** зэрэг улсууд тогтоосон байна.

10. ЖИЛИЙН ТУРШ ЯВУУЛАХ ХЯНАЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ(EX POST)


Төсвийг баталсны дараа хууль тогтоох байгууллага төсөвт тавих хяналтаа үргэлжлүүлдэг. Төсвийн хэрэгжилтэд тавих хяналт нь тухайн жилийн бодит зарцуулалтын талаарх мэдээлэл, аудитын цаг үеийн тайланд үндэслэн явагддаг. “ЭЗХАХБ-ын Төсвийн ил тод байдлын сайн туршлага”-аас үзэхэд, ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 70 орчим хувь нь сар бүр санхүүгийн тайлан гаргадаг бөгөөд энэ нь жилийн төсвийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг өгдөг. Цөөн хэд улс тайланг улирал тутам гаргадаг байна. Эдгээр сарын тайлангууд нь жилийн дунд үед илүү дэлгэрэнгүй тайлагнах боломжийг дэмждэг.

Батлагдсан төсөвт гарсан аливаа томоохон өөрчлөлтийг мөн хууль тогтоох байгууллага хянаж, батлах ёстой байдаг. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 75 гаруй хувь нь төсвийн тодотголыг хууль тогтоомжоор баталдаг. Хууль тогтоогчид эдгээр хүсэлтийг батлахаас өөр сонголтгүй байж болох ч бодлогын талаар саналаа илэрхийлж болдог.

Жилийн эцсийн тайлан нь Засгийн газраас тайлагнах гол баримт бичиг юм. Аудитын дүгнэлтэд парламентын хяналт шалгалт хийх нь төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан, бодлого нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэхийг баталгаажуулдаг. ЭЗХАХБ-ын олон парламентуудад Аудитын дээд байгууллагаас гаргасан тайлангуудыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий тусгайлан Аудитын хороо буюу Төрийн хариуцлагын хороо (*Public Accounts Committee*) байдаг. Бусад орнуудын хувьд дээрх хяналтыг Төсвийн

хороо, эсхүл түүний дэд хороод гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч нийт гишүүн орны гуравны хоёрт нь жилийн эцсийн аудитын тайланг хянах үүрэг бүхий хорооны зөвлөмжийг дараа оны төсөв батлах үйл явцад харгалзан үзэх, нэгтгэх албан ёсны үйл явц байхгүй байна.

Зураг 5. Хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлдэг төсвийн тодотгол, тайлангууд



Гэхдээ аудитын үе шат болон дараагийн төсөв батлах үе шат хоорондын уялдаа холбоогүй бэхжүүлсэн зарим орнуудын туршлагауд байна. Тухайлбал, **ХБНГУ**-д Аудитын дээд байгууллагын төлөөлөгчид Төсвийн хорооны илтгэгчид болон яамны мэргэжилтнүүдийн анхан шатны зөвлөлдөх уулзалт болон тайлан, нэмэлт, өөрчлөлтийг танилцуулдаг Төсвийн хорооны хуралдаанд оролцож, зөвлөгөө өгдөг байна. **Австри Улсын** төсвийн баримт бичигт зардлын тодорхой чиглэлүүдээр Аудитын шүүхийн хамгийн сүүлийн үеийн, хамаарал бүхий зөвлөмжүүдийг оруулсан байдаг. **Франц Улсад** Санхүүгийн хорооны мэргэшсэн гишүүд аудитын дүгнэлтийг дараагийн төсвийн хэлэлцүүлэгт харгалзан үзэх асуудлыг хангуулах үүрэг хүлээдэг байна.

11. ХОРООНЫ АЛБАН ХААГЧИД

Төсвийн хорооны албан хаагчдын тоо ЭЗХАХБ-ын хууль тогтоох байгууллагуудад харилцан адилгүй байгаа бөгөөд ажилтнууд нь төсөв боловсруулах техникийн мэдлэгтэй, эсхүл хууль эрх зүйн мэдлэгтэй байж болно. Албан хаагчдын тоо хоёроос гурав байх нь хамгийн түгээмэл байдаг бол **Японд** 10, **БНСУ**-д 21, **Францын** Парламентын танхим бүрт 25, **Туркт** 28, **АНУ**-ын Төлөөлөгчдийн танхим 35, АНУ-ын Сенат 47 ажилтантай байна.

Дээрхээс гадна хороод гаднаас зөвлөгөө авч болдог. ЭЗХАХБ-ын бүх гишүүн орнуудад төсвийн хороо нь хөндлөнгийн шинжээчдээс зөвлөгөө авах эрхтэй байна. Үүнээс гуравны нэгээс илүү нь хөндлөнгийн шинжээч ажиллуулах эрхтэй байна.

12. МЭРГЭШСЭН СУДАЛГААНЫ АЛБА, АЛБАН ХААГЧИД

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентын гуравны нэгээс илүүд нь судалгааны албаны бүтцэд төсвийн шинжилгээ хийдэг тусгай нэгж байдаг байна. Эдгээр нэгжүүд ихэвчлэн 10 орчим ажилтантай байдаг бол **Испани** 2, **Турк** 40 албан хаагчтай байна. **Их Британийн** Нийтийн танхимын Хяналтын алба нь 14 ажилтантай байна. Тус нэгж нь парламентын тусгай хороодыг дэмжиж, үндсэн болон нэмэлт тооцоо, яамдын жилийн тайлан, зарцуулалтын хяналт, төлбөр тооцоо, төсвийн мэдэгдэл зэргийг системтэйгээр хянаж байдаг.

Зарим парламентад тусгайлсан нэгж байхгүй боловч судалгааны алба нь цөөн тооны мэргэшсэн боловсон хүчинтэй байдаг (5-аас 7 хооронд) байна. Үүнд **Канад, Чех, Эстони, Латви, Норвеги** улсуудын жишээг дурдаж болох юм.

13. ХАРААТ БУС ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА (ХБТБ)

Хараат бус төсвийн байгууллагууд (парламентын төсвийн бие даасан алба болон төсвийн зөвлөлүүд) хурдацтай хөгжиж байна - эдгээр нь ЭЗХАХБ-ын орнуудад жишиг болон тогтсон бөгөөд зарим улс хэд хэдэн байгууллагатай байна.

Парламентын төсвийн хэлэлцүүлэг нь ХБТБ-ын дүн шинжилгээг авч хэлэлцэх онцгой боломжийг олгодог. ХБТБ-ын загваруудад нийтлэг байдаг үндсэн чиг үүргүүд нь макро эдийн засаг, эсхүл төсвийн таамаглал гаргах, үнэлэх, батлах, төсвийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын өртөг тооцох, урт хугацааны төсвийн тогтвортой байдлын дүн шинжилгээ хийх мөн хууль тогтоох байгууллагад төсвийн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиг үүргүүд байна.

Хүснэгт 7. ЭЗХАХБ-ын зарим гишүүн орны Парламентын төсвийн албаны төсөв, орон тоо


Улсын нэр	Байгууллагын нэр	Он	Төсөв (ам.доллар)	Орон тоо
Австрали	Парламентын төсвийн алба	2017	5.1 сая	40
Австри	Парламентын төсвийн алба	2017	1.1 сая	8
Канад	Парламентын төсвийн алба	2018	3.9 сая	27
Грек	Парламентын төсвийн алба	2017	0.6 сая	16
Ирланд	Парламентын төсвийн алба	2018	1.0 сая	12
Итали	Парламентын төсвийн алба	2017	7.1 сая	27
БНСУ	Үндэсний Ассамблейн Төсвийн алба	2017	13.1 сая	138
Мексик	Төрийн санхүүгийн судалгааны төв	2016	2.7 сая	60
АНУ	Конгрессын Төсвийн алба	2016	46.5 сая	235

Эх сурвалж: (OECD, 2019)

14. НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Ил тод, хариуцлагатай байдлыг дэмжихэд парламент чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ ил тод ажиллаж, сонгогчдын өмнө байнгын хариуцлагатай байх ёстой. Сүүлийн жилүүдэд парламентууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран парламентын нээлттэй байдлыг хангах үзэл баримтлалыг түлхүү хэрэгжүүлэх болсон.

Зураг 6. Төсвийн хорооны хуралдаан олон нийтэд нээлттэй байдаг эсэх



Хүснэгт 8. Хорооны тайланг нийтэлдэг эсэх

Хорооны тайланг нийтэлдэг эсэх	Улсын тоо	Улсын нэр
Тийм, тогтмол	26	Австри, Австрали, Бельги, БНСУ, Швейцар, Чили, Чех, ХБНГУ, Дани, Испани, Эстони, Финланд, Франц, Грек, Ирланд, Исланд, Итали, Люксембург, Норвеги, Шинэ Зеланд, Португал, Словак, Словени, Турк, Швед, АНУ
Тийм, заримдаа	1	ИБУИНХУ
Үгүй	2	Латви, Унгар
Бусад	5	Израил, Канад, Нидерланд, Польш, Япон

Эх сурвалж: (OECD, 2019)

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентын хорооны хурлыг олон нийтэд нээлттэй явуулах, эсхүл хорооны хурлыг телевиз, интернетээр дамжуулах нь түгээмэл байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентуудын дийлэнх нь мөн хорооны тайланг нийтэлдэг байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентууд төсвийн хэлэлцүүлгийн явцад олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор тодорхой арга хэрэгслүүдийг ашигладаг. Тухайлбал, Байнгын хороод (25 улс) нийтийн сонсгол зохион байгуулах зэрэг уламжлалт оролцооны механизмыг түгээмэл ашигладаг бол Засгийн газар төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах механизмыг бүрдүүлсэн байна.

Найман (8) улс (**Австрали, Канад, Эстони, Финланд, Япон, Португал, Словак, АНУ**) Хороодын уулзалт, эсхүл иргэдтэй уулзах арга хэмжээнүүдээр дамжуулан олон нийтийн оролцоог хангадаг бол долоон (7) улс (**Эстони, Финланд, Герман, Солонгос, Люксембург, Шинэ Зеланд, Португал**) цахим өргөдлийг (*e-petition*) ашигладаг байна. Харин **Франц, Грек, Швейцар** улсууд "нийгмийн сүлжээний платформ дээр дижитал хэлэлцүүлэг" зохион байгуулдаг бол зөвхөн **Австри Улс** "хяналт шалгалтын асуудлыг тодорхойлоход *crowdsourcing* буюу олон түмний санаа бодлыг тусгах" аргыг нэвтрүүлэхээр бэлтгэж байна. **Нидерланд Улс** 2017 онд шинэлэг шинэ практик болох "V-100"-г нэвтрүүлсэн байна. Нидерландын Парламентаас зохион байгуулдаг "V-100" арга хэмжээнд нийгмийн 100 төлөөлөгч оролцож, жил бүрийн төсвийн тайланг хянаж, хариуцсан сайдад тавьж болох асуултын талаар хороодод саналаа өгдөг байна.

Харин, **Их Британийн** Парламент төсөвтэй холбоотойгоор цахим өргөдөл болон дижитал хэлэлцүүлэг огт явуулж байгаагүй боловч бусад бодлогын хэлэлцүүлэгт хоёуланг нь ашигладаг байна.

1.3. ДЭЛХИЙН БАНК: ТӨРИЙН САНХҮҮД ПАРЛАМЕНТЫН ҮҮРЭГ РОЛЬ (World Bank: The role of parliament in public finance)²⁴⁰

Хууль тогтоох байгууллагуудын төсөвт үзүүлэх нөлөөлөл улс орнуудад олон зуун жилийн турш хувьсан өөрчлөгдөж сайжирч ирсэн. Түүхээс харахад анх дэлхийн улс орнуудын парламентууд зөвхөн татвар ногдуулах эрхтэй байсан бол аажмаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг хянах тогтолцоо бий болсон байна. Өнөөдөр хууль тогтоох байгууллагууд төсөвт янз бүрийн түвшинд нөлөө үзүүлж байна. Зарим парламентын төсөвт үзүүлэх нөлөө идэвхгүй байхад зарим нь төсөв боловсруулах үйл явцад хүчтэй байр суурьтай оролцож байна.

²⁴⁰ Дэлхийн банкнаас гаргасан гишүүн орнуудын улсын төсөвт үзүүлэх парламентын оролцоо, төсөв батлах үйл явц, төсөв батлах хугацаа зэргийг тоймлосон ишлэв.
World Bank: The Role Of Parliament In Public Finance

Ардчилсан засаглалын үндсэн хуультай орнуудын парламентууд төсвийн үйл явцад идэвхитэй оролцоотой байх боломжтой болсон. Жишээ нь Нэгдсэн Вант Улсын (United Kingdom) парламентын төсвийн эрх мэдэл 19-р зууны дунд үед хамгийн өндөр байсан ба парламентаас улсын зарлага, орлогын саналд хэдэн ч удаа нэмэлт өөрчлөлт оруулах эрх мэдэлтэй байсан байна (Einzig 1959). Гэвч урт хугацааны төлөвөөс харахад ихэнх аж үйлдвэржсэн орнуудын үндэсний хууль тогтоох байгууллагуудын төсвийн бодлого боловсруулахад оролцох оролцоо, нөлөөлөл буурсан байна (Coombes 1976).

Төсөв батлах үйл явцын талаарх мэдээллээс үзэхэд энэхүү үйл явц улс орон бүрт харилцан адилгүй байх боловч төсвийн ихэнх системд ижил төстэй нийтлэг талууд байна Тухайлбал:

Улсын төсөв батлах үйл явцад оролцогч талууд:

Сангийн яам нь (Finance ministry or treasury) макро эдийн засгийн төсөөллийг боловсруулах, төсвийн үйл явцыг хуваарийн дагуу зохион байгуулах, зарцуулах мөнгөний хэмжээг тооцоолох үүрэгтэй байдаг. Мөн Сангийн яам нь төсвийн бодлого боловсруулах, төсвийн хэрэгжилтэд хяналт тавихад чухал бөгөөд үндсэн үүргийг гүйцэтгэдэг.

Бие даасан Аудитын дээд байгууллагууд нь (Independent supreme audit institutions) Засгийн газар, хууль тогтоох байгууллагаас баталсан төсөв бодитой эсэх, хуульд заасны дагуу зарцуулсан эсэхийг хянан шалгадаг байна.

Судалгааны төвүүд болон олон нийтэд түшиглэсэн иргэний нийгмийн байгууллагууд (Civil society organizations)-ын төсвийн үйл явцад оруулж буй хувь нэмэр улам бүр нэмэгдэж байна. Иргэний нийгмийн байгууллагууд ерөнхий дүн шинжилгээний явцад ажиглагдаагүй өнцгөөс хараат бус бие даасан байдлаар судалгаа хийж дүгнэлт гаргадаг байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь (The media) төсвийн хэлэлцүүлгийн гол асуудлуудыг олон нийтэд дамжуулах, мэдээлэл түгээхэд чухал үүрэгтэй. Олон нийтэд төсвийн талаарх мэдээлэл хүргэхийн тулд сэтгүүлчид хууль тогтоох байгууллага болон түүний хороодод бүрэн нэвтрэх эрхтэй байдаг бөгөөд холбогдох баримт бичиг, мэдээлэл нь тэдэнд нээлттэй байдаг байна.

Олон улсын санхүүгийн байгууллагууд болон донор байгууллагууд (International financial institutions and donor agencies) гадаад өр ихтэй ядуу буурай орнуудын төсвийн үйл явцад чухал үүрэгтэй оролцдог. Олон улсын санхүүгийн байгууллагууд зээл олгохдоо хатуу нөхцөл тавьдаг ба хууль тогтоох байгууллагын үүрэг нь зээлдүүлэгчийн тохиролцоог тусгасан төсөв батлахад чиглэдэг.

ТӨСӨВ БАТЛАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ҮЕ ШАТУУД

Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар, ихэнх улс орнуудын төсөв батлах үйл явц дөрвөн үе шаттай байна.

1. Төсвийн төсөл боловсруулах (Drafting)
2. Хууль тогтоох/батлах (Legislative)
3. Хэрэгжүүлэх (Implementation)
4. Аудит ба үнэлгээ (Audit and evaluation)

Засгийн газар нь ардчилсан зарчмаар байгуулагдсан ихэнх оронд дээрх дарааллаар төсөв батлах үйл явц явагддаг. Гэхдээ тухайн улсын онцлог, янз бүрийн оролцогчдын нөлөөлөл, цаг хугацааны хүчин зүйлсээс шалтгаалан харилцан адилгүй дараалалтай байх нь бий.

Хүснэгт 9. Жилийн төсвийн үйл явцын үе шатууд



Судалгаанаас үзэхэд ихэнх улс орнуудад төсөв батлах үйл явцад Сангийн яам, түүний холбогдох хэлтэс, албадууд, Хууль тогтоох байгууллага, түүний хороод болон Аудитын дээд байгууллагууд голлох үүрэгтэй оролцож байна.

ПАРЛАМЕНТААР ТӨСӨВ БАТЛАХ (PARLIAMENTARY APPROVAL OF THE BUDGET)

Төсвийг батлахад парламентын үүрэг роль улс орнуудад харилцан адилгүй байдаг. Зарим улсын парламент нь төсвийн үйл явцад хүчирхэг тоглогчид болж төсөвт хүчтэй нөлөөлдөг бол зарим улсын парламент ерөнхийдөө гүйцэтгэх засаглалын өргөн барьсан төсвийг ямар ч өөрчлөлтгүйгээр баталдаг.

Төсөв батлах эрх зүйн орчны хувьд, хууль тогтоох байгууллагын төсвийн эрх мэдлийг тухайн улсын Үндсэн хуульд тусгасан байдаг ч үүнээс гадна бусад хууль тогтоомж, хууль тогтоох дүрэмд тусгасан байж болдог.

Улс орнуудад төсвийн тодотгол хийх янз бүрийн хэлбэрүүд байдаг. Ихэнх улсуудад парламентаас төсөвт хэдэн ч удаа тодотгол хийх эрх мэдэлтэй байна (40%). Хамгийн том жишээ нь АНУ-ын Үндсэн хуулиар Конгрессын төсвийн бүрэн эрхэд хууль ёсны хязгаарлалт тогтоодоггүй ба Конгрессын хязгааргүй эрх мэдэл нь гүйцэтгэх засаглалын санал болгосон төсвийг бүхэлд нь дахин өөрчлөх боломжийг олгодог байна.

Хүснэгт 10. Улс орнуудын төсөвт тодотгол хийх эрх мэдэл

Төсөвт тодотгол хийх хууль тогтоох эрх мэдэл		
Төсвийн эрх мэдэл	Улс орнуудын тоо	Нийт дүнгийн хувь
Төсөвт хэдэн ч удаа тодотгол хийх эрх мэдэлтэй	32	40%
Төсөв танах эрх мэдэлтэй (Reductions of existing items only)	17	21%
Төсөвт үзүүлэх нөлөөллийн эрх тодорхойгүй	15	19%
Төсвийн өсөлтийг бусад зардлаас таналт хийх байдлаар зохицуулж тэнцвэржүүлдэг	13	16%
Засгийн газрын зөвшөөрөлтэйгээр зардлыг бууруулах эрхтэй	4	5%
Бүгд	81	100%

ТӨСӨВ БАТЛАХ ХУГАЦАА

Хууль тогтоогчид төсөв батлах, оновчтой шийдвэр гаргахад тохирсон хангалттай хугацаа тогтоосон байдаг. Олон улсын туршлагаас харахад хууль тогтоох байгууллага төсвийг бодитой дүн шинжилгээ хийж, нягталж батлахын тулд доод тал нь гурваас дөрвөн (3-4) сарын хугацаа шаардагддаг байна.

Хүснэгт 11.

Төсвийн жил эхлэхээс хэдий хугацааны өмнө хууль тогтоох байгууллагад төсвөө танилцуулдаг вэ?		
	Улс орнуудын тоо	Нийт дүнгийн хувь
Хоёр сар хүртэл	10	26%
Хоёроос дөрвөн сар	23	59%
Дөрвөөс зургаан сар	5	13%
Зургаа ба түүнээс дээш сар	1	3%
Бүгд	39	100%

ХУУЛЬ ТОГТООХ ХОРОО БА ТӨСӨВ (LEGISLATIVE COMMITTEES AND THE BUDGET)

Төсөв боловсруулах үйл явц нь хэд хэдэн үе шатуудыг дамждаг бөгөөд ихэвчлэн төсөвтэй холбоотой тодруулгын хуралдаан хийгддэг байна. Эдгээр тодруулга хуралдаан нь төсвийг өргөн хүрээнд авч үзэн Засгийн газар болон сөрөг хүчний аль алинд нь танилцуулах зорилготой байдаг. Парламентын хороодыг парламентын "хөдөлгүүр" гэж нэрлэх бөгөөд улс төржилтөөс хол, илүү гүнзгий, илүү техникийн шинжтэй хяналт тодруулгыг хийдэг байна. Төсөв батлахтай холбогдуулан салбарын төлөөлөл болох хороодын зүгээс санал зөвлөмж гаргаж болох ч төсөвт эдгээр хороодын саналыг заавал тусгах албагүй байдаг. Эдгээр хороод (боловсрол, зам тээвэр, байгаль орчин гэх мэт) өөрсдийн салбар, чиглэлээр ихэвчлэн төсвийн зардлыг нэмэгдүүлэх хүсэлтэй байдаг ч нөгөө талаасаа эдгээр салбарын зардлыг шалгах явцад зөрүүтэй саналууд гардаг учир хороодын санал, туршлагыг чухалчлан авч үздэг.

Хүснэгт 12. Хороодын төсвийн төсөлд нөлөөлөх чадамж

Хороод	Улс орнуудын тоо	Хувь
Төсвийн хороо нь бусад хороодоос албан ёсны санал авахгүйгээр төсөвтэй холбоотой асуудлыг шийддэг. Салбарын хороод зөвлөмж гаргаж болох ч Төсвийн хороо дагаж мөрдөх албагүй.	19	47.5%
Төсвийн асуудлыг Төсвийн хороо хэлэлцэх үед өөр салбарын хорооны гишүүд төсвийн хорооны хуралдаанд оролцдог. Тухайлбал, Боловсролын яамны зардлыг хэлэлцэх үед боловсролын хорооны гишүүд төсвийн хорооны хуралдаанд оролцдог.	6	15%
Төсвийн нэгдсэн хороо орлого, зарлагын нийт түвшин, салбар тус бүрд хуваарилалт зарцуулалтыг хэлэлцдэг. Тухайлбал, боловсролын салбарын зардлын нийт хэмжээг Төсвийн хороо тогтоодог боловч Боловсролын хорооны гишүүн боловсролын салбарын төсвийн дүнг хуваарилдаг.	7	17.5%
Салбарын хороод салбар тус бүрээр төсөв хуваарилах асуудлыг шийддэг. Төсвийн хороо тухайн салбарын төсвийн хуваарилалтыг хийдэггүй ба зөвхөн техникийн туслалцаа үзүүлдэг.	2	5%
Бусад	6	15%
Бүгд	40	100%

Source: OECD (2003)

БҮЛЭГ 2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**2.1 АНУ-ЫН КОНГРЕССЫН ТӨСВИЙН АЛБАДУУД**

Эрх зүйн орчин: АНУ нь Холбооны Бүгд найрамдах, Үндсэн хуульт, Ерөнхийлөгчийн засаглалтай улс. Тус улсын Конгрессын бүрэн эрх, үүргийг Үндсэн хуулиараа зохицуулсан бөгөөд Сенат болон Төлөөлөгчдийн танхим гэсэн хоёр танхимтай. Дээд танхим болох Сенат нь 100 гишүүнтэй. Доод танхим болох Төлөөлөгчдийн танхим 435 гишүүнтэй.²⁴¹

1974 онд **Конгрессоос төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хууль** (Congressional Budget and Impoundment Control Act²⁴², 1974) батлагджээ. Энэ хуулиар Ерөнхийлөгчийн төсөв хөрөнгө захиран зарцуулах эрхийн хэрэгжилтэнд хяналт тавих шинэ процедурыг хуульчилжээ. Мөн Ерөнхийлөгчөөс хамааралгүйгээр Конгресс шаардлагатай гэж үзвэл төсвийн тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлж, хэрэгжилтэнд нь хяналт тавих боломжтой болсон байна.

Ийнхүү Конгресс төсөв хэлэлцэн батлах, хэрэгжилтэнд нь хяналт тавих хариуцлагатай бөгөөд томоохон эрх мэдлийг өөртөө авсанаар төсөв, эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, Засгийн газраас хараат бус, төвийг сахисан, үнэн зөв, шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийдэг Конгрессын гишүүд болон Байнгын хороодод төсөвтэй холбоотой мэдээлэл гаргаж өгдөг хүчирхэг албадууд шаардлагатай гэж үзсэн. Ингээд Конгрессын дэргэд төсвийн шинжилгээ, судалгаагаар мэргэшсэн аппарат, нэгжүүдийг ажиллуулах болсон. Мөн Конгрессоос Ерөнхийлөгчийн зүгээс төсвийг захиран зарцуулахгүй байгаад хяналт тавих системийг бий болгосон, хоёр танхимд тус бүрд нь зөвхөн төсөв боловсруулах ажлыг хариуцах хороодыг байгуулсан, Конгресст төсвийн тэргүүлэх чиглэлийг Ерөнхийлөгчийн төсөвт баригдахгүйгээр тодорхойлох боломжийг олгосон байна.

²⁴¹ Төлөөлөгчдийн танхимд сонгогдох гишүүдийн тоо тухайн муж улсын хүн амын тооноос хамаарна.

²⁴² Конгрессоос баталсны дагуу төсөв мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахаас татгалзахыг холбооны нөөцийн импаундмент гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч Конгрессын баталснаар төсвийг зарцуулахгүй байж болохыг хэлнэ. Энэ эрх нь 1921 оны Төсөв болон нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар АНУ-ын Ерөнхийлөгчид олгогдсон байдаг.


Төсвийн удирдлагын газар нь гүйцэтгэх засаглалын түвшинд олон сарын турш төсвийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулна. Хуулиар Ерөнхийлөгч холбооны улсын дараа жилийн төсвийг Конгресст 2-р сарын эхний Даваа гарагт өргөн барина. Конгресс төсвийг хүлээж авсанаас хойш олон сарын турш судалгаа шинжилгээ хийж, хэлэлцэн батлах бөгөөд энэхүү ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг дараах албадууд ажилладаг:

1. Конгрессын төсвийн алба
2. Конгрессын номын сангийн Судалгааны алба
3. Конгрессын төрийн хариуцлагын алба

Конгрессийн төсвийн алба (CBO – Congressional budget office)

Бүтэц: Энэхүү холбооны агентлаг нь 1974 онд *Конгрессын төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хуулийн* дагуу байгуулагдсан. 250 гаруй ажилтантай, тэдгээрийн 70 хувь нь эрдмийн зэрэг цолтой төсвийн мэргэжлийн шинжээч, эдийн засагчид болон нийгмийн бодлогын шинжээчид байдаг. Тус алба нь дараах бүтэцтэй:

Зураг 7. Конгрессын төсвийн албаны зохион байгуулалт



Сенатын ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын спикер хамтран Конгрессын төсвийн албаны даргыг 4 жилийн хугацаатай томилдог ба аль ч танхим түүнийг тогтоолоор өөрчилж болдог.

Чиг үүрэг: Конгрессын хоёр танхимаас нилээд хэдэн жилээр тооцсон нэгдсэн төсвийг батлах бөгөөд энэ нь хууль болж ёсчлогдохгүй, зөвхөн орлого, зарлагатай холбоотой хууль батлахад гарын авлага болно. Конгрессын төсвийн алба нь Конгресс болон Сенат, Танхимын Төсвийн хороонд судалгаа шинжилгээ хийж өгөх бөгөөд ингэхдээ улс төрийн ямар нэгэн зөвлөмжийг баримтлахгүй.

Алба нь жил бүрийн 1-р сарын сүүлээр хуульд заасны дагуу дараагийн 10 жилийн орлого, зарлагын тооцоог багтаасан төсөв, эдийн засгийн төлөв байдлын судалгааг гаргаж өгдөг. Мөн Ерөнхийлөгчөөс АНУ-ын нэгдсэн төсвийг Конгресст өргөн барьснаас хойш нэг сарын хугацаанд уг төсөвт бие даасан, хараат бус шинжилгээ, тооцоолол хийж Төсвийн асуудал хариуцсан байнгын хороодод хүргүүлдэг.

Үүний зэрэгцээ Конгрессын санал болгосон төсвийн төсөлд мөн үнэлгээ, тооцоолол хийнэ. Конгрессоос хэрэгжүүлэхээр санал болгосон төсөл хөтөлбөрүүдийн тооцооллыг боловсруулж, хэрэгжиж эхэлсэн хөтөлбөрүүдийн явцын үнэлгээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн хийх зэргээр холбогдох судалгаа тооцооллыг сонирхогч талуудад хүргүүлдэг.

Конгрессын төрийн хариуцлагын алба (GAO - Government accountability office)

Бүтэц: Конгрессын төрийн хариуцлагын алба нь 1921 онд *Төсөв болон Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн* дагуу байгуулагдсан. Төв оффис нь Вашингтон хотод байх ба салбарууд нь АНУ-ын 11 гол хотуудад үйл ажиллагаагаа явуулдаг. Эдийн засагч, социологч, нягтлан бодогч, төрийн бодлогын шинжээч, өмгөөлөгч болон эрүүл мэндийн бодлогын мэргэжилтэн зэрэг 3300 гаруй албан хаагчидтай бөгөөд тэдний 2/3 нь төв оффист ажилдаг байна.

Албаны дарга буюу Ерөнхий хянагчийг Конгрессоос дэвшүүлсэн нэрсээс сонгож Ерөнхийлөгч 15 жилийн хугацаатайгаар томилдог. Төрийн албанд ховор байдаг томилгоо буюу ийнхүү урт хугацаагаар томилж байгаа нь тасралтгүй удирдлагыг хангаж байгаа хэрэг юм.

Чиг үүрэг: Төрийн хариуцлагын албаны зарчим нь Конгрессыг цаг үеийн тулгамдсан асуудалтай холбоотой бодит, баримтанд тулгуурласан, нам бус, олон талт, шударга, тэнцвэртэй мэдээллээр хангах явдал.

Тус албаны эрхэм зорилго бол Конгрессыг Үндсэн хуулийн үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад нь туслах бөгөөд Америкийн ард түмний ашиг сонирхолын тулд Холбооны байгууллагуудуудын өмнөөс хариуцлагын баталгаа өгөх явдал юм.

Конгрессын хороод, дэд хороодын хүсэлтийн дагуу дараах үндсэн үүргийг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй:

- Улсын агентлагууд төсвийн хөрөнгийг хэр үр ашигтай зарцуулж байгааг тогтоох аудит хийх;
- Хууль бус, буруу үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдэгдлийн дагуу шалгах;
- Төрийн бодлого, хөтөлбөрүүд зорилгодоо хүрч байгаа эсэхийг шалгах;
- Бодлогын судлагаа хийх, Конгрессоор хэлэлцэж байгаа асуудлуудыг шийдвэрлэх хувилбарыг гаргаж өгөх.

Конгрессын судалгааны алба (Congressional research service)

Бүтэц: “Конгрессын тархи” гэгддэг энэхүү алба нь 1914 онд байгуулагдсан. Нийт 700 гаруй ажиллагсадын 450 гаруй нь шинжээч, хуульчид бөгөөд дараахь судалгааны 5 хэлтэст хуваагдан ажиллаж байна.

Хүснэгт 13. Судалгааны албаны зохион байгуулалт

<p>1) Америкийн хуулийн хэлтэс</p>	<p>Хууль эрх зүйн орчинд бий болж байдаг олон мянган асуудлуудад анхаарлаа хандуулдаг. Зарим асуудал нь Үндсэн хуулийн хүрээнд Конгрессын зохион байгуулалтын онцгой эрхэд хамаардаг.</p>
<p>2) Дотоодын нийгмийн бодлогын хэлтэс</p>	<ul style="list-style-type: none"> • боловсрол, ажиллах хүч болон тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал; • эрүүл мэнд болон санхүүгийн даатгал; эрүүл мэндийн үйлчилгээ; • хүн амын насжилтын бодлогын судалгаа; • нийгмийн хамгаалал, тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж; • цагаачлал, муж улсуудын аюулгүй байдал; • дотоодын мөрдөн шалгалт, эрүүгийн шүүн таслах ажиллагаа; • халамж, хоол хүнс, орон сууцны нөхцөл.
<p>3) Гадаад харилцаа, батлан хамгаалах,</p>	<p>Гадаадын бүх улс орны улс төр, эдийн засгийн хөгжлийн судалгаа хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> • олон улсын байгууллага;

<p>худалдааны хэлтэс</p>	<ul style="list-style-type: none"> • АНУ болон бусад улс үндэстний хоорондын улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын харилцаа холбоо; • терроризм болон дүрвэгчид зэрэг улс үндэстэн хоорондын асуудал; • үндэсний аюулгүй байдал: <ul style="list-style-type: none"> · <i>дайны стратеги,</i> · <i>АНУ-ын батлан хамгаалахын төсөв,</i> · <i>байлдааны хэрэгсэл,</i> · <i>дайны нөхөн олговор,</i> · <i>цэргийн бааз.</i> • худалдаа: худалдааны гэрээ, экспорт, импорт, гаалийн тариф зэрэг эдийн засгийн асуудлууд.
---------------------------------	--

Эдгээр нь зөвхөн судалгааны хэлтсүүд бөгөөд “арын албанд” Захиргааны хэлтэс, Харилцаа холбооны хэлтэс, Конгрессын мэдээлэл, хэвлэлийн хэлтэс, Захирлын зөвлөхүүдийн хэлтэс, Санхүү, захиргааны хэлтэс, Мэдээллийн менежмент, технологийн хэлтэс, Хүний нөөц менежментийн хэлтэс зэрэг захиргааны хэлтсүүд ажилладаг.

Чиг үүрэг: Конгрессын номын сангийн харьяанд ажиллах Судалгааны алба судалгаа шинжилгээ хийхдээ объектив, нам бус, үнэн зөв, найдвартай зарчмыг баримтлана.


Конгрессын хууль тогтоох болон шийдвэр гаргах бүхий л үйл явцад сүүлийн үеийн, бүх талын хууль эрх зүйн орчны судалгаа, шинжилгээ, лавлагаа, мэдээлэл гаргана.

2.2 БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН ТӨСВИЙН АЛБА

Солонгос улс нь Парламентын Бүгд найрамдах улс боловч Ерөнхийлөгчийн засгийн хэв шинжийг зарим талаараа агуулсан тогтолцоотой. Үндсэн хуулиар²⁴³ хууль тогтоох эрх мэдэл Үндэсний Ассамблейд хадгалагдах бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч тэргүүлэн хэрэгжүүлнэ. 1948 онд байгуулагдсан Үндэсний Ассамблей нь нэг танхимтай, 299 гишүүнтэй, бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд 17 байнгын болон тусгай хороотой. Үндэсний Ассамблей нь хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

БНСУ-ын төсвийн алба нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл, Үндэсний Ассамблейн төсвийн албаны тухай хуулийн дагуу 2003 онд байгуулагдсан. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь Үндэсний Ассамблейн даргын шууд удирдлаган дор ажилладаг.

Зураг 8. Үндэсний Ассамблейн даргын удирдлагад ажилладаг нэгжүүд²⁴⁴



1.Бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа:

Үндэсний Ассамблейн Төсвийн Алба (ҮАТА) нь улсын төсөв, санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийж, үнэлэх, дүгнэх замаар Үндэсний Ассамблейд дэмжлэг үзүүлэх ерөнхий чиг үүрэгтэй. Төсвийн албаны

²⁴³ Үндсэн хуулиа анх 1948 онд баталснаас хойш 5 удаа шинэчлэн найруулсан.
²⁴⁴ СТ-18/218 Төсвийн хараат бус байгууллагын эрх зүйн орчны харьцуулсан судалгаа

мэргэжилтнүүд болон шинжээчид бие даасан, хараат бус, хөндлөнгийн судалгаа, шинжилгээгээр хангадаг.

Тус алба нь Төлөвлөлт, менежментийн хэлтэс, Төсвийн шинжилгээний хэлтэс, Тооцоолол, татварын анализын хэлтэс, Эдийн засгийн шинжилгээний хэлтэс гэсэн үндсэн 4 хэлтэстэй. Төсвийн алба нь захирал, орлогч дарга, 3-8 дугаар түвшний судлаач болон төрийн албан хаагчдаас бүрдэнэ. Хэлтсүүд нь дараах чиг үүрэгтэй:

1. Төлөвлөлт менежментийн хэлтэс

- Үйл ажиллагааны төлөвлөгөө, ерөнхий хяналт, төрөл бүрийн хөтөлбөрүүдийн зохицуулалтыг гүйцэтгэх;
- Холбогдох нэгжүүдэд зөвлөх болон зохицуулах чиглэл өгөх;
- Үндэсний ассамблейн гишүүд болон хороодоос хүссэн судалгаа, шинжилгээний хүсэлтийг хүлээн авах, ангилах;
- Хүний нөөцийн менежмент болон, төсвийн хэрэгжилтийн зохицуулалт хийх.

2. Төсвийн шинжилгээний хэлтэс

- Үндэсний төсөв, дансны тооцоо, сангууд (үндэсний томоохон хөтөлбөр), эдийн засгийн менежментийн анализ хийх;
- Нэгдсэн төсвийн үлдэгдэл, улсын өрийн хэмжээ, төсвийн тогтвортой байдал зэрэгт судалгаа хийх;
- Төрөл бүрийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт дээр үнэлгээ болон, хяналт тавьж, дүн шинжилгээ хийх;
- Төрийн байгууллагууд болон засгийн газрын гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог хариуцах.

3. Тооцоолол, татварын анализын хэлтэс

- Төсөвтэй холбоотой хууль тогтоомжид зардлын тооцоо хийх;
- Дунд болон урт хугацааны үндэсний төсвийн төлөвлөлт гаргах;
- Орлогын тооцооллын талаар төсөлд хавсаргасан хууль тогтоомжийн нэр томъёонд дүн шинжилгээ, зөвлөмж гаргах;
- Татварын тогтолцоо болон бодлогын талаар судалгаа, шинжилгээ хийх.

4. Эдийн засгийн шинжилгээний хэлтэс

- Эдийн засгийн чиг хандлага болон макро эдийн засгийн урьдчилсан төлөвлөлтөд судалгаа хийх;
- Аж үйлдвэр болон хөдөлмөр эрхлэлт, санхүүд суурилсан эдийн засгийн чиг хандлагад дүн шинжилгээ хийх;
- Урт хугацааны эдийн засгийн стратеги бодлого болон хүн амын бүтцийн талаар, судалгаа, төлөвлөлт хийх;
- Засгийн газрын бодлогод эдийн засаг хэрхэн нөлөөлж буйг судлах.

Төсвийн алба нь төсвийн болон эдийн засгийн статистикийн нэгдсэн систем болох NABOSTATS (www.nabostats.go.kr)-ыг 2018 оны 9-р сарын 1-ээс ажиллуулж эхэлсэн. Энэ нь нэг цэгийн статистик мэдээллийн систем бөгөөд хэрэглэгчид YATA-ны хууль тогтоомж, төсөв боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн талаарх хэлэлцүүлэгт шаардлагатай үндэсний, орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагын санхүү, эдийн засгийн харилцааны талаарх нэгдсэн статистик, дүн шинжилгээний мэдээллүүдийг авах боломжтой юм.


Энэ хүрээнд Төсвийн албанаас Үндэсний Ассамблейн Байнгын хороодын гүйцэтгэж буй хууль тогтоомжийн ажлыг дэмжих зорилгоор Хороо болгоноор тогтмол ашиглагддаг статистикийн хураангуйг нэгтгэн гаргадаг.

NABOSTATS систем нь дараах статистик мэдээллээр хангадаг байна. Тухайлбал:

Хүснэгт 14. Төсвийн албаны гүйцэтгэсэн статистик судалгааны төрлүүд

(2019 оны байдлаар)

	Судалгааны төрөл	Тоо
1	Байнгын хорооны статистик судалгаа	206
2	Хүн ам болон нийгмийн судалгаа	25
3	Эдийн засгийн статистик судалгаа	32
4	Хойд Солонгосын статистик судалгаа	98
5	Олон улсын статистик судалгаа	27
6	Үндэсний Ассамблейн хэлэлцүүлгийн товхимол	4
7	Төсвийн статистик судалгаа	75
8	Татварын статистик судалгаа	31
9	Орон нутгийн санхүү	10
10	Төрийн байгууллагын статистик	11



Хууль эрх зүйн орчин:

Үндэсний Ассамблейн тухай хуулийн²⁴⁵ 22-2 дугаар зүйлээр Үндэсний Ассамблейн Төсвийн албаны эрх зүйн үндсийг дараах байдлаар тогтоож өгсөн байна. Тухайлбал:

1. Төрийн санхүү болон сангийн менежмент, төсвийн зохицуулалттай холбоотой асуудлыг судлан шинжлэх, үнэлэх, дүгнэх түүнчлэн парламентын үйл ажиллагааг дэмжих зорилготой Үндэсний Ассамблейн төсвийн албыг байгуулна.
2. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь дарга, шаардлагатай бусад албан хаагчидтай байна.
3. Төсвийн албаны даргыг Үндэсний Ассамблейн Удирдах хороо (House Steering Committee)-ны зөвшөөрөлтэйгөөр Үндэсний Ассамблейн тэргүүн томилж, чөлөөлнө.
4. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Ассамблейн Төсвийн албатай холбоотой шаардлагатай бусад асуудлыг тусдаа хуулиар зохицуулна гэж заажээ.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны үйл ажиллагааг 11 зүйл бүхий бие даасан хуулиар зохицуулж байна.

²⁴⁵ National Assembly act, https://korea.assembly.go.kr:447/res/low_06_read.jsp

Үндэсний Ассамблейн Төсвийн албаны хууль²⁴⁶-иас**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Тус хуулийн зорилт нь Үндэсний Ассамблейн төсвийн алба, түүний чиг үүрэг болон холбогдох бусад асуудлыг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Эрх зүйн байдал

Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь (цаашид төсвийн алба гэх) Үндэсний Ассамблейн даргын удирдлаганд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. Төсвийн алба нь эрх зүйн байдлын хувьд бие даасан байна.

3 дугаар зүйл. Чиг үүрэг

Төсвийн алба нь төрийн сангуудын удирдлага, төсвийн тайлан, тооцоотой холбогдох дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Төсвийн тайлан, төрийн сангуудыг эрхлэн явуулахтай холбогдох төсөл, төсвийн тооцоололтой холбогдох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;
- Төсвийн болон төрийн сангуудын зардалтай холбогдох асуудлаар болон өртөгтэй холбогдох тооцоолол гаргах;
- Макро эдийн засгийн хандлага болон төрийн санхүүтэй холбогдох асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;
- Үндэсний хэмжээний чухал төсөл, хөтөлбөр, дунд болон урт хугацааны санхүүгийн нөхцөл байдлын талаар шинжлэх, үнэлэх;
- Зөвлөл болон Үндэсний Ассамблейн гишүүдээс шаардсан аливаа асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, гүйцэтгэх.

4 дүгээр зүйл. Дарга

- Төсвийн албаны дарга нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарах ба дэд сайдтай адил хэмжээний цалин хангамжтай байна.
- Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ туршлагатай бөгөөд асуудалд төвийг сахисан байр сууринаас хандах үүрэгтэй.
- Дарга нь Үндэсний Ассамблейн тэргүүний тушаалаар томилсон Төсвийн албаны төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, үйл ажиллагааг нь удирдах чиг үүрэгтэй.

5 дугаар зүйл. Зөвлөх хороо

- Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22-2,3-т заасны дагуу Үндэсний Ассамблейн дарга нь Төсвийн албаны даргыг томилохдоо эхлээд Зөвлөх хорооноос санал болгосон хүнийг авч хэлэлцэнэ.
- Зөвлөх хорооны гишүүд нь төсвийн албаны чиг үүрэгтэй холбогдох асуудлаар туршлагатай, улс төрийн хувьд төвийг сахисан байх ба Үндэсний Ассамблейн гишүүн болон Үндэсний Ассамблейн ажлын албаны албан хаагч бус этгээд байна.
- Зөвлөх хорооны үйл ажиллагаа, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг журмаар²⁴⁷ зохицуулна.

6 дугаар зүйл. Томилгоо

Төсвийн албаны 5 болон түүнээс дээш зэрэглэл(grade) бүхий төрийн албан хаагчдыг Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө. Үндэсний Ассамблейн дарга нь эрх мэдлийнхээ зарим хэсгийг журмын дагуу шилжүүлсэн тохиолдолд бусад албан хаагчдыг Төсвийн албаны дарга томилж, чөлөөлж болно.

²⁴⁶ National Assembly Budget Office Act, <http://korea.nabo.go.kr/about/laws.php>
(<http://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9%EA%B5%AD%ED%9A%8C%EC%98%88%EC%82%B0%EC%A0%95%EC%B1%85%EC%B2%98%EB%B2%95>)

²⁴⁷ <http://www.law.go.kr/LSW/lumLsLinkPop.do?spntninfSeq=140839&chrClsCd=010202&ancYnChk=0>

7 дугаар зүйл. Бүтэц

- Төсвийн албаны туслах байгууллага нь дэд дарга, ерөнхий захирал болон захиралтай байна. Дээрх албан тушаалын нэрсийг журмын дагуу өөрөөр тогтоож болно.
- Төсвийн албаны даргын дор дэд дарга ерөнхий захирал ажиллах ба мөн дэд захирлууд тэдгээрийн үйл ажиллагаанд шууд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллахыг зөвшөөрнө. Төсвийн албаны даргын харьяанд үндсэн бүтцэд хамаарахгүй ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.
- Төсвийн албаны даргын дэргэд зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл ажиллаж болно. Төсвийн албаны бүтэц, бүрэлдэхүүнийг журмаар тогтооно. Албаны нэгжийн чиг үүрэг тэдгээрийг байгуулах болон дэд захирлуудтай холбогдох асуудлыг Төсвийн албаны дарга өөрөө тодорхойлно.

7.2 (Судалгааны ажилтнуудын албан тушаалын хяналт)

- Хэлтсийн дарга судалгааны ажилтнуудыг ажилд авахдаа ажилтнуудаас албан тушаалын шалгалт авна.
- 1-р зүйлийн дагуу хэлтсийн дарга албан тушаалын шалгалтын үр дүнд үндэслэн ажлын ур чадварын үнэлгээ гаргах ба (Төрийн албан хаагчийн хууль) 34.3-т заасны дагуу шаардлагатай бол байгууллагын дарга ур чадварын шалгалт авч болно.
- 1-р зүйлийн дагуу албан тушаалын шалгалт авах, 2-р зүйлийн дагуу ур чадварын шалгалт авах зэрэг шаардлагатай асуудлыг Үндэсний Ассамблейн журмаар зохицуулна.

8 дугаар зүйл. Хороод болон Үндэсний Ассамблейн гишүүдэд материал танилцуулах

Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ Хороо болон Үндэсний Ассамблейн гишүүдийн хүсэлтийн дагуу тэдэнд шаардлагатай материалыг танилцуулах үүрэгтэй.

9 дүгээр зүйл. Тайлан

Төсвийн албаны дарга болон бусад албан хаагчид нь Үндэсний Ассамблейн хороод болон гишүүдийн хүсэлтийн дагуу судалгаа, тайлан ба холбогдох тайлбарыг хороодод гаргаж өгнө. Албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэх явцад холбогдох төрийн байгууллага болон тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хууль журамд оруулбал зохих өөрчлөлт, хууль бус асуудлын талаар Үндэсний Ассамблейн төсөв, санхүүгийн болон бусад хариуцсан хороодод мэдээлэл, илтгэл хүргүүлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Мэдээлэл авах

Төсвийн албаны дарга нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай байгаа баримт мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас Үндэсний Ассамблейн даргын зөвшөөрлөөр авах, танилцах эрхтэй байна. Төрийн байгууллагууд нь тухайн мэдээллийг нууцлах онцгой шалтгаангүй бол гаргаж өгөх үүрэгтэй.

11 дүгээр зүйл. Төлөөлөх

Энэ хууль болон холбогдох журамд заасан, мөн энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлуудыг Үндэсний Ассамблейн дарга Үндэсний Ассамблейн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

2.3 ГҮРЖИЙН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД

Гүрж улс нь Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд Найрамдах улс юм. Төрийн тэргүүн Ерөнхийлөгч нь 5 жилийн хугацаатай сонгогдох ба гүйцэтгэх засаглалыг тэргүүлнэ. Хууль тогтоох дээд байгууллага нь нэг танхимт Дээд зөвлөл. Одоогийн Үндсэн хуулиа 1995 онд баталсан. Үндсэн хуулиар парламентын бүтэц, бүрэн эрхийг баталгаажуулахын зэрэгцээ ирээдүйд Гүржийн нутаг дэвсгэрийн нэгдмэл байдлыг сэргээсний дараа Гүрж улс нь Улсын зөвлөл болон Сенат гэсэн хоёр танхимаас бүрдсэн

парламенттай болох тухай Үндсэн хуулийн 4-т заажээ. Энэ тохиолдолд парламентын доод танхим болох Улсын зөвлөлийн гишүүд нь зөвхөн сонгуулийн пропорциональ тогтолцоогоор сонгогдох болно. Сенатын бүрэлдэхүүнд Гүржийн нутаг дэвсгэрийн нэгжүүдээс сонгогдсон сенатчид, Абхазаас сонгогдсон сенатчид, Ажараас сонгогдсон сенатчид, Ерөнхийлөгчөөс томилогдсон 5 сенатч багтах юм байна.

Гүржийн Үндсэн хуульд зааснаар засгийн газрын төсөв тэнцвэртэй байна. Өөрөөр хэлбэл, улсын төсөв алдагдалгүй байх ба зээл авч төсвийн хөрөнгийг бүрдүүлэхгүй гэсэн үг юм.

Гүрж улсад улсын төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэх болон батлах гүйцэтгэлийг хангах ерөнхий дөрвөн үе шаттай байх ба энэхүү ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг дараах албадууд ажилладаг:

1. Парламентын Төсвийн Газар (Parliament Budget Office)
2. Төсвийн Хууль Тогтоох Газар (The Legislative Budget Office)
3. Нийтийн Танхимын Төсвийн Газар (House Budget Office)
4. Сенатын Төсөвлөлтийн Хороо (Senate Appropriations Committee)
5. Сенатын Төсөв Үнэлгээний Газар (Senate Budget and Evaluation office)
6. Төсөв Төлөвлөлтийн Газар (The Office of Planning and Budget) OPB

Парламентын төсвийн газар (Parliament Budget Office)

Гүржийн Парламентын төсвийн газар нь Гүржийн парламентын Санхүү-төсвийн хороонд (Parliament Budget Office of Georgia existing with Finance and Budget Committee of parliament of Georgia) харьяалагдан Гүржийн парламентын хороод, парламентын гишүүд болон парламентын албан хаагчдад төсөв санхүү, эдийн засгийн мэдээллийг гаргаж өгөх зорилгоор байгуулагдсан. Анх 1997 оны 8-р сарын 25-нд Гүржийн парламентын товчооны (Bureau of Parliament of Georgia) шийдвэрийн дагуу байгуулагдсан ба хамгийн сүүлд 2008 оны 11 сарын 3-нд парламентын төсвийн газарт бүтцийн шинэчлэл хийгдсэн. Үүнд: **USAID** (United States Agency for International Development) оролцож Парламентын төсвийн газрын үйл ажиллагаа болон үүсгэн байгуулах ажилагаанд ихээхэн дэмжлэг үзүүлсэн.

Төсвийн газар нь Гүржийн үндсэн хууль, Гүржийн парламентын эрх зүйн зохицуулалт, бусад эрх зүйн акт, Гүржийн парламентын албан хаагчдын тогтоол, Төсөв санхүүгийн хороо ба төсөв санхүүгийн хорооны албан хаагчдын тогтоол, Гүржийн парламентын удирдагчийн бусад акт, мөн Парламентын төсвийн газрын тогтоолын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

Бүтэц: Төсвийн газрын гол зорилго бол Гүржийн парламентад төсөв санхүү, эдийн засаг болон бусад чиглэлээр дүн шинжилгээ, мэдээллийг гарган өгөх юм. Төсвийн газар энэ зорилгоо мониторинг болон эдийн засгийн судалгаа шинжилгээ хийх замаар гүйцэтгэнэ. Одоогоор 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Чиг үүрэг: Төсвийн газар дараах чиглэлээр судалгаа шинжилгээ хийнэ.

- Гүржийн улсын төсөв түүнчлэн гүржийн бусад нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв байгуулалт, хэлэлцүүлэг, батлах ба гүйцэтгэх талаар, мөн төсвийн санхүүжилт зарлагын үр ашиг болон тэдгээрийн гүржийн хуулийн нийцэмж зэргийн талаар
- Улсын макро эдийн засгийн хөгжлийн нөхцлүүд болон төслийн үзүүлэлтүүд
- Суурь мэдээлэл болон удирдан чиглүүлэх албан бичгийн үндсэн дээр төсвийн болон мөнгөний бодлогын үндсэн чиглэл ба дунд хугацааны стратегээ тодорхойлох.

- Улсын төсвийн төслийг Гүржийн макро эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлттэй нийцүүлэх.
- Гүржийн төлбөр тооцооны тэнцлийн байр суурь
- Гүржийн мөнгөний бодлого, татварын бодлого ба ёс заншлын бодлого
- Улсын өрийн асуудал
- Төсвийн илүүдэл / дутагдлын асуудал

Төсөв Төлөвлөлтийн Газар (The Office of Planning and Budget – OPB)

Төсөв Төлөвлөлтийн Газар нь 1972 оны Executive Reorganization Act-ийн дагуу засгийн эрх баригчийн газарт төсөв төлөвлөлтийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэйгээр албан ёсоор байгуулагдсан.

Бүтэц: Төсөв Төлөвлөлтийн Газар нь хоёр нэгж, гүйцэтгэх салбар болон бусад зургаан салбартай. Ойролцоогоор 60 албан хаагчтай. Дараах салбар нэгжүүдэд хуваагдана:

- Захиргааны салбар
- Хөрөнгө төсвийн нэгж
- Боловсролын салбар
- Гүйцэтгэх газар
- Засгийн газрын ерөнхий салбар
- Эрүүл мэнд, хүний үйлчилгээний салбар
- Мэдээлэл технологийн салбар
- Эдийн засгийн хөгжлийн салбар
- Төлөвлөлт ба үнэлгээний нэгж

Чиг үүрэг: Төсөв Төлөвлөлтийн Газар нь засгийн эрх баригч болон бусад бодлого боловсруулагчдад улсын засгийн газрын үйл ажиллагааг дээшлүүлэхэд үнэ цэнэтэй, бодитой, цагаа олсон мэдээллүүдийг гарган өгөх үүрэгтэй. Мөн Улсын төсвийн удирдагчийн хувьд засгийн эрх баригч жил бүр улсын төсвийн төслийг Ерөнхий Ассамблейд танилцуулах үүрэгтэй. Төсвийн саналыг хүргүүлэхээс өмнө Төсөв Төлөвлөлтийн Газар агентлагын төсвийн төслүүд болон бодлогын асуудалд шинжилгээ хийнэ. Түүнчлэн засгийн эрх баригчийн хэлэлцүүлэгт дэлгэрэнгүй төсвийн төслийг боловсруулна.

Гүйцэтгэх засаглалын салбарын агентлаг бүр төсвийн жил (7-р сарын 1 өдөр) эхлэхээс өмнө Төсөв Төлөвлөлтийн Газар руу жил бүрийн үйл ажиллагааны төсвөө хүргүүлэх ёстой. Төсөв Төлөвлөлтийн Газар эдгээр зарлагын төлөвлөгөөг төсөвлөлтийн акттай нийцэж байгаа эсэхийг хэлэлцэнэ. Мөн эдгээр агентлагуудын зарлагад үргэлжлүүлэн мониторинг хийх ажлыг хариуцна. Төсөв Төлөвлөлтийн Газар нь мөн улсын хөгжлийн стратеги төлөвлөгөөнүүдийг боловсруулдаг гол агент юм.

Сенатын Төсөв Үнэлгээний Газар (Senate Budget and Evaluation office)

Сенатын Төсөв Үнэлгээний Газар нь 2003 онд үүсгэн байгуулагдсан.

Чиг үүрэг: Улсын төсвийг боловсруулах программ хангамж болон төсөв боловсруулах, хөгжүүлэх бие даасан чадавхи бүрдүүлэх зорилготой. Сенатын гишүүдэд бодитой, үнэн зөв, нарийн нягт, үзэл сурталжсан бус, цагаа олсон мэдээллийг гарган өгөх.

Мэдээлэл хэрхэн олж авах: Мэдээллийн хүсэлтийг утсаар, и-мэйлээр, захидлаар гаргаж болно. Мэдээллийн хүсэлтийн дагуу мэдээлэл болон судалгааг хоёр долоо хоногийн дотор гаргаж өгнө. Бүх мэдээлэл болон судалгааны үр дүнг и-мэйл, уян диск, эсвэл бичиг баримтаар мэдээлнэ. Түүнээс гадна төсөвлөлтийн баримт бичиг болон бусад төсөвтэй холбоотой баримтуудыг онлайнгаар үзэх боломжтой байдаг.

Сенатын Төсөвлөлтийн Хороо (Senate Appropriations Committee)

Сенатын Төсөвлөлтийн Хороо нь Jack Hill-аар удирдуулдаг ба ойролцоогоор 30 гишүүнтэй үйл ажиллагаа явуулдаг.

Чиг үүрэг: Төсөвлөлтийн Хороо нь жил бүрийн гүйцэтгэлд тулгуурлан засгийн газрын агентууд, яам, байгууллагуудын төсвийн хуваарилалтыг хийх саналыг гаргах ажлыг хариуцдаг. Мөн өөрийн 9 дэд хороодтой, чуулган зохион байгуулах ажлыг хариуцна.

Нийтийн Танхимын Төсвийн Газар (House Budget Office)

Чиг үүрэг: Гүрж Улсын Төлөөлөгчдийн Танхимын (Georgia House of Representative) 180 гишүүд болон тэдэнд үйлчилдэг албан хаагчдад үнэн бодит, цагаа олсон төсвийн мэдээлэл болон шинжилгээг хүргэх үүрэгтэй.

Нийтийн Танхимын Төсвийн Газрын төсвийн шинжээчид улсын бүх яамны санхүү төсвийн ажилчидтай хамтран ажиллах ба Нийтийн Танхимын хүсэлтийн дагуу намын бодлогоос ангид мэдээллийн туслалцаа үзүүлнэ. Энэ газар нь түүхэн, одоо үеийн, урьдчилан төлөвлөсөн төсөвлөлт, орлого зарлагын мэдээллийн бааз юм. Түүнчлэн энэхүү газар нь төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх, төсвийн Нийтийн Танхимын хуулийн төсөл боловсруулах, мөн төсвийн хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулах ажлыг хариуцдаг.

Санхүүгийн зарим өвөрмөц үйлчилгээ үзүүлэх, татвар, долларын ханшийн менежмент хийх зэргээр өөрийн улсын иргэдэд үйлчлэхийн тулд улсын засгийн газрын үр ашгийг боломжит хамгийн өндөр түвшинд хүргэх зорилготой.

Төсвийн Хууль Тогтоох Газар (The Legislative Budget Office)

Төсвийн Хууль Тогтоох Газар (The Legislative Budget Office) нь 1970 онд Төлөөлөгчдийн Танхим ба Сенатад зөвлөх үйлчилгээ үзүүлэх дундын газар хэлбэрээр байгуулагдсан. Энэ газар нь төсвийн хууль тогтоох шинжээч Robert Hobbs-аар удирдуулдаг ба ойролцоогоор 10 албан хаагчтай ажилладаг.

Чиг үүрэг: Төсөв боловсруулах үе шатны турш Төсвийн Хууль Тогтоох Газар нь ОРВ болон хууль тогтоогчид, засгийн эрх баригчидтай хамтран ажиллана. Мөн төсөвт шинжилгээ хийнэ.

Энэ газар нь чуулган болгоны дараа ажлын байранд гэнэтийн шалгалт хийн, зарим тохиолдолд тухайн салбарын төсвийн зарлагыг тодруулахын тулд илүү гүнзгий судлана. Хууль тогтоох төсвийн шинжээч болон Хууль Тогтоох Төсвийн Газрын албан хаагч жил бүрийн төсвийн чуулганд оролцох, төсвийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй.


2.4 КАНАДЫН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН АЛБА

Канад Улс нь Парламентын засагтай ардчилсан, Үндсэн хуульд хаант улс юм. Төрийн тэргүүн нь Хатан хаан II Элизабет. Канадын Ерөнхий сайд Засгийн газрын тэргүүн юм. Гүйцэтгэх эрх мэдэл нь албан ёсоор, үндсэн хуулийн дагуу Хатан хаанд хамаардаг. Гэхдээ үндсэн хуулийн концепцийн дагуу Хатан хаан ба түүний томилсон төлөөлөгч болох Канадын Амбан захирагч их төлөв ёслолын шинжтэй, улс төрийн бус үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх нь Канадын Засгийн газрын танхимд байдаг. Канад Улсын хууль тогтоох байгууллага нь 2 танхим бүхий парламент юм. Дээд танхим – Сенат 105 гишүүнтэй, Доод танхим – Нийтийн танхим 308 гишүүнтэй.

Бүтэц: Парламентын Төсвийн алба (The Parliamentary Budget Officer – PBO)-ыг 2006 оны 12-р сард Канадын Парламентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Парламентын номын сангийн бүтцэд байгуулсан. Парламентын төсвийн алба нь Сенат болон

Төлөөлөгчдийн танхимын спикерт ажлаа тайлагнадаг Парламентын номын санд мөн ажлаа тайлагнах ёстой. Одоогоор Парламентын төсвийн алба нь эдийн засаг төсвийн шинжилгээ, орлого зарлагын шинжилгээ гэсэн хоёр хэлтэстэй. Үүнд нийт 13 албан хаагч ажиллаж байна.

Зураг 9. Канадын Парламентын төсвийн алба



Чиг үүрэг: Төсвийн албаны зорилго нь төсвийг улам ил тод болгох. Энэ нь парламентын гишүүдэд эдийн засаг, төсвийн талаар цагаа олсон системтэй мэдээлэл, судалгаа шинжилгээг гаргаж өгөх юм.

1. Холбооны хариуцлагын тухай актаар (Federal Accountability Act) Төсвийн алба нь Сенат болон Төлөөлөгчдийн танхимд улсын төсөв, засгийн газрын ба үндэсний эдийн засгийн талаар урьдчилсан тооцоолсон, биеэ даасан судалгаа шинжилгээг тусгайлан гаргаж өгөх үүрэгтэй. Үүнд:
 - Улсын эдийн засаг төсвийн чиглэлээр судалгаа хийх
 - Засгийн газрын урьдчилсан тооцоонд (төлөвлөсөн зарлага г.м) судалгаа дүн шинжилгээ хийх
 - Парламентаар хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой аль ч санхүүгийн саналын өртгийг урьдчилан тооцоолох.
2. Төсвийн алба мөн парламентын дараах хороодод мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлнэ:
 - Сенатын Үндэсний санхүүгийн байнгын хороо
 - Төлөөлөгчдийн танхимын санхүүгийн байнгын хороо
 - Төлөөлөгчдийн танхимын олон нийтийн санхүү бүртгэлийн байнгын хороо
 - Эрх зүйн зохицуулалтанд нэр нь тусгагдаагүй засгийн газрын үйл ажиллагаа хариуцсан бусад байнгын хороо

3. Төсвийн алба нь дараах бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлнэ. Эдийн засаг-төсвийн судалгаа шинжилгээ болон Орлого зарлагын судалгаа шинжилгээ гэсэн хоёр категорийн дагуу гурван төрлийн судалгааны бүтээгдэхүүн гаргана.
- Эдийн засаг, төсвийн судалгаа шинжилгээ
 - **Ердийн:** улирлын эдийн засаг санхүүгийн шинэ мэдээлэл
 - **Судалгаа:** эдийн засаг, төсөвт үүсч буй гол асуудлуудын талаар суурь мэдээлэл ба судалгааны мэдээлэл.
 - **Хүсэлтээр:** хороодын хүсэлтээр товч болон дэлгэрэнгүй судалгаа шинжилгээнүүд
 - Орлого зарлагын судалгаа шинжилгээ
 - **Ердийн:** парламентын төсөвлөлтийн цуврал, парламентын мэдээллийн цуврал, засгийн газрын төсвийн шийдвэр гаргаагчийн цуврал
 - **Судалгаа:** төсвийн ил тод байдал, зарлагын менежмент, санхүүгийн мэдээлэл, засгийн газрын үйл ажиллагааны суурь мэдээлэл
 - **Хүсэлтээр:** хороодын эсвэл парламентын гишүүдийн хүсэлтээр товч болон дэлгэрэнгүй судалгаа шинжилгээнүүд

Бүх бүтээгдэхүүн Төсвийн албаны олон нийтийн вэбсайт болох www.parl.gc.ca/pbo-dpb дээр шууд тавигдана.

2.5 ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО (PAC – The public accounts committee) (ИХ БРИТАНИ, АВСТРАЛИ, ШИНЭ ЗЕЛАНД)

Төрийн хариуцлагын хороо (PAC – The Public Accounts Committee) нь Вэстминистерийн загварын²⁴⁸ улсууд буюу Их Британи, Канад, Шинэ Зеланд, Ирланд, Энэтхэг, Хонконг, Малта, Сингапур зэрэг орнуудаас үүсэлтэй.

Вэстминстерийн системийн үед гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох засаглалынхаа салшгүй хэсэг нь байдаг ба засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд засгийн газрын зөвшөөрөлгүйгээр парламентын зүгээс өөрчлөлт оруулах нь засгийн газартаа парламент итгэл үзүүлэхгүй байна гэдэг утгаар ойлгогддог. Харин конгрессын системийн үед гүйцэтгэх засаглалаас Конгрессын бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн тооцооллыг өргөн барьдаг. Конгрессоос эцсийн байдлаар баталсан төсөвт Ерөнхийлөгчийн өргөн барьсан бүх төсвийг заавал хамруулах шаардлагагүй байдаг. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсвийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн батлаагүй нь Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл болдоггүйгээрээ конгрессийн систем нь Вэстминстерийн системээс ялгаатай байна.

Анх 1861 онд Их Британийн Нийтийн танхимын тогтоолоор Төрийн хариуцлагын хороо байгуулагдсан.

Их Британн нь Үндсэн хуульт, Эзэн хаант, нэгдмэл улс. Төрийн эрх нь Вэстминистерийн систем бүхий Парламент бөгөөд Лордуудын танхим, Нийтийн танхимаас бүрддэг. Нийтийн танхим ихэнх үүргийг гүйцэтгэнэ, тодруулбал, ямар ч шинэ хууль, хуулийн нэмэлт өөрчлөлт, хориг, татвар ногдуулалтын шийдвэр Нийтийн танхимын шийдвэргүйгээр гардаггүй. Нийтийн танхим бүх ард түмнээс дээд тал нь 5 жилээр шууд сонгогддог 650 гишүүнтэй. Лордын танхим нь Английн сүм хийдийн хамба нар, угсаа залгамжлагчид, язгууртнуудаас Хаан томилдог 733 гишүүдийн бүрэлдэхүүнтэй.

²⁴⁸ Вэстминистерийн загвар (Westminster system) Британийн парламент болон засгийн газрын институцийн үндсэн шинж чанарыг илэрхийлэх бөгөөд энэхүү загварыг олон шинж Канад, Австрали, Шинэ Зеланд болон Ази, Африк, Кариб дахь Британийн колони байсан олонхи улсад хэрэглэдэг байна.

Бүтэц: Нийтийн танхимын энэхүү тусгай хороо одоогийн байдлаар 14 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хорооны даргаар нь сөрөг хүчнээс сонгодог байна.

Чиг үүрэг: Энэхүү байнгын хороо нь төрийн зарцуулалтыг үр ашигтай, үнэн зөв, хариуцлагатай байлгахын тулд төсвийг хянаж байсан. 1983 онд Үндэсний аудитын тухай хуулийн дагуу тус хорооны үндсэн үүрэг нь Ерөнхий хянагчийн тайланд шалгалт хийхдээ бодлогын асуудлыг бус харин төсвийн зардлын үнэ, чанарыг зах зээлийн бодит ханштай нийцсэн, үр ашигтай, бүтээмжтэй байгаа эсэхэд хяналт шалгалт хийдэг болсон. Ерөнхий хянагчийн хувьд төрийн байгууллагуудын зардлыг хянаж тайлагнана.

2.5.1 АВСТРАЛИ

Үндсэн хуульт хаант засагтай парламентын холбооны улс. 1856 онд Өмнөд шинэ Уэльс, Викториа, Тасмани мужид, 1857 онд Өмнөд Австрали, 1860 онд Куинсленд, 1890 онд Хойд Австрали мужид анхны парламентууд тус тус байгуулагдсан.

1901 онд Австралийн колониуд нэгдэхэд Холбооны парламентыг байгуулжээ. Холбооны парламент хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг бөгөөд хоёр танхимтай. Доод буюу Төлөөлөгчдийн танхим нь 3 жилийн хугацаатай сонгогдох 150 гишүүнтэй, Дээд танхим буюу Сенат нь 6 жилийн хугацаатай сонгогдох 76 гишүүнтэй. Хууль хэлэлцэн батлахдаа хоёр танхим ижил боловч Сенат нь санхүүтэй холбогдолтой хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй.

Австралийн Хамтын нөхөрлөлийн улс нь засаг захиргааны хувьд 6 муж улс, 2 эх газар болон бусад жижиг арлаас бүрддэг. Муж улс бүр өөрийн Үндсэн хуультай бөгөөд тус бүрдээ хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалтай.

Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хороо

Бүтэц: 1951 онд *Төрийн хариуцлага, аудитын хорооны тухай хуулийн* (1951 он) дагуу Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хороо (Joint Committee of Public Accounts and Audit – JCPAA) байгуулагдсан. Тус хорооны зарим эрх зүйн асуудлыг *Ерөнхий аудиторын тухай хуулиар* (1997 он) зохицуулна. Төлөөлөгчдийн танхимаас удирдана. 16 гишүүдийн бүрэлдэхүүнтэй, тэдний 6-г нь Сенатаас, 10-г нь Төлөөлөгчдийн танхимаас томилно

Мөн Австралийн Хамтын нөхөрлөлийн 6 муж улс, 2 эх газар нь тус бүрдээ Төрийн хариуцлагын хороотой.

Чиг үүрэг: Дээр хэлсэнчлэн Төрийн хариуцлагын хорооны үндсэн үүрэг нь төрийн байгууллагуудын санхүүгийн удирдлага, ялангуяа төсвийн гүйцэтгэлийг шинжлэн судлах замаар засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх гол зорилготой.

Австралийн Төрийн хариуцлага, аудитын хороо нь төсвийн хөрөнгийг хуулийн дагуу, үр ашигтай, бүтээмжтэй байгааг хянах үүрэгтэй. Тухайлбал:

- төсвийн ороgo, зарлагын тооцоог хянаж шалгана,
- мужуудын захиргааны санхүүд шалгалт хийнэ,
- парламентад танилцуулагдсан бүх аудитын тайланд шалгалт хийнэ,
- Парламентад танилцуулагдсан төсөвтэй холбоотой бүхий л асуудлуудыг хянаж шалгах,
- хяналт, шалгалтын үр дүнг Парламентын хоёр танхимд танилцуулах,
- Парламентын сонирхсон асуудалд хариу өгөх,
- Парламентад зөвлөмж гаргах,

- Ерөнхий сайдын Ерөнхий аудитад санал болгосон нэр дэвшигчийг дэмжих, татгалзах бүрэн эрхтэй,
- мужуудын захиргааны жилийн төсвийн удирдлага болгож байдаг үзэл баримтлалд Парламентын өмнөөс дэмжих эрхтэй²⁴⁹,

Мөн 2 жил тутам Авсралийн Татварын алба нь тус хорооны татвартай холбоотой асуулгад хариу өгөх.²⁵⁰

2.5.2 ШИНЭ ЗЕЛАНД

Эртнээс уламжлалтай засгийн газрын Вэстминистерийн загвараар төсвийн хөрөнгийг батладаг. Шинэ Зеланд нь энэхүү уламжлалыг Үндсэн хууль (1986 он) болон Төрийн санхүүгийн тухай хууль (1989 он) зэрэг эх сурвалжуудаар хэрэгжүүлдэг байна.

Шинэ Зеланд улсын төсөв батлах явцад Засгийн газраас дараах процессыг анхааран үзнэ:

- Урьдчилсан төлөвлөлт;
- Бодлогын үйл явцыг санхүүгийн нөөцтэй уяалдуулах;
- Парламентын зарцуулах эрх мэдлийг эрэлхийлэх.

Төсвийн үйл явц нь дараах хэд хэдэн үе шатуудаас бүрдэнэ:

- Стратегийн үе шат;
- Төсвийг танилцуулахад бэлтгэх;
- Төсөвт тусгагдах санаачлагыг боловсруулах;
- Төсвийн суурь мэдээлэлд хяналт тавих;
- Төсвийн төслийг хэлэлцэж батлах;
- Төсвийн баримт бичгийг боловсруулж, танилцуулах;
- Төсвийн хуваарилалтын хуулийн төслийг батлах .

Стратегийн үе шат (VIII-XI сар)

Төсвийн үйл явц дахь стратегийн үе шатанд сайд нар салбарынхаа төсвийн зорилтыг ирэх гурван жилээр тодорхойлно. Энэ үе шатанд Сайд нарын танхим нь Сангийн сайд болон бусад сайд нараас ирсэн мэдээлэл болон зөвлөмжийг хүлээн авч Засгийн газрын хүрэх зорилтот түвшин, холбогдох үр өгөөжийг хэлэлцэж төсвийн батална.

Стратегийн үе шатанд гаргасан шийдвэр нь Төсвийн бодлогын баримт бичгийн гол суурь болж өгдөг. Энэхүү агуулга нь төсвийн нэн тэргүүний зорилтыг тодорхойлох сайд нарын шийдвэр юм. Төсвийн бодлогын баримт бичгийн хамгийн чухал элементүүд нь зорилтот арга хэмжээнд зарцуулах төсвийн төлөвлөлт, ашгийн нийлбэрийг тогтоох, нийт зээл болон хөрөнгийн хэмжээг тогтоох зэрэг болно. Уг баримт бичиг нь стратегийн үе шатны эцсийн үр дүн болох ба хагас жилийн тодотголоор мэдээллийг баяжуулдаг.

Төсвийг танилцуулахад бэлтгэх үе шат (XI сараас дараа жилийн II сар хүртэл)

Салбарын сайд нар дараа жилийнхээ төсөв болон бараа материал худалдан авах гэрээ хэлцэлд бэлтгэх үе шат юм. Бараа материал худалдан авах гэрээ хэлцэл нь төсвийн тодотголд шууд хамаарахгүй бөгөөд салбарын эцсийн бүтээгдэхүүн болон зорилтыг тодорхойлж, тухайн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, эцсийн бүтээгдэхүүн боловсруулан гаргахад шаардагдах төсөв, зардлыг төсвийн тодотголд тусгана. Мөн дараа жилийн төсөвт салбарын төсвийг дараагийн хоёр жилээр тооцоолж тусгасан байх ёстой.

²⁴⁹ Уг эрхийг 1999 оноос олгосон.

²⁵⁰ Уг эрхийг 2007 оноос олгосон.

Төсөвт тусгагдах санаачилгыг боловсруулах үе шат

Салбарын сайдууд, яамдын хэлтэс, албад тухайн жилийнхээ төсвийг санаачлан боловсруулахдаа нэн тэргүүнд үйл ажиллагааны зардал, ашиг орлогын эрсдэлээ тооцоолж үзэх шаардлагатай. Эдгээр бодлогын санал, санаачилга нь стратегийн үе шатны туршид төсвийн үндсэн чиглэл болон тухайн жилийн төсвийн параметрт нийцэж байх ёстой.

Төсвийн суурь мэдээлэлд хяналт тавих үе шат (II-IV сар)

Салбарын сайд нар тухайн жилийнхээ зарцуулалтыг батлагдсан төсвийн хэмжээнд барьж ажиллахыг зорьдог. Энэхүү батлагдсан төсвийн хэмжээ нь суурь мэдээлэл бөгөөд үүнд дараа жил, түүний дараагийн хоёр жилд зарцуулах төсвийн нийт дүн багтсан. Эцсийн бүтээгдэхүүн болон бараа бүтээгдэхүүн худалдан авах зардлын агуулга тодорхой нэг шалтгааны улмаас холилдсон тохиолдолд түүний агуулгын өөрчилж болох боловч энэ тохиолдолд Засгийн газраас баталсан бодлогын зорилтуудад нийцсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх ёстой. Хэрэв салбарын сайд нар тухайн суурь мэдээллийн агуулга, зорилтыг өөрчлөхийг хүсвэл Сайд нарын танхим уг мэдээлэлд нарийн хяналт, шалгалт хийж, саналыг авч хэлэлцэн тухайн суурь мэдээллийг өөрчлөх болсон нөхцөл байдлыг судалсаны үндсэн дээр батална.

Дараа жилийн төсвийн суурь мэдээллийг бэлтгэх, хянахтай зэрэгцэн сайд нар тухайн жилийн өөрчлөлтийг багтаасан Нэмэлт тооцооллыг хүлээн зөвшөөрдөг. Нэмэлт тооцооллын саналд Сайд нарын танхимын шийдвэр болон төсөвт тухайн жилд урьдчилан таамагласан өөрчлөлтүүдийн хамт санал болгодог.

Төсвийн төслийг хэлэлцэн батлах үе шат (II-IV сар)

Энэ хугацаанд Сайд нарын танхим нь сайд нарын төсвийн зардал, ашиг орлогыг ямар түвшинд (зардлыг нэмэгдүүлэх эсвэл бууруулахын аль нэгийг сонгох) батлах тухай бодлогын саналыг хянан үзнэ. Сайд нарын танхим нь Засгийн газрын стратегийн хамт сайд нарын саналууд, ялангуяа Төсвийн бодлогын баримт бичигт тусгалаа олсон төсвийн нэн чухал зарчмууд болон төсвийн зорилтуудыг үнэлнэ. Төлөөлөгчдийн танхим Төсвийн бодлогын баримт бичгийн талаарх Санхүү, зардлын хорооны тайланг хэлэлцэсний дараа Сайд нарын танхим төсвийн эцсийн хувилбарыг батална.

Төсвийн баримт бичгийг боловсруулж, танилцуулах үе шат

“Төсвийн өдөр” Сангийн сайд Төлөөлөгчдийн танхимд төсвийн жилийг хааж байгаатай холбогдуулан дараах баримт бичгийг танилцуулна:

- шинээр эхэлж буй төсвийн жилийн эхний хуваарилалтын хуулийн төсөл
- төсвийн тухай илтгэл болон Санхүүгийн стратегийн тайлан
- төсвийн тодотгол
- үндсэн тооцоолол
- салбарын урьдчилсан төлөвлөгөө

Хуулийн зохицуулалтаар төсвийн төслийг Төлөөлөгчдийн танхимд жил бүрийн VII сарын 31-ээс өмнө танилцуулах ёстой. Практикт төсвийн төслийг V, эсвэл VI сард танилцуулна. Энэ үед хуулийн төслийн нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг явагдах ёстой.

Төсвийн хуваарилалтын хуулийн төслийг батлах үе шат

Санхүүгийн стратеги тайлан, төсвийн тодотгол болон тооцооллыг Санхүү, зардлын хороонд илгээх бөгөөд Хороо нь баримт бичгүүдийг хянуулахаар сонгогдсон хороонд шилжүүлнэ. Сонгогдсон хороо нь сайд нар болон холбогдох салбаруудын

хуваарилалтын хүсэлт буюу эрэлт хэрэгцээг хянан үзэж Төлөөлөгчдийн танхимд хоёр сарын дотор тайлагнана. Мөн Санхүү, зардлын хороо нь Санхүүгийн стратеги тайлан болон төсвийн тодотголд хяналт шинжилгээ хийнэ. Энэ үед хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг явагдаж, Төлөөлөгчдийн танхим батална.

ШИНЭ ЗЕЛАНДЫН САНХҮҮ, ЗАРДЛЫН ХОРОО

Бүтэц: Төлөөлөгчдийн танхимын тогтоолоор 1890 онд Санхүү, зардлын хороо (Finance and Expenditure Committee – FEC) байгуулагдсан бөгөөд Шинэ Зеландын Парламентын байнгын бөгөөд 13 тусгай хороодын²⁵¹ нэг. 12 гишүүнтэй.

Чиг үүрэг: Санхүү, зардлын хороо бол улсын салбарын санхүүгийн менежментийг хянан шалгах үүрэгтэй гол сонгогдсон хороо. Уг хороо нь Төлөөлөгчдийн танхимыг төлөөлөн хяналт тавих ба урьдчилсан тооцоо болон Засгийн газрын гаргасан жилийн эцсийн санхүүгийн тооцоог бүхэлд нь хянана.

Тус хороо нь улсын төсвийг батлах явцад Санхүүгийн стратеги тайлан, төсвийн тодотголд хяналт шинжилгээ хийх бөгөөд сайд нар болон холбогдох салбаруудын хуваарилалтын хүсэлт буюу эрэлт хэрэгцээг хянан үзэж Төлөөлөгчдийн танхимд 2 сарын дотор тайлагнана. Мөн Ерөнхий аудитортой холбоотой асуудлаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- **Ерөнхий аудиторын судалгаа ба мэдэгдэл:** Хороо нь Ерөнхий аудиторын мэдэгдлүүд болон түүнтэй холбогдолтой асуудлуудыг хянан шалгах эрхтэй.
- **Ерөнхий аудиторын томилгоо:** Хороо Ерөнхий аудиторын томилгоонд хориг тавих, эсвэл санал өгөх зэргээр зөвлөлдөнө.
- **Ерөнхий аудиторыг чөлөөлөх:** Ерөнхий аудиторыг чөлөөлөх санал оруулахын өмнө Хороотой заавал зөвлөлдсөн байна.
- **Аудитын газрын санхүүжилт ба төлөөлөлтийн ажил:** Хороо нь Аудитын газрын санхүүжилт, төсвийн урьдчилсан тооцоог хянах үүрэгтэй. Аудитын газрын жил бүрийн төсвийн тодотголын талаар зөвлөлдсөн байх ёстой

2.6 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Холбооны Хурал (Федеральное Собрание) нь Холбооны Зөвлөл (Совет Федерации), Төрийн Дум (Государственная Дума) гэсэн хоёр танхимтай.

Эрх зүйн орчин: Парламентын хяналтын тухай хууль нь 3 бүлэг, 15 зүйлтэй бөгөөд тус улсын Үндсэн хууль, ОХУ-ын субъектүүдийн Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль болон Холбооны Хурлын танхимуудаас гаргасан эрх зүйн актын хүрээнд Холбооны Хурлын танхимууд, хороод, комиссууд, танхимуудын гишүүд, Тооцооллын танхим, Парламентын мөрдөн шалгах хорооноос асуудлын шалтгаан нөхцөл, баримт нотолгоог мөрдөн шалгах болон парламентын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.

Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Парламентын хяналтын тухай хуулийг 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Холбооны Хурлын Төрийн Думаар баталж, 27-ны өдөр Холбооны Зөвлөлөөс дэмжсэн байна. Харин 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

Парламентын доод танхим болох Төрийн Дум нь парламентын хяналтын хүрээнд ОХУ-ын Засгийн газар болон бусад байгууллагын дараах тайлан, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэнэ. Үүнд:

²⁵¹ Тусгай хороод нь Төлөөлөгчдийн танхимаас томилогдсон Парламентийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд онцгой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах эрх бүхий нэгж юм.

- Засгийн газрын үйл ажиллагааны жилийн тайлан (§5);
- Төв банкны үйл ажиллагааны жилийн тайлан (§5);
- Аудитын танхимын үйл ажиллагааны жилийн тайлан (§164¹);
- Төв банкны ОХУ-ын төрөөс мөнгө-зээлийн талаар баримтлах нэгдсэн бодлогын хэрэгжилтийн тайлан.

ОХУ-ын парламентын хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “парламентын хяналтыг хэрэгжүүлэх субъектүүд”-ийг баталсан байдаг.

1. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий субъектүүдэд дараах субъектүүд хамаарна. Үүнд:

- I. Холбооны Хурлын танхимууд - Холбооны Зөвлөл болон Төрийн Дум;
- II. Холбооны Хурлын танхимуудын хороод, комиссууд;
- III. Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаанд шаардагдах нөхцөл байдал, баримт нотолгоог мөрдөн шалгах хороо;
- IV. Холбооны Зөвлөлийн гишүүд болон Төрийн Думын төлөөлөгчид.

2. Тооцооллын танхим нь төрийн хяналт (аудит)-ыг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай төрийн дээд байгууллага бөгөөд Холбооны Хуралд ажлаа хариуцан тайлагнах байгууллага тул парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд энэ хууль болон 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан Тооцооллын танхимын тухай хуульд заасан эрхийн хүрээнд тодорхой хэлбэр, журмыг баримтлан оролцоно.

ОХУ-ын парламентын хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд “парламентын хяналтын хэлбэрүүд”-ийг баталсан байдаг. Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хэлбэрүүдийг авч үзвэл,

- 1) Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг Төрийн Думаар хэлэлцэх;
- 2) Холбооны Хурлын танхимууд, хороод, Төрийн аудитын байгууллагаас төсвийн асуудлаар урьдчилсан, явцын болон дараагийн шатны парламентын хяналтыг хэрэгжүүлэх;
- 3) Төрийн Думаар Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх жилийн тайлан, Төрийн Думын төлөөлөгчдөөс тавьсан асуултын хариулт сонсох;
- 4) Төрийн Думаар Төв банкны жилийн тайланг хэлэлцэж, шийдвэр гаргах;
- 5) Төв банкны ерөнхийлөгчийн Төв банкны үйл ажиллагааны жилийн тайлан, төрийн мөнгө-зээлийн бодлогын үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, илтгэлийг сонсох;
- 6) Төв банкны үйл ажиллагаанд Төв банкны тухай хуульд заасан бусад арга хэлбэрээр парламентын хяналтыг хэрэгжүүлэх;
- 7) Холбооны Хурлын танхимуудаас асуулга тавих;
- 8) Холбооны Зөвлөлийн гишүүд, Төрийн Думын төлөөлөгчдөөс асуулга тавих;
- 9) Холбооны Хурлын танхимуудаас Засгийн газрын гишүүд, гүйцэтгэх засаглалын байгууллагууд, холбооны бусад байгууллага, төсвөөс гадуурх тусгай төрийн сангийн удирдлага, албан тушаалтнуудын мэдээллийг сонсох, “Засгийн газрын цаг”-ын хүрээнд Холбооны Зөвлөлийн гишүүд, Төрийн Думын төлөөлөгчдөөс тавьсан асуулга, асуултын хариуг сонсох, түүнчлэн Холбооны Хурлын танхимуудын хороод, комисст дээр нэр дурдсан байгууллага, албан тушаалтнуудын мэдээллийг сонсох;
- 10) Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Засгийн газрын тэргүүн, шадар сайд, Ерөнхий прокурор, Төв банкны ерөнхийлөгч, Сонгуулийн ерөнхий хорооны дарга зэрэг холбогдох албан тушаалтнуудыг мэдээлэл авах зорилгоор дуудаж сонсох;
- 11) Тооцооллын танхимын дарга, орлогч, аудитуудыг томилох, чөлөөлөх;
- 12) Холбооны Хурлаас Тооцооллын танхимтай Тооцооллын танхимын тухай хуульд заасан хэлбэрээр хамтран ажиллах;

- 13) Төрийн Думаас хүний эрхийн асуудлаар эрх бүхий төлөөлөгчидтэй хамтран ажиллах;
- 14) Ерөнхий прокурорын жилийн тайлан илтгэл, хууль хэрэгжүүлэх, сахин мөрдүүлэх ажиллагааны өнөөгийн байдал, цаашид бэхжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлын талаар мэдээлэл сонсох;
- 15) Холбооны Хурлын төлөөний хүмүүсийг хуулийн дагуу байгуулагдсан байгууллагад илгээх, эгүүлэн татах;
- 16) Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнуудыг Холбооны Хурлын танхимуудын хороод болон комиссын хуралдаанд дуудах;
- 17) Парламентын сонсгол зохион байгуулах;
- 18) Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах.

ОХУ-ын Төрийн Думын Байнгын хороод хөгжлийн хөтөлбөр, төсөв, татвар, гааль-тарифын бодлогын үндсэн чиглэл болон төсвийн урт хугацааны төсөөллийн төслүүдийг хэлэлцсэн тухай дүгнэлт гаргах, төслүүдтэй холбогдуулан парламентын сонсгол зохион байгуулахыг санаачлах эрхтэй.

Холбооны төсөвт тавих парламентын хяналт

ОХУ-ын Үндсэн хуулийн 114 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тус улсын Засгийн газар нь холбооны төсвийг боловсруулж Төрийн Думд өргөн мэдүүлэх бөгөөд холбооны төсвийн хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийн тайланг Төрийн Думд хүргүүлнэ.

Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Төрийн Думын регламентад²⁵² 2013 онд “Төрийн Думаас төсвийн харилцаанд парламентын хяналтыг хэрэгжүүлэх” асуудлыг тусгасан 212 дугаар бүлгийг шинээр нэмсэн нь Үндсэн хууль дахь төсвийн талаарх парламентын хяналтыг нарийвчлан зохицуулсан байна. (§1753-1755)

Парламентын хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд төсөвт тавих хяналтыг ОХУ-ын Холбооны Хурлын танхимууд, тэдгээрийн хороод, Төрийн аудитын байгууллагаас хэрэгжүүлэхээр заасан байна.

Энэ хуульд зааснаар төсөвт тавих хяналтыг урьдчилсан, явцын, эцсийн гэсэн үе шатуудаас бүрдэнэ. (§5, 11) Төсөвт тавих парламентын урьдчилсан хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- 1) ОХУ-ын төсвийн бодлогын үндсэн чиглэлийн төсөл болон татварын бодлогын үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэх;
- 2) ОХУ-ын төрийн хөтөлбөрийн төсөл болон түүнд оруулах өөрчлөлтийн талаарх саналуудыг хэлэлцэх;
- 3) Дараагийн жил болон төлөвлөгөөт хугацааны холбооны төсвийн тухай болон ОХУ-ын төсвийн тусгай сангийн тухай холбооны хуулийн төслийг ОХУ-ын Төсвийн тухай хуулийн дагуу хэлэлцэн батлах.

Сангийн яам нь ОХУ-ын төсвийн болон татварын бодлогын үндсэн чиглэлүүдийн төслийг Засгийн газар, Төрийн Думд (Төсөв, татварын байнгын хороо) хэлэлцүүлэхээр нэгэн зэрэг өргөн мэдүүлнэ.

Мөн ОХУ-ын салбаруудын хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд холбогдох хөтөлбөрийн төслийг Засгийн газар болон Төрийн Думд (Төсөв, татварын байнгын хороо болон холбогдох Байнгын хороо) хэлэлцүүлэхээр нэгэн зэрэг өргөн мэдүүлнэ.

²⁵²OECD. (2019) Budgeting and Public Expenditures in OECD countries 2019.OECD.

Дээрх төслүүдийг Төрийн Дум хүлээн авсны дараа Төрийн Думын Зөвлөл ажлын 1 өдөрт багтааж Холбооны Зөвлөлд хүргүүлнэ. Харин Парламентын амралтын хугацаанд Төрийн Думын дарга хүргүүлнэ. Шаардлагатай бол Төрийн Дум нь ОХУ-ын Аудитын танхим, Холбооны Зөвлөлийн Байнгын хороодыг оролцуулан холбогдох төслүүдээр парламентын сонсгол явуулж болно.

Холбогдох төслийн талаарх Холбооны Хурлын танхимуудын дор дурдсан Байнгын хороодын дүгнэлт, түүнчлэн парламентын сонсголын зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ. Үүнд:

- Төрийн Думын Төсөв, татварын байнгын хороо;
- Холбооны Зөвлөлийн Төсөв, санхүүгийн зах зээлийн байнгын хороо;
- Холбооны Зөвлөлийн Холбооны бүтэц, бүс нутгийн бодлого, нутгийн өөрийн удирдлага, Умардын асуудал эрхэлсэн байнгын хороо.

Төсөвт тавих парламентын явцын хяналтын хүрээнд Холбооны Зөвлөлийн танхимын хороодын болон комиссын хуралдаан, парламентын сонсголын үеэр парламентын асуулга, төлөөлөгчийн асуулгатай холбогдуулан холбооны төсвийн болон тусгай сангийн төсвийн гүйцэтгэлийн талаарх асуудлыг хэлэлцэнэ.

Парламентын эцсийн шатны хяналтын хүрээнд холбооны төсвийн гүйцэтгэл, ОХУ-ын улсын төсвийн тусгай сангийн төсвийн тайланг хэлэлцэн батлах журмыг ОХУ-ын Төсвийн тухай хуулийн дагуу явуулна.


Төрийн Дум төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг дараах журмаар хэлэлцэнэ:

(холбогдох албан тушаалтны илтгэл, тайланг сонсоно)

- төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын илтгэлийг;
- төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой Аудитын танхимын дүгнэлтийн талаарх тус танхимын даргын тайланг;
- төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг хэлэлцсэний дараа Төрийн Дум Холбооны төсвийн гүйцэтгэлийн тухай хуулийг батална, эсхүл батлахаас татгалзана.

Аудитын танхим нь 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн ОХУ-ын Аудитын танхимын тухай 41 тоот Холбооны хуулийн дагуу төсвийн эрх зүйн харилцааны хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлнэ.

Төрийн Думын регламентын 56 дугаар зүйлд зааснаар парламентын сонсголоор холбооны төсвийн төсөл, түүний хэрэгжилтийн тайланг мөн хэлэлцэж болно.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Төсвийн дүн шинжилгээ, хяналтын чиг үүрэг бүхий парламент дахь бүтцийн нэгжүүд тэдгээрийн үйл ажиллагааны талаархи харьцуулсан судалгаа (ПСХ)
- Төсвийн харилцааны зохицуулалт, бусад орнуудын туршлага, Засгийн газраас харах бус, бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн байдал судалгаа (ПСХ)
- Төсвийн үйл явц дахь парламентын оролцоо (Мэдээллийн хуудас, ПСХ)
- Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай анхдагч хуулийн төсөл, түүн холбогдох материал, УИХТГ, 2021,
- Senate Budget Committee. budget.senate.gov/ (Америк)
- House Committee on the Budget. budget.house.gov/
- Congressional Budget Office. Э www.cbo.gov/
- Government Accountability Office. www.gao.gov
- Office of Management and Budget. www.whitehouse.gov/omb
- Үндэсний Ассамблейн Төсвийн албаны цахим хуудас. www.NABO.co.kr (Солонгос)
- Солонгос Үндэсний Ассамблейн цахим хуудас www.assembly.go.kr (Солонгос)
- Их Британи: Public Accounts Committee. <http://www.parliament.uk/>
- Шинэ Зеланд: Joint Committee of Public Accounts and Audits. <http://www.aph.gov.au/>
- Канад: Public Accounts Committee. www.parl.gc.ca/pbo-dpb
- Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газар. УБ., 2010 он.
- Төсвийн харилцааны зохицуулалт, бусад орнуудын туршлага, хараат бус, бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн байдал. Харьцуулсан судалгаа.УИХ-Тамгын газрын Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв. 2009 он.
- WORDL BANK: Effective Financial Scrutiny: The Role of Parliament in Public Finance
- A Guide to the Public Finance Act. August 2005. Resource: <http://www.treasury.govt.nz/>
- Budget Process. Overview. 2009. New Zealand. Resource: <http://www.treasury.govt.nz/>
- Public Finance Act (1989 он). New Zealand. Resource: <http://www.legislation.govt.nz/>
- Putting it Together, An explanatory guide to the New Zealand Public Sector Financial Management System. Resource: <http://www.treasury.govt.nz/>
- Technical guide (Part 2) For departments and Ministerial Offices. 2009. New Zealand. Resource: <http://www.treasury.govt.nz/>
- Argentina: Auditor General <http://www.agn.gov.ar/>
- Australia: Joint Committee of Public Accounts and Audits <http://www.aph.gov.au/house/committee/jpaa/index.htm>
- Canada: Office of the Auditor General <http://www.oag-bvg.gc.ca/>
- Canadian Council of Public Accounts Committees <http://www.ccpac.ca>
- Chile: Comptroller General <http://www.contraloria.cl/>
- France: Court of Accounts: <http://www.ccomptes.fr/>
- Germany: Federal Court of Audit <http://www.bundesrechnungshof.de/>
- Hungary: State Audit Office <http://www.asz.gov.hu/>
- India: Committee on Public Accounts <http://parliamentofindia.nic.in/committee/p17.htm>
- International Organisation of Supreme Audit Institutions <http://www.intosai.org>
- Philippines: Commission on Audit <http://www.coa.gov.ph/>
- Public Service Accountability Monitor <http://www.psam.org.za>
- South Africa: Office of the Auditor-General <http://www.agsa.co.za/>
- South Korea: Board of Audit and Inspection <http://www.bai.go.kr/>
- Sweden: National Audit Office <http://www.riksrevisionen.se/>
- United Kingdom: National Audit Office <http://www.nao.org.uk/>

- United Kingdom: Public Accounts Committee
<http://www.parliament.uk/commons/selcom/pachome.htm>
- United States: General Accounting Office <http://www.gao.gov/>
- OECD. (2015). Recommendation of the Council on Budgetary Governance.pdf
<https://www.oecd.org/gov/budgeting/Recommendation-of-the-Council-on-Budgetary-Governance.pdf>
- OECD. (2019). Budgeting and Public Expenditures in OECD Countries 2019. OECD
<https://doi.org/10.1787/9789264307957-en>
- World Bank: Effective Financial Scrutiny: The Role of Parliament in Public Finance
- 2005 International Monetary Fund, IMF Working Paper Fiscal Affairs Department Who Controls the Budget: The Legislature or the Executive? Prepared by Ian Lienert Authorized for distribution by Jack Diamond June 2005
- The Role of the Legislature in the U.S. Budget Process, 10th Annual Meeting of the OECD Network of Parliamentary Budget Officials and Independent Fiscal Institutions, Keith Ha Director
- World Bank Parliamentary Staff Training Program, Effective Financial Scrutiny: The Role of Parliament in Public Finance, Prepared by Joachim Wehner, 2005
- Tools for parliamentary oversight, A comparative study of 88 national parliaments, Written and edited by Hironori Yamamoto, 2007

**ТӨСВИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

*Ц.Норовдондог (Ph.D), Г. Алтан-Оч (Ph.D),
Г.Оюун-Эрдэнэ*

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭГ. ТӨСВИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- АНУ
- Европын Холбооны Хэт их алдагдлын журам (Excessive deficit procedure)
- Зүүн Өмнөд Азийн улс орнуудын төсвийн дүрэм

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХЯЗГААРЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тохиолдол
- Төсвийн дүрэм
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт

НОМ ЗҮЙ



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/, Олон улсын валютын сан зэрэг олон улсын байгууллагаас гаргасан судалгааны тайланг судалж үзэхэд, төрийн санхүүгийн шийдвэр гаргахад баримтлах дүрмийг дэлхийн улс орнууд Үндсэн хуулийн хүрээнд тодорхой зохицуулдаг байдал түгээмэл байна. Ялангуяа бичмэл Үндсэн хуультай, эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад төсөв, нийтийн санхүүгийн харилцааг Үндсэн хуулийн бие даасан бүлгээр зохицуулж, Үндсэн хуулийн шууд үйлчлэх хэм хэмжээг бүрдүүлсэн нь парламент, засгийн газраас дур зоргоороо шийдвэр гаргахаас сэргийлж, хариуцлагын хэм хэмжээг Үндсэн хуулийн түвшинд тогтоосон байна.

Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх эдийн засгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд болох нийт орлого, зарлага, өр, алдагдлыг хазаарласан тоон хязгаарлалтыг эдийн засгийн хөгжлийн түвшин харгалзахгүйгээр дэлхийн цөөнгүй орнууд органик болон Үндсэн хуулиараа тогтоож өгдөг байна.

ЭЗХАХБ-аас гаргасан “Төсвийн тогтолцооны эрх зүйн орчин: харьцуулсан судалгаа”²⁵³-нд гишүүн орнуудын төсвийн тогтолцоог Үндсэн хуулиар хязгаарласан болон хязгаарлаагүй гэж хоёр хувааж авч үзсэн байна.

Эхний бүлэгт эх газрын Европын улс орнууд, АНУ болон ЭЗХАХБ-ын гишүүн Азийн улс орнуудыг багтаасан байна. Эдгээр улс орнуудын Үндсэн хууль, эсхүл Үндсэн хуульчилсан /органик/ хуулиудад холбогдох төсвийн тогтолцооны тодорхой зарчмуудыг тусгаж, холбогдох санхүүгийн хязгаарлалтуудыг тогтоосон байна. Дээр дурдсан орнуудад Үндсэн хуулийн шүүх /ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллага/ нь төсвийн хууль тогтоомжуудыг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянаж байдаг бөгөөд энэ нь төсвийн тогтолцоог өөрчлөхгүй байх эрх зүйн баталгаа болдог байна.

Хоёрдугаар бүлэгт Вестминистерийн тогтолцоо бүхий болон Скандинавын орнуудыг голчлон багтааж байгаа юм. Эдгээр орнуудад төсвийн тогтолцооны зарчмуудыг Үндсэн хуулиар зохицуулах нь ховор байна. Бичмэл Үндсэн хуульгүй орнуудын хувьд Үндсэн хуулийн хүчин чадал бүхий хязгаарлалт байхгүй бөгөөд төсвийн тогтолцооны хууль зайлшгүй шаарддаггүй байна. Үүнийг Дани, Норвеги зэрэг улсын жишээн дээр харж болох бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл, эсхүл парламентын холбогдох хорооноос баталсан тогтоолоор төсвийн эрх зүйн орчныг бүрдүүлдэг ба энэ нь илүү харилцан тохиролцооны шинжтэй байдаг байна. Эдгээр нь хуулийн адил хүчтэй байх боловч хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах процесс шаарддаггүйгээр илүү уян хатан байдаг байна. Мөн эдгээр орны хувьд Үндсэн хуулийн шүүхийн тогтолцоо байдаггүй нь төсвийн тухай хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагаас чөлөөлдөг байна.

Эдийн засаг, улс төрийн нэгдэл болох Европын Холбооны хувьд 2011 оноос эхлэн Хэт их алдагдлын тухай журмыг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. Холбогдох дүрмийн дагуу гишүүн орнуудын төсвийн алдагдал ДНБ-ний 3%-иас хэтрэхгүй байхаар заасан байна.

Үндсэн хуулийн эдийн засгийн онолын төсвийн тогтолцоог бүрдүүлэх зарчмуудын дотроос хамгийн чухал нь *төсвийн тэнцвэрт байдал* бөгөөд энэ нь нийт 203 Үндсэн хуулийг шүүн үзэхэд 28 Үндсэн хуульд холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

Европын Холбооны хувьд, төсвийн тэнцвэртэй байдал, алдагдлын талаар нэгдсэн дүрэм үйлчилж байгаа бол улс орнуудын өөрсдийн нөхцөл байдалд тааруулан холбогдох дүрмийн хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд төсвийн алдагдлын хувийг тогтоож байна. Хэт их алдагдлын тухайн журмын дагуу ЕХ-ны гишүүн орнуудын төсвийн алдагдал 3%-иас хэтрэхгүй байна.

²⁵³ Төсвийн тогтолцооны эрх зүйн орчин: харьцуулсан судалгаа-The legal framework for budget systems: An international comparison, OECD Journal on Budgeting, Volume 4, No 3, 2004, p 15.

Төсвийг тэнцвэртэй байлгах зохицуулалтын тухайд эдийн засагчид эсрэг тэсрэг байр суурьтай байна. Зарим судлаачид төсөв тэнцвэртэй байх, төсвийн зарлагын дээд хэмжээг тогтоох зэрэг асуудал нь зөвхөн Үндсэн хуулиар баталгаажиж, төсвийг бодитойгоор төлөвлөх, улс төрчдийн санхүүгийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа бол зарим эдийн засгийн онолчдын хувьд төсвийг алдагдалгүй байлгах заалт нь эдийн засгийн урт хугацааны бодлогод сөрөг нөлөөтэй, энэ нь ялангуяа эдийн засгийн удаашрал, хямралын үед асуудлыг улам даамжруулах аюултай, хямралын эсрэг түргэн шуурхай арга хэмжээ авахад саад учруулна гэж үзэж байна.

Түлхүүр үг: *улсын нэгдсэн төсөв, төсвийн хяналт, эдийн засгийн гүйцэтгэлийн шалгуур, төсвийн орлого, зарлага, улсын өр, төсвийн алдагдал, budget*

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. ТӨСВИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төсөв, санхүүгийн харилцааны илүү нарийвчилсан шинжтэй, төрийн шийдвэр гаргалтыг хязгаарлах хоёр үндсэн арга хэлбэр байдаг.²⁵⁴ *Нэгдүгээрт, улс төрийн шийдвэр гаргах ажиллагаанд процедурын хяналт тогтоох* явдал юм. Тухайлбал, тодорхой асуудлуудыг энгийн олонх бус дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх. Хэдийгээр дээрх процедурын хязгаарлалт нь санал хураалтын дүнд шууд нөлөөлөх боломж сул байдаг ч иргэдийн санал бодлыг харгалзан үзэх боломж олгодог байна.

Хоёрдугаарт, төрийн эдийн засгийн бодлогыг тодорхойлох тоон хязгаарлалтыг Үндсэн хуулиар тогтоох. Тухайлбал, төсвийн зарлагын өсөлтийг ДНБ-ний өсөлтийн хэмжээний тодорхой хувиас хэтрүүлэхгүй байх хязгаарлалт тавих зэрэг зохицуулалтуудыг дурдаж болох юм. Энэ төрлийн хязгаарлалтууд нь уян хатан биш тул сайтар хэлэлцэж, тооцож судалсны үндсэн дээр тогтоох шаардлагатай байдаг бол шууд хэрэгждэгээрээ давуу талтай юм. Эдгээр нь Үндсэн хууль дахь төрийн үйл ажиллагааны ерөнхий хязгаарлалтуудаас гадна, эдийн засгийн бодлогын мөн чанар, шийдвэр гаргалтад нийцсэн тусгай хязгаарлалт юм.

Үндсэн хуулийн эдийн засгийн онолын үзэл санаа улс орнуудад хэрхэн тусгагдсаныг судалж үзэхэд, бичмэл Үндсэн хуультай улс орнуудын хувьд Үндсэн хууль нь нийтийн санхүүгийн салбарын суурь зарчим болох бөгөөд төсөв, санхүүгийн харилцааг зохицуулсан заалтууд, тэдгээрийн хэм хэмжээ, агуулга нь харилцан адилгүй байна.

Үндсэн хуулийн төсөв, санхүүгийн зохицуулалтыг агуулгын хувьд:

- материаллаг шинжтэй суурь зарчмууд;
- санхүүгийн тоон хязгаарлалтууд гэсэн үндсэн 2 бүлэгт ангилан хувааж болох юм.

Үндсэн хуулийн материаллаг шинжтэй суурь зарчмууд гэдэгт төсвийн тогтолцооны суурь зарчмууд, тэдгээрт нийцсэн парламент, засгийн газрын төсвийн үүрэг хариуцлага, төсвийн процессын зарим чухал харилцаа, төрийн төв болон орон нутгийн байгууллагын төсвийн эрх мэдлийн харилцаа, хөндлөнгийн аудитын байгууллагын эрх зүйн баталгаа зэргийг голчлон багтаасан байдаг байна.

²⁵⁴ Д.Халиун “Төсвийн тогтвортой байдал ба төсвийн алдагдлыг хязгаарлах зохицуулалт: Гадаадын зарим орны туршлага” СТ-20/217

Хүснэгт 1. Үндсэн хуульдаа төсвийн эдийн засгийн зарчмуудыг тусгасан байдал

№	Зохицуулалтын төрөл	Тоо	Улс орнууд
1.	Төсөв тэнцвэртэй байх	28	Ангол, Австри, Бенин, Буркина Фасо, Кабо Верде, Чад, Коста Рика, Кот Д'Ивуар, Египет, Эль Сальвадор, Габон, ХБНГУ, Гана, Унгар, Итали, Мали, Мавритани, Марокко, Никарагуа, Нигер, Панам, Перу, Серби, Словени, Сингапур, Испани, Швейцар, Украин
2.	Төсвийг нэг жилээс дээш хугацаагаар төлөвлөж, тайлагнах боломжг	4	ХБНГУ, Швед, Грек, Австри
3.	Тодорхой байх	5	ХБНГУ, Испани, Итали, Мальта, БНСУ
4.	Төсвийн гүйцэтгэл үр ашигтай байх	5	Дани, Швед, Япон, АНУ, Австри
5.	Санхүүгийн тоон хязгаарлалт	5	Дани, Испани, Финланд, Швед, Люксембург
6.	Төсөв батлах процесс, цаглавар	5	Мальта, Ботсвана, ХБНГУ, Литва, Израил
7.	Төсвийн хяналт	3	АНУ, ХБНГУ, Итали

Төсөв тэнцвэртэй байх. Төсвийн тогтолцоог бүрдүүлэх зарчмуудын дотроос хамгийн чухал нь **төсвийн тэнцвэрт байдал** бөгөөд энэ нь ихэнх улс орнуудын Үндсэн хуулийн үндсэн зарчмуудын нэг бөгөөд түүнийг 19-р зуунаас эхлэн нэвтрүүлж эхэлсэн байдаг байна.

Дэлхийн 203 орноос 28 улсын Үндсэн хуульд тэнцвэртэй байх (төсөв алдагдалгүй байх) буюу төсвийн зарлага нь төсвийн орлого болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээр бүрэн санхүүжигдсэн байх зохицуулалтыг тусгасан байна.²⁵⁵

Тодорхой байх. Төсөвт зөвхөн орлого, зарлагын тодорхой бүрэлдэхүүнийг тусгасан байх бөгөөд хуульд зааснаас гадуурх зарцуулалтыг хамруулахгүй байх нь төсвийг хүндрүүлэх нөхцөл байдлыг хязгаарлахад чиглэсэн байна.

Төсвийн гүйцэтгэл үр ашигтай байх. Ихэнх улс орнууд Үндсэн хуульдаа төсвийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах шаардлагыг тусгасан байдаг буюу Парламентаас зөвшөөрсөн төсөл, хөтөлбөр зэрэг тодорхой зориулалтын дагуу зарцуулах шаардлага тавьдаг байна.

Санхүүгийн тоон хязгаарлалт. Үндсэн хуулийн эдийн засгийн асуудлын хүрээнд улсын өр чухал байр суурийг эзэлдэг байна.

Төсөв батлах процесс, цаглавар. Зарим улс орнуудын (Испани, Словени, Австри) Үндсэн хуульд тогтоосон хугацаанд төсвийг баталж чадаагүй бол өмнөх оны төсвийн хуулийг мөрддөг байна. Харин Мальта, Ботсвана улсуудад сангийн сайд буюу засгийн газарт 4 сарын хугацаанд төсвөөс санхүүжилт гаргах эрхийг хуулиар буюу ерөнхийлөгчийн шийдвэрээр олгодог байна. ХБНГУ, БНСУ-д төсвийг хугацаанд нь батлаагүй тохиолдолд санхүүжүүлэх тодорхой зарлагуудыг тогтоосон байдаг бол Литва, Израильд төсвийн зарлагын 1/12-ээс хэтрэхгүй байх зарлагыг санхүүжүүлдэг байна.

Төсвийн хяналт. Дийлэнх улс орны хувьд төсвийн гүйцэтгэл, хяналтын тодорхой механизмтай байна. Тухайлбал, АНУ-ын хувьд улсын мөнгөн сангийн орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, мэдээг хэвлэлд тогтмол нийтлэхээр заасан. ХБНГУ-д Холбооны сангийн сайд нь Холбооны Засгийн газрын өмнөөс бүх орлого, зарлага болон дараагийн төсвийн жилийн актив, пассивын талаарх тайлангаа, Холбооны Аудитын Шүүх нь төсвийн гүйцэтгэлд аудит хийж нийгмийн санхүүжилтийг үр ашигтай, зөв зүйтэй эрхэлснийг тодорхойлсон талаарх тайлангаа жил бүр Бундестаг болон Бундесратад тус

²⁵⁵ Үндсэн хууль-Constitute <https://www.constituteproject.org>

тус оруулдаг байна. Италид төсвийн хяналтын чиг үүрэг бүхий бие даасан байгууллага нь харьцангуй сүүлийн үед байгуулагдсан бөгөөд парламентдаа харьяалагддаг онцлогтой аж.

Төсөв, санхүүгийн бие даасан хуульгүйгээр парламент, засгийн газрын тогтоолоор зохицуулдаг улс орнууд ч бас байна. Жишээлбэл: Норвеги, Дани.

Төсөв тогтвортой байх, төсвийн алдагдлыг хязгаарлах зохицуулалтын талаарх зарим бус нутаг, улс орны туршлагыг авч үзье.

АНУ

АНУ-ын хувьд төсвийг тэнцвэртэй байлгах асуудал Үндсэн хуулиар зохицуулагдаагүй. Үндсэн хуульд төсвийг тэнцвэртэй байлгах нэмэлт өөрчлөлтийг хэд хэдэн удаа оруулахаар оролдож байсан боловч олонхын дэмжлэг аваагүй. Төсвийг тэнцвэртэй байлгах зохицуулалтын тухайд эдийн засагчид эсрэг тэсрэг байр суурьтай байдаг бөгөөд зарим нь төсөв тэнцвэртэй байх, төсвийн зарлагын дээд хэмжээг тогтоох зэрэг асуудал нь зөвхөн Үндсэн хуулиар хангалттай баталгаажна гэж үздэг байна.²⁵⁶ Ингэснээр төсвийг бодитойгоор төлөвлөх, улс төрчдийн санхүүгийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа бол зарим эдийн засгийн онолчдын хувьд төсвийг алдагдалгүй байлгах заалт нь эдийн засгийн урт хугацааны бодлогод сөрөг нөлөөтэй, энэ нь ялангуяа эдийн засгийн удаашрал, хямралын үед асуудлыг улам даамжруулах аюултай, хямралын эсрэг түргэн шуурхай арга хэмжээ авахад саад учруулна гэж үздэг байна.²⁵⁷

АНУ Төсвийн тэнцвэртэй байдал болон гэнэтийн алдагдлыг хянах тухай хуулийг²⁵⁸ 1985 онд анх баталсан. Ерөнхийлөгч Рональд Рейганы бүрэн эрхийн хугацааны эхэнд АНУ-ын улсын өр хоёр дахин нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ хуулийг зөйлшгүй батлах түлхэц болсон байна. Судлаачдын үзэж байгаагаар, Рейганы захиргааны эхний зургаан жилийн хугацаанд АНУ-ын үндэсний өр нь АНУ-ын оршин тогтносон эхний хоёр зуун жилийн хугацаанд Засгийн газрын хуримтлуулсан бодит өрийн хэмжээнээс (үүнд дэлхийн II дайнд АНУ-ын оролцоог санхүүжүүлэхтэй холбоотой өр багтсан) давсан байна.²⁵⁹ 1986 он гэхэд холбооны өр АНУ-ын ДНБ-ний 41%-д хүрсэн байна.

Хуульд төсвийн зарлагыг хоёр ангилалд хуваажээ. Үүнд:

- Засгийн газрын байгууллагуудын цалин, бусад үйл ажиллагааны зардлыг багтаасан “батлагдах” зарлага болон;
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн зардал, ажилгүйдлийн даатгал, хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх дэмжлэг, бүтээгдэхүүний шошго хөтөлбөрийн санхүүжилт зэргийг багтаасан “заавал байх ёстой” зарлага.

Батлагдах зардлыг жил бүрийн төсвийн хуваарилалтын тогтоолоор батлах бол заавал байх зардлыг хуулиар тогтоохоор заасан байна. Төсвийн орлогыг хуулиар тогтоосон дүрмээр тогтооно.

1985 оны хуулийн дагуу Холбооны төсвийн зөвшөөрөгдөх алдагдлын хэмжээг алдагдлыг эцэслэн арилгахтай уялдуулж тооцохоор заасан. Төсөв зөвшөөрөгдсөн алдагдлаас хэтэрсэн тохиолдолд төсвийг танах шаардлагатай байна.

АНУ-ын төсвийн хувьд 2000-аад оноос хойш тэнцвэрт байдал алдагдаж, алдагдлын хэмжээ тогтмол нэмэгдэж ирсэн.

²⁵⁶ АНУ-ын Үндсэн хууль 1787 <https://www.whitehouse.gov/1600/constitution>

²⁵⁷ Эдийн засгийн бодлогын хүрээлэн-Economic Policy Institute, 2016.

<http://www.epi.org/publication/economist-statement-constitutional-balanced-budget-amendment/>

²⁵⁸ Төсвийн тэнцвэртэй байдал болон гэнэтийн алдагдлыг хянах тухай хууль-Balanced Budget and Emergency Deficit Control Act of 1985 <https://www.govtrack.us/congress/bills/99/hires372>

²⁵⁹ Стиглиц Дж. Ю. Экономика государственного сектора. М., ИНФРА-М, 1997. С. 59.

Европын Холбооны Хэт их алдагдлын журам (Excessive deficit procedure)

2011 онд батлагдсан ЕХ-ны Тогтвортой байдал, өсөлтийн тухай гэрээ (ТБӨТГ) нь ЕХ-ны орнуудын төсвийн бодлогын уялдаа холбоог зохицуулах үүрэгтэй дүрэм юм. Тус дүрэм нь урьдчилан сэргийлэх болон залруулах гэсэн 2 үндсэн арга хэрэгслээс бүрдэнэ.

Урьдчилан сэргийлэх нь ЕХ-ны орнуудын төсвийн бодлогыг тогтвортой явуулахад чиглэсэн байдаг бол залруулах арга хэрэгсэл нь улс орнууд улсын өр, эсхүл төсвийн алдагдлыг хэт их гэж үзсэн тохиолдолд авах ёстойг арга хэмжээ тогтоож өгдөг байна.²⁶⁰

Хэт их алдагдлын журам (ХИАЖ) нь Европын Холбооны үйл ажиллагааны тухай гэрээний 126 дугаар зүйлээр зохицуулагддаг. Энэ нь ЕХ-ны ТБӨТГ-ийн залруулах арга хэрэгслийн үндэс суурь болдог. ЕХ-ны орнууд 2 шалгуурыг хангасан байх ёстой. Үүнд:

- тэдгээрийн төсвийн алдагдал ДНБ-ний 3 хувиас хэтрэхгүй байх;
- улсын өр (засгийн газрын өр ба төрийн байгууллагуудын өр) нь ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй байх.

ХИАЖ нь тухайн улс орныг дагаж мөрдөх залруулга арга хэмжээ, бодлогын төлөвлөгөө, мөн тэдгээрийг хэрэгжүүлэх хугацааг тогтоохыг шаарддаг. Зөвлөмжийг дагаж мөрдөөгүй тохиолдолд Евро бүсийн орнуудад торгууль ногдуулах эрхтэй байна.

Зүүн Өмнөд Азийн улс орнуудын төсвийн дүрэм

Зүүн Өмнөд Азийн улс орнуудын хувьд хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь төсөв тэнцвэртэй байх (70%) дүрэм байна.²⁶¹ Тухайн бүс нутгийн хувьд зөвхөн Сингапур Улс холбогдох дүрэм хязгаарлалтыг Үндсэн хуульдаа тусгасан байгаа бол дийлэнх орнууд нь хууль тогтоомжоор зохицуулдаг байна. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих механизм нь улс төрийн амлалт, мөн төсвийн хараат бус байгууллагын хяналтаас бүрддэг бол цөөнгүй улс оронд тодорхой зорилтоос гажсан нөхцөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээг нь зааж өгсөн байна.

Хүснэгт 4. ЗӨА-ийн улс орнуудын төсвийн дүрэм, 2018

	Төсөв тэнцвэртэй байх	Өр	Зарлага	Орлого
Бруней Даруссалам	х	х	х	х
Камбож	х	⊙	х	х
Индонез	⊙	⊙	х	х
Лаос	⊙	х	⊙	⊙
Малайз	⊙	⊙	х	х
Мьянмар	⊙	х	х	х
Филиппин	⊙	х	х	х
Сингапур	□	⊙	⊙	х
Тайланд	Х	⊙	⊙	х
Вьетнам	⊙	⊙	⊙	□
Зүүнд Өмнөд Ази /нийт/	7	6	4	2

Үндсэн хууль
 Олон улсын гэрээ
 Үндсэн хуульчилсан хууль/органик хууль
 Дотоод дүрэм/бодлого
 Улс төрийн амлалт
 бусад
 х байхгүй/мэдээлэлгүй

²⁶⁰ Хэт их алдагдлын журам-Excessive deficit procedure https://eur-lex.europa.eu/summary/glossary/excessive_deficit_procedure.html#:~:text=EU%20countries%20must%20demonstrate%20sound,not%20exceed%2060%25%20of%20GDP.

²⁶¹ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/-OECD <https://www.oecd-ilibrary.org/sites/ce240ac0-en/index.html?itemId=/content/component/ce240ac0-en>

Хүснэгт 5. Төсвийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах механизм, 2018

	Төсөв тэнцвэртэй байх	Өр	Зарлага	Орлого
Автомат залруулгын механизм		Тайланд	Тайланд	
Холбогдох нэгжүүд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй	Индонез, Лаос	Камбож, Индонез, Тайланд	Лаос, Тайланд, Вьетнам	Лаос
Хууль тогтоох байгууллагад залруулах арга хэмжээ бүхий саналыг хүргүүлэх, өргөн барих	Мьянмар, Вьетнам	Вьетнам	Тайланд, Вьетнам	Вьетнам
Байхгүй	Малайз, Филиппин, Сингапур, Австрали, Япон, БНСУ	Малайз, Сингапур, Австрали, Япон, БНСУ	Сингапур, Япон, БНСУ	Австрали, Япон, БНСУ

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХЯЗГААРЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын төсвийн хязгаарлалттай холбоотой голлох хууль нь Төсвийн Тогтвортой Байдлын тухай хууль (2010) ба Төсвийн тухай хууль (2011) юм. Эдгээр хуулиуд нь төсвийн тогтвортой байдал, төсвийн бодлого, төсвийн үйл явц, төсөөллийн ил тод байдлыг хангах, төсвийн үр дагаврын талаарх үндсэн зарчмуудыг баримталдаг.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь эрдэс баялгаар макро-эдийн засаг, татварын тогтвортой байдлыг хангах, инфляцыг хязгаарлах, төсвийн бодлогын гол зорилтуудыг дэвшүүлдэг байна.

Төсвийн тусгай шаардлагууд (төсвийн дүрэм) нь нэгдсэн төсвийн хувьд 2013 оны төсвийн жилээс, нийт өрийн хувьд 2014 оны төсвийн жилээс хэрэгжиж эхэлсэн байна. Засгийн газар анхны суурь жишиг үзүүлэлт, шалгууруудаа хангаж чадаагүй тул эдгээр тусгай шалгуурууд бүхий хууль тогтоомжоо удаа дараа өөрчилсөн байна.

Одоогийн байдлаар төсөвт дараах тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна:

- 6.1.1. *нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;*
- 6.1.2. *Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.*
- 6.1.3. *Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;*
- 6.1.4. *Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдээдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.*
- 7.2. *Энэ хуулийн 7.1.1-д заасан төсвийн тэнцлийн зорилтыг дөрвөн жил тутамд нэг удаа өөрчлөн тогтооно.*

Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тохиолдол

- 8.1. *Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг дараах тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно:*
 - 8.1.1. *тухайн жилийн ДНБ-ний²⁶² өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад “0”, эсхүл түүнээс бага, хасах хувьтай бол;*
 - 8.1.2. *гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувь ба түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол.*

2020 оны эдийн засгийн уналтын улмаас Засгийн газар Төсвийн тусгай шаардлагуудаа түр зогсоосон. Энэхүү түр түдгэлзүүлэлтийг хэзээ, хэрхэн эргэж сэргээх нь тодорхойгүй байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлогыг хуримтлуулах зорилгоор Төсвийн тогтворжуулалтын санг байгуулсан.

Эдгээр 2 хуулиуд нь ил тод байдал, хариуцлагын өндөр жишиг тогтоосон боловч эдгээр хуулиудыг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш удаа дараагийн Засгийн газрууд төсвийн тэдгээр зарчмуудыг дагаж мөрдөхгүй байсаар ирсэн тул Засгийн газрын гадаад өр төлбөр нэмэгдсэн байна.

Төсвийн дүрэм

2021 оны байдлаар төсвийн тусгай шаардлагад 12 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Макро-эдийн засаг, орлогын хэт өөдрөг төсөөлөл, ашигт малтмалын тогтворгүй орлогоос үүдэлтэй орлогын тогтворгүй эх үүсвэр болон төсвийн их хэмжээний зардлын нэмэгдлийн (ялангуяа төсвийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтад зарцуулсан зардал) улмаас Засгийн газар төсвийн дүрмүүдийг удаа дараа биелүүлж чадахгүйд хүрчээ.

Эдгээрээс зарим онцгой нэмэлт өөрчлөлтүүдийг дурдвал:

- 2015 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2015 онд тухайн жилийн ДНБ-ний 2 хувиас 5 хувь хүртэл болгож, Засгийн газрын өрийн түвшинг тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас 58.3 хувь хүртэл болгож өөрчлөв.
- 2015 онд Засгийн газрын өрийн түвшинг жил бүрийн нэрлэсэн ДНБ-ний 60 хувиас болгож өөрчлөв.
- 2016 онд Засгийн газрын өрийн түвшинг 2016 оны санхүүгийн жилд ДНБ-ний 88 хувь хүртэл болгож өөрчлөв.
- 2017 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2017 оны санхүүгийн жилд 10.4 хувь хүртэл болгож өөрчлөв.

Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн доод хэмжээ нь ДНБ-ний таван хувиас доошгүй байх тухай заалтыг 2017 онд өөрчилж Сангийн хөрөнгийг Засгийн Газар зарцуулах боломжтой болжээ.

²⁶² Эрдэс баялгийн түүхий эдийн үнийн урт хугацааны дундажаар тооцох.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт

Дүрэм 1: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Анх ТТБ-ын тухай хуулиар төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг ДНБ-ний хоёр хувиас хэтрэхгүй байхаар баталсан. 2016 оны есдүгээр сард хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2017 онд 9.9%, 2017 оны дөрөвдүгээр сард батлагдсан нэмэлт өөрчлөлтөөр дахин 10.4% болгосон. 2017 оны 4-р сард оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2023 оноос эхлэн энэ харьцаа 2%-иас хэтрэхгүй байхаар заасан.

Хүснэгт 1: Төсвийн алдагдлыг ДНБ-д харьцуулсан харьцаа (хувь)

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Хуулийн хязгаар	2.0	2.0	5.0	18.5	10.4	9.5	6.9	5.1	3.6
УИХ-аар баталсан	2.0	1.9	1.8	3.4	9.1	9.5	6.9		
Бодит байдал	1.3	4.0	5.0	15.3	6.4	0.0	1.7		

Дүрэм 2: Засгийн газрын өрийн хязгаар

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд анх Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 40 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан. Харин 2015, 2016 оны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар өрийн таазыг Засгийн газрын өр, ДНБ-ний 60 хувьд хүргэж, 2021 он хүртэл хойшлуулсан нь 2016 онд 2.6 дахин, 2017 онд 2.0 дахин, 2018 онд 1.7 дахин өссөн байна. 2019 онд 1.6 дахин өссөн байна.

Хүснэгт 2: Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь (%)

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Хуулийн хязгаар	50.0	40.0	58.3	88.0	85.0	80.0	75.0	70.0	60.0
УИХ-аар баталсан	46	40	40	55	50	40	55.3	54.3*	27.9*
Бодит байдал	53	54	52.4	78.8	72.5	58.9	31.7	34.1*	

Дүрэм 3: Төсвийн зарлагын дүрэм


Төсвийн зардлын өсөлт нь тухайн оны уул уурхайн бус салбарын ДНБ-ний өсөлт, сүүлийн 12 жилийн уул уурхайн бус салбарын ДНБ-ний дундаж өсөлтөөс хэтэрч болохгүй гэсэн байна.

2016 онд уг журам зөрчигдөж, 2017 онд бууруулж мөрдүүлэхээр УИХ-аас шийдвэрлэсэн хэдий ч төсвийн зарлага 2017 онд 5.3 хувь өсөж, гэхдээ хуульд заасан 19.5 хувиас хэтрээгүй байна.

Хүснэгт 3: Төсвийн зарлагын өсөлт (хувь)

	2013	2014	2015	2016	2017
Хуулийн хязгаар	22.4	22.8	23.1	24.3	19.5
УИХ-аар баталсан	18.0	10.0	4.7	9.7	-3.6
Бодит байдал	2.4	15.9	0.1	33.4	5.3

Монголын эдийн засгийн талаар Дэлхийн банкны хийсэн сүүлийн дүн шинжилгээнд²⁶³ дурьдахдаа, төсвийн бодлого, мөнгөний бодлого нь сүүлийн 10 жилийн хугацаанд эдийн засгийн мөчлөг дагасан шинжтэй болсоноор эдийн засгийн хэлбэлзлийг улам бүр нэмэгдүүлэх хандлагатай байна хэмээн тэмдэглэжээ.



²⁶³ “Mines and Mind” World Bank 2020

**УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН,
ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ЭСЭХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДАС БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА**

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл,
М.Солонго, Д.Халиун*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ.УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАЖ БАЙГАА
ЭСЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДСЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Нэг. Хүний эрхийн тухай ойлголт, анхаарах асуудлууд

- 1.1.Төсвийн үйл явцад баримтлах хүний эрхийн зарчмуудын талаар
- 1.2.Хүний эрхийн шалгуур үзүүлэлтийн талаар
- 1.3.Нийтлэг статистик мэдээллийг хүний эрхийн үнэлгээнд ашиглах талаар
- 1.4.Төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнөх шатанд анхаарах зүйлс

Хоёр.Гадаадын зарим орны төсвийн төслийн хүний эрхийн нийцлийн талаарх туршлага

- 2.1.Шотландын туршлага
- 2.2.Уганда Улсын туршлага

Гурав. Үндсэн эрх, эрх чөлөө болон бусад хүний эрх, эрх чөлөөний ерөнхий хязгаарлалт

ХОЁР.УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД
ЧИГЛЭГДСЭН ЭСЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДСЫН ТАЛААРХ
СУДАЛГАА

2.1 Ядуурлын гол шалтгаан

- 2.2 Ядуурлыг бууруулах арга зам
- 2.3 Вьетнам улсын туршлага
- 2.4 Гана улсын туршлага
- 2.5 Болив улсын туршлага

ГУРАВ.УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ
ЭСЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДСЫН ТАЛААРХ СУДАЛГАА

1.Онол, практикийн асуудлууд болон өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага

- 1.1.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдал
- 1.2.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиг хандлага

2.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, түүний хэрэгжилт

- 2.1.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг шалгах хуудас, шалгуур үзүүлэлт
- 2.2.Төсвийг жендэрийн мэдрэмжтэй эсэхийг шалгах хуудас

- 2.3 Украин улсын туршлага
- 2.4 Австри улсын туршлага

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ОУПХ	Олон улсын парламентын холбоо
НҮБХЭДКГ	НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ЖМТ	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүний эрхийн үнэлгээний гурван төлөв
Хүснэгт 2. Төсвийг хүний эрхийн хэм хэмжээтэй уялдуулан үнэлэх нь
Хүснэгт 3. Төсвийн орлого бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах шалгуур үзүүлэлтийн жишээ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Шотландын хүний эрхэд суурилсан төсвийн үйл явц
Зураг 2. Шотландын төсвийн үйл явцын цаглабар



УДИРТГАЛ

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн 597 дугаар захирамжаар баталсан “Тамгын газрын 2021 оны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” хүрээнд гүйцэтгэх ажлын жагсаалтын 2.16-т заасан арга хэмжээ болох “Улсын төсвийн тухай хуулийн төсөл хүний эрхэд суурилсан, ядуурлыг бууруулсан, жендэрийн мэдрэмжтэй эсэх шалгуур үзүүлэлтүүдийг шалгах хуудсын талаарх судалгаа” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэн болон УИХ-ын Тамгын газрын ХШҮГ-ын Төсвийн хяналт, шалгалтын хэлсийн ажилтнуудаас бүрдсэн хамтарсан судалгааны баг гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

Улсын төсвийн тухай хуулийн төсөл хүний эрхэд суурилсан, ядуурлыг бууруулсан, жендэрийн мэдрэмжтэй эсэх шалгуур үзүүлэлтийн талаарх олон улсын туршлагыг онол-арга зүйн үндэслэл, олон улс болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудаас гаргасан тайлан мэдээлэл, гадаадын зарим орны хууль, эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судлахад чиглэгдсэн.

Түлхүүр үг: *Төсвийн хяналт, хүний эрхэд суурилсан төсөв, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, ядуурлыг бууруулах*

Keywords: *Budgetary scrutiny, human rights budgeting, gender sensitive budgeting, Poverty reduction*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. Ардчилал, зах зээлийн нийгэмд хүний эрхийг хангах үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, үр нөлөөг сайжруулахад төсвийн төсөвлөлт чухал үүрэг рольтой. Парламентын зүгээс улсын төсвийг батлах, улс орныхоо хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо хүний эрхийг хангахад хангалттай хөрөнгө төсөвлөсөн эсэхэд юуны өмнө анхаарах ёстой. Мөн түүнчлэн Засгийн газрын төсвийн зарцуулалтад хяналт тавих эрхийнхээ хүрээнд шаардлагатай гэж үзвэл хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хангалтгүй ажилласан Засгийн газарт хариуцлага тооцох механизмыг ашиглаж болдог. Ингэхдээ хүний эрхийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах нь баримталж буй бодлого болон бодит байдал, хэрэгжилтийн зөрүү, сорилтуудын талаар илүү сайн ойлголт өгч, төсвийн мөчлөг дахь оролцогч талуудын оролцоо, ил тод байдлыг нэмэгдүүлж, илүү хариуцлагатай болгох ач холбогдолтой.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт нь улс орнууд иргэдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргүүдийн үндэс суурийг бүрдүүлж байна. Түүнчлэн 2016 онд Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ)-ноос парламентч нарт зориулан гаргасан Хүний эрхийн гарын авлага (IPU, 2016)-д тусгасан зөвлөмжүүдийг хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшинд ашиглаж байна.

Олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг хариуцлагыг холбогдох гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон орнууд *дэвшилттэйгээр хангах, боломжит хамгийн их нөөцийг дайчлах, ялгаварлан гадуурхахгүй тэгш байх* зарчмууд дээр үндэслэн хэрэгжүүлэх ба хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэсэн төсөв нь төсвийн аливаа сонголтыг *ил тод, хариуцлагатай, ялгаварлан гадуурхахгүй, оролцоонд тулгуурласан* байхыг шаарддаг байна.

Бүс нутгийн хэмжээнд мөрдөж буй зарим удирдамж, заавар (Төсвийн бодлого дахь хүний эрхийн зарчмууд)-т хүний эрхэд суурилсан төсөв нь дээрх гурван зарчимд нийцсэн

байхаас гадна төсвийн бодлогын үндсэн зорилго нь хүний эрхийг хангахад чиглэсэн байх, төсвийн бодлого нь байгаль орчинд ээлтэй байх, улс орнуудын төсвийн бодлого нь эдийн засгийн хямралын үед ч эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчны эрхийг дордуулахгүй байхаар тус тус заасан байна.

Судалгаанд хүний эрхэд суурилсан төсөвлөлтийн сайн туршлага хуримтлуулсан Шотланд болон Уганда улсын туршлагыг судалсан болно. Их Британийн бүрдэл улс болох Шотландын хувьд төсвөөр дамжуулан хүний эрхийг хангах асуудалд ихээхэн анхаарч, хүний эрхэд суурилсан төсвийн үйл явцыг хэрэгжүүлсэн байна. Ингэхдээ ил тод байдал, оролцоог хангах, хариуцлагатай болгоход чиглэсэн төсвийн үйл явцын индикаторуудыг боловсруулан ашиглаж байна. Уганда Улсын хувьд парламентаар хэлэлцэж буй хуулийн төсөл, стратеги, бодлогын баримт бичиг, төсөв болон Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээний хүний эрхийн үр дагаврын талаар парламентад хурдан шуурхай мэдээлэх зорилго бүхий шалгах хуудсыг боловсруулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

Хоёр. Улс орнууд төсвийн төсөл ядуурлыг бууруулахад чиглэгдсэн эсэхийг хянан тогтоохдоо бодлого, хөтөлбөрүүд, хууль эрх зүйн орчны чанар, оролцоо, засаглалын чадвар, арга зүй, бүтэц зохион байгуулалт зэргийг чухалчлан авч үздэг байна. Түүнчлэн салбарын хөгжлийн бодлого, бүс нутгийн хөгжил, хяналт, шинжилгээ үнэлгээний тогтолцоо, ядуурлыг бууруулахад чиглэсэн зардал, түүний динамик өөрчлөлт зэргийг харгалздаг болох нь тодорхой байна.

Мөн нийгмийн халамжийн бодлого, халамжаас хамааралтай хүмүүсийн тоо, ядуурлын чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээний чанар, зөвлөлдөх механизмыг ашигласан байдал, салбарын ажиллагсдын онцлог, ядуу иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын ядуурлыг бууруулах чиглэлээр төрийн бодлого боловсруулах үйл явцад оролцох оролцоо, төрийн бодлогын хамтын үр нөлөө, харилцан уялдаа холбоо зэргийг харгалзан үздэг байна.

Төсвийн төслийн ядуурлыг бууруулж чадах эсэхэд үнэлгээ өгөх арга зүй талаас нь авч үзвэл, улс орнууд ядууралд нөлөөлөх төсвийн орлого, зардлын элементүүдийн нөлөөллийн шинжилгээ, ядуурлыг бууруулах чиглэлээр гаргасан зардал, түүний төсвийн нийт зардалд эзлэх хувь зэрэг үзүүлэлтийг ашигладаг болох нь харагдаж байна.

Улс орнуудын ядуурлыг бууруулах зорилтын хэрэгжилт, төсвийн төсөвлөлт дэх ядуурлыг бууруулахад чиглэсэн зорилт, арга хэмжээний үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлттэй холбоотой туршлагыг судлах хүрээнд Вьетнам улс, Гана болон Болив улсын туршлагыг судалгаанд дэлгэрүүлэн авч үзлээ. Судалгаанд авагдсан улс орнууд ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээг төсөвт тусгах, төсөвт тусгасан эсэхийг үнэлэхдээ юуны өмнө энэ чиглэлээр боловсруулж гаргасан бодлогын баримт бичгийг харгалзан үздэг байна. Түүнчлэн салбаруудын бодлогын уялдаа холбоог ядууралд нөлөөлөгч хүчин зүйлстэй холбож, нийгмийн нэгдмэл системийн хүрээнд төсвийн төслийн ядуурлыг бууруулах зорилт, арга хэмжээг тусгасан байдлын зэрэгт үнэлэлт, дүгнэлт өгдөг болох нь харагдлаа.

Гурав. Парламентын зүгээс жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг (ЖМТ) хийхдээ төсвийн хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийх, парламентын гишүүд болон санхүүгийн мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлэх, эмэгтэйчүүдийн болон иргэний нийгмийн зөвшилцлийн байгууллагуудын жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийх арга зүйг сайжруулахад голлон анхаарч байна.

Улс орнуудын жишигт жендэрийн мэдрэмжтэй төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хууль, эрх зүйн орчныг тодорхойлж, олон нийтийн санаа бодлыг тусгасан, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эсэхийг анхаарч, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилладаг байна.

Манай улсын хувьд төрийн захиргааны байгууллагуудыг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг боловсруулах арга зүйн удирдамжтай болгох, түүнийг мөрдүүлэх, төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн шинэчлэл хийгдэхгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жендэрийн мэдрэмжтэй төсвийн тооцоолол, тайлагналын маягыг агуулсан арга зүйн жишиг удирдамж, зааврыг өөрийн орны онцлог, бусад орнуудын тэргүүлэх туршлагад нийцүүлэн боловсруулж салбарын яамдыг удирдлагаар ханган, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийг нягталж, төсвийн төсөл жендэрийн тэгш бус байдлыг бууруулах ач холбогдол, үр нөлөөтэй байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж ажилласнаар дээрх асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Улс орнуудын туршлага төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, төсвийг хэрэгжүүлэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих бүхий л үе шатанд жендэрийн тэгш байдлын шалгуур үзүүлэлтийг харгалзах, энэ чиглэлээр урьд өмнөх жилүүдийн төсвийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээний үр дүн, өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хангаж ажиллах нь чухал болохыг харуулж байна.

Судалгаанд жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг боловсруулах, үнэлэх асуудлын хүрээнд Украин улс, Австри улсын туршлагыг дэлгэрүүлэн авч үзсэн болно. Украин улс жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах үйл явцад үндсэн хууль, төсвийн тухай ерөнхий хуулийн зохицуулалтын хүрээнд дэмжлэг үзүүлдэг бол Австри улс төсөв боловсруулахад жендэрийн тэгш байдлыг хангах тодорхой зарчмуудыг үндсэн хуулиндаа тусгаж өгсөн байна.

/Мэдээллийн дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү/

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ.УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДСЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон олон улсын хүний эрхийн гэрээнүүд нь хүний эрхийг бүх хүмүүст ямар ч ялгалгүй эдлүүлэх баталгаа болдог.

Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу улс орнууд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах ёстой бөгөөд ингэхийн тулд шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх үүргийг хүлээж байдаг. Засгийн газрууд хүний эрхэд суурилсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвөөр дамжуулан хүний эрхийн баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлж байдаг. Улсын төсөв нь улс орны эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хамгийн чухал баримт бичиг бөгөөд Засгийн газрууд хүний эрхийг бодитойгоор хангаж чадаж байгаа эсэхийг үнэлэх нэн чухал арга хэрэгсэл болох юм.

“Don’t tell me what you value: show me your budget and I will tell you what you value”

US President Joe Biden

“Надад өөрийн үнэт зүйлсийн талаар бүү хэл. Төсвөө надад харуул: би танд таны үнэт зүйлс юу болохыг хэлэх болно.”

АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден

2016 онд Олон улсын парламентын холбоо (ОУПХ)-ноос гаргасан Парламентч нарт зориулсан Хүний эрхийн гарын авлага (IPU, 2016)-д: “Парламентын бүхий л үйл ажиллагаа буюу хууль тогтоох, улсын төсвийг батлах, гүйцэтгэх засаглалд хяналт тавих зэрэг нь хүний улс төр, иргэн, эдийн засаг, нийгэм болон соёлын эрхийг хамарч, үүгээрээ хүмүүсийн эдгээр эрхээ эдлэхэд шууд нөлөөлж байдаг. Парламент нь ард түмнийг төлөөлж, төрийн үйл хэрэгт оролцдог төрийн дээд байгууллагын хувьд хүний эрхийн манаач мөн юм. Парламентын бүхий л үйл ажиллагаанд хүний эрхийн асуудалд хэр их тусгагдаж байгаагаас улс орны амгалан тайван байдал, нийгмийн эв найрамдал, хөгжил ихээхэн шалтгаалдаг тул парламент энэхүү үүргээ ямагт ухамсарлаж байх ёстой.” гэжээ.

Нэг. Хүний эрхийн тухай ойлголт, анхаарах асуудлууд

1.1.Төсвийн үйл явцад баримтлах хүний эрхийн зарчмуудын талаар

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт нь улс орнууд иргэдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргүүдийн үндэс суурийг бүрдүүлж байна. Үүгээр зохистой амьдралын түвшин, эрүүл мэнд, боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх эрхээр хангагдахаар заасан нь төсвийн бодлого, үйл явцад маш тодорхой үр дагавар бий болгож байдаг. Эдгээр үүрэг, хариуцлагыг дээрх олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон орнууд дараах байдлаар хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ. (Renzi & Lakin, 2019) Үүнд:

1. **Дэвшилттэйгээр хангах (Progressive realization):** улс орнууд зохих хязгаарлалтын хүрээнд урьдчилан тооцоолсон, тодорхой, зорилтот бодлогоор хүн бүрийн хүний эрхийг хангахыг тасралтгүй сайжруулахыг эрмэлзэнэ. Энэ нь нөөц хуваарилалт, зарцуулалт, үйлчилгээ үзүүлэх зэрэгт чухал үр дагаврыг үүсгэнэ.
2. **Боломжит хамгийн их нөөц (Maximum available resources):** Улс орнууд хүний эрхийн үүргээ биелүүлэхдээ аль болох их нөөц бололцоог дайчилна. Энэ нь дан

ганц татвар ногдуулах болон хуваарилах асуудал бус хуваарилагдсан хөрөнгө зарцуулагдахгүй байх, төсвийн алдагдал болон санхүүжилтийн сонголтуудад мөн хамаарах юм.

3. **Ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх (Non-discrimination and equality):** Хүний эрхийн үүргээ биелүүлэхдээ улс орнууд арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг зэргийг үндэслэн ялгаварлан гадуурхаж болохгүй. Энэ нь төсвийн хуваарилалт, зарцуулалтад үр дагаврыг үүсгэх ба төрөөс эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн байдлыг дээрдүүлэхэд шаардсан бодлого, санаачилгуудыг хэрэгжүүлэхийг шаардана.

Эдгээр үүргийг одоо хэрэгжүүлж буй бодлогыг үнэлэх, дүгнэлт өгөх төдийгүй шударга ёсонд илүү нийцсэн хувилбар боловсруулж, санал болгох, Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийн шаардлагуудыг хүндэтгэж, хангах хууль зүйн механизмыг ашиглахад хэрэглэж болох юм.

Улсын төсөв ба хүний эрх

“Хүний бүхий л эрх нь төсөвтэй холбоотой буюу төсвийн үр дагаврыг дагуулж болно.

Энэ хэрээр улсын төсөв нь ямар эрх, хэний төлөө хэрэгжихийг шууд тодорхойлно. Төсвийн шинжилгээ нь төрийн бодлого болон үйл ажиллагааны хоорондын зөрүүг тогтоох, хүний эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх, бодлогын альтернатив сонголт, хувилбаруудыг бий болгож, түүнийг эрэмбэлэх, эцэст нь үүрэг хүлээгчдийн үүргээ биелүүлэх хариуцлагыг бэхжүүлэх чухал хэрэгсэл юм.

Хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэсэн төсөв нь төсвийн аливаа сонголтыг **ил тод, хариуцлагатай, ялгаварлан гадуурхахгүй, оролцоонд тулгуурлан** хийхийг шаарддаг. Эдгээр зарчмуудыг төсвийн төслийг өргөн хүрээний хэлэлцүүлгийн үндсэн дээр боловсруулж, баталсан үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах үе шатаас эхлээд парламентаар хэлэлцэж, батлах зэрэг төсвийн бүх шатанд баримтлах ёстой.

Харин парламент нь тодорхой хэмжээ, хүрээнд төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй байхаас гадна төсвийн төсөлд шинжилгээ хийх хангалттай хугацаагаар хангагдаж, хэрэгжитэлд хяналт тавих эрхтэй байх ёстой.”

Эх сурвалж: Human Rights in Budget Monitoring, Analysis and Advocacy, Training Guide, Geneva, OHCHR, 2010.

Бус нутгийн хэмжээнд: Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын (IACHR) санаачилгаар 2021 онд “Төсвийн бодлого дахь хүний эрхийн зарчмууд” (The Principles for Human Rights in Fiscal Policy, 2021)-ыг удирдамжийг улс орнуудыг хүний эрхийг дээдэлсэн төсвийн бодлого боловсруулах, төсвийн үйл явц дахь төрийн болон төрийн бус бусад оролцогчид (хувийн хэвшлийн ААН, байгууллагууд, ИНБ, иргэний хөдөлгөөн, үндэсний болон бүс нутгийн мониторингийн байгууллагууд г.м.)-ын хариуцлагыг дээшлүүлэх зорилготойгоор боловсруулсан байна.

Тус удирдамжид Төсвийн бодлого дахь хүний эрхийг хангахад чиглэсэн 15 зарчмыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Хүний эрхийг хангах нь төсвийн бодлогын үндсэн зорилго байна.
2. Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах болон хангах үүргүүд нь төрийн идэвхтэй үйл ажиллагааг шаардах бөгөөд төсвийн бодлоготой холбоотойгоор төрийн бүрэн эрхэд хязгаарлалт тогтооно.
3. Улс орнуудын төсвийн бодлого нийгмийн шударга ёсыг хангахад чиглэсэн байна.
4. Улс орнуудын төсвийн бодлого нь байгаль орчинд ээлтэй байна.

5. Улс орнууд төсвийн бодлогоор дамжуулан бүтцийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, тэгш байдлыг хөхиүлэн дэмжинэ. Ийм бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ эрх нь хязгаарлагдаж буй төлөвийн шалгуур үзүүлэлтийг ашиглаж, шаардлагатай бол тэдгээрийн байдлыг дээрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
6. Улс орнууд төсвийн бодлогоороо дамжуулан сектор дамнасан хандлага (*intersectoral approach*)-ыг ашиглан жендэрийн тэгш байдлыг хангана.
7. Төсвийн бодлого нь ил тод, оролцоог хангасан болон хариуцлагатай байна. Хүмүүс төсвийн мэдээлэл авах эрхтэй байна.
8. Улс орнууд тогтвортой төсвийн бодлогын хүрээнд хүний эрхийг хангахад шаардлагатай төсөв, санхүүгийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
9. Улс орнууд төсвийн бодлогодоо нэн тэргүүний ач холбогдол болгон эдийн засаг, нийгэм, соёл болон байгаль орчны эрхийн хамгийн бага суурь баталгааг хангах үүргийг хүлээнэ.
10. Улс орнууд эдийн засаг, нийгэм, соёл болон хүрээлэн буй орчны эрхийг дэвшилттэйгээр бүрэн хэрэгжүүлэхэд боломжит нөөц бололцоогоо дээд зэргээр дайчилна.
11. Улс орнуудын төсвийн бодлого нь эдийн засаг, нийгэм, соёл болон байгаль орчны эрхийг дордуулахгүй байхад анхаарна, энэ нь эдийн засгийн хямралын үед мөн хамаарна.
12. Улс орнууд төсвийн бодлогын тодорхой арга хэрэгслээр дамжуулан зарим үйлдлийг урамшуулах, эсхүл хориглох, мөн гадаад хүчин зүйлсийг залруулах, хүний эрхийн баталгааг хангахад төсвийн бодлогын нэн тэргүүний арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй, зарим тохиолдолд үүрэгтэй байна.
13. Улс орнууд болон тэдний элсэн орсон олон улсын байгууллагууд төсвийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Тэдгээр нь хүний эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд засаглалын боломж, нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
14. ААН, байгууллага, тэдгээрийн зуучлагчид зэрэг төрийн бус оролцогчид төсвийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүний эрхийг хангах хариуцлагыг хүлээнэ.
15. Улс орнууд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ёстой бөгөөд төсвийн бодлоготой холбоотойгоор хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд иргэний, улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчны эрх хөндөгдсөнөөс үл хамааран зохих нөхөн олговор олгоно.

1.2. Хүний эрхийн шалгуур үзүүлэлтийн талаар

2012 онд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (НҮБХЭДКГ)-аас гаргасан “Хүний эрхийн индикаторууд: Хэмжих, хэрэгжүүлэх удирдамж” (UN, OHCHR, 2012)-д: дурдсанаар сүүлийн жилүүдэд үндэсний болон олон улсын хүний эрхийн төлөө тэмцэгчид, бодлого боловсруулагчид зэрэг янз бүрийн оролцогч дунд хүний эрхийг хэрэгжүүлэх, хангахад хүний эрхийн үнэлгээнд ашиглах үзүүлэлтүүдийг боловсруулах шаардлага ихэссэн байна.

Хүний эрхийг хангагдаж байгаа эсэхийг хэмжих санаа нь нэрт сэтгэгч, эдийн засагч Ж.К.Гэлбрейтийн “хэрэв тоолохгүй бол анзаарагдахгүй” гэсэн үзэл санаан дээр суурилсан байдаг, нөгөө талаар “хэмждэг бол хэрэгждэг” гэх санааг үүнд мөн дурдаж болох юм. Нийгмийн эрэлтэт зарим зорилгыг биелүүлэх тулд тэдгээр зорилгод нийцсэн зорилтуудыг тодорхойлж, шаардлагатай арга хэрэгслийг дайчилж, мөн эдгээр арга хэрэгслийг хүссэн үр дүн болгон хувиргадаг бодлого, механизмыг тодорхойлох хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь энэ бодлын гол цөм юм. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдалд

дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангах, ахиц дэвшилд хяналт тавих, гүйцэтгэл, ерөнхий үр дүнг хэмжихэд статистик, шалгуур үзүүлэлт, индексийн хэлбэр бүхий мэдээллийн хэрэгцээ шаардлага өндөр байгаа юм.

Шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах нь харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, мэдээллийг үр дүнтэй бүртгэхэд тусалдаг бөгөөд асуудлыг тодорхойлох, үр дүнг хянах, хариу арга хэмжээ авах зэргийг хялбаршуулдаг. Сайн тодорхойлогдсон шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарлалт, “trade off” буюу солилцоо/гацааны талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулж, нийгмийн эн тэргүүнд тавих зүйлсийн талаар илүү өргөн хүрээтэй зөвшилцөл бий болгоход тусалдаг. Хамгийн чухал нь зөв ашигласан тохиолдолд статистик мэдээлэл нь нийгмийн хөгжил дэвшлийг цогцлооход хариуцлагатай, ил тод соёлыг бий болгох хүчирхэг хэрэгсэл болж чадах юм.

Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой зорилгын шаардлагуудад тохируулж, нийцүүлэх шаардлагатай. Шалгуур үзүүлэлтүүдийг илүү үр дүнтэй, үр ашигтайгаар ашиглахын тулд мэдээллийг цуглуулах, боловсруулах арга зүй нь зөв, зохистой, үзэл баримтлалын хувьд зөв, эмпирикээр нотолсон байх ёстой.

Хүний эрхийг хангуулах үүднээс төсвийн үйл явцыг шалгах нь

- Төсөв (хөтөлбөр)-ийг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоог хангах тогтолцоо бий эсэх?
- Төсийн баримт бичгийг олон нийтэд нээлттэй байдлаар мэдээлдэг үү, эсхүл ямарваа нэгэн хүсэлт гаргах шаардлагатай юу?
- Төсвийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх хугацаа, хуваарийг хууль тогтоомжид тусгагдсан уу?
- Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хууль тогтоох байгууллага, хараат бус байгууллагууд хяналт тавьдаг уу?
- Төсвийн төсөл боловсруулах журмыг оролцогч талуудын оролцоо, ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор тодорхой давтамжтайгаар хянагддаг, шинэчлэгддэг үү?
- Зорилтод хүн амын бүлгүүдэд зориулсан төсвийн хуваарилалт (салбараар, эсхүл ангиллаар) хөтөлбөрийн хэдэн хувийг эзэлдэг вэ?
- Ямар салбаруудад бодит зарцуулалт болон төсөвлөгдсөн хуваарилалтууд зөрүүтэй байдаг вэ?

Иргэний болон улс төрийн дараах хоёр эрхийг хөхиүлэн дэмжиж, хамгаалснаар төсвийн үйл явцыг хүний эрхийн баталгааг хангахад чиглүүлэхэд чухал хувь нэмэртэй юм. Эдгээр нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19.2-оор баталгаажсан мэдээлэл авах эрх, мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлээр баталгаажсан төрийн үйл хэрэгт оролцох эрх юм.

Үүнэтэй нэгэн адил, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1986 онд баталсан НҮБ-ын Хөгжих эрхийн тунхаглалын 2 дугаар зүйлд “Улс орнууд нь нийт хүн ам, хувь хүний сайн сайхан байдлыг байнга дээшлүүлэхэд чиглэсэн үндэсний хөгжлийн зохистой бодлого боловсруулах эрх, үүргийг хүлээнэ, үүнийг хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагаа, чөлөөт болон утга учир бүхий оролцооны үндсэн дээр явуулах бөгөөд үр дүнд бий болсон хөрөнгийг шударгаар хуваарилна”, мөн 8 дугаар зүйлд “Улс орнууд хөгжлийн чухал хүчин зүйл болон хүний бүх эрхийг хангахад бүх хүрээнд олон нийтийн оролцоог хөхиүлэн дэмжинэ” гэж тус тус заажээ. Эдгээрийг улсын, орон нутгийн төсвийн үйл явцад санаж байх нь чухал юм.

Практикт, төсвийн үйл явцад оролцох оролцооны олон төрлүүд байдаг. Тухайлбал, төсвийн шийдвэр гаргах процесст шууд оролцох, энэ нь тодорхой хэмжээнээс давсан төсвийн зарцуулалтыг ард нийтийн санал асуулга буюу референдумаар шийдвэрлэх, эсхүл ивэхгүй/пассив оролцоо буюу иргэдэд юу болох гэж байгаа талаар, эсхүл төсвийн шийдвэрийн талаар мэдээлэх зэрэг юм.

1.3. Нийтлэг статистик мэдээллийг хүний эрхийн үнэлгээнд ашиглах талаар

Нийгэм, эдийн засгийн статистик тоо мэдээг хүний эрхийг хангах, хамгаалахад ашиглах нь байгаа статистик тоо мэдээллийг ангилал, улсын дунджаас авахуулаад хүний эрхийн нийтлэг шинж чанараар холбогдсон хамгийн жижиг бүлгүүд, эсхүл хувь хүний түвшинд авч үзэхийг шаардана. Гэвч тийм төрлийн мэдээлэл цуглуулах, нэгтгэх, ангилах нь тэр болгон боломжгүй байдаг. Чухамдаа, дээр дурдсан (UN, OHCHR, 2012) дурдсан хүний эрхийн үзүүлэлтүүдийн хүрээ нь хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж гүйцэтгэхэд шаардлагатай нэн чухал мэдээллийг тодорхойлоход ихээхэн хувь нэмэртэй юм. Нөгөөтэйгүүр, холбогдох шалгуур үзүүлэлтээр тоо мэдээлэл олдохгүй байх явдал нь өөрөө хүний эрхийг хангах, хамгаалах үүрэг хүлээгч хүний эрхийн үүргээ хангалттай биелүүлээгүй, хүсэл эрмэлзэл дутмаг байгаагийн үзүүлэлт болох юм.

Холбогдох шалгуур үзүүлэлтүүд бэлэн байгаа тохиолдолд хэмжүүрийн гурван төлөвийг нэгтгэн үр дүн, үйл явцын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан дүн шинжилгээ, үнэлгээг системтэйгээр хийж болох юм. “Дундаж” төлөв нь улс орны ерөнхий нөхцөл байдал, хөгжил дэвшлийг, “Хязгаарлагдсан байдал/Deprivation”-ын төлөв нь хамгийн ихээр эрх нь хязгаарлагдаж буй бүлгүүдийн, “Тэгш бус байдал”-ын төлөв нь хүн амын бүлэг, эсхүл бүс нутгуудын хоорон дахь тэгш бус байдлыг багасгахад гарч буй ахиц дэвшлийг тус тус харуулах юм.

Хүснэгт 1. Хүний эрхийн үнэлгээний гурван төлөв

Цаг хугацааны давтамж	Дундаж төлөв	Хязгаарлагдсан байдлын төлөв	Тэгш бус байдлын төлөв
Эхний үзүүлэлт	Улсын дундаж үзүүлэлт	Хамгийн ихээр эрх нь хязгаарлагдаж буй бүлэг: <ul style="list-style-type: none"> • хүйсээр; • орлогын түвшингээр; • бүс нутгаар; • ястан, угсаатнаар; • боловсролын түвшингээр гм. 	Дараах бүлгүүдийн хоорондын ялгаа: <ul style="list-style-type: none"> • эрэгтэй, эмэгтэй; • орлогын түвшин хамгийн их, хамгийн бага; • хамгийн сайн, хамгийн муу үзүүлэлттэй бүс нутаг; • уугуул хүн ам, шилжин суурьшсан хүн ам гм.
Хоёр болон түүнээс дээших үзүүлэлт	Улсын дундаж үзүүлэлт хэрхэн өөрчлөгдсөн бэ?	Эрх нь хамгийн ихээр хязгаарлагдсан бүлгийн нөхцөл байдал хэрхэн сайжирсан бэ?	Хүн амын бүлгүүдийн хоорондын ялгаа хэрхэн өөрчлөгдсөн бэ? Нэмэгдсэн үү, буурсан уу?

Эх сурвалж: Human rights indicators: A Guide to Measurement and Implementation, UN, OHCHR. (2012)

1.4. Төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнөх шатанд анхаарах зүйлс

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (НҮБХЭДКГ)-аас 2017 онд гаргасан “Засгийн газрын төсвөөр дамжуулан хүний эрхийг хангах нь” гарын авлага (OHCHR, 2017)-д улсын төсвөөр дамжуулан хүний эрхийг хангахтай холбоотой суурь ойлголтууд, төсвийг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих явцад хүний эрхийг хангах сайн туршлага, зөвлөмжүүдийг тусгасан байна. Судалгаанд холбогдох зөвлөмжүүдийг тоймлон оруулсан болно.

Төсвийн агуулгыг тодорхойлох/боловсруулахад хүний эрхийн үүргийн талаар анхаарч үзэх гол зүйлүүд

- Хүний эрхийн олон улсын гэрээнд тусгагдсан хүний эрхтэй холбоотой үүргүүд нь Засгийн газар орлогыг хэрхэн бүрдүүлэх, хөрөнгийг хэрхэн хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлд хэрхэн хяналт тавих, үнэлэх, аудит хийх зэрэгт нөлөөлөх хэм хэмжээг тусгасан байдаг.
- Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцууд нь негатив болон позитив²⁶⁴ үүргийг бий болгож байдаг. Позитив үүргүүд нь ихэвчлэн санхүүжилт шаарддаг.
- Хүний эрхийн гэрээ нь гэрээнд заасан эрх буюу эрхийн зарим нэг хэсгийг нэн даруй, эсхүл бүрэн хэрэгжүүлэхийг шаардаж байгаа бол төсвийн хязгаарлалт нь энэхүү үүргийг биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.
- Засгийн газар нэгдэн орсон гэрээнд заасан хүний бүх эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээг яаралтай авах үүрэгтэй. Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тухайн эрхийг хэрэгжүүлэхэд тохиромжтой, хангалттай, үр дүнтэй байх ёстой. Эдгээр хэм хэмжээнүүд нь төсөвт нөлөө үзүүлдэг.
- Төсвийн хязгаарлалт нь гэрээний эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүйг гэрээгээр хүлээн зөвшөөрсөн тохиолдолд оролцогч улсууд боломжит нөөц бололцоогоо ашиглан дээрх эрхийг шат дараатайгаар хэрэгжүүлэх ёстой. Эдгээр хэм хэмжээ нь төсвийн төслийг хэрхэн боловсруулах, хэрэгжүүлэх, аудит хийх зэрэгт нөлөө үзүүлдэг.
- Ялгаварлан гадуурхахгүй байх үүрэг нь хүний эрхийн бүх олон улсын гэрээ, конвенцид нийтлэг байдаг бөгөөд Засгийн газрууд төсвөөр дамжуулан аливаа нэг бүлэг, бүлгүүдийг ялгаварлан гадуурхахгүй байхыг дээд зэргээр анхаарах ёстой.

Төсвийн үйл явц дахь хүний эрхийн үүргийн үүргийн талаар анхаарч үзэх гол зүйлүүд

- Засгийн газар төсвийн үйл явцын бүхий л үе шатанд иргэний нийгэм, олон нийтийн оролцоог хангах зохистой механизм, үйл явцыг бий болгох ёстой.
- Төсвийн гол баримт бичгүүдийг цаг тухайд нь олон нийтэд ил тод болгох, ингэснээр иргэний нийгэм, олон нийт энэ үйл явцад ашигтай хувь нэмэр оруулахад шаардлагатай мэдээллээр хангагдана.
- Төсвийн гол мэдээллийг энгийн иргэдэд ойлгомжтой хэлбэрт оруулж гаргах.

Засгийн газрын орлогын талаар анхаарч үзэх гол зүйлүүд

- Засгийн газраас төсвийн орлогоо хэрхэн нэмэгдүүлэх талаар гаргадаг шийдвэр нь хүмүүсийн эрхээ эдлэхэд ихээхэн нөлөөлдөг. Хүний эрхийг зөвхөн Засгийн газар төсвийг хэрхэн хуваарилж, зарцуулснаар бус, харин

²⁶⁴ "Негатив" болон "позитив" үүргийн ялгаа. Хүний эрхийн зарим үүрэг нь хүний одоогийнэдэлж буй эрхэд төрөөс саад болохгүй байх үүрэг гэж тодорхойлсон байдаг. Эдгээрийг "негатив" үүрэг гэж үзэж болно. Улс орнууд гол төлөв хүний эрх, эрх чөлөөнд харшлах аливаашийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахаас татгалзах, бусад хэлбэрээр саад учруулахгүй байснаар хүний эрхийг хүндэтгэж байдаг. Хүний эрхийн бусад үүргийг "позитив үүрэг" гэж тодорхойлж болно. Энэ нь төрөөс хүний эрхийн баталгаа бүрдүүлэхийг шаарддаг. Улс орнууд тодорхой арга хэмжээ авснаар эдгээр үүргээ биелүүлдэг бөгөөд төрөөс эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай институци, бараа, үйлчилгээ үзүүлэхгүй бол хүн эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгаа нь позитив үүрэг юм.

орлогоо нэмэгдүүлэх талаар хийдэг сонголтоор дамжуулан мөн хэрэгжүүлдэг.

- Засгийн газар нь эрхүүдийг бүрэн дүүрэн, бодитоор хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгө хуваарилах ёстой бөгөөд орлогыг нэмэгдүүлэхдээ гагцхүү эдийн засгийн ач холбогдлыг харгалзах бус, орлогыг үр дүнтэй, үр ашигтайгаар бүрдүүлэхэд анхаарах ёстой юм. Тухайлбал, татвараас зайлсхийх явдлыг зогсооход анхаарах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдийн засгийн тооцоо, дүн шинжилгээнд үндэслэн эдлүүлэх гм.
- Ялгаварлан гадуурхахгүй байх гэдэг нь Засгийн газрын орлого нэмэгдүүлэх арга хэмжээний нөлөөлөл нь тодорхой бүлэг, ялангуяа бага орлоготой хүмүүст сөрөг байдлаар (пропорциональ бусаар) нөлөө үзүүлэх ёсгүй гэсэн үг юм. Засгийн газар орлогоо нэмэгдүүлэх арга хэмжээний өөр өөр бүлгүүдэд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэхийн тулд холбогдох тооцоо судалгааг тогтмол хийж байх ёстой. Засгийн газраас татварын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг эрэлхийлэхэд прогрессив татвар (татварын суурь өсөх тутам татвар ногдох хувь хэмжээ нь өсөх татвар)-ыг нэвтрүүлэх, харин хэрэглэгчийн хураамж зэрэг регрессив татвар (татварын суурь өсөх тутам татвар ногдох хувь хэмжээ нь буурах татвар) нь бага орлоготой хүмүүст ихээр нөлөөлдөг гэдгийг анхаарах ёстой.

Төсвийн хуваарилалтын талаар анхаарч үзэх гол зүйлүүд

- Засгийн газрын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө нь хүний эрхийн баталгааг хангахтай холбоотойгоор хүлээсэн үүргүүдийг тусгаж, хүний эрхийг хамгийн сайн хангахуйц байдлаар боловсруулагдаж, хэрэгжих ёстой. Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэг гол алхам бол дээрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрүүдийг нарийвчилсан, бодитой тооцоо, дүн шинжилгээнд тулгуурлан төсөвлөх явдал юм.
- Зарим эрхийг нэн даруй хэрэгжүүлэх ёстой байдаг бөгөөд хангалттай мөнгө хуваарилахгүй байх, зарцуулахгүй байх нь эдгээр эрхүүдийг хэрэгжүүлэхгүй байх шалтгаан байж болохгүй юм.
- НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос²⁶⁵ “Засгийн газрууд бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөндөө эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэхэд “нэн тэргүүн”-ийн ач холбогдол өгөх шаардлагатай бөгөөд энэ нь юуны түрүүнд Засгийн газрын төсвийн хуваарилалтад тусгагдсан байх ёстой” гэжээ.
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй холбоотой төсөл, хөтөлбөрүүдэд төсвийн хуваарилалтыг багасгах нь ихэвчлэн хүмүүсийн дээрх эрхийг эдлэхэд сөрөг нөлөө үзүүлж, холбогдох бараа, үйлчилгээ ховордох/хомсдоход хүргэдэг. Ийм нөхцөлд Засгийн газар хуваарилалт буурснаас болж хүмүүсийн эрх ашгийг хохирохгүй байх альтернатив төлөвлөгөө, хөтөлбөртэй байх ёстой.
- Засгийн газрууд өөр өөр бүлэгт төсөв дэх хуваарилалтын үр нөлөөг үнэлэх, хөрөнгө хуваарилсан байдлаараа (шууд болон шууд бусаар) ялгаварлан гадуурхахгүй байх үүргээ биелүүлж байгаа эсэхийг баталгаажуулахад холбогдох тэтгэмж, халамжийн судалгааг тогтмол хийх ёстой.

²⁶⁵ UN Committee on Economic, Social and Cultural Rights, <https://www.ohchr.org/en/hrbodies/cescr/pages/cescrindex.aspx>

Хоёр.Гадаадын зарим орны төсвийн төслийн хүний эрхийн нийцлийн талаарх туршлага

2.1.Шотландын туршлага

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын бүрдүүлэгч улс болох Шотландын хувьд сүүлийн 10 гаруй жилийн турш Шотландын Хүний эрхийн комиссоос эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах, холбогдох хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжуудад тусгах ажлыг эрчимтэй хийж ирсэн байдаг. Түүнчлэн, 2012, 2016 онуудад Шотландын төсвийн эрх, хариуцлага нэмэгдсэнтэй холбоотой төсвийн хяналт, төсвийн процесс дахь парламентын оролцох оролцооны асуудал анхаарлын төвд орсон. Ийнхүү Шотландын Парламентын Санхүү, Үндсэн хуулийн хороо болон Шотландын Засгийн газар хамтран Төсвийн үйл явцын хяналтын бүлэг (Budget Process Review Group)-ийг байгуулж, тус хорооноос төсвийн процессор дамжуулан хүний эрхийг хангахтай холбоотой зөвлөмжүүдийг боловсруулсан байдаг.²⁶⁶ Шотландын Парламентын холбогдох хороод (Тэгш байдал, хүний эрхийн байнгын хороо)-оос хүний эрхийн асуудал, үүн дотор хүний эрхийг улсын төсөвтэй уялдуулан анхаарах болсон нь Шотландад хүний эрхийн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжуудад тусган хэрэгжүүлэх, Шотландын хүний эрхийг хангах, хамгаалах үйлсэд олон улсад тэргүүлэгч болох зорилтыг дэмжиж байна.

Түүнчлэн, 2018 онд Шотландын Хүний эрхийн комисс нь Шотландад эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах, хөгжүүлэх зорилгоор хүний эрхэд суурилсан төсвийн шинжилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхээр Европын Холбооноос санхүүжилт аван, холбогдох төслийг хэрэгжүүлсэн байдаг.

Дээрх бүгдийн үр дүнд Шотландад хүний эрхийг хангахад чиглэсэн төсвийн үйл явцын сайн туршлага бий болсон гэж үзэж болохоор байна.

Зураг 1. Шотландын хүний эрхэд суурилсан төсвийн үйл явц



Эх сурвалж: Human Rights Budgeting and Budget Analysis,

Scottish Human Rights Commission, 2015

²⁶⁶ Briefing Paper 2:The Context for Human Rights Budget Work in Scotland, 2019 <https://www.scottishhumanrights.com/media/1907/hrbw-paper-2-vfinal.pdf>

Зураг 2. Шотландын төсвийн үйл явцын цаглабар



Эх сурвалж: Шотландын Парламентын Судалгааны алба²⁶⁷

Шотландын төсөв нь тэгш байдал, үүн дотор жөндөрийн тэгш байдал, хүний эрх болон сайн сайхан байдал зэрэг ойлголт дээр суурилсан байдаг.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактад гарын үсэг зурж, баталсан улс бүр:

“Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.”

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд дээр дурдсан хүний эрхийн хэм хэмжээг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх (үр дүн, гарцад суурилсан хэм хэмжээ), бол зарим нь шууд хэрэгжүүлэх (үйлдэл, үйл ажиллагаанд суурилсан)-ийг шаарддаг.

²⁶⁷ <https://digitalpublications.parliament.scot/ResearchBriefings/Report/2018/5/10/Guide-to-the-new-Scottish-budget-process#What-has-been-agreed->

Хүний эрхийг хангахад чиглэсэн Засгийн газрын ажил нь нэн ялангуяа дараах үр дүнд чиглэх ёстой байна. Үүнд:

- “шаардлагатай хамгийн бага түвшинг”, эсхүл “хамгийн бага суурь/minimum core” түвшинг хангах;
- Хүний эрхийг бүрэн хангахдаа “дэвшилттэйгээр хэрэгжүүлэх”, өөрөөр хэлбэл “хамгийн бага суурь” нь дангаараа хангалтгүй бөгөөд зөвхөн суурь түвшинг илтгэх бол цаашлаад дэвшилттэйгээр ахиулах шаардлагатай юм;
- “дордуулахгүй байх/Non-retrogression” Засгийн газраас хүний эрхээ эдлэх явдлыг хязгаарлаж байгаа бол үүнийгээ “бүрэн нотлох/тайлбарлах” шаардлагатай юм.

Хүний эрхийн хэм хэмжээг төсөвт хэрхэн тусган хэрэгжүүлэх вэ?

Хүний эрхийн хэм хэмжээ болон төсөв хоёр хэрэн уялдаж байгааг илүү сайн ойлгоход хүний эрхэд суурилсан төсөв (*human rights budgeting*) болон хүний эрхийг хангасан эсэхийг шалгах төсвийн дүн шинжилгээ (*human rights budget analysis*) гэх хоёр ялгаатай боловч харилцан уялдаатай хоёр ажлыг авч үзэж шаардлагатай юм.

Хүснэгт 2. Төсвийг хүний эрхийн хэм хэмжээтэй уялдуулан үнэлэх нь

	Төсөв бүрдүүлэлт	Төсвийн хуваарилалт	Төсвийн зарцуулалт
Хамгийн бага суурь түвшин	Бүх хүний хүний эрхийн суурь түвшинг хангахад санхүүжилт бүрдсэн үү?	Хуваарилалт нь бүх хүний хүний эрхийн суурь түвшинг хангахад ач холбогдолтой байна уу?	Санхүүгийн менежментийн тогтолцоо нь хуваарилагдсан хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг хангаж чадаж байна уу?
Ялгаварлан гадуурхахгүй байх	Орлогыг хэнээс бүрдүүлж байна вэ? Зарим нэг бүлэгт тэгш бусаар нөлөөлж байна уу?	Хуваарилалт нь бүлгүүдийн хүний эрхийг эдлэхэд гарч буй ялгааг бууруулахад ач холбогдол өгч байна уу?	Зарим тодорхой бүлгүүдэд пропорциональ бусаар нөлөөлөхөөр хөрөнгийг дахин хуваарилсан уу?
Дэвшилттэйгээр хэрэгжүүлэх	Орлогыг нэмэгдүүлж (нэмэгдүүлэх боломжтой юу) болох уу?	Хуваарилалт нь нэмэгдэж байна уу? Буурч байна уу? Буурч байгаа бол хэр үндэслэлтэй вэ?	Санхүүгийн менежментийн тогтолцоо нь сайжирсан уу? Суларсан уу?

Эх сурвалж: <https://www.scottishhumanrights.com/projects-and-programmes/human-rights-budget-work/>

Төсвийн үйл явцад хамаарал бүхий хүний эрхийн зарчмууд

Шотландад хүний эрхэд суурилсан хандлагын PANEL (Participation, Accountability, Non-discrimination and Equality, Legality) зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Оролцоог хангах: хүмүүс эрхэд нь нөлөөлөх шийдвэр гаргах явцах оролцох.
- Хариуцлагатай байдал: Хүний эрхэд хэрхэн нөлөөлж байгааг хянах болон зөрчигдсэн бол түүнийг залруулах механизмтай байх.
- Ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байдлыг хангах: бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг хориглох, урьдчилан сэргийлэх, арилгах ёстой. Эрхээ эдлэхдээ хамгийн их саад бэрхшээлтэй тулгарч буй хүмүүсийг нэн тэргүүний ээлжид авч үзэх.
- Эрх мэдэлжүүлэх: хүн бүр эрхээ ойлгож, өөрсдийн амь, амьдралд нөлөөлөх бодлого, шийдвэр боловсруулахад оролцохдоо дэмжлэг авах.

- Хууль ёсны байх: хандлагууд нь дотоодын болон олон улсын хууль тогтоомжуудад заасан эрх зүйн актуудад үндэслэсэн байх.

Товчхондоо энэ нь төсвийн үйл явц нь олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх бөгөөд дээр дурдсан зарчмуудыг төсвийг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах зэрэг бүхий л үйл явцад удирдлага болгох юм.

Холбогдох үйл явцын шалгуур үзүүлэлт (*process indicator*) боловсруулж, хэрэглэх нь төсвийн үйл явцын ил тод байдал, оролцоог хангах, хариуцлагатай болгоход ахиц дэвшил гаргахад ихээхэн хувь нэмэртэй юм. 2018 онд Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн үр дүнд Шотландын Хүний эрхийн комисс нь дараах гурван үйл явцын шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. Үүнд:

- Төсвийн ил тод байдлын дэлхий дахины үзүүлэлт/Global indicator of fiscal transparency: Open Budget Survey²⁶⁸ дээр үндэслэн боловсруулсан, ил тод байдал (мэдээлэл цаг хугацааны хувьд болон бусад байдлаар хүртээмжтэй эсэх) хариуцлагын механизмын үр ашигтай байдал (хуул тогтоох байгууллага, аудитор, хараат бус төсвийн байгууллагууд), олон нийтийн оролцоог хангасан байдал зэргийг үнэлнэ.
- Төсвийн үйл явц дахь оролцооны чанарын үзүүлэлт/Indicator of quality of participation in national budget process: Шотланд дахь улсын төсвийн процесс дахь оролцооны чанарыг үнэлэх зорилготой. Зөвлөлдөх үйл явцын 7 сайн туршлагыг тодорхойлсон Consultation Charter²⁶⁹ дээр үндэслэн боловсруулсан.
- Орон нутгийн түвшин дахь төсвийн мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг үзүүлэлт/ Indicator of availability, accessibility and transparency of budget information at the Local Level: энэ нь Шотландын төрийн байгууллагуудын мэдээллээр хангах үүргийг үнэлэх зорилготой, төсвийн мэдээллийг батлагдсан загвар, хуваарийн дагуу мэдээлж байгааг үнэлдэг.

Түүнчлэн, төсвийн орлого бүрдүүлэх, хуваарилах, зарцуулахтай холбоотойгоор нөөцийн шалгуур (*resource indicators*) үзүүлэлтүүдийг ашиглаж болох юм. Нөөцийн шалгуур үзүүлэлт нь дараах байдалтай байж болох юм.

Хүснэгт 3.Төсвийн орлого бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах шалгуур үзүүлэлтийн жишээ

Төсвийн орлого бүрдүүлэх жишээ	Төсвийн орлогын ДНБ-д харьцах харьцаа Төсвийн орлого дахь татварын орлогын хувь хэмжээ Татварын орлого, төрлөөр (орлогын албан татвар, ААН-ийн орлогын албан татвар, НӨАТ) нийт татварын орлогод эзлэх хувиар Татвар (төрлөөр)-ын татвар төлөгчийн нийт орлоготой харьцах харьцаа Татвараас зайлсхийх (Tax effort: Tax Evasion Gap) Санхүүгийн хууль бус урсгалын дундаж Palma Ratio: эдийн засгийн нийт тэгш бус байдлын хэмжүүр
Хуваарилалтын жишээ	Зардлын харьцаа (нийт дүнд эзлэх хувь) салбараар Дэд салбарын зардлын харьцаа Салбар, дэд салбарын нэг хүн, нэг нэгжид ногдох харьцаа Хамгийн бага суурь түвшинг хангахад зарцуулах зардлын харьцаа
Зарцуулалтын жишээ	Төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүү Гүйлгээний зардал зэрэг зарцуулалтын үр ашигтай байдлын дүн шинжилгээ

²⁶⁸ <https://www.internationalbudget.org/open-budget-survey/>

²⁶⁹ <https://www.consultationinstitute.org/consultation-charter-7-best-practice-principles/>

2.2. Уганда Улсын туршлага

Парламентын Хүний эрхийн хороодын гишүүдэд зориулсан “Хүний эрхийн хэрэгжилт дахь парламентын оролцоо: Сайн туршлага, шинэ боломжуудыг тодорхойлох нь” (IPU, OHCHR, 2019) сэдэвт семинарыг ОУПХ, НҮБХЭДКГ хамтран 2019 онд Женев хотноо зохион байгуулсан. Уг семинараар парламентуудын хүний эрхийг хангах чиглэлээр амжилт гаргаж буй сайн туршлагын талаар хэлэлцэн, хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг боловсруулсан байна.

Тус арга хэмжээнд төсвийн үйл явцаар дамжуулан хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотойгоор Бахрейн Улсын Парламент Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хангалттай хэмжээний санхүүжилт төсөвлөхийг шаардсан явдал, мөн Уганда Улсын Хүний эрхийн байнгын хорооноос боловсруулсан парламентаар хэлэлцэх бүхий л асуудлыг (хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, улсын төсвийн төсөл) хүний эрхийн үүднээс хянан шалгах шалтгуур үзүүлэлт бүхий шалгах хуудсыг боловсруулан, нэвтрүүлснийг тус тус онцлон тэмдэглэжээ. (IPU, OHCHR, 2019)

Уганда Улсын Парламент Хүний эрхийн байнгын хороог 2012 онд Парламентаар хэлэлцэж буй бүхий л асуудлыг хүний эрхийн стандарт, хэм хэмжээг хангуулах чиг үүрэгтэйгээр байгуулсан. Үүнтэй холбоотойгоор хүний эрхийн стандарт, хэм хэмжээг үнэлэх энгийн ойлгомжтой шалгуур үзүүлэлт нэвтрүүлэх зайлшгүй шаардлага үүссэн. Ийнхүү Уганда Улсын Хүний эрхийн байнгын хороо Их Британийн Дээд Комиссарын газартай хамтран холбогдох шалгах хуудсыг боловсруулсан байна.

Хүний эрхийн нийцлийг шалгах хуудас тус улсын түүхэнд анхдагч бөгөөд Парламентаар хэлэлцэж буй хуулийн төсөл, стратеги, бодлогын баримт бичиг болон Засгийн газрын хөтөлбөрийн хүний эрхийн үр дагаврын талаар Парламентад хурдан шуурхай мэдээлэх, хүний эрхийн асуудалд анхаарлаа хандуулах механизмыг бүрдүүлж байгаа юм. Тус шалгах хуудас нь Уганда Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт агуулагдах тодорхой эрхийг авч үзэж байгаа бөгөөд Парламентад асуудал өргөн мэдүүлж буй Сайд, Парламентын гишүүн бүрийг тухайн танилцуулж буй асуудлын хүний эрхийн үр дагаврын талаарх мэдээллээр хангахаар үүрэгжүүлж байгаа юм.

Судалгаанд Уганда Улсын дээрх шалгах хуудсыг тоймлон орчуулсан болно.

УГАНДА УЛСЫН ПАРЛАМЕНТ, ХҮНИЙ ЭРХИЙН БАЙНГЫН ХОРОО

1. Танилцуулга, нөхцөл байдал (Standing Committee on Human Rights, 2012)

Төрийн бодлогын Үндэсний зорилт, чиглэлийн зарчмын V зорилт²⁷⁰ нь төрөөс хүний эрхийг хамгаалж, хөхиүлэн дэмждэг институцуудыг баталгаагаар хангах, хүндэтгэх болон зохих дэмжлэг үзүүлэхийг шаарддаг.

Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэг (20-50 дугаар зүйл) нь хүний үндсэн эрх, эрх чөлөө болон бусад эрх, эрх чөлөөг хангах, хөхиүлэн дэмжих баталгаагаар хангадаг. Дөрөвдүгээр зүйлгийг хүний бүхий л эрх, эрх чөлөөг багтаасан байдаг учир Хүний эрхийн Билль гэж нэрлэх нь элбэг.

Уганда Улсад хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлыг эрчимжүүлэх зорилгоор Парламентын дэгийн 146 (1) (m)-д дараах чиг үүрэг бүхий Хүний эрхийн асуудал эрхэлсэн байнгын хороог байгуулсан. Үүнд:

²⁷⁰ Objective V of the National Objectives and Directive Principles of State Policy.
<https://www.helpinelaw.com/law/uganda/constitution/constitution01.php>

- (a) Парламентаар хэлэлцэж буй асуудал бүрийн хүний эрхийн асуудлыг хянаж, тайлагнах;
- (b) Уганда Улсын үндэсний болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээн үүргийн хэрэгжилт, олон улсын хүний эрхийн хяналтын байгууллагуудад гаргаж өгдөг илтгэл, тайлангуудын хэрэгжилтийг хангах;
- (c) Уганда Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тайлан дахь зөвлөмжүүдийг судлах, Засгийн газарт хариуцлага тооцох;
- (d) Уганд Улсын хүний эрхтэй холбоотой аливаа асуудлыг шалгах;
- (e) Парламентаас хүний эрхтэй холбоотой асуудлаар Байнгын хороонд даалгасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Иймд Хүний эрхийн байнгын хороо нь хүний эрхийг хамгаалах, төр засаг, хүн бүр хүний эрхийг хүндэтгэж, хангаж, хөхиүлэн дэмжих байгааг хангуулах болон хяналт тавих чиг үүргийн хүрээндээ онцгой үүргийг хүлээнэ.

2.Шалгах хуудсын зорилго

Шалгах хуудсаар Байнгын хороо, эсхүл асуудал өргөн мэдүүлж буй Засгийн газрын аль ч яам хүний эрх хангагдаж буй эсэхийг үнэлэх боломжтой юм. Ингэхдээ Байнгын хороог дараах мэдээл, удирдамжаар хангах зорилготой. Үүнд:

- (a) Хүний эрхэд суурилсан хандлага нь хуулийн төсөл, хөтөлбөр, төсөв болон бусад баримт бичгийг боловсруулахад тусгагдсан байхыг хангах, тодорхойлох;
- (b) Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгийн холбогдох зүйлд тусгагдсан тодорхой хүний эрхүүдийг тодорхойлж, хүйс, арьс өнгө, үндэс угсаа, омог, шашин шүтлэг, нийгмийн гарал, өмч хөрөнгө, улс төрийн үзэл бодол болон хөгжлийн бэрхшээлийн үндсэн дээр ялгаварлан гадуурхахгүй байх, эмзэг байдалд анхаарал хандуулсан байдал (цөөнх), хариуцлагатай байдал, эрх мэдэлжүүлсэн байдал, оролцоо болон хамрагдах байдлыг хэрхэн төрийн бодлого, хууль тогтоолд тусгах;
- (c) Холбогдох салбаруудад хүлээсэн үүргээ хэрэгжүүлүүлэх үүднээс үүрэг хүлээсэн этгээд (институци, төрийн байгууллага)-ийн чадавхыг тодорхойлох;
- (d) Эрх эдлэгч (үр шимийг хүртэгч)-ийн хүний эрхийн холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх, хангуулах чадавхыг бүрдүүлэх, нэмэгдүүлэх.

3.Хүний эрх

Хүний эрх гэдэг ойлголт нь хүн болж төрсний хувьд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээ юм. Тэдгээр нь үндэс угсаа, хүйс, шашин шүтлэг, арьс өнгө, хэл болон бусдаас үл хамааран хүн бүрийн заяагдмал, төрөлхийн эрхүүдийг хэлэх юм.

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээхийг хангуулах юм. 1948 оны 12 дугаар сарын 10-нд дэлхийн улс орнуудын хүлээн зөвшөөрч баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд бүх эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн эрхийн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан байдаг.

3.1.Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө

Дараах эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулсан. Үүнд:

- (a) Тэгш байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх (21 дүгээр зүйл)
- (b) Амьд явах эрх (22 дугаар зүйл)
- (c) Эрх чөлөөтэй байх (23 дугаар зүйл)
- (d) Нэр төрийг нь доромжлох, хүнлэг бус харьцахаас ангид байх (24 дүгээр зүйл)

- (e) Боолчлогдох, бусдын эрхшээлд байх, албадан хөдөлмөрөөс ангид байх (25 дугаар зүйл)
- (f) Эд хөрөнгөө хууль бусаар хураалгахгүй байх (26 дугаар зүйл)
- (g) Иргэний хувийн нууц, орон байрны болон бусад хөрөнгийн халдашгүй байдал (27 дугаар зүйл)
- (h) Шүүхээр шударгаар шүүлгэх эрх (28 дугаар зүйл)
- (i) Чөлөөтэй бодож сэтгэх, өөрийн үзэл бодолтой байх, түүний чөлөөтэй илэрхийлэх, чөлөөтэй зорчих, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх эрх (29 дүгээр зүйл)
- (j) Сурч боловсрох эрх (30 дугаар зүйл)
- (k) Гэрлэх эрх (31 дүгээр зүйл)
- (l) Тогтолцооноос гадуур орхигдсон бүлгийн байдлыг дээрдүүлэх (*Affirmative action²⁷¹ in favour of marginalised groups*) (32 дугаар зүйл)
- (m) Эмэгтэйчүүдийн эрх (33 дугаар зүйл)
- (n) Хүүхдийн эрх (34 дүгээр зүйл)
- (o) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх (35 дугаар зүйл)
- (p) Цөөнхийн эрх (36 дугаар зүйл)
- (q) Соёлын эрх болон түүнтэй адилтгах эрх (37 дугаар зүйл)
- (r) Иргэний эрх, үйл ажиллагаа (38 дугаар зүйл)
- (s) Цэвэр, эрүүл орчинд амьдрах эрх (39 дүгээр зүйл)
- (t) Эдийн засгийн эрх (40 дүгээр зүйл)
- (u) Мэдээлэл авах эрх (41 дүгээр зүйл)
- (v) Хуулийн өмнө адил тэгш байх, ямар ч алагчлалгүйгээр хуулиар хамгаалуулах эрх (42 дүгээр зүйл)
- (w) Бусад эрх (45 дугаар зүйл)

3.2. Хүний эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих үүрэг

Парламентын хүний эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих үүргийг Үндсэн хуулийн 20.2 болон Төрийн бодлогын Үндэсний зорилт, чиглэлийн зарчмын V зорилтоор баталгаажуулсан.

4. Хүний эрхийн үндсэн зарчим

Олон улсын байгууллагууд олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд хүний эрхийг хэрхэн ойлгох, тайлбарлах, хөхиүлэн дэмжих зэрэгт дараах тулгуур болсон үндсэн зарчмуудыг боловсруулж, бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:

- a) Хүний эрх нь түгээмэл бөгөөд салшгүй байна;
- b) Хүний эрх нь хуваагдашгүй байна;
- c) Хүний эрх нь харилцан хамааралтай байна;
- d) Тэгш, үл ялгаварлан гадуурхах;
- e) Оролцоог хангасан байх;
- f) Хариуцлага ба эрх зүйт ёс.

5. Шалгах хуудас

Үндсэн хууль дахь хүний эрх, эрх чөлөө нь хоёр төрөлтэй. Энэ нь хэзээ ч зөрчигдөж болохгүй эрх, эрх чөлөө буюу абсолют эрх болон абсолют бус эрх юм.

²⁷¹ Баталгаа бий болгох арга хэмжээ - Энэ нэр томъёог тэгш боломж бий болгох зорилгоор жендер, арьс өнгө, үндэстэн угсаатны байдлыг харгалзан авч үзсэн бодлогод хэрэглэдэг. Ийм арга хэмжээг илэрхий институцийн шинжтэй бий болсон давуу бус, санаандгүй үүсч бий болсон ялгавартай байдлыг арилгах зорилгоор авч хэрэгжүүлдэг. (Ц.Даваадулам, 2010)

1-р хэсэг. Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд заасан зөрчихийг хориглосон эрх, эрх чөлөө

Үндсэн хуулиар баталгаажсан зарим эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлахыг хориглосон байдаг. Эдгээрийг ихэвчлэн “хязгаарлаж, зөрчиж болохгүй эрх” гэж нэрлэдэг. Хязгаарлаж, зөрчиж болохгүй эрх нь абсолют буюу туйлын эрх байх бөгөөд олон нийтийн, үндэсний, дэлхий дахины аюулгүй байдалд ямар нэгэн аюул учруулж байгаагаас үл хамааран Төрөөс ямар нэгэн саад учруулах ёсгүй юм.

Дараах эрх, эрх чөлөө нь Үндсэн хуульд заасан "хязгаарлаж, зөрчиж болохгүй" эрх, эрх чөлөө юм.

Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгүүлэхээс ангид байх эрх	24 дүгээр зүйл, 2012 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай хууль
Боолчлогдох, бусдын эрхшээлд байхаас ангид байх	25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт
Шүүхээр шударгаар шүүлгэх эрх	28 дугаар зүйл
<i>Habeas Corpus</i> -хүний халдашгүй байдал	23 дугаар зүйлийн 23.9 дэх заалт

2-р хэсэг. Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд нь Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлээр баталгаажсан эрх, эрх чөлөөтэй нийцэж байна уу?

Хүснэгт 4. А.Ерөнхий зүйл

Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн зорилго юу вэ?	
Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд нь Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд заасан эрх, эрх чөлөөг хэрхэн хөхиүлэн дэмжиж байна вэ?	
Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн шууд болон шууд бусаар хамаарах эрх, эрх чөлөө болон Үндсэн хуулийн холбогдох заалтыг бичнэ үү	
Зорилго нь Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлээр баталгаажсан эрх, эрх чөлөөтэй нийцэж байна уу?	
Нийцээгүй тохиолдолд холбогдох эрх, эрх чөлөө болон зөрчлийг тодорхойлон бичнэ үү	

Хүснэгт 5.Б.Тодорхой эрх, эрх чөлөө

1.Тэгш байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх (21 дүгээр зүйл)	21 дүгээр зүйл хангагдахгүй байгаа шалтгаан	Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэрэгслийг хангахгүй байж болзошгүй шалтгаан
Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн зорилго, үйлчлэх хүрээг үнэлэхдээ санал болгож буй хуулийн төслийн хамгийн их нөлөөлөх магадлалтай бүлгүүдийг тодорхойлно уу? Тодорхой жендэрийн үр дагавар үүсэх үү?		
Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд нь улс төр, эдийн засаг, нийгэм болон соёлын амьдрал, эсхүл өөр хүрээнд аливаа хүн, бүлэгт хүмүүсийн илүү тааламжтай эсхүл таагүй байдлыг бууруулж байна уу?		
Илүү тааламжтай, эсхүл тааламжтай бус		

<p>байдлыг бүрдүүлж байгаа нь аливаа хүн, бүлэн хүмүүсийг хүйс, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн гарал, өмч хөрөнгө, улс төрийн үзэл бодол, эсхүл хөгжлийн бэрхшээлийг үндэслэсэн үү?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд нь хүйсийг харгалзан үзэж байна уу? Жишээ нь: бодлого, хөтөлбөр нь бараа, үйлчилгээ үзүүлэх, ажилд авах, томилох, олон нийтийн газар, олон нийтийн тээврийн хэрэгсэл хэрэглэх, боловсрол, мэргэжил дээшлүүлэх зэрэгт тэгш байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хангаж байна уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь аливаа хүн, бүлэг хүмүүст хүйс, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн гарал, өмч хөрөнгө, улс төрийн үзэл бодол, эсхүл хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэйгээр сөрөг үр дагавар бий болгож байна уу?</p>		
<p>Тааламжтай бус хандлага, эсхүл сөрөг үр дагавар нь аль нэг хүн, бүлэг хүмүүст саад тотгор/сул тал үүсгэж байна уу? Тааламжтай бус хандлага нь тогтолцооноос гадуур орхигдсон бүлгийн байдлыг дээрдүүлэх арга хэмжээний хэсэг мөн үү? Дээрдүүлэх арга хэмжээ, түүний мөн чанарыг тодорхойлно уу.</p>		
<p>2.Амьд явах эрх (22 дугаар зүйл)</p>	<p>22 дугаар зүйл хангагдахгүй байгаа шалтгаан</p>	<p>Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэрэгслийг хангахгүй байж болзошгүй шалтгаан</p>
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь хүний амьд явах эрхийг санаатайгаар хязгаарлаж байна уу? Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь хүний амьд явах эрхийг хязгаарлахад нөлөөлж байна уу?</p>		
<p>Хэрэв тийм бол хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь зөвхөн шүүхээр шийдвэрлэж, ял шийтгэж, түүнийг Дээд шүүхээр шийдвэрлэсэн тохиолдолд амьд явах эрхийг хязгаарлаж байна уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь аль нэг хүний амь насанд заналхийлж байна уу? Жишээ 1: Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь хүний амь насанд шууд хамаарах ус, агаар, хоол хүнс хангагдах эрхэд нөлөөлж байна уу? Жишээ 2: Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь хүний амь насанд аюул учирсан тохиолдолд хүмүүс рүү гал нээх эрхийг олгож байна уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь хүн, хэсэг бүлэг хүний амь насыг хамгаалах ямарваа нэгэн хамгаалалт, стратеги дэвшүүлж байна уу?</p>		

<p>Жишээ нь: хүүхдийн эндэгдэл, цар тахал, насралтыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна уу? Террорист болон бусад халдлагын тохиолдолд хүний амь насыг хамгаалах гм.</p>		
<p>3.Эрх чөлөөтэй байх (23 дугаар зүйл)</p>	<p>23 дугаар зүйл хангагдахгүй байгаа шалтгаан</p>	<p>Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэрэгслийг хангахгүй байж болзошгүй шалтгаан</p>
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь аливаа хүний эрх чөлөөг хязгаарлаж байна уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь 23.1-т заасан хязгаарлалтын үндэслэлийг агуулж байгаа юу? Хэрэв тийм бол, холбогдох үндэслэлийг тодорхойлно уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь хүнийг хуулиар тогтоосон газарт байлгахаар тусгасан уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь саатуулагдсан, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүнийг шүүхэд хандах боломжоор хангасан уу? Хэрэв тийм бол, хязгаарлах, саатуулах хугацааг заасан уу?</p>		
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь ойр дотны хүн, өмгөөлөгч, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжоор хангасан уу?</p> <ul style="list-style-type: none"> • Ойр дотны хүнд мэдэгдэх тодорхой журам байгаа юу? • Хоригдож буй газарт ойр дотны хүн, өмгөөлөгч, хувийн эмч нэвтрэх боломжоор хангагдсан уу? 		
<p>4.Нэр төрийг нь доромжлох, хүнлэг бус харьцахаас ангид байх (24 дүгээр зүйл)</p>	<p>24 дүгээр зүйл хангагдахгүй байгаа шалтгаан</p>	<p>Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэрэгслийг хангахгүй байж болзошгүй шалтгаан</p>
<p>Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь 2012 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай хуультай нийцэж байна уу?</p> <ul style="list-style-type: none"> • Хуульд эрүү шүүлт гэж тодорхойлсон үйлдлийг тусгасан уу? • Хүний нэр төрийг хамгаалж байна уу? • Хуулийн төсөлд тусгасан санкц, шийтгэл нь хүний нэр төрийг хамгаалж байна уу? <p>Жишээ нь: Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөрт ямар санкц, шийтгэлийг тусгасан бэ? Тэдгээр нь тухайн хүнийг хувь хүний хувьд гутаан доромжилж байна уу?</p>		
<p>5.Боолчлогдох, бусдын эрхшээлд байх, албадан хөдөлмөрөөс ангид байх (25 дугаар зүйл)</p>	<p>25 дугаар зүйл хангагдахгүй байгаа шалтгаан</p>	<p>Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэрэгслийг хангахгүй байж болзошгүй шалтгаан</p>

Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь аливаа хүний бусдын эрхшээлд байхыг тусгасан уу?		
Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр нь аливаа хүнийг хөдөлмөрлөхийг шаардлага болгож байгаа юу?		
Хэрэв тийм бол, шаардагдаж буй хөдөлмөрийн мөн чанарыг тодорхойлно уу?		
Хөдөлмөр гүйцэтгэхийг шаардлага болгож буй хүн нь хууль ёсны дагуу саатуулагдсан, хоригдсон, ял шийтгүүлсэн, эсхүл хүчний байгууллагын гишүүн үү?		

Гурав. Үндсэн эрх, эрх чөлөө болон бусад хүний эрх, эрх чөлөөний ерөнхий хязгаарлалт

Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг хохироохгүй, эсхүл нийтийн эрх ашгийг хамгаалахыг шаарддаг. Нийтийн эрх ашиг нь Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгээр баталгаажсан эрх, эрх чөлөөг эдлэхэд чөлөөт, ардчилсан нийгэмд зохих ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, эсхүл Үндсэн хуульд зааснаас хэтрүүлэн хязгаарлахыг хориглодог.

Хуулийн төсөл, бодлого, хөтөлбөрт тусгасан зохицуулалтууд нь Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлээр баталгаажсан хүний эрх, эрх чөлөөтэй нийцээгүй болохыг тогтоосон бол дараагийн алхам болгон холбогдох зохицуулалтуудыг Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу чөлөөт, ардчилсан нийгэмд илэрхий хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг тогтоох юм.

Энэхүү хязгаарлалтын үндэслэлийг Парламентын холбогдох хороонд гаргах өгөх үүргийг холбогдох хуулийн төсөл, бодлого, хөтөлбөрийг боловсруулж (sponsoring) буй яам, агентлаг хүлээнэ.

Хүснэгт 6. Тусгай хэсэг

Тусгай хэсэг	43 дугаар зүйл хангагдахгүй байгаа шалтгаан	Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэрэгслийг хангахгүй байж болзошгүй шалтгаан
Холбогдох эрх, эрх чөлөөний мөн чанар нь юу вэ? Эдийн засгийн, иргэний, цөөнхийн, эсхүл хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг тусгай бүлгийн, амь нас, эсхүл хүний аюулгүй байдал уу, өмч хөрөнгө үү, шударга шүүхээр шүүлгэх гм.		
Хязгаарлалтын зорилго нь юу вэ? Жишээ нь: хязгаарлалтын зорилго нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хэмжээнд ач холбогдолтой байх ёстой		
Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нь батлан хамгаалах, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийгмийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл олон нийтийн нийтлэг эрх ашгийн үүднээс шаардлагатай юу?		
Хязгаарлалтын мөн чанар нь юу вэ? (Шууд хязгаарлалт уу, шууд бус хязгаарлалт уу)		
Хязгаарлалт болон түүний зорилгын хоорондын хамаарал нь юу вэ? Хязгаарлалтууд нь тухайн зорилгыг хангахад шаардлагатай хэмжээнээс хэтэрсэн хязгаарлалт уу?		
Тухайн зорилгыг ханахад илүү бага хязгаарлалтын арга хэмжээг авч болох уу?		

ХОЁР.УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭГДСЭН ЭСЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДСЫН ТАЛААРХ СУДАЛГАА

2.1 Ядуурлын гол шалтгаан²⁷²

Дэлхийн хүн амын 8 орчим хувь нь нэн ядуу амьдарч байна. Ядуурлын үндсэн шалтгаануудыг авч үзвэл дараах байдалтай байна.

1. Тэгш бус байдал

"Тэгш бус байдал" гэдэг нь хэсэг бүлэг хүмүүсийг нийгэмд дуу хоолойгоо хүргэх боломжийг хязгаарлаж, төлөөлөлгүй болгож буй системийн саад бэрхшээлийг илрүүлэхэд хэрэглэгддэг, энгийн боловч заримдаа төөрөгдүүлсэн нэр томъёо юм. Хүн ам ядуурлаас ангижрахын тулд нийгмийн бүх бүлгүүд шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой. Ялангуяа шийдвэр гаргалт нь таны нийгэмд эзлэх байр суурьд нөлөөлөхөөр бол Та санал бодлоо илэрхийлэх хэрэгтэй.

2. Зөрчил

Зөрчилдөөн нь ядуурлыг нэмэгдүүлэх эрсдэлд хүргэдэг хамгийн түгээмэл шалтгаануудын нэг юм. Сири зэрэг бүс нутагт өрнөж буй том хэмжээний, удаан үргэлжилсэн хүчирхийлэл нь нийгмийн хөгжлийг зогсоож, дэд бүтцийг эвдэн сүйтгэж, хүмүүсийг (ихэвчлэн нуруун дээрх хувцаснаас өөр зүйлгүй) дүрвэхэд хүргэдэг.

3. Хоол тэжээлийн дутагдал, өлсгөлөн

Ядуурал нь өлсгөлөнд хүргэдэг хэдий боловч өлсгөлөн нь ядуурлын шалтгаан бөгөөд түүнийг тэтгэгч мөн. Хэрэв хүн хангалттай хоол хүнс авч чадахгүй бол ажиллахад шаардагдах хүч чадал, эрч хүч дутагдах болно.

4. Эрүүл мэндийн үйлчилгээний муу тогтолцоо

Хэт ядуурал, баталгаагүй эрүүл мэнд зэрэгцэн оршдог. Эрүүл мэндийн тогтолцоо сул орнуудад хумхаа, суулгалт, амьсгалын замын халдвар зэрэг урьдчилан сэргийлэх, эмчлэхэд хялбар өвчин түгээмэл байдаг. Өвчлөл их байх нь ядуурал орших шалтгаан болдог.

5. Цэвэр ус, ариун цэвэр, эрүүл ахуй

Одоогоор 2 тэрбум гаруй хүн гэртээ цэвэр усгүй байна. Энэ нь хүмүүс ус авахын тулд өдөр бүр 200 сая орчим цагийг хол зайд алхахад зарцуулж, ирээдүйд ажилд орох, боловсрол эзэмшихэд ашиглаж цагаасаа хугаслахад хүргэж байна.

6. Боловсролын дутагдал

Боловсролгүй хүн бүр ядуу амьдардаггүй. Гэхдээ нэн ядуу хүмүүсийн ихэнх нь боловсролгүй байдаг. Дүрэмт хувцас, номны мөнгө дутмаг, охидын боловсролд харьцангуй нэг талыг барьж анхаарсан байдал зэрэг олон шалтгаан боловсролын ерөнхий чанарт сөргөөр нөлөөлж байдаг.

7. Уур амьсгалын өөрчлөлт

Цөлжилт, усны үер зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн тааламжгүй нөхцөл байдал нь өлсгөлөнг бий болгоход хүчтэй нөлөө үзүүлдэг бөгөөд үр дагавар нь дүрвэгсдийг бий болгох, мөргөлдөөнд нөлөөлөх зэрэг төрөл бүрийн хэлбэрүүдээр дамжиж мөчлөгийн шинжтэй ядуурлыг бий болгодог.

²⁷² <https://reliefweb.int/report/world/11-top-causes-global-poverty>

8. Төрийн дэмжлэг дутагдах

Эрүүл мэндийн үйлчилгээ аль эсвэл хүнсний тусламж авах боломжийг олгосон нийгмийн халамжийн хөтөлбөрүүд улс орнуудад байдаг. Гэхдээ засгийн газар бүхэн иргэддээ ийм төрлийн тусламж үзүүлж чаддаггүй бөгөөд эмзэг бүлгийн гэр бүлүүд нэн ядуурлын түвшинд буцаж очихоос сэргийлэх арга хэмжээ авч чадахгүй байх тохиолдол цөөнгүй.

9. Төрийн хүнд суртал, муу дэд бүтэц

Зам, гүүр, худаг, гэрлийн кабель, гар утас, интернет зэрэг дэд бүтцийн хомсдол нь иргэдийн бизнес хийх боломжийг хязгаарлаж байдаг.

10. Ажлын байрны хомсдол

Ажлын байргүй, цалин орлогогүй бол хүмүүс ядууралтай тулгарах болно. Нөөцийг хэт их ашиглах нь уламжлалт амьжиргаанд дарамт болж байна.

11. Нөөцийн хомсдол

Бэлэн мөнгөний хадгаламж, хүнсний нөөц зэрэг нь эрсдэлт хүчин зүйлсийг даван туулах боломжийг олгодог. Хэт ядуу амьдарч буй хүмүүст санхүү болон хөрөнгийн нөөц ихэвчлэн байдаггүй.

2.2 Ядуурлыг бууруулах арга зам²⁷³

- Эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, ариун цэврийн байгууламж зэрэг салбарт эдийн засгийн хурдацтай бөгөөд тогтвортой өсөлтийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх; ядууст идэвхтэй оролцох, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах боломжийг олгох;
- Ус болон бусад байгалийн нөөцийн менежментийг сайжруулах;
- Хөдөө аж ахуйн хөтөлбөрт хөрөнгө оруулж, хэрэгжүүлэх;
- Улс орнуудыг худалдаа эрхлэлтийг ядуурлаас ангижруулах арга зам болгохыг дэмжих;
- Ажлын байр, орлогын хүртээмжийг нэмэгдүүлж, бизнес эрхлэх чадварыг хөгжүүлэх;
- Бүх хүмүүст боловсрол, эрүүл мэнд, хангалттай хоол хүнс, ариун цэврийн байгууламж, орон байр, цэвэр ус зэрэг нийгмийн үндсэн үйлчилгээнд хамрагдах боломжийг олгох;
- Бусдын туслалцаа хэрэгтэй байгаа хүмүүсийг дэмжих нийгмийн хамгааллын тогтолцоог үе шаттай хөгжүүлэх;
- Ядуурлыг бууруулах, арилгах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд ядуу иргэдийг татан оролцуулах;
- Нөөц болон үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдахад учирч буй саад бэрхшээлийг арилгах;
- Интернет холболт, хямд эрчим хүч зэрэг технологи, инновацийг иргэдэд хүртээмжтэйгээр хүргэх

Түүнчлэн ядуурлыг бууруулахын тулд Америкийн Конгресс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой үздэг.²⁷⁴

- Цалин хөлсний доод хэмжээг өсгөх;
- Орлогын татварын хөнгөлөлт үзүүлэх;
- Ижил ажилд, ижилхэн цалин хөлс тогтоох;
- Өвдсөн болон ажиллаагүй, түр эзгүй байх үед цалин, хөлс олгох;

²⁷³ <https://borgenproject.org/10-ways-to-reduce-poverty-in-the-world/>

²⁷⁴ <https://www.americanprogress.org/article/the-top-10-solutions-to-cut-poverty-and-raise-the-middle-class/>

- Ажлын байранд өнгөрүүлэх цаг хугацааг уян хатан тогтоох;
- Хүүхэд харах сайн үйлчилгээ, эрт үеийн боловсролд хөрөнгө оруулалт хийх;
- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;
- Эрүүгийн эрх зүйн тогтолцоог шинэчилж, шийтгүүлж байсан иргэдийг дахин ажил эрхлэх боломжоор хангах;

2.3 Вьетнам улсын туршлага

Тус улс ядуурлыг бууруулахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.²⁷⁵

- Ядуурал, өлсгөлөнг арилгах;
- Бүх нийтэд сайн боловсрол олгох;
- Жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийг чадавхжуулах
- Хүүхдийн эндэгдлийг бууруулах;
- Эхийн эрүүл мэндийг сайжруулах;
- ХДХВ/ДОХ, хумхаа, халдварт өвчинтэй тэмцэх;
- Байгаль орчны тогтвортой байдлыг хангах;
- Эмзэг байдлыг багасгах;
- Сайн засаглалыг хангаж, ядуурлыг бууруулах;
- Ядуурлыг устгаж, үндэстний цөөнхийн соёл, ялгаатай байдлыг хадгалах;
- Ядууст чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлэх;

2.4 Гана Улсын туршлага

Ганийн парламентын зүгээс ядуу иргэдийг дэмжих бодлого боловсруулах, төсөв зохиоход гүйцэтгэх засаглалд үзүүлэх нөлөөгөө нэмэгдүүлж байгаа.²⁷⁶

Энэ үйл явцад хэд хэдэн бэрхшээл тулгардаг боловч дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн тохиолдолд тэдгээрийг даван туулж чадна гэж үзэж байна.

- а) Ядуурлыг дэмжих бодлого, төсөв боловсруулах асуудлаар УИХ-ын тусгай хороодын ажилд хүрэлцээтэй санхүүжилт олгодог болох
- б) УИХ-ын “Ядуурлыг бууруулах хороо” нь ядуурлыг бууруулахад чиглэгдсэн төсөв, бодлогын үр нөлөөг шинжлэх, сурталчлах үйл явцыг нотолгоонд суурилсан мэдээллээр дэмжих зорилгоор Хөгжлийн түншүүд, ИНБ, ТББ-уудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- в) Ядуу иргэдийг дэмжих бодлого, төсвийг боловсруулахад баримтлах зөвлөлдөх механизмыг тодорхойлсон хууль байхгүй тохиолдолд УИХ энэхүү механизмыг Үндэсний эдийн засгийн бодлого, төсвийн мэдэгдэлд төсөв боловсруулахдаа тусгахыг сангийн яаманд үүрэг болгон, захирамж гаргаж болно.

2.5 Болив Улсын туршлага

Төсөв ба ядуурлыг бууруулах стратегийн бичиг баримт

Болив улс анх удаа ядуурлыг бууруулах төлөвлөгөө боловсруулж холбогдох арга хэмжээний зардлыг тооцох оролдлого хийсэн бөгөөд бүх арга хэмжээг татварын орлого, тусламжаар санхүүжүүлэх боломжгүй гэж дүгнэсэн.

Ядуурлыг бууруулах стратегийн бичиг баримт нь үйл ажиллагааны янз бүрийн чиглэлүүдийн дунд байгаа нөөцөө ашиглан юу хийхээ шийдэхэд тус дөхөм болохуйц тэргүүлэх чиглэлүүдийг тогтоогоогүй байсан.

²⁷⁵https://documents1.worldbank.org/curated/en/62823146877562446/114514322_20041117143030/additional/multi0page.pdf

²⁷⁶https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf

Засгийн газар ядуурлыг бууруулахад чиглэгдсэн зорилтуудыг төсөвт дараах агуулгын хүрээнд тусгасан. Эдгээр нь

- (i) Эрүүл мэнд; (ii) Боловсрол; (iii) Ариун цэврийн байгууламж; (iv) Хот байгуулалт; ба (v) Хөдөөгийн хөгжил зэрэг болно.

Төсвийн ангилалд ядуурлыг бууруулах стратегийн бичиг баримтын зорилтуудыг үнэлж болохуйц шалгуур үзүүлэлтүүдийг оруулж өгсөн. Энэ утгаараа төсвийн хуваарилалт бодлогын баримт бичиг гарахаас өмнөх үеийнхээс өөрчлөгдсөн бөгөөд төсөв ядуурлыг бууруулахад чиглэгдсэн эсэхийг дүгнэх боломжийг олгож байгаа.

Институцийн чадавхыг бэхжүүлэх

Үр дүнд чиглэсэн төсвийн тогтолцоонд шилжих институцийн чадавх маш сул гэж үнэлэгдсэн.

Төвлөрлийг сааруулах

Болив улсад ядууст чиглэсэн зарцуулалтыг хянах нь амаргүй байдаг. Учир нь нийт төсвийн тодорхой хэсгийг хотын захиргааны түвшинд хэрэгжүүлдэг. Үндэсний засгийн газар орон нутгийн захиргаанаас төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой төсвийн нарийвчилсан бүх мэдээллийг авдаггүй.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Нийт зарцуулалтыг хянахад хүндрэлтэй байгаа хэдий ч төсвийн гүйцэтгэлийг ил тод болгох, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн чухал алхмууд хийгдсэн.

Төсвийн төлөвлөлтөд ядуурлыг бууруулах зорилтыг тусгах нь²⁷⁷

- ✓ Мянганы хөгжлийн зорилтуудыг харгалзаж үзэх
- ✓ Төсөвт ядууст чиглэсэн бодлогыг тусгах
- ✓ Төсвийн үйл явцад УИХ-ын оролцоо, нөлөөг бэхжүүлэх
- ✓ Парламент дараах асуултуудад өөрөө хариулт өгөх нь чухал. Эдгээр нь:
 - Хуваарилах нөөцийн хэмжээ хэд байх вэ?
 - Ямар зорилтот бүлгийг хамруулах вэ?
 - Зорилтот бүс нутаг хаана байх вэ?
 - Нөөцийг хэрхэн зарцуулах вэ?
 - Хэрхэн хянаж, үнэлэх вэ? зэрэг болно.
- ✓ Ядуу хүмүүсийг анхаарч үзсэн болохыг Парламентаас хэрхэн баталгаажуулах талаар;
- ✓ Ядуурлыг бууруулахыг дэмжсэн төсөвт нөөцийг хуваарилах;
- ✓ УИХ-аас ядуурлыг бууруулах бодлогод хяналт тавих;
- ✓ Төсвийн хууль тогтоох үйл явцад ядуу иргэд, иргэний нийгмийн байгууллагыг оролцуулах;

²⁷⁷https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf

Хүснэгт 7. Шалгах хуудас

№	
1	Үр дүнд суурилсан төсөвлөлт болж чадсан уу? ²⁷⁸
2	<p>Вьетнамын туршлага</p> <p>Хуримтлуулсан мэдээллийн санг ашиглан ядууралд үзүүлэх нөлөөллийн олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ хийх:²⁷⁹</p> <p>Нөлөөлөгч үзүүлэлтүүдэд²⁸⁰</p> <ul style="list-style-type: none"> ▪ Бүтээмж ▪ Ажил эрхлэлт ▪ Суурин хүн амын нийт хүн амд эзлэх хувь ▪ Төсвийн орлого ▪ Төсвийн зардал ▪ Төсвийн орлого, зардлын хоцрогдолтой утга ▪ Урсгал зардал ▪ Хөрөнгийн зардал ▪ Эрдэс бүтээгдэхүүний гол нэр төрлийн бүтээгдэхүүний орлого ▪ Эрдсийн бус бүтээгдэхүүний орлого...
3	<p>Индонезийн туршлага</p> <p>Эдийн засгийн өсөлтийн хувь²⁸¹</p> <p>Төсвийн зардлын зүйл ангиудын нийт зардалд эзлэх хувь хэмжээний динамик</p> <p>Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн төсвийн зардлын төсвийн зардалд эзлэх хувь, динамик</p>
4	<p>Молдав улсын туршлага</p> <p>Дахин хуваарилалтын бодлого²⁸²</p> <p>Боловсролын түвшин</p> <p>Халамжаас хамааралтай хүмүүсийн тоо</p>
5	<p>Африкийн туршлага</p> <p>Засаглалын чанарт гарсан ахиц²⁸³</p> <p>Залуучуудыг сургах, хөдөлмөр эрхлүүлэх боломж хэр байна вэ?</p> <p>Ядуу иргэдийн халдварт өвчинд нэрвэгдэх эрсдэл хэр зэрэг байна вэ?</p> <p>-Өмнө нь УИХ ядуу иргэдийн асуудлын талаар судлан үзэж, хэлэлцүүлэг хийсэн үү?</p> <p>-Ядуу иргэдийн хүсэл эрмэлзэл үндэсний хэмжээнд тусгалаа олсон уу?</p> <p>Стратеги, бодлогын бичиг баримтууд, ялангуяа улсын төсөв болон ядуурлыг бууруулах стратеги зэрэг бичиг баримтууд хэр чанартай боловсрогдсон, хоорондоо ямар түвшинд уялдсан бэ?</p> <p>-Ядуу иргэдийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого үнэхээр үр дүнтэй байна уу?</p> <p>Ганийн туршлага²⁸⁴</p> <ol style="list-style-type: none"> a) Ядууралтай тэмцэх ажилд зориулсан төсөв b) Ядууралтай тэмцэх ажлыг хариуцсан Парламентын хорооны оролцогч талуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагааны түвшин c) Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн төсвийг зохиоход зөвлөлдөх механизмыг ямар түвшинд хэрэглэсэн байх d) Ядуурлын оношлогоо, шинжилгээг хэр зэрэг хийсэн

²⁷⁸ Budgeting for Poverty Reduction, <https://www.sida.se/en/publications/budgeting-for-poverty-reduction---evaluation-of-poverty-reduction-strategies-in-latin-america---2005>

²⁷⁹ Government spending and poverty reduction in Vietnam, <https://openknowledge.worldbank.org/handle/10986/24114>

²⁸⁰ <http://jedsnet.com>

²⁸¹ <https://www.econjournals.com/index.php/ijefi/article/view/5831>, Implementing Pro Poor Budgeting in Poverty Reduction: A Case of Local Government in Bone District, South Sulawesi Province, Indonesia

²⁸² <https://planipolis.iiep.unesco.org/en/2006/republic-moldova-poverty-reduction-strategy-annual-evaluation-report-2005-annual-evaluation>

²⁸³ https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf

²⁸⁴ <https://www.econjournals.com/index.php/ijefi/article/view/5831>

	<p>e) Ядууралтай холбоотой зардлыг хуваарилахдаа бүс нутгийн онцлог, хүн амын бүлгийг хэр харгалзсан</p> <p>f) Ядууралтай тэмцэх хөтөлбөрийн чанарт хийсэн үнэлгээ</p>
6	<p>Ядуурлыг²⁸⁵ бууруулах чиглэлээрх хөтөлбөрүүдийг олон нийтэд сурталчилсан байдал</p> <p>Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн тусдаа хөтөлбөрүүд гарсан эсэх</p> <p>Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн давуу тал</p> <p>Төсвийн зардал ядуурлыг бууруулахад чиглэгдсэн эсэх</p> <p>Төсвийн зардлыг хуваарилахдаа салбарын ажиллагсдын онцлогийг харгалзсан эсэх</p> <p>Оролцогч талуудыг хамруулж уулзалт, арга хэмжээ зохион байгуулахаар тусгасан эсэх</p>
7	<p>Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн төсвийн хэмжээ²⁸⁶</p> <p>Боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэхэд хуваарилсан төсвийн зардал, төсвийн нийт зардалд эзлэх хувь</p>
8	<p>Авилгатай тэмцэх арга хэмжээний төсөв, динамик хэмжээ²⁸⁷</p> <p>Хүн амын хүнсний хэрэгцээг хангаж байгаа байдал</p> <p>Ажлын байрны шингээлт ихтэй салбаруудыг хэр зэрэг дэмжиж байгаа</p> <p>Дэд бүтцийн болон бүтээмж өндөртэй салбарт дэмжлэг үзүүлж байгаа эсэх</p>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

ГУРАВ.УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ЭСЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШАЛГАХ ХУУДСЫН ТАЛААРХ СУДАЛГАА

1.Онол, практикийн асуудлууд болон өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага

1.1.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдал

Төсвийн тухай хуулийн²⁸⁸ 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг; 4.1.6-д Улсын төсөв гэж Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг; хэлнэ гэж тус тус заасан байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг төрийн бодлого боловсруулах, ялангуяа төсөвлөлт, стратеги төлөвлөлтийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх хандлага бөгөөд төсвийн мөчлөг, бүх үе шатанд буюу бодлого төлөвлөлтөөс эхлэн төсвийн зарцуулалт, хяналт шинжилгээний бүхий л үе шатанд хэрэгжих ёстой цогц арга хэмжээ юм.

ЖМТ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулан тус тусад нь төсөв батлах, эсвэл тэдэнд зориулан төсвийг адил тэгш тоогоор хуваарилах тухай асуудал биш, харин тэдний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөв боловсруулахыг хэлнэ. Эрэгтэй эмэгтэй хүмүүс нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр суурь, нийгэм-эдийн засгийн байдал, хэрэгцээ өөр өөр байдаг тул төрийн бодлого болон улсын төсөв тэдэнд харилцан адилгүй байдлаар хүрч, нөлөөлж байдаг.

Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэхийн тулд дараах хоёр арга хэлбэрүүдийг хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

²⁸⁵ https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf

²⁸⁶ <https://www.files.ethz.ch/isn/96629/wp208.pdf>

²⁸⁷ <https://www.files.ethz.ch/isn/96623/wp206.pdf>

²⁸⁸ Төсвийн тухай хууль

1. Үндэсний, салбар, орон нутаг, байгууллагын хэмжээний бүхий л бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах, ХШҮ хийх, шинэчлэн боловсруулах;
2. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тусгай хөтөлбөр, арга хэмжээнд төсөв хуваарилах.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг улсын, орон нутгийн, байгууллагын төсвийн мөчлөг, үе шатанд хэрэгжүүлэхэд дараах үе шатыг анхаарч үзнэ. Үүнд:

Бодлого, төлөвлөлт-төсөвлөлт:

Тодорхой бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудал хөндөгдөж буй эсэхэд шинжилгээ хийж, бодлого хэрэгжүүлэх суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг хүйсээр ангилсан мэдээлэл, судалгаанд тулгуурлаж шаардагдах төсвийг бодит тооцоонд үндэслэн тогтоох, батлах.

Бодлогын хэрэгжилт, төсвийн зарцуулалт:

Төсвийг зарцуулахдаа эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг тооцох, ялгаварлан гадуурхахгүй байх, хүний нөөцийн бүрдүүлэлтэд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах.

Хяналт шинжилгээ, үнэлгээ:

Бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд жендэрийн мэдрэмжтэй арга зүйд тулгуурлан, хүйсээр ангилсан тоо баримт, чанарын үзүүлэлтээр тодорхойлно. Төсвийн зарцуулалтын үр ашгийг үнэлж дүгнэснээр дараагийн арга хэмжээнд зориулсан зөвлөмж бичих.

Төсөвлөлтөд дүн шинжилгээ хийх эрх зүйн үндэслэлийг авч үзвэл Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *“Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь газар, бусад үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, төсвийн хөрөнгө, санхүүгийн актив, санхүүгийн зээл болон эдийн засгийн бусад нөөц баялгийг эрэгтэй, эмэгтэй хүнд адил нөхцөлөөр тэгш, хүртээмжтэй хуваарилах үүрэг хүлээнэ.”* гэж; мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-т төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь *тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;* чиг үүрэгтэй гэж тус тус заасан байна.

Жендэрийн төсөвлөлтөд дүн шинжилгээ хийхдээ төсвийн үйл явц, хуваарилалт, зарцуулалт нь нийгэм дэх эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэж, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн эсэхэд анхаардаг (Жендэрийн үндэсний хороо, 2018). Төсөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийх талаар олон янзын хандлага, арга хэлбэрүүдийг улс орнууд, хөгжлийн байгууллагууд туршин хэрэгжүүлж байгаатай уялдуулан дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой байна. Үүнд:

- **Жендэрийн хэрэгцээ тодорхойлох шинжилгээ:** Төсвийг төлөвлөж эхлэхээс өмнө бүх оролцогч талууд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор төрийн бодлого, хөтөлбөр нь жендэрийн тэгш байдлыг хангах бодлогод нийцсэн эсэх, бодлого хэрэгжүүлэхэд төсөв талаас юунд хамгийн түрүүнд анхаарах шаардлагатайг тодорхойлно.

- **Урьдчилсан үнэлгээ:** Улсын, орон нутгийн болон байгууллагын үйл ажиллагаа бүрийн төсвийн шалгуур үзүүлэлт, хэмжигдэхүүнийг тодорхойлоход жендэрийн тэгш байдлыг хангах талаар тусгагдсан эсэхэд үнэлгээ хийнэ.
- **Үр нөлөөний үнэлгээ:** Жилийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бодлогын арга хэмжээ нь жендэрийн тэгш байдал хангахад чиглэсэн эсвэл энэ талаар тусгагдсан эсэхийг үнэлэхдээ тодорхой нэгж бүхий төсвийн шалгуур үзүүлэлтүүдээр үр нөлөөний үнэлгээ хийнэ. *Энэ арга хэлбэрийг төсвийн жендэрийн аудитын нэг хэлбэр болгон төсөв батлах эрх бүхий төв байгууллага бус өөр эрх бүхий байгууллагаар хийлгэх нь илүү үр дүнтэй гэжээ (OECD, Ronnie Downes, Lisa von Trapp and Scherie Nicol, 2017).*
- **Оролцоонд суурилсан хандлага:** Төсөвт илүү нарийн шинжилгээ хийх, мэдээллийн эх сурвалжийг олон янзын хүмүүсийн үзэл бодлоор баяжуулан, мэдээллийн цогц сантай болох замаар ЖМТ-ийн санаачилгын үр нөлөөг бэхжүүлнэ (МЕРИТ, 2020). Улс, орон нутгийн төсөв төлөвлөх, захиран зарцуулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаснаар иргэд өөрт тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхэд санал оруулж, шийдвэрлүүлэх боломж олгодог.

1.2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиг хандлага

Монгол Улсын Засгийн газраас төсвийн бодлогоор дамжуулан жендэрийн тэгш байдлыг дэмжих арга замыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн ЖМТ-ийг хэрэгжүүлснээр төсвийн хуваарилалт сайжрах ач холбогдолтой бөгөөд үр дүнд нь жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдсэн байна. Уг хэрэгцээ шаардлагад тулгуурлан төсвийн хуваарилалтыг жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн сайжруулах үйл явцыг дараах үе шатуудад хувааж үзнэ. Үүнд:

1-р шат: Төсвийг жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, хандлагаар шинжлэн үзэх;

2-р шат: Жендэрийн шинжилгээнд үндэслэн төсвийн хуваарилалтыг өөрчлөн сайжруулах;

3-р шат: Цаашид жендэрийг төсвийн үйл явцад хийх дүн шинжилгээний нэг хэсэг болгох.

Жендэрийн төсөвлөлтийн хүрээнд эхний үе шатны дагуу улс, орон нутаг, салбар, байгууллагад амьдарч, ажиллаж, үйлчилгээ хүртэж байгаа эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн тэгш байдлыг хангахын тулд тэдний ямар асуудал, ялгаатай хэрэгцээг шийдэх хэрэгтэйг байгааг илрүүлж, байгууллага, орон нутаг, салбарын, үндэсний бодлого нь тэдгээр асуудлыг анхаарч тусгасан эсэх, өөрөөр хэлбэл жендэрийн мэдрэмжтэй эсэхийг шалгана. Үүний дараа хуваарилагдсан төсөв нь уг жендэрийн мэдрэмжтэй бодлогын хэрэгжилтийг дэмжиж байгаа эсэхийг шинжлэн үздэг. Төсөв хөтөлбөрөөр бус, зардлаар хуваарилагдсан байвал төсөвт шууд шинжилгээ хийхэд хүндрэлтэй. Энэ тохиолдолд жендэрийн дүн шинжилгээнд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй бодлого байгаа эсэх, төсөв нь уг бодлоготой уялдаатай, хэрэгжилтийг нь бүрэн дэмжиж байгаа эсэхийг шинжилж болно. Жендэрийн нөхцөл байдлын шинжилгээ хийгдэж, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлттэй болсон тохиолдолд жендэрийн мэдрэмжтэй төсөв нь дараах хэлбэрүүдээр хэрэгжих боломжтой. Үүнд:

1. Үндэсний, салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн, эсхүл нийгэмд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг дэмжсэн төсөв.

2.Салбар, байгууллагын жендэрийн мэдрэмжтэй ажиллах чадавхийг дээшлүүлэхэд зориулагдсан тусгайлсан төсөв.

3.Ялгаатай хэрэгцээтэй, тусгай анхаарал шаардаж буй бүлгийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төсөв.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлд ЖМТ-ийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх нь Засгийн газрын бүрэн эрх байхыг заасанчлан жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлд Засгийн газрын хариуцлагыг дээшлүүлэх мониторингийн механизм бий болгох нь ЖМТ-ийн үйл явцын салшгүй хэсэг байна. Засгийн газрын төдийгүй төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын, иргэдийн оролцоог хангах нь жендэрийн мэдрэмжтэй төсвийн үндсэн зарчим байх ёстой. Ялангуяа төсөвт оруулах аливаа өөрчлөлт жендэрийн хувьд ямар үр нөлөө үзүүлэх вэ гэдгийг төсвийн үйл явцад оролцогчид бодолцохоос гадна иргэний нийгмийн байгууллага, иргэд мониторинг хийх нь үр дүнтэй.

ЖМТ нь төсвийн үйл явцыг илүү нээлттэй болгон эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн оролцоог сайжруулах, төсвийн мэдээллийг илүү хүртээмжтэй, ойлгомжтой болгох, төсвийн талаарх эрх зүйн орчныг сайжруулах гэх мэт олон сайн нөлөөтэй. Энэ хүрээнд

- төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийж эмэгтэй эрэгтэй хүмүүст төсөв хэрхэн ялгаатай нөлөөлж байгааг тодорхойлох;
- төсвийн бодлого, нөөцийн хуваарилалтыг жендэрийн тэгш байдалд чиглүүлэн сайжруулах;
- төсвийн нийт үйл явцыг жендэрийн мэдрэмжтэй болгох цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх тогтолцоог нутагшуулах нь зүйтэй байна.

Ийнхүү жендэрийн дүн шинжилгээ (жишээ нь жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ) хийгдэж, түүнд суурилсан жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулагдан, жендэрийн мэдрэмжтэй төсөв хэрэгжсэнээр шат шатны төсөв илүү оновчтой, үр өгөөжтэй болох эргэх холбоо хангагдана.

2.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, түүний хэрэгжилт

2.1.Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг шалгах хуудас, шалгуур үзүүлэлт

Улсын төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийх нь дэлхий нийтэд төсөвт шинжилгээ хийх шинэлэг аргуудын нэг болж байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүст төсвийн зарцуулалт хэрхэн нөлөөлж байгааг тодруулах замаар хөрөнгийн тэгш хуваарилалтыг хангахад туслах үр дүнтэй арга хэрэгсэл болж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой байна.

Жендэрийн төсөвлөлт нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах стратегийн чухал, салшгүй хэсэг бөгөөд жендэрийн агуулга, үзэл санааг бодлого, хөтөлбөрийн төсвийн шийдвэртэй уялдуулах, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв хуваарилах байдлаар хэрэгжинэ. Товчоор ЖМТ гэж төсвийн бүхий л үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах агуулгыг ойлгоно. Илрэх хэлбэр нь:

- үндэсний, салбарын, орон нутгийн болон байгууллагын төсөвт жендэрийн үнэлгээ хийх,
- төсвийн үйл явцад жендэрийн үзэл баримтлалыг тусгах,
- төсвийг жендэрийн тэгш байдлыг хангах зорилгод нийцүүлэн сайжруулах гэсэн үйл явцын цогц байна.

Төсөв гэх ойлголт нь төлөвлөсөн зардал, орлогыг жагсаасан Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан санхүүгийн төлөвлөгөө бөгөөд ЖМТ гэдэг нь төсвийн

бүхий л үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах үйл явц болно. Нөгөөтэйгүүр ЖМТ гэдгээр санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бодитой болгодог жендэрийн тэгш байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулахуйц Засгийн газрын төлөвлөлтийг тодорхойлно. Зөвхөн төсвийн агуулга төдийгүй төсөв боловсруулах, батлах, түүнийг хэрэгжүүлэх, хянах үйл явц, бүтцийн тухай асуудлыг бүхэлд нь хамарна.

2.2.Төсвийг жендэрийн мэдрэмжтэй эсэхийг шалгах хуудас

Судалгааны эх сурвалж, онол, практикийн мэдээллүүдэд үндэслэн шалгах хуудсыг дараах агуулгын хүрээнд боловсруулах хувилбарыг дэвшүүлж байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд тавигдах ерөнхий шалгуур, шаардлагыг дараах агуулгын хүрээнд хамааруулж үзэх боломжтой. Үүнд:

- Төсвийн мөчлөгийн бүх үе шатанд буюу бодлого төлөвлөлтөөс эхлэн төсвийн зарцуулалт, хяналт шинжилгээний бүхий л үе шатанд ЖМТ-ийг хэрэгжүүлэх боломжтой байдлаар тусгах
- Бодлого төлөвлөлтөд бодлогын жендэрийн дүн шинжилгээ хийх
- Хүйсээр ангилсан, жендэрийн мэдрэмжтэй тоо мэдээлэл ба чанарын судалгаа гаргах
- Төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийхдээ орлого, зарлагын үзүүлэлтүүдийн аль алийг харгалзаж үзэх
- Холбогдох салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх
- Салбар бүрээр зарцуулах хөрөнгийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш хүртэхээр хуваарилах
- Жилийн төсвийн төслийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх
- Улсын төсвийн төсөл жендэрийн тэгш байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх
- Нөөцийн хуваарилалтыг жендэрийн тэгш байдалд чиглүүлэх түүний хуваарилалт, зарцуулалт нь нийгэм дэх эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэж, жендэрийн тэгш байдалд эерэгээр нөлөөлж байгаа эсэх зэрэг шаардлагуудыг хангахуйцаар бодлого төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг хангуулах хэрэгтэй байна.

Хүснэгт 8. Шалгах хуудас

Д/д	Шалгах асуулт	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг төсвийн төсөл боловсруулахад анхаарч үзсэн эсэх	-Үндэсний, салбар, орон нутаг, байгууллагын хэмжээний бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө		
2.	Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг /загварыг/ жендэрийн мэдрэмжтэй байхаар тооцоолсон эсэх	-Хөдөлмөр эрхлэлт, -цалин хөлс, -хэрэглээний ялгаатай байдал, -хуримтлалын түвшин		
3.	Төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн саналд жендэрийн шинжилгээ хийсэн эсэх	-Салбар дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн нөхцөл байдлын дүн шинжилгээ		

4.	Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тусгай хөтөлбөр, арга хэмжээнд төсөв хуваарилсан эсэх	-Салбар бүрээр зарцуулах хөрөнгийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш хүртэхээр хуваарилсан байх		
5.	Төсвийн зардлын хуваарилалтад жендэрийн шинжилгээ хийсэн эсэх	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй үйл явц, ажил, үйлчилгээний жендэрийн нөлөөллийн судалгаа		
6.	Төсвийн орлого бүрдүүлэлтэд жендэрийн шинжилгээ хийсэн эсэх	Шууд бус татварын төрлүүд буюу НӨАТ, бензин, тамхи зэрэгт ногдуулдаг онцгой албан татвар эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлж буй талаар шинжилгээ		

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

2.3 Украин улсын туршлага

Украин²⁸⁹

Украин улсын жендэрийн тэгш байдлын зарчмуудыг тодорхойлсон хууль эрх зүйн бат суурьтай. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрх, боломжийг хангахад чиглэсэн зохицуулалтын гол аргуудын нэг бол эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш эрхийг баталгаажуулсан Украины Үндсэн хууль (1996 онд батлагдсан) юм.

24-р зүйлд Украины бүх иргэдийн эрх, эрх чөлөөний тэгш байдлыг баталгаажуулсан. Түүнд зааснаар эмэгтэйчүүдийг олон нийт, улс төр, соёлын үйл ажиллагаанд эрэгтэйчүүдтэй адил тэгш боломжоор хангах, боловсрол эзэмших, мэргэшүүлэх, хөдөлмөрлөх, түүнийхээ цалин хөлсийг олгох замаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхийн тэгш байдлыг хангана гэж заасан байдаг. Тэгш байдлыг хангахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж мөн тунхагласан байна. Эдгээр нь:

- Эрх эмэгтэйчүүдийн хөдөлмөр, эрүүл мэндийг хамгаалах тусгай арга хэмжээ авах;
- Тэтгэврийн хөнгөлөлтийг бий болгох;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр, эхийн асран хамгаалах үүргийг хослуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- Эх, хүүхдийн эрх зүйн хамгаалалт, материаллаг болон хүмүүнлэгийн дэмжлэг, түүний дотор жирэмсэн эмэгтэйчүүд, эхчүүдэд цалинтай чөлөө олгох, бусад давуу эрх олгох; зэрэг болно.

Үндсэн хуулийн эдгээр заалтуудыг боловсруулахдаа 2005 оны 9-р сарын 8-нд Украины "Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрх, боломжийг хангах тухай хууль" батлагдсан нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын гол акт болсон юм. Нийгмийн бүхий л салбарт, хүйсээр ялгаварлан гадуурхах үзлийг арилгах төрийн жендэрийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлсон "Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрх, боломжийг хангах тухай" Украины хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах баримт бичгүүдийг боловсруулж баталжээ.

- 2006 онд "Украины нийгэмд жендэрийн тэгш байдлыг хангах 2010 он хүртэлх төрийн хөтөлбөр".
- Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан төсвийн зарчмууд

²⁸⁹ <https://eca.unwomen.org/en/digital-library/publications/2016/05/gender-responsive-budgeting--analysis-of-budget-programmes-from-gender-perspective>

Энэхүү зарчимд:

- Төсвийн тогтолцооны шударга, шударга байдлын зарчим: Украины төсвийн тогтолцоо нь нийтийн баялгийг иргэд, нутаг дэвсгэрийн хамтын нийгэмлэгийн хооронд шударга хуваарилах зарчимд суурилдаг;
- Ил тод, олон нийтэд ил тод байх зарчим: Улсын төсөв, орон нутгийн төсвийг боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих үйл явцыг олон нийтэд мэдээлдэг;
- Тиймээс одоогийн хууль тогтоомж нь Украины төсөв боловсруулах үйл явцад жендэрийн хэтийн төлөвийг нэгтгэх хууль эрх зүйн зохицуулалтын найдвартай үндэслэл болж байгаа юм.

Тус улсын хувьд жендэрийн шинжилгээг дараах алхамуудаар гүйцэтгэж байна.

- Салбар дахь жендэрийн асуудлыг тодорхойлох, нөхцөл байдлын шинжилгээ хийх;
- Шинжилгээ хийх программын мэдээллийг цуглуулах;
- Хөтөлбөр/үйл ажиллагаа/, арга хэмжээний жендэрийн шинжилгээ хийх;
- Холбогдох төсвийн хуваарилалтад жендэрийн шинжилгээ хийх;
- Нэмэлт элемент: Төлөвлөсөн төсвийн үйл ажиллагааны жендэрийн нөлөөллийн үнэлгээг хийх;
- Жендэрийн тэгш байдлыг сайжруулах зөвлөмж боловсруулах;
- Жендэрийн төсвийн шинжилгээний үр дүнг баримтжуулах;

2.4 Австри улсын туршлага

Австри²⁹⁰ улсад 2008 оны 1-р сараас эхлэн шинэ үндсэн хуулийн хуулиар засгийн газрын бүх түвшинд төсөвт жендэрийн тэгш байдлын зарчмыг баримтлах шаардлагатай болсон. Эдийн засагчид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хэд хэдэн арга хэрэгслийг боловсруулсан бөгөөд энэ нь төсвийн орц, гарц, үр дүн, үр нөлөөг агуулсан онцлогтой байна. Хандивлагч болон түнш орнуудын хувьд заавал дагаж мөрдөх тохиролцсон конвенц, тунхаглал, зарчмууд нь жендэрийн тэгш байдлын үзэл санааг төсөвт тусгах нь чухал байдаг.

Холбооны Үндсэн хуулийн 7-р зүйлд Холбооны засгийн газар, муж, орон нутгийн эрх баригчдад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тэгш хандах үүрэг хүлээсэн заалтыг тусгасан байна.

Холбооны Үндсэн хуульд оруулсан хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлт (13-р зүйлийн 3-р зүйл) нь төсвийн удирдлагын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах зорилтыг хангаж ажиллахыг байгууллагуудад үүрэг болгосон.

А. Төсвийн орлогод жендэрийн тэгш байдал туссан эсэхэд дүн шинжилгээ хийх хэрэгслүүд

- Шууд (орлого, аж ахуйн нэгжийн татвар) болон шууд бус татвар (нэмэгдсэн өртгийн албан татвар) зэрэг засгийн газраас төвлөрүүлдэг орлогууд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хэрхэн ялгаатайгаар нөлөөлөх вэ?

²⁹⁰https://www.entwicklung.at/fileadmin/user_upload/Dokumente/Publikationen/Downloads_Themen_DivBerichte/Gender/CHECKLIST_12032009_barriere.pdf

- Хэрэглэгчээс авах хураамж эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд хэрхэн өөр өөр нөлөөлдөг вэ?
- Ирээдүйд өрийн дарамтыг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хэрхэн үүрэх вэ?
- V. Төсвийн зарлагад дүн шинжилгээ хийх хэрэгсэл
 - Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн үйлчилгээ зэрэг төрийн үйлчилгээний зардлаас эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хэрхэн ашиг тус хүртэх вэ?
 - Бодлого болон бодлоготой холбоотой нөөцийн хуваарилалт нь ямар арга замаар жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад нөлөөлөх вэ?
 - Бодлого, хөтөлбөрүүд нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн өөр өөр хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг хэрхэн тусгадаг вэ?
 - CEDAW ²⁹¹ -д заасан болон тухайн улсын тусгайлсан зөвлөмжид дурдсан эмэгтэйчүүдийн эрхийг харгалзан үзсэн үү?
 - Дэд бүтэц, төрийн үйлчилгээнд оруулах төсвийн хөрөнгө оруулалт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өөр өөр хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг хэрхэн хангах вэ?
 - Зардал нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн цаг ашиглалтад хэрхэн өөр өөр нөлөөлдөг вэ?
 - Засгийн газар жил бүрийн төсвийн тайланд жендэрийн тэгш бус байдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгдөг үү?

Хандивлагч орнуудын төсвийн хэлэлцээрийн үйл явцтай холбоотой жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт батлагдсан эсэхийг шалгах асуултуудыг доорх хэсэгт харуулав.

- ✓ Жендэрийн оролцогчид (төр/ТББ/Донорууд) бодлого боловсруулахад оролцож байгаа эсэх, цаг хугацаанд нь оролцуулж чадаж байна уу?
- ✓ жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хэрэгслүүдийг ашигласан уу (үр ашиг хүртэгсдийн хүсэл, эрмэлзлийн үнэлгээ, бодлогын үнэлгээ, цаг ашиглалтын дүн шинжилгээ)?
- ✓ Дунд хугацааны төсвийн зардлыг төслийг боловсруулахад жендэрийн харилцаанд оролцогчид (төр/ТББ/Донор) хамрагддаг уу?
- ✓ Дунд хугацааны төсвийн зардлыг төслийг боловсруулахад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хэрэгслүүдийг ашигласан уу?
- ✓ Хяналт шинжилгээнд жендэрийн харилцаанд оролцогчид (төр/ТББ/Донор) оролцож байна уу?
- ✓ Мэдээлэл, хяналт, үнэлгээний системийг жендэрийн оролцогчид, ялангуяа эмэгтэйчүүдийн байгууллагууд ашигладаг уу?
- ✓ Төсвийн бодлого, зарлагад өөрчлөлт оруулах тогтолцоо бий юу?
- ✓ Жендэрийн тэгш байдал болон ядуурлыг бууруулах зорилтын хоорондын хамаарлыг тооцож үзсэн үү?
- ✓ Бодлогод хүйсээр нь ангилсан өгөгдлийг ашигладаг уу?
- ✓ Бодлогын төлөвлөлтөд жендэрийн саад тотгор, ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг арилгах арга хэмжээг харгалзан үздэг үү?
- ✓ Жендэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах арга хэмжээ бодлогод тусгасан уу?
- ✓ Дунд хугацааны төсвийн зардлыг төсөөлөл, төсөлд жендэрийн орц, гарц, үр дүн, нөлөөллийг тусгадаг уу?
- ✓ Жендэрийн тэгш байдалд салбарын бодлогуудын үр нөлөөг тооцож үздэг үү?

²⁹¹ The Committee on the Elimination of Discrimination against Women (CEDAW) is the body of independent experts that monitors implementation of the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- https://www.entwicklung.at/fileadmin/user_upload/Dokumente/Publikationen/Downloads_Themen_DivBerichte/Gender/CHECKLIST_12032009_barriere.pdf
- https://www.unescap.org/sites/default/files/SDD_Gender-Responsive_Budgeting.pdf
- <https://eca.unwomen.org/en/digital-library/publications/2016/05/gender-responsive-budgeting--analysis-of-budget-programmes-from-gender-perspective>
- <https://www.files.ethz.ch/isn/96629/wp208.pdf>
- <https://www.files.ethz.ch/isn/96623/wp206.pdf>
- Төсвийн тухай хууль
- <https://www.econjournals.com/index.php/ijefi/article/view/5831>, Implementing Pro Poo Budgeting in Poverty Reduction: A Case of Local Government in Bone District, South
- <https://planipolis.iiep.unesco.org/en/2006/republic-moldova-poverty-reduction-strategy-annual-evaluation-report-2005-annual-evaluation>
- https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf
- <https://www.econjournals.com/index.php/ijefi/article/view/5831>
- https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf
- https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf
- Budgeting for Poverty Reduction, <https://www.sida.se/en/publications/budgeting-for-poverty-reduction---evaluation-of-poverty-reduction-strategies-in-latin-america---2005>
- Government spending and poverty reduction in Vietnam <https://openknowledge.worldbank.org/handle/10986/24114>
- <http://jedsnet.com>
- <https://reliefweb.int/report/world/11-top-causes-global-poverty>
- <https://borgenproject.org/10-ways-to-reduce-poverty-in-the-world/>
- <https://www.americanprogress.org/article/the-top-10-solutions-to-cut-poverty-and-grow-the-middle-class/>
- https://documents1.worldbank.org/curated/en/628231468777562446/114514322_20041117143030/additional/multi0page.pdf
- https://www.agora-parl.org/sites/default/files/agora-documents/parliaments_poverty_reduction_and_the_budget_process_in_africa_en.pdf
- Жендэрийн үндэсний хороо. (2018). Жендэр ба бодлого төлөвлөлт. Улаанбаатар ЗДМ хэвлэлийн компани.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт. Сургалтын гарын авлага (2014). Улаанбаатар Жендэрийн үндэсний хороо, НҮБ-ын хүн амын сан.
- МЕРИТ, К. м. (2020). Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага Улаанбаатар.
- OECD, Ronnie Downes, Lisa von Trapp and Scherie Nicol. (2017). Public Governance and Territorial Development Directorate: Gender Budgeting in OECD countries. OECD Journal
- UNPD, UN Women. (2015). Gender responsive budgeting manual for municipalities Istanbul.

**ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ЗАРДАЛ, ҮР НӨЛӨӨГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ:
ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА**

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл, Р.Нургүл,
И.Жаргалзаяабямба, Д.Гэрэлт-Од*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Парламентын төсвийн хяналт, шинжилгээний албаны гүйцэтгэх үүрэг /Олон Улсад/
2. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцож буй арга, зарчим /Монгол Улсын нөхцөл байдал/
3. Хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцох онол, арга зүй
 - 3.1. Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх онол, арга зүй
 - 3.2. Хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ, олон улсын туршлага
- 4 Хууль, тогтоомжийн төслийн өртөг тооцох, зардал, үр нөлөөний шинжилгээ хийх алхам, арга зүй, улс орнуудын туршлага
 - 4.1. Зардал, үр ашгийн шинжилгээ, онол, арга зүй
 - 4.2. Австрали улс
 - 4.3.Тайланд улс
 - 4.4.Канад улс
 - 4.5. Шинэ Зеланд улс
5. Бодлогын өртгийг тооцоолох үйл явц
 - 5.1. Онол, арга зүй
 - 5.2. Австрали улс
 - 5.3. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

PBO	Parliamentary budget office
УИХ	Улсын Их Хурал
ХШҮГ	Хяналт шалгалт, үнэлгээний газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
RIA	Regulatory impact assessment
NPV	Net present value
BCR	Benefit to cost ratio
MIRR	Modified internal rate of return

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Аргачлалын хавсралт
- Хүснэгт 2. Аргачлалын хавсралт
- Хүснэгт 3. Зардал, үр ашгийн шинжилгээний давуу, сул тал
- Хүснэгт 4. Зардал, үр ашгийн шинжилгээ хийх алхам
- Хүснэгт 5. Санхүүгийн гол үзүүлэлтүүд
- Хүснэгт 6. Бодлогын үр нөлөөний төрлүүд
- Хүснэгт 7. Санхүүгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөх бодлогын нөлөө
- Хүснэгт 8. Зардлын тооцоолол хийх загварчлалын хэлбэр
- Хүснэгт 9. Суурь ба симуляц тооцоолол

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Бодлогын өртөг тооцох цаг хугацааны үзүүлэлт
- Зураг 2. Онцгой албан татварын өөрчлөлтийн үр нөлөө



УДИРТГАЛ

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн 597 дугаар захирамжаар баталсан “Тамгын газрын 2021 оны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд “Хууль, тогтоомжийн төслийн зардал, үр нөлөөний шинжилгээ” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэн болон УИХ-ын Тамгын газрын ХШҮГ-ын газрын Төсвийн хяналт, шалгалтын хэлтсийн ажилтнуудаас бүрдсэн хамтарсан судалгааны баг гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

Гадаад орнуудын Парламентын төсвийн шинжилгээний албаны чиг үүрэг, үйл ажиллагаа болон хууль, тогтоомжийн төслийн нөлөөллийн үнэлгээ, зардал, үр ашгийн шинжилгээ, бодлогын өртөг тооцох онол арга зүйн асуудлуудын талаар олон улсын туршлага судлах, парламентын түвшинд анхаарах асуудлуудыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд Парламентын төсвийн шинжилгээний албаны үйл ажиллагаа, чиг үүргийн талаарх олон улсын туршлага, хууль, эрх зүйн зохицуулалтын төслийн үр нөлөөг тооцох арга зүй, зардал тооцох, зардал-үр ашгийн шинжилгээ хийх онол, арга зүй, бодлогын өртөг тооцох аргачлал, энэ чиглэлээрх Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гишүүн орнуудын туршлага болон Монгол Улсын туршлага зэргийг хамруулан судалсан болно.

Түлхүүр үг: *Хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөө, зардал, үр ашгийн шинжилгээ, бодлогын өртөг тооцоолол, Парламентын төсвийн шинжилгээний алба*

Keywords: *Regulatory impact assessment, cost-benefit analysis, policy costing, Parliamentary budget office*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны I хэсэгт Парламентын төсвийн хяналт, шинжилгээний албаны чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх гадаад орнуудын туршлагыг оруулсан. Энэхүү мэдээлэл нь УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагааг боловсронгуй болгох, тус хэлтсээс УИХ-ын гишүүдэд үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн гаргахад албаны албан хаагчдад гарын авлага болохын зэрэгцээ хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал боловсруулах, судалгааны ажлын суурь хүрээг тодорхойлоход хөтөч болсон гэж хэлж болно. Парламентын төсвийн хяналт, шинжилгээний албадын үйл ажиллагааны жагсаалтаас давхцлыг нь арилгаж, системтэйгээр ангилж үзвэл дараах чиг үүргийг нийтлэг байдлаар хэрэгжүүлж байна. Эдгээр нь:

- 1) Макро эдийн засаг, төсвийн шинжилгээ хийх;
- 2) Мэдээллийн бааз бүрдүүлэх, олон нийттэй харилцах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 3) Төсвийн эрх зүйн орчны хэрэгжилтэд хяналт тавих;
- 4) Хууль, тогтоомж, бодлогын өртөг тооцоололт, зардал, үр ашгийн шинжилгээ хийх;
- 5) Үйлчилгээ үзүүлэх, судалгаа шинжилгээний ажлаар дамжуулан үйл ажиллагааны үр дүнг дэмжих гэх мэт.

Судалгаанаас үзэхэд, парламентын төсвийн шинжилгээний алба нь хууль эрх зүйн зохицуулалт болон бодлогын өртөг тооцох ажиллагааг заавал гүйцэтгэдэг, зардал үр ашгийн шинжилгээг цөөн тохиолдолд хийдэг болох нь харагдсан.

Судалгааны II хэсэгт, Монгол Улсын Хууль, тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 59-р тогтоолоор батлагдсан хууль, тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын хавсралтуудыг хамруулсан бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу хууль, тогтоомжийн төсөл боловсруулах шатанд нөлөөллийн үнэлгээ, зардлын тооцоолол хийх үүрэгтэй. Засгийн газрын тогтоолоор батлагдсан зардлын тооцооллын аргачлал нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардал (цаашид “зардал” гэх)-ыг тооцож, цаашид төсвийн ачааллыг аль болох багасгах санал боловсруулахад чиглэгдэж байгаа бөгөөд хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх хүрээнд зардал, үр ашгийн шинжилгээг урьдчилан хийх ажиллагаа төдийлөн хангалттай биш байна.

Судалгааны III хэсэгт хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцох онол, арга зүй, олон улсын туршлагын талаар авч үзсэн бөгөөд судалгаанд авагдсан улс орнууд хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ зардал, үр ашгийн шинжилгээг бие даасан шалгуур болгож авч үзэж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагуудын гишүүн орнуудын сайн туршлагаас үзэхэд хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийх үйл ажиллагаа нь дараах ажилбарууд болон үе шатуудаас бүрдэж байна. Эдгээр нь:

- Хэлэлцүүлэг ба оролцогч талуудын оролцоог хангах;
- Асуудлыг тодорхойлох;
- Суурь нөхцөл байдлыг үнэлэх;
- Зорилгыг томъёолох;
- Зохицуулалтын саналын хувилбаруудыг тодорхойлох;
- Хувилбаруудыг тодорхойлох, нөлөөллийг үнэлэх
- Үр ашиг, зардлын шинжилгээ хийх;
- Давууд үзэж сонгосон шийдлийг тодорхойлох;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох; зэрэг болно.

Мөн энэ хэсэгт эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний чанарыг дээшлүүлэхэд хууль тогтоомжийн төсөл боловсруулах дараалал, хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх алхамууд чухал үүрэгтэй болохыг Армен, Франц орнуудын туршлагаар харуулсан болно. Эдгээр орнуудад хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг сайжруулахад төр, захиргааны байгууллагуудын засаглал, бүтэц, зохион байгуулалт, талуудын болон хөндлөнгийн оролцоо, мэргэжил, арга зүйн чанарын түвшин чухал үүрэгтэйг онцолсон байна.

Судалгааны IV хэсэгт хууль, тогтоомжийн төслийн өртөг тооцох, зардал, үр ашгийн шинжилгээ хийх алхам, арга зүй, улс орнуудын холбогдох туршлагыг авч үзсэн болно. Зардал, үр ашгийн шинжилгээ нь үнэлгээний нэгдмэл системийн мөнгөн хөрөнгийн агуулгаар илэрхийлэгдсэн нэг шалгуур үзүүлэлт бөгөөд энэхүү шинжилгээ нь цаг хугацаа, хөдөлмөрийн нөөц, чимхлүүр ажлыг шаардсан онцлогтой байдаг байна.

Зардал үр ашгийн шинжилгээ хийх алхам нь судалгаанд авагдсан Австрали, Тайланд, Канад, Шинэ Зеланд зэрэг орнуудын хувьд ижил төсөөтэй байна. Эдгээр орнууд зардал үр ашгийн шинжилгээ хийх үйл явцад бодлого, зохицуулалтын боломжит хувилбаруудыг тодорхойлох, зохицуулалтын үйлчлэлийн нөлөөнд өртөх талуудын хожоо, алдагдлыг тооцох, зардал, үр ашгийн шинжилгээний арга, техникийг сонгох, үйлчлэлийн хугацааг тодорхойлох, инфляцийг харгалзах, хорогдуулалтын хувийг тооцох, ялгаатай

хувилбаруудад дурдсан арга техникийг ашиглах, харьцуулах гэсэн ажилбаруудыг хамруулдаг байна.

Судалгааны V хэсэгт Policy costing буюу бодлогын өртөг тооцох үйл явцыг хамруулсан бөгөөд энэ нь зардал, үр ашгийн шинжилгээтэй холбоотой буюу хууль, тогтоомжийн төслийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн бүрэлдэхүүнд орвол зохих үзүүлэлт болохыг судлаачид, ялангуяа Австрали, ИБУИНХУ-ын Засгийн газар онцолж байна. Судалгааны эхний хэсэгт Парламентын төсвийн шинжилгээний албаны хийх ажил, гүйцэтгэх үүрэгт бодлогын өртөг тооцох үйл явцыг хамруулсан байгааг дурдсан.

Бодлогын өртөг тооцох үйл явцын хүрээнд өртгийг дангаар нь тооцохоос гадна статик болон оролцогч талуудын хариу үйлдлийн нөлөөлөл, санхүү, эдийн засгийн орчин, төсвийн орлого, зардал, хөрөнгөд үзүүлэх нөлөөлөл гэсэн нөлөөллүүдийг хамруулдаг байна. Ингэж нөлөөлөл тооцох нь зардал, үр ашгийн шинжилгээнээс ялгаатай хэдий ч хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг бүрэлдэхүүнд ордог байна.

/Мэдээллийн дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү/

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Парламентын төсвийн хяналт, шинжилгээний албаны чиг үүрэг, үйл ажиллагаа /Олон Улсад/

Дэлхийн улс орнуудад Парламентын төсвийн хяналт шинжилгээний албаны гүйцэтгэх үүрэг, хийж хэрэгжүүлдэг үйл ажиллагааны жагсаалтыг боловсруулж гаргахдаа нийт 20 гаруй орны туршлагыг судалсан бөгөөд ашигласан эх сурвалжийг хавсралтад харуулав.

Хүснэгт 1. Парламентын төсвийн шинжилгээний албаны үүрэг, үйл ажиллагаа, хамруулсан орнууд

№	Парламентын төсвийн шинжилгээний алба, улс орнуудаар	№	Парламентын төсвийн шинжилгээний алба, улс орнуудаар
1	Guideline for Operationalizing a Parliamentary Budget Office	11	Functions of the PBO of North Macedonia
2	Encouraging fiscal responsibility	12	Indian PBO's functions
3	Parliamentary budget office of South Africa	13	The Changing Role of Parliament in the Budget Process
4	Functions of the Office are to provide the National Assembly of Zambia	14	Italy
5	Parliamentary budget office of Ireland	15	The Congressional Budget Office (CBO)
6	Role of the proposed Parliamentary Budget Office - Parliament	16	GN-PBO member countries
7	Roles of Parliamentaty budget office of Kenya	17	Australia and UK, Canadian
8	Functions of the Parliament Budget Office	18	The Role of Parliamentary Budget Office (PBO) in the Budget Cycle and Fiscal Oversight Function of Parliament (Ugandan Experience)
9	Office of the Parliamentary Budget Officer	19	Korea
10	Roles of the PBO of Sierra Leone	20	Ireland

Парламентын төсвийн хяналт шинжилгээний албаны чиг үүрэг, үйл ажиллагаа

1) Дүн шинжилгээ хийх хүрээнд

- Засгийн газрын жилийн төсөв, эдийн засгийн суурь нөхцлүүдийн төсөөлөлд дүн шинжилгээ хийх, ирээдүйг ялгаатайгаар таамаглах, сар, улирлын эдийн засаг, төсвийн мэдээг нийтлэх;
- Төсвийн хэтийн төлөв, нэмэлт зардал, татвар, эдийн засгийн гүйцэтгэлийг тогтмол шинжлэх;
- Гол нэр төрлийн орлого, зарлага, өрийн тогтвортой байдал, салбарын зарцуулалт, ТӨҮГ-ын санхүүгийн байдалд шинжилгээ хийх, эконометрик болон статистикийн загваруудыг ашиглаж эдийн засаг, санхүүгийн орчны бодлогын үр нөлөө, хэтийн төлөв, эрсдэлийн үнэлгээ хийх;
- Үндэсний эдийн засгийн хөгжлийн бодлогын санал, хувилбарт шинжилгээ хийх;
- Мөнгө, төсвийн бодлого, жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөг багтаасан багтаасан үндэсний эдийн засгийг хөгжүүлэх бодлогын үр нөлөөг хянаж, үнэлэх;
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эрсдэлд үнэлгээ өгөх;
- Макро эдийн засгийн зорилтуудын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, тэргүүлэх хэрэгцээ, хөгжлийн чиглэлд үндэсний нөөцийг оновчтой ашиглаж байгаа эсэхийг үнэлэх;
- Засгийн газрын хөтөлбөрүүдийн дунд, урт хугацааны үр нөлөөг үнэлэх;
- Парламентын гишүүдийг эдийн засгийн болон хөгжлийн асуудлаар мэтгэлзэх боломжийг олгох, мэтгэлцэх асуудлын хүрээг нь тодорхойлох;
- Сангийн яамны тайлан болон засгийн газартай холбоотой санхүүгийн эрсдэлд хийсэн бусад байгууллагуудын тайланд шинжилгээ хийх;
- Засгийн газрын хөтөлбөрүүдэд зарцуулж буй олон жилийн зардлын хувь хэмжээ, онцлогийг тодорхойлж яамны бодлогод шинжилгээ хийх, үндэсний хэмжээний зорилго, зорилтуудыг хангахад нөөцийг хуваарилж чадаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх боломжийг парламентын гишүүдэд олгох, үндэсний давуу талуудыг тусгасан төсвийн хүрээг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх;
- Шинжилгээндээ жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлүүд, төрийн аудитын газар болон парламентаас томилдог бие даасан бусад байгууллагуудын тайланг хамруулч авч үзнэ;
- Зардал бууруулах саналыг гаргах;
- Хууль, тогтоомжийн эдийн засгийн үр нөлөөг тооцож, хэрэгцээтэй мэдээллээр хангах;
- Дунд хугацааны төсвийн хүрээ, дунд болон урт хугацааны төсвийн төсөөллийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, урт хугацааны тогтвортой байдал, нэг үеэс нөгөөд чиглэсэн нөөцийн шилжилт, хүн амын насжилтаас шалтгаалсан урт хугацааны төсвийн чиг хандлагын шинжилгээ хийх;
- Засгийн газрын төсвийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын төслийн зураглал, төсвийн дүн шинжилгээг хийж, УИХ-д улирал тутам гүйцэтгэлийн тайлан гаргаж, төсөв, эдийн засгийн мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэж, төсвийн тухай хууль тогтоомж, хяналтын талаар УИХ, байнгын хороодод зөвлөгөө өгөх;
- Тодорхой салбарууд, бодлогын товч мэдээллээр хангах, гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллагын аль алиных нь бодлого боловсруулагчдад тавигдаж буй цаг хугацааны шаардлага, төсвийн нарийн цогц байдал нь төсвийн төсөл, үзэл баримтлалыг товч бөгөөд ойлгомжтой тайлбарлах эрэлт хэрэгцээг бий болгож байна. Энэ нь УИХ-д танилцуулах мэдээлэлд тавигдах шаардлага, стандартыг тогтоох хэрэгцээг бий болгосон.

1. Мэдээллийн бааз бүрдүүлэх, олон нийттэй харилцах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээнд

- Дүн шинжилгээ хийхдээ ашигласан түүхий мэдээлэл, мэдээллийн эх сурвалжийг ил болгож, тайлан, мэдээллийн зохиогчийн эрхийг хамгаалах, орон нутгийн судалгааны төвүүд болон олон улсын байгууллагууд зэрэг эх сурвалжаас зохих өгөгдлийг ашиглаж гүйцэтгэх засаглалын төсөөлөл, өгөгдлөөс ялгаатай төсвийн хувилбаруудыг гаргах;
- Эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүдийн мэдээллийн сан бүрдүүлэх;
- Бодлого тодорхойлохгүй, зөвхөн бодлогын сонголт, асуудлын талаарх товч мэдээллийг өгөх, энгийн байх зарчмыг баримтлан тайлагнаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэдийг нарийн төвөгтэй дүн шинжилгээг ойлгоход нь туслах, олон нийтэд таниулах, сурталчлах;
- УИХ-ын гишүүдийн эдийн засаг, төсвийн чиглэлийн мэдлэгийг дээшлүүлэх;
- Төрийн сан, санхүү, улсын төсвийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг бэхжүүлэх, сайжруулах, иргэний нийгэм, олон нийтийн хүсэл, хүсэл тэмүүллийг тусгах үүднээс төсвийн асуудлаар иргэний нийгэм, УИХ-ын хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх, иргэдийн төсөв, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Улсын төсөв, эдийн засагт харилцан ашиг сонирхол бүхий эрдэмтэн судлаачид, судалгааны төвүүд, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудын сүлжээг бий болгох;
- Оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлж, хэвлэмэл болон олон нийтийн цахим, мэдээллийн хэрэгслийг багтаасан төхөөрөмжийн ашиглалт, олон нийттэй харилцах харилцааны стратегийг тодорхойлох;
- Парламентын төсвийн шинжилгээний нэгжийн албан ёсны вэбсайт нь нэвтрэхэд хялбар, байршуулсан тайлан, шинжилгээ, мэдээлэл нь тогтмол шинэчлэгдэж, гаргасан мэдээлэл нь ил тод, хүртээмжтэй, ойлгомжтой байх ёстой;
- Төсвийг ойлгох чадавхийг нэмэгдүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй санал хүсэлтийн механизмаар дамжин харилцаж болно;
- Бүрэн эрхээ үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж үзэн төсөв, эдийн засгийн асуудлаар үндэсний болон олон улсын зарим байгууллагатай харилцаа тогтоох; чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах судалгааны хүрээлэн, хувь хүн, байгууллагатай хамтран ажиллах;

2. Хяналт тавих хүрээнд

Төсвийн дүрмийн биелэлт, төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвтэй холбоотойгоор чуулганаар хэлэлцэж баталсан асуудал, тайланг нэгтгэн гаргах, төсвийн бодлогын мэдэгдэлд тусгагдсан төсвийн хариуцлагын зарчим, санхүүгийн зорилтууд, УИХ-д өргөн мэдүүлсэн эдийн засаг, санхүүгийн үр нөлөө бүхий хуулийн төслийн талаар УИХ-ын холбогдох хороодод мэдээлэх;

3. Хууль, тогтоомж, бодлогын өртөг тооцооллт, хөтөлбөрийн зардал, үр ашгийн шинжилгээ хийх хүрээнд

- Бодлого, хөтөлбөрийн саналууд, улс төрийн томоохон намуудын сонгуулийн үйл ажиллагааны зардал тооцох, сонгуулийн амлалтын санхүүгийн үр нөлөөг үнэлэх, төсөвт чухал нөлөө үзүүлэх хуулийн төсөл болон засгийн газрын саналын санхүүгийн зардлыг тооцож, УИХ-аас нотлох баримтад суурилсан, иргэдэд чиглэсэн оновчтой бодлого гаргахад нь дэмжлэг үзүүлэх;
- Зардал тооцох арга зүйг боловсруулах;

- УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн зардлын тооцоо, хуулийн төсөл, бодлогын саналын өртөг, үр ашгийн дүн шинжилгээ хийхэд ашиглах мэдээллийн санг бүрдүүлэх;
- Төсөвт хамгийн их нөлөөлөл үзүүлэх боломжтой саналуудын зардлыг тооцох, эсвэл зөвхөн бүхэл бүтэн хороо эсвэл чухал бөгөөд дэд хороогоор батлагдсан саналуудын зардлыг тооцох;

4. Үйлчилгээ үзүүлэх, судалгааны ажлаар үйл ажиллагааны үр дүнг дэмжих хүрээнд

- Парламентын мэдлэгийн суурийг дэлхийн түвшинд хүргэж бэхжүүлэх зорилгоор эдийн засгийн бодлогын сэдвүүд, салбарын хөгжил, олон улсын эдийн засгийн бодлогын хөгжил, худалдааны эдийн засгийн чиглэлээр тасралтгүй судалгааны санаачилга гаргах, тодорхой сэдвүүдээр аналитик судалгаа хийх;
- УИХ-ын хороодод төсөв, санхүү, эдийн засгийн мэдээллийн талаар мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, гишүүдийн хүсэлтэд хариу бэлтгэх, төсвийн төсөл, эдийн засгийн чиг хандлагын талаар УИХ-ын холбогдох хороонд зөвлөмж гаргах;
- Шаардлагатай үед аль нэг санхүүгийн жилийн хувьд төсвийн чиглэлээр баримтлах ялгаатай дүрмүүдийг санал болгох;
- Засгийн газрын хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн хэмжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг судалж, үнэлэх;
- Засгийн газрын үйл ажиллагаанд ерөнхийд нь хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Төрийн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, төрийн санхүүд нөлөөлөх саналуудын санхүүгийн агуулгыг тодорхойлох;
- Засгийн газрын санал болгож буй бодлого, худалдан авалт, хуулийн төслүүдтэй холбоотой эрсдэлийн талаар тайлан гаргах;

Хоёр. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцож буй арга, зарчим /Монгол Улсын нөхцөл байдал/

2015 оны 5 дугаар сарын 29-нд УИХ-аар Хууль тогтоомжийн тухай хуулийг хэлэлцэн баталсан бөгөөд энэхүү хуулийн зорилгыг хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид "хууль тогтоомж" гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх явдал хэмээн тодорхойлсон байдаг. Тус хууль нь 11 бүлэгтэй бөгөөд хуулийн 3-р бүлгийн 12.1 дэх хэсэгт Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хүрээнд засгийн газар дараах аргачлалыг баталж, мөрдүүлнэ хэмээн тусгасан байдаг. Эдгээр нь:

- 12.1.1.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;
- 12.1.2.Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;
- 12.1.3.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;
- 12.1.4.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;
- 12.1.5.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал;
- 12.1.6.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал; зэрэг болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 3-р бүлгийн 12.1-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр аргачлал батлах тухай 59-р тогтоолыг баталж гаргасан бөгөөд энэхүү тогтоол нь үндсэн хэсэг, 6 хавсралтаас бүрдсэн байдаг. Аргачлалыг дараах хүснэгтүүдээр товч танилцуулъя.

Хүснэгт 2. Аргачлалын хавсралт

<u>Хавсралт 1</u> Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал	<u>Хавсралт 2</u> Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал	<u>Хавсралт 3</u> Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал
Нэг. Ерөнхий зүйл	Нэг. Хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах	Нэг. Ерөнхий зүйл
Урьдчилан тандан судлах ажлын үе шат	Хоёр. Хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага	Хоёр. Шалгуур үзүүлэлтийг сонгох <ul style="list-style-type: none"> ▪ Зорилгод хүрэх байдал ▪ Практикт хэрэгжих боломж ▪ Ойлгомжтой байдал ▪ Хүлээн зөвшөөрөгдөх байдал ▪ Зардал ▪ Харилцан уялдаа
Гурав. Асуудалд дүн шинжилгээ хийх	Гурав. Анхдагч хуулийн төсөл боловсруулах	Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох
Дөрөв. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох	Дөрөв. Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх
Тав. Асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулах	Тав. Улсын их хурлын тогтоолын төсөл боловсруулах	Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх
Зургаа. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах <ul style="list-style-type: none"> ▪ Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө ▪ Эдийн засагт үзүүлэх үр нөлөө ▪ Нийгэмд үзүүлэх үр нөлөө 		
Долоо. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх		

Эх сурвалж: <http://parliament.mn/laws>



Хүснэгт 3. Аргачлалын хавсралт

<u>Хавсралт 4</u> Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал	<u>Хавсралт 5</u> Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал	<u>Хавсралт 6</u> Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал
Нэг. Ерөнхий зүйл	Нэг. Ерөнхий зүйл	Нэг. Ерөнхий зүйл
Хоёр. Хуулийн этгээдийн зардлыг тооцох	Хоёр. Хяналт-шинжилгээг хийх үе шат	Хоёр. Үнэлгээ хийх үе шат
Гурав. Иргэний зардлыг тооцох	Гурав. Хууль тогтоомжийн зорилгыг тодорхойлох	Гурав. Төлөвлөх үе шат
Дөрөв. Төрийн байгууллагын зардлыг тооцох	Дөрөв. Тохирох хэмжүүрийг сонгох	Дөрөв. Хэрэгжүүлэх үе шат
	Тав. Мэдээллийг нэгтгэн цуглуулах	Тав. Үнэлэх үе шат
	Зургаа. Тайлагнах	

Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn>

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй гэж заажээ. УИХ-аар хэлэлцэгдэж батлагддаг, Засгийн газрын 59-р тогтоолд тусгасан аргачлалд хамаарахгүй бодлогын зарим бичиг баримтуудыг доор дурьдвал дараах байдалтай байна. Эдгээр нь:

- 12.2.11 Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл батлах тухай;
- 12.2.12 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;
- 12.2.13 Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай;
- 12.2.14 Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай;
- 12.2.15 Төрөөс мөнгөний бодлогын талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл батлах тухай; зэрэг болно.

Өөрөөр хэлбэл дээрх бодлогын баримт бичгүүдэд зардал, үр нөлөөний шинжилгээ, үнэлгээ хийхгүй гэсэн үг. Манай улсын практикаас хууль, тогтоомжийн төсөл боловсруулахдаа Засгийн газрын баталсан аргачлалын хавсралтад тусгасан үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, хийж байгааг харах боломжтой.²⁹² Харин зардалтай холбосон үр өгөөжийн тооцоолол хийгдсэн дүр зураг харагдахгүй байгаа юм. Зардал, үр ашгийн тооцоо нь мөнгөн агуулгаараа тухайн хууль, эрх зүйн зохицуулалт хэр өгөөжтэй байж чадахыг харуулдаг онцлогтой бөгөөд бодлогын ялгаатай сонголтуудыг харьцуулах боломжийг олгодог. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход энэхүү аргачлалыг баримтална. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардал (цаашид “зардал” гэх)-ыг тооцож, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулахад энэхүү аргачлалын зорилго оршино” хэмээсэн байдаг.

²⁹² <http://forum.parliament.mn/?status=Submitted>

Гурав. Хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцох онол, арга зүй

3.1 Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх онол, арга зүй

Эрх зүйн зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ гэж юу вэ?²⁹³

Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ (RIA-Regulatory impact assessment) нь төрөөс шинэ эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэхээс өмнө боловсруулбал зохих баримт бичиг юм. Энэ нь хууль, эрх зүйн зохицуулалт дэвшүүлсэн зорилгодоо хүрэх боломжтой эсэхийг нөлөөллийн нарийвчилсан, системтэй үнэлгээнд тулгуурлан тодорхойлоход чиглэгддэг. Шинэ хууль, эрх зүйн зохицуулалт нь урьдчилан таамаглахад бэрхшээлтэй олон үр дагаврыг араасаа дагуулж болзошгүй тул RIA нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулалтыг шаардаж байдаг. RIA-г хийхдээ нөлөөлөлд өртөх оролцогч талуудыг хамруулан судалгаа хийж, тэдэнтэй харилцан зөвлөлддөг.

Нөгөө талаас RIA нь бизнес, төрийн бус байгууллага эсвэл төр, захиргааны байгууллагын санал болгож буй аливаа зохицуулалтын үр нөлөөг зардал, үр ашиг, эрсдэлээр үнэлдэг бодлогын хэрэгсэл юм. RIA-ийн үндсэн зорилго нь зохицуулалтыг нийгмийн сайн сайхан байдлын үүднээс авч үздэг. Өөрөөр хэлбэл зохицуулалтын үр өгөөж зардлаас давж байгааг батлах явдал чухал байдаг. RIA-г ашигладаг улс орнуудын засгийн газар зохицуулалтын зардал, нөлөөллийн дөрвөн үндсэн зорилтыг тодорхойлсон.

- ✓ Засгийн газрын үйл ажиллагааны үр ашиг, зардлын аль алиныг нь багтаасан бодит нөлөөллийн талаарх ойлголтыг дээшлүүлэх;
- ✓ Бодлогын олон зорилтыг нэгтгэх;
- ✓ Ил тод байдал, зөвлөгөөг сайжруулах;
- ✓ Төрийн хариуцлагыг сайжруулах;

Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ яагаад чухал вэ?²⁹⁴

RIA нь хуулийн төсөл бичигдэхээс өмнө хийгддэг. Энэ нь бодлогын зөвхөн нэг хувилбарыг үнэлдэггүй. Заримдаа хууль тогтоомжийн бус арга хэмжээ нь нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн шийдэл байж болохыг харуулдаг. RIA нь төлөвлөсөн зохицуулалтыг дэмжих үндэслэлтэй аргуудыг гаргахад тусалдаг тул сайн чанарын хууль боловсруулахад чухал хүчин зүйл болох боломжтой. Ялангуяа хуулийн давхардал гаргахад зайлсхийх, төрийн хүнд суртлыг бууруулахад тусална.

3.2 Хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ, олон улсын туршлага²⁹⁵

Хууль эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулах дараалал, анхаарах зүйлс

Хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний чанар нь хууль эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулах дараалал, үүнд оролцогч талууд, төслийг хянах, үнэлэх тогтолцооноос шалтгаалдаг гэж дүгнэж болно.

Арменийн туршлагаас²⁹⁶ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ хийдэг бөгөөд үнэлгээчин нь санал болгож буй шийдвэрийн төсөл санаачлагч, аль эсхүл энэ чиглэлээр холбогдох салбарын яамыг төлөөлсөн шинжээч байж болно.

²⁹³ <https://eese-toolkit.itcilo.org/index.php/en/toolkit/toolkit-part-2/section-2-3/assessment-tool-12/what-is-a-regulatory-impact-assessment.html>

²⁹⁴ <https://www.oecd.org/gov/regulatory-policy/45706745.pdf>

<https://www.google.com/search?q=GUIDELINES+FOR+THE+REGULATION+IMPACT+ASSESSMENT+%28RIA+%29+Poland>

²⁹⁵ CEPA strategy guidance note on Regulatory impact assessment February 2021,

<https://unpan.un.org/sites/unpan.un.org/files/Strategy%20note%20regulatory%20impact%20assessment%20Mar%202021.pdf>

²⁹⁶ https://www.legislationline.org/download/id/8103/file/Armenia_regulatory_impact_assessment_manual_en.pdf

Төсөл боловсруулагч нь бодлогын санал, санал болгож буй шийдвэр, журмын төсөл боловсруулдаг төрийн байгууллагын мэргэжилтэн байх бөгөөд салбарын бусад яамдын нөлөөллийн үнэлгээчдэд баталгаажуулалт хийлгэж илгээхээс өмнө нөлөөллийн анхны үнэлгээг хийдэг.

Франц улсын хувьд²⁹⁷ хууль, эрх зүйн зохицуулалтын чанарыг дээшлүүлэхэд дараах үйл явц чухал болохыг онцлон тэмдэглэжээ. Эдгээр нь:

- Шинээр хууль, журам гаргах үйл явцыг чанаржуулах, үргэлжлүүлэн бэхжүүлэх.
- УИХ-ын гишүүдийн санаачилсан зохицуулалтыг шинээр гаргах арга, зарчмыг чангатгах;
- Нөлөөллийн үнэлгээнд талуудын оролцоо, хамтын дүгнэлт, зөвлөмжийг бүтээлчээр тусгах;
- Зардлыг тооцоолох зэрэг арга зүйн хэрэгслийг хөгжүүлэх, ашиглах, санд хадгалах мэдээллийн хангалттай нөөцийг бий болгох;
- Нөлөөллийн үнэлгээг тогтоолын төслийн хүрээнд өргөжүүлэн авч үзэх, УИХ-ын гишүүдийн санаачилсан хуулийн төслүүд болон УИХ-ын нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслүүдийг ижил төстэй аргаар боловсруулахыг дэмжих;
- Эдийн засагчдыг нөлөөллийн үнэлгээ хариуцсан багуудад оруулж ажиллуулах, дадал, соёлын өөрчлөлтийг дэмжих зорилгоор яамдуудад сургалтын нэгдсэн хөтөлбөрийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх;
- Нөлөөллийн урьдчилан үнэлгээ, бодит хэрэгжилт хоёрыг нэгтгэж үнэлэлт, дүгнэлт өгөх; зэрэг болно.

Хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх алхамууд

2021 оны 2-р сард Нэгдсэн үндэсний байгууллагын төрийн захиргааны асуудал эрхэлсэн хорооноос (The United Nations Committee of Experts on Public Administration) хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхтэй холбоотой зөвлөмж, гарын авлагыг боловсруулж гаргасан бөгөөд энэхүү гарын авлагад хууль, эрх зүйн зохицуулалтын төсөлд зардал, үр ашгийн шинжилгээ хийх нь чухал болохыг онцолсон байдаг.

Хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ нь дараах алхамуудаар дамжин хийгддэг.

- 1) Асуудлыг тодорхойлох
- 2) Суурь хэмжилтийг тогтоох
- 3) Зорилго ба сонголтуудыг тодорхойлох
- 4) Шийдвэр гаргах шалгуур ба хөндлөнгийн логик үзүүлэлтүүдийг сонгох
- 5) Талуудтай зөвлөлдөх
- 6) Мэдээлэл цуглуулах, зардал, үр ашгийн шинжилгээ хийх
- 7) Төрөл бүрийн хувилбаруудыг харьцуулах
- 8) Сонголт хийх
- 9) Хязгаарлалт ба тодорхойгүй байдал
- 10) Хяналт шинжилгээ, үнэлгээ

Техник²⁹⁸

Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явц нь арга, техник сонгох, шийдвэр гаргахаас шалтгаалаад өөрчлөгдөж байдаг. Зардлыг тооцож, тодорхойлох нь үр ашгийг тооцож, тодорхойлохоос хялбар байдаг. Захиргааны байгууллагын нэмэлт ачаалал,

²⁹⁷ <https://www.oecd.org/gov/regulatory-policy/betterregulationineuropefrance.htm>

²⁹⁸ <https://unpan.un.org/sites/unpan.un.org/files/Strategy%20note%20regulatory%20impact%20assessment%20Mar%202021.pdf>

шууд зардлыг тодорхойлж, хэмжихэд стандарт зардлын загварыг ашигладаг. RIA-ийн чухал хэсэг бол сонголтуудыг өөр хооронд нь болон суурь нөхцөлтэй харьцуулах явдал байна.

Харьцуулалт хийхдээ дараах аргуудыг ашигладаг.

- Зардлын үр ашигт сонголтын хувилбарын шинжилгээ. Үр ашиг нь мэдэгдэж байгаа эсвэл зорилт нь тогтоогдсон үед засгийн газар эсвэл олон улсын байгууллагаас энэ арга техникийг ашиглаж сонголтуудыг харьцуулдаг.
- Үр ашиг-зардлын шинжилгээ. Энэ нь эдийн засгийн салбар дахь цэвэр үр өгөөжөөр сонголтуудыг эрэмбэлэхэд туслах мөнгөний үнэ цэнийн гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд дээр суурилдаг. Энэ техник нь динамик нөлөө болон бүтээмж, инноваци, худалдааны нөлөөллийг харгалзан үздэг.
- Олон шалгуурын шинжилгээ. Энэ нь сонголтуудыг ялгаатай шалгууруудаар эрэмбэлэх шаардлагатай үед ашиглагддаг.

Дараалал²⁹⁹

- Хэлэлцүүлэг ба оролцогч талуудын оролцоо-Нөлөөлөлд өртөж болзошгүй бүх оролцогч талууд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн саналыг RIA-н үйл явцын бүх үе шатанд тусгана.
- Асуудлын тодорхойлолт-Зохицуулалтаар дамжуулан шийдэх асуудлын мөн чанар, цар хүрээний үнэлгээг тоон үзүүлэлтээр тодорхойлно.
- Зорилго-Зохицуулалтын саналын бодлогын зорилтууд болон зорилгыг тодорхой томъёолно.
- Зохицуулалтын саналын тодорхойлолт-Одоо байгаа зохицуулалтын орчин, санал болгож буй хуулийн төслийг тайлбарлах, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага, төр захиргааны байгууллагыг тодорхойлох, хэрэгжүүлэх дүрэм, хэрэгжилтийг хангах стратегийг тодорхойлох;
- Хувилбаруудыг тодорхойлох-Тодорхойлсон асуудлын боломжит шийдэлд тооцогдох зохицуулалтын бус аргуудыг багтаасан практик хувилбаруудын жагсаалтыг гаргах;
- Үр ашиг, зардлын шинжилгээ-Өмнөх алхмуудад тодорхойлсон хувилбаруудаас хүлээгдэж буй үр ашиг, зардлыг тооцох;
- Давууд үзэж сонгосон шийдлийг тодорхойлох-Тодорхойлсон зохицуулалтын санал нь авч үзсэн хувилбаруудаас яагаад давуутай болохыг тоймлон харуулна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох-зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх, шаардлагатай мэдээллийг урьдчилан тодорхойлох.

Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээний шилдэг туршлагын зарчмууд³⁰⁰

- Цар хүрээг тодорхойлох, ил тод байдал, оролцоог хангах;
- RIA-ийн засаглал: зөв зохион байгуулалт эсвэл системийн дизайнтай байх;
- Захиргаа, удирдлагын чадавх, хариуцлагыг бэхжүүлэх замаар RIA-г нэвтрүүлэх;
- Зорилтод нийцсэн RIA аргачлалыг нэвтрүүлэх;
- RIA-г тасралтгүй хянах, үнэлэх, сайжруулах зэргийг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гишүүн орнууд хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тооцох тэргүүлэх туршлагад тооцож байна.

²⁹⁹ <https://knowwww.eu/nodes/5d36cf92173ff1da1be52b2f>

³⁰⁰ Best practice principles for regulatory impact analysis, <https://www.oecd-ilibrary.org/sites/663f08d9-en/index.html?itemId=/content/component/663f08d9-en>

Хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх нэгээхэн чухал хэсэг нь зардал, үр ашгийн шинжилгээ хийх явдал байдаг болох нь олон улсын байгууллагын зөвлөмж, гадаад орнуудын, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын туршлага болон онол, арга зүйн судалгаанаас тодорхой харагдаж байна.

Дөрөв. Хууль, тогтоомжийн төслийн өртөг тооцох, зардал, үр нөлөөний шинжилгээ хийх алхам, арга зүй, улс орнуудын туршлага

4.1 Зардал, үр ашгийн шинжилгээ, онол, арга зүй³⁰¹

Net present value-г NPV гэж тэмдэглэе.

$$NPV = \sum_{n=1}^N \frac{R_t - E_t}{(1 + k_t)^n} = \frac{B_1}{(1 + k_1)^1} + \frac{B_2}{(1 + k_2)^2} \dots \frac{B_N}{(1 + k)^N} - I(0)$$

NPV	Цэвэр өнөөгийн үнэ цэнэ
R	Өгөөж буюу орох урсгал
E	Зардал буюу гарах урсгал
k	Хорогдуулалтын хувь
N	Хууль, эрх зүйн зохицуулалтын үйлчлэх цаг хугацаа
I(0)	Анхны хөрөнгө оруулалт-Initial investment

Онолын хувьд B буюу benefit нь цэвэр мөнгөн урсгалыг илэрхийлнэ. Энэ нь орох болон гарах мөнгөн урсгалын зөрүү юм. K буюу хорогдуулалтын хувийг хувийн секторын бизнес санхүүжилтийн дундаж зардлаар тооцдог. Цэвэр мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэ цэнийг дараах хамаарлаар илэрхийлбэл энэ нь санхүүжилтээ төлсөний дараах тухайн бизнест үлдэж байгаа цэвэр хөрөнгө болно.

$$PV = \frac{B_1}{(1 + k_1)^1} + \frac{B_2}{(1 + k_2)^2} + \dots \frac{B_N}{(1 + k_n)^N}$$

NPV = PV – Initial Investment буюу цэвэр өнөөгийн үнэ цэнэ нь санхүүжилтийн зардлаа төлөөд бизнест шинээр үлдэж байгаа үнэ цэнээс анхны хөрөнгө оруулалтын мөнгөн дүнг хассан ялгавраар тодорхойлогдох бөгөөд энэ нь эерэг утгатай байвал төслийг хэрэгжүүлэх боломжтой байх наад захын шалгуур хангагдаж байна гэж үздэг.

Дээрх аргыг нийгмийн бараа бүтээгдэхүүний хувьд (хууль эрх зүйн зохицуулалтаас бий болох) нэлээд өвөрмөц хэлбэрээр тооцдог онцлогтой. Үүнд: Benefit-ийг эдийн засагт бий болгож буй эерэг, сөрөг талуудыг мөнгөн агуулгаар тооцож гаргадаг бол, хорогдуулалтын хувийг ихэвчлэн алдагдсан боломжийн зардлаар төлөөлүүлэн сонгож тооцоолол хийдэг. Тухайлбал нийгмийн бараа, бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдсан хөрөнгийн санхүүжилтийг Засгийн газраас дайчилсан бол тэрхүү хөрөнгийг үндсэндээ татварын орлогоор санхүүжүүлдэг. Тэгвэл хорогдуулалтын хувийг тооцоходоо хувийн сектор татвар төлөөгүй байсан бол чөлөөлөгдсөн мөнгөн хөрөнгөөрөө ямар өгөөж олох байсан болохыг харгалзан үздэг байна³⁰². Хорогдуулалтын хувийг алдагдсан боломжийн зардлаас гадна зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа бизнесүүдийн өгөөжийн дундаж хувиар тооцох болох боломжтой гэж үздэг. Түүнчлэн эдийн засагт мөнгөн

³⁰¹ https://web.uniroma1.it/dip_management/sites/default/files/CH12_1_0.pdf

³⁰² Public finance 8th edition, Harvey S.Rosen, 2012

хөрөнгийн хуваарилалтын зорилго зөвхөн ашгийн төлөө бус хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг. Үүнтэй холбоотойгоор хорогдуулалтын хувийг зарим үед цаг хугацааны уртад өөрчлөгдөж байдаг хэрэглээний ахиуц ханамжийн налалт, хэрэглээний өсөлтөөр тодорхойлж болно гэж үздэг.³⁰³

Эдгээр нь сонгон хэрэгжүүлж байгаа төсөл, өрсөлдөгч сонголттой харьцуулахад харьцангуй өндөр өгөөжтэй байж чадаж байгаа эсэхийг тогтооход ашиглагддаг гэсэн үг. Ингээд тооцож гаргасан цэвэр өнөөгийн үнэ цэнэ 0-ээс их утгатай байвал, сонголтыг хэрэгжүүлэх боломжтой хувилбар мөн гэж үзнэ. Үүнийг судлаачид хэрэгжүүлэх төслийн хүрээнд хангавал зохих наад захын шалгуур үзүүлэлт гэж нэрлэдэг. Харин хэд хэдэн сонголтуудыг харьцуулах хэрэгтэй болсон тохиолдолд наад захын шалгуур үзүүлэлтийг хангасан хувилбаруудыг үнэлж, эрэмбэ дараалал тогтоох хэрэгтэй болох юм.


Тухайн нийгмийн бараа, бүтээгдэхүүнийг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан санхүүжүүлж байгаа бол хорогдуулалтын хувийг жигнэсэн дундаж байдлаар тооцдог. Түүнчлэн зардал, үр ашгийн шинжилгээг хууль, тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцоолох зорилгоор хийх үйл явцыг нэмэлт аргуудаар дэмжиж болно.

Тухайлбал эдийн засагт бий болгож буй зардал, үр өгөөжийг тооцож өгөөжийн дотоодын хувь (Internal rate of return), өгөөжийн сайжруулсан дотоод хувь (Modified internal rate of return), монтекарло симуляц (Montecarlo simulation), мэдрэмжийн шинжилгээ (Sensitivity analysis), олон шалгуур үзүүлэлт бүхий шинжилгээ (Multicriteria analysis) зэргийг дурдаж болно. Ингээд эдгээр аргуудаар хамгийн сайн үнэлэгдсэн хууль, тогтоомжийн төсөл бол мөнгөн агуулгаараа (in terms of money) эдийн засагт хамгийн өндөр үр өгөөжийг өгч чадна гэж үзэж болно.

Манай улсын болон гадаад орнуудын хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх арга зүйн хүрээнд хууль, тогтоомжийн төслийн зардал, үр ашгийн шинжилгээ нь зөвхөн хангавал зохих шалгуур үзүүлэлтүүдийн мөнгөн агуулгаар илэрхийлэгдсэн нэг үзүүлэлт болж байдаг. Жишээ нь: хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрх.. гэх зэрэг чанарын олон шалгууруудаар сонголтын үйл явцыг чанарыг баталгаажуулдаг.

Хууль эрх зүйн зохицуулалт эдийн засгийн секторт илүү нөлөө үзүүлэхээр онцлогтой байгаа үед зардал, үр ашгийн шинжилгээний тооцоолол төвөгшил харьцангуй багатай байдаг гэж хэлж болно.

Ерөнхийдөө зохицуулалтын хүрээнд бий болсон үр ашгийн хүлээгдэж буй утга хэдий чинээ хэлбэлзэлтэй байна, энэ нь тэр хэмжээгээр тодорхойгүй байдал ихтэй байгааг харуулах бөгөөд эрсдэлийн нөлөөгөөр хорогдуулалтын хувь нэмэгдэж цэвэр өнөөгийн үнэ цэнийн утга харьцангуй буурч тооцогддог байна.



³⁰³https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/935551/Social_Discount_Rates_for_Cost-Benefit_Analysis_A_Report_for_HM_Treasury.pdf

Хүснэгт 9. Зардал, үр ашгийн шинжилгээний давуу, сул тал³⁰⁴

Давуу тал	Сул тал
Бодлогын зэрэг, сөрөг нөлөөг тооцдог.	Хэмжиж болохгүй үр нөлөөг хамруулдаггүй.
Бодлогын хувилбарын зардал үр нөлөөний харьцуулалтыг цаг хугацаагаар нь харгалзуулан хийх боломжтой.	Нэмэлт шинжилгээ шаардлагатай.
Бодлогын саналуудын цэвэр өгөөж, алдагдлыг тооцож, харьцуулалт хийж болно.	Нийгмийн болон хүрээлэн буй орчны үр нөлөөг тооцоход төвөгтэй.
	Төрөл бүрийн техникийн үр чадвар, цаг хугацаа, зардал шаарддаг.

Эх сурвалж: <http://regulatoryreform.com/wp-content/uploads/2015/02/Montenegro-USAID-RIA-Manual-2011.pdf>

4.2 Австрали улс³⁰⁵

2020 онд Австрали улсын Засгийн газраас гаргасан хууль, тогтоомжийн төслийн зардал, үр ашгийн шинжилгээ нь дараах алхамуудаас бүрдэнэ гэж үзжээ.

Хүснэгт 5. Зардал, үр ашгийн шинжилгээ хийх алхам

Алхам	Үйл явц
1	Зохицуулалтын хувилбаруудыг тодорхойлох
2	Зардал, үр ашиг хамаарах оролцогчдыг тогтоох
3	Үр нөлөөг тодорхойлох, хэмжих индикаторуудыг сонгох
4	Санал болгосон эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үйлчлэх хугацааных нь хувьд таамаглах
5	Үр нөлөөг мөнгөөр хэмжих
6	Өнөөгийн үнэ цэнийг нь гаргаж авахын тулд ирээдүйн өртөг, үр өгөөжийг нь хорогдуулах
7	Хувилбар бүрийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг тооцоолох
8	Мэдрэмжийн шинжилгээ хийх
9	Дүгнэлт гаргах

Эх сурвалж: <https://obpr.pmc.gov.au/resources/guidance-assessing-impacts/cost-benefit-analysis>

4.3 Тайланд улс³⁰⁶

2018 онд Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Тайланд улсын хууль зүйн яамнаас хамтран хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг шинжлэх гарын авлагыг Засгийн газарт зориулан гаргасан байна. Энэхүү гарын авлагад хууль, тогтоомжийн төслийн зардал, үр өгөөжийн шинжилгээ нь дараах алхамуудаас бүрдэнэ гэж үзжээ.

1. Зохицуулалтын нөлөөнд өртөх оролцогчдыг тодорхойлох
2. Зардал, үр өгөөжийн төрлүүдийг тогтоох
3. Зардал, үр өгөөжийг үнэлэх
4. Шийдвэр гаргалтын шалгуур үзүүлэлтийг ашиглаж, оновчтой хувилбарыг сонгох

³⁰⁴ <http://regulatoryreform.com/wp-content/uploads/2015/02/Montenegro-USAID-RIA-Manual-2011.pdf>

³⁰⁵ <https://obpr.pmc.gov.au/resources/guidance-assessing-impacts/cost-benefit-analysis>

³⁰⁶ <https://aimp2.apec.org/sites/PDB/Supporting%20Docs/2487/Completion%20Report/EC%2008%2014A%20Thailand%20RIA%20Guidelines.pdf>

4.4 Канад улс³⁰⁷

Канад улсын Засгийн газрын санхүүгийн асуудал эрхэлсэн хороо³⁰⁸ 2007 онд Засгийн газрын яам, агентлагуудад зориулсан зардал, үр ашгийн шинжилгээ хийх гарын авлагыг гаргасан байдаг. Энэхүү гарын авлагад зардал үр ашгийн шинжилгээг дараах алхамуудаар хийдэг болохыг дурджээ.

1. Асуудал, эрсдэл, суурь нөхцөлүүдийг тодорхойлох;
2. Зорилтуудыг томъёолох;
3. Зохицуулалтын болон зохицуулалтын бус сонголтуудын хувилбарыг тодорхойлох;
4. Зардал, үр ашгийг үнэлэх: Гол нөлөөллийг тодорхойлох, зардал, үр нөлөөг хэмжих, хорогдуулалтын хувийг тооцох, зардал, үр дүнтэй сонголтын шинжилгээ, оролцогч талуудад үзүүлэх нөлөөлөл, ажил эрхлэлт, хэрэглэгч, хувь хүмүүс, засгийн газар, бусад оролцогчдод үзүүлэх нөлөөлөл;
5. Тайлан гаргах: хувилбар бүрийн хувьд зардал, үр ашгийн шинжилгээ хийх, хувилбар бүрийн хувьд оролцогчийн шинжилгээ хийх.

4.5 Шинэ Зеланд улс³⁰⁹

Шинэ Зеланд улсын засгийн газраас зардал, үр ашгийн шинжилгээ хийх гарын авлагыг 2015 онд боловсруулж гаргасан бөгөөт тус гарын авлагад зардал үр ашгийн шинжилгээг дараах алхамуудаар хийдэг болохыг тайлбарласан байна.

1. Бодлого, зохицуулалтын боломжит хувилбаруудыг тодорхойлох;
2. Хэн хожиж, хэн алдагдал хүлээхийг тогтоох;
3. Зардал, үр ашгийг тооцоолох: Сөрөг утгатай зардал, давхар тооцоолол, гадаад хүчин зүйлийн нөлөө, өдөөгдсөн зан төлөв, татвар ногдуулалтаас хүлээх алдагдал;
4. Зардал, үр ашгийг үнэлэх-Үүнд:
үр ашиг нь төлөхөд бэлэн байгаа мөнгөн дүнгээр, зардал нь алдагдсан боломжийн зардлаар тодорхойлогдох
 - Үнэлгээ эрсдэлийг шингээсэн байх;
 - Үнэлгээ тодорхойн тоон завсарт байх;
 - Үнэлгээ хууль, эрх зүйн зохицуулалтын үйлчлэх хугацааг хамруулсан байх;
 - Зардал, үр ашиг нь инфляцын нөлөөг харгалзсан байх.
5. Хорогдуулалтын хувь, зардал, үр нөлөөний үнэлгээг харьцуулах: NPV (Net present value), BCR (Benefit to cost ratio), MIRR(modified internal rate of return) зэргийг харьцуулах учиртай байдаг байна.
6. Зардал үр ашгийн үнэлгээг харьцуулах, нэмэлт судалгаа хэрэгтэй эсэхийг тогтоох

Тав. Бодлогын өртгийг тооцоолох үйл явц

5.1 Онол, арга зүй

Бодлогын өртгийг тооцоолох үйл явц нь хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний нэгээхэн чухал хэсэг байдаг.³¹⁰

³⁰⁷ <https://www.tbs-sct.gc.ca/rtrap-parfa/analys/analys-eng.pdf>

³⁰⁸ The Treasury Board of Canada Secretariat is the administrative branch of the Treasury Board of Canada (the committee of ministers responsible for the financial management of the federal government)

³⁰⁹ <https://www.treasury.govt.nz/sites/default/files/2015-07/cba-guide-jul15.pdf>


³¹⁰ Best practice principles for regulatory impact analysis

Бодлогын өртөг тооцох (Policy costing) гэж юуг хэлэх вэ?³¹¹

УИХ-ын Төсвийн шинжилгээний албаны бодлогын зардлын тооцооллын хүрээнд бодлого хэрэгжсэн тохиолдолд санхүүгийн гол үзүүлэлтүүдэд гарч болзошгүй өөрчлөлтийг харьцуулан тооцдог. Бодлого хэрэгжсэнээр гарах өөрчлөлтийг бодлого хэрэгжээгүй байх үеийн нөхцөл байдалтай харьцуулж санхүүгийн үр нөлөөний ялгаатай талуудыг тодорхойлохоос гадна санхүүгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлдог.

Дараах зураг бодлогын өртөг тооцооллыг үндсэн элементүүдийг харуулав.

Зураг 1. Бодлогын өртөг тооцох цаг хугацааны үзүүлэлт



Эх сурвалж: Парламентын төсвийн шинжилгээний алба, Австрали

Суурь үзүүлэлт нь бодлогын өртөг тооцох эхлэлийн цэг бөгөөд бодлогын өртөг нь санхүүгийн гол үзүүлэлтүүдийн засгийн газрын төсөөллийг илэрхийлдэг. Австралийн Санхүү, эдийн засгийн яам засгийн газрын бодлого, тэргүүлэх чиглэлд үндэслэн эдгээр төсөөллийг тогтмол шинэчилж, нийтэлдэг. УИХ-ын гишүүний зүгээс төсвийн шинжилгээний албаны мэргэжилтэнд хандан хүсэлт гаргаснаар бодлогын зардал тооцогдох үйл явц эхэлдэг. Төсвийн шинжилгээний алба нь бодлогын үр нөлөөг тооцоолохын тулд бодлогын хэрэгжилтийн үндсэн параметрууд болох суурь орлого, зардал, хөрөнгө, цэвэр позитив үзүүлэх нөлөөллийг үнэлдэг.

Бодлогын хэрэгжилт улсын төсөв, цаашдын үр дүнд ямар нөлөө үзүүлэхийг тодорхойлж байгаа тул гишүүний хувь захиалгын бодлогын өртөг тооцооллын үр нөлөөг мэдээлдэггүй. Сонгуулийн өмнөх болон сонгуулийн дараах тайланд бодлогын зардлын бодлогын дараах нөлөөллийг тусгадаг. Энэ хүрээнд одоогийн төсвийн жил болон дараагийн гурван жилийн нөлөөллийн тооцоог гаргадаг. Ил тод байдлыг хангахын үүднээс нэмэлт долоон жилийн хугацааны санхүүгийн нөлөөллийг тооцож, дүнд хугацааны үнэлгээ хийдэг.

Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт 5-д Засгийн газрын санхүүгийн гол үзүүлэлтүүдийн төсөөлөлд нийцүүлэх бодлогын зардлыг тооцоолоход ашигладаг санхүүгийн гол үзүүлэлтүүдийн тоймыг харуулав.

³¹¹ <https://pbo.vic.gov.au/What is a policy costing%3F>

Хүснэгт 6. Санхүүгийн гол үзүүлэлтүүд

Нөлөөлөл	Индикатор	Тодорхойлолт
-	Орлого	<ul style="list-style-type: none"> Татвар, хүү, торгуулийн орлого, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт Төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтын ногдол ашиг Тэтгэлэг
	Зардал	<ul style="list-style-type: none"> Нийгмийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, ажиллагсадтай холбоотой зардал өсөх Төрийн байгууллагад олгох татаас нэмэгдэх
=	Үйл ажиллагааны цэвэр баланс	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн жилд хамаарах орлого, зардлын зөрүү Ажил гүйлгээний цэвэр үр дүн
+, -	Хөрөнгө	<ul style="list-style-type: none"> Бодит болон санхүүгийн хөрөнгө худалдаж авах, зарах Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгийг дахин үнэлэх
=	Хөрөнгийн цэвэр дүн (цэвэр позиц)	<ul style="list-style-type: none"> Бодлогын үр нөлөөний харьцуулалт хийх боломжийг олгох Хөрөнгө, мөнгөн урсгалд гарсан цэвэр өөрчлөлт тодорхойлогдоно.

Эх сурвалж: Парламентын төсвийн шинжилгээний алба, Австрали


Бодлогын нөлөөллийн санхүүгийн хамгийн чухал үзүүлэлт бол цэвэр позицод гарсан өөрчлөлт юм. Энэ нь улсын орлого, төрөөс төлсөн зардал, хөрөнгийн өөрчлөлтийг хэмждэг. Хөрөнгийн хөдөлгөөнийг тусгах нь бодлогын өөрчлөлтийг харьцуулах боломжийг олгодог. Үйл ажиллагааны цэвэр тэнцлийн өөрчлөлт нь улсын орлогын болон зардлын нөлөөллийн ялгааг илэрхийлнэ. Энэ нь бодлого хэрэгжсэн тохиолдолд гарах санхүүгийн тогтвортой байдлыг харуулах үзүүлэлт юм. Үүнийг төсвийн ашиг, алдагдал ч гэж нэрлэдэг.

Бодлогын санхүүгийн нөлөөллийг тодорхойлохдоо санхүүгийн үзүүлэлтүүдийг орлогын нөлөөлөл, зардлын нөлөөлөл, хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээнд үзүүлэх нөлөөллийн өртгийн бүрдэл хэсгүүдэд хувааж ангилдаг.

Үр нөлөөний төрлүүд

Бодлогын өртгийн тооцоололд ямар нөлөөллийг оруулахыг талаар шийдвэр гаргахдаа бодитой байдал, бодлогын үр дүнд гарах өөрчлөлт, бодлоготой шууд холбоотой зан үйлийн нөлөөллийг харгалзан үздэг. Дараах зурагт бодлогын өртөг тооцохдоо авч үзэх нөлөөллийн төрлийг онцгой албан татварын жишээн дээр харуулав.

Зураг 2. Онцгой албан татварын өөрчлөлтийн үр нөлөө



Эх сурвалж: Парламентын төсвийн шинжилгээний алба, Австрали

Хүснэгт 7. Бодлогын үр нөлөөний төрлүүд

Статик шууд нөлөө	Зан төлөвийн Шууд нөлөөлөл	Өргөн хүрээний санхүүгийн үр нөлөө	Өргөн хүрээний эдийн засгийн үр нөлөө
<ul style="list-style-type: none"> ▪ Бодлогын үр нөлөө үйлчлэх оролцогчдын зан төлөвт төдийлөн өөрчлөлт гарахгүй байх ▪ Өдөөгч үзүүлэлтүүд өөрчлөгдөхгүй байх ▪ Өртөг тооцооллын бүрэлдэхүүн хэсгүүд 	<ul style="list-style-type: none"> ▪ Бодлого оролцогчдын зан төлөв, хариу үйлдэлд шууд нөлөөлнө. ▪ Тухайлбал татварын татварын өсвөл, татварын дараах орлого багасч эрэлт буурна. 	<ul style="list-style-type: none"> ▪ Эдийн засагт гарсан өөрчлөлт нь төсөвт нөлөөлнө. ▪ Жишээ нь: Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого нь цалинг өсгөж, цалингийн татварыг нэмэгдүүлнэ. ▪ Нөлөөлөл нь дам байдалтай. 	<ul style="list-style-type: none"> ▪ Зардал, үр ашгийн шинжилгээ хийх ▪ Үндэсний нийт бүтээгдэхүүн, цалин зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд гарах өөрчлөлтийг авч үзнэ. ▪ Төсвийн шинжилгээний алба макро эдийн засаг хариуцсан нэгжтэй хамтран ажиллаж болно.
Үргэлж тооцох боломжтой.	Үр нөлөө гарах үед тооцох боломжтой.	Заримыг нь тооцох боломжтой.	Тооцоход бэрхшээлтэй.

Эх сурвалж: Парламентын төсвийн шинжилгээний алба, Австрали

Бодлогын өртөгт харгалзан үзэх эдийн засгийн янз бүрийн нөлөөллийн хамаарлыг хүснэгт 6-д нэгтгэн харуулав. Эдийн засгийн нөлөөлөл нь бодлогын сонголтын шалтгаан болдог. Гэхдээ төсөвт үзүүлэх нөлөөллийг тусгаагүй байдаг.

Бодлогын өртөг тооцох жишээ авч үзье. Засгийн газар шинээр төлбөртэй зам ашиглалтад орвол орлогын нөлөөллийг тооцох боломжтой. Орлогын шууд статик хандлага нь одоо байгаа замын ашиглалтын загварт (төлбөргүй) үндэслэн замын хөдөлгөөнийг төсөөлдөг. Өөрөөр хэлбэл төлбөртэй зам байгаа эсэхээс үл хамааран замын ашиглалт өөрчлөгдөхгүй гэж үзнэ. Төлбөртэй зам байгаа нь зарим жолоочийн зан төлөвт дараах байдлаар нөлөөлнө.

- Зарим жолооч нар шинэ замыг ашиглана.
- Зарим жолооч нар төлбөртэй зам ашиглахаас татгалзана.
- Одоо ашиглагдаж байгаа замын оронд барьж байгуулсан шинэ замаар зорчих жолооч нарт нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх иргэд дурамжхан байна.

Жолооч нарын зан үйлийн шууд хариу үйлдэл нь төлбөртэй зам ашиглалтаас олох орлогод нөлөөлөх нь тодорхой. Зам ашигласны төлбөр байгаа эсэх нь төлбөр хураамжийн орлогоос гадна засгийн газрын орлогод өөр нөлөө үзүүлж болзошгүй. Шинэ замын системийн (төлбөртэй замыг оруулаад) талаарх хувь хүний үнэлгээ нь хүн амын дунд янз бүрийн хариу үйлдэл үзүүлэхэд хүргэж болно. Зарим хүмүүс машин жолоодоход илүү татагдаж, улмаар олон хүн автомашинтай болж, авто тээврийн хэрэгслийн татварын орлого нэмэгдэж, нийтийн тээврийн орлого буурдаг. Төсвийн эдгээр өргөн хүрээний үр нөлөөг бодлогын зардалд тэр бүр тусгадаггүй. Төлбөртэй зам байгаа нь зам тээврийн салбарын бүтээмж нэмэгдэх, жолооч нарын чөлөөт цагийг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжрах, түгжрэл багасах зэрэг эдийн засгийн өргөн хүрээтэй эерэг үр дагаваруудыг бий болгож болох юм. Эдгээр нөлөөлөл нь бодлогын зардалд хамаарах төсвийн үзүүлэлтүүдэд тусгагдаагүй байж болно.

Санхүүгийн нөлөөлөл

Хүснэгт 8-д санхүүгийн гол үзүүлэлтэд хамаарах бодлогын нөлөөллүүдийг үзүүлэв. Эдгээр нь засгийн газрын салбарын суурь үзүүлэлтэд (Төсвийн шинжилгээний нэгжээс зардлын анхаарал хандуулдаг) нөлөөлөх орох, гарах чиглэлтэй урсгалуудыг харуулна. Засгийн газар нь төрийн хяналтад байдаг бүх байгууллагыг төлөөлдөг.

Хүснэгт 8. Санхүүгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөх бодлогын нөлөө

Орлого		Зардал		Хөрөнгө	
Орлого өсөх	Орлого буурах	Зардал өсөх	Зардал буурах	Хөрөнгө өсөх	Хөрөнгө буурах
Шинэ татвар	Татварын хувь багасах	Шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг зогсоох,	Хөрөнгө, дэд бүтэц барих, худалдаж авах	Хөрөнгө зарж борлуулах
Бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого нэмэгдэх	Шилжүүлэг багасах	Ажиллах хүч өсөх	Төр, захиргааны байгууллагын бүтэц, орон тоо хумигдах	Төр, захиргааны байгууллагын хөрөнгө оруулалтын зардал өсөх	Төр, захиргааны байгууллагын хөрөнгө оруулалтын зардал буурах
Ногдол ашиг, хүүний төлбөр өсөх	Ногдол ашиг, хүүний төлбөр буурах	Төр, захиргааны байгууллагын бүтэц, орон тоо нэмэгдэх	Үйлчилгээг хөнгөвчлөх		
Хураамж, торгууль өсөх	Хураамж, торгууль буурах	Өрийн үйлчилгээний зардал, өмчийн өртөг өсөх	Өрийн үйлчилгээний зардал, өмчийн өртөг буурах		
Хөрөнгийн борлуулалт нэмэгдэх					
Засгийн газрын сектор					

Эх сурвалж: Парламентын төсвийн шинжилгээний алба, Австрали

Харгалзах бусад үзүүлэлтүүд

Хугацаа

Бодлогын санхүүгийн нөлөөлөл хэзээ гарах нь бодлогын өртөг тооцоход чухал ач холбогдолтой. Бодлого хэзээ эхлэхийг мэдсэнээр санхүүгийн шууд статик нөлөөллийн гарах хугацааг загварчлах боломжтой болно. Бодлого нь тодорхой хугацаанд үе шаттайгаар хэрэгжих хууль тогтоомжийн санхүүгийн шууд нөлөөллийг загварчлах цаг хугацааны баримжааг өгнө, аль эсвэл ижил төстэй туршлага дээр үндэслэн үйл явдал тохиох цаг хугацааны талаар дүгнэлт хийх боломжтой.

Бэлэн мөнгө, аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл

Тохируулах суурьтай нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үйл ажиллагааны цэвэр тэнцлийн санхүүгийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо орлогыг олсон үед нь (хүлээн авсан үед нь бус), зардлыг гарсан үед нь (төлбөр хийгдсэн үед нь биш) хүлээн зөвшөөрөх учиртай. Санхүүгийн цэвэр тэнцлийн үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийг тооцоходоо бэлэн мөнгөний орох, гарах урсгалууд, тэдгээрийн тохиох цаг хугацааг харгалзан үздэг. Орох, гарах урсгал тэнцвэртэй байх нь төсвийн эрүүл байдлын үзүүлэлтэд шууд нөлөөтэй байдаг.

Хэн бодлогын өртөг тооцооллыг хийлгэх вэ?

Парламентын аль ч гишүүн бодлогын өртөг тооцоолол хийлгэх хүсэлт гаргаж болно. Бодлогын өртөг тооцоо хүсэлтийг хүлээн авах урьдчилсан нөхцөл нь бодлогын агуулгыг хангалттай тайлбарласан байх явдал юм. Олон нийт бодлогын өртөг тооцоолол хийлгэх боломжгүй хэдий ч бодлогын өртгийн тооцооллын талаар цахим хаягнаас харах практик нийтлэг байдаг.

Бодлогын өртгийн тооцоолол үнэ цэнийг хэрхэн нэмэгдүүлдэг вэ?

Үр дагавар, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харьцуулах боломж

Засгийн газрын үндсэн зарчим бол санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Энэ нь засгийн газрын орлого нь цаг хугацааны явцад гаргасан үйл ажиллагааны болон хөрөнгийн зардлыг тэнцвэржүүлэх ёстой гэсэн санааг илэрхийлнэ. УИХ-ын гишүүд бодлогын хувилбаруудыг боловсруулж байгаагийн хувьд бодлогын параметруудийн санхүүгийн үр дагаврыг ойлгох нь чухал юм. Бодлогыг батлахаас өмнө олон удаа боловсруулах шаардлага гарч ирж болно. Гол үзүүлэлт бол бодлогын зорилт, санхүүгийн үр дагаврын хамгийн оновчтой түвшнийг тогтоох явдал байна.

Парламентын төсвийн шинжилгээний нэгж нь бодлогын өртгийн тооцооллыг харьцуулахуйц байдлаар гаргадаг бөгөөд энэ нь парламентын гишүүд мөрийн хөтөлбөрийнхөө санхүүгийн үзүүлэлтийг бие даасан байдлаар тодорхойлох, бодлогын хувилбарууд болон хослолуудыг үнэлэх боломжийг олгоно. Санхүүгийн үр дагавар, хүлээн зөвшөөрөгдөхуйц байдлыг тодорхойлох, улс төрийн намуудын санал болгож буй бодлоготой харьцуулалт хийх зорилгоор бодлогын өртгийн тооцоолол хийлгэж болно. Бодлогын өртөг тооцооллын үйлчилгээ нь бодлогыг боловсруулах, парламентаар хэлэлцүүлэх, олон нийтийн зүгээс санал болгож буй бодлогын санхүүгийн үр дагаврыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

5.2 Австрали улс³¹²

Парламентын төсвийн албанаас бэлтгэдэг зардлын тооцоолол

Австрали Улсын Парламентын төсвийн алба (Parliamentary Budget Office) жил бүр олон тооны Зардлын тооцооллыг Парламентын гишүүдийн захиалгаар гаргаж өгдөг. Парламентын гишүүд нь төрийн төсөв, санхүүтэй холбоотой дор дурдсан зардал, санхүүгийн судалгааг хийлгэж, шийдвэр гаргахдаа ашигладаг.

- Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг төсөвт хэрхэн тусгасан талаарх зардлын тооцоолол судалгаа
- Тодорхой хугацаан дахь Төсвийн төсөөллийн талаарх судалгаа
- Тухайн бодлого, арга хэмжээ нь нийгмийн бүлэг нэгж тус бүрт хэрхэн нөлөөлж байгаа талаарх зардлын тооцооллын судалгаа

Парламентын төсвийн албанаас гаргадаг зардлын тооцооллын төрөл

Парламентын төсвийн алба 3 төрлийн зардлын тооцоолол хийдэг.

- Парламентын бүрэн эрхийн хугацаанд Парламентын гишүүд, сенаторуудын захиалгаар тухайн бодлого, арга хэмжээтэй холбогдсон зардлын тооцооллыг хийдэг. Зардлын тооцооллыг нийтэд ил болгох эсхүл, хаалттай байлгахыг захиалагчийн хүсэлтээр шийдвэрлэнэ.
- Парламентын сонгуультай холбогдон завсарласан үед Парламентын намын бүлгүүдийн эрх бүхий гишүүд эсхүл, эрх бүхий бие даагч нарын хүсэлтээр олон

³¹² What is a Parliamentary Budget Office costing?, https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Budget_Office/Publications/Information_papers

нийтэд зарласан бодлого, арга хэмжээний зардлын тооцооллыг хийдэг. Зардлын тооцооллыг бэлэн болсон үеэс нийтэд ил болгодог.

- Парламентын ээлжит сонгуулийн дараа Парламентын төсвийн алба нь Сонгуулийн дараах тайланг (Post-Election Report) бэлтгэн гаргадаг. Энэ тайланд дор хаяж 5 суудал авсан намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр төсөвт хэрхэн нөлөөлөх талаар тусгадаг. Тайланг нийтэд ил болгодог.

Парламентын төсвийн албанаас гаргадаг зардлын тооцоолол нь Засгийн газраас боловсруулсан тооцооллоос ангид бие даасан мэдээллийн эх үүсвэр болдог. Ингэснээр Парламентын гишүүдэд төсөв, санхүүгийн тоо баримт, мэдээллүүдийг харьцуулах боломжийг олгодог.

Зардлын тооцооллын зорилго

Парламентын төсвийн албанаас боловсруулж гаргадаг Зардлын тооцооллын зорилго нь Парламентын гишүүдийг төсөв санхүүгийн талаарх үнэн зөв, бие даасан, хараат бус тоо баримт, мэдээллээр хангахад оршино.

Зардлын тооцооллын зорилт

- Парламентаар хэлэлцэгдэж буй төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ нь Австрали Улсын төсвийн бодлогын хүрээнд тусгагдсаны дагуу санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх.
- Тухайн бодлого, арга хэмжээ нь төсөвт хэрхэн нөлөөлж буйг үнэлэх.

Зардлын тооцоололд тусгасан төсвийн нөлөөллийн хамрах хүрээ

Парламентын төсвийн албанаас боловсруулж гаргадаг зардлын тооцоолол нь тухайн хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ Австрали Улсын төсөвт хэрхэн нөлөөлж байгааг, төсвийн тэнцлийг хэрхэн өөрчилж байгааг тооцоолон харуулдаг. Төсөвт үзүүлэх нөлөөллийг судлахдаа дараах нөлөөллүүдийг судалдаг.

- ✓ **Шууд нөлөөлөл** – Өнөөгийн тоо баримтад тулгуурлан төсөвт үзүүлэх шууд санхүүгийн нөлөөллийг тооцоолдог.
Жишээ нь: Төсвийн орлогыг өсгөх зорилгоор НДШ-ийн хувь хэмжээг 10%-иас 12 болгож өсгөснөөр төсвийн орлого 20% нэмэгдэнэ.
- ✓ **Хариу үйлдлийг тооцсон нөлөөлөл** – Тухайн төлөвлөсөн бодлого, арга хэмжээний нөлөө нь шууд тусах хувь хүн, аж ахуйн нэгж ямар хариу үзүүлэх, энэхүү хариу үйлдэл нь Төсөвт хэрхэн нөлөөлөхийг тооцоолно.
Жишээ нь: НДШ-ийн хувь хэмжээ өссөнөөр байгууллагын зардал нэмэгдэж, ашиг буурна. Ингэснээр төлөх татварын хэмжээ багасч төсвийн орлого буурна.
- ✓ **Нийт эдийн засгийн нөлөөлөл** – Тухайн бодлого, арга хэмжээний Төсөвт үзүүлсэн нөлөөллийн улмаас нийт эдийн засагт ямар үр нөлөө үзүүлэхийг судална.
Жишээ нь: НДШ-ийг өсгөснөөр аж ахуйн нэгжийн ашиг буурч хөрөнгө оруулалт багасна. Аж ахуйн нэгжүүд цалин өсгөхөөс түдгэлзэх, ингэснээр иргэдийн орлого царцаж, эдийн засагт хэрэглээ өсөхгүй байх. Аж ахуйн нэгжүүд “дугуйтай цалин” олгох явдал нэмэгдэж, далд эдийн засаг тэлэх.

Ихэнх тохиолдолд нийт эдийн засгийн нөлөөлөл нь их биш эсхүл, тодорхойлох боломжгүй байдаг. Иймд Парламентын төсвийн албанаас боловсруулж гаргадаг Зардлын тооцоолол нь ихэвчлэн Төсөвт нөлөөлөх шууд нөлөөлөл болон хариу үйлдлийг тооцсон нөлөөллийг судлан харуулдаг.

Зардлын тооцоолол хийхэд тавигдах стандарт, шаардлага

Парламентын төсвийн албанаас гаргадаг Зардлын тооцооллыг хийхдээ Засгийн газраас Төсвийг боловсруулахад баримталдаг стандарт шаардлагыг мөрддөг.

Зардлын тооцооллыг хийхдээ “Төсвийн шудрага байх зарчмыг баримтлан Зардлын тооцоолол хийх гарын авлага”-ыг (Charter of Budgetary Honest Policy Costing Guidelines) удирдлага болгоно.

Зардлын тооцоололд тусгагдсан төсвийн нөлөөллийн хамрах хугацаа

Зардлын тооцоололд тухайн бодлого, арга хэмжээний төсөвт нөлөөлөх 10 жилийн хугацааны нөлөөллийг тусгадаг. Шаардлагатай бөгөөд тооцоолох боломжтой бол 10 жилээс дээш хугацааны төсвийн нөлөөллийн тооцооллыг хийдэг.

Зардлын тооцооллыг хийх үйл явц

Зардлын тооцоолол хийх үйл явц нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

1. Бодлого арга хэмжээний онцлогийг тодорхойлох
2. Тоо, баримтыг цуглуулах, үзүүлэлтүүдийн төсөөллийг тодорхойлох
3. Зардлын тооцоолол хийх арга, загварчлалыг боловсруулах
4. Зардлын тооцоолол үнэ зөв, бодит байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн танилцуулга

Зардлын тооцооллыг хийсний дараа Зардлын тооцооллын тайланг бэлтгэж захиалагч гишүүн, сенаторт хүргүүлнэ.

1. Бодлого арга хэмжээний онцлогийг тодорхойлох. Зардлын тооцооллын үйл явц нь тооцоолол хийх бодлого, арга хэмжээний онцлогийг тодорхойлохоос эхэлдэг. Захиалга ирүүлсэн Парламентын гишүүн эсхүл, намын бүлгээс тухайн бодлого арга хэмжээний талаар нарийвчилсан асуулга авна. Бодлого, арга хэмжээний онцлогийг тодорхойлох үйл явцын хүрээнд захиалагчаас авах асуулга нь дор дурдсан асуудлуудыг агуулсан байна.

- Тухайн хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний зорилго, зорилтыг тодруулах.
- Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй бодлого, арга хэмжээнд ямар өөрчлөлт оруулахыг зорьж байгааг зүйл тус бүрээр нь нарийвчлан тодруулах. Үүнд:
 - Тэтгэмжийн өөрчлөлт орсон эсэх;
 - Төлбөрийн хувь хэмжээний өөрчлөлт орсон эсэх;
 - Татварын хувь хэмжээний өөрчлөлт орсон эсэх;
 - Төсвийн шилжүүлэг хийх үндэслэлд өөрчлөлт орсон эсэх;
 - Тухайн бодлого, арга хэмжээнд хамрагдах шалгуурт өөрчлөлт орсон эсэх;
 - Санхүүжилтийн хэлбэрт өөрчлөлт орсон эсэх;
 - Тухайн бодлого, арга хэмжээний санхүүгийн байдалд нөлөөлөх бусад хүчин зүйлс.
- Хэрэгжүүлэх төлөвлөгөө, төрийн аль байгууллага хэрэгжүүлэх талаар
- Хүчин төгөлдөр болох хугацаа
- Нийтэд зарлах хугацаа
- Өнөөгийн арга хэмжээнээс шинээр баталсан бодлого, арга хэмжээнд шилжих төлөвлөгөө
- Бодлого, арга хэмжээ нь үргэлжлэн хэрэгжих эсэх, эсхүл тодорхой хугацааны дараа зогсоох эсэх. Хэрэв зогсоох бол тухайн бодлого, арга хэмжээ дуусах хугацаа
- Захиалагчаас хүссэн бусад шинжилгээ, судалгаа

2. Тоо баримтыг цуглуулах, үзүүлэлтүүдийн төсөөллийг тодорхойлох. Тухайн бодлого, арга хэмжээний талаар нарийвчилсан судалгаа хийхийн тулд Парламентын төсвийн албанаас өргөн хүрээний холбогдох мэдээлэл, тоо баримтыг цуглуулдаг. Энэхүү тоо баримт, мэдээлэл нь Зардлын тооцоололд ашиглах үзүүлэлтүүдийн төсөөлөл, тооцоолол хийх аргачлалын үндэс болох бөгөөд тухайн тоо баримт, мэдээллийн чанар нь Зардлын тооцооллын үр дүнд нөлөөлж байдаг.

Тоо баримт цуглуулах

Парламентын төсвийн албанаас хийсэн зардлын тооцооллын тайланд тоо баримт, мэдээллийн эх үүсвэр, үнэн зөв болох тухай танилцуулгыг тусгадаг.

Тоо баримт нь өнөөгийн бодит үзүүлэлтүүд бөгөөд зардлын тооцооллын суурь болдог. Парламентын төсвийн алба нь Засгийн газрын харьяа нэгж, байгууллагуудтай мэдээлэл авах санамж бичиг байгуулж, энэхүү санамж бичгийн хүрээнд зардлын тооцоолол хийхэд шаардлагатай тоо баримт, мэдээллийг олж авдаг. Тоо баримт, мэдээллийг хүсэлт гаргаснаас хойш 5-10 хоногт багтаан хүлээн авдаг ч, зарим тохиолдолд илүү хугацаа шаардагдаж болдог.

Хэрэв Засгийн газрын харьяа байгууллагын мэдээлэл нь нууц мэдээлэл бол Парламентын төсвийн алба нь хуулийн дагуу уг мэдээллийг нууцлах үүрэгтэй.

Үзүүлэлтүүдийн төсөөлөл

Зардлын тооцоолол хийхдээ бодлого, арга хэмжээний үр дүн, ирээдүйн болох үйл явдлыг, тоо баримтыг таамаглан холбогдох үзүүлэлтүүдийн төсөөллийг ашигладаг. Үзүүлэлтүүдийн төсөөллийг тооцоолоходоо эмпирик судалгаа, онолын таамаглал, мэргэжлийн үнэлгээнд тулгуурлан хийдэг.

Үзүүлэлтүүдийн төсөөлөл нь зардлын тооцооллын үр дүнг тооцоолоход дараах ач холбогдолтой.

- Зардлын тооцоололд дутагдалтай тоо, баримтыг ашиглах боломжийг олгох;
- Бодлого, арга хэмжээний үр дүн, хариу үйлдлийг тооцоолох боломжийг олгох;
- Загварчлалд ашиглах хувьсагчуудыг тодорхойлох боломжийг олгох.

Зардлын тооцоололд хэрэгжлэгдэх үзүүлэлтүүдийн төсөөллийг 2 төрөлд ангилж болно.

- Таамаглалд шууд ашиглах үзүүлэлтүүдийн төсөөлөл – Зардлын тооцоолол хийх зорилгоор тухайн үзүүлэлтийг таамаглан шууд тогтоох.
Жишээ нь: ДНБ-ний өсөлт ирэх 3 жилд 6%, 6.5%, 6.2% байна гэх мэт.
- Загварын үзүүлэлтүүдийн төсөөлөл – Загварчлалын үр дүнд тооцоолон гаргасан үзүүлэлтүүдийн төсөөлөл.

Жишээ нь: Загварчлалд төсвийн орлого ДНБ-ний 30% байна гэж тусгасан бол ирэх 3 жилийн төсвийн орлогыг олоходоо ирэх 3 жилийн ДНБ-нийг тооцоолж гарган түүний 30% тооцно.

Парламентын төсвийн албанаас хийсэн Зардлын тооцооллын тайланд авч ашигласан голлох үзүүлэлтүүдийн төсөөллийн тухай танилцуулна.

3. Зардлын тооцоолол хийх арга, загварчлалыг боловсруулах. Парламентын төсвийн албанаас хийсэн зардлын тооцоолол хийх арга, загварчлал нь судалгаа тус бүрээс хамаарч олон янз байдаг. Зардлын тооцоолол хийх загварчлал нь дараах хүчин зүйлсээс хамаарна.

- Бодлого, арга хэмжээний онцлог
- Тоо баримт, мэдээллийн хүртээмжтэй байдал
- Судалгаа хийж дуусгах хугацаа

Загварчлал нь тухайн бодлого, арга хэмжээний төсөвт нөлөөлөх суурь болон симуляцын нөлөөллийг тооцоолон гаргадаг. Мөн бодлого, арга хэмжээнүүдийн нөлөөллийн давхацлыг тодорхойлж тооцоолно.

Зардлын тооцоололд ашиглалсан загварчлал, түүний үр дүнгийн талаар Зардлын тооцооллын тайланд танилцуулж тусгана.

Загварчлалын хэлбэр

Зардлын тооцоолол хийх загварчлал нь олон төрөлтэй байдаг ба ерөнхийд нь “Нэгжээс ерөнхий тооцоолол хийх загварчлал” (Bottom-up) болон “Ерөнхийгөөс нэгжид тооцоолол хийх загварчлал” (Top-down) гэсэн үндсэн 2 хэлбэртэй.

Хүснэгт 9. Зардлын тооцоолол хийх загварчлалын хэлбэр

Нэгжээс ерөнхий тооцоолол хийх загварчлал	Ерөнхийгөөс нэгжид тооцоолол хийх загварчлал
<p>Энэ нь олон тооны нэгж тус бүрийн мэдээллийг цуглуулан нэгж тус бүрийн үр нөлөөг тогтоон нийт нөлөөллийг тооцоолох загварчлалын арга.</p> <p><i>Жишээ нь: НӨАТ-ийн 2%-ийг буцаан олгоно гэсэн бодлого, арга хэмжээний Зардлын тооцооллыг хийхдээ иргэн бүрийн төлсөн НӨАТ-ын хэмжээг тооцон буцаан олголтыг тооцоолж улмаар нийт шаардлагатай санхүүжилтийн хэмжээг гарган Төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоолно.</i></p>	<p>Энэ нь ерөнхий тоо баримт нь тодорхой, тогтвортой нөхцөлд энэхүү ерөнхий тоо, баримтыг ашиглан нийт нөлөөллийг тооцоолох загварчлалын арга.</p> <p><i>Жишээ нь: Хүн бүрт 300,0 мянган төгрөг олгоно гэсэн бодлого, арга хэмжээний Зардлын тооцооллыг хийхдээ тухайн хугацаан дахь хүн амын тоог тогтоон (хүн амын тоо нь өөрчлөгдөхгүй) 300,0 мянган төгрөгөөр үржүүлж нийт шаардлагатай санхүүжилтийг тооцон төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоолно.</i></p>
<p>Давуу тал Нарийвчилсан судалгаа хийгдэх тул нэгж тус бүрийн үр нөлөөг тогтоох боломжтой.</p> <p>Сул тал Их хэмжээний мэдээлэл цуглуулж боловсруулах шаардлагатай тул нөөц хөрөнгө, цаг хугацаа их шаардана. Нэгж тус бүрийн тоо баримтын чанар, хүртээмжтэй байдлаас шууд хамарна.</p>	<p>Давуу тал Тооцоолол хийхэд нөөц хөрөнгө, цаг хугацаа бага шаардана.</p> <p>Сул тал Нэгж тус бүрийн үр нөлөөг тогтоох боломжгүй.</p> <p><i>Жишээ нь дээр дурдсан 300,0 мянган төгрөг хичнээн өрхийн амьжиргаанд дэмжлэг болж чадсан эсэхийг тодорхойлох боломжгүй. (сарын 10 сая төгрөгийн орлоготой өрхөд нөлөө багтай бол сарын 500 мянган төгрөгийн орлоготой өрхөд маш их дэмжлэг болно г.м)</i></p>

Суурь ба симуляц тооцоолол

Зардлын тооцооллын загварчлал нь төсөвт нөлөөлөх суурь болон симуляц тооцооллыг тооцоолж гаргана. Суурь болон симуляц нөлөөллийн зөрүүг тухайн “бодлого, арга хэмжээний зардал” гэж нэрлэнэ.

“Бодлого арга хэмжээний зардал”_t = “Симуляц нөлөөлөл”_t - “Суурь нөлөөлөл”_t

Үүнд: “t” нь тухайн тооцооллын жил

Хүснэгт 10. Суурь ба симуляц тооцоолол

Суурь тооцоолол	Симуляц тооцоолол
<p>Суурь тооцооллыг тооцохдоо</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэв шинэ бодлого, арга хэмжээ хэрэгжүүлж байвал суурь нөлөөлөл нь “0” байна. - Хэрэв төсөвт тусгайлан заагдсан зардал орлогод хамаарах арга хэмжээнд өөрчлөлт оруулах бол суурь нөлөөлөл нь Төсвийн үзүүлэлттэй тэнцүү байна. - Хэрэв төсөвт тусгайлан заагаагүй бол өнөөгийн Төсвийн тоонд тулгуурлан үзүүлэлтийн төсөөллийг суурь нөлөөллөөр тооцож авдаг. 	<p>Симуляц тооцоололд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний онцлогийг тусгасан байдаг. Хамгийн гол тусгах онцлог нь бодлого, арга хэмжээний хариу үйлдлийн нөлөөллийг тооцох явдал юм.</p> <p>Симуляц тооцооллыг тооцохдоо тооцооллын загварт шинэ хувьсагч оруулах эсхүл, тухайн өгөгдөлтэй уялдуулан өөрчилдөг.</p>

Жишээ нь: Автомашины импортын татварыг 5%-иас 10% болгож нэмэгдүүлсэн. Жилд 50,000 ширхэг буюу 150,0 тэрбум төгрөгийн автомашин импортлоно гэж үзье.

Тэгвэл суурь тооцоолол буюу одоогийн импортын татварын орлого нь

$$150,0 \text{ тэрбум} * 5\% = 7,5 \text{ тэрбум.}$$

Хэрэв бүх хүчин зүйл тогтмол бол импортын татвар өссөнөөр олох импортын татвары орлого нь

$$150,0 \text{ тэрбум} * 10\% = 15,0 \text{ тэрбум буюу } 7.5 \text{ тэрбум төгрөгийн орлогын өсөлт}$$

Гэхдээ татвар нэмснээр автомашины үнэ нэмэгдэж борлуулалт буурна. Импортын татвар 5%-иар нэмэгдэхэд автомашины үнэ 5.5%-иар нэмэгдэнэ (НӨАТ-ын 10%-ийг тооцсон үнэ). Автомашины эрэлтийн мэдрэмж нь 0.2 гэвэл автомашины үнэ 5.5% нэмэгдэхэд борлуулалт 1.1% буурна. Тэгвэл автомашины борлуулалтын бууралт

$$50000 * 1.1\% = 550 \text{ автомашин буюу } 150 * 1.1\% = 1.65 \text{ тэрбум төгрөг}$$

Иймд татвар өссөнөөр олох импортын татварын орлогын симуляц тооцоолол нь

$$(150 - 1.65) * 10\% = 14.835 \text{ тэрбум төгрөг болно.}$$

Автомашины импортын татварыг 10% болж өсгөснөөс бий болох Төсвийн нөлөөлөл буюу симуляц тооцоолол болон суурь тооцооллын зөрүү:

$$14.835 - 7.5 = 7.335 \text{ тэрбум төгрөгийн орлогын өсөлт.}$$

Нэмэлт тайлбар: Дээр дурдсан жишээнд эхэлж тооцсон 7.5 тэрбум төгрөгийн нэмэлт орлого нь энэ судалгааны “Зардлын тооцоололд тусгасан төсвийн нөлөөллийн хамрах хүрээ” хэсэгт дурдсан төсөвт нөлөөлөх “Шууд нөлөөлөл” болно.

Харин сүүлд тооцсон 7.335 тэрбум төгрөгийн орлогын өсөлт нь “Хариу үйлдлийг тооцсон нөлөөлөл” болно.

Тооцоололд энэ судалгааны “Үзүүлэлтүүдийн төсөөлөл” хэсэгт дурдсан үзүүлэлтүүдийн төсөөллийг ашигласан. Үүнд: “Таамаглалд шууд ашиглах үзүүлэлтүүдийн төсөөлөл” буюу эрэлтийн мэдрэмжийг 0.2 гэж шууд авч хэрэглэсэн. Үүнд үнэ өсвөл эрэлт буурдаг онолын таамаглалыг авч ашигласан бөгөөд эрэлтийн мэдрэмж 0.2 гэсэн тоо нь урьд өмнө хийгдэж байсан эмпирик судалгааны үн дүн юм. Харин автомашины борлуулалтын бууралтыг “Загварын үзүүлэлтүүдийн төсөөлөл” буюу эрэлтийн мэдрэмжийн томъёог ашиглан тооцоолсон.

Бодлого, арга хэмжээний нөлөөллийн давхцалыг тодорхойлох

Зардлын тооцооллыг хийх үед хэд хэдэн бодлого арга хэмжээний нөлөөллийг тооцоолох шаардлага үүсч болно. Мөн тухайн нэг хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ нь төсвийн хэд хэдэн орлого, зарлагад нөлөөлж болно. Энэ үед нөлөөллийн давхцал байгаа эсэхийг тодорхойлж, байгаа бол давхцалын үр нөлөөг арилгах шаардлагатай. Үр нөлөөний давхцал нь төсөвт үзүүлэх нөлөөг ихэсгэж эсхүл бууруулж болно.

Жишээ нь: ЖДҮ-ийг дэмжих зорилгоор дараах 2 төрлийн дэмжлэгийг үзүүлнэ.

а) ЖДҮ аж ахуйн нэгжид 1,0 сая төгрөгийн төсвийн дэмжлэг үзүүлнэ. Гэхдээ энэ дэмжлэгийг татвар ноогдох орлоготой адилтган үзнэ.

б) Татварын хувь хэмжээг 10%-иас 8% болгон бууруулсан.

100,0 сая төгрөгийн орлоготой ЖДҮ аж ахуйн хувьд дээр дурдсан арга хэмжээний төсөвт үзүүлэх нөлөөг арга хэмжээ тус бүрт нь тооцоолбол:

- Төсвийн дэмжлэг 1.0 төгрөгнөөс 10% татвар тооцвол цэвэр дүнгээр төсвөөс 0.9 сая төгрөгийн зардал төсөвт бий болно..

- Татварын хувь хэмжээ буурснаар 2.0 сая төгрөгийн төсвийн орлогын бууралт бий болно.

Нийтдээ 2.9 сая төгрөгийн ачаалал төсөвт бий болно.

Гэхдээ хэрэв татварын бууралтын арга хэмжээ нь төсвийн дэмжлэгт бас нөлөөлнө гэж үзвэл 1.0 сая төгрөгийн дэмжлэгээс тооцох татварын хувь хэмжээ нь 8% болох бөгөөд төсвөөс гарах цэвэр зардал нь 0.9 сая биш харин 0.98 сая болно. Иймд нөлөөллийн давхцалыг тооцсон төсвийн нөлөөллийг тооцвол нийт төсвийн ачаалал 2.92 сая төгрөг болно. Өөрөөр хэлбэл, арга хэмжээний давхцал нь төсөвт нөлөөлөх нөлөөллийг 0.02 сая төгрөгөөр өсгөсөн байна.

4. Зардлын тооцооллын үнэ зөв, бодит байдал

Парламентын төсвийн алба нь зардлын тооцооллын үнэ зөв, бодит байдалд ихээхэн анхаарал хандуулдаг. Парламентын төсвийн алба нь ашиглаж буй загварчлал, аргачлал, мэдээллийн чанарыг тогтомол сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Зардлын тооцооллын үнэ зөв, бодит байдлыг хангахын тулд дор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.

- Засгийн газрын холбогдох албадуудтай хамтран загварчлалын нийтлэг аргачлал, нэгдсэн төсөөллийн тоо баримт болон бодлого, арга хэмжээг үнэлэх ижил хандлагыг ашигладаг.

- Зардлын тооцооллыг хийх явцад үр дүнг ахлах түвшний мэргэжилтнүүдээр тогтмол хянуулах замаар дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.
- Шаардлагатай тохиолдолд гадны мэргэжилтнүүдээр загварчлал үр дүнг хянуулдаг. Ингэхдээ мэдээллийн нууцлалыг ханган ажилладаг.

Парламентын төсвийн албанаас гаргадаг зардлын тооцооллын тайлан

Парламентын төсвийн албанаас гаргадаг зардлын тооцооллын тайлан нь Парламентын гишүүдийн захиалгын дагуу боловсруулсан эсхүл, сонгуулийн дараах тайланд тусгагдсан зардлын тооцоолол юм. Зардлын тооцооллын тайлан нь дор дурдсан мэдээллүүдийг агуулдаг.

- Бодлого, арга хэмжээний тухай танилцуулга
- Бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцэл, мөнгөн урсгалын тэнцэл болон хөрөнгийн тэнцэлд үзүүлэх нөлөө (ихэвчлэн одоогийн төсөв болон дараагийн 3 жилийн төсөвт нөлөөлөх нөлөөлөл)
- Дунд хугацаанд төсөвт үзүүлэх нөлөө (ихэвчлэн 10 жилээр тооцоолол хийх бөгөөд шаардлагатай бөгөөд боломжтой тохиолдолд илуу урт хугацааны тооцооллыг хийдэг). Үүнд:
 - Төсвийн орлого, зардал тус бүрт үзүүлж буй нөлөөллийг дэлгэрэнгүйгээр харуулах
 - Тухайн бодлого, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөний талаарх дэлгэрэнгүй тооцоолол
 - Бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэцийн өөрчлөлттэй холбоотой зардалын тооцоолол
- Зардлын тооцооллыг хийхэд ашигласан аргачлал, төсөөллийн талаарх танилцуулга
- Зардлын тооцоололд ашиглагдсан тоо баримт, мэдээллийн эх үүсвэрийн талаар
- Зардлын тооцооллын үнэн зөв, бодит байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн тухай
- Шаардлагатай бусад тооцоолол шинжилгээ

Төсвийн нөлөөллийг тайлагнах

Зардлын тооцоолол тусгагдсан төсвийн нөлөөллийн тооцооллыг харуулахдаа дор дурдсан төсвийн үзүүлэлтүүдийг авч үзнэ.

- Төсвийн тэнцэлд – Аливаа бодлого, арга хэмжээ төсвийн орлого зарлагад өөрчлөлт оруулах замаар төсвийн тэнцэлд нөлөө үзүүлж байдаг. Зардлын тооцоололд төсвийн тэнцэл, Засгийн газрын мөнгөн урсгалын тэнцэл (зарим зардал нь тодорхой хугацааны туршид зарцуулагдаж болно), Хөрөнгийн тэнцэлд (Засгийн газрын мэдэл дэх санхүүгийн хөрөнгөд нөлөөлж байвал) нөлөөлөх нөлөөллийг харуулдаг.
- Засгийн газрын зээлийн хүүгийн зардалд – Төсвийн тэнцлийн өөрчлөлт нь Засгийн газрын зээлийн хүүгийн зардалд нөлөөлнө. Хүүгийн зардлын нөлөөллийг тооцоолохдоо дор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзнэ.
 - Тухайн арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгө нь хүүгийн зардалд бодитоор нөлөөлөх эсэх (жишээ нь: төсвөөс олгох зээл нь Засгийн газрын хүүгийн зардалд нөлөөлөхгүй. Учир нь зээлдэгчийн төлсөн зээлийн хүүгээр Засгийн газар хүүгийн зардлыг нөхөж болно.)
 - Хүүгийн зардалд нөлөөлөх нөлөөлөл мэдэгдэхүйц хэмжээтэй эсэх

5.3 Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Бодлогын өртөг тооцох арга

Бодлогын өртөг тооцох үйл явц нь бодлогын боломжит хувилбаруудыг үнэлж, тодорхой үе шатуудаар дамжин хийгддэг. Бодлогын өртөг тооцох зорилго нь бодлогыг өөрчлөлтийн төрийн санхүүд үзүүлэх нөлөөг үнэн зөв тусгах явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэх нь санхүүгийн урьдчилсан таамаглалыг хийх, үр ашигтай, тэгш шударга байдлын зарчмыг хангах, бодлого боловсруулагчдад чанартай мэдээлэл дамжуулах, санал солилцох боломжийг олгохын зэрэгцээ эдийн засаг, төсвийн хүлээгдэж буй үр дүнгийн прогнозыг хийхэд чухал ач холбогдолтой.

Бодлогын үр нөлөөллийн тооцоолол нь дараах 5 алхмаар дамжин хийгддэг гэж үздэг байна. Эдгээр нь

- Татварын хувь хэмжээ, босго зэрэг бодлогын параметруудад пүүс, хувь хүмүүсийн зан үйлийн үзүүлэх статик буюу тогтвортой нөлөө;
- Бодлогын өөрчлөлтөд пүүс, хувь хүмүүсийн зан үйлийн шууд нөлөө;
- Бүс нутгийн газар нутагт буюу бичил түвшний зан үйлийн нөлөө;
- Эдийн засаг болон түүнтэй холбоотой бодлогын өөрчлөлтийн макро түвшний зан үйлийн үр нөлөө;
- Бодлогын багцын нийт цэвэр нөлөө зэрэг болно.

Бодлогын өөрчлөлтийн зардлыг тооцох эхний алхам нь статик нөлөөг тооцох явдал юм. Бодлогын өөрчлөлтөд өртсөн хүмүүсийн зан төлөв нь эдийн засагт үзүүлэх нөлөөллөөс үл шалтгаалан бодлогын өөрчлөлтийн эсрэг хариу үйлдлийг шууд үзүүлдэг.

Бодлогын өөрчлөлт нь ажиллаж амьдрах дэг жаяг, хэрэглэж буй бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, хэмнэлт зэрэг эдийн засгийн шийдвэрт нөлөөлж болно. Хоёр дахь алхам нь эдийн засгийн нөлөөллийг таамаглах үйл явц бөгөөд бодлогын өөрчлөлт нь өрхийн хэрэглээ, татвар, тэтгэмж, инфляц, хүүгийн хэмжээ зэрэгт нөлөөлж болзошгүй юм.

Зардал тооцох үйл явц

Зардал тооцох арга хэмжээг доороос дээш, (бие даасан), дээрээс доош (нийт багцын цэвэр нөлөөллөөс) эсвэл аль алиныг нь хослуулсан байдлаар авч үзэж болно.

Зардлыг сайтар тооцоход аналитик чадвар, хамтын оролцоо зэрэг нь чухал ач холбогдолтой. Төрийн сан нь төсөв болон бодлогын арга хэмжээний үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлдэг бөгөөд бодлогын арга хэмжээ тус бүр улсын секторын цэвэр зээлд (“зардал”) үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолсон таван жилийн хугацаанд тоон утгаар илэрхийлж харуулдаг.

Дээр дурдсан статик нөлөөлөл, зан үйлийн шууд нөлөөлөл болон нягт уялдаа холбоотой, салбар дахь аливаа бичил түвшний зан үйлийн нөлөөг боловсруулсан аргачлалын дагуу тооцож, бодлогын арга хэмжээний үр нөлөөг оноожуулан, хасах, аль эсвэл хэрэгжүүлэх эсэхийг шийдэх боломжтой.

Тооцооллын эцсийн зорилго нь бодлого, шийдвэрүүдийн нөлөөллийг багцаар нь үнэлж, эдийн засгийн нөхцөл байдлын хэтийн төлөвийн таамаглахад чиглэгдэнэ.

Сангийн яам бодлогын өөрчлөлттэй холбоотойгоор гарах зардлыг үндэслэлтэй гэж үзэж байгаа эсэх талаараа олон нийтэд мэдэгдэнэ. Дараа нь эдгээр зардлыг тооцоонд урьдчилсан байдлаар тусгаж, дээр дурдсан дөрөв, тав дахь алхмуудаар нөлөөллийн үнэлгээг хийж, тооцооллыг иж бүрэн болгоно.

Бодлогын шууд зардал тооцох аргачлал

Сангийн яам бодлогын шууд өртгийг гурван үе шатаар тооцдог байна.

1. Суурь үзүүлэлтийг бий болгох: Бодлогын арга хэмжээнд өөрчлөлт орохгүй байх тохиолдолд үр дүнг тодорхойлох
2. Статик нөлөөллийг тооцоолох: Аливаа зан үйлийн болон эдийн засгийн арга хэмжээ авахаас өмнө, шинэ болон хуучин зохицуулалтыг нийтлэг суурь түвшинд мөрдөж ажилласнаас үүсэх төсвийн нөлөөллийг тооцох
3. Зан үйлийн үр нөлөөг тооцоолох: Энэ нь өөрчлөлтөд шууд өртсөн эсвэл ойр дотны холбоотой хэсэг бүлэг хүмүүс эсвэл пүүсүүдийн зан үйлийн хариу үйлдлийг илэрхийлдэг.

Зардлыг алдаа багатайгаар тооцохдоо дээрх гурван үе шат тус бүрийг нотлох баримт, ихэвчлэн олон нийтэд ил болоогүй захиргааны мэдээллийг, тухайлбал, татвар төлөгч эсвэл тэтгэмж нэхэмжлэгчийн талаарх мэдээлэл, дотоод, гадаадын судалгаа, шинжилгээг ашиглана. Түүнчлэн эдгээр шууд зардлыг тооцохын тулд бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн гаргасан загвар, төсвийн албаны гаргасан мэдээ, бусад эх сурвалжаас авсан бодлогын параметрууд, хувь хэмжээний шалгуурууд, үр дүн, тогтвортой байдал, чанарын үзүүлэлт зэргийг мөн ашиглаж, зардал тооцох үйл явцыг системтэйгээр хийж гүйцэтгэнэ.

Бодлогод шууд өөрчлөлт оруулах, тухайлбал, татварын хувь хэмжээг өөрчлөх, татвар ногдуулах суурийг өргөжүүлэх зэрэг бодлогын зардлыг тооцоход харьцангуй хялбар байдаг. Эдгээр загварууд нь нотлох баримтаар баталгаажсан бөгөөд тоон үзүүлэлтүүдээр илэрхийлэхэд харьцангуй хялбар тул төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоолох боломжийг олгодог.

Зарим арга хэмжээнүүд, тухайлбал шинэ татвар нэвтрүүлэх нь зардлын тооцоог хийхэд амаргүй нөхцөл байдлыг үүсгэдэг. Тохиромжтой суурь үзүүлэлтийг авч үзэх нь зан үйлийн шууд хариу үйлдлийг тогтооход дэмжлэг болох хэдий ч үр дүнг тодорхой бус болгох хүчин зүйл болж байдаг. Үүнд: Залилан, татварын зөрчил зэргийг оруулж болно.

Үнийн уян хатан байдал

Зах зээлийн өрсөлдөөний хэлбэр, хэрэглэгчдийн бараа, үйлчилгээний үнийн мэдрэмж орлогын болон хэрэглээний хэмжээнд харилцан адилгүй өөрчлөлтийг бий болгоно.

Татвар ногдуулах орлогын мэдрэмж

Энэ нь хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг өөрчлөхөд хувь хүмүүсийн үзүүлэх хариу үйлдлийг тооцоход ашиглагддаг. Шилжилт хөдөлгөөн, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа, татварын төлөвлөлт, ажиллах хүчний хангамж зэрэг татвар ногдох орлогын мэдрэмжийн үзүүлэлтүүд нь эдийн засаг дахь хэрэглээ, хөрөнгө оруулалтад бодитойгоор нөлөөлнө.

Элэгдлийн хувь хэмжээ

Зарим бодлогын арга хэмжээ, тухайлбал татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн босго зэрэг үзүүлэлтэд гарсан өөрчлөлт нь элэгдлийн хэмжээг өндрөөр тогтоох нөхцөл байдлыг өдөөж болох юм.

Харилцан хамаарал

Арга хэмжээний хариуд үзүүлэх зан үйлийн үр нөлөөг тооцоход хүндрэл учруулдаг нэг хүчин зүйл бодлогууд өөр хоорондоо хэрхэн холбогдож байгааг тодорхойлоход амаргүй байдаг явдал юм.

Жишээлбэл, суурь тэтгэврийн өөрчлөлт нь тэтгэврийн зээлийн болон орон сууцны тэтгэмж авах эрхэд нөлөөлнө. Суурь тэтгэврийн хэмжээ нь орлогоос шалтгаална. Үүний

нэгэн адил, зарим нь нийгмийн даатгалын урамшуулал нь татварын дараах орлогоос хамаардаг тул орлогын албан татварын зарим өөрчлөлт нь нийгмийн даатгалын зардалд нөлөөлж болох юм.

Хүлээн авах хувь хэмжээ

Тэтгэмж, нийгмийн хамгааллын бодлого, зарим татварын хөнгөлөлтүүд нь хураамжийн хэмжээг тооцоход төвөгтэй болгодог. Тухайлбал Universal Credit³¹³ (UC-амьжиргааг дэмжих зорилготой зээлийн карт)-ийн хураамж нь амьжиргааны өртөгт нөлөөлөх тул, худалдан авалтын зардлын бууралт нь эдийн засагт үржүүлэгчийн үүргийг төдийлөн сайн гүйцэтгэдэггүй.

Өнөөгийн бодлогын зардлын төрлүүд

Бодлогын зардлууд³¹⁴ (Policy costings)-ыг 2021 оны 3 дугаар сарын байдлаар дараах зүйлүүдийг хамруулсан байна. Үүнд:

- Коронавирусийн цар тахлын үед ажлын байрыг хадгалан үлдэх: 2021 оны 9 дүгээр сар хүртэл;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогыг дэмжих: хоёр тэтгэлэгийг нэмэлтээр хамруулах;
- Хөнгөлөлтийн хувь: амралтын өдрүүдэд гурван сарын турш 100%-иар, есөн сарын туршид 66%-ийн хөнгөлөлт үзүүлэх;
- НӨАТ-ын хөнгөлөлтийг сунгах (2021.09.30-ны өдрөөс 5%-иар, 2022.03.31-ний өдрөөс 12.5%-иар)
- НӨАТ-ын хувь хэмжээг хойшлуулсан төлбөрийг гурван сар хүртэл сунгах төлбөрийн шинэ схем;
- Түлш, шатахууны татвар: 2021-2022 он хүртэл царцаах;
- Архины татвар: 2021-2022 он хүртэл царцаах;
- Нийтлэг (Universal) зээл: тэтгэмжийг зургаан сарын туршид 20 фунт стерлингээр өсгөн нэмэгдүүлэх;
- Нийтлэг зээл: орлогын доод түвшнийг гурван сараар хойшлуулах;
- Нийтлэг зээл: 2021-2022 онд хуваарилагдаагүй ашгийг 2500 фунт стерлингийн хэмжээнд байлгах;
- Хамтарсан байр сууцны төлбөр: хөнгөлөлтийг нэмэгдүүлэх;
- Хууль ёсны өвчний улмаас олгох тэтгэлэгийг хөнгөлөх;
- Алдагдлыг буцаан олгох: Гурван жилийн хугацаанд 2,000,000 фунт стерлингээр нэмэгдүүлсэн;
- Корпорацийн татвар: 2023 оны 4 дүгээр сараас 250,000 фунт стерлингээс дээш ашигтай байвал хувь хэмжээг 25%-иар, 50,000 фунт стерлингээс дээш ашигтай байвал хувь хэмжээг ашгийн 19%-иар тус тус бууруулна.
- НӨАТ-ыг 2023-2024 онуудад 85,000 фунт стерлингээр тогтооно.
- Өв залгамжлалын татварыг 2025-2026 онуудад 2020-2021 оны түвшинтэй адил байлгана.
- Тэтгэврийн насан туршийн тэтгэмжийг 2025-2026 онуудад 1,073,100 фунт стерлингийн түвшинд хадгална.
- Хөрөнгийн ашгийн татварын чөлөөлөгдөх дүнг 2025-2026 онуудад 12,300 фунт стерлингийн хэмжээнд байлгана.

³¹³ <https://www.gov.uk/universal-credit>

³¹⁴Төсөв, 2021, Бодлогын зардал

https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/965777/Budget_2021_policy_costings_.pdf

**МОНГОЛ УЛС ДАХЬ УУЛ УУРХАЙН ЗАМ, ТЭЭВРИЙН ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТ, ТҮҮНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, ҮР АШИГ**

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл, Д.Халиун,
Р.Нургүл, И.Жаргалзаяабямба*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

I. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НӨЛӨӨ

- 1.1 Уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг
- 1.2 Уул уурхайн салбарын үр ашигт нөлөөлөх хүчин зүйлс
- 1.3 Уул уурхайн салбар дахь замын дэд бүтцийн хөгжлийн ач холбогдол
- 1.4 Монгол Улсад нүүрсний салбарыг дэмжин хөгжүүлэх нь чухал болох тухай

II. ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ, ЦААШДЫН ХАНДЛАГА

- 2.1 Дэлхийн улс орнуудын нүүрсний батлагдсан нөөц
- 2.2 Дэлхийн нүүрсний импорт, экспортын хувь хэмжээ
- 2.3 Дэлхийн нүүрсний үнэ
- 2.4 БНХАУ-ын коксжих нүүрсний салбарын төлөв байдал
- 2.5 БНХАУ-ын нүүрсний эрэлт хэрэгцээ, цаашдын хандлага
- 2.6 Монгол Улсын нүүрсний экспортын судалгаа
- 2.7 Хятад Улс яагаад нүүрс импортолдог вэ?
- 2.8 Монгол Улсын нүүрсний нөөц
- 2.9 Хилийн боомтын талаарх мэдээлэл
- 2.10 Боомтын хүчин чадлын үнэлгээ

III. ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- 3.1 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл
- 3.2 Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор

IV. АВТОЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- 4.1 ТТ-Гашуунсухайт чиглэлийн шинээр баригдах 250 км авто зам
- 4.2 Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 480 км авто зам
- 4.3 Замын свот шинжилгээ

**V. ЗАМ, БООМТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН НҮҮРСНИЙ САЛБАРЫН ҮР АШИГ
БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**

5.1 Үр ашгийн тухай ойлголт, төрлүүд, мөн чанар

- 5.2 Тооцооллын оршил, рекуррент загвар
- 5.3 Таван толгой-Гашуунсухайт төмөр замын хувьд хийгдсэн тооцоо
- 5.5 Тонн нүүрсний өртгийн тооцоо, прогноз
- 5.6 Замын бүтээн байгуулалттай холбоотой нүүрсний салбарын харьцангуй үр ашиг
- 5.7 Монгол Улсын эдийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн захиалгын дагуу Өмнөговь аймгийн нутагт орших Таван толгойн бүлэг ордоос хилийн боомтууд руу чиглэсэн төмөр зам болон авто замын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, эдгээр замууд ашиглалтад орсноор бий болох үр ашиг, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг төслийн техник эдийн засгийн үндэслэл болон холбогдох бусад мэдээлэлд түшиглэн судалснаас гадна зам тээврийн дэд бүтэц сайжирснаар нүүрсний томоохон ордуудыг ашигласнаас гарах үр ашгийн өсөлт, Монгол Улсын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг эконометрик загваруудыг ашиглан прогноз тооцоо хийсэн болно.

Судалгааны хамрах хүрээ: Судалгааны явцад дэлхийн болон БНХАУ-ын нүүрсний эрэлт, нийлүүлэлт, үнийн хэтийн төлөв, Монгол Улсын нүүрсний нөөц, экспортын хилийн боомтууд, шинээр баригдаж буй Таван толгой-Гашуунсухайт, Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Таван толгой-Ханги, Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн автозамуудын бүтээн байгуулалтын ажлын явц, хүчин чадал болон замын бүтээн байгуулалттай холбоотойгоор дээрх боомт, замуудаар нүүрс тээвэрлэх Таван толгойн бүлэг ордуудын үр ашгийн өсөлт, макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл зэрэг асуудлуудыг цогц байдлаар судаллаа.

Судалгааны 1-р хэсэгт, нүүрсний салбарыг бодлогоор дэмжин хөгжүүлэх нь Монгол улсын хөгжилд чухам ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах үүднээс энэхүү судалгаанд уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, үр ашигт нөлөөлөх хүчин зүйлс, уул уурхайн салбар дахь замын дэд бүтцийн хөгжлийн ач холбогдол зэргийг тоймлон судалсан.

Судалгааны 2-р хэсэгт, дэлхийн нүүрсний нөөц, хэрэглээ, Хятад Улсын нүүрсний эрэлт, эрэлтийн хандлага, нүүрсний үнийн дэлхийн зах зээл дэх төлөв, Монгол Улсын нүүрсний нөөц, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажлын явц байдал зэргийг;

Судалгааны 3, 4-р хэсэгт, шинээр баригдаж буй төмөр зам болон автозамуудын байршил, техникийн болон хүчин чадлын үзүүлэлт, санхүүгийн үр ашиг, бүтээн байгуулалтын ажлын явц байдал, ач холбогдол, төрөөс гаргасан холбогдох тогтоол шийдвэрүүд зэрэг үндсэн мэдээллүүдийг хураангуйлан танилцуулав.

Судалгааны 5-р хэсэгт, үр ашгийн үзүүлэлтүүд буюу нүүрсний үнэ, өртөг, ам.долларын ханшийн прогноз хийснээс гадна замын хэмнэлт, хураамжаар дамжуулан шинэ замуудын ашиглалтын дүнд бий болох үр ашиг, мөн өмнөх жилүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, зардлын өсөлт хадгалагдана гэж үзсэн үеийн үр ашгийг гаргаж харьцуулалт хийснээр нүүрсний компаниудад бий болох ашгийг тооцож гаргалаа. Ийнхүү компаниудын ашиг нэмэгдсэнээр макро эдийн засагт ямар нөлөө үзүүлэхийг энэ бүлэгт авч үзсэн болно.

Түүнчлэн энэ бүлгийн эхэнд онол, арга зүйн мэдээллийг оруулсан нь үр ашгийн үзүүлэлтийн эдийн засгийн агуулгыг тайлбарлах зорилготой. Уул уурхайн салбарт дэд бүтцийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд газар ашиглалт, нөөц баялгийн үйлдвэрлэлд шууд хамааралтай, эцсийн бүтээгдэхүүний орцыг бий болгоход гол суурь нь болж өгдөг онцлогтой. Иймд энэ салбарын үр ашгийг бүхэлд нь тооцохдоо нэмүү өртгөөс гадна байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нь ч харгалзаж үзэх учиртай юм.

Түлхүүр үг: Нүүрс, нүүрсний уурхай, нүүрсний үнэ, төмөр зам, автозам, нүүрс, үр ашиг

Keywords: Coal, coal mining, coal price, railroad, road, efficiency

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Эдийн засагт гүйцэтгэх үүргийн хувьд уул уурхайн салбар нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, үндэсний орлого, улсын нэгдсэн төсвийн орлого, экспорт, ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, валютын ханшийг тогтворжуулах нөлөөтэй байдаг бол мөнгөн сангийн агуулгаараа түлш, шатахуун, цахилгаан, ус, үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, тээврийн үйлчилгээг худалдаж авах, цалин тавьж олгох, татвар, санхүүжилтийн зардлууд болох хүү, ногдол ашгийн төлбөр төлж, орлогыг нэмэгдүүлэх үржүүлэгчийн дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг байна.

Уул уурхайн салбарын нэмүү өртөг буюу үр ашигт: эрдэс бүтээгдэхүүний үнэ, уулын ажлын явц, үйлдвэрлэл буюу олборлолтод шаардлагатай техник, хангамжийн материалын үнэ, үйл ажиллагааны болон тогтмол зардал, санхүүжилтийн зардал гэсэн үзүүлэлтүүд нөлөөлдөг. Тухайлбал эрдэс бүтээгдэхүүний үнэ нь нэмэгдсэн, олборлолт эхэлснээс хойш цөөхөн жил болж байгаа буюу техник хэрэгслийн бүтээмж харьцангуй өндөр, шатах тослох материал, сэлбэг хэрэгслийн үнэ бага, үйлдвэрлэл, олборлолтын хэмжээ их буюу тогтмол зардлын нөлөөгөөр нэгж бүтээгдэхүүний өртөг буурах нөхцөл бүрдсэн байх үед энэ салбарын үр ашиг харьцангуй сайн байна.

Замын дэд бүтцийн эдийн засаг болон уул уурхайн салбар дахь ач холбогдлыг судлаачид дараах байдлаар тодорхойлж байна. Эдгээр нь:

- ✓ Бүс нутгийн буюу зам дагуух засаг захиргааны нэгжийн хөгжил;
- ✓ Байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх харьцангуй таатай нөлөөллийн өсөлт;
- ✓ Түүхий эд материалын бүс нутгийн онцлогт тохирсон ханган нийлүүлэлт;
- ✓ Бүс нутаг хоорондын худалдаа, арилжааны өсөлт;
- ✓ Ажиллагсдын ажлын байран дээрээ шилжин очих таатай боломж;
- ✓ Тээвэрлэлтийн хугацааны богиносолт буюу тээвэрлэлт хийж буй жолоочийн цалингийн зардлын бууралт;
- ✓ Тээврийн хэрэгслийн эвдрэл, сэлбэг хэрэгслийн зардлын багасалт;
- ✓ Бүх төрлийн засвар, оношилгоо, засвар үйлчилгээний зардлын бууралт;
- ✓ Шатахуун, шатах тослох материалын зардлын хэмнэлт;
- ✓ Тээврийн хэрэгслийн биет элэгдлийн хэмжээний бууралт;
- ✓ Зам тээврийн ослын тооны цөөрөлт;
- ✓ Дотоодын болон гадаадын зах зээлд бүтээгдэхүүн нь чиглэсэн стратегийн шинэ үйлдвэр аж ахуйн газруудын хөгжил зэрэг болно.

Монгол Улсын эдийн засагт нүүрсний салбар чухал болохыг I бүлгийн хүрээнд мөн тайлбарласан бөгөөд бусад хүчин зүйлс тогтмол байхад макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд зах зээлийн багтаамж буюу цар хүрээний нөлөөлөл ихтэй, гадаад валютын ханшны өсөлтийг тогтоон барихад дэмжлэг болохуйц нөлөөтэй, нэмүү өртөг өндөртэй салбар илүү таатай нөлөө үзүүлнэ.

- ✓ Тэгвэл манай улсын хувьд нүүрсний салбар нь дангаараа *ДНБ-ний 20 гаруй хувь, нийт экспортын 40.6 хувь*, улсын төсөвт төвлөрүүлсэн уул уурхайн, *олборлох салбарын орлогын 46.1 хувийг* эзэлж байгаа нь энэ салбарын нөлөө харьцангуй өндөр байгааг илтгэнэ.

Нөгөө талаас манай улсын Засгийн газрын гадаад өр төлбөрийн хэмжээ 8.5 тэрбум гаруй ам.доллар хүрч ДНБ-нийнхээ тал хувиас давсан өнөө үед экспортын салбар, ялангуяа их хэмээний экспортын орлогыг олох чадвартай нүүрсний салбарыг дэмжих нь *гадаад валютын ханшийг тогтворжуулахад* чухал ач холбогдолтой.

- ✓ Түүнчлэн Таван толгойн бүлэг ордын нүүрсний нөөцийн үлэмж хэсгийн эзэлдэг “Эрдэнэс таван толгой”, “Тавантолгой”, “Энержиресурс”, “Хангад

эксплорэйшн” компаниудын *татварын өмнөх ашгийн борлуулалтын нийт орлогод эзлэх дундаж хувь 30 орчим* хувьтай байгаа нь эдийн засгийн бусад салбаруудын дунджаас хавьгүй өндөр байгаа юм. Нэмүү өртөг өндөртэй салбарын төлөх ашгийн татварын хэмжээ, төсөвт төвлөрүүлэх орлого харьцангуй өндөр байхаас гадна эдийн засаг дахь хуримтлал, хөрөнгө оруулалтад үзүүлэх нөлөө нь илүү байдаг.

Нүүрсний эрэлтэд тухайн улсын болон дэлхийн улс орнуудын нүүрсний хэрэглээ, нөлөөлдөг бол **нийлүүлэлтэд** нүүрсний нөөц нөлөөлдөг гэж үздэг. Эрэлт, нийлүүлэлт нь үнийг тогтоох гол хүчин зүйлс юм. БНХАУ-ын нүүрсний салбарын томоохон судалгааны байгууллага болох “Фенвэй Энержи” дэлхийн коксжих нүүрсний эрэлт жилд ойролцоогоор 2 орчим хувиар өсч 2025 онд дээд цэгтээ буюу 1,065.2 сая тоннд хүрэх бол урт хугацаанд аажмаар буурч 1,000 сая тонны түвшинд хадгалагдана. Харин дэлхийн эрчим хүчний нүүрсний эрэлт жил бүр ойролцоогоор 0.2 хувиар өсөж, 2050 он гэхэд 7,700 сая тоннд хүрнэ гэж тооцоолжээ.

- ✓ Эндээс дэлхийн нүүрсний нийт хэрэглээ ирэх 30 жилд дунджаар 8765 сая тонн (1065 сая тонн+7700)-той тэнцэхээр байна.

Нүүрсийг дотор нь хэд хэд ангилах боловч үндсэндээ эрчим хүчний болон коксжих гэсэн гол хоёр төрөлд ангилж үздэг. Эрчим хүчний нүүрсийг цахилгаан, дулааны үйлдвэрлэлд, коксжих нүүрсийг гангийн үйлдвэрлэлд түгээмэл ашигладаг. Манай улсад энэ хоёр төрлийн нүүрсний нөөц аль аль нь хүрэлцэхүйц хэмжээтэй байгаа болохыг 6.3 тэрбум тонн нүүрсний нөөцтэй “Эрдэнэс таван толгой” компанийн коксжих нүүрс нийт нөөцийн 53 хувийг, эрчим хүчний нүүрс 47 хувийг эзэлж байгаагаар тайлбарлаж болно.

ВР-ээс гаргасан “Дэлхийн 2020 оны эрчим хүчний статистик үзүүлэлтүүд” тайланд дэлхийн нүүрсний батлагдсан нөөц 1070 тэрбум тонн, одоогийн хэрэглээний түвшингээр тооцвол 132 жилийн нөөцтэй гэж тооцсон бөгөөд Монгол Улсын нүүрсний нөөцийн хэмжээ дэлхийн нүүрсний нөөцийн 0.2%-ийг эзэлж байна.

- ✓ Хятад Улс жилд үйлдвэрлэсэн дэлхийн нийт нүүрсний 50 орчим хувийг хэрэглэдэг бөгөөд тус улсын нүүрсний хэрэглээний хэмжээ 2050 он хүртэл дунджаар 4382.5 сая тонн ($8765 \cdot 0.5$) байхаар байна. Эндээс одоо хэрэглэж байгаа нүүрсний хэмжээг нь ашиглаж Хятад Улсын нүүрсний хэрэглээ 2050 он хүртэл хэдэн хувиар өсөх болохыг тооцвол 0.4% ($3800 \cdot (1+g)^{30} = 4382.5$) гэсэн үр дүн гарч байна. Энэ хувь бага байгаа хэдий ч жил бүр өсөн нэмэгдэх хандлагыг илэрхийлж байгаа нь чухал үзүүлэлт мөн юм. 2019 оны Хятадын нүүрсний импортын мэдээллээс манай улсын экспортлох боломжтой нүүрсний хэмжээ 48 сая тонн+12 сая тонн=60 сая тонн гэсэн тооцооллыг хийх боломжтой.
- ✓ Манай улсын томоохон нүүрсний орд газар Хятад Улсаас өрсөлдөгчдөөсөө хавьгүй ойр оршдог, ижил төрлийн техник, орцуудыг хэрэглэдэг, цалингийн зардал арай багатай байдаг зэрэг нь давуу тал, онцлогийг замын бүтээн байгуулалтаар дэмжиж өгвөл нүүрсний өртөг өрсөлдөгчидтэйгөө харьцуулахад харьцангуй давуу талтай болох бөгөөд нүүрсний экспортыг замын хүчин чадалтай уялдуулан нэмэгдүүлж жилд 87 сая тонн нүүрс гаргах боломжтой болно гэж үзэж байна. Саяхан хамгийн том нийлүүлэгч улс Австралиас авах коксжих нүүрсний БНХАУ-ын импорт мэдэгдэхүйц буурсан нь хоёр улсын улс төрийн хурцадмал байдлаас үүдэн Хятадын талаас импортын хориг тавьсантай холбоотой.

Тодруулбал, 2020 оны 10-р сараас Австралийн коксжих нүүрсэнд импортын хориг тогтооходоо Хятадын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос дотоодын 10 компанид

Монгол, Индонез, Орос улсаас ямар нэг хатуу хязгаарлалтгүйгээр нүүрс импортлох эрх өгсөн байна. Энэ нь Монгол Улсын нүүрсний экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хятад Улс өөрөө нүүрсний үлэмж нөөцтэй томоохон үйлдвэрлэгч хэдий боловч нүүрсний нөөцийн байршил, байгаль орчны аюулгүй байдал, коксжих нүүрсний нөөцийн хэмжээ, олон улсын нүүрсний үнийн түвшин дэх нүүрсний үнийн бууралт зэргээс шалтгаалж нүүрсийг бусад орнуудаас импортолдог байна.

Гэхдээ Монгол Улсаас импортлох Хятад Улсын нүүрсний эрэлтэд сөрөг нөлөө үзүүлэх үзүүлэх хүчин зүйлс байгаа болохыг төр, засгийн газар анхаарлынхаа гадуур орхиж болохгүй. Тухайлбал, дэлхийн томоохон эдийн засаг бүхий улс орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн санаа санаачилга, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний улмаас нүүрсний хэрэглээ 2014 оноос хойш буурсаар байна. Үүний зэрэгцээ, нүүрс, хийн түлшээр ажилладаг уламжлалт цахилгаан станцууд нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр ажилладаг цахилгаан станцуудаас өртгийн хувьд илт давуу талтай байсан бол технологийн хөгжил, сайжруулалтууд зэрэг нь энэхүү давуу талыг бууруулах хандлага ажиглагдаж байна. Мөн БНХАУ нь эрчим хүчний нүүрсний хамгийн том нийлүүлэгч болох Индонез Улсаас импортлох нүүрсний хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. Дээрх хоёр улс ирэх 3 жилийн хугацаанд 1.46 тэрбум ам.доллар эрчим хүчний нүүрс авахаар гэрээ байгуулсан байна.

Хятад Улс 2060 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтгүй орон болох тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 75 дугаар чуулганы үеэр (2020.09.22) зарласан. Цинхуа их сургуулийн Эрчим хүч, байгаль орчин, эдийн засгийн хүрээлэнгээс хүлэмжийн хийг бууруулахтай холбоотой шинэ тайланд дурдсанаар 2050 он гэхэд Хятад Улс нь нүүрсний станцаас ангид улс болно гэж тэмдэглэжээ.

Тус улсын хувьд хүлэмжийн хийг бууруулах чиглэлд ирэх арван таван жилийн хугацаанд буюу 2035 он хүртэл харьцангуй аажим шилжилтийг авч хэрэгжүүлэх бол түүнээс хойших жилүүдэд эрчимтэй өөрчлөлт хийх төлөвтэй байна.

Гэвч Хятад Улс нь одоогоор эрчим хүчний хангамжийн хувьд нүүрсний станцаас ихээхэн хамааралтай хэвээр байгаа юм. Хятадын төрийн өмчийн эрчим хүчний компаниудын хувьд цаашид байгалийн хийн олборлолт, борлуулалтыг нэмэгдүүлэх нь хүлэмжийн хийг бууруулах эхний алхам болж байна. Тухайлбал, 2035 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх байгалийн хийн хувь хэмжээг 16%-д хүргэхээр тус улс зорьж байгаа юм. Уг үзүүлэлт өнгөрсөн 2019 оны байдлаар 8%-тай байсан ажээ.³¹⁵

Боомтын хүчин чадлыг тооцохдоо боомтоор гарсан ачааны хэмжээг 3 дахин нэмэгдүүлж жилд ямар хэмжээний нүүрсийг авто замаар тээвэрлэн экспортлох боломжтой болохыг тооцсон бөгөөд боломжит хэмжээ 58.72 сая тонн гарсан.

- ✓ Энэ нь шинээр баригдаж буй Тавантолгой-Манлай-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамуудын нүүрс тээвэрлэлтийн нийт хүчин чадал болох $(23.5-2)+(30-2)=49.5$ сая тонноос өндөр байгаа нь боомтын хүчин чадлын өсөлт автозамын бүтээн байгуулалтын үр дүнд бий болох нүүрс тээврийн ачааны өсөлтийг хангаж чадахаар түвшинд байгаа болох нь харагдаж байна. Төмөр замаар тээвэрлэх үед замын хүчин чадлын түвшинд нүүрсийг бүрэн боомтоор гаргах боломжтой гэж үзэх бөгөөд ингэж үзэх ч учиртай юм. Учир нь төмөр зам Монгол Улс болон Хятад Улсын боомтыг чирэгдэлгүйгээр дайран өнгөрч гардаг.

³¹⁵ <http://www.mongolianminingjournal.com/a/71184> , <https://www.mining.com/web/china-to-phase-out-coal-power-around-2050/>

Өмнөговь аймагт хийгдэж буй Замын дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотойгоор Таван-толгой-Гашуунсухайт, Таван-толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Таван толгой-Ханги, Таван-толгой-Гашуунсухайт чиглэлийн автозамуудын Техник эдийн засгийн үндэслэлийн үндсэн мэдээллийг судалгаанд ашигласан бөгөөд төмөр замын ажилд төрөөс санхүүжилт олгох, автозамын бүтээн байгуулалтын санхүүжилтийг замын компани өөрөө хариуцаж, үйл ажиллагааны эрсдэлийг хүлээх заалтыг концессын гэрээнд тусгасан. Замын хүчин чадал ашиглалтын түвшин хангалттай байх үед буюу судалгаанд авагдсан 4 зам нийлээд жилд 98.5 сая тонн ачааг тээвэрлэх боломжтой гэж үзсэн бөгөөд замын бүтээн байгуулалтын ажил санхүүгийн хувьд үр ашиг өндөртэй гарах тооцоо судалгаа хийгджээ.

Төлөвлөгөөнд тусгасны дагуу зам ашиглагдах үед үр ашгийг замын бүтээн байгуулалт талаас харвал сайн үр дүн гарах хэдий боловч свот шинжилгээгээр тодорхой эрсдэл, аюулууд байж болохоор байгааг тооцож гаргалаа.

- ✓ Свот шинжилгээний үр дүнгээс төмөр замын хувьд тээврийн эрэлт нь нэг зах зээлээс хэт хамааралтай байдал үргэлжлэх, нүүрсний ханш, эрэлт олон улсын зах зээл болон улс төрийн бодлогоос шалтгаалан хэлбэлзэж тээврийн хэмжээний тогтворгүй байдал бий болох, гадаад валютын ханш хэлбэлзэх, хил орчмын нүүрс шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалт хийгдэхгүй байх зэрэг эрсдэл байгаа бол тээвэрлэлтийн дийлэнх хэсэг нэг харилцагчаас шууд хамааралтай, бусад харилцагч нартай тээвэрлэлтийн гэрээ хэлэлцээр хийж эхлээгүй байгаа, шаардагдах хил орчмын нүүрс шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажил тодорхойгүй, ажиллах хүчний нөөц, дутмаг байгаа зэрэг сул талуудтай байна.
- ✓ Авто замын хувьд замын компаниуд эрсдэлээ өөрөө хүлээж томоохон хөрөнгө оруулалт хийж байгаа тул ачаа тээвэрлэлт, ялангуяа нүүрс тээвэрлэлтийн хэмжээ хэлбэлзэх, Концессын гэрээнд Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам 27 жил, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам 12 жилийн хугацаатай ашиглагдаж төрийн мэдэлд шилжихээр байгаа нь тонн тутамд ногдуулсан хураамжийн орлогын нийт хэмжээ дээрх хугацаанд найдвартай байх эсэх нь тодорхой бус байх, тээврийн эрэлт нь нэг зах зээлээс хэт хамааралтай байдал үргэлжлэх зэрэг эрсдэлүүд байна.

Уурхайн үр ашиг талаас нь авч үзвэл Зам дэд бүтцийн байгуулалттай холбоотой үр ашгийг зөвхөн замын хувьд тооцох нь учир дутагдалтай бөгөөд шинэ замуудыг барьж байгуулснаар гол тээвэрлэгч болох Таван толгойн бүлэг ордуудын үр ашгийн өсөлт хэд болох, бий болсон үр ашгийн харьцангуй өсөлт нь төсвийн орлого болон макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд ямар хувь нэмэр оруулахыг тооцох нь зүйтэй юм. Ингэснээр замын бүтээн байгуулалттай холбоотой үр ашгийн тооцоо иж бүрэн болох учиртай. Энэхүү судалгааны хувьсах үзүүлэлттэй үндсэн хоёр бүрэлдэхүүний эхнийх нь нүүрсний эрэлт, үнэ, удаах нь нүүрсний өртгийн тооцоолол билээ.

Үр ашгийн өсөлтийн тооцоог хийхдээ ашигласан үндсэн орцууд нь нүүрсний үнийн прогноз, ам.долларын ханшийн прогноз, зардал өртгийн прогноз, тээврийн хэмнэлтийн зардал, авто зам болон шороон замаар тээвэрлэх тээврийн зардал, тээвэрлэх боломжтой нүүрсний хэмжээ зэрэг болно. Уул уурхайн компанийн хувьд зам ашигласнаар гарах тээврийн зардлын хэмнэлт нь төлж буй замын хураамжаас өндөр байх үед зам ашиглах нь үр дүнтэй гэж тооцогдоно. Энэ нөхцөл хангагдаж байна.

Ердийн дундаж өсөлтийг тооцож прогноз хийх нь геометр прогрессийн өсөлтийг илэрхийлэхэд хүрдэг тул нүүрсний үнэ, зардал өртгийн прогнозыг цаг хугацааны хүчин зүйлтэй холбож энгийн шугаман регрессийн загвар ашиглан хийсэн. Харин ам.долларын

ханшийг ARMA загварыг ашиглаж прогнозлосон болно. Ингээд гаргаж авсан орлогын рекуррент зүй тогтлоос зардлыг хассан ялгаврыг авч үзэж нэг төмөр зам, нэг авто замын хувьд үр ашгийн тооцоо хийж түүнийгээ үлдсэн хоёр замуудад хөрвүүлснээр нийт үр ашгийн тооцоог гаргалаа.

Харьцангуй үр ашгийг тооцохдоо шинэ замуудыг ашигласнаар бий болох үр ашиг болон өмнөх жилүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, зардлын өсөлт хадгалагдана гэж үзсэн үеийн үр ашиг хоёрын зөрүүг гаргаж авсан болно.

- ✓ Тооцооллын үр дүн болох харьцангуй үр ашиг нь төсвийн орлогыг жилд дунджаар 1.7 тэрбум ам.доллар-аар, экспортын орлогыг 12 орчим тэрбум ам.доллар-аар нэмэгдүүлж, шинээр 30 ажлын байр бий болгох үр нөлөөтэй байна. Түүнээс гадна хугарлын цэгийг заавал биелүүлэх шаардлага гэсэн төсөөлөлд буулгаж нүүрсний дундаж үнэ хэдээс багагүй байвал харьцангуй үр ашиг биелэх болохыг гаргалаа.
- ✓ Нүүрсний дундаж үнэ ирэх 11 жилийн дунджаар 145.07 ам.доллар-аас буухгүй байхад нүүрсний уурхайн ордууд зам бариагүй байсан үеийнхээс илүү ашигтай ажиллаж чадахаар байгаа бөгөөд энэ нь ам.долларын прогнозын дундаж утгын хувьд хангалттай биелэхээр байна.
- ✓ Нөгөө талаас өнгөрсөн 10 жилд нүүрсний дундаж үнэ 0.204 буюу жилд дунджаар 20.4 хувийн өсөлттэй байжээ. Сөрөг нөхцөлөөр бодоход жилд дунджаар 4.73 $((145.07-95.37)/95.37*1/11)$ хувиар буюу түүхэн гүйцэтгэлээсээ 4.3 дахин багаар нүүрс өсөхөд нүүрсний компаниудын үйл ажиллагаа харьцангуй ашигтай байх нөхцөл биелэх юм.

Ер нь замын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил нь нүүрсний компаниудын ашгийг өсгөхөд томоохон түлхэц үзүүлэх тул нүүрсний компаниуд олборлолтынхоо түвшинг өсгөн нэмэгдүүлнэ гэж тооцоог хийхэд бодит байдлаас хол зөрөхгүй биз ээ.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НӨЛӨӨ


1.1 Уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг

Орчин үеийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь эрдэс болон эрдсийн бүтээгдэхүүнүүд, тухайлбал суурь болон үнэт метал, нүүрс, төмөр, төмрийн хүдэр, шохойн чулуу, зэс зэргээс шууд хамааралтай болсон гэж хэлж болно. Эрдсийн бүтээгдэхүүнийг барилга, дэд бүтцийг барьж байгуулах, тээврийн хэрэгслийг үйлдвэрлэх, компьютер электроник, харилцаа холбооны бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл, эрүүл мэнд, хоол, хүнс, эрчим хүч, цахилгаан дамжуулах салбар зэрэгт өргөн ашиглаж байна.³¹⁶ Эрдсийн салбар нь үйлдвэрүүдийн түүхий эдийг хангахаас гадна өндөр цалинтай ажлын байрыг бий болгох, төрөл бүрийн татварууд тухайлбал, байгалийн нөөц ашигласны төлбөрийг төлөх, бэлтгэн нийлүүлэгчдийн борлуулж буй бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг өсгөх зэрэг шууд болон дам хэлбэрийн олон эерэг нөлөөг үзүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмждэг. Түүнээс гадна нийтээр хэрэглэх боломжтой дэд бүтцийг хөгжүүлэх ач холбогдлыг араасаа дагуулж байдаг. Ерөнхийдөө уул уурхайн чиглэлээр судалгаа хийдэг судлаачид энэ салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар ангилж байна.

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөх, валютын ханш тогтворжих;
- Экспорт нэмэгдэх;
- Засгийн газрын төсвийн орлого өсөх;
- Үндэсний орлогын түвшин дээшлэх;
- Ажил эрхлэлтийн түвшинд өсөлт гарах.

Мөнгөн орлогын хуваарилалтын хувьд уул уурхайн салбарын нөлөөллийг дараах байдлаар ангилж болно.

Зураг 1. Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа



- Түлш, шатахуун, цахилгаан, ус, тээврийн үйлчилгээг худалдаж авах
- цалин тавьж олгох,
- Татвар төлөх
- Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдаж авах
- Хүү болон ногдол ашгийн төлбөр төлөх зэрэг төрлүүдэд хувааж үзэж болно.

1.2 Уул уурхайн салбарын үр ашигт нөлөөлөх хүчин зүйлс

Уул уурхайн салбарын үр ашигт буюу ашигт дараах 4 хүчин зүйлс нөлөөлнө:

- ✓ Үнэ
- ✓ Уулын ажил
- ✓ Орцын үнэ
- ✓ Тогтмол зардал

³¹⁶ [Importance of Mining \(straterra.co.nz\)](http://Importance of Mining (straterra.co.nz))

✓ Санхүүжилтийн зардал

Үнэ тусгаар байдлаар буюу олон улсын зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч тогтож байдаг бол өртөг нь уулын ажил, орцын үнэ, тогтмол зардал зэргээс хамаардаг. Гэхдээ зардлын хэмжээ үнийг тогтоох нэгээхэн үндэслэл болж байдгийг хайхрахгүй байж болохгүй юм. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа нь өрөм, тэсэлгээ, хөрс, олборлох, борлуулах үе шатуудтай бөгөөд эдгээр үйл явцуудад хүн, техник, газар шороо зэрэг орцууд ордог гэж үздэг. Зардал эхэлж гарснаар уулын ажил, бүтээгдэхүүний тоо хэмжээтэй уялдаж цаг хугацааны үе шатуудад бодит хөрөнгийн удирдлагаар дамжиж бүтээгдэхүүний нэгжийн өртөг харилцан адилгүй буюу төлөвлөгөөнөөс ялгаатайгаар тогтоогдоно.

Уулын ажлаас зардлын норм өөрчлөгдөнө. Норм тогтоохдоо хронометраж хийх бөгөөд нэг өдөрт зарцуулах бодит цаг, гүйцэтгэх нийт бүтээмж, заалт, орцуудын зарцуулалтыг тодорхойлно. Тухайлбал, хүн болон байгалийн хүчин зүйлстэй холбоотой зогсолт, ээлж солих гэх зэрэг ашиглагдахгүй өнгөрч байгаа цаг хугацааны хүчин зүйлийг харгалзаж, нийт бүтээмжийг тодорхойлдог. Бодитойгоор зарцуулсан хугацаанд бий болсон техникийн бүтээмж, ашигласан гол орцууд болох түлш, машины сэлбэг хэрэгсэл зэргийг тооцож, тухайн жилийн төлөвлөгөөг ханган биелүүлэхэд шаардлагатай техник болон урсгал зардлуудыг тооцож гаргадаг онцлогтой.

Цаг хугацаа өнгөрөх тутам уулын ажлын зохион байгуулалт, олборлолт болон тээвэрлэлт хийж байгаа талбайн хэмжээ, маршрут, техникийн үзүүлэлтүүд өөрчлөгдөнө. Тухайлбал хөрс тээвэрлэх зай зэрэг орон зайн алслалтын үзүүлэлтээс хамаараад техникүүдийн ажлын бүтээмж тодорхой хэмжээгээр багасч байдаг буюу зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэж байдаг.

Зураг 2. Нүүрсний уулын ажил



Уул уурхайн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас капитал буюу үндсэн хөрөнгийн багтаамж ихтэй байдгаараа ялгаатай. Үйл ажиллагаандаа төрөл бүрийн хүнд даацын тээврийн хэрэгсэл, машин механизмыг ашиглах бөгөөд гаргаж авсан бүтээгдэхүүнд нь олон төрлийн орц харагддаггүй, байгалийн эрдэс бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнх нь үр дүн болж байдаг.

Цаг цагаараа байдаггүй тул зардал нь бараа үйлчилгээ, мөнгөний нийлүүлэлт, үнэ, ажиллаж байгаа тоног төхөөрөмжүүд, тэдгээрийн янз бүрийн хольцоос хамаарна. Үнэ хувьсах зардлын харьцаа төлөвлөлтөд чухал байдаг бөгөөд энэ харьцааг тогтмол гэж үзээд орлого, зардлын төлөвлөлт хийдэг хэдий боловч хувьсах шинжтэй юм шиг тогтмол зардал байж болно. Тийм болохоор үнэ, тоо хэмжээ, зардлын дундаж үзүүлэлт санхүүгийн төлөвлөлтөд чухал үүрэгтэй. Нөгөө талаас үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн бүхэлдээ тухайн жилд борлогдох албагүй бөгөөд орлогын тайланд орлоготой холбоотой зардлыг тусгасан байдгийг анзаарах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, орлогын тайланд тусгагдах нэгж бүтээгдэхүүний өртөг үйлдвэрлэл, олборлолтын түвшинд тодорхойлогдчихсон байдаг гэж хэлж болно.

Уул уурхайн техник, тоног төхөөрөмжид олон орц, орцын олон үнэ байх тул зардлыг урт хугацаагаар нарийн төлөвлөж, таамаглахад хялбар биш. Иймд цаг хугацаатай холбосон динамик таамаглал, прогнозын аргыг орлого, зардлын төлөвлөлтөд хэрэглэх нь заримдаа сайн нөлөөтэй байна.

Тогтмол зардлын нөлөө бүтээгдэхүүний өртөгт чухлаар нөлөөлнө. Олборлолтын хэмжээ нэмэгдэх тутам нэгж бүтээгдэхүүнд ногдох тогтмол зардлын хэмжээ багасдаг. Энэ нь нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулах нөлөө үзүүлж, ашигт ажиллагааг дэмждэг.

Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх өөр нэг чухал үзүүлэлт бол санхүүжилт, түүний зардлын хэмжээ юм. Санхүүжилтийг өр, өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс бүрдүүлэх боломжтой бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөсөн хэмжээнд явуулахад шаардлагатай баталгаа, хамгаалалт, татвар төлөхийн өмнөх ашгаас хасагддаг зардал гэж үздэг.

1.3 Уул уурхайн салбар дахь замын дэд бүтцийн хөгжлийн ач холбогдол

Аливаа зүйл, бодит бараа үйлчилгээ, ачааг зам, усан зам, төмөр зам, агаарын зам, дамжуулах хоолой зэргийг ашиглан нэг байрлалаас нөгөө орон зайд шилжүүлэх үйл явцын далайц улам бүр нэмэгдэж байна. Зам нь арилжаа, худалдаа, солилцооны салшгүй нэг хэсэг болсон гэж үзэж болно. Тээврийн систем нь амьд организмын цусан хангамж юм хэмээн *Aldcroft, Freeman* нар тодорхойлжээ.

Замын дэд бүтцийн уул уурхайн салбар дахь ач холбогдлыг судлаачид дараах байдлаар тодорхойлж байна.³¹⁷ Эдгээр нь:

- Бүс нутгийн буюу зам дагуух засаг захиргааны нэгжийн хөгжилд;
- Ялгаатай бүс нутгуудын бараа, бүтээгдэхүүний төрөлжсөн худалдаа, арилжааны өсөлт;
- Ажиллагсдын ажлын байран дээрээ шилжин очих таатай боломж;
- Түүхий эд материалын бүс нутгийн онцлогт тохирсон ханган нийлүүлэлт;
- Тээвэрлэлтийн хугацааны богиносолт буюу тээвэрлэлт хийж буй жолоочийн цалингийн зардлын бууралт;
- Тээврийн хэрэгслийн эвдрэл, сэлбэг хэрэгслийн зардлын багасалт;
- Бүх төрлийн засвар, оношилгоо, засвар үйлчилгээний зардлын бууралт;
- Шатахуун, шатах тослох материалын зардлын хэмнэлт;
- Тээврийн хэрэгслийн биет элэгдлийн хэмжээний бууралт;
- Зам тээврийн ослын тооны цөөрөлт;
- Байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх харьцангуй таатай нөлөөллийн өсөлт;
- Дотоодын болон гадаадын зах зээлд бүтээгдэхүүн нь чиглэсэн стратегийн шинэ үйлдвэр аж ахуйн газруудын хөгжил зэрэг болно.

1.4 Монгол Улсад нүүрсний салбарыг дэмжин хөгжүүлэх нь чухал болох тухай

Аливаа салбарыг онцлон хөгжүүлэх нь дараах хүчин зүйлсийг хэр зэрэг харгалзсан эсэхээс хамаарч байдаг гэж үзэж болно. Нүүрсний салбарын хувьд үүнийг тооцвол:

- ✓ Тоо хэмжээний буюу цар хүрээний нөлөө: Нүүрсний салбар нь их хэмжээний үйлдвэрлэл борлуулалт хийх зах зээл байгаа.
- ✓ Валютын ханш: Гадаад өр ихтэй, гадаад валютын ханш жил тутам өсч байгаа манай улсын хувьд чухал валютын ханшийг тогтворжуулахад нөлөөтэй салбар бол яах аргагүй нүүрсний салбар мөн.

³¹⁷ [Microsoft Word - Aldagheiri and Bradshaw.doc \(ctrf.ca\)](#)

- ✓ Эдийн засгийн өсөлт: Нэмүү өртөг буюу ашигт ажиллагаа энэ салбарын хувьд хавьгүй өндөр байгаа нь хуримтлалд харьцангуй эерэгээр нөлөөлнө. Эдийн засаг дахь хуримтлал буюу хөрөнгө оруулалтад харьцангуй сайн нөлөөтэй гэсэн үг. Таван толгойн бүлэг ордын гол төлөөлөл болсон Таван толгой, Энержиресурс, Хангадэксplorэйшн, Эрдэнэс таван толгой компаниудын татварын өмнөх ашгийн борлуулалтын нийт орлогод эзлэх хувь 30 орчим хувьтай байгаа нь эдийн засгийн бусад салбаруудын дунджаас хавьгүй өндөр байгаа юм.³¹⁸ Бусад хүчин зүйлс тогтмол байхад нэмүү өртөг өндөртэй болон нэмүү өртөг багатай хоёр ялгаатай үйлдвэр аж ахуйн газрын нэмүү өртөг өндөртэй нь эдийн засагт оруулах хувь нэмрийн хувьд өндөр байдаг.

Монгол Улсын уул уурхайн салбарт хамгийн том байр суурийг эзэлж байгаа нүүрсний салбар цар хүрээний хувьд ямар ач холбогдолтой болохыг дараах үзүүлэлтүүдээс харж болно.

ДНБ-д үзүүлэх нөлөө

2019 онд уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 25%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72%, экспортын 90%-ийг тус тус бүрдүүлж байна.

2020 онд уул уурхайн салбар ДНБ-ний 22%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71%, экспортын 94%-ийг тус тус бүрдүүлсэн.

Экспортод үзүүлэх нөлөө

Манай улс 2019 онд 36.4 сая тонн нүүрс экспортолж, 3.1 тэрбум ам.долларын орлого олж байв. Энэ нь 2019 оны Монгол Улсын нийт экспортын 40.6 хувийг эзэлсэн гэсэн үг юм. Харин өнгөрөгч онд нүүрсний экспортын хэмжээ ийнхүү огцом буурсан шалтгааныг цар тахлын улмаас нүүрсний тээвэрлэлт удааширсантай холбон тайлбарласан байна.

Төсөвт үзүүлж буй нөлөө

Эрдэс баялаг буюу нүүрсний салбар нь Улсын болон орон нутгийн төсөв дараах татвар, төлбөр, хураамжуудыг төлж байна.

- ✓ Аж ахуйн нэгжийн ОАТ;
- ✓ Гаалийн хураамж;
- ✓ Түлш түүхий эд материал;
- ✓ ХХОАТ;
- ✓ АМНАТ;
- ✓ Ашиглалтын газрын төлбөр;
- ✓ Агаарын бохирдлын төлбөр;
- ✓ НДШ;
- ✓ ЭМД;
- ✓ Тусгай зөвшөөрлийн төлбөр;
- ✓ Газрын төлбөр, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар.

Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2019 оны гүйцэтгэлээр 11.9 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.9 их наяд төгрөг буюу 18.6 хувиар өссөн байна.

Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2.9 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 590.7 тэрбум төгрөг буюу 25.4 хувиар өссөн байна. Үүнд:

³¹⁸ Судлаачийн тооцоолсноор

Уул уурхайн салбараас	2.6 (21.96%) их наяд төгрөг
Газрын тосны салбараас	232.3 (1.95%) тэрбум төгрөг
Тусгай зөвшөөрлийн төлбөр	6.9 (0.31%) тэрбум төгрөг
Бусад орлого	29.3(0.25%) тэрбум төгрөг

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 24.5 хувийг бүрдүүлж байна.

Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого

2019 оны гүйцэтгэлээр улсын төсөвт 2,621.56 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

Алт	116.84 тэрбум төгрөг	Улсын төсөвт төвлөрүүлсэн уул уурхайн, олборлох салбарын орлогын 46.1 хувь буюу бараг тал хувийг нүүрсний салбар оруулжээ.
Нүүрс	1,210.57 тэрбум төгрөг	
Цайр	66.27 тэрбум төгрөг	
Зэс	1,090.12 тэрбум төгрөг	
Төмөр	25.42 тэрбум төгрөг	
Жонш	34.82 тэрбум төгрөг	
Бусад	77.53 тэрбум төгрөг	

Ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө

Нүүрсний салбарын ажилчдын тоон мэдээ	
Он	Ажилчдын тоо
2019	15259
2020	15103
2021	24325

Эх сурвалж: АМХЭГ

Уул уурхайн олборлох салбарт нийт 60 орчим мянган ажилчид ажиллаж байгаа бөгөөд үүний 25 хувийг нүүрсний салбарт ажиллагсад бүрдүүлж байна.

II. ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ, ЦААШДЫН ХАНДЛАГА

2.1 Дэлхийн улс орнуудын нүүрсний батлагдсан нөөц

BP-ээс гаргасан “Дэлхийн 2020 оны эрчим хүчний статистик үзүүлэлтүүд”³¹⁹ тайланд дэлхийн нүүрсний батлагдсан нөөц 1070 тэрбум тонн, одоогийн хэрэглээний түвшингээр тооцвол 132 жилийн нөөцтэй гэж тооцсон байна. Дэлхийн нүүрсний бүх нөөц голдуу дараах 10 нутаг дэвсгэрт тархсан байна. Үүнд: АНУ 23.3%, ОХУ 15.2%, Австрали 13.9%, БНХАУ 13.2%, Энэтхэг 9.9%, Индонез 3.7%, Герман 3.4%, Украин 3.2%, Казахстан 2.4%-ийг тус тус эзэлж байгаа бол Монгол Улсын нүүрсний нөөцийн хэмжээ дэлхийн нүүрсний нөөцийн 0.2%-ийг эзэлж байна.

Эрчим хүчний нүүрс: Энэ ангилалд антрацит, хүрэн нүүрс орох бөгөөд голдуу дулааны цахилгаан станцад ашиглагддаг. Энэ төрлөөс хамгийн үнэтэй болох антрацит нийт нөөцийн зөвхөн 1%-ийг эзэлдэг байна. Антрацит нь дулаан сайн ялгаруулдаг, бараг утаа гаралгүйгээр хурдан шатдаг бөгөөд цэвэрлэх байгууламж, үйлдвэрийн тогоо, карбид, цахиур, хөнгөн цагаан үйлдвэрлэхэд ашигладаг байна. Хүрэн нүүрс нь баталгаажсан нийт нүүрсний нөөцийн 50% буюу тал хувийг эзэлдэг бол үнэ багатай, усны агууламж өндөр, нүүрс устөрөгчийн агууламж бага байдаг байна. Иймд энэ төрлийн нүүрсийг зөвхөн үйлдвэрийн жижиг тогоонд ашиглах бөгөөд дулааны станцад ашиглахдаа өндөр

³¹⁹ BP Statistical Review of World Energy 2020, <https://www.bp.com/content/dam/bp/business-sites/en/global/corporate/pdfs/energy-economics/statistical-review/bp-stats-review-2020-full-report.pdf>

чанарын нүүрсстэй хольдог байна.

Кокосжсон нүүрс: Кокосжсон нүүрсийг голдуу гангийн үйлдвэрт хэрэглэх бөгөөд төмрийн хүдрийн хайлуулахад ашигладаг.

2.2 Дэлхийн нүүрсний импорт, экспортын хувь хэмжээ

Дэлхийн нүүрсний үйлдвэрлэл болон хэрэглээ


Нүүрсний үйлдвэрлэл болон хэрэглээний хувьд Ази-Номхон далайн улс орнууд дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 2019 оны байдлаар Хятад Улс 47.6%, АНУ 8.5%, Индонез 9%, Австрали 7.8%, Энэтхэг 7.6%, ОХУ 5.5%, Казахстан 1.2%-ийг тус тус үйлдвэрлэсэн байгаа бол манай улс дэлхийн хэрэглээний 0.6%-ийг үйлдвэрлэсэн байна. Хэрэглээний хувьд нүүрсний хэрэглээний нийт 51.7%-ийг БНХАУ, 11.8%-ийг Хонконг, 7.2%-ийг АНУ, 2.3%-ийг ОХУ эзэлж байна.

Дэлхийн нүүрсний импортын хувьд нийт импортын 18.1%-ийг БНХАУ, 16.1%-ийг Энэтхэг, 14.9%-ийг Европ тив, 13.9%-ийг Япон, 10.6%-ийг БНСУ тус тус эзэлж байгаа бол нүүрс экспортлогч орнуудыг Австрали тэргүүлж нийт нүүрсний экспортын 27.5%-ийг эзэлж байна. Хоёрдугаарт Индонез 26%, гуравдугаарт ОХУ 16.6%-т, АНУ 6.8%, Өмнөд Африк 6.2%, Колумби 5.9%-ийг тус тус экспортолж байгаа бол Монгол Улс болон Канад Улс тус бүр 2.9%-ийг экспортод нийлүүлж байна.

Дэлхийн нүүрсний худалдааны урсгал

Нүүрсний худалдааны урсгалыг авч үзвэл гол экспортлогч болох Австрали Улсын нийт экспортын 30%-ийг Япон, 21%-ийг БНХАУ-д, 18%-ийг Ази-Номхон далайн бусад улсад, 14%-ийг БНСУ-д эзэлж байна. (Зураг 3.)

Зураг 3. Дэлхийн нүүрсний худалдааны урсгал, 2019 он



Эх сурвалж: Олон улсын эрчим хүчний агентлаг

Экспортын хэмжээгээр 2-т жагсдаг Индонез Улсын нүүрсний экспортын хувьд Ази-Номхон далайн бусад улс 30%, Энэтхэг 28%, БНХАУ 24%, Япон 9%, БНСУ 8%-ийг тус тус эзэлж байна.

9%-ийг Япон, 4%-ийг Энэтхэг эзэлж байна.

Манай улсын хувьд нүүрсний экспортын 100% орчим хувийг БНХАУ эзэлж байгаа бол бусад зах зээлд нийлүүлж буй нүүрсний хэмжээ 0.005 эксажоулиэс хэтрэхгүй байна.

Дэлхийн нүүрсний зах зээлийн чиг хандлага, нөлөөлөх хүчин зүйл³²⁰

Нүүрс нь дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлийн хоёр дахь чухал эх үүсвэр хэвээр байгаа хэдий ч дэлхийн томоохон эдийн засаг бүхий улс орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн санаа санаачилга, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний улмаар нүүрсний эзлэх хувь 2014 оноос хойш тасралтгүй буурсаар байна.

2019 онд дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрсний хэрэглээ өмнөх оны мөн үеэс 0.6%-иар буурсан бол дэлхийн эрчим хүчний балансад эзлэх хувь 0.6 пункт (27% хүртэл)-ээр буурсан нь сүүлийн 16 жилийн хамгийн бага үзүүлэлт болж байна.

Олон улсын эрчим хүчний агентлаг (ОУЭХА)-ийн тооцооллоор цахилгаан эрчим хүчний хэрэглээ буурснаас 2020 онд нүүрсний хэрэглээ 7%-иар буурсан бол сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн эрэлт 0.9%-иар өссөн байна.

Нүүрсний хэрэглээ нь дэлхийн эрчим хүчний хэрэглээний 47%-ийг бүрдүүлж байгаа бол Ази, Номхон далайн бүс нутгийн хурдацтай хөгжиж буй орнууд үүнээс 44%-ийг хэрэглэж байна. Түүнчлэн Африк (22%), ТУХН (14%), ЕХ (13%) зэрэг бүс нутагт цахилгаан үйлдвэрлэхэд нүүрс ихээхэн хувийг эзэлж байна. Олон хүчин зүйлийг харгалзан дунд хугацаанд буюу ойрын 5-10 жилд нүүрс нь эрчим хүчний гол эх үүсвэрүүдийн нэг хэвээр байх болно гэж үзэж болохоор байна.

Дэлхий дахинд ESG³²¹-ийн дэлгэрч байгаатай холбоотойгоор хатуу нүүрсустөрөгчөөс татгалзах явдлыг хурдасгана гэж шинжээчид таамаглаж байна.³²² Томоохон хөрөнгө оруулалтын сан болон банкууд ESG-ийн бодлогын хүрээнд хатуу нүүрсустөрөгчийн үйлдвэрлэл, ашиглалттай холбоотой төслүүдэд хөрөнгө оруулахгүй байх тухай мэдэгдсэн байдаг. Энэ нь одоо байгаа ордуудын санхүүжилтийн өртөг нэмэгдэх, ирээдүйд шинэ орд газар ашиглахгүй байхад хүргэж болзошгүй юм.³²³

Нүүрсээр ажилладаг цахилгаан үүсгүүрийг байгальд ээлтэй, хий эсхүл сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг цахилгаан станцуудаар солих хэд хэдэн оронд хэрэгжиж буй хөтөлбөрүүд нь 2025 он гэхэд дэлхий даяар нийт 275 ГВт хүчин чадалтай нүүрсний цахилгаан станцуудыг хаахад хүргэх бол 100 ГВт нь АНУ-д, 75 ГВт нь ЕХ-ны орнуудад оногдож байна.

Үүний зэрэгцээ, нүүрс, хийн түлшээр ажилладаг уламжлалт цахилгаан станцууд нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр ажилладаг цахилгаан станцуудаас барилгын өртгийн хувьд илт давуу талтай байсан бол технологийн хөгжил, сайжруулалтууд зэрэг нь энэхүү давуу талыг бууруулж байна. Мөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр ажилладаг зарим төрлийн цахилгаан станцуудын ашиглалтын зардал нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудтай харьцуулахад мэдэгдэхүйц бага байдаг байна.

³²⁰ <https://www.acra-ratings.ru/research/2324>

³²¹ ESG нь Байгаль орчин, нийгэм, засаглал гэсэн үг юм.

³²² <https://www.acra-ratings.ru/research/2324>

³²³ Дэлхий нийтээр бохир эрчим хүчнээс татгалзаж байгаатай холбоотойгоор улс орнуудын нүүрсний компаниуд ESG-ийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэж байна. Тухайлбал, ОХУ-ын хамгийн том эрчим хүчний нүүрс үйлдвэрлэгч “СУЭК” ХН нь Мурманск боомт (экспортын нүүрсний шилжүүлэн ачих гол төв)-д тоос, салхинаас хамгаалах дэлгэц барих ажилд хөрөнгө оруулалт хийж байна. Тус компани нь энэхүү түлшийг тээвэрлэх, шатаах явцад гарах тоос, хүлэмжийн хийн ялгаруулалтыг хамгийн бага байлгах үүднээс илчлэг сайтай нүүрсний ордыг ашиглах, нүүрс баяжуулахад онцгой анхаарч ажилладаг. Мөн нөхөн сэргээлт, хөрсний давхаргыг нөхөн сэргээх, мод тарих, тохижуулах зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлдэг байна. <https://www.acra-ratings.ru/research/2324>

Хүснэгт 1. ЕХ-ны 2018 оны цахилгаан станцуудын барилга угсралт, засвар үйлчилгээний өртөг

	Барилгын зардал (ам.доллар/кВт)	Засвар үйлчилгээний зардал(ам.доллар/МВт*ч)	Эрчим хүчний өртөг (ам.доллар/МВт*ч)
Атомын цахилгаан станц	6 600	35	150
Нүүрсний станц	2 000	45	120
Байгалийн хийн станц	1 000	60	90
Нарны хавтан	1 090	15	110
Салхин цахилгаан станц	1 950	20	95
Усан дээрх салхин цахилгаан станц	4 920	20	140

Эх сурвалж: ОУЭХА

2.3 Дэлхийн нүүрсний үнэ

Ихэнх улс орнууд дотоодын хэрэгцээгээ хангахуйц нүүрсний нөөцтэй байдаг. Дэлхийн нүүрсний олборлолтын 20 хүрэхгүй хувь нь олон улсын бирж дээр худалдаалагддаг байна. Эдгээр нь голчлон эрчим хүч (цахилгаан үйлдвэрлэхэд) ба өндөр чанарын коксжих нүүрс (ган үйлдвэрлэхэд зориулагдсан) юм. Хямд үнэтэй хүрэн нүүрсний олон улсын худалдаа бараг хийгддэггүй.

Одоогийн байдлаар эрчим хүчний болон коксжих нүүрс гэсэн хоорондоо харилцан уялдаатай боловч хоёр тусдаа зах зээл үүсээд байна.

Нүүрсний үнэ чанар, тээврийн зардал болон бусад нөхцөлөөс хамаарч харилцан адилгүй байдаг. Эрчим хүчний нүүрсний үнийг ихэвчлэн илчлэг чанарыг нь харгалзан тогтоодог.

Саяхныг хүртэл нүүрсний үнийг бүрдүүлэхэд коксжих нүүрсний үнэ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, эрчим хүчний нүүрсний үнийг ихэвчлэн илүү үнэтэй коксжих нүүрсний үнийг хямдруулах замаар тогтоодог байсан бол одоогийн байдлаар нүүрсний спот болон фьючерсийн үнэ нь эрчим хүчний нүүрсний үнийг тогтоож байна. Энэ нь эрчим хүчний нүүрснээс ялгаатай нь коксжих нүүрс газрын тос, хий болон бусад эрчим хүчний эх үүсвэрүүдтэй өрсөлдөх чадваргүйтэй холбоотой юм.

Нүүрс тээвэрлэх тээврийн дэд бүтэц (төмөр зам, боомт, усан онгоц) бий болгоход томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай байдаг тул нүүрсний салбар нь урт хугацааны гэрээг өргөнөөр ашигладаг онцлогтой. Худалдагч, худалдан авагчид хоёулаа нүүрсний хангамжийн томоохон төслүүдэд ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг.

Урт хугацааны гэрээг өргөнөөр ашиглах бас нэг шалтгаан бол нүүрсний чанар юм. Нүүрсний чанар нь худалдааны тодорхойлогч хүчин зүйлүүдийн нэг бөгөөд ялангуяа коксжих нүүрсний чанар металлургийн үйлдвэрүүдэд маш чухал ач холбогдолтой юм.

Ихэнхдээ стандарт техникийн үзүүлэлтүүд нь нүүрсний талаарх ерөнхий мэдээллийг өгдөг бөгөөд энэ нь худалдан авагчид болон хэрэглэгчдийг нүүрсний маркийг үнэлэх илүү нарийн шинжилгээ шаардах бөгөөд илүү урт хугацаа шаарддаг байдаг байна. Нүүрсний марк батлагдсаны дараа худалдагч ба худалдан авагчийн хоорондын харилцаа нь удаан хугацаанд үргэлжилдэг. Гэхдээ цаг үеэ дагаа урт хугацааны гэрээний хүрээнд үнийн тогтолцоо аажмаар өөрчлөгдөж байна.

Олон улсын нүүрсний худалдаанд спот гэрээ нь урт хугацааны харилцаанд хамаарахгүй бусад бүх гүйлгээг хамардаг. Спот гэрээг нэг удаагийн, ачааны хэсэг, эсхүл цуврал ачааг нийлүүлэхэд байгуулж болно. Зарим спот гэрээг байнгын харилцаа холбоо тогтоож чадахгүй жижиг нийлүүлэгчид эсхүл худалдан авагчид ашигладаг бол бусад спот гэрээнүүд нь худалдагч, худалдан авагчдын хоорондох урт хугацааны харилцаанд суурилагддаг.

Сүүлийн жилүүдэд зардлыг бууруулахыг хүсч буй худалдан авагчид эрэлт нь тодорхойгүй байгаа нөхцөлд нийлүүлэлтэд уян хатан хандах шаардлагатай байгаа тул спот гэрээний хэрэглээ ихээхэн өсч байна. Энэ нь мөн шинээр гарч ирж буй болон хөгжингүй орнуудын цахилгаан станцын эрчим хүчний нүүрсний эрэлт нэмэгдэж байгаагийн үр дүнд олон улсын нүүрсний худалдааны зах зээлд шинэ тоглогчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

Одоогийн байдлаар янз бүрийн бүс нутагт уягдсан стандарт техникийн нөхцөл бүхий спот үнийг тогтсон байдаг. Тиймээс нүүрсний экспортод хамааралтай үндсэн хоёр спот үнийг ашигладаг байна. Энэ нь Өмнөд Африкийн эрчим хүчний нүүрсний экспортын FOB Richards Bay (Өмнөд Африк), Австралийн эрчим хүчний нүүрсний экспортын FOB Newcastle (Австрали)-ийн үнэ юм. Импортлогчдын суурь үнэ нь Баруун хойд Европын CIF ARA спот үнэ (Амстердам - Роттердам - Антверпен) юм. Японы импортын хувьд CIF-ийн спот үнэ нь ихэвчлэн тус улсын гаалийн статистикийн нүүрсний импортын үнийн жигнэсэн дундаж байдаг. АНУ-ын бүс нутгууд спот үнийг нийтэлсэн байдаг.

Нүүрсний салбарт фьючерсийн биржүүд гарч эхэлж байгаа бөгөөд илүү ил тод байдлыг хангаж байна. Өмнө нь стандартчиглагдсан гэрээ хэлцэл хийгддэг фьючерс зах зээл нь нүүрсний чанараас шалтгаалсан олон төрөл, түүнчлэн уул уурхайн компаниуд болон эцсийн хэрэглэгчид нягт харилцаатай байдаг тул биржээр нүүрс худалдаалахад тохиромжгүй гэж үзэж байсан. Тийм ч учраас нүүрсний фьючерс биржүүд бусад түүхий эдийн биржүүдээс хожуу үүссэн юм.

Нүүрсний фьючерсийн зах зээлүүд газрын тосны фьючерсийн зах зээлтэй адил хөгжлийн түвшинд хараахан хүрээгүй байна. Гэсэн хэдий ч нүүрсний үнийг тодорхойлоход фьючерсийн зах зээл аль хэдийн томоохон уул уурхайн компаниуд болон эцсийн хэрэглэгчдийн хооронд хоёр талт хэлэлцээр хийж байсантай ижил үүрэг гүйцэтгэж эхэлсэн бөгөөд нүүрсний үнэд үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдэж байна.³²⁴

Нүүрсний үнийн хэлбэлзэл нь эрсдэлийн гол хүчин зүйл юм. Урт хугацаанд үргэлжлэх хямд үнэ нь нүүрсний шинэ ирээдүйтэй ордуудыг ашиглах, ялангуяа тээврийн болон терминалын дэд бүтцийг хөгжүүлэх шаардлага ордуудын хувьд эрсдэлийн гол хүчин зүйл болдог.

Австралийн нүүрсний үнийн төсөөлөл (2021-2024 он)

Зураг 4. Коксжих нүүрсний үнийн төсөөлөл, нүүрсний төрлөөр 2021-2024 он (метрик тонн/ам.доллар)

Хатуу коксжих нүүрс (Ам.доллар/тонн)

Огноо	2021	2022	2023	2024	2025	(2021)
Low	121.0	129.3	122.3	119.3	130.0	110.0
High	146.3	155.0	157.6	165.0	166.0	160.0
Average	134.8	144.7	146.4	147.8	150.7	137.6
Median	135.6	145.5	150.0	150.0	150.0	140.0

PCI төрлийн нүүрс (Ам.доллар/тонн)

Огноо	2021	2022	2023	2024	2025	(2021)
Low	84.0	85.0	85.0	85.0	85.0	73.0
High	110.0	112.0	120.0	123.0	110.0	120.0
Average	100.5	101.9	102.3	101.3	98.8	96.8
Median	103.1	102.0	103.3	100.0	100.0	98.6

Хагас зөөлөн коксжих нүүрс (Ам.доллар/тонн)

Огноо	2021	2022	2023	2024	2025	(2021)
Low	73.0	72.0	72.0	72.0	72.0	62.0
High	105.0	111.0	111.0	114.0	102.0	110.0
Average	92.8	93.7	93.8	92.2	87.3	90.7
Median	93.3	91.0	93.0	90.0	87.5	91.9

Ньюкастл нүүрс (Ам.доллар/тонн)

Огноо	2021	2022	2023	2024	2025	(2021)
Low	65.0	63.6	60.0	59.0	64.0	54.4
High	91.5	90.0	85.0	80.0	78.0	75.0
Average	78.8	75.0	71.8	71.2	71.8	68.0
Median	78.0	73.0	73.0	72.4	75.0	70.0

Эх сурвалж: <https://www.statista.com/statistics/779868/forecasted-price-of-coking-coal-by-type/>

³²⁴ https://www.energycharter.org/fileadmin/DocumentsMedia/Thematic/Coal_Study_2010_ru.pdf
https://studme.org/53076/marketing/tseny_ugol

2.4 БНХАУ-ын коксжих нүүрсний салбарын төлөв байдал

Хятад Улсын коксжих нүүрсний зах зээлийн сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийг авч үзэхэд нийт хэрэглээ 531.4 сая тонн байсан бол түүний 88.2% буюу 468.5 сая тонныг дотоодын зах зээл дээрээс, харин 11.5% буюу 61.0 сая тонныг гадны улс орноос импортолжээ.

Хятад Улс нь дотоодын бизнес эрхлэгчид болон бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр төр засгийн зүгээс олон талын бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд үүний хүрээнд коксжих нүүрсний нийт хэрэглээний ойролцоогоор 10 хувийг импортоор хангах бодлого баримталдаг.

Фенвэй Энержи судалгааны байгууллагаас 2020-2030 онд Хятад Улсын коксжих нүүрсний зах зээлд импортын нүүрсний эзлэх хувь хэмжээ нь 15%-иас бага байх, импортын нүүрсний хэмжээ нь 64.0-71.5 сая тонн байх таамаглалыг дэвшүүлсэн.

1. Гангийн салбарын нөлөө - Коксжих нүүрс нь гангийн үйлдвэрлэлийн чухал түүхий эдийн нэг тул бизнесийн харилцан хамаарлын хувьд салшгүй нягт холбоотой.

2. Засгийн газрын бодлого, арга хэмжээний нөлөө - Хятад Улс нь 2014 онд 1 тонн ган үйлдвэрлэхэд 0.69 тонн коксжих нүүрс ашигласан бол уг үзүүлэлт 2018 онд 0.56 тонн болж буурсан. Үүнд нийлүүлэлтийн талд бүтцийн реформ, байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлсэн 13 дах таван жилийн төлөвлөгөө болон бусад арга хэмжээ нөлөөлсөн. Цаашид эдгээр бодлогын хэрэгжилт бүрэн хангагдсанаар уг үзүүлэлт тогтворжих боломжтой.

2.5 БНХАУ-ын нүүрсний эрэлт хэрэгцээ, цаашдын хандлага³²⁵

Хятадын нүүрсний зах зээлийн богино хугацааны хандлага дараах байдалтай байна: “Today think thank”-ийн мэдээлснээр 2021 онд БНХАУ-д цар тахлын нөлөө буурч эдийн засаг өсөх дүр зурагтай байна.

2021 онд тус улсын коксжих нүүрсний импорт өмнөх онынхоос 2-3 сая тонноор нэмэгдэж 75 сая тоннд хүрэх төлөвтэй байна. 2020 онд 72.57 сая тонн коксжих нүүрс импортолсон нь 2019 оныхоос 2.7%-иар буурсан үзүүлэлт байна.

Үнийн хувьд: 2021 онд тонн коксжих нүүрс 1400-1600 юань буюу өндөр түвшинд байх ба жилийн хоёрдугаар хагаст эрэлтээ дагаад үнэ өсөх хандлагатай байгаа бол эрчим хүчний нүүрсний импортын хэмжээ 300 сая тоннд хадгалах төлөвтэй байна.

2020 онд тус улсын түүхий нүүрсний олборлолт 3.84 тэрбум тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 0.9% -иар өссөн байна. Тэр дундаа коксжих нүүрс 1.152 тэрбум тонн буюу өмнөх оны мөн үеэс 3.13%, эрчим хүчний нүүрс 3.152 тэрбум тонн буюу 2.5%-иар тус тус нэмэгдсэн байна.³²⁶

БНХАУ-ын нүүрсний зах зээлийн хувьд 2019 оны байдлаар нийт импортын 34%-ийг Индонез, 32%-ийг Австрали, 16%-ийг Монгол, 13%-ийг ОХУ тус тус эзэлж байсан.

2020 онд БНХАУ 304 сая тонн коксжих нүүрс импортолсон бөгөөд энэ нь 2014 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Улс орнуудаар авч үзвэл Монгол Улс, Австрали, ОХУ Канад, АНУ-аас голлон нийлүүлж байна.

Хамгийн том нийлүүлэгч улс Австралиас авах коксжих нүүрсний БНХАУ-ын импорт мэдэгдэхүйц буурсан нь хоёр улсын улс төрийн хурцадмал байдлаас үүдэн Хятадын

³²⁵ China National Coal Association

³²⁶ <https://ett.mn/mon/23/item/1685>

талаас импортын хориг тавьсантай холбоотой. Тодруулбал, 2020 оны 10-р сараас Австралийн коксжих нүүрсэнд импортын хориг тогтоохдоо Хятадын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос дотоодын 10 компанид Монгол, Индонез, Орос улсаас ямар нэг хатуу хязгаарлалтгүйгээр нүүрс импортлох эрх өгсөн.³²⁷

Хориг тогтоосноос хойш 11 дүгээр сард Австралиас 247 мянган тонн коксжих нүүрс, 12 дугаар сард огт импортлоогүй байна. 2020 оны 11 дүгээр сар хүртэл хугацаанд Хятадын коксжих нүүрсний нийт импортын 51.3%-ийг Австрали эзэлсэн байна.³²⁸

БНХАУ-д нийлүүлэх эрчим хүчний нүүрсний экспортоор Индонез, Австрали, ОХУ тэргүүлдэг. 2020 онд БНХАУ 2014 оноос хойш анх удаагаа Өмнөд Африкаас авсан бөгөөд цаашид мөн импортоо нэмэгдүүлэх хандлагатай байна. Мөн оны 11 дүгээр сард Колумби Улсаас эрчим хүчний нүүрсийг их хэмжээгээр импортлосон бөгөөд урьд өмнө нь тус улсаас их хэмжээгээр нүүрс авч байгаагүй байна. Мөн дээрхтэй зэрэгцэн БНХАУ нь эрчим хүчний нүүрсний хамгийн том нийлүүлэгч болох Индонез Улсаас импортлох нүүрсний хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. Дээрх хоёр улс ирэх 3 жилийн хугацаанд 1.46 тэрбум ам.доллар эрчим хүчний нүүрс авахаар гэрээ байгуулсан байна. Мөн шинжээчдийн үзэж байгаагаар Shanxi, Shaanxi болон Өвөр Монгол дахь дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломжтойг тэмдэглэсэн байна.³²⁹

БНХАУ нь 2020 оны 12 дугаар сард 216,8 км бүхий дотоодын нүүрс тээврийн төмөр замын шинэ шугамыг ашиглалтад оруулсан байна. Тус шугам нь улсын хойд хэсэгт байрлах Хэбэй мужийн Хуанхуа хотын зүүн хэсэг байрлах Шаньдун мужийн Янкоу хотуудыг холбож байгаа юм. Тус төмөр замын нэвтрүүлэх чадал нь 32 сая тонн бөгөөд 47.5 сая тонн болгон нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. Guohua Energy Shouguang цахилгаан станц нь өмнө Лункоу, Хуанхуагаас далайн тээврээр тээвэрлэсэн нүүрс авч хэрэглэдэг байсан бөгөөд тээврийн зардал тонн тутам 107 юань байсан бол төмөр замаар тээвэрлэснээр тээврийн зардал тонн тутам 43 юань болж буурахаар тооцоолсон байна. Ийнхүү тээврийн зардал жилд 170 сая юань буюу 24 сая ам.доллараар буурах юм байна.³³⁰

БНХАУ-ын Хөгжил, шинэтгэлийн хорооноос 2021 оны 6 дугаар сарын 8-9 өдрийн хурлаар улсын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийн хангахад нүүрс хадгалах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ гэж мэдэгдсэн байна.

Хүснэгт 2. БНХАУ-ын нүүрсний импорт, улсаар

Улсын нэр	2020 оны 12-р сар	2019 оны 12-р сар	± %	1-12-р сар 2020	1-12-р сар 2019	± %
Австрали	0	111	-100.0	35,368	30,843	14.7
ОХУ	1,177	17	6705.1	6,725	5,443	23.6
Канад	510	0	n/a	4,664	3,009	55.0
АНУ	135	0	n/a	950	1,118	-15.0
Бусад	198	0	n/a	1,095	374	192.6
Далайгаар тээвэрлэсэн нийт	2,019	129	1470.4	48,803	40,788	19.7
Монгол	1,551	1,569	-1.1	23,766	33,773	-29.6
Нийт	3,570	1,697	110.3	72,569	74,561	-2.7

Эх сурвалж: <https://www.statista.com/statistics/779868/>

³²⁷ <https://www.argusmedia.com/en/news/2216785-chinas-australian-coal-ban-distorts-prices>

³²⁸ <https://www.argusmedia.com/en/news/2203807-china-coal-ban-puts-steelmakers-in-quandary-correction>

³²⁹ <https://www.scmp.com/economy/china-economy/article/3121426/china-coal-why-it-so-important-economy>

³³⁰ <https://cfts.org.ua/news/2020/12/28/v-kitae-nachala-rabotu-zheleznyaya-doroga-postroennaya-spetsialno-dlya-perevozki-uglya-62603>


2021 оны нэгдүгээр улиралд Хятад Улс 11.25 сая тонн коксжих нүүрс импортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ нь 45.9%-иар буурсан үзүүлэлт болохыг тус улсын Гаалийн ерөнхий газраас (2021.04.21) мэдээлжээ. Зөвхөн гуравдугаар сард импортлосон коксжих нүүрсний хэмжээ нь 4.91 сая тонн байна. Өнгөрсөн оны мөн сартай харьцуулахад 13%-иар бага хэдий ч өмнөх хоёрдугаар сарынхаас 52.01%-иар өсчээ.

Импортлосон үнийн тухайд, тонн коксжих нүүрсний дундаж үнэ 131.96 ам.доллар буюу өнгөрсөн оныхоос 8.2 ам.доллараар хямд аж. Гэхдээ өмнөх хоёрдугаар сарын үнээс 20.99 ам.доллараар нэмэгдсэн байна.

Тэгвэл оны эхний улиралд Монгол Улс нийт 6.67 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд хоёрдугаар сард 2.02 сая тонн, гуравдугаар сард 2.14 сая тонн нүүрсийг тус тус экспортолсон.

Мөн хугацаанд Орос улс гадаад зах зээлд нийт 42.47 сая тонн нүүрс экспортолсноос нэгдүгээр сард 176.8 мянган тонн коксжих нүүрс, хоёрдугаар сард коксжих нүүрсний экспортоо 91%-иар нэмэгдүүлж, манай улсын нийлүүлэлтээс давсан байна.

Зураг 5. БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хувь хэмжээ, улсаар



Эх сурвалж: АМХЭГ

Хятадын нүүрсний зах зээлийн урт хугацааны хандлага дараах байдалтай байна:

БНХАУ-ын нүүрсний салбарын томоохон судалгааны байгууллага болох “Фенвэй Энержи” дэлхийн коксжих нүүрсний эрэлт жилд ойролцоогоор 2 орчим хувиар өсч 2025 онд дээд цэгтээ буюу 1,065.2 сая тоннд хүрэх бол урт хугацаанд аажмаар буурч 1,000 сая тонны түвшинд хадгалагдана;

Харин дэлхийн эрчим хүчний нүүрсний эрэлт жил бүр ойролцоогоор 0.2 хувиар өсөж, 2050 он гэхэд 7,700 сая тоннд хүрнэ гэж тооцоолжээ.³³¹

Нүүрс нь хөгжиж буй орнууд, ялангуяа Хятад, Энэтхэгийн эрчим хүчний үйлдвэрлэлийн гол эх үүсвэрийн нэг юм. Ази, Номхон далайн орнууд дэлхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 44%-ийг хэрэглэдэг бөгөөд эрчим хүчний гол эх үүсвэр болох нүүрснээс 47% хамааралтай байдаг тул нүүрсний эрэлт ойрын 5-10 жилд тогтвортой байна гэж үзэж болох юм.

³³¹ https://www.bdsec.mn/wp-content/uploads/2021/04/ETT_Bond_MNG_0407.pdf

Хятад Улсын хувьд нүүрснээс татгалзаж, байгальд ээлтэй түлш хэрэглэг стратеги хэрэгжүүлэхээр зарласан хэдий ч нийт 250 ГВт-ын хүчин чадалтай нүүрсээр ажилладаг эрчим хүчний блокуудыг барьж байгуулахаар төлөвлөж байна.

Хятад Улс нь дэлхийн нүүрсний хамгийн их нөөцтэй орнуудын нэг: 2019 оны эцсээр 1.1 их наяд тонн (дэлхийн батлагдсан нөөцийн 13.2%). Тус улс нь дэлхийн хамгийн том нүүрс үйлдвэрлэгч (дэлхийн үйлдвэрлэлийн 47% буюу 2019 онд 3.8 тэрбум тонн) бөгөөд нүүрсний хэрэглэгч (дэлхийн хэрэглээний 52 орчим хувь) юм. Хятадын нүүрсний томоохон сав газрууд аж үйлдвэр хөгжсөн бүс нутгуудтайгаа ойрхон байрлах тул цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд нүүрс ихээхэн хэрэглэдэг.

ВР-ийн мэдээлснээр одоогийн олборлолт дээр үндэслэн БНХАУ-ын батлагдсан нүүрсний нөөц нь 37 жилийн хугацаанд хангалттай байх тооцоолол гарч байгаа бөгөөд энэ нь урт хугацаандаа эрчим хүчний стратегия үндсээр нь өөрчлөхгүй тохиолдолд импортоос ихээхэн хамааралтай болгох юм.

ACRA-ийн үзэж байгаагаар нүүрсний нөөц дуусч байгаатай холбоотойгоор Хятад Улс нүүрс үйлдвэрлэх, ялангуяа импортын нүүрсэнд найдахаас илүүтэйгээр байгалийн болон шингэрүүлсэн хийн худалдан авалтыг нэмэгдүүлж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглахыг эрмэлзэнэ гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан Хятад байгалийн хийн болон шингэрүүлсэн хийн импорт, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээгээ нэмэгдүүлнэ гэж тооцсон байна. 2020 оны дундуур ОХУ-ын “Газпром” компани Хятадын түншүүдтэйгээ хийн нийлүүлэлтийг 6 тэрбум шоо метрээр нэмэгдүүлэхээр тохиролцсон байна. (жилд 44 тэрбум шоо метр хүртэл), ойрын ирээдүйд тус компанийн ТУЗ-ийн даргын хэлснээр Хятад руу хий экспортын хэмжээ 130 тэрбум шоо метрээс давна гэжээ.

Өнөөгийн байдлаар Хятад нүүрсний хэрэгцээгээ дотооддоо хангах боломжтой байгаа бол томоохон цахилгаан хэрэглэгчид болон Япон, Энэтхэг, ЕХ-ны орнууд импортын нүүрснээс хараат байгаа юм. Европын орнуудын эрчим хүчний альтернатив эх үүсвэрийг нэвтрүүлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч дунд хугацаанд (5-10 жил) нүүрснээс бүрмөсөн татгалзахад хүндрэлтэй байх болно гэж үзэж байна.

ОХУ-ын нүүрсний олборлолт 2020 онд 9%-иар, экспорт 3%-иар тус тус буурсан бол экспортод гаргасан 199 сая тонн нүүрсний гуравны хоёр нь Ази тивд ногдож байна. Экспортыг нэмэгдүүлэхэд тээврийн дэд бүтэц сул, байхгүй байгаатай байгаа бөгөөд Оросын Төмөр замын тооцсоноор Дорнод Сибирь дахь орд газар дахь 56 сая тонн нүүрс тээвэрлэгдэхгүй үлдэж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэхэд ОХУ Байкал-Амурын төмөр замын магистралийг өргөтгөж 1000 гаруй км зам тавих 9.6 тэрбум ам.доллар бүхий төсөл хэрэгжүүлэхээр мэдэгдсэн.

2.6 Монгол Улсын нүүрсний экспортын судалгаа

Нүүрсний зах зээлийн богино хугацааны хандлага дараах байдалтай байна:

Цар тахлын нөхцөл байдлын улмаас Монгол Улсын хувьд коксжих нүүрсний экспорт 2020 онд мэдэгдэхүйц буурсан нь БНХАУ-ын боомтод урьдчилан сэргийлэх хяналтыг чангатгасантай холбоотойгоор тээвэрлэлт удааширсантай холбоотой.

Тухайн оны эхний 11 сарын үзүүлэлтээр Монголоос 22.21 сая тонн коксжих нүүрс БНХАУ-аас импортолсон нь 2019 оны мөн үеэс 9.69 сая тонноор буюу 30.98%-иар буурсан.

Ингэснээр тус улсын коксжих нүүрсний нийт импортын 32.12%-ийг эзэлжээ. Монголын Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Замын-Үүд, Цагаандэл уул болон Булган гэсэн боомтуудаар коксжих нүүрс Хятад импортолж байна. Өнгөрсөн оны байдлаар Гашуунсухайт-Ганцмод боомтоор БНХАУ-ын 80 гаруй худалдаа эрхлэгчид Монголын

коксжих нүүрсийг импортолжээ. Тэдгээрээс “Chinalco”, “Wanli”, “Zituo”, “Yiteng” болон “Fangcheng” гэсэн компаниуд импортын хэмжээгээр тэргүүлсэн байна.³³²

2021 онд Монгол Улсаас 33-37 сая тонн коксжих нүүрс импортлох таамаг тооцоог “Today think thank”-ийн шинжээчид гаргасан байна. БНХАУ-ын зах зээл дээр Монголын коксжих нүүрсний эрэлт цаашдаа ч өндөр байна гэдгийг тэмдэглэж, үүнд дэд бүтэц, тэр дундаа боомтын нэвтрүүлэх хүчин чадал болон төмөр замын тээвэр хөгжүүлэлтээс хамаарч байгааг онцоллоо.

Эрчим хүчний нүүрсний тухайд, Монголын борлуулалтын үнэ коксжих нүүрсний үнээс хамаагүй доогуур байгаа ч тээврийн зардал үндсэндээ коксжих нүүрснийхтэй ижил, боомт хүрэх өртөг өндөр байна. Монголын эрчим хүчний нүүрсний экспортын өртөг зардалтай харьцуулахад Өвөр Монголын дотоодын эрчим хүчний нүүрснийх илүү өрсөлдөх чадвартай байгаа юм. Тиймээс төмөр замыг барьж дуусаагүй тохиолдолд Монголын эрчим хүчний нүүрс БНХАУ-ын зах зээлд үндсэндээ нэмэгдэх төлөвгүйг шинжээчид үзэж байна.

Хүснэгт 3. Монгол Улсын импортлох боломжтой нүүрсний хэмжээ

Хятад Улсын импортын бүтэц	Импортод эзлэх хувь	Эрчим хүчний нүүрсний импорт (сая тонн)	Коксжих нүүрсний импорт (сая тонн)
Индонез	34		
Австрали	32		
Монгол	16	300*0.16=48	75*0.16=12
ОХУ	13		
Нийт	95 хувь	Нийт импорт 300	Нийт импорт 75

Эх сурвалж: судлаачийн боловсруулснаар

2.7 Хятад Улс яагаад нүүрс импортолдог вэ?

Хятадын нүүрсний нөөцийн дийлэнх нь баруун болон хойд мужуудад байрладаг. Шаньси, Шэньси гэсэн хоёр муж болон Өвөрмонголын өөртөө засах орон Хятадын батлагдсан нүүрсний нөөцийн бараг 70 орчим хувь, нийт нүүрс олборлолтын талаас илүү хувийг дангаараа бүрдүүлдэг. Үүний эсрэгээр нүүрс хэрэглэдэг гол төвүүд хүн ам ихээр байрладаг хэдий ч тогтоогдсон нүүрсний нөөцийн 5 хүрэхгүй хувийг эзэлдэг тус улсын зүүн болон өмнөд хэсэгт оршиж байна. Энэхүү нүүрсний нөөцийн хуваарилалт, хэрэглээний тэнцвэргүй байдал нь нүүрсийг төмөр зам, авто замаар холын зайд тээвэрлэхийг шаардаж байгаа юм.

Түүнээс гадна дараах хүчин зүйлс Хятадын нүүрсний импортод нөлөөлж байна.

- ✓ Байгаль орчны аюулгүй байдал
- ✓ Коксжих нүүрсний нөөцийн хязгаарлагдмал байдал
- ✓ Олон улсын нүүрсний үнийн түвшин, хэлбэлзэл: Гадаадад байгаа нүүрс нь дотоодын нийлүүлэлтээрээ өрсөлдөх чадвартай болохын хэрээр Хятадын эрэг хавийн мужуудын аж ахуйн нэгжүүдийн нүүрс импортлох хандлага нэмэгддэг.
- ✓ Засгийн газрын бодлого

³³² <https://www.bloomberg.com/news/articles/2021-06-09/china-considers-imposing-price-controls-on-surg-ing-coal-market>

Хүснэгт 4. Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ болон үнийн төсөөлөл (2022-2024 он) (тонн/ам.доллар)

Төрөл	Нэр	Үнэ												Үнийн төсөөлөл*		
		2015.07	2016.12	2017.01	2018.01	2018.06	2019.01	2019.06	2020.01	2020.06	2021.01	2021.05	2022	2023	2024	
Боловсруулагүй нүүрс	Антрацит	68.83	64.25	91.70	167.40	148.69	145.02	131.36	121.83	96.20	114.08	161.90	85.0	84.3	86.0	
	Коксжих	42.36	40.30	127.71	139.60	128.20	128.16	127.05	109.94	103.99	150.88	193.69				
	Сул коксжих	34.42	29.81	58.79	94.40	89.87	91.45	83.02	76.71	69.09	90.32	108.42				
	Коксжих чанаргүй нүүрс	25.77	24.02	48.88	83.76	79.30	81.29	72.96	-	50.33	80.30	101.31				
Баяжуулсан нүүрс	Хүрэн нүүрс	-	-	-	-	-	-	-	-	45.41	79.76	93.94				
	Антрацит	71.59	65.57	105.33	171.15	146.97	150.68	145.20	135.66	111.19	123.73	167.77	112.0	115.0	115.0	
	Коксжих нүүрс	-	55.64	141.27	124.98	144.06	137.90	137.36	121.83	118.24	153.95	231.41				
	Сул коксжих нүүрс	-	42.72	100.03	109.69	116.97	114.67	110.19	99.27	93.67	122.13	153.78				
Кокс	Коксжих чанаргүй нүүрс	-	28.48	49.57	59.66	58.16	55.04	53.53	51.78	44.65	75.19	89.94				
	Кокс	-	-	-	-	-	-	-	178.65	175.29	283.51	291.99				


Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар <https://mpraat.gov.mn/news/2020/>,

2.8 Монгол Улсын нүүрсний нөөц

Монгол орны хэмжээнд 12 нүүрсний сав газар, 3 нүүрстэй талбайд энэ оны статистик мэдээгээр нүүрсний нийт батлагдсан геологийн нөөц 32.6 тэрбум.тн байна. 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар хүчин төгөлдөр нүүрсний 173 аж ахуйн нэгжийн 296 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар хүлээн авсан 32.61 тэрбум.тн нөөцийг аймаг тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

32.6 тэрбум.тн нүүрсний геологийн нөөцийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болон антрацит, чулуун, хүрэн гэсэн гурван төрөлд чанараар нь хуваан харуулбал дараах байдалтай байна.

Зураг 6. Геологийн нөөц (тэрбум тонн)³³³



Эх сурвалж: АМХЭГ

Томоохон ордуудын нөөцийн мэдээлэл³³⁴

Тавантолгой ордын нөөц: Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын нутгийг дамнан орших Тавантолгойн нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК ба “Энержи ресурс” ХХК-иуд нь Цанхи, Бор тээг, Оорцог, Бортолгой, Онч хараат, Ухаа-худаг гэсэн 6 хэсгээс бүрдэх ба нийт 10 тусгай зөвшөөрлийн хүрээнд 5,428.82 сая.тн нүүрсний нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар хүлээн авсан байдаг.

Нарийн сухайт ордын нөөц: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийн Сухайтын нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Монголын алт (МАК)” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК ба “Чинхуа Мак Нарийн Сухайт” ХХК-иуд нь Хүрэн толгой, Овоот толгой, Хүрэн шанд, Нарийн сухайт гэсэн 4 хэсгээс бүрдэх ба нийт 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд 1,004.94 сая.тн нүүрсний нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар хүлээн авсан байдаг.

³³³ Нүүрсний төрлүүд

- Хүрэн нүүрс (Lignite мөн "brown coal") нь бага хувирсан нүүрс бөгөөд ихэвчлэн дулааны цахилгаан станцад түлш болгон хэрэглэдэг.
- Чулуун нүүрс (Sub-bituminous болон bituminous coal) - нүүрсний хувирлын дунд шатны бүтээгдэхүүн. Дулааны цахилгаан станцад түлш болгон хэрэглэхээс гадна зарим онцгой төрөл-кокских нүүрсийг коксжуулан гангийн үйлдвэрт хэрэглэнэ.

Харас антрацит болон антрацит (Anthracite) - хамгийн их хувирсан нүүрс. Голчлон утаагүй түлш болгон хэрэглэнэ. <https://www.tavantolgoi.mn/post/41248>

³³⁴ <https://mrpam.gov.mn/news/1749/>

Хүснэгт 5. Эрдэс бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, хил нэвтэрсэн боомтоор 2016-2021.05

Боомтын нэр	Барааны нэр, хэм.нэгж	2016	2017	2018	2019	2020	2021 оны эхний 5 сар
Замын-Үүд	Чулуун нүүрс, тонн	201,315.8	1,339,948.6	1,771,134.7	1,477,423.3	1,724,599.9	867,920.3
	Үүнээс: автозамаар тээвэрлэсэн чулуун нүүрс, тонн						
	Зэсийн баяжмал, тонн	657,353.6	652,398.5	653,161.1	639,791.3	642,171.5	48,540.6
	Төмрийн хүдэр, тонн	5,320,401.5	4,959,590.0	5,544,591.3	7,003,769.0	7,905,403.1	261,738.5
	Хайлуур жоншны хүдэр, баяжмал, тонн	76,606.0	129,582.5	355,573.4	513,633.5	510,984.9	3,294,806.6
	Молибден, тонн	5,615.7	6,452.4	5,993.2	5,689.5	6,365.0	252,879.5
	Цайрын хүдэр, баяжмал, тонн	112,978.6	94,017.8	93,147.3	94,748.4	83,772.4	2,810.4
	Түүхий нефть, баррель	358,295.9	336,349.5	324,939.1	371,823.1	358,790.5	33,713.3
	Чулуун нүүрс, тонн	12,847,770.4	17,173,784.7	18,178,848.2	20,498,508.7	14,743,223.3	100,295.1
	Зэсийн баяжмал, тонн	904,635.2	794,823.5	783,570.2	763,830.8	752,880.8	3,569,246.9
Шивээхүрэн	Чулуун нүүрс, тонн	11,951,381.2	12,729,158.0	14,124,036.0	12,425,744.0	10,800,019.5	2,899,815.7
Ханги	Чулуун нүүрс, тонн	377,603.6	1,128,170.3	1,014,271.7	777,885.7	556,473.6	605,769.4
	Төмрийн хүдэр, тонн	5,434.3	10,247.6	80,444.5	86,536.3	142,378.6	83,658.7
Чулуун нүүрс тээвэрлэсэн автомашины ажилтын тоо, гарах урсгал	Замын-Үүд				2,577	2,164	658
	Гашуунсухайт	159,892	220,927	210,280	207,543	137,927	30,703
	Шивээхүрэн	121,660	129,256	141,631	121,968	104,762	27,374
	Ханги	4,314	13,136	10,743	8,183	5,802	6,242
Чулуун нүүрс тээвэрлэсэн автомашины тоо	Замын-Үүд				124	94	51
	Гашуунсухайт	6,433	14,012	17,886	10,956	8,669	7,196
	Шивээхүрэн	1,681	1,804	2,030	2,564	1,709	1,518
	Ханги	211	524	545	462	292	282

Эх сурвалж: ГЕГ

2.9 Хилийн боомтын талаарх мэдээлэл³³⁵

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэнээр Замын-Үүд боомтын том оврын тээврийн хэрэгслийн тоо 3 дахин, Гашуунсухайт боомтын нэвтрүүлэх хүчин чадал 3 дахин нэмэгдэнэ. Ханги боомтын нэвтрүүлэх хүчин чадлын хамгийн боломжит хэмжээгээр нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Замын-Үүд боомтын бүтээн байгуулалтын ажил³³⁶

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд хилийн Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтын ажлыг БНХАУ-ын 201 сая юань (75 тэрбум төгрөг)-ийн буцалтгүй тусламжаар санхүүжүүлж, төслийн хүрээнд зорчигч тээврийн 30, ачаа тээврийн 28 барилга, дэд бүтэц, ногоон байгууламж барина. Мөн шуурхай удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн теле хяналтын систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд болон өндөр хүчин чадлын рентген, тоног төхөөрөмжүүд суурилуулах юм. Боомтын барилга угсралтын ажлыг 2020 оны 10 дугаар сард дуусгахаар төлөвлөсөн боловч цар тахлын улмаас ажлын явц удааширч төлөвлөсөн хугацаанаас хойшлогдсон.

ГЕГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу өнөөгийн байдлаар Замын-Үүд боомтын зорчигч тээврийн хэсгийн ажлын гүйцэтгэл 31%-тай, ачаа тээврийн хэсгийн ажлын гүйцэтгэл 17%-тай байгаа бөгөөд зорчигч тээврийн хэсгийг 2021 онд, ачаа тээврийн хэсгийг 2022 онд ашиглалтад өгөхөөр төлөвлөсөн байна.

Хилийн Замын-Үүд боомт нь нийт зорчигчийн 40 хувь, суудлын тээврийн хэрэгслийн 76 хувь нэвтэрдэг импортын хамгийн том боомт боловч барилга байгууламж, дэд бүтэц нь өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангахгүй, ачааллаа дийлэхгүйгээс зорчигч, ачаа тээвэр хилээр нэвтрэхэд олон төрлийн хүндрэл тулгардаг.

Боомтын шинэчлэлээр нийт талбай 8 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, том оврын ачаа тээврийн хэрэгслийн тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 7 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ажил

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд 2019.10.15-ны өдөр Гашуунсухайт боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн.

Бүтээн байгуулалтын энэхүү ажлыг Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 148 сая юаний (55.3 тэрбум төгрөг) буцалтгүй тусламжийн санхүүжилтээр зэсийн баяжмал экспортлох 2, нүүрс экспортлох 10 эгнээ хүнд даацын авто зам, талбай, барилга байгууламж, дэд бүтэц, ногоон байгууламжийн цогцолбор баригдана.

Түүний зэрэгцээ Улсын төсвийн санхүүжилтээр тээврийн хэрэгслээс дээжийн агууламж, чанарыг автоматаар тодорхойлох дэвшилтэт тоног төхөөрөмж, өндөр хүчин чадлын рентген, орчин үеийн телехяналтын систем бүхий шуурхай удирдлагын төвтэй холбогдсон тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд суурилагдана.

³³⁵ <http://www.diiip.mn/khiliinboomt>

³³⁶ <http://upri.ub.gov.mn/wp-content/uploads/замын-үүд-Товч-танилцуулга.pdf>

Боомтын барилга угсралтын ажлыг 2020 оны 10 дугаар сард дуусгахаар төлөвлөсөн боловч цар тахлын улмаас ажлын явц удааширч төлөвлөсөн хугацаанаас хойшлогдсон. ГЕГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу өнөөгийн байдлаар Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ажил бүрэн эхлээгүй, ажилчдын орон сууцны барилга, үерийн далан барих зэрэг бэлтгэл ажлын хэмжээнд явагдаж байна.

Гашуунсухайт боомт нь нүүрсний экспортын 51.4 хувь, зэсийн баяжмалын экспортын 55 хувийг нэвтрүүлдэг боловч одоогийн зам талбай, дэд бүтэц, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа нь өсөн нэмэгдэж буй экспортын хэрэгцээ шаардлагад хүрэлцэхгүй, ачааллаа дийлэхгүйн улмаас 100 гаруй км тээврийн хэрэгслийн дараалал үүсгэж, иргэдийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Түүнчлэн “нүүрсний хулгай” зэрэг хууль бус, маргаантай үйлдлүүд гарсаар байна.

Боомтын шинэчлэлийн үр дүнд нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэж, экспортын байгалийн баялгийн чанар, тоо хэмжээг бүрэн тодорхойлж татварыг бүрэн хурааж, Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны өсөлт, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд чухал ач холбогдолтой юм.

Ханги боомтын бүтээн байгуулалтын ажил

Ханги боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тойм зургийг “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн нэгж гүйцэтгэсэн бөгөөд “Хилийн боомтын үндэсний зөвлөл”-өөр хэлэлцүүлэн шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Дорноговь аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хот хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Бугат хотын хөрөнгө оруулалтаар суурьшлын бүсийг импортын цахилгаан эрчим хүчээр хангахаар талууд тохиролцоноор 2018 оны 10 дугаар сараас эхлэн Ханги хилийн боомт эрчим хүч хэрэглэж байна.

Хоёр талын гэрээгээр дээрх шугам, станц нь Монгол Улсын өмч болох бөгөөд цаашид эрчим хүчний засвар үйлчилгээг БНЗӨБЦТС ТӨХК-ийн Дорноговь аймаг дахь салбар хариуцан ажиллах аж. Дээрх ажлыг аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” /2016-2020/ үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Ханги хилийн боомтын цогцолборын бүтээн байгуулалт, дэд бүтэц, боловсруулах үйлдвэр барих, үйлчилгээг өргөжүүлэх төсөл хөтөлбөрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн байна.³³⁷

2.10 Боомтын хүчин чадлын үнэлгээ

Төмөр зам Монгол Улсын хилийн боомтоор өнгөрч Хятад улсын хилийн боомтоор гарах тул нүүрс тээвэрлэх чадварын хувьд бие даасан бөгөөд хүрэлцээтэй шинж чанартай. Иймд шинэ автозамын хүчин чадалтай холбож боомтын хүчин чадалд үнэлгээ өгөх нь зүйтэй юм.

Боомтууд 7 хоногийн 6 өдөр ажиллаж байгаа бөгөөд жилд $6 \times 52 = 318$ хоног дунджаар ажиллана. Нэг хоногт боомтоор гаргах ачааны хэмжээг жилийн нийт хоногийн тоогоор үржүүлснээр нэг жилд гарах нийт ачааны хэмжээ гарч ирнэ. Нийт ачаанаас 2 сая тонн хэмжээтэй нь нүүрснээс бусад ачаа тээврийн хэмжээг эзэлдэг гэж үзвэл автозамаар тээвэр хийж боомтоор гаргах нүүрсний хэмжээг дараах байдлаар тооцоолно.

³³⁷ <https://montsame.mn/mn/read/171832>

Хүснэгт 6. Боомтын хүчин чадлын үнэлгээ

Одоо байгаа боомтын хүчин чадал: Нэвтрүүлж буй ачааны машины тоо	Хүчин чадал 3 дахин нэмэгдэх үед	Нэгж ачааны машины даацыг 100 тонн гэж үзвэл	Жилд нэвтрүүлэн ачаа тээвэр	Бусад ачаа тээвэр болох 2 сая тонныг хасвал
Замын Үүд боомтоор өдөрт 166 ачааны автомашин	498	49800	49800*318=15.8 сая тонн	13.8 сая тонн
Гашуунсухайт боомтоор 450 тээврийн хэрэгсэл	1350	13500	13500*318=42.9 сая тонн	40.9 сая тонн
Ханги боомтоор 55-70	187.5	18750	18750*318=5.9 сая тонн	3.9 сая тонн

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх хүснэгтийн сүүлийн багана дахь ачааны хэмжээг нэгтгэж жилд ямар хэмжээний нүүрсийг авто замаар тээвэрлэн боомтоор гаргах боломжтой болохыг тооцвол 58.72 сая тонн гарч байна. Энэ нь шинээр баригдаж буй Тавантолгой-Манлай-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамуудын нүүрс тээвэрлэлтийн нийт хүчин чадал болох $(23.5-2)+(30-2)=49.5$ сая тонноос өндөр байгаа нь боомтын хүчин чадлын өсөлт автозамын бүтээн байгуулалтын үр дүнд бий болох нүүрс тээврийн ачааны өсөлтийг нэвтрүүлж чадахаар түвшинд байгаа болох нь харагдаж байна.

III. ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**3.1 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл³³⁸**

Монгол Улс 2008 онд үндэсний төмөр замын сүлжээг өргөтгөх урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, Говийн бүсийн төмөр зам, Зүүн бүсийн төмөр зам, Баруун бүсийн төмөр зам, Хэвтээ чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтуудыг хийхээр төлөвлөсөн.

УИХ-аас 2010 онд “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын тухай 32 дугаар тогтоолыг баталсан. Түүнд шинээр 6600 гаруй км төмөр замыг 3 үе шаттай барихаар заасан бөгөөд эхний үе шатанд баригдах 1100 км төмөр замын хэсэгт **Тавантолгой-Зүүнбаян** чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулахаар тусгасан байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух 30 км-ийн бүсэд Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 37 ашигт малтмалын орд газар байдаг. Тавантолгойн нүүрсний ордоос гадна Цагаан суврагын зэсийн орд, Хармагтайн зэс, алтны орд, Манлайн нүүрсний орд зэрэг нүүрс, зэс, алт, гөлтгөнө, цеолит, ураны томоохон ордууд байршиж байгаа бөгөөд 6.02 тэрбум тоннын нөөц бүхий баялагтай.

Төмөр замыг барьснаар Тавантолгойн нүүрсний уурхайн коксжих нүүрсийг ОХУ, БНХАУ руу экспортлох шинэ гарц бий болгох ба төмөр замын трассын дагуу томоохон орд газрууд байрлаж байгаа нь уул уурхайн экспортод чухал үүрэгтэй гэж үзсэн байна.

Байршил:

Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сум, Дорноговь аймгийн Мандах, Сайншанд сумын Зүүнбаян багийн нутаг дэвсгэрийг хамарна. Энэ төмөр зам нь Тавантолгойн уурхайг УБТЗ-ын төв магистраль шугамтай холбох юм.

³³⁸ Шинэ төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсгийн тодотгол, 2019 он

Төслийг хэрэгжүүлэгч:

Захиалагч - “Монголын төмөр зам” ТӨХК

Доод бүтцийн ажлын гүйцэтгэгч - Зэвсэгт хүчний жанжин штаб болон дотоодын 46 аж ахуйн нэгж

Дээд бүтцийн ажлын гүйцэтгэгч - “УБТЗ” ХНН

Санхүүжилт:

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг байгуулахад 2.85 их наяд төгрөг шаардлагатай бөгөөд төмөр замын суурь бүтцийг барьж байгуулахад 2.39 их наяд төгрөг зарцуулж, хөдлөх бүрэлдэхүүн болох вагон, зүтгүүрийг 460.11 тэрбум төгрөгөөр худалдан авахаар тооцсон.

Хүснэгт 7. Нийт хөрөнгө оруулалт

	Ажлын нэр	Хөрөнгө оруулалт (сая төгрөг)
	Суурь бүтэц:	
	ТЭЗҮ, зураг төсөл	14,773.73
	Төслийн удирдлага	28,833.24
	Талбайн хяналт (Геологи, геодези)	3,959.02
	Замын доод бүтэц (Хоолой, газар шорооны ажил)	683,270.42
	Барилга, депо, засварын газрын барилга угсралтын ажил	1,288,873.92
	Гүүр	130,480.43
	Замын дээд бүтэц	70,928.94
	Дохиолол холбоо	80,000.00
	Эрчим хүч	31,838.35
	Магадлашгүй зардал	60,239.58
	Суурь бүтэц нийт	2,393,197.63
	Хөдлөх бүрэлдэхүүн:	
	Зүтгүүр (24 зүтгүүр)	190,656.00
	Вагон (1272 вагон)	269,460.00
	Хөдлөх бүрэлдэхүүн нийт	460,116.00
	НИИТ	2,853,313.63

Эх сурвалж: ТЭЗҮ

Эхний ээлжийн санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК хүүгүй, 20 жилийн хугацаатай, 750 тэрбум төгрөгийн үнэ бүхий үнэт цаас гаргаж “Эрдэнэс-Тавантолгой” ХК худалдан авах замаар санхүүжүүлнэ. /нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгаж, эргэн төлөгдөх нөхцөлтэй/

ТЭЗҮ-д шаардлагатай санхүүжилтийн үлдэгдэл 2.10 их наяд төгрөгийг 6%-ийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлээр санхүүжүүлэхэд 1.19 их наяд төгрөгийн зээлийн хүү бүхий 3.30 их наяд төгрөгийг зээлдэгчид эргүүлэн төлөхөөр тооцоолжээ.

Төслийн санхүүгийн үр дүн

Ачааны хэмжээ

Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх ачааны хэмжээг 2021, 2022 онд 10 сая тонн, 2023, 2024 онд 12 сая тонн, 2025-2040 онуудад тээвэрлэх ачааны хэмжээг доод тал нь 15 сая тонн байна гэж үзсэн.

Тариф

Энэхүү төмөр замаар нүүрс тээвэрлэх үндсэн тарифыг тонн.км нь 0.035 ам.доллар (92.45 төгрөг) байхаар тооцсон бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний ханшийн зүй тогтлоос нь хамааран 2 жилд 5% нэмэгдүүлэхээр тооцсон.

Үйл ажиллагаа эхэлснээс хойш 20 жилийн хугацаанд 13.5 их наяд төгрөгийн орлого, жилд дунджаар 674.8 тэрбум төгрөгийн тээврийн орлого олно гэж тооцоолсон. Уг төмөр зам үйл ажиллагаа эхэлсэн эхний жил 383.6 тэрбум төгрөг 20 дахь жил буюу 2040 онд 835 тэрбум төгрөгийн тээврийн орлого олохоор тооцоолсон байна.

Хүснэгт 8. 2021-2040 оны тээврийн орлогын төлөв

Үзүүлэлт	Нэгж	2021	2022	2023	2024	2025
Ачааны хэмжээ	сая.тн	10	10	12	12	15
Тариф	төг	92.45	92.45	97.08	97.08	101.93
Тээврийн орлого	сая.төг	383689.49	383689.49	483458.4	483458.4	634514.25
		2026	2027	2028	2029	2030
Ачааны хэмжээ	сая.тн	15	15	15	15	15
Тариф	төг	101.93	106.55	106.55	111.17	111.17
Тээврийн орлого	сая.төг	634514.25	663273.75	663273.75	692033.25	692033.25
		2031	2032	2033	2034	2035
Ачааны хэмжээ	сая.тн	15	15	15	15	15
Тариф	төг	115.79	115.79	120.41	120.41	125.03
Тээврийн орлого	сая.төг	720792.75	720792.75	749552.25	749552.25	778311.75
		2036	2037	2038	2039	2040
Ачааны хэмжээ	сая.тн	15	15	15	15	15
Тариф	төг	125.03	129.65	129.65	134.27	134.27
Тээврийн орлого	сая.төг	778311.75	807071.25	807071.25	835830.75	835830.75

Эх сурвалж: ТЭЗҮ

ТЭЗҮ-д тооцоолсноор 20 жилийн хугацаанд 13.5 их наяд төгрөгийн орлого олж, 8.8 их наяд төгрөгийн зардал гаргаж, 3.5 их наяд төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллана.

Түүнчлэн мөн хугацаанд улсад 1.16 их наяд төгрөгийн татвар төлнө. Хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод хувь (IRR) нь 8.9%-тайгаар анхны хөрөнгө оруулалтаа (Payback period) 14 жилийн хугацаанд, үйл ажиллагаа эхэлснээс хойш 12 жилийн хугацаанд нөхөх боломжтой.

NPV буюу цэвэр өнөөгийн үнэ цэнээрээ 273.8 тэрбум төгрөгийн ашигтай, Ашигт байдлын индекс 1.096 байна.

Хүснэгт 9. Үр ашгийн тооцоо

№	Үзүүлэлт	2021 он
1	Орлого	13,497,055.79 сая төгрөг
2	Ашиглалтын үеийн зардал	8,818,295.75 сая төгрөг
3	Үйл ажиллагааны ашиг	4,678,760.04 сая төгрөг
4	Татвар	1,169,690.01 сая төгрөг
5	Цэвэр ашиг	3,509,070.03 сая төгрөг
6	Цэвэр өнөөгийн үнэ цэнэ (NPV)	273,860.16 сая төгрөг
7	Өгөөжийн дотоод хувь (IRR)	8.90%
8	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа (PbP)	12
9	Ашигт байдлын индекс (PI)	1.096

Эх сурвалж: ТЭЗҮ

Хэрэгжүүлэх хугацаа:

2 жилийн хугацаатай хэрэгжинэ. (Шав тавих ёслолын ажиллагаа 2019 оны 5-р сарын 24-ны өдөр болсон.)

Техникийн үндсэн үзүүлэлтүүд:

Зэрэглэл	Монголын төмөр замын 3-р зэрэглэл
стандарт	MNS 6229-2010
Гол замын урт	414.6км
Дэлгэмэл урт	486.6км
Өртөө	1
Зөрлөг	6
Голын даац	25 тн
Цариг	1520 мм /өргөн цариг/

Удирдах хэвгий Тавантолгой-Зүүнбаян талдаа 6%, Зүүнбаян-Тавантолгой талд 9%

Хүчин чадал:

Жилд 15 сая тн ачаа тээвэрлэхээр тооцоолсон.

Тээвэрлэлтийн төлөвлөгөө

Энэхүү төмөр замаар 2021 онд 8 сая тонн ачааг тээвэрлэхээр тооцоологдсон бөгөөд хоногт 8 хос галт тэрэг аялуулна. 80 вагоноос бүрдсэн 1 галт тэргээр 5680 цэвэр тонн ачаа тээвэрлэх бөгөөд ачааны вагоны хамтаар бохир жин нь 7500 тонн байна.

Жилийн ажлын өдрийг 365 хоногоор тооцвол 1 өдөрт 8 галт тэргээр 45440 тонн, 1 жилд 14995200 тонн ачаа тээвэрлэх боломжтой. Төлөвлөгдсөн 15 сая тонн ачааг 1 жилд тээвэрлэх бүрэн боломжтой гэж үзсэн. 2023 онд 23 сая тонн ачааг тээвэрлэнэ гэж тооцоолсон бөгөөд хоногт 12 ачаатай галт тэрэг явуулна.

Өртөө, зөрлөг

Тавантолгой өртөөнд нүүрс ачих ачааны терминалтай байх ба энэ терминалын замуудын тоо, байрлалыг тусдаа уурхайнуудын бүтээгдэхүүн гаргалтын хэмжээнээс хамааран тогтоохоор тооцсон. Түүнчлэн Тавантолгой өртөө нь зүтгүүр ба вагон засвар, зэхэлтийн газруудтай байна.

Зөрлөгийн замуудын урт

Зөрлөгийн замуудын ашигтай уртыг 1700 м байхаар сонгосон. Замын ийм урт нь мөн 80 вагонтай, 5680 тонн цэвэр жинтэй, 23,5 тонн голын ачаалал бүхий галт тэргэнүүдийг татах боломж олгоно. Зөрлөгүүд нь хамгийн багадаа 3 замтай байх бөгөөд тус зөрлөг нь галт тэргийг өнгөрөөх, гүйцэж түрүүлүүлэх зориулалттай.

Галт тэрэгний бүрэлдэхүүн

23,5 тонн голын даац бүхий С70 загварын 14 метр урт вагонуудаас бүрдэнэ гэж тооцоолсон. С70 вагон нь дараах үндсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

Бохир жин	92.8 тонн
Хувийн жин	22.8 тонн
Голын даралт	23.2 тонн
Даац	70 тонн
Вагоны урт	14.0 метр

Вагоны парк

Вагоны тоог ачаа тээврийн хэмжээ, галт тэргэнүүдийн цэвэр жин, шаардагдах галт тэргэнүүдийн тоо, галт тэрэг хоорондын интервал, очих өртөөнүүдийн хоорондох эргэлтийн хугацаа зэргийг үндэслэн тогтоосон байна. 2021 онд ачаа тээврийн 1/4 нь Сайншандад, 3/4 нь БНХАУ-ын Эрээн өртөөнд, 2023 онд нийт ачааны 1/3 нь Сайншандад, 2/3 нь Эрээн өртөөнд хүргэгдэнэ гэж таамагласан байна.

Хүснэгт 10. Шаардлагатай ачааны вагоны паркийн хэмжээ

	Шаардлагатай вагоны тоо	
	2021 он	2023 он
Тавантолгойгоос Сайншанд хүртэл тээвэрлэлт хийх	158	316
Тавантолгойгоос Эрээн хүртэл тээвэрлэлт хийх	904	1206
Нөөц	54	77
Нийт	1116	1599

Тайлбар: Нөөцийг нийт вагоны паркийн 5%-аар тооцсон болно.

*Эх сурвалж: ТЭЗҮ***Төслийн явц:**

2021 оны 5-р сарын 10-ны байдлаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын ажил дараах гүйцэтгэлтэй явагдаж байна.³³⁹

Далан, ухмалын ажил:

416.1 км урт, 25.1 сая метр.куб бүхий төмөр замын далан, ухмалын барилгын ажлыг зэвсэгт хүчний 9 анги нэгтгэл, үндэсний 49 аж ахуй нэгж компани хамтран бүрэн хийж дуусгасан байна.

Гүүр хоолойн ажил:

Зэвсэгт хүчний 1 анги, 13 аж ахуй нэгж төмөр замын трассын дагуу нийт 2427 урт метр бүхий 27 гүүрийг барьж дуусгасан. Мөн трассын дагуу байрлах 379 дөрвөлжин хоолой, 216 дугуй хоолой бүхий нийт 595 хоолойн ажлыг зэвсэгт хүчний 9 анги нэгтгэл, үндэсний 25 компани хамтран бүрэн хийж дуусгасан.

2020 онд төмөр замын доод бүтэц, хиймэл байгууламжийн барилгын ажлууд бүрэн хийгдэж дууссан.

Өртөө, зөрлөг:

Энэ нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын эхлэл цэг дээр баригдаж буй өртөөний барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ бүрэн шийдэгдсэн нийт 120 айлын 3 ш орон сууц удирдлагын байр, зүтгүүр зэхэх депо, зам ангийн барилга зэрэг цогц байгууламж бөгөөд 1 өртөө 6 зөрлөгтэй баригдахаар төлөвлөгдсөн. Одоогоор 1 зөрлөгийн барилга байгууламжуудыг ашиглалтад хүлээн авсан. Бусад зөрлөгийн барилгын ажил 98 хувь, өртөөний барилгын ажил 71 хувийн гүйцэтгэлтэй. Зэвсэгт хүчний 5 анги ажиллаж байна.

Цахилгаан, эрчим хүч:

Төмөр замын дагуу 455.5 км 35 киловаттын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг үндэсний 10 компани 80 хувийн гүйцэтгэлтэйгээр барьж байна. Дэд станцын өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 74,7 хувь, өртөө, зөрлөг, парк перроны гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл дуусаж экспертизээр баталгаажсан. Агаарын шугам өндөрлөх ажил бүрэн дууссан.

Дохиолол холбоо:

Төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны байгууламжийн ажлын хүрээнд төмөр замын 2 талаар цагираг хэлбэрээр нийт 871 км шилэн кабель угсарч

³³⁹ <https://www.mtz.mn/content/show/id/1225>

суурилуулахаас одоогийн байдлаар 620 км шилэн кабель тарааж угсарч, суурилуулсан. Уг ажлыг 5 аж ахуй нэгж 71%-ийн гүйцэтгэлтэй хийж байна.

Нийт 859.4 мянган метр куб балласт олборлохоос 784.9 мянган метр куб буюу 92 хувийг олборлосон.

Бетон дэр:

Төмөр замд 842.6 мянган ширхэг бетон дэр шаардлагатайгаас 622.6 мянган ширхэгийг дотоодын 4 үйлдвэрт үйлдвэрлэсэн ба 74.3 хувьтай байна.

Төмөр замын дээд бүтцийн барилга угсралт:

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дэлгэмэл урт нь 463 км бөгөөд үүнээс 422 км дээд бүтцийг угсарсан. Нийт 168 км-т балласт буулгаж чигжих ажил үлдсэн байна.

Ач холбогдол: Тавантолгойн уурхайгаас коксжих нүүрс экспортлох, уул уурхайн ба аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэртэй гэж үзээд төмөр замын эдийн засгийн үр ашгийг дараах байдлаар тодорхойлжээ.

Монголын уул уурхайн экспортод голлох нөлөө үзүүлэх төмөр замын чиглэл болно. Орд газрууд эдийн засгийн эргэлтэд орох боломж бүрдэнэ.

Уул уурхайн салбарын хөгжилд гол нөлөө үзүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний үнийг өсгөн тээвэрлэлтийн зардлыг бууруулна.

Энэ чиглэлийн төмөр зам баригдаж, “УБТЗ” ХНН-ийн гол замтай холбогдон төмөр замын нэгдсэн сүлжээ ашиглалтад орсноор БНХАУ, ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд /Тавантолгойн ордын нүүрсийг Хятад, Солонгос, Японы зах зээлд хүргэх/ хүрч экспортын хоёр ба гурав дахь шинэ гарцуудыг бий болгож эцсийн хэрэглэгчид шууд хүргэх, далайн боомт нөхцөлөөр бүтээгдэхүүнийг борлуулах нөхцөл бүрдэнэ. Одоогийн байдлаар манай улс уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр борлуулж байна.

Ашигт малтмалын нөөц бүхий ордуудыг ашиглах, аж үйлдвэрийн парк байгуулах орон нутагт ажлын байрны тоог нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн бодит үр өгөөжийг өгнө. Төмөр зам ашиглалтад орсноор 1000 орчим шууд ажлын байр шинээр бий болно.

Тавантолгойн коксжих нүүрсний олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ өнөөгийн түвшнээс 2 дахин нэмэгдэх боломж бүрдэнэ.

БНХАУ руу экспортлох эерэг хамааралт бүтээгдэхүүн болох төмрийн хүдрийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой. Улс орны хөгжилд стратегийн ач холбогдолтой, чухал бүтээгдэхүүний нэг ган бөгөөд түүнийг гарган авдаг гол түүхий эд нь коксжих нүүрс, төмрийн хүдэр юм. Манай улс коксжих нүүрс, төмрийн хүдрийн арвин нөөцтэй бөгөөд Сайншандад Дархан, Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийг Тавантолгой коксжих нүүрсээр боловсруулан ган үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангах, улмаар ган металлургийн хүнд үйлдвэрлэл хөгжих, экспортлох боломжтой болно.

Төмөр замын дэд бүтэц хөгжихийн зэрэгцээгээр бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдлын асуудал үлэмж хэмжээгээр багасна.

Говийн бүсэд төмөр зам дагасан суурьшлын томоохон төвүүд шинээр үүсэж, түүнийг дагасан хөнгөн болон хүнд үйлдвэр хөгжих боломж бүрдэнэ.

Төмөр зам баригдсанаар уул уурхайн салбараас гадна бусад салбарын хөгжил, тэдгээрийн логистикт чухал нөлөө үзүүлнэ.

Тавантолгой нүүрсний уурхайн коксжих нүүрсийг ОХУ, БНХАУ руу экспортлох шинэ гарц бий болгох ба шинээр барих төмөр замын трассын дагуу Цагаансуварга, Төмөртэйн Овоо, Хармагтай, Манлай зэрэг нүүрс, төмөр, зэс, цайрын томоохон орд газрууд байрлаж байгаа нь Монголын уул уурхайн экспортод голлох нөлөөг үзүүлэх төмөр замын чиглэл болох болно.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамыг барьж одоо байгаа дотоодын төмөр замын сүлжээгээр дамжуулан Орос, Хятадын төмөр замын сүлжээнд холбогдох, цаашилбал далайн боомтуудад хүрэх.

Тавантолгойн ордын нүүрсийг Хятад, Солонгос, Японы зах зээлд хүргэх.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух 30 км-ийн бүсэд зөвхөн Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ашигт малтмалын орд газрууд нийт 37 байна. Тавантолгойн нүүрсний ордоос гадна Цагаан суврагын зэсийн орд, Хармагтайн зэс алтны орд, Манлайн нүүрсний орд зэрэг нүүрс, зэс, алт, гөлтгөнө, цеолит, ураны томоохон ордууд байршиж байгаа бөгөөд 6.02 тэрбум тоннын нөөц бүхий баялаг байна. Төмөр зам баригдсанаар эдгээр орд газар эдийн засгийн эргэлтэнд орох боломж бүрдэж байна

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам баригдаж, “УБТЗ” ХНН-ийн гол замтай холбогдон төмөр замын нэгдсэн сүлжээ ашиглалтад орсноор Монгол Улсын эдийн засагт бодит үр өгөөж өгөх ба БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын хоёр ба гурав дахь шинэ гарцуудыг бий болгож эцсийн хэрэглэгчид шууд хүргэх, далайн боомт нөхцөлөөр бүтээгдэхүүнийг борлуулах нөхцөл бүрдэнэ. Өнөөгийн байдлаар манай улс уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр борлуулж байна.

Улс орны хөгжилд стратегийн ач холбогдолтой, чухал бүтээгдэхүүний нэг ган бөгөөд түүнийг гарган авдаг гол түүхий эд нь коксжих нүүрс, төмрийн хүдэр юм. Монгол улс коксжих нүүрс, төмрийн хүдрийн арвин нөөцтэй бөгөөд Сайншандад Дархан, Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийг Тавантолгой коксжих нүүрсээр боловсруулан ган үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангах, улмаар ган металлургийн хүнд үйлдвэрлэл хөгжих, экспортлох боломжтой болно.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам баригдаж, “УБТЗ” ХНН-ийн гол замтай холбогдон төмөр замын нэгдсэн сүлжээ ашиглалтад орсноор Монгол Улсын эдийн засагт бодит үр өгөөж өгөх ба БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын хоёр ба гурав дахь шинэ гарцуудыг бий болгож эцсийн хэрэглэгчид шууд хүргэх, далайн боомт нөхцөлөөр бүтээгдэхүүнийг борлуулах нөхцөл бүрдэнэ. Өнөөгийн байдлаар манай улс уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр борлуулж байна.

Нүүрсний тээвэрлэлтийн зардлыг багасгаж, БНХАУ-ын коксжих нүүрс импортлогч хамгийн том бүсүүд болох Хэбэй, Ляонин мужууд дахь үйлдвэрүүдэд хямд зардлаар нүүрс хүргэх ач холбогдолтой.

Тус төмөр зам баригдсанаар Тавантолгойн коксжих нүүрсний 1 худалдан авагч, нэг зах зээлээс хамаарсан үнийн өрсөлдөөнгүй байдлыг байхгүй болгоно. Зүүн хойд Хятадын зах зээлд эрэлтэд тулгуурласан, үнийн өрсөлдөөнт байдлаар олон гарцаар зэрэг нийлүүлэх, мөн түүнчлэн БНХАУ, ОХУ-аар дамжин далайн чанад дахь Япон, Солонгос зэрэг гуравдагч зах зээлд өндөр үнээр уул уурхайн бүтээгдэхүүнийг нийлүүлж борлуулах боломж бүрдэнэ.

Төмөр замын нэгдсэн сүлжээг барьж байгуулснаар Монгол Улс ашигт малтмалын нөөц бүхий идэвхгүй байгаа ордуудаа ашиглах, олон улсын үнэ тарифаар худалдан авагчдад түгээх боломж бүрэн нээгдэнэ.

Монгол Улс төмөр замын сүлжээг стратегийн орд газрууд болон томоохон төслүүдтэйгээ холбосноор Аж үйлдвэрийн парк байгуулах, нэмүү өртөг шингэсэн боловсруулсан уул уурхайн бүтээгдэхүүнийг олон улсад гаргах эдийн засгийн томоохон боломжийг бий болгоно

Улс орны хөгжилд стратегийн ач холбогдолтой, чухал бүтээгдэхүүний нэг ган бөгөөд түүнийг гарган авдаг гол түүхий эд нь коксжих нүүрс, төмрийн хүдэр юм. Монгол улс коксжих нүүрс, төмрийн хүдрийн арвин нөөцтэй бөгөөд Сайншандад Дархан, Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийг Тавантолгой коксжих нүүрсээр боловсруулан ган үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангах, улмаар ган металлургийн хүнд үйлдвэрлэл хөгжих, экспортлох боломжтой болно.

Тавантолгойн коксжих нүүрсний олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ өнөөгийн түвшнээс 2 дахин нэмэгдэх боломж бүрдэх бөгөөд БНХАУ руу экспортлох эерэг хамааралт бүтээгдэхүүн болох төмрийн хүдрийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болно.

Төмөр замын дэд бүтэц хөгжихийн зэрэгцээгээр бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдлын асуудал үлэмж хэмжээгээр багасна.

Зүүнбаян нь Дорноговь аймгийн нутагт орших тосгон бөгөөд засаг захиргааны хувьд Сайншанд сумын нэг баг юм. 3000 гаруй оршин суугчтай. Зүүнбаян тосгоны хүн ам 2-3 дахин өсч, 7-10 мянган хүн амтай томоохон суурьшлын төв бий болно. Тавантолгойн нүүрсний уурхай, Тавантолгойн төмөр замын өртөө байрлах Өмнөговь аймгийн Цогтцэций сум мөн адил томоохон суурьшлын төв болон хөгжих болно. Хүн амын суурьшил дагасан хөнгөн болон хүнд үйлдвэр хөгжинэ.

Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ. Өмнөговь, Дорноговь аймагт төмөр замын уг чиглэл ашиглалтад орсноор 1000 орчим шууд ажлын байр, төмөр замыг дагаад олон ажлын байр шинээр бий болохоос гадна олборлолтын хэмжээ нэмэгдсэнээр уурхайнууд, тэдгээрт үйлчлэх салбаруудын олон мянган ажлын байр хадгалагдаж, нэмэгдэнэ.

Төмөр зам баригдсанаар зөвхөн уул уурхайн салбарт бус хүнс, мал аж ахуйн салбар, арьс ширний үйлдвэрлэл, тэдгээрийн логистикт чухал нөлөөг үзүүлнэ. Бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаа улам бүр хөгжинэ.

Холбогдох тогтоол шийдвэрүүд

УИХ-аас 2010 онд **Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг** баталж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг 1-р үе шатанд барьж байгуулахаар шийдвэрлэсэн.

2011 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн “**Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого**”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 35/32 дугаар зөвлөмж гаргасан. Үүнд шинээр барихаар заасан төмөр замын суурь бүтцийн концессыг уралдаант шалгаруулалтаар олгох нь үндэсний аюулгүй байдалд харшилна гэж үзсэн тул уг концессыг төрийн өмчит, эсхүл төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд шууд гэрээний үндсэн дээр олгох гэж зааж өгсөн.

Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын эхний болон хоёр дугаар үе шатанд баригдах төмөр замын суурь бүтцийг нийгэм, эдийн засагт онц ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц гэж үзэж, эдгээр төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор төмөр замын суурь бүтцийг “барих-ашиглах-шилжүүлэх” концессыг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

УИХ-ын 2018 оны 6-р сарын 29-ны өдрийн “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүдийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан.

Засгийн газрын 2019 оны 4-р сарын 10-ны өдрийн “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолоор шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор 1 удаагийн, хүүгүй, 20 хүртэлх жилийн хугацаатай 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК худалдах, “Эрдэнэс-Тавантолгой” ХК худалдан авах замаар санхүүжүүлэхийг даалгасан.

3.2 Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор³⁴⁰

Одоогийн байдлаар БНХАУ руу авто замаар нүүрс экспортлоход хил хүртэл тээвэрлэж буй зардал тонн тутамд 32 ам.доллар зарцуулдаг бол төмөр замаар тээвэрлэхэд уг зардал 4 дахин буурч 8 ам.доллар болно. Мөн улсын төсөвт жилд 20-28 сая ам.долларын татвар төлөхөөс гадна 25 жилийн хугацаанд ойролцоогоор 1 тэрбум ам. долларыг Засгийн газарт төвлөрүүлж, эдийн засгийн өсөлтөд бодитойгоор дэмжлэг үзүүлнэ гэж үзсэн.

Энэхүү төмөр зам нь Монголд анхны 1-р зэрэглэлийн UIC-60 уулзваргүй төмөр зам болж байгаагаараа онцлогтой. Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл 240 орчим километр гол замтай, 2 өртөө, 5 зөрлөгтэй, нэг голын даац нь 25 тонн, 16 гүүр, 126 хоолой, малын 8 гарцтай баригдаж байна.

Төмөр зам нь MNS 6229-2110 стандартын дагуу баригдаж байгаа бөгөөд дараах багц ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж байна. Үүнд:

Дээд, доод бүтэц: 16 ширхэг нийт 1300м уртын гүүр, 123 ширхэг ус зайлуулах хоолой, мал амьтны гарц, 30 мян.тн зам төмөр, 475 мян.ш бетон дэр, 475 мян ширхэг багц бэхэлгээ, 57ш. суман шилжүүлэг.

Дохиолол холбоо: SCADA, TETRA тоон радио систем 10 цамхаг (30-70м өндөр) GPRS, GNSS галт тэрэгний байршил тогтоох систем.

Өртөө зөрлөгийн барилга байгууламж: 2 өртөө, 5 зөрлөг, Ачилтын тойрог, Удирдлага хяналтын төв, Оффис, 110 айлын ажилчдын орон сууц, 1500 хүний түр сууц, агуулах гэх мэт 70,000 м2 байгууламж.

Делогийн барилга байгууламж: Хөдлөх бүрэлдэхүүн, эд анги болон зам засварын цех, зэхэлтийн төв. Үүнд зүтгүүрийн 4 цех, вагоны 6 цех.

Эрчим хүч хангамж: 35/10kV-ын 3 дэд станц, 270 км урт 35кВт-ын ЦДАШ.

Шилэн кабел: 600 км урт шилэн кабел.

Хөдлөх бүрэлдэхүүн: Зүтгүүр 16, Вагон 810.

Засварын тоног төхөөрөмж: Өдөрт 6 вагон засах хүчин чадал бүхий засварын тоног төхөөрөмж.

³⁴⁰ Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх зөвлөх үйлчилгээ, 2020 оны 4-р сар

Байршил:

Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-овоо, Ханбогд сумдаар дайран өнгөрнө.

Төслийг хэрэгжүүлэгч:

Захиалагч - “Тавантолгой төмөр зам” компани.

“Тавантолгой төмөр зам” ХХК нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 66%, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 34%-ийн хамтарсан хөрөнгө оруулалттай бөгөөд төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өмнө гарсан зардал болох 275.8 сая ам.долларын ажлыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн зүгээс хөрөнгө оруулалтад тооцон хувь эзэмшихээр болсон.

Ерөнхий гүйцэтгэгч - "Бодь интернэшнл" ХХК, туслан гүйцэтгэгчээр 62 аж ахуйн нэгж ажиллаж байна.

Санхүүжилт:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг үргэлжлүүлэхэд шаардлагатай 792.2 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг “Эрдэнэс тавантолгой” ХК санхүүжүүлж байна. Энэхүү санхүүжилтийн дүнгээр “Тавантолгой төмөр зам” ХХК нь “Зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын ерөнхий гэрээ” (ЕРС)-г Ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан.

Хүснэгт 11. Төслийн хөрөнгө оруулалтын зардал

Ажлын нэр	Хөрөнгө оруулалт
АЕСОМ ТЭЗҮ	1068
“МТЗ” ТӨХК-иас шилжүүлсэн хөрөнгө оруулалт	275.8
ЕРС гэрээний дүн	792.2
ТЭЗҮ тодотгол	213

Эх сурвалж: ТЭЗҮ

Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал нь “Донмёнг Инженеринг энд Консалтэнтс” компанийн 2020 онд гүйцэтгэсэн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголын судалгааны хүрээнд тооцоолсон нэмэлт хөрөнгө оруулалт болох 213.4 сая ам.доллар, АЕСОМ Asia компанийн 2013 онд гүйцэтгэсэн техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлогдсон 1,068 сая ам.долларын нийлбэр дүн буюу 1,282 сая ам.доллар байна.

Төслийн санхүүгийн үр дүн

ТЭЗҮ-д тооцоолсноор эхний жилд 74.98 сая ам.долларын орлого олж, үйл ажиллагаа эхэлснээс хойш 13 дахь жилд хөрөнгө оруулалтаа нөхнө. 30 жилийн хугацаанд 8.0 тэрбум долларын орлого олж, 3.0 тэрбум ам.долларын зардал гаргаж, 4.9 тэрбум ам.долларын татварын өмнөх ашиг, 4.4 тэрбум ам.долларын татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, улсад 618.95 сая ам.долларын татвар, нийгмийн даатгал төлнө гэж үзсэн. Хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод хувь (IRR) 9.45%, 30 жилийн хугацаанд төсөл нь 5.0 тэрбум ам.долларын цэвэр мөнгөн хуримтлалтай байх боломжтой бөгөөд үүний өнөөгийн үнэ цэнэ (NPV) 1317.1 сая ам.доллар байхаар тооцоолсон байна.

Хүснэгт 12. Санхүүгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	30 жилд /сая ам.доллар/
1	Хөрөнгө оруулалтын нийт зардал	1,282.01 сая ам.доллар
2	АЕСОМ-н хүрээнд тодорхойлсон хөрөнгө оруулалт	1,068.58 сая ам.доллар
3	Дээд доод бүтэц барих зардал	480.23 сая ам.доллар
4	Барилга байгууламжийн зардал	51.05 сая ам.доллар
5	Эрчим хүч барих зардал	20.00 сая ам.доллар
6	Зүтгүүр, вагон засварын депогийн зардал	184.48 сая ам.доллар
7	Төслийн бусад зардлууд	139.45 сая ам.доллар
8	Магадлашгүй зардал	81.11 сая ам.доллар
9	НӨАТ, гаалийн татвар	112.26 сая ам.доллар
10	ТЭЗҮ-ийн тодотголын хүрээнд тодорхойлсон нэмэлт хөрөнгө оруулалт	213.43 сая ам.доллар
11	Дээд доод бүтэц барих зардал-ачилтын хэсгийн зам	21.57 сая ам.доллар
12	Дээд доод бүтэц барих зардал-хил холболтын зам	97.63 сая ам.доллар
13	Дээд доод бүтэц барих зардал-ТТ өртөөнд нэмэгдсэн зам	3.85 сая ам.доллар
14	Дээд доод бүтэц барих зардал-1-р зөрлөгт нэмэгдсэн зам	1.98 сая ам.доллар
15	Барилга байгууламжийн зардал	7.89 сая ам.доллар
16	6-р зөрлөгийн дохиолол, хилийн камер	4.75 сая ам.доллар
17	Зүтгүүр вагон депогийн нэмэлт тоног төхөөрөмж	1.00 сая ам.доллар
18	Зам барилгын машин механизм	5.02 сая ам.доллар
19	Захиалагчийн хяналт	5.30 сая ам.доллар
20	Суурьшлын бус	45.03 сая ам.доллар
21	НӨАТ	19.40 сая ам.доллар
22	Тээврийн орлого	8,068.01 сая ам.доллар
23	Ашиглалтын үеийн зардал	3,302.30 сая ам.доллар
24	Ашиглалтын үеийн элэгдэл тооцоогүй зардал	2,499.05 сая ам.доллар
25	Суурь бүтэцтэй холбоотой зардал	74.00 сая ам.доллар
26	Хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой зардал	1,309.03 сая ам.доллар
27	Ерөнхий ба удирдлагын зардал	1,115.80 сая ам.доллар
28	Үйл ажиллагааны ашиг	4,923.63 сая ам.доллар
29	Зээлийн эргэн төлөлт хүүгийн зардал	0.000 сая ам.доллар
30	Татварын өмнөх ашиг	4,923.63 сая ам.доллар
31	ОАТ	492.36 сая ам.доллар
32	Цэвэр ашиг	4,431.27 сая ам.доллар
33	Үйл ажиллагааны мөнгөн урсгалын дүн	3,794.70 сая ам.доллар
34	Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт	2,599.16 сая ам.доллар
35	Төслийн өнөөгийн үнэ цэнэ	1,317.16 сая ам.доллар
36	Хөрөнгө оруулалтын өгөөжийн дотоод хувь (IRR)	9.45%
37	Хөрөнгө оруулалт нөхөх хугацаа (PbP)	13.03
38	Ашигт байдлын индекс (PI)	2.52

Эх сурвалж: ТЭЗҮ

Хүснэгт 13. Мэдрэмжийн үзүүлэлт

№	Мэдрэмжийн үзүүлэлт	NPV		IRR		PBP	
		1,317	-10%	9.45%	-10%	13.0	-10%
		10%	-10%	10%	-10%	10%	-10%
1	Ачаа тээврийн хэмжээний өсөлт	1,625	1,009	10.48%	8.35%	11.3	15.1
2	Хөрөнгө оруулалтын зардлын хэтрэлт	1,204	1,430	8.66%	10.37%	14.3	12.2
3	Ашиглалтын зардлын хэтрэлт	1,207	1,427	9.09%	9.80%	13.4	12.3
4	Түлшний үнийн өсөлт	1,273	1,362	9.31%	9.59%	13.1	12.5
5	Цалингийн зардлын өсөлт	1,267	1,367	9.28%	9.62%	13.2	12.4

Эх сурвалж: ТЭЗҮ

Ачаа тээвэрлэлт

Гөмөр зам ашиглалтад орох 1 дэх жил буюу 2022 онд 10.56 сая тонн, 3 дахь жил буюу 2024 онд 26.4 сая тонн, харин 2026-2041 онд хүртэл буюу 5,10,15, 20 дахь жилүүдэд 31.68 сая тонн, 30 дахь жилд буюу 2051 онд төмөр замын суурилагдсан хүчин чадлын гүвшингийн бүрэн ашиглалт буюу 50.16 сая тонн нүүрс тээвэрлэх хэтийн тооцоо кийгдсэн. Иймд шинээр баригдах төмөр замаар ашиглалтын 30 жилийн хугацаанд буюу 2022-2051 онд авто замаас 12.8 хувиар их буюу нийт 12.8 сая.тн нүүрс илүү тээвэрлэх боломжтой гэж үзжээ.

Хүснэгт 14. Тавантолгой уурхайн орчмын аж ахуй нэгжүүдийн нийт нүүрс тээвэрлэлтийн таамаг

Он	2022	2023	2024	2025 он ба түүнээс хойш
Тээвэрлэх ачааны хэмжээ (сая.тн)	10.56	21.12	26.4	31.68

Эх сурвалж: ТЭЗҮ

Хэрэгжүүлэх хугацаа: 2 жилийн хугацаатай хэрэгжинэ. (2019 оны 9-р сараас эхэлсэн)

Техникийн үндсэн үзүүлэлтүүд:

Зэрэглэл	1
Гол замын урт	208,5 км
Дэлгэмэл урт	267 км
Өртөө	2
Зөрлөг	5
Цариг	1520 мм өргөн цариг
Даац	25 тн
Хоногт аялах галт тэрэгний тоо	12
Галт тэрэгний вагоны тоо	106 ш

Хүчин чадал:

Жилд 30 сая тн ачаа тээвэрлэхээр тооцоолсон.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам 2022 онд ашиглалтад орно гэж үзээд ашиглалтын 4 дэх жил буюу 2025 онд ачааны тодорхойлогдсон түвшинд буюу 31.68 сая.тн ачааг тээвэрлэх боломжтой гэж тооцоолсон.

Тээврийн эрэлт болон тээвэрлэлтийн төлөвлөгөө

ES44AC серийн зүтгүүр бүхий 100 вагонтай галт тэрэг аялуулах хувилбарыг сонгосон. 100 вагонтай 12 хос галт тэрэг аялна гэж тооцоод жилд 31.68 сая.тн ачаа тээвэрлэх боломжтой гэж үзжээ. Тэгш чиглэлд ачаатай 100 вагон бүхий 10300 тн жинтэй, сондгой чиглэлд хоосон 100 вагон бүхий 2300 тн жинтэй галт тэргүүдийг аялуулахаар тооцсон байна. Тэгш чиглэлд ачаатай 100 вагон бүхий 10300 тн жинтэй, сондгой чиглэлд хоосон 100 вагон бүхий 2300 тн жинтэй галт тэргүүдийг аялуулахаар тооцсон.

Хүснэгт 15. Хөдлөх бүрэлдэхүүн

Зүтгүүрийн төрөл	Хөдлөх бүрэлдэхүүн				Галт тэрэг		Дараагийн талт тэрэг явах хугацаа	Тээвэрлэлтийн хэмжээ				Тайлбар
	Зүтгүүрийн хувийн жин	Вагоны хувийн жин	Цэвэр жин	Бохир жин	Вагоны тоо	Эргэлт		Хоногт	Сард (28)	Жилд (330)	Сая.тн	
ES44AC	300	2000	8000	10000	100	12	120	96000	2,688,000	31,680,000	31.68	Сондгой чиглэлд хоосон тээвэр

Эх сурвалж: ТЭЗҮ

Хүснэгт 16.Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын шугамын тээх чадвар

Хоорондын замын нэвтрүүлэх чадвар /хоногт/	Жилд тээх ачааны хэмжээ /сая.тн/	Тайлбар
12	31,68	Төслийн өгөгдөл жилд 30 сая.тн боловч хоногт 100 вагоной 12 хос галт тэрэг аялна гэж үзвэл жилд 31.68 сая.тн ачаа тээвэрлэх боломжтой байна.
19	50,16	Тавантолгой-Гашуунсухайт хоорондын гол замаар хоногт хамгийн ихдээ 19 хос галт тэрэг нэвтрүүлэх боломтой байгаа бөгөөд энэ тохиолдолд жилд 330 хоногт тээвэрлэлтийн үйл ажиллагааг явуулахад 50.16 сая.тн ачаа тээвэрлэнэ.

Жич: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг дээд хүчин чадлаар ашиглах үед уурхай орчмын ачилтын байгууламжууд болон Ганц мод өртөөний буулгалтын байгууламжуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай болно.

Эх сурвалж:ТЭЗҮ

Хүснэгт 17. Ачааны хэмжээний өсөлттэй уялдсан хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээ

Он	2022	2023	2024	2025
Жилд ачих ачааны хэмжээ /сая.тн/	10.56	21.12	26.4	31.68
Хоногт ачих ачааны хэмжээ /мян.тн/	32	64	80	96
Хоногт явах галт тэрэгний тоо	4	8	10	12
Хэрэгцээт вагоны тоо	509	1018	1272	1526
Гол замын зүтгүүрийн тоо	10	18	22	26
Сэлгээний зүтгүүрийн тоо	2	2	2	2

Эх сурвалж:ТЭЗҮ

Өртөө, зөрлөг

Төмөр замын трасс нь Тавантолгой өртөөнөөс хөдлөн, Гашуунсухайт өртөөг дайрч, БНХАУ-ын хилийн боомт дээр дуусах өмнөд хойд төвийг холбоно.

Энэ нь ачаа тээврийн эрэлт хэрэгцээг хангах төмөр зам болохын хувьд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай холбон Монгол Улсын төмөр замын нэгдсэн сүлжээнд холбогдох боломжтой төлөвлөгдсөн.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь нэг шугамтай ба 2 өртөө, 6 зөрлөгтэй.

Уг чиглэлд эхлэл, төгсгөлийн 2 өртөө, 6 зөрлөгийг төлөвлөсөн. 1-р зөрлөгөөс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай холбогдох зөрлөг төлөвлөгдсөн ба 4-р зөрлөгөөс “Оюу толгой” ХХК болон бусад уурхайтай холбогдох, цаашид өргөтгөхөөр авч үзсэн.

Ирээдүйд уг суурь бүтцээр, түүнчлэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн суурь бүтцүүдийг дамнасан зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх боломжтой бөгөөд үүнтэй холбоотой барилга байгууламж, зорчигчийн тавцан зэргийг нэмж барьж байгуулах, өргөтгөх боломжтой.

Нүүрс ачих болон сэлгээний ажил хийх, галт тэрэг хүлээн авч, явуулах зорилгоор 1 өртөө (Тавантолгой өртөө) болон тээвэрлэсэн нүүрсийг БНХАУ-ын Ганц мод өртөөнд дамжуулах 1 өртөө (Гашуунсухайт өртөө)-г тус тус төлөвлөсөн.

Галт тэрэг зөрөх болон үзлэг засвар хийх 6 зөрлөгтэй байна. 1-5-р зөрлөгийг өмнө хийсэн даланг ашиглан төлөвлөсөн бөгөөд Гашуунсухайт өртөөг улсын хилд ойртуулж, үүний дагуу хуучин Гашуунсухайт өртөөний ойролцоо 6-р зөрлөгийг шинээр төлөвлөсөн байна.

Монгол Улс болон БНХАУ-ын хилийн ойролцоо байрлах Гашуунсухайт өртөөг хүлээн авах, явуулах замын ашигтай уртыг бүрэн хангах боломжтой газрыг сонгосон бөгөөд

цаашид 1435 мм, 1520 мм цариг бүхий төмөр замуудын хооронд ачаа шилжүүлэн ачих терминал барих газрыг харгалзан тооцоолсон.

Тавантолгой өртөө

Тавантолгой өртөөний 1, 4, 5, 6, 7 дугаар замууд нь галт тэрэг хүлээн авч, явуулах харин 2, 3 дугаар зам нь тэгш чиглэлийн галт тэргийг хүлээн авч, зүтгүүрийг зам дээр зэхэх, галт тэрэгний бүрэлдэхүүнд техник болон ачааны үзлэгүүдийг нэгэн зэрэг хийх боломжтой байна.

Өртөө нь галт тэрэг хүлээн авах, явуулах нийт 8 замтай бөгөөд ачааны хэмжээ нэмэгдэхэд өртөөний урд талд 5 зам, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замтай холбогдох тохиолдолд өртөөний замуудын хойд талд 2 зам нэмж барих боломжтой. Ачилтын хэсгийн шулуун талбай 196 м бөгөөд замуудад 4 ачилтын бункер байхаар тооцсон.

Гашуунсухайт өртөө

Гашуунсухайт өртөөг хилийн ойролцоо аль болох ойр барихаар газраа сонгосон. Импортын ачааг шилжүүлэн ачих нарийн царигийн өртөөг Гашуунсухайт өртөөний зүүн талд 260 м зайнд, 6 замтай байхаар төлөвлөсөн. Хоёр өртөөний дунд шилжүүлэн ачих замууд байх боломжтой.

Гашуунсухайт өртөө нь галт тэрэг хүлээн авах, явуулах 7 замтай бөгөөд 6 дугаар зөрлөгтэй 1 хоорондын зам, БНХАУ-ын Ганц мод өртөөтэй 2 хоорондын замаар тус тус холбогдохоор төлөвлөсөн.

Мөн Гашуунсухайт өртөө болон нарийн царигийн өртөөний дунд бүх төрлийн ачааг ачих, буулгах, шилжүүлэн ачих боломжтой, томоохон хэмжээний ложистикийн төв барих боломжтой.

Ганц мод өртөө (БНХАУ-ын талд)

Тавантолгой өртөөнөөс БНХАУ-ын Ганц мод өртөө хүртэл 236.745 км. Өргөн царигийн зам төгсгөл Хятадын нарийн царигийн өртөөний баруун талд байрлах хоорондын зай нь 560 м ба нүүрс буулгах газрын хэмжээ 10 га гэж тооцсон. БНХАУ-ын боомт өртөөний нарийн царигийн төгсгөл нь өргөн царигийн төгсгөлийн өртөөнөөс өндөр байрласан байгаа тул татах зам төлөвлөн, буулгалтын хэсгийг төлөвлөсөн.

Ажлын зургийг БНХАУ-ын тал гүйцэтгэх учир нарийвчлан ачилт буулгалтын хэсгийг ТЭЗҮ-д төлөвлөөгүй байна.

Галт тэрэгний бүрэлдэхүүн, вагон

Галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагоны голын даац 25 тонн, урт нь 12.00 метр гэж үзсэн.

Голын даац 25 тонн, вагоны хувийн жин 20 тонн, нэг вагоны ачааллах хүчин чадал нь 80 тонн болж гэж тооцсон.

Төслийн явц:³⁴¹

2020 оны 4-р улирлын байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явц дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд:

газар шорооны ажил	99.29%
хоолойн ажил	100%
гүүрийн ажил	100%

³⁴¹ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт

өртөө, зөрлөгийн барилгын ажил	8,8%
төмөр замын дээд бүтцийн ажил	189 км, 70.6%
бетон дэр үйлдвэрлэл	100%
балласт үйлдвэрлэл	71.06%

Эхний 208 км төмөр замын газар шорооны ажил бүрэн дуусаж, ус зайлуулах хоолойн ажил 98 хувь, мал амьтны гарц 97 хувь, дэд бүтцийн ажил 46 хувь буюу гол замын үеийг 106 км-ийг угсарсан.³⁴²

2021 оны 5-р сарын байдлаар газар шорооны ажил 81 хувь, дээд бүтцийн барилга угсралт 67 хувь буюу гол замын угсрах ажил 233 км-ийг гүйцэтгэхээс 201 км-ийг нь тавьсан байна.

Ач холбогдол: Төмөр зам баригдсанаар жилдээ 30 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг тээвэрлэн экспортлох боломжтой гэж тооцоолсон.

Түүнчлэн нийгэм, эдийн засагт олон эерэг үр нөлөөтэй.

Монгол Улсын экспортын салбарын гуравны нэгийг дангаар бүрдүүлдэг нүүрсний салбарын экспортын орлого 2.1 дахин нэмэгдэж, дунджаар 7.47 тэрбум ам.доллар хүрэх боломжтой. /30 жилийн хугацаанд/ Зүүн Азийн зах зээлд (БНХАУ, Япон, Солонгос) Монголын нүүрсний экспортын эзлэх хувь 2019 оны байдлаар 10.5% байгааг нэмэгдүүлж 20-29%-ийг нийлүүлэх боломжтой байсан./30 жилийн хугацаанд/

Нүүрсний экспортын түвшин жилд 71.4 сая тоннд хүрнэ. /2019 онд 34.8 сая тонн/

Нүүрс, газрын тос, төмрийн хүдэр, мах болон малын гаралтай түүхий эдийн экспорт нэмэгдэхийн зэрэгцээ гэр ахуй, өргөн хэрэглээний болон барилгын материалын импорт нэмэгдэх төлөвтэй.

Малын бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдлын асуудал үлэмж хэмжээгээр багасна. Төмөр замын тээвэрлэлт нь авто замтай харьцуулахад байгаль орчинд бага сөрөг нөлөөлөлтэй.

Авто тээврийн осол, зөрчил буурч иргэдийн амь нас, эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Төмөр замын боомтоор дангаараа жилд 30 сая тонн хүртэлх хэмжээний нүүрс экспортлох боломжтой. Ингэснээр Тавантолгой бүлэг орд орчмын уурхайнуудын олборлолтын хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой болно. 2,000 орчим ажлын байр шинээр бий болно.

Төмөр зам нь ачаа тээврийн зориулалттай ч төмөр зам дагуу оршдог газар нутаг нь Монголын говь нутгийг дэлхийд гайхуулах аялал жуулчлалын давтагдашгүй гайхамшигт газруудтай, мөн бусад аймаг, бүс нутагтай харьцуулахад хилийн боомт зангилаа газар олонтой. Энэ нь тус бүс нутагт төдийгүй Монгол Улсад нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлж, аялал жуулчлалыг илүү эрчимтэй татах, ингэснээр үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах таатай орчинг бий болгоно. Иймд ирээдүйд зорчигч тээвэр нэвтрүүлэх боломжтой.

Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад зах зээл дэхь эрэлт хэрэгцээ нэмэгдэхээс гадна, олон улсын жишгээр Монгол Улсын нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн бодлого, менежмент сайжирч, орон нутагт төмөр замын бусад дагалдах дэд бүтэц, логистикийн тогтолцоо хөгжих боломж нөхцөл бүрдэнэ.

³⁴² <http://bodi.mn/post/63288>

Одоогийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтийн монопольт зах зээлд өрсөлдөөн бий болж, зам тээврийн зах зээлийн үнэ тариф бодитой тогтох, тухайн зах зээлд өрсөлдөгчдийн өрсөлдөх чадвар сайжрах, шинээр баригдсан төмөр замын суурилагдсан хүчин чадал жигдэрч нэмэгдэх зэрэгт нөлөөлнө.

ТЭЗҮ-д авч үзсэнээр нийгмийн нөлөөллийн хувьд 30 жилийн хугацаанд 1.75 тэрбум ам.долларын зэрэг нөлөөллийг авчирна. Энэ нь нэг жилд ногдох дундаж дүнгээр 58.4 сая ам.доллар болно. Улсад 619 сая ам.долларын татвар (ОАТ ба НДШ) төлнө.

Хүснэгт 15. Нийгмийн нөлөө

Нийгмийн нөлөөлөл	30 жил сая ам.доллар
Монгол Улсад төлөх татвар	619.0
Орлогын албан татвар	492.4
Нийгмийн даатгалын шимтгэл	126.6
Ажиллагсдын цалин хөлс	973.7
Дам нөлөө	159.3
Нийт	1752.0

Эх сурвалж: ТЭЗҮ

Хөдөлмөрийн зах зээлд зөвхөн төмөр замын салбарт шинээр 1122- 1355 ажлын байр бий болно. Уул уурхайн салбар дахь ажлын байр 2-3 дахин нэмэгдэх боломжтой. Төмөр замын бүтээн байгуулалтын шатанд 1700- 1870 хүн ажиллана гэж үзсэн байна.

Хүснэгт 19. Хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөр эрхлэлт	
Төмөр замын ашиглалтын шатанд шаардлагатай ажлын байр	1355
Уул уурхайн салбарт бий болох нэмэлт ажлын байр	9150
Дагалдан хөгжих салбаруудын нэмэлт ажлын байр	1050
Нийт (байнгын ажлын байр)	11555
Барилга угсралтын шатанд бий болох ажлын байр (2020-2022)	1870

Эх сурвалж: ТЭЗҮ

Төмөр замын төсөл хэрэгжсэнээр 30 жилийн хугацаанд авто замтай харьцуулахад Зам хэрэглэгчид нийт 1089.57 сая ам.долларын ашгийг хүртэх боломжтой гэж тооцсон бөгөөд үүний 92.0 хувь буюу 1011.22 сая ам.долларыг ТА3-ын хэмнэлтээс, 5.4 хувь буюу 59.04 сая ам.долларыг зорчих хугацааны хэмнэлтээс, 1.2 хувь буюу 13.097 сая ам.долларыг Зам тээврийн осол буурснаас гарах хэмнэлтээс, 0.6 хувь буюу 6.21 сая ам.долларыг байгаль орчинг хамгаалах арга хэмжээний хэмнэлтээс тус тус хүртэнэ. Өөрөөр хэлбэл, Зам хэрэглэгчид авто замтай харьцуулахад жилд дунджаар 36.32 сая ам.долларын ашиг хүртэх боломжтой гэж үзсэн.

Холбогдох тогтоол шийдвэрүүд

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын дэд бүтцийг Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.4-т заасан 2 дугаар үе шатанд барихаар тусгагдсан.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 2016 оны 9 дүгээр сард УИХ-ын 45 тоот тогтоолоор баталсан бөгөөд үүнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын дэд бүтцийг бүрэн барьж, ашиглалтад оруулах ажлыг оруулсан.

Улсын Их Хурлаас Тавантолгойн нүүрсний ордын сав газрын хөгжлийг цогц аргаар эрчимжүүлэх, түүний дотор Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийг эрчимжүүлэх үүрэг бүхий 2018 оны 73 дугаар тогтоолыг баталсан.

Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосон.

Засгийн газрын 2019 оны “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 304 дүгээр тогтоолоор, Тавантолгой

Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг олгосон.

Ерөнхий сайдын 2018 оны 176 дугаар захирамж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 33 дугаар тушаал, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох ажлыг “Тавантолгой төмөр зам” ХХК-д даалгасан.

IV. АВТОЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 112.414.2 километр байдаг. Үүнээс: хатуу хучилттай зам 10,151 километр, хайрган хучилттай 1,207.9 километр, сайжруулсан хөрсөн зам 604.9 километр байна.

Авто замыг дотор нь:

Олон улсын чанартай авто зам;

Улсын чанартай авто зам;

Орон нутгийн чанартай авто зам;

Нийслэлийн авто зам;

Тусгай зориулалтын авто зам;

Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто зам гэж ³⁴³ ангилдаг байна.

Олон улс, улсын чанартай авто зам нь 14,918.7 километр буюу 48.5%-ийг эзэлдэг байна.

Авто зам нь :

Асфалтобетон хучилттай;

Цементбетон хучилттай;

Хайрган хучилттай төрөлтэй байна.

³⁴³ <https://www.legalinfo.mn/law/details/12656>

Хүснэгт 20. Авто тээврийн салбарын үндсэн үзүүлэлт (жилээр)

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Жилийн тээврийн орлого (сая төг)	467,169.9	506,434.6	695,858.41	796,055.4	564,388.2
Тээвэрлэсэн ачаа (мянган тонн)	20,406.2	31,212.9	42,033.78	40,848.8	30,455.0
Ачаа эргэлт (сая тн км)	4,236.2	5,661.3	6,640.6	6,203.8	4,685.3
Сайжруулсан зам (км) Үүнээс:	10,126.0	10,355.2	10,835.6	11,619.1	11,963.8
хатуу хучилттай	7,456.6	8,431.4	9,022.8	9,806.3	10,151.0
хайрган хучилттай	1,696.8	1,308.9	1,207.9	1,207.9	1,207.9
сайжруулсан хөрсөн зам	972.6	614.9	604.9	604.9	604.9

Эх сурвалж: УСГ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2021.04.01-ний байдлаар www.1212.mn

Хүснэгт 21. Авто замын хилийн боомтоор нэвтэрсэн ачаа урсгалын мэдээ (тонн)

	Боомтын нэр	зай(км)	2021 оны I улирал		
			экспорт	импорт	нийт
1	Гашуунсухайт	239	2,755,756	-	2,755,756
2	Замын- Үүд	7	52,009	219,502	271,511
3	Ханги	20	394,619	-	394,619
4	Шивээхүрэн	65	1,973,156	-	1,973,156
	Нийт дүн	331	5,175,540	219,502	5,395,042

Зам, тээврийн салбарын 2021 оны I улирлын статистик мэдээ

Автотээвэрээр 2021 оны эхний улиралд 9.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 6.2 сая тонн буюу 3 дахин өссөн байна. Ачаа тээврийн өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 5.9 сая тонн буюу 3.4 дахин өссөн нь нөлөөлсөн байна.³⁴⁴

2020 онд автотээврийн салбарын орлого 564.38 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 29.1%-иар буурсан үзүүлэлттэй байна. БНХАУ-руу нүүрс экспортлох авто замаар хил хүртэл тээвэрлэж буй зардлыг нэг тонн тутамд 32 ам.доллар, нүүрс олборлолтын зардалд 22.8 ам.долларыг тус тус зарцуулдаг байна.³⁴⁵

Хүснэгт 22. Улсын хилээр орсон гарсан тээврийн хэрэгслийн тоо, боомт (жилээр)

Тээврийн хэрэгслийн төрөл	Боомтын нэр	2016	2017	2018	Жилийн өсөлт	
					2017/2016	2018/2017
Улсын хилээр орсон						
Ачааны машин	Гашуунсухайт	215,690	278,912	253,091	129%	91%
	Ханги	4,407	14,231	13,462	323%	95%
Улсын хилээр гарсан						
Ачааны машин	Гашуунсухайт	214,484	280,101	251,864	131%	90%
	Ханги	4,391	14,132	12,225	322%	87%
Улсын хилээр орсон, гарсан тээврийн хэрэгслийн тоо бүгд						
Ачааны машин бүгд	Гашуунсухайт	430,174	559,013	504,955	130%	90%
	Ачааны %	95%	96%	96%		
	Ханги	8,798	28,363	25,687	322%	91%
	Ачааны %	29%	60%	64%		

Эх сурвалж: Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын техник эдийн засгийн үндэслэл, боть-2, 2019

³⁴⁴Зам, тээврийн хөгжлийн яам, МУ-ыг зам, тээвэр, Статистикийн мэдээлэл, 2021 оны 1 улирал <https://mrt.d.gov.mn/i/2675>

³⁴⁵<http://bodi.mn/post/63288>

Гашуунсухайт боомтоор нүүрс тээвэрлэх үйл ажиллагааг 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс сэргээснээс хойш дунджаар 60-70 машин хил нэвтэрсэн. 2020 оны 4 сарын 27-ны өдрийн байдлаар 192 нүүрс тээврийн машин хилээр нэвтэрсэн байна. Гашуунсухайт боомтоор нүүрснээс гадна зэсийн баяжмал экспортолдог бөгөөд манай улсын төсвийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Тус боомтоор экспортолсон зэс, нүүрсний хэмжээг гаалийн байгууллагын тоо баримтаас үзэхэд: 2017 онд 794.8 мянган тонн зэсийн баяжмал, 17.173 сая тонн нүүрс, -2018 онд 783.5 мянган тонн зэсийн баяжмал, 18.155 сая тонн нүүрс, -2019 онд 763.8 мянган тонн зэсийн баяжмал, 20.643 сая тонн нүүрсийг тус тус экспортолсон байна. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж байгаа нүүрсний дийлэнх хувийг Гашуунсухайт боомтоор хил гаргадаг.

4.1 ТТ-Гашуунсухайт чиглэлийн шинээр баригдах 250 км авто зам

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км цемент бетон хучилттай их даацын автозамаар зөвхөн Тавантолгойгоос Гашуунсухайтын боомт руу чиглэсэн тээврийн хэрэгслүүд зорчдог. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км даацын хатуу хучилттай авто замыг 2020-2023 барих ба хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах–барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК нь 2019 оны 3 дугаар сарын 29-нд өдөр байгуулсан.

Өмнөговийн Тавантолгойгоос Гашуунсухайт чиглэлийн одоогийн хоёр урсгалтай байгаа 250 км автозамыг 4 урсгалтай болгохоор концессын гэрээгээр хөрөнгө оруулалтыг шийдсэн байна.

Одоогоор тус чиглэлд баригдсан замаар “Эрдэнэс тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи рөсурс” ХХК, “Хангад эксплорэйшн” ХХК, “Хүннү рөсурс” ХХК-иудын олборлосон нүүрсийг голчлон тээвэрлэдэг. Шинээр хоёр эгнээ замыг хүч нэмэн барьснаар одоогийн 65-70 тонноор тээвэрлэж байгааг 95-100 тонн болгон өсгөхөөс гадна замын нэвтрүүлэх чадвар, хөдөлгөөний аюулгүй байдал сайжрах юм. 2019 оны байдлаар жилд 19 сая тн нүүрс тус чиглэлд тээвэрлэн Гашуунсухайт боомтоор экспортолсон байдаг ба Хятадын талын боомтын татан авалтаас шалтгаалан тээвэрлэлт хязгаарлагддаг.

Байршил:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төслийн авто замд Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрийг хамарна.

Төслийг хэрэгжүүлэгч:

Захиалагч - Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Үндэсний хөгжлийн газар;

Концесс эзэмшигч – “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК;

Гүйцэтгэгчээр- “Өндөр Алтай зам” ХХК, “Мотор сөрсвис” ХХК, “Пик дөвөлөмөнт” ХХК, “ЗБИБ” ХХК;

Зөвлөхөөр- “Ростов” ХХК болон “Ар Си Эс Си” ХХК-ийн түншлэл ажиллаж байна.

Санхүүжилт:

Нийт хөрөнгө оруулалт **412,633,000** (Дөрвөн зуун арван хоёр сая зургаан зуун гучин гурван мянган) ам.доллартай тэнцэнэ.

Нүүрсний ордууд:

Эрдэнэс Тавантолгой” ХК
Тавантолгой” ХК
Энержи ресурс” ХХК
“Хангад эксплорэйшн” ХХК
Хүннү ресорс” ХХК

Хэрэгжүүлэх хугацаа:

Автозамын барилгын ажлын хугацаа эрх бүхий этгээдээс мэдэгдэл гарсан өдрөөс хойш **2.5** жилийн дотор барих бөгөөд концессын зүйлийг ашиглах хугацаа авто замыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **12** жилд ашиглаж төрд шилжүүлнэ. Концессын гэрээний нийт хугацаа **14.5** жил байна.

Зам ашигласны хураамж (тн/км)

Автозамыг ашиглалтад оруулсан өдрөөс хойш засвар арчлалтыг хариуцах, хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх зорилгоор авто замаар зорчих тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураана. Зам дагуу үйлчилгээний байгууламж, төлбөр хураах пост барьж байгуулахаар тусгасан байна. Энэ төлбөр нь нүүрс болон зэс, бусад ашигт малтмал тээвэрлэсэн хүнд даацын автомашины **нэг тонн ачаа тутамд 3.4 ам.доллартай тэнцэх** төгрөгөөс илүүгүй байна. I, II улиралд хураах төлбөрийг тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийн, III, IV улиралд хураах төлбөрийг тухайн жилийн 6 дугаар сарын 30-ны өдрийн Монголбанкны зарласан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлж тээврийн хэрэгслээс хураана.

Автозамыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш эхний 6 жилд зам ашигласны төлбөр тогтвортой байна. Харин 7 дахь жилээс төлбөрийн стандартын талаар хамтарсан тооцоолсон нийт орлогын хэмжээнд хүрээгүй нөхцөлд өөрчлөлт оруулна. Өөрчлөлтийн хэмжээ нь төлбөр хураан авсан өдрөөс 6 дахь жилийн эцсийн орлогын нийт хэмжээ болон санхүүгийн загвараар урьдчилсан тооцоолсон өмнөх 6 жилийн нийт хэмжээний зөрүүнд тулгуурлана.

Хүчин чадал:

Жилд тээвэрлэсэн ачааны нийт хэмжээ **290,466,000** (Хоёр зуун ерэн сая дөрвөн зуун жаран зургаан мянган) тонн байхаар тооцоолсон. Шаардлагатай бол түүнээс илүү тээвэрлэх боломжтой. Гэхдээ боомтын нэвтрүүлэх хүчин чадлаар хязгаарлагддаг.

Төслийн явц:

Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто Зам барилгын ажлыг 2020 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс эхэлж 2020 оны 11 дугаар сарын 18-ны өдөр зогсоосон байна. Талбайд хэмжилт, дурандлага, нүүлгэн шилжүүлэлт, хөрс хуулалт, ухмал далангийн дүүргэлтийн ажил хийгдсэн, зам барилгын ажлын гүйцэтгэл **10%**-тай байна.³⁴⁶

2021 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар нийт 7 гүйцэтгэгч компанийн 823 хүн, 401 төхник, машин мөханизм, 3 чулуу бутлуур, 2 бетон зуурмагийн үйлдвэр, 10 кемп ажиллаж байна. Шинээр 3 асфальт бетон завод, 3 ЦБС-ийн материал холих төхөөрөмж, 4 чулуу бутлуур, 1 бетон зуурмагийн үзель угсарч байна.

Нийт зам барилгын ажил **34.8%**-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

³⁴⁶ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2020 оны байдлаар

Замын чиг сэргээх 240.30 км/м³ буюу 100%,
Ургамлын үндэс бүхий хөрс хуулах 520,590.08 км/м³ буюу 59.7%,
Ул хөрс тэгшилж, нягтруулах 6,070.40 км/м³ буюу 0.7%,
Зөөлөн материалын ухмалаас зайлуулах 547,528.45 км/м³ буюу 93.5%,
Хатуу материалын ухмалын тэсэлгээний ажил 99,316.91 км/м³ буюу 26.6%,
Хатуу материалын ухмалаас далан байгуулах 23,914.05 км/м³ буюу 20.8%,
Хатуу материалын ухмалаас тохиромжгүй материалыг зайлуулах 112,428.45 км/м³ буюу 43.5%,
Ухмалын ул хөрсийг тэгшилж, нягтруулах 92,778.79 км/м³ буюу 41.7%,
Тохиромжгүй материал зайлуулах 62,136.83 км/м³ / буюу 79.8%,
Зөвөрөөр далан байгуулах 1,550,007.16 км/м³ буюу 54.9%,
Суурийн доод үе 82,652.54 км/м³ буюу 6.6%,
Хөвөө 13,783.0 км/м³ буюу 1.4%,
Төмөр бетон хоолой 15 км буюу 6.9%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Төслийн нийгмийн өгөөж, үр дагавар ба эрсдэл

Уг авто зам барих төсөл хэрэгжсэнээр нэн тэргүүнд орчин үеийн даац, хүчин чадал сайтай авто тээврийн хэрэгслээр богино хугацаанд, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр ачаа тээвэрлэж экспорт, импортын барааны тээврийн хөдөлгөөний эрчим нэмэгдсэнээр эдийн засгийн хөгжлийг идэвхжүүлэх хурдасгах ач холбогдолтой.

Төслөөс шууд үзүүлэх үр нөлөө нь бүс нутгийн иргэдийн эдийн засгийн бололцоо тодорхой хувиар нэмэгдэх гэхээсээ улс орны аж үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, жижиг дунд бизнес, үйлчилгээ, худалдааны цэгүүдэд шинэ ажлын байр гэх мэт хөгжлийн боломж нөхцөл сайжрахаас гадна, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломж орон нутагт бүрдэнэ.

Цаашилбал төсөл хэрэгжсэнээр тээврийн үр ашгийг өсгөж, ачаа тээврийн эргэлт нэмэгдэж, хугацааны хэмнэлт бий болох, тээврийн хэрэгслийн туулах зайг багасган улмаар орлогын түвшин болон ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулах, хүний хөгжлийн талаар төр засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг дэмжихэд шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэх зэргээр ядуурлыг бууруулахад шууд ба шууд бус нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Нээдүгээрт: Төслийн зүгээс төсөл хэрэгжих бүсийн оршин суугчдыг ажлын байраар хангах боломж бүрдүүлнэ. Зам барилгын ажлын үер орон нутгийн иргэдийг түр ажлын байраар хангана. Төслийн нарийн мэргэжлийн чадвар шаардахгүй ажилд орон нутгийн иргэдийн хүчийг дайчлахдаа ажилгүй болон орлого бага ядуу иргэдийг түлхүү авч ажиллуулна.

Хоёрдугаарт: Төслийн үр дунд бизнесийн шинэ болзол нөхцөл бүрдүүлнэ. Эдийн засгийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээний өсөлт гарна. Тухайлбал хөдөө аж ахуйн бус хөрөнгө оруулалтыг ерөнхийдөө ядуу бус иргэд жижиг оврын дэлгүүр, үйлчилгээний төв, автомашины үйлчилгээний цэг, дугуй засвар зэрэг аж нэгж байгуулахад ашиглах магадлалтай.

Одоогийн байдлаар хөдөө орон нутагт амьжиргааны их үүсвэр төрөлжөөгүй ба өрхийн ихэнх албан сектор, хөдөө аж ахуй, худалдаа арилжаанаас хараат шинжтэй байна. Төсөл хэрэгжсэнээр замын дагуу үйлчилгээний бүсэд үйлчилгээний цэг, замын засвар, арчлалтын хэсэг байгуулагдах учир бизнесийн шинэ боломж бий болох нь харагдаж байна.

Гуравдугаарт: Замыг сайжруулснаар тогтмол, найдвартай, хурдан шуурхай тээврийн үйлчилгээтэй болж, аяллын цаг богиносох төдийгүй тээврийн хэрэгслийн жолоочийн тав дух дээшилнэ. Замын дэд бүтэц сайжирснаар богиносч, нүүрсний зах зээлд хурдан шуурхай саадгүй хүрэх боломж нээгдэнэ.

Нийгмийн хөгжилд хамгийн түрүүнд сум орон нутгийн төсөв нэмэгдэх замаар мэдрэгддэг, сум орон нутгийн үйлчилгээний чанар, хангамж сайжрахын сацуу аймаг, сум нийгмийн статус дээшлэх нь нэгэн үр өгөөж болдог төдийгүй боловсролын болон эрүүл мэндийн ажилтан зэрэг боловсон хүчний хүртээмж, түүнчлэн Засгийн газар, олон улс ба төрийн бус байгууллагуудын хөтөлбөрийн ханган нийлүүлэлт ч ихэснэ.

Бүс нутгийн иргэдэд төсөл хэрэгжсэнээр тэдний аж байдалд нөлөөлж, сөрөг үр дагавар гарч болзошгүйг анхаарах шаардлагатайг онцолж байна. Үүнд:

- Зам тавих ажлын явцад байгаль орчинд хохирол учруулах;
- Зам тавих ажлын үеэр усны эх үүсвэрт нөлөөлөх;
- Зорчих хөдөлгөөн нэмэгдсэнээр ард иргэдийн тайван байдал алдагдах;
- Замын байдал сайжирснаар авто машины хурд нэмэгдэн улмаар аваар ослын хэмжээ өсөх,

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд төслийн бүх шатанд сонирхлын бүлгүүдийг өргөнөөр оролцуулах шаардлагатай юм. Энэ нь уг төслийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх гол үндэс болно. Замын хажуугийн зогсоол, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах туслах зам зэргийг техникийн болон нийгмийн анхаарвал зохих асуудалд тусгаж байгуулна.

Төслийн хэрэгжилтийн явцад учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга замуудыг авч дурдвал:

Орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх;

- Хөдөлгөөний зохицуулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянах, орон нутгийн иргэдээс гарах гомдлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах;
- Усны хомсдолтой газарт замын барилгын материалд шаардагдах усыг шинээр худаг ус гаргаж авах.

Эдгээр арга замуудыг хэрэглэн учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах төлөвлөгөө гаргаж ажиллах шаардлагатай.

Төлөвлөж буй авто замын хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

Зам барилгын болон засварын ажлын өртөг

Авто замын барилгын ажлын урьдчилсан төсвийн тооцоог ЗТБХБ-ын сайдын 2011 оны 7-р сарын 18-ны өдрийн 200 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв зохиох заавар”-ын дагуу RBC-Estimator програм ашиглан гүйцэтгэлээ.

Барилгын ажлын төсвийн нийт дүн нь 663 583 789 350 төгрөг бөгөөд удирдлагын зардал болон бусад зардлыг тооцоод концессын гэрээний дүн нь 785 280 000 000 төгрөг буюу 320 000 000.00 ам.доллар болж байна. Энэ үед инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлууд багтсан болно.

Таван толгой-Гашуунсухайтын авто замд одоогоор төлөвлөн зарцуулагдаж байгаа засвар арчлалтыг зардлыг, шинээр барих авто замын засвар арчлалтын зардал концессын хэрэгжүүлэх ашиглах хугацаа үйл ажиллагааны зардал зэргийг оролцуулан уялдуулан жилд дунджаар 7 723 577 ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн.

Эзэмших хугацааны авто замын засвар арчлалтыг Концесс эзэмшигч хариуцна. Ингэснээр Монгол Улсын засгийн газарт аливаа нэгэн санхүүгийн хүндрэл үүсэхгүй.

Хүснэгт 23.Тээвэр ашиглалтын зардал

№	Зардал	Хэмжих нэгж	Одоо байгаа авто замаар	Шинээр 4-н эгнээ зам барьснаар
1	Тээвэрлэх хугацаа	Хоног/рэйс	3	1
2	Шатахуун зарцуулалт	литр	350.00	270.00
		ам \$	3.66	2.82
3	Автомашин элэгдэл, хорогдол	төгрөг	5.30	1.76
4	Жолоочийн цалин	тонн/ам \$	5.40	4.30
5	Ашиг		6.30	6.30
6	Ашиглалт		7.30	2.43
7	Гаалийн хяналтын зардал		+	+
8	Замын хураамж	ам \$	1.98	
Нийт		ам \$	29.94	17.61

Эх сурвалж: ТЭЗҮ

Тайлбар: Дээрх зардлыг Тавантолгойгоос Гашуунсухайтын боомт хүртэлх 1 тонн нүүрсийг авто машинаар тээвэрлэж хүргэхээр тооцлоо. Тооцоог хийхдээ одоо хийгдэж байгаа нэг удаагийн рэйсийн хугацаанд үндэслэн тооцсон болно.

Тооцооноос харахад тээвэр ашиглалтын зардлын хэмнэлт нь (одоо гарч байгаа тээвэр ашиглалтын зардал, зэрэгцээ шинэ зам барьснаар гарах тээвэр ашиглалтын зардлын зөрүү) 29.94 ам \$-17.61 ам \$=12.33 ам \$ байна.

Иймд авто замын хураамжийг урьдчилсан тооцоогоор тээвэр ашиглалтын зардлын хэмнэлтийг үндэслэн хэмнэгдэж байгаа 12.33 ам долларын 40% буюу 5 ам долларыг тонн тутамд авахаар төлөвлөж байна.

Үүнээс нэг ам долларыг одоо ашиглаж байгаа авто замын эзэмшигч “Эрдэнэс Монгол” ХХК-д төлнө. Авто замын хураамжийг тонн нүүрс тутмаас тооцож, нүүрсний татвар хураамжтай хамт авна.

Төслийн хөрөнгийн үр ашгийн тооцоо

Төлөвлөж буй замын барилгын ажлыг 2020 оноос эхлэн хоёр жилийн дотор дуусгахаар төлөвлөж байна. Төслийн ТЭЗҮ, инженерийн нарийвчилсан судалгаа, зураг төслийн ажил, гэрээ байгуулах, тендер зарлах болон барилгын ажлыг эхлүүлэх шаардлагатай бусад бэлтгэл ажлыг 2019 оноос эхлүүлэх юм.

Эдийн засгийн дүн шинжилгээг зам баригдах 2020 оноос 2035 он хүртэл 15 жилийн хугацааг хамруулж хийсэн болно. Төслийн үр ашгийг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

A. Төслийн зардлыг дараах мөнгөн урсгалд тооцсон. Үүнд:

- Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах барилга угсралтын ажлын хөрөнгө
- Ашиглалтын явцад засвар арчлалтын ажилд жил бүр шаардагдах хөрөнгө оруулалт
- Ашиглалтын хугацаанд шаардагдах дунд болон их засварын ажлын хөрөнгө
- Албан татварууд

B. Төслийн орлогод дараах мөнгөн урсгалыг тооцсон. Үүнд:

- Зам ашигласны төлбөр хураамж

C. Хорогдлын хувь

- Төслийн ӨЦҮ тооцоолохдоо “Хорогдлын хувийг” Засгийн газрын бонд, төв банкны бодлогын хүү арилжааны банкны зээлийн хүү, инфляц, хүсэн хүлээж буй ашиг зэргээс хамааруулан тогтоодог.

Авто замын төсөл нь ашгийн бус нийгмийн шинжтэй төсөл байдаг. Иймээс хөгжиж байгаа орнуудад авто замын төслийн *Хорогдлын хувийг* тухайн улсын нийгэм эдийн засаг, хүн амын амьжиргааны төвшин, эрүүл мэнд, дэд бүтцийн хөгжил зэрэг олон хүчин зүйлээс хамааруулан Засгийн газар нь өөрсдөө эрсдэлээ хүлээн тогтоодог.

Хорогдлын хувийг санхүүжүүлэгч байгууллага ихэвчлэн санал болгодог. Жишээ нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас гаргадаг зөвлөмжид “Хорогдлын хувийг” 12,0%-р авахыг заасан байдаг. Манай төслийн хувьд хөрөнгийг БНХАУ-аас босгох тул “Хорогдлын хувийг” 6,0%-р тооцсон болно.

Эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь (NPV) 158 762 197,79 ам доллар, Дотоод өгөөжийн хувь (IRR) 14,69% гарсан.

Ач холбогдол: Зам баригдсанаар нүүрсний экспортыг 50-60%-ийг тээвэрлэдэг замын урсгал сайжирч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө эрс багасна;

Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайтын боомтоор тээвэрлэгдэж буй нүүрсний тээвэрлэлтэд шинэ гарцыг бий болгоно;

Зах зээлийн өрсөлдөөний бодлогын хувьд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замд гарч буй нүүрс тээвэрлэлтийн монополь байдлыг задалж нүүрс тээврийн ачааны зах зээлийн төвлөрлийг сааруулах, тухайн зах зээлд шударга өрсөлдөөний орчин нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой;

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замд гардаг тээврийн хэрэгслийн хилийн боомт руу нэвтрэх гэж зогсдог замын нийт уртын тал хүртэлх буюу 130 км-ээр үүсдэг урт дараалал зам, тээврийн түгжрэлийн асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ;

Зам хэрэглэгчдэд үүсдэг аяллын хугацааны алдагдал багасгах, түгжрэлийн улмаас бий болдог тээвэр ашиглалтын зардлын өсөлт буурах боломжтой болно;

Уг түгжрэлийн үед жолооч нарын дунд үүсдэг нийгмийн сөрөг асуудлууд (жолооч нарын дунд архи дан согтуурах, гэмт хэрэг, авар осол) бүрэн шийдэгдэнэ;

Нүүрс тээвэрлэлтийн явцад байгаль орчинд үүсдэг тоосжилт, агаарын бохирдол (шатахууны дутуу шаталтаас үүдэлтэй хорт утаа, угаар) тодорхой хэмжээнд багассанаар жолооч, зорчигчид болон бүс нутгийн оршин суугчдын эрүүл, аюулгүй, орчинд ажиллах амьдрах хүний эрх тодорхой хэмжээнд хамгаалагдах ач холбогдолтой.

Авто замтай холбогдох тогтоол шийдвэрүүд:

Концессын тухай хуулийн 6.2.12 дахь заалт;

Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтоолын 24¹⁵;

Засгийн газрын 2017 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 2 дахь хавсралтад нэмэлт өөрчөлт оруулах тухай” 166 дугаар тогтоол;

УИХ-ын 2018 оны “Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол;

Засгийн газрын 2018 оны “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 229 дүгээр тогтоол;

Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэл.

4.2 Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 480 км авто зам

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 480 км авто замын эхлэл нь Тавантолгойн нүүрсний бүлэг орд бөгөөд зам дагуух ашигт малтмалын орд газрууд, уурхайнууд олноор нээгдэж эхэлдэг. Тавантолгойн бүлэг орд дээр үйл ажиллагаа явуулж буй 3 уурхайд Эрдэнэс Тавантолгой, Ухаахудаг, Тавантолгой багтана. Уул уурхайн олборлолт, тээвэрлэлт хийх боломжтой ордуудад Барууннаран, Цант-Уулын нүүрсний уурхай, Оюутолгойн зэсийн баяжмал, Дорноговь аймгийн нутагт байрлах Цагаан суваргын зэс, Мандах нуур, Айл баян уурхайн нүүрс, Элстэй уурхайн төмрийн хүдрийг Ханги боомт чиглэлд тээвэрлэдэг. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 480 км авто зам төсөл хэрэгжүүлэх “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлийн концессын гэрээг 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан. Энэ концессоор 2020-2023 онд тусгай зориулалтын авто зам барих гэрээтэй.

Байршил:

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замд Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Хатанбулаг, Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын нутаг дэвсгэрийг хамарна.

Төслийг хэрэгжүүлэгч:

- Эрх бүхий этгээд-Засгийн газрын төлөөлж Үндэсний хөгжлийн газар;
- Зохицуулагч байгууллага- Төрийн байгууллага;
- Концесс эзэмшигч-“Тахилт хайрхан транс” ХХК;
- Ерөнхий гүйцэтгэгч-“Ти Ти Си энд Ти” ХХК;
- Зөвлөхөөр-“Эм Си Пи Си Жи Ар” ХХК;

Туслан гүйцэтгэгчээр-“Ундарга-Од” ХХК, “Эн Ди Ти Кэй” ХХК, “Их харгуйн зам” ХХК, “Сайхан говь роуд” ХХК, “Ханароуд” ХХК, БНХАУ-ын “Synohydro corporation” LLC, “China Geo Engineering Corporation” LLC, “Yunnan Sunny Road and Bridge” CL, “Beijin Uni Construction Group Mongolia LLC.

Санхүүжилт:

Концесс эзэмшигч нь Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам төслийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр бүрэн санхүүжүүлнэ. Нийт хөрөнгө оруулалт нь **501,000,000 (таван зуун нэг сая)** ам.доллартай тэнцэнэ. Концессын гэрээнд “авто замын төслийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр бүрэн санхүүжүүлнэ” гэж заасан.

Төслийн санхүүгийн үр дүн

Хувилбар-1-ийн хувьд: Тавантолгой-Манлай-Ханги чиглэлд хайрган хучилттай авто зам барих нь эдийн засгийн үр ашиггүй байна. Харин асфальтобетон болон цементобетон хучилттай авто зам барих нь хөрөнгө оруулалтын хувьд IRR=21-22%-ийн өгөөжтэй байна. Үүнээс:

Асфальтобетон хучилттай авто зам барих нь хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ цэнэ NPV=669.040 сая ам.доллар, өгөөжийн хувь IRR=22% байна.

Цементобетон хучилттай авто зам барих нөхцөлд NPV=659.026 ам.доллар байна. Эндээс Трасс1-ийн хувьд асфальтобетон хучилттай зам барих хувилбар нь хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь хэмжээ болон NPV=10.014 сая ам.доллараар илүү үнэ цэнэтэй байх тооцоо гарч байна.

Хувилбар-2-ын хувьд: Тавантолгой-Манлай-Ханги чиглэлд хайрган хучилттай авто зам барих нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байна. Харин асфальтобетон болон

цементобетон хучилттай авто зам барих нь хөрөнгө оруулалтын хувьд IRR=18%-ийг өгөөжтэй, хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр үнэ цэнийн хувьд асфальтобетон хучилттай авто зам барих хувилбар NPV=444.213 сая ам.доллар байгаа бол цементобетон хучилттай авто зам барих нөхцөлд NPV= 435.854 ам.доллар байна Эндээс уг трассаар асфальтобетон хучилттай зам барих хувилбар нь NPV=8.359 сая ам.доллараар илүү үнэ цэнэтэй байна.

Трассын хувилбаруудын харьцуулалт:

Төслийн хөрөнгө оруулалтын шинжилгээгээр трассын 2-р хувилбараар асфальтобетон хучилттай зам барих нь илүү үр ашигтай байгаа бол трассын сонголтын хувьд хувилбар 1 нь рувилбар 2-оос 5.1 км-ээр илүү урттай хэдий ч хөрөнгө оруулалтын хувьд IRR=4 % -иар илүү өгөөжтэй, өнөөгийн цэвэр үнэ цэнийн хувьд асфальтобетон хучилттай авто зам барихад хувилбар-2 -оос NPV= 224.827 сая ам.доллараар илүү байна. Энэ нь Тавантолгой-Манлай-Ханги чиглэлд Хувилбар-1 -ийн дагуу асфальтобетон хучилттай авто зам барих нь судлагдсан бусад хувилбаруудаас илүү ашигтай болохыг харуулж байна.

Хүснэгт 24. Нүүрсний ордууд:

	Ордын нэр	Эрдэс баялгийн нэр	Нөөцтэй (тн)	Олборлох жилийн хүчин чадал (мян.тн)	Алслагдсан байдал (км)
Өмнөговь аймаг					
1.	Барууннаран	ашигт малтмал	330 сая	5 сая	
2.	Цант уулийн	нүүрс			
3.	Оюунтолгой уурхай	хүдэр	6.45 тэрб		Ханбогд сумнаас 35 км, Гашунсухайт боомтоос 100 км зайд оршдог зэс алтны уурхай.
		зэс	45 сая		
		алт	1838		
		молөбдин	157 мян		
		мөнгө	12 мян 49		
Дорноговь аймаг					
4.	Цагаан суваргын орд	зэс	1.6 сая	320	УБ-560 км, ДГ Мандах-66 км, ОТ-160 км, Ханги- 210 км зайд оршино.
		молөбдин	66.1 мян	14 сая 600	
5.	Мандах нуур уурхай	коксжих нүүрс	100 сая	500	Ханги боомтоос 165 км алсад
6.	Айлбаянгийн уурхай	антрацит нүүрс	14 сая	1.5-2 сая	Сайншандаас 180 км, Ханги мандал-с 160 км. Уурхайгаас Ханги хүртэл 160 км сайжруулсан хайрган замтай.
7.	Элстэй уурхай	төмрийн хүдэр	7.32 сая	560	Хатанбулаг сумаас 50 км, Хангиас 140 км зайд оршдог.

Эх сурвалж: УУС

Хэрэгжүүлэх хугацаа:

Энэхүү гэрээг байгуулагдсан өдрөөс хойш концессын гэрээний хугацаа **30** жил байна Авто замын барилгын ажлын хугацаа эрх бүхий этгээдээс мэдэгдэл гарсан өдрөөс хойш **2.5** жил байна. Концессын зүйлийг ашиглах хугацаа авто замыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **27** жил байна. Гэрээний гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлийг биелүүлэх хугацаа гэрээ байгуулагдсан өдрөөс хойш **6** сар байна.

Зам ашигласны хураамж (тн/км):

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн автозамыг ашиглалтад оруулсан өдрөөс хойш концессын зүйлийг ашиглах, засвар арчлалтыг хариуцах, хөрөнгө оруулалтын зардлаа

нөхөх зорилгоор авто замаар зорчих тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураах эрхийг эдэлнэ. Зам дагуу үйлчилгээний байгууламж, төлбөр хураах пост барьж байгуулахаар тусгасан байна. Авто зам ашигласны төлбөр нь нүүрс, зэс болон бусад ашигт малтмал тээвэрлэсэн хүнд даацын автомашины **нэг тонн/км ачаа тутамд 19** (арван есөн) төгрөгнөөс илүүгүй байна. Хүнд даацын тээврийн хэрэгслийн буцах чиглэл нь үнэ төлбөргүй.

Хүчин чадал:

Жилд 22-25 сая тонн тээвэрлэх хүчин чадалтай.

Төслийн явц:

Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замыг барих ажлын явц нь талбайд хэмжилт болон бутлуур суурилуулах зэрэг бэлтгэл ажлууд хийгдэж байна.³⁴⁷ 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар барилгын талбайд 750 инженер техникийн ажилтан болон туслах ажилчид барилгын бэлтгэл ажил, замын трасс сэргээх, хөрс хуулах, далангийн дүүргэлт, ухмалын, карьерын материалын шинжилгээ, чулуу бутлах, кэмп байгуулах, усны худаг гаргах ажлууд хийгдэж байна. Мөн 464 машин механизм, 3 цэгт чулуу бутлуур ажиллаж, нийт зам барилгын ажил 9.3%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үүнээс:

Замын чиг сэргээх 334 км/м³ буюу 71.92%,

Хөрс хуулалт 340,138 км/ м³ буюу 16.51%,

Далангийн дүүргэлт 243,041 км/м³ буюу 3%,

Ухмал 158,399 км/м³ буюу 10.71% -ийн тус гүйцэтгэлтэй байна.

Шинэ авто замтай холбогдох тогтоол шийдвэрүүд:

Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай 196 дугаар тогтоолд “Тавантолгой-Ханбогд;

Концессын тухай хуулийн 6.2.12 дахь заалт;

Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” батлагдсан. Энэ бодлогын барим бичиг нь Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (2015-2030), Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Хөгжлийн зам хөтөлбөрүүдтэй уялдсан байна.

УИХ-ын 2018 оны “Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол;

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 20 дахь хэсэг;

Засгийн газрын 2019 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 238 дугаар тогтоол;

Төслийн ач холбогдол

Авто замын салбар дахь хөрөнгө оруулалтын нийгэм эдийн засгийн үр ашиг нь зам хэрэглэгчдийн зардлын хэмнэлтээр тодорхойлогддог. Төлөвлөж буй автозамын төслүүдийн хувьд Зам хэрэглэгчдийн зардлын (ЗХЗ) гол хэмнэлт нь IRR =18 байх үеэс IRR=7 болох үед зам хэрэглэгчдийн хүртэх үр ашиг байна. Тухайлбал: Трасс 1-ээр

³⁴⁷ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2020 оны байдлаар

асфальтобетон хучилттай авто зам барих төслийн хувьд нийт 319.495 сая ам.долларын хөрөнгө оруулалт (үүнээс 287.003 сая ам.долларыг барилгын ажилд, 32.493 сая ам.долларыг засварын ажилд) оруулах тохиолдолд зам хэрэглэгчдэд нийт 988.528 сая ам. долларын ашиг бий болохоор байна.

Үүний 94 хувь буюу 925.1 сая ам.доллар нь ердийн болон шинээр үүсэх тээврийн хөдөлгөөний улмаас бий болсон тээвэр ашиглалтын зардлын хэмнэлтээс, 3 хувь буюу 23.21 сая ам.доллар нь зорчих хугацааны хэмнэлтээс, 1 хувь буюу 7.5 сая ам.доллар нь зам тээврийн ослын бууралтаас, 3 хувь буюу 32.6 сая ам.доллар нь бусад ашиг буюу төсөл хэрэгжсэнээр эрүүл мэнд, аялал жуулчлалын салбарт болон байгаль орчинд бий болох үр нөлөөгөөр үүсэх ашгаас бүрдэнэ. Хэрэв энэ ашгаас төслийн хөрөнгө оруулалтын зардлыг хасвал уг төслийн цэвэр ашиг 669.033 сая ам.доллар болж байна. Энэ төслийн хөрөнгө оруулалтын IRR=22 % өгөөж болно.

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлд авто зам барих трассын хувилбаруудыг харьцуулж эдийн засгийн дун шинжилгээ хийхэд трасс 1-р хувилбараар асфальтобетон хучилттай авто зам барих төсөл нь бусад төслүүдээс илүү их үр өгөөжтэй байна.

Трассын 1-р хувилбараар асфальтобетон хучилттай зам барих хувилбарыг зэрэгцүүлэхэд:

Хөрөнгө оруулалтын хувьд: Хамгийн бага зардал буюу C1a/b =370.74 сая.\$ (Хувилбар-1: C1ц/б = 377.21 сая.\$, Хувилбар-2: C1a/b=426.99 сая.\$, C1ц/б=430.57 сая.\$) зарцуулагдах бол төслийн хөрөнгө оруулалтын өнөөгийн цэвэр унэ цэнэ NPV=669.040 сая ам.доллар, өгөөжийн хувь IRR=22% байгаа ньбусад төслүүдээс хамгийн их ашигтай төсөл болохыг харуулж байна.

Зам хэрэгчдийн хүртэх ашгийн хувьд: Төсөл хэрэгжсэнээр нийт 988.535 сая.\$-ийн ашгийг зам хэрэгчид хүртэх боломжтой бөгөөд үүний 94 хувь буюу 925.0сая.\$ нь ердийн болон шинээр үүсэх тээврийн хөдөлгөөний ТА3-ын хэмнэлтээс, 3 хувь буюу 23.21 сая.\$ нь зорчих хугацааны хэмнэлтээс, 1 хувь буюу 7.5 сая.\$ нь зам тээврийн ослын бууралтаас, 3 хувь буюу 32.6 сая.\$ нь төсөл хэрэгжсэнээр бүс нутгийн нийгэм эдийн засаг, бодит салбарын хөгжил, байгаль орчинд автозамын төслийн үзүүлэх үр нөлөөгөөр бий болох үр ашгаас тус тус бүрдэнэ.

Бүс нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөний хувьд: Замын үйлчлэх хүрээнд хамрагдах нэг хүн ам тутам төслийн хөрөнгө оруулалтаас 2725 ам. долларыг хүртэх боломжтойг хөрөнгө оруулалтын эдийн засгийн шинжилгээний үр дүн харуулж байна.

Бүс нутгийн нийгэм эдийн засгийн байдалд динамик эгнээний шинжилгээ хийхэд энэхүү төслийг хэрэгжүүлэхэд бүс нутагт нийгэм эдийн засгийн суурь үндэслэл байна. Гэвч бүс нутгийн хүн амын эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах хүний эрхийн асуудалд анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байгаа нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын захиалгаар Бодлогын Инновацийн Хүрээлэнгээс UNDP байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”-ний үр дүнгээр тогтоогдсон байна.

Мөн динамик шинжилгээгээр төсөл хэрэгжих бүс нутагт Аялал жуулчлалын салбарын гол үзүүлэлт болох улсын хилээр орж ирсэн гадаадын жуулчдын тоо бусад бүсүүдээс хамгийн их буюу улсын дүнгээр 4.1 пунктээр их гарч байна. Энэ нь дэд бүтцийг дэмжих замаар тухайн салбарыг тогтвортой хөгжүүлэх өргөн боломж байгааг харуулж байв.

Түүнчлэн динамик шинжилгээний үр дүн төсөл хэрэгжих бүс нутагт байгаль орчинд хохирол учирсан талбайн хэмжээ бусад бүсээс хамгийн их буюу улсын дүнгээс 145.6 пунктээр буюу 1.6 дахин өндөр байгааг харуулав.

Энэ бүхэн нь төслийн хэрэгжилтийг Эрүүл мэнд, Аялал жуулчлалын салбар болон байгаль орчны нөлөөлөлтэй уялдуулан авч үзэж, нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийх шаардлагатайг харуулсан.

Эрүүл мэндийн салбарт бий болох ашиг. Төслийн замын гол объект болох Тавантолгойн бүлэг орд нь орон нутагт тоосжилт, агаарын бохирдлыг үүсгэж буй хамгийн том эх үүсвэр бөгөөд энэ нь бүс нутагт 10000 хүнд ногдох нийт өвчлөл улсын дунджаас 3.9 пунктээр өндөр байгаа гол шалтгаан болж байна гэж үзэв.

Эрүүл мэндийн салбарт ЭМД-ын сангаас даатгуулагчдын эмчилгээ үйлчилгээнд 2017 онд улсын хэмжээнд нийт 62.2 тэрбум төгрөгийг зарцуулсны зөвхөн амьсгалын зам, хоол тэжээл бодисын солилцооны эмгэгт зарцуулсан зардлыг авч үзвэл жилд 29.80 тэрбум төгрөг болж байна. Үүнд зам, тээврийн бохирдлын нөлөөллийг тооцвол 5.96 тэрбум төгрөг болох ба энэ нь улсын чанартай замын сүлжээний 1км-т 550.0 мянган төгрөг буюу 222.41 ам.долларын зардал ногдож байна. Эндээс Төслийн замд төсөл хэрэгжихгүй нөхцөлд бүс нутагт бий болох эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээний зардлыг тооцвол 261.5 сая төгрөг болох бол төсөл хэрэгжих нөхцөлд уг зардал 155.2 сая төгрөг болж уг зардал 106.3 сая төгрөгөөр хэмнэгдэхээр байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарт төслийн замын дам нөлөөллөөр шууд бусаарбий болох ашиг болж төслийн хөрөнгө оруулалтын бусад үр ашгийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Аялал жуулчлалын салбарт бий болох ашиг. Тус салбар нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны үйл ажиллагаа хосолсон шинж чанараараа бусад эдийн засгийн салбараас онцлогтой. Уг салбар нь байгалийн тогтоц, өгөгдөл, тухайн улсын соёлын өв, ёс заншил, онцлог уламжлалын нөөцөн дээр тулгуурлан, үгүй болохоос хамгаалдаг, эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаж, хүний сайн сайхан байдалд чиглэсэн, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн бодлого хэрэгжих боломжтойгоороо онцлог юм.

Судалгаагаар аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2017 оны гүйцэтгэлээр 57.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.6 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар өсч 2010 онтой харьцуулахад 39.0 тэрбум төгрөгөөр буюу 3.1 дахин өссөн байна.

Тооцоо судалгаанаас харахад аялал жуулчлалын салбарт жилийн нийт нэмэгдэл өртгийн өсөлтийн 33 хувь нь зам тээврийн салбарын нөлөөллөөр бий болж байна. Хэрэв төслийн замд ногоон байгууламж агаарын бохирдлыг бууруулах, хөрсөн замыг хучилттай болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлбэл тээврийн хэрэгслийн ашиглалтын болон зорчих хугацааны зардлыг бууруулж, жуулчдыг ая тухтай байдал сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн үйл ажиллагаа болж, аялал жуулчдын салбарт жилд 47.5 сая төгрөгний ашиг гарах боломж байна.

Байгаль орчны нөлөөллөөр бий болох ашиг. Төсөл хэрэгжсэнээр дараах үр нөлөө, ашиг гарна. Үүнд:

Хамрагдах эдэлбэр газар болон хөрсөнд учрах хохирлын шууд нөлөөлөл өртөж болох 356.55 га талбай хамгаалагдана.

Бүс нутагт асфальтобетон хучилттай авто зам шинээр барих үед замын трассын дагууд нийт 139.317 мянган у/м элсний хамгаалалт барьж 15-20м зүлэгжүүлсэн зурвас байгуулан байгаль орчноо хамгаална.

Тоосжилтын нөлөөнөөс 3.5 сая м² талбайг хамгаалж, жилд 7% буюу 163.3 тн/ жилээр бууруулах боломжтойг экологи эдийн засгийн үнэлгээний тооцоо харуулж байна.

Хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчинг тодорхой хэмжээнд бүрдүүлж, хөдөө аж ахуй, бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Байгальд орчинд бий болох хохирлын зардал шууд бусаар 14.1 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцоо байна. Үүний 25.4 сая төгрөг авто замын зурвас газарт хамаарах эдэлбэр газарт учирах хохирлын зардлаас, 13.7 тэрбум төгрөгийг хөрсөнд учрах хохирлын зардлаас, 308.2 сая төгрөгийг тоосжилт болон тээврийн хэрэгслийн шатахуун гарах хорт хийн бохирдлын зардлаас тус тус хэмнэх боломжтой. Эдгээр алдагдсан боломжийн өртөг нь Байгаль орчинд төслийн замын дам нөлөөллөөр бий болж шууд бус ашиг бол, төслийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үндэслэл болох юм.

Төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол

Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайтын боомтоор тээвэрлэгдэж буй нүүрсний тээвэрлэлтэд шинэ гарцыг бий болгоно;

Зах зээлийн өрсөлдөөний бодлогын хувьд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замд гарч буй нүүрс тээвэрлэлтийн монополь байдлыг задалж нүүрс тээврийн ачааны зах зээлийн төвлөрлийг сааруулах, тухайн зах зээлд шударга өрсөлдөөний орчин нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой;

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замд гардаг тээврийн хэрэгслийн хилийн боомт руу нэвтрэх гэж зогсдог замын нийт уртын тал хүртэлх буюу 130 км-ээр үүсдэг урт дараалал зам, тээврийн түгжрэлийн асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ;

Зам хэрэглэгчдэд үүсдэг аяллын хугацааны алдагдал багасгах, түгжрэлийн улмаас бий болдог тээвэр ашиглалтын зардлын өсөлт буурах боломжтой болно;

Уг түгжрэлийн үед жолооч нарын дунд үүсдэг нийгмийн сөрөг асуудлууд (жолооч нарын дунд архидан согтуурах, гэмт хэрэг, авар осол) бүрэн шийдэгдэнэ;

Нүүрс тээвэрлэлтийн явцад байгаль орчинд үүсдэг тоосжилт, агаарын бохирдол (шатахууны дутуу шаталтаас үүдэлтэй хорт утаа, угаар) тодорхой хэмжээнд багассанаар жолооч, зорчигчид болон бүс нутгийн оршин суугчдын эрүүл, аюулгүй, орчинд ажиллах амьдрах хүний эрх тодорхой хэмжээнд хамгаалагдах ач холбогдолтой.

4.3 Замын свот шинжилгээ

Хүснэгт 25.Төмөр замын свот шинжилгээ

Дотоод хүчин зүйл	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> ✓ Зөвхөн Тавантолгойд ашиглалт явуулж буй уурхайнуудын төлөвлөлтөөр манай эдийн засгийн судалгааны ашиглалтын хугацаа болох 30-аас дээш жил (200 гаруй жил) тээвэрлэх боломжтой нүүрсний нөөц байгаа төдийгүй уг нөөцийг нэмэгдүүлэх, зэргэлдээ байршилтай уурхайнуудад тээвэрлэлтээр үйлчлэх боломжтой. ✓ Монгол Улсын хэмжээний стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг зорилтот зах зээлтэй холбох хамгийн хямд, дөт дэд бүтцийн шийдэл ✓ Говийн бүсийн экологид хамгийн ээлтэй тээврийн төрөл ✓ Тавантолгойн ордод олборлолт хийж буй төрийн өмчийн “Эрдэнэс Тавантолгой” ХКийн 66 хувийн оролцоотой учир голлох ачаа үүсгэгч, хэрэглэгчтэйгээ /“Тавантолгой төмөр зам” ХХК/ ашиг сонирхол нэгдмэл ✓ Өмнөх жилүүдэд төслийн бэлтгэл судалгааны ажлууд олон хувилбараар, олон улсын зөвлөх компаниудаар хийгдсэн. 	<ul style="list-style-type: none"> ✓ Компанийн үйл ажиллагаа, төслийн санхүүжилт төрийн шийдвэрээс ихээхэн хамааралтай ✓ Компанийн санхүүгийн өөрийн хуримтлал байхгүй, тогтвортой орлогын эх үүсвэртэй болж чадаагүй ✓ Тээвэрлэлтийн дийлэнх хэсэг нэг харилцагчаас шууд хамааралтай, бусад харилцагч нартай тээвэрлэлтийн гэрээ хэлэлцээр хийж эхлээгүй байгаа ✓ Төмөр замын царигийн төлөвлөлттэй уялдан хил дамнасан сүлжээтэй шууд холбогдох, хөдлөх бүрэлдэхүүний харилцан зохицуулалттай уялдсан хүндрэл ✓ Шаардагдах хил орчмын нүүрс шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажлын тодорхойгүй байдал ✓ Ижил төрлийн төсөл хэрэгжүүлсэн мэргэшсэн ажиллах хүчний нөөц,

<ul style="list-style-type: none"> ✓ Улс төр, ашиг сонирхлын зөрүүтэй байдлаас болж олон жил яригдаж, хүлээгдэж байгаа төсөл учраас нийгмийн хүлээлт өндөр, дээрх төрлийн саад бэрхшээл үүсэх магадлал багатай. 	<p>компанийн хэмжээнд төдийгүй улсын хэмжээнд ч дутмаг байгаа.</p>
Гадаад хүчин зүйл	
Боломж	Эрсдэл, хүндрэл
<ul style="list-style-type: none"> ✓ БНХАУ, Монгол, ОХУ-уудыг дамнансан эдийн засгийн коридор байгуулах чиглэлд бүрдэж байгаа улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны таатай орчин ✓ Гадаад зах зээлд коксжих нүүрсний эрэлт өсөх, үгүйдээ тодорхой хугацаанд тогтвортой байх ✓ Сайн чанарын нүүрсийг БНХАУ-ын дэд бүтцийг ашиглан Япон, Энэтхэг болон Зүүн Азийн хэрэглэгчдэд хүргэх тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ✓ Говийн бүсийн ордуудын батлагдсан нөөц нэмэгдэх ✓ “Тавантолгой төмөр зам” ХК-ийн эзэмшлийн тодорхой хувийг нь олон улсын хөрөнгийн зах зээлд гаргах (IPO) замаар нэмэлт санхүүжилт босгох ✓ Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын трасс эрчимтэй баригдаж байгаагаас шинэ төсөл зөвхөн хил давсан шугам бус, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн сүлжээ, цаашилбал ирээдүйд зүүн коридортой холбогдох төмөр замын нэгдсэн сүлжээний хэсэг болж ач холбогдол нь өсөх ✓ “Тавантолгой цахилгаан станц” ашиглалтад орсноор хямд, найдвартай цахилгааны эх үүсвэрээр хангагдаж, өртөг бага, бүтээмж өндөр, байгаль орчинд ээлтэй орчин үеийн технологийг (цахилгаан төмөр зам) тээвэрлэлтэд нэвтрүүлэх ✓ Нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор хямд, найдвартай түлшний эх үүсвэрээр хангагдаж тээврийн өртөг буурч, өрсөлдөх чадвар нэмэгдэх ✓ Шинээр баригдаж байгаа боломждоо тулгуурлан Үр ашигтай, шинэ техник технологи нэвтрүүлсэн, олон улсын стандартын дагуу зам барих 	<ul style="list-style-type: none"> ✓ Тээврийн эрэлт нь нэг зах зээлээс хэт хамааралтай байдал үргэлжлэх ✓ Нүүрсний ханш, эрэлт олон улсын зах зээл болон улс төрийн бодлогоос шалтгаалан хэлбэлзэж тээврийн хэмжээний тогтворгүй байдал үүсгэх ✓ Гуравдагч зах зээлд гарахад чиглэсэн тээврийн эрх зүйн орчин бүрдэхгүй байх, дамжин өнгөрөх гэрээ хэлэлцээр хэрэгжихгүй байх ✓ Гадаад валютын ханшийн хэлбэлзэл ✓ Монгол Улсын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, хууль, эрх зүйн болон засаглалын тогтворгүй байдал үргэлжлэх ✓ Хил орчмын нүүрс шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалт хийгдэхгүй байх, хугацаа хойшлосноос төслийн ашиглалт саатах ✓ Улс орны нөхцөл байдал, санхүүжилтээс шалтгаалж барилга угсралтын ажил саатах, эвдрэл гэмтэл нэмж үүсэх ✓ Бусад давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн нөхцөл үүссэнээс төслийн хэрэгжилт саатах, удаашрах

Эх сурвалж: ТЭЗҮ

Хүснэгт 26. Авто замын свот шинжилгээ

Дотоод хүчин зүйл	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> ✓ Зөвхөн Тавантолгойд ашиглалт явуулж буй уурхайнуудын төлөвлөлтөөр манай эдийн засгийн судалгааны ашиглалтын хугацаа болох 30-аас дээш жил (200 гаруй жил) тээвэрлэх боломжтой нүүрсний нөөц байгаа төдийгүй уг нөөцийг нэмэгдүүлэх, зэргэлдээ байршилтай уурхайнуудад тээвэрлэлтээр үйлчлэх боломжтой. ✓ Монгол Улсын хэмжээний стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг зорилтот зах зээлтэй холбох хамгийн хямд, дөт дэд бүтцийн шийдэл ✓ Говийн бүсийн экологид хамгийн ээлтэй тээврийн төрөл ✓ Улс төр, ашиг сонирхлын зөрүүтэй байдлаас болж олон жил яригдаж, хүлээгдэж байгаа төсөл учраас нийгмийн хүлээлт өндөр, дээрх төрлийн саад бэрхшээл үүсэх магадлал багатай. 	<ul style="list-style-type: none"> ✓ Компанийн үйл ажиллагаа, төслийн санхүүжилт төрийн шийдвэрээс ихээхэн хамааралтай ✓ Тээвэрлэлтийн дийлэнх хэсэг нэг харилцагчаас шууд хамааралтай, бусад харилцагч нартай тээвэрлэлтийн гэрээ хэлэлцээр хийж эхлээгүй байгаа ✓ Шаардагдах хил орчмын нүүрс шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажлын тодорхойгүй байдал
Гадаад хүчин зүйл	
Боломж	Эрсдэл, хүндрэл
<ul style="list-style-type: none"> ✓ БНХАУ, Монгол, ОХУ-уудыг дамнансан эдийн засгийн коридор байгуулах чиглэлд бүрдэж байгаа улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны таатай орчин 	<ul style="list-style-type: none"> ✓ Замын компаниуд эрсдэлээ өөрөө хүлээж томоохон хөрөнгө оруулалт хийж байгаа тул ачаа тээвэрлэлт, ялангуяа нүүрс

<ul style="list-style-type: none"> ✓ Гадаад зах зээлд коксжих нүүрсний эрэлт өсөх, тодорхой хугацаанд тогтвортой байх ✓ Сайн чанарын нүүрсийг БНХАУ-ын дэд бүтцийг ашиглан Япон, Энэтхэг болон Зүүн Азийн хэрэглэгчдэд хүргэх тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ✓ Говийн бүсийн ордуудын батлагдсан нөөц нэмэгдэх ✓ “Тавантолгой цахилгаан станц” ашиглалтад орсноор хямд, найдвартай цахилгааны эх үүсвэрээр хангагдаж, өртөг бага, бүтээмж өндөр, байгаль орчинд ээлтэй орчин үеийн технологийг (цахилгаан төмөр зам) тээвэрлэлтэд нэвтрүүлэх ✓ Нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор хямд, найдвартай түлшний эх үүсвэрээр хангагдаж тээврийн өртөг буурч, өрсөлдөх чадвар нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> тээвэрлэлтийн хэмжээ хэлбэлзэх тохиолдол гарах ✓ Концессын гэрээнд Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам 27 жил, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам 12 жилийн хугацаатай ашиглагдаж төрийн мэдэлд шилжихээр байгаа нь тонн тутамд ногдуулсан хураамжийн орлогын нийт хэмжээ дээрх хугацаанд найдвартай байх эсэх нь тодорхой бус байх ✓ Тээврийн эрэлт нь нэг зах зээлээс хэт хамааралтай байдал үргэлжлэх ✓ Нүүрсний эрэлт, үнэ, ханш, эрэлт олон улсын зах зээл болон улс төрийн бодлогоос шалтгаалан хэлбэлзэж тээврийн хэмжээний тогтворгүй байдал үүсгэх ✓ Гадаад валютын ханшийн хэлбэлзэл ✓ Монгол Улсын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, хууль, эрх зүйн болон засаглалын тогтворгүй байдал үргэлжлэх ✓ Хил орчмын нүүрс шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалт хийгдэхгүй байх, хугацаа хойшлоосноос төслийн ашиглалт саатах ✓ Улс орны нөхцөл байдал, санхүүжилтээс шалтгаалж барилга угсралтын ажил саатах, эвдрэл гэмтэл нэмж үүсэх ✓ Бусад давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн нөхцөл үүссэнээс төслийн хэрэгжилт саатах, удаашрах
---	--

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

V. ЗАМ, БООМТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН НҮҮРСНИЙ САЛБАРЫН ҮР АШИГ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

5.1 Үр ашгийн тухай ойлголт, төрлүүд, мөн чанар

Үр ашиг гэдэг бол хувь хүн, бизнесийн байгууллага, үйлдвэрийн газар аливаа зүйлийг бүтээхдээ цаг хугацаа, энерги, материал, хөдөлмөр зэрэг нөөцүүдийг байж болох хамгийн бага түвшинд ашиглах тухай ойлголт юм.³⁴⁸


Эдийн засгийн үр ашиг нь хэд хэдэн төрөлтэй³⁴⁹ бөгөөд дараах байдлаар ангилж болно.

Үр ашигт байдал хангагдсанаар нэгж хугацаанд бий болох үр ашгийн ерөнхий хэмжээ нэмэгдэж, эдийн засаг, нийгмийн амьдралд тогтвортой хөгжил дэвшил бий болж байдаг.

³⁴⁸ [Efficiency Definition \(investopedia.com\)](http://investopedia.com)

³⁴⁹ [Five Types of Economic Efficiency - Quickonomics](#)

Зураг 7. Хуваарилалтын үр ашиг




Хуваарилалтын үр ашиг:

Бараа үйлчилгээний хуваарилалт хэрэглэгчдийн таалалд нийцэж байх үед энэ төрлийн үр ашиг бий болж байна гэж үздэг. Тэдний бараа үйлчилгээ худалдаж авахын тулд нэмж төлөхөд бэлэн байгаа үнэ нь нэмж авах ахиу ханамжтай тэнцүү байгаагаар үүнийг тайлбарладаг. Бизнесүүд үнийг өсгөх боломж хязгаарлагдмал байдаг тул төгс өрсөлдөөнт хэлбэрийн зах зээлд илүүтэй ажиглагддаг.

Эх сурвалж: *Five Types of Economic Efficiency - Quiconomics*

Зураг 8. Бүтээмжийн үр ашиг




Бүтээмжийн үр ашиг:

Хамгийн бага бага зардлаар хамгийн их бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх тухай ойлголт юм. Түүнчлэн эдийн засаг нэмж бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ өөр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг багасгахгүй гэсэн санааг цаанаа агуулж байдаг. Энэ нь зурган дээр B цэгээр тодорхойлогдож байна.

Эх сурвалж: *Five Types of Economic Efficiency - Quiconomics*

Зураг 9. Нийгмийн үр ашиг



Нийгмийн үр ашиг:

Гадаад хүчин зүйлийн эерэг болон сөрөг нөлөөг харгалзаж төрийн зарим зохицуулалт болох татвар, татаасын үйлчлэлээр үр ашигтай үйлдвэрлэлийн түвшин хангагдах нөхцөлийг харуулдаг. Бизнесүүд үр ашигтай ажиллахын зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн хэмжээ оновчтой байх ёстой болохыг илэрхийлдэг.

Эх сурвалж: *Five Types of Economic Efficiency - Quiconomics*

Эндээс үр ашиг гэдэг нь үйлдвэрлэл, үйлчилгээ, нөөцүүдийн хэмжээ, харьцаа оновчтой, бизнесүүдэд зардал багатай, орлого өндөртэй, хэрэглэгчдэд хэмнэлттэй, бүтээгдэхүүн үйлчилгээ чанартай, байгаль орчинд ээлтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн, баялгийн үйлдвэрлэл болон санхүүгийн нөөц, оролцогч талуудыг хамруулсан өргөн хүрээний ойлголт байдаг байна.

Үр ашигтай байдал нь бизнесүүдэд зардлыг бууруулж ашгаа нэмэгдүүлэх боломжийг олгохын хажуугаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлдэг. Засгийн газрын хувьд төсвийн орлогоо нэмэгдүүлэх, зардлаа бууруулах, улмаар төсвийн алдагдлаа багасгах нөлөөтэй. Оролцогч талууд баялгийн чанарыг чухалд үзэхийн зэрэгцээ, нөөцийн үйлдвэрлэл, хуваарилалын хэмжээг оновчтой төлөвлөх, санхүүгийн цэвэр хуримтлалын хэмжээнд дэмжлэг үзүүлэх замаар эдийн

засгийн тогтвортой өсөлт, нийгмийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд эерэг нааштай дэмжлэгийг бий болгож байдаг. Үр ашгийн талаарх энэ ойлголт нь уул уурхайн салбарын ашигт ажиллагаа, ялангуяа externality буюу байгаль орчны нөлөөллийн хувьд чухал хамаатай болох нь тодорхой юм.

5.2 Тооцооллын оршил, рекуррент загвар

Замын бүтээн байгуулалтын ажлын үр ашиг, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг өмнөх хэсэгт дэлгэрэнгүй үзсэн тул зам, боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор гарах үр ашгийг нүүрсний уурхайнуудын хувьд болон макро эдийн засгийн хувьд тооцож үзье.

Юуны өмнө нүүрсний уурхайн үр ашгийн тооцоо хийхтэй холбоотой дараах ойлголт, хамаарлуудыг авч үзэх нь зүйтэй юм.

- CT=Q(t)-Q(ec)
- Q(t)-нийт ачаа тээвэр
- Q(ec)-нүүрснээс бусад ачаа тээвэр
- CT-замаар тээвэрлэх боломжтой нүүрсний хэмжээ

Тухайн жилд ордын нүүрсний борлуулалтын шинэ хэмжээг биет хэмжээний хувьд тооцохдоо

$$Sale = CT * \frac{Q_1}{\sum Q_i}$$

- Q1 1-р орд газрын нүүрс олборлолтын хэмжээ
- Qi l-р орд газрын нүүрс олборлолтын хэмжээ

Шинээр барих замуудаар тээвэрлэлт хийх үндсэн орд газруудын сүүлийн 5 жилийн олборлолтын хэмжээний дунджийг тооцож, олборлолтын дунджуудын нийлбэр болох 22693.41 мянган тоннд хувааснаар нүүрс олборлолтын хэмжээний хувийн жинг гаргав. Үндсэн ордуудад Эрдэнэс Тавантолгой, Энержи ресурс, Ухаа Худаг, Тавантолгой, Хангад Эксплорэйшн зэрэг компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь таван толгойн бүлэг ордын нүүрсний нөөцийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа юм.

Хүснэгт 27. Нүүрсний олборлолт

Орд	2016	2017	2018	2019	2020	Дундаж
Эрдэнэс тавантолгой	7617.7	9866.1	10820.5	16527.7	13640.8	11694.56
Энержи ресурс" ХХК Ухаа Худаг	2990.9	8225.4	8478.8	10028	7193.5	7383.32
Тавантолгой" ХК	4033	3881.5	1808.9	2240	2152	2823.08
Хангад Эксплорэйшн" ХХК Барууннаран		94.3	1383.2	956.5	735.8	792.45

Эх сурвалж: Ашигт малтмал газрын тосны газар

Үр дүнг нэгтгэвэл дараах байдалтай байна.

Эрдэнэс тавантолгой	0.51533
Энержи ресурс" ХХК Ухаа Худаг	0.32535
Тавантолгой" ХК	0.1244
Хангад Эксплорэйшн" ХХК Барууннаран	0.03492

Нүүрсний уурхайнууд дээр тооцож гаргасан харьцаа үзүүлэлттэй ойролцоогоор олборлолт хийнэ гэж үзэхэд хилсдэхгүй бөгөөд замаар гаргах боломжтой нүүрсний

хэмжээг гаргасны дараа тухайн орд газраас ямар төрлийн нүүрснүүд олборлодог болохыг харгалзан үзвэл энэ нь борлуулалтын хэмжээний прогнозыг нарийвчлалын түвшин өндөртэй хийх эрх ашигт илүү нийцнэ. Борлуулалтын нүүрсний төрлийг харгалзан тогтоовол тухайн боомтын хувьд /1 зам ашиглана/:

$$Sale(1) = CT * \frac{Q_1}{\sum Q_i} * \frac{I_1}{TI} * P_1 + CT * \frac{Q_2}{\sum Q_i} * \frac{I_2}{TI} * P_2 + CT * \frac{Q_3}{\sum Q_i} * \frac{I_3}{TI} * P_3$$

- Sale Борлуулалт
- Q1 1-р орд газрын нүүрсний олборлолтын хэмжээ
- I1 1-р орд газраас 1-р төрлийн нүүрсний боомтоор гарсан хэмжээ
- TI 1-р орд газраас боомтоор гарсан нүүрсний нийт хэмжээ
- Pi I-р төрлийн нүүрсний үнэ

Ингээд дээрх хамаарлыг ашиглан үр ашгийн тооцоог орд газар болон замуудын хувьд нэгтгэн тооцъё.

5.3 Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын хувьд хийгдсэн тооцоо

Энэхүү замаар нүүрсний дараах компаниуд тээвэрлэлт хийнэ. Шинээр баригдаж байгаа замыг эдгээр ордууд бүгд ашиглаж тээвэрлэлт хийнэ гэж үзсэн бөгөөд ингэх нь ч бодит байдалд илүү нийцнэ.

- ✓ Эрдэнэс Тавантолгой
- ✓ Таван толгой
- ✓ Ухаа Худаг
- ✓ Хангад Эксплорэйшн

Тавантолгой-Гашуун сухайт төмөр замын ачаа тээврийн хэмжээ таамаглалыг тус замын ТЭЗҮ-д дараах байдлаар тооцсон байна.

Хүснэгт 28. Ачаа тээврийн таамаглал

Хугацаа хугацаа	Таван толгойн сав газар дахь уурхайнуудын олборлолт, экспортын төлөвлөгөө	Дотоодын борлуулалт	Концессын гэрээ ба бусад зохицуулалтын хүрээнд авто замаар тээвэрлэгдэх ачаа	Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх ачаа	Таван толгой-Гашуун сухайт төмөр замын ачаа тээврийн хэмжээ таамаглал, тн
2022	63	1.1	33.728	5	10.56
2023	63	1.1	33.728	5	21.12
2024	63	1.1	33.728	5	26.4
2025	94	2.54	33.728	5	31.68
2026	94	2.54	33.728	5	31.68
2027	94	2.54	33.728	10	31.68
2028	94	2.54	33.728	10	31.68
2029	94	2.54	33.728	10	31.68
2030	94	2.54	33.728	10	31.68
2031	94	2.54	33.728	10	31.68
2032	94	2.54	33.728	15	31.68
2033	94	2.54	33.728	15	31.68
2034	94	2.54	28.6715	15	31.68
2035	94	2.54	28.6715	15	31.68
2036	94	2.54	28.6715	15	31.68
2037	94	2.54	28.6715	15	31.68
2038	94	2.54	28.6715	15	31.68
2039	94	2.54	28.6715	15	31.68
2040	94	2.54	28.6715	15	31.68
2041	94	2.54	28.6715	15	31.68
2042	94	2.54	25.9565	15	50.16
2043	94	2.54	25.9565	15	50.16
2044	94	2.54	25.9565	15	50.16
2045	91.5	2.54	25.9565	15	50.16

2046	91.5	2.54	25.9565	15	50.16
2047	86	2.54	25.9565	15	50.16
2048	86	2.54	25.9565	15	50.16
2049	86	2.54	22.864	15	50.16
2050	86	2.54	22.864	15	50.16
2051	86	2.54	22.864	15	50.16
	89.4	2.396	29.47985	12.5	36,608

Эх сурвалж: ТЭЗҮ

2020 оны нүүрсний борлуулалтын мэдээг тухайн ордын нүүрсний нэр төрлийн хувийн жинг илэрхийлдэг гэж үзээд тооцоог хийе.

Хүснэгт 29. Нүүрсний нэр төрлийн хувийн жин (боомтоор гарсан байдлаар)

Нүүрсний төрөл	Эрдэнэс Таван Толгой	Нийт нүүрсэнд эзлэх хувь	Энержи ресурс	"Тавантолгой" ХК	Хангад Эксплорэйшн
Түүхий коксжих	4168.7	0.934			38.8
Сул коксжих	220.2	0.0493		501.1	
Эрчим хүчний	71.3	0.0159			
Баяжуулсан коксжих			545.4		
Нийт	4460.2		545.4	501.1	38.8

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Эрдэнэс Таван Толгой компани 3 төрлийн нүүрс үйлдвэрлэн борлуулдаг, бусад 3 компани нь 1 төрлийн нүүрс үйлдвэрлэн борлуулж байна. Ингээд нүүрсний компани бүрийн хувьд үр ашгийн прогноз, тооцооны загварыг гаргаж, гаргасан загвараа ашиглаж үр ашгийн хэмжээг тооцож үзье.

Эрдэнэс-Тавантолгой компани

Эрдэнэс-Тавантолгой компанийн нүүрсний борлуулалтын загвар дараах хамаарлаар илэрхийлэгдэнэ гэж үзэж болохоор байна. Эрдэнэс таван толгой компани нь гурван төрлийн нүүрс олборлон борлуулж байгаа бөгөөд бусад компаниуд нь нэг төрлийн нүүрс үйлдвэрлэж байна.

$$Sale(Эрдэнэс – Тавантолгой) = 0.51 * CT * (0.934 * P1 + 0.0493 * P2 + 0.0159 * P3)$$

Борлуулалтын энэхүү загварт түшиглэн татварын өмнөх ашгийг тус компанийн хувьд дараах байдлаар тооцож болно.

$$Total\ profit = 0.51 * CT * ((0.934 * P1(a) + 0.0493 * P2(a) + 0.0159 * P3(a)) - C * Q - Q((TC_1 - TC_2) - F))$$

Нүүрсний уурхайн компаниуд шинэ замыг одоо байгаа замаас илүүд үзэж ашиглахдаа төлсөн хураамжаас зам ашигласнаар гарах хэмнэлт илүү байх ёстой гэсэн нөхцөлийг харгалзана.

$TC_1 - TC_2 > F$. Татвар төлөхийн өмнөх ашгийн хэмжээнээс тээврийн зардлын хэмнэлтийн хэмжээг хассаны дараах ашиг нь зам ашигласнаар гарах ерөнхий үр ашгийг илэрхийлнэ. Тээврийн зардлын хэмнэлт нь $(TC_1 - TC_2) - F$ гэсэн томъёоллоор тооцогдоно.

- C Нэг тонн нүүрсний зардал
- TC1 Одоо ашиглаж байгаа альтернатив замын тээврийн дундаж зардал
- TC2 Шинэ замын тээвэрлэлтийн зардал
- F Замын хураамж

Ганцмод-Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд нефтийн бүтээгдэхүүн, барилгын материал, машин, тоног төхөөрөмж, металл хийц, хүнд машин механизм хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг жилд нийтдээ 2 хүртэлх сая.тн ачаа тээврийн боломж ойрын

хугацаанд бий болно хэмээн тооцлоо. Мөн эдгээр компаниудын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулсан бөгөөд эндээс нүүрсний уурхайнууд бүгд шинээр баригдах төмөр замыг ашиглан бүтээгдэхүүнээ тээвэрлүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бол харин Оюу толгой ХХК-ийн хувьд аль хэдийн барьж, ашиглаж буй өөрийн хөрөнгө оруулалт, эзэмшил бүхий автозамтай, бүтээгдэхүүнээ нурмаг биш, уутанд хийж тээвэрлэдэг, бүтээгдэхүүний өртөг даах чадвар өндөр (зэсийн ханш 1 тонн нь 4358.5-7253.7 ам.доллар) тул төмөр замаар заавал тээвэрлэх сонирхолгүй болохоо илэрхийлсэн. Иймд нүүрснээс бусад ачааг 2 сая тонн гэж үзэв.

Эрдэнэс-Тавантолгой компанийн хувьд татварын өмнөх ашгийн тооцоог хийхэд хэрэглэгдэх үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харуулав. Хүснэгтэд тусгагдсан үзүүлэлтүүдийг хэрхэн тооцсон талаарх тайлбарыг үндсэн орцуудын хамт хүснэгтийн дараагийн хэсэгт хийсэн болно. $Q=0.51 * CT$

Хүснэгт 30. Үр ашгийн тооцооны загвар №1: Эрдэнэс Таван Толгой

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032
Q	4.37	9.75	12.44	15.14	15.14	15.14	15.14	15.14	15.14	15.14	15.14
P1 (Түүхий коксжих, ам доллар)	175.7	185.4	195.1	204.8	214.5	224.2	233.9	243.6	253.3	263.0	272.7
P2 (Сул коксжих, ам доллар)	107.9	113.3	118.8	124.3	129.7	135.2	140.7	146.1	151.6	157.0	162.5
P3 (Эрчим хүчний, ам доллар)	77.0	80.9	84.7	88.6	92.4	96.3	100.2	104.0	107.9	111.7	115.6
C (мянган төг)	101.9	109.4	116.8	124.3	131.7	139.2	146.6	154.1	161.6	169.0	176.5
ТС1 ам.доллар)	32	32	32	32	32	32	32	32	32	32	32
ТС2 ам.доллар)	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
F(ам.доллар)	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03
Замын хүчин чадал	10.56 2	21.12	26.4	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68
Нүүрснээс бусад ачаа тээвэр	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
Тээвэрлэх боломжтой нүүрс (СТ)	8.562	19.12	24.4	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Нүүрсний борлуулалтыг тооцохын тулд нүүрсний үнийн түүхэн мэдээлэл, түүний прогноз чухал үүрэгтэй. Дээр дурдсан 4 компани дараах төрлийн нүүрсийг олборлож байгаа болно.

Хүснэгт 31. Нүүрсний үнийн мэдээлэл

Нүүрсний төрөл	2015.1	2016.12	2017.01	2018.01	2018.06	2019.01	2019.06	2020.01	2020.06	2021.01	2021.05
Түүхий коксжих	42.36	40.3	127.71	139.6	128.2	128.16	127.05	109.94	103.99	150.88	193.69
Сул коксжих	34.42	29.81	58.79	94.4	89.87	91.45	83.02	76.71	69.09	90.32	108.42
Эрчим хүчний	25.66 5	23.04	41.72	64.205	61.015	63.035	57.16	53.525	49.62	63.24	72.7
Баяжуулсан коксжих	-	55.64	141.27	124.98	144.06	137.9	137.36	121.83	118.24	153.95	231.41

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

5.4 Нүүрсний үнийн прогноз


Нүүрсний үнийг нэр төрлийнх нь хувьд дараах байдлаар тэмдэглэе.

- P1 Түүхий коксжих нүүрсний үнэ
- P2 Сул коксжих нүүрсний үнэ
- P3 Эрчим хүчний нүүрсний үнэ


Энгийн шугаман регрессийн загварыг ашиглан нүүрсний үнийн загварыг гаргаж авбал дараах байдалтай байна. Арифметик болон абсолют дундаж өсөлт, геометр дундаж өсөлтийг ашиглан нүүрсний үнийн прогноз хийхэд нүүрсний үнэ хэт өндрөөр тогтоогдох сул талтай тул цаг хугацааны хэмжээст харгалзах нүүрсний үнийг тодорхойлох нь зохистой байдаг. Учир нь цаг хугацаа аливаа өөрчлөлтийг бүхэлд тусгасан хэмжигдэхүүн болж чаддаг. Нөгөө талаас нүүрсний үнэ дэлхийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс хамааран тогтоогдож байдаг болохыг мэдэж байх нь зүйтэй.

Зураг 10. Нүүрсний үнийн энгийн шугаман регрессийн загвар


Түүхий коксжих нүүрсний үнийн загвар




Сул коксжих нүүрсний үнийн загвар



Эрчим хүчний нүүрс



Баяжуулсан нүүрс



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

5.5 Тонн нүүрсний өртгийн тооцоо, прогноз

Үр ашгийн тооцооны удаах үндсэн бүрэлдэхүүн нь зардал байдаг. Тэгвэл Эрдэнэс-Тавантолгой компанийн хувьд нүүрсний зардлыг 1 тоннд ногдох байдлаар нь тооцъё.

Хүснэгт 32. Нэг тонн нүүрсний өртөг: Эрдэнэс-Тавантолгой

	2016	2017	2018	2019	2020
Нийт зардал (мянган төгрөг)	514,782,694.80	608,273,021.80	1,009,220,007.00	1,305,900,866.20	1,311,933,093.60
Q (мян.тонн)	7,617.70	9,866.10	10,820.50	16,527.70	13,640.80
C	67,577.20	61,652.80	93,269.30	79,012.90	96,177.10

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Тавантолгойн бүлэг ордод нүүрсний олборлолт явуулж байгаа нүүрсний компаниудын 1 тоннд ногдох нүүрсний зардал доорх хүснэгтэд үзүүлсэн байдалтай байна.

Хүснэгт 33. Нүүрсний ордуудын нэг тонн нүүрсний өртөг


	2016	2017	2018	2019	2020
Эрдэнэс тавантолгой (олборлолт)	7617.7	9866.1	10820.5	16527.7	13640.8
Нийт зардал	514,782,694.8	608,273,021.8	1,009,220,007.0	1,305,900,866.2	1,311,933,093.6
1 тонн нүүрсний зардал	67,577.2	61,652.8	93,269.3	79,012.9	96,177.1
Энержи ресурс" ХХК Ухаа Худаг (олборлолт)	2990.9	8225.4	8478.8	10028	7193.5
Нийт зардал	316384520	712475353.7	960346397.8	1100424231	934233605.6
1 тонн нүүрсний зардал	105,782.38	86,618.93	113,264.42	109,735.16	129,871.91
Тавантолгой" ХК (олборлолт)	4033	3881.5	1808.9	2240	2152
Нийт зардал	111,291,439.	237,185,086.	164,006,773.4	205,693,259.6	216,079,485.9
1 тонн нүүрсний зардал	27595.19936	61106.55321	90666.57825	91827.34804	100408.683
Хангад Эксплорэйшн" ХХК Барууннаран(олборлолт)	-	94.3	1383.2	956.5	735.8
Нийт зардал	3000478.2	17739805.5	85639276.7	94373099.4	58738367.7
1 тонн нүүрсний зардал		188 120.9491	61 913.87847	98 665.02812	79 829.25754

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

1 тонн нүүрсний дундаж зардлын өсөлт “Хангад Эксплорэйшн” компанийг үл оруулаад үлдсэн 3 нүүрсний компанийн хувьд 11.75 хувь байгаа болох нь дээрх хүснэгтийг ашиглаж тооцсон тооцооллын үр дүнгээс гарсан. Эрдэнэс-Тавантолгой компанийн тонн нүүрсний дундаж зардлын өсөлт 12 хувь байгаа нь тус компанийн хувьд энэ хувь хэмжээг ашиглан үр ашгийн тооцоог хийх боломжтой болохыг илтгэнэ.

Тавантолгойн нүүрсний үндсэн 4 бүлэг ордоос шинээр баригдаж буй 4 замаар нүүрс тээвэрлэхээс өмнө зам бүрд зориулсан олборлолтыг тусад нь хийхгүй. Нүүрсний компаниуд орд газраа нүүрсээ нэг мөр олборлож, шинэ замуудаар тус тусад нь тээвэрлэнэ. Иймд нэг тонн нүүрс олборлох өртөг орд газрын хувьд нүүрсний нийт үйлдвэрлэл өснө гэсэн төсөөлөлд түшиглэн хийгдэх учиртай. Гэхдээ энэ тооцоо нь хэт өндөр болгох хандлагатай тул энгийн шугаман регрессийн загварыг ашиглан зүй нэг тонн нүүрсний зардлын зүй тогтлыг гаргаж авъя.


Зураг 11. Эрдэнэс-Тавантолгой компанийн нэг тонн нүүрсний өртгийн загвар



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Зураг 12.Энержи ресурс компанийн нэг тонн нүүрсний өртгийн загвар

Нэг тонн нүүрсэнд ногдох зардлын тооцоо



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээр дурдсан, тооцож прогнозлон гаргаж авсан үнэ болон зардлын мэдээллийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 34. Үр ашгийн тооцоо №2:Энержи ресурс


Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032
Q	2.8	6.2	7.9	9.7	9.7	9.7	9.7	9.7	9.7	9.7	9.7
P(баяжуулсан)	189.0	198.5	208.0	217.5	227.0	236.6	246.1	255.6	265.1	274.6	284.1
C (мянган төг)	137.6	144.7	151.8	159.0	166.1	173.2	180.3	187.5	194.6	201.7	208.9
ТС1 ам.доллар)	32	32	32	32	32	32	32	32	32	32	32
ТС2 ам.доллар)	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
F(ам.доллар)	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03
Замын хүчин чадал	10.56 2	21.12	26.4	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68
Нүүрснээс бусад ачаа тээвэр	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
Тээвэрлэх боломжтой нүүрс (СТ)	8.562	19.12	24.4	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Тавантолгой

Зураг 13. Нэг тонн нүүрсэнд ногдох зардлын тооцоо, загвар

Нэг тонн нүүрсэнд ногдох зардлын тооцоо




Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 35. Үр ашгийн тооцоо №3: Таван толгой

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032
Q	1.1	2.4	3.0	3.7	3.7	3.7	3.7	3.7	3.7	3.7	3.7
P(сул коксжих)	107.9	113.3	118.8	124.3	129.7	135.2	140.7	146.1	151.6	157	162.5
C (мянган төг)	144.9	162.5	180.1	197.8	215.4	233.0	250.7	268.3	285.9	303.6	321.2
ТС1 ам.доллар)	32	32	32	32	32	32	32	32	32	32	32
ТС2 ам.доллар)	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
F(ам.доллар)	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03
Замын хүчин чадал	10.56 2	21.12	26.4	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68
Нүүрснээс бусад ачаа тээвэр	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
Тээвэрлэх боломжтой нүүрс (СТ)	8.562	19.12	24.4	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68	29.68

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хангад Эксплорэйшн



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 36. Үр ашгийн тооцоо№3: Хангад Эксплорэйшн


Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032
Q	0.30	0.67	0.85	1.04	1.04	1.04	1.04	1.04	1.04	1.04	1.04
P1 (Түүхий коксжих, ам доллар)	175.7	185.4	195.1	204.8	214.5	224.2	233.9	243.6	253.3	263	272.7
C (мянган төг)	115.7	124.9	133.9	142.8	151.8	160.8	169.7	178.7	187.6	196.6	205.5
ТС1 ам.доллар)	32.0	32.0	32.0	32.0	32.0	32.0	32.0	32.0	32.0	32.0	32.0
ТС2 ам.доллар)	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
F(ам.доллар)	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03	0.03
Замын хүчин чадал	10.6	21.1	26.4	31.7	31.7	31.7	31.7	31.7	31.7	31.7	31.7
Нүүрснээс бусад ачаа тээвэр	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0
Тээвэрлэх боломжтой нүүрс (СТ)	8.6	19.1	24.4	29.7	29.7	29.7	29.7	29.7	29.7	29.7	29.7

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээр харуулсан хүснэгтүүдийн зарим үзүүлэлт ам. доллараар илэрхийлэгдсэн байгаа тул валютын тооцоог ижилсүүлэх үүднээс ам.долларын төгрөгөөр илэрхийлэгдсэн ханшийг прогнозлов.

Ам.долларын прогноз:

Зураг 14. Ам долларын ханшны энгийн шугаман регрессийн загвар




Ам.доллар нь хугацааны цувааны хэлбэртэй өгөгдөл бөгөөд нэг хувьсагчтай хугацааны цувааны шинжилгээний forecasting хийх арга зүйг ашиглаж ханшийг таамаглах нь зохимжтой байдаг.

Энэхүү хүснэгтийн зүүн талд энгийн шугаман регрессийн загвараар гаргаж авсан загварыг харуулав. Энэхүү загварын чанарыг ARMA загвар илүү сайжруулна.

Өгөгдөл нь 1999 оны 3-р сарын 1-нээс 2021 оны 5-р сар хүртэлх 267 ханшийн өгөгдлийг агуулсан болно.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар


Зураг 15. Ам.долларын ханшийн итгэх интервалын дээд, доод утгын график



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Ам.долларын прогнозын загварын тэгшитгэл: $USFE = C(1)*(@TREND+1) + C(2)*@SEAS(1) + [AR(3)=C(3),UNCOND]$

Зураг 16. Ам.долларын ханшийн ажиглалтын болон загварын утга, зөрүү



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Прогнозлосон ам.долларын ханш

Жил бүрийн ханшийн прогнозыг гаргахын тулд сар бүрээр гаргасан ханшийн утгуудыг 12 сараар нь багцлан, багцад орсон утгуудаа дундаж утгынх нь тооцсон болно.

2022	2949.201	2028	3455.518
2023	3033.402	2029	3540.158
2024	3117.678	2030	3624.868
2025	3202.029	2031	3709.649
2026	3286.453	2032	3794.499
2027	3370.949		

5.6 Замын бүтээн байгуулалттай холбоотой нүүрсний салбарын харьцангуй үр ашиг

Нэгэнт шинээр зам барьсан тул харьцангуй үр ашгийг тооцох хэрэгтэй болно. Үүний тулд одоо байгаа замыг хэмнэлт, нэмэлт хураамжгүйгээр ашиглан түүхэн гүйцэтгэлд түшиглэн нүүрсний олборлолт, борлуулалтын үйл ажиллагааг явуулах үед бий болох үр ашиг, замын дэд бүтцийг хөгжүүлснээр хүчин чадал нь нэмэгдсэн замаар нүүрсний олборлолт, борлуулалтын үйл ажиллагааг явуулах үед бий болсон үр ашиг хоёрын зөрүүг тооцох шаардлагатай юм.

Сүүлийн 10 жилийн хугацаанд эдийн засгийн бодит өсөлт дунджаар 7.8 хувь байсан бөгөөд ДНБ зэрэгцүүлэх үнээр 2019 онд 19.0 их наяд төгрөг болж, 2010 онтой харьцуулахад манай улсын эдийн засаг 2 дахин тэлсэн байна. Нефтийн бүтээгдэхүүн, барилгын материал, машин, тоног төхөөрөмж, металл хийц, хүнд машин механизм хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг жилд нийтдээ 2 хүртэлх сая.тн ачаа тээврийн боломж ойрын хугацаанд бий болно хэмээн тооцлоо. Тооцоог 11 жилээр хийсэн болно. Энэ нь тооцоолол хийхэд урт хугацаа бөгөөд замын бүтээн байгуулалтаар дамжиж бий болох үр ашгийн тооцоог концессын гэрээ болон ТЭЗҮ-д тусгасан хугацаагаар тоймлон харах боломжтой.

Хүснэгт 37. Шинэ замын ашиглалтын өсөлтөөс гарах олборлолтын нэмэгдэл

Он	Замтай холбоотой шинэ хүчин чадлаар	Түүхэн гүйцэтгэлд суурилсан байдлаар	Зөрүү
2022	66.07	32.96	33.11
2023	78.52	35.55	42.97
2024	83.69	38.13	45.56
2025	92.08	40.72	51.36
2026	92.08	43.30	48.78
2027	92.08	45.89	46.19
2028	92.08	48.47	43.61
2029	92.08	51.06	41.02
2030	92.08	53.64	38.44
2031	92.08	56.22	35.86
2032	92.08	58.81	33.27
			460.17

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 38. Төмөр замыг ашиглаж олох нүүрсний компаниудын үр ашиг (сая төгрөгөөр)

Он	Сая тонн	Замтай холбоотой шинэ хүчин чадлаар/Таван толгой/Гашуунсухайт-төмөр зам	Зүүн баян төмөр замын хүчин	Зүүн баян төмөр зам	Төмөр замыг ашиглаж тээвэрлэх нүүрсний нийт үр ашиг
2022	8.57	3,846,667.95	8	3,590,822	7,437,490
2023	19.02	9,481,258.26	10	4,984,889	14,466,147
2024	24.19	12,450,936.10	10	5,147,142	17,598,078
2025	29.58	16,328,050.61	13	7,175,952	23,504,003
2026	29.58	17,485,363.76	13	7,684,575	25,169,939
2027	29.58	18,691,146.11	13	8,214,500	26,905,646
2028	29.58	19,940,265.65	13	8,763,470	28,703,736
2029	29.58	21,230,827.92	13	9,330,655	30,561,483
2030	29.58	22,569,452.47	13	9,918,962	32,488,414
2031	29.58	23,952,810.55	13	10,526,928	34,479,739
2032	29.58	25,381,329.70	13	11,154,743	36,536,072

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 39. Авто замыг ашиглаж олох нүүрсний компаниудын үр ашиг (сая төгрөгөөр)

Он	Сая тонн	Замтай холбоотой шинэ хүчин чадлаар/Таван толгой-Манлай-Ханги	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн автозамын хүчин чадал	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн нийт үр ашиг	Авто замыг ашиглаж тээвэрлэх нүүрсний нийт үр ашиг
2022.0	21.5	8006227.5	28.0	10426714.8	18432942.3
2023.0	21.5	10385630.0	28.0	13525471.6	23911101.7
2024.0	21.5	11255154.8	28.0	14657876.1	25913030.9
2025.0	21.5	12160382.3	28.0	15836776.9	27997159.2
2026.0	21.5	13105149.4	28.0	17067171.3	30172320.6
2027.0	21.5	14091847.4	28.0	18352173.3	32444020.7
2028.0	21.5	15114015.0	28.0	19683368.3	34797383.3
2029.0	21.5	16171339.3	28.0	21060348.9	37231688.2
2030.0	21.5	17269294.8	28.0	22490244.4	39759539.2
2031.0	21.5	18405233.4	28.0	23969606.3	42374839.7
2032.0	21.5	19578892.3	28.0	25498092.2	45076984.5

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 40. Урсгалаараа буюу түүхэн гүйцэтгэлд суурилсан үр ашиг /замын хэмнэлтгүй байх үед/

Нүүрсний тонн хэмжээ	Хэмнэлтгүй үеийн буюу өмнөх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн түвшинд гарсан нийт үр ашиг	Урсгалаараа буюу түүхэн гүйцэтгэлд суурилсан борлуулалтын хэмжээ (бүлэг ордын хувьд)	Замын бүтээн байгуулалт баригдаагүй гэж үзэх үеийн нийт үр ашиг
8.57	3,240,834.5	33.0	12,464,166.4
19.02	8,212,054.0	35.6	15,349,028.5
24.19	10,791,521.4	38.1	17,010,364.3
29.58	14,244,093.9	40.7	19,608,502.5
29.58	15,346,461.9	43.3	22,464,563.9
29.58	16,497,252.3	45.9	25,593,607.4
29.58	17,691,332.3	48.5	28,989,143.9
29.58	18,926,808.8	51.1	32,670,820.1
29.58	20,210,302.1	53.6	36,649,107.7
29.58	21,538,482.7	56.2	40,936,223.7
29.58	22,911,779.4	58.8	45,552,459.4

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 41. Зам барьж байгуулах үед зам бариагүй байх үеийнхтэй харьцуулсан үр ашгийн тооцооны харьцуулалт

Он	Замын бүтээн байгуулалтыг ашиглаж тээвэрлэсэн нүүрсний уурхайнуудын үр ашиг	Замын бүтээн байгуулалтыг ашиглаагүйгээр нүүрс борлуулна гэж үзэх үеийн үр ашиг
2022.0	25,870,432.12	12,464,166.41
2023.0	38,377,248.59	15,349,028.46
2024.0	43,511,108.86	17,010,364.29
2025.0	51,501,161.79	19,608,502.53
2026.0	55,342,259.41	22,464,563.95
2027.0	59,349,666.43	25,593,607.39
2028.0	63,501,119.34	28,989,143.90
2029.0	67,793,170.68	32,670,820.13
2030.0	72,247,953.23	36,649,107.68
2031.0	76,854,578.43	40,936,223.69
2032.0	81,613,056.80	45,552,459.40
Нийт	635,961,755.68	297,287,987.82

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Нийт үр ашгийн өсөлт = 635,961,755.68 – 297,287,987.82 = **338,673,767.86**

Жилийн дундаж үр ашгийн өсөлт(сая төг) = $\frac{338,673,767.86}{12} = 30,788,524.35$

5.7 Монгол Улсын эдийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Макро эдийн засагт үзүүлэх шууд нөлөөллийг дараах үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тооцох боломжтой.

- ✓ Татвар, төсөв
- ✓ Экспортын орлого
- ✓ Ажил эрхлэлт
- ✓ Валютын ханш

Хүснэгт 42. Монгол Улсын эдийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл /1 жилийн хувьд/

✓ Татвар, төсөвт оруулж буй үндсэн хувь нэмэр	30,788,524.35 *0.1= 3.07 их наяд төгрөгийг орлогын татвар хэлбэрээр: 87.72 сая*173 ам.доллар*0.05=758.7 сая ам.долларыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр тус тус улсын төсөвт төвлөрүүлэх боломжтой болно.
✓ Экспортын орлого	87.72 сая*173 ам.доллар-3.1 тэрбум ам.доллар=15.17 тэрбум ам.доллар-3.1 тэрбум ам.доллар=12.07 тэрбум ам.доллар
✓ Ажил эрхлэлт	2019 онд нүүрсний салбарт нийт 15259 ажилтан ажиллагсад ажиллаж байхад 3.1 тэрбум ам. долларын экспортын орлого олдог байсан болохыг үндэслэл болговол ажиллагсдын тооны өсөлт энэхүү салбарт=(9.13/3.1)*15259-15259=29681.2 буюу багадаа 30 орчим мянган хүнийг шинээр ажлын байртай болгох боломж бүрдэж байна.
✓ Валютын ханш	Валютын ханш жил бүхэн нэмэгдэж байгаа манай улсын хувьд экспортын орлого дунджаар 12.07 тэрбум. Ам.доллараар өснө гэдэг бол мэдэгдэхүйц томоохон дэмжлэг мөн юм.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Харьцангуй ашигтай байх нөхцөл биелэхийн тулд хугарлын цэгийн үзэл санаанд тулгуурлан үнэ хэдээс доошгүй байхыг тооцож гаргая.

$$Q_{av} * \left((P - C_{av}) + \frac{(32 - 8) + (38 - 32)}{2} - \frac{(0.03 + 3.4)}{2} \right) \geq \text{Түүхэн гүйцэтгэлээрх үр ашиг}(av)$$

Q_{av}=87.72 сая тонн

C_{av}=180.95 мян төг

32 ам.доллар

8 ам.доллар

38 ам.доллар

0.03 ам.доллар

3.4 ам.доллар

Түүхэн гүйцэтгэлээрх үр

ашиг (av)=13,146,056

Боломжит үйлдвэрлэлийн дундаж хэмжээ

Нэг тонн нүүрсний дундаж зардал

1 тонн нүүрс тээвэрлэх авто замын зардал

1 тонн нүүрс тээвэрлэх төмөр зардал

1 тонн нүүрс тээвэрлэх шороон замын зардал

Төмөр замын хураамж

Авто замын хураамж

Түүхэн гүйцэтгэлийг давтагдана гэж үзэж тооцсон үр

ашигийн дундаж

Эндээс дараах тэнцэтгэл бишийг бодож болно. Үнэ хэдээс доошгүй байхыг тооцож гаргая

$$87.72 * ((P - 180950) + 13.29) \geq 27,026,180.7$$

$$(P - 180950 + 13.29) \geq 308095$$

P≥489032 төгрөг гэж гарах бөгөөд энэ нь дунджаар 145.07 ам.доллар болж байна. Энэхүү харьцаа хадгалагдаж байх үед нүүрсний ордуудын харьцангуй үр ашигтай байх нөхцөл биелнэ. Дээр дурдсан орд газруудаас олборлож байгаа нүүрсний дундаж үнэ прогнозлож гаргасан тооцоогоор түүхий коксжих, сул коксжих, эрчим хүчний, баяжуулсан коксжих зэрэг нүүрсний төрлүүдийн хувьд дунджаар 173.06 ам.доллар байгаа бөгөөд 2015-2021 оны түүхэн гүйцэтгэлээр нь аваад үзвэл 95.37 ам.доллар байна. Нүүрсний дундаж үнэ ирэх 11 жилийн дунджаар **145.07 ам.** доллар-аас буухгүй байхад нүүрсний уурхайн ордууд зам бариагүй байсан үеийнхээс илүү ашигтай ажиллаж чадахаар байгаа бөгөөд энэ нь ам.долларын прогнозын дундаж утгын хувьд хангалттай биелэхээр байна.

Нөгөө талаас өнгөрсөн 10 жилд нүүрсний дундаж үнэ 0.204 буюу жилд дунджаар 20.4 хувийн өсөлттэй байжээ. Сөрөг нөхцөлөөр бодоход жилд дунджаар 4.73 ((145.07-95.37)/95.37*1/11) хувиар буюу түүхэн гүйцэтгэлээсээ 4.3 дахин багаар нүүрс өсөхөд нүүрсний компаниудын үйл ажиллагаа харьцангуй ашигтай байх нөхцөл биелэх юм. Иймд нүүрсний үнэ ямар байх хандлагатай, өсөлт нь хэр зэрэг байх төлөвтэй байгаа талаарх чанарын судалгааны дүгнэлтийг авч үзэх нь зүйтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Шинэ төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсгийн тодотгол, 2019 он
- <https://www.mtz.mn/content/17>
- <http://bodi.mn/post/63288>
- <http://bodi.mn/product/65191>
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх зөвлөх үйлчилгээ, 2020 оны 4-р сар
- Шинэ төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсгийн тодотгол, 2019 он
- <https://www.mtz.mn/content/17>
- <http://bodi.mn/post/63288>
- <http://bodi.mn/product/65191>
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх зөвлөх үйлчилгээ, 2020 оны 4-р сар
- Зам, тээврийн хөгжлийн яам, МУ-ыг зам, тээвэр, Статистикийн мэдээлэл, 2021 оны 1 улирал <https://mrt.d.gov.mn/i/2675>
- <http://bodi.mn/post/63288>
- Зам, тээврийн хөгжлийн яам, МУ-ыг зам, тээвэр, Статистикийн мэдээлэл, 2021 оны 1 улирал <https://mrt.d.gov.mn/i/2675>
- <http://bodi.mn/post/63288>
- Тавантолгой ХК-ны 2020 оны тайлангаас
- ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2020 оны байдлаар
- Сангийн яам, ХХК-ны мэдээлэл
- Монгол банкны статистик
- Ашигт малтмал газрын тосны газар
- Статистикийн ерөнхий газар
- Five Types of Economic Efficiency - Quickonomics
- EFFICIENCY | meaning in the Cambridge English Dictionary
- Economic Efficiency Definition (investopedia.com)
- Importance of Mining (straterra.co.nz)
- Microsoft Word - Aldagheiri and Bradshaw.doc (ctrf.ca)



**ЦАР ТАХЛЫН МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АМЬДРАЛД
ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨЛӨЛ БА АЛДАГДСАН БОЛОМЖИЙН ЗАРДАЛ**

*Ц.Норовдондог (Ph.D), Ш.Батцэнгэл,
Д.Халуун, О.Билгүүтэй*

ГАРЧИГ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1. ЦАР ТАХЛААС ШАЛТГААЛЖ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АМЬДРАЛД ГАРСАН
ӨӨРЧЛӨЛТ

2. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ГАРСАН
ӨӨРЧЛӨЛТ

3. ЦАР ТАХЛЫН УЛМААС ГАРСАН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АЛДАГДСАН
БОЛОМЖИЙН ЗАРДАЛ

4. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧНЫ ХҮРЭЭНД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, НӨЛӨӨЛӨЛ

5. ЦАР ТАХЛЫН ҮЕД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧНЫ ХҮРЭЭНД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

6. НИЙГМИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, НӨЛӨӨЛӨЛ
АШИГЛАСАН МАТЕРИАЛ



УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Цар тахлын эдийн засаг, нийгэмд үзүүлсэн нөлөөлөл ба алдагдсан боломжийн зардал” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэлээ. Сэдвийн хүрээнд цар тахлаас шалтгаалж эдийн засаг, нийгмийн амьдралд гарсан өөрчлөлтүүд болон макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн орчин, нийгмийн хамгааллын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн нөлөөллийг судалснаас гадна цар тахлын улмаас эдийн засаг, нийгэмд учирсан алдагдсан боломжийн өртгийг тоон шинжилгээний аргаар тооцоолж харьцуулсан дүгнэлт гаргав.

Түлхүүр үг: *Цар тахал, макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн орчны үзүүлэлтүүд, нийгмийн үзүүлэлтүүд*

Keywords: *Covid-19, macroeconomic variables, financial environment indicators, social indicators*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсын Засгийн газар “КОВИД-19” цар тахлын халдварыг тогтоон барих, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг нь бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Нийт дүнгээр нь авч үзвэл, Монгол Улсын хувьд 2020 оны 4-р сараас 2021 оны 6 дугаар сарын хооронд 3.27 их наяд төгрөгийн төсвийн нэмэлт зарлага, 1.9 их наяд төгрөгийн төлөвлөсөн орлогын хөнгөлөлт, чөлөөлөлт, 649 тэрбум төгрөгийн төсвийн гадуурх санхүүжилт зэрэгт 5.1 их наяд төгрөгийг ковидын сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулаад байна.

Алдагдсан боломжийн зардлын тооцооллын хувьд:

Алдагдсан боломжийн өртөг зардлыг 2020 оны жилийн эцсийн ковидтой байх үеийн гүйцэтгэлийн үр дүнг ковидгүй байх үеийн төсөөлөлтэй харьцуулан тооцоолсон бөгөөд энэхүү тооцооллын үр дүнд ковидгүй байсан бол 2020 онд:

- ДНБ ойролцоогоор 2.4 их наяд төгрөгөөр их;
- Засгийн газрын өрийн хэмжээ буюу төсвийн алдагдал 1.6 их наяд төгрөгөөр, бага;
- Экспорт 2.8 их наяд төгрөгөөр, импорт 6.2 их наяд төгрөгөөр өндөр;
- Хөдөлмөр эрхлэгчдийн тоо 1700-аар одоо байгаа түвшнээс өндөр байх байжээ.

Түүнээс гадна ажилгүй иргэдийн тоо 23 мянга орчмоор цөөн, өрхийн дундаж мөнгөн орлого 197.5 мянган төгрөгөөр ахиу байх байсан гэсэн үр дүн гарлаа.

Ковидтой байх үеийн эдийн засаг, нийгмийн амьдралд гарсан үр дүн бол цар тахлын сөрөг үр нөлөө болон түүнийг бууруулах чиглэлээр төр, засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүчин чармайлтын үр дүн мөн.

Монгол Улсын засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэж байгаа хэдий ч Монгол улсын Засгийн газар, Монгол-банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд төрөөс таваар мөнгөний харилцаа хэвийн явагдах орчинг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, өрхийн амьжиргаа, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үзүүлэлтүүдийн чанарыг боломжит түвшинд барих чиглэлээр ажиллаж байна.

2020 оны эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийг 2019 онтой харьцуулж хийсэн судалгааны үр дүнгийн хувьд:**Макро эдийн засгийн хүрээнд:**

ДНБ-ний бүрдэл хэсэг болох худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарууд эрсдэлтэй нөхцөл байдалд байсаар байна. 2019 онтой харьцуулахад 2020 онд ДНБ 5.3 хувиар буурчээ. Эдийн засгийн өсөлтийг бууруулахад нөлөөлсөн салбарууд нь уул уурхай, олборлолт, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, болон үйлчилгээний бусад үйл ажиллагаа зэрэг байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний эцсийн ашиглалтаарх тооцооллоос эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлсэн гол бүрдэл хэсэг нь эцсийн хэрэглээ, цэвэр экспортын хэмжээ байсан бол хөрөнгийн нийт хуримтлалын хэмжээний бууралт сөрөг нөлөө үзүүлсэн байгаа нь харагдаж байна.

Инфляцийн түвшин 2020 онд 2.3 хувь байсан буюу ерөнхийдөө нам дор түвшинд хадгалагджээ. Энэ нь хэрэглээний сагсанд ордог бараа, үйлчилгээний үнэ харьцангуй тогтвортой байсантай холбоотой байна. Түүнчлэн төгрөгийн болон валютын харилцах дансанд байрших мөнгөний хэмжээ буурсан, эсрэгээрээ төгрөгийн болон хадгаламжийн нэмэгдсэн байна. Мөнгөний нийт нийлүүлэлтийн хэмжээ өссөн хэдий ч мөнгөний эргэлтийн хурд буюу нэрлэсэн ДНБ-нийг нийт мөнгөний нийлүүлэлтийн хэмжээнд харьцуулсан харьцаа 2019-2020 онд 1.83-аас 1.67 болж буурсан байна. Энэ нь зээл олголтын хэмжээ багассан, бизнес эрхлэгчдийн орлого тасалдаж мөнгөний эргэлтийн хурд саарсантай холбоотой.

Гадаад валютын ханш рублээс бусад гадаад валютуудын хувьд бага зэрэг өсчээ. Манай улсын хувьд гадаад валютын ханш жил тутам нэмэгдэж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн болон гадаад өрийн өсөлт, гадаад валютын нийлүүлэлтээс давсан эрэлттэй үндсэндээ холбоотой байдаг. 2020 онд гадаад валютын ханш ерөнхийдөө өссөн нь мөнгөний нийт нийлүүлэлт 16 хувиар буюу гадаад валютын албан нөөцийн өсөлтөөс өндрөөр нэмэгдсэн, төв банкнаас нийлүүлсэн гадаад валютын нийлүүлэлтээс зах зээлийн эрэлт давсантай холбоотой юм.

Хязгаарлалт хорио цээрийн нөхцөл байдал үргэлжилбэл ажилгүй иргэдийн тоо өсөх, худалдан авалт, эрэлт буурах, улмаар эдийн засгийн идэвхжил сулрах, худалдан авалт, борлуулалтын хэмжээ багассанаар ДНБ-ний хэмжээ агших үйл явц үргэлжлэх эрсдэлтэй.

Нөгөө талаас цар тахалтай холбоотой эрүүл мэндийн зардал өсч, иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ хэвээр байгаад байвал төсвийн орлого хумигдахын хажуугаар төсвийн зардал өсөх эрсдэл бий болно. Энэ нь засгийн газрын өрийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх шалтгаан болж болзошгүй байна. 2020 онд өмнөх онтой харьцуулахад төсвийн алдагдлын хэмжээ 3.9 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Засгийн газар эрэлтийг дэмжих, бодит секторын нийлүүлэлтийг өсгөх чиглэлээр гаргасан хүчин чармайлтаа үргэлжлүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл нь цар тахлын хэмжээ хумигдахгүй байгаа байдал болж байна. Бараа, үйлчилгээний нийлүүлэлт тасалдах бодит нөхцөл байдал үүсвэл үнийн түвшин өсөх, худалдан авах чадвар хумигдах, амьжиргааны түвшин буурах сөрөг үр дагавруудыг бий болгоно.

Цаашид Засгийн газар гадаадаас нэмэлт эх үүсвэр татаж өрийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөл байдал үүсвэл түүнийг ажлын байрыг бий болгох, дэд бүтэц, нөөцийн болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлд зарцуулах нь илүү оновчтой байна.

Санхүүгийн зах зээлийн орчны хүрээнд:

2020 онд *арилжааны банкуудын* нийт зээлийн үлдэгдэл 16.4 их наяд орчим төгрөг болсон нь 2019 онтой харьцуулахад 1.3 их наяд орчим төгрөгөөр багассан үзүүлэлт болж байна. Энэ нь 2020 онд цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн орчны тодорхой бус байдал нэмэгдэж, зээл олголт буурсантай холбоотой.

Иргэд, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого жигд бус болж тасалдсанаас нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ арилжааны банкуудын хувьд 1.6 орчим хувиар нэмэгдсэн бол *ХЗХ-ны* чанаргүй зээл 2019-2020 онд 4.04%-4.53% болж өсчээ.

ББСБ-ын нийт зээлд эзлэх чанаргүй зээл 2020 оны 4-р улиралд 11.16 хувь болсон нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2.06 хувиар нэмэгдсэн үр дүн болж байна. Чанаргүй зээлийн өсөлт нь мөнгөний өртөг буюу зээлийн хүүгийн хэмжээг өсгөхөд хүргэж болзошгүй, дотоодын хуримтлалд мөн сөрөг нөлөөтэй болохыг санхүүгийн байгууллагууд бодолцож эрсдэлийн удирдлагын чанарыг дээшлүүлэх, эдийн засагт эерэг нөлөөллийг бий болгох үйлдвэр аж ахуйн газруудыг зээлийн санхүүжилтээр хангах, Сангийн яамтай хамтран ажиллах, бодлого үйл ажиллагаагаа уялдуулах үйл явцаа сулруулахгүй, харин ч богино хугацаанд эрчимжүүлэх шаардлагатай болж байна.

Даатгалын салбарын сүүлийн 5 жилийн нийт хураамжийн дундаж өсөлт 12.8 хувь байгаа бөгөөд цар тахалтай холбоотойгоор 2020 онд 2.5 хувь болж буурсан байна. Даатгалын салбарын хөрөнгө, орлогын өсөлтийн хувь буурсан хэдий ч эдгээр үзүүлэлтүүдийн нэрлэсэн дүн өсөлттэй гарчээ. Үүнд даатгалын хураамжийн орлогын нэлээд хэсгийг заавал даатгуулах даатгал буюу жолоочийн хариуцлагын даатгал, жил тутам тоо нь нэмэгдэж байгаа авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээнээс бүрдүүлж байгаа нь нөлөөлсөн гэж үзэж болно.

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ өнгөрсөн онтой харьцуулахад 12.5 хувиар өсөж 3,029.7 тэрбум төгрөг болсон нь 2020 онд дийлэнх томоохон хувьцаат компаниуд борлуулалтын орлогоо жигд тогтвортой байлгаж чадсантай холбоотой. Харин цар тахлаас шалтгаалж хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхийг тодорхойлогч үзүүлэлт болох хувьцааны хөрвөх чадвар 3.2 нэгжээр буурч 1.8 хувьд хүрчээ.

Нийгмийн салбарын хувьд:

Хөдөлмөр эрхлэгчдийн тоо 2019 онд 1,188,440 байсан бол 2020 онд 1,124,564 болж буурчээ. 2019-2020 онд нийт ажиллагсдын ажиллах хүчинд эзлэх хувь 0.92-оос 0.84 болж багассан байна.

Өрхийн мөнгөн орлого 2019 онд 1,375,080 байсан бол 2020 онд 1,424,598 болж өөрчлөгджээ. Нэрлэсэн дүнгээрээ өрхийн орлого нэмэгдсэн ч энэ нь чанартай өсөлт хараахан биш юм. Учир нь орлого хуваарилалтыг харуулдаг үзүүлэлт болох Жинийн индекс 2019-2020 онд 32.5-аас 32.83 болж өссөн буюу орлогын тэгш бус байдал нэмэгдсэн, нөгөө талаас бодит дотоодын нийт бүтээгдэхүүн нэрлэсэн ДНБ-ний бууралтаас ихээр буурсан, хэрэглээний үнийн индекс нам дор түвшинд тогтвортой байсан хэдий боловч хэрэглээний сагсанд ордоггүй олон төрлийн бараа, үйлчилгээний үнэ өссөн, засгийн газраас өрхийн орлогыг дэмжихэд чиглэгдсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн зэрэг нь үүнийг нотолж байна.

2020 онд 1000 хүнд ногдох төрөлт, нас баралтын тоо үндсэндээ тогтвортой байсан байна. Коронавирусийн тархалт, хөл хорионоос шалтгаалан өрхүүд бизнесийн үйл ажиллагаагаа зогсоосон, үйл ажиллагаа нь тасалдсан, үйлчлүүлэгчийн тоо буурсан зэрэг нь орлого буурахад голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Малчин болон газар тариалан эрхлэгч өрхүүдийн 70 хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого буурсан байна.
- Коронавирусийн сөрөг нөлөөнд цалинтай хөдөлмөр эрхэлдэг хүн ам харьцангуй бага өртсөн хэдий ч гурван өрх тутмын нэгийнх нь цалингийн орлого буурсан байна.
- ҮСХ-ноос явуулсан боловсролын салбарын асуулгад хамрагдсан иргэдийн 95% нь ковид-19 сөргөөр нөлөөлж байна гэж үзжээ. Судалгаагаар теле хичээлд хүүхдүүдийн 91% нь хамрагдаж байгаа гэж хариулсан боловч үүнээс зөвхөн 20% нь тогтмол үзэж байгаа, 15.1% нь огт үзээгүй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл таван хүүхдийн нэг нь л тогтмол хичээлд хамрагдсан байна. Хичээл огт үзээгүй шалтгаануудыг тодруулахад гэртээ теле хичээл үзэх боломж хомс, зурагт, интернэт байхгүй, хичээл нь сонирхолгүй, ойлгомжгүй зэрэг шалтгаанууд байсан байна.
- Хүн амын төрөлт, нас баралтын түвшин сүүлийн жилүүдэд тогтвортой байсан хэдий ч 2021 он гарсанаас хойш цар тахлаас болж нас барсан хүмүүсийн тоо нэмэгдэж, өвчлөлийн цар хүрээ өсч байна.

Иймд УИХ, Засгийн газар, салбарын яамдууд дор бүрнээ анхаарч судалгаа тооцоонд суурилсан ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийнхээ чанарыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

Судалгааны харьцуулалт, дүн шинжилгээг эдийн засаг, нийгмийн дараах үзүүлэлтүүдийн хүрээнд гүйцэтгэв.

Хүснэгт 1. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

Эдийн засгийн үзүүлэлт		Нийгмийн үзүүлэлтүүд
Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Санхүүгийн зах зээлийн орчны үзүүлэлтүүд	
<ul style="list-style-type: none"> ✓ Мөнгөний нийлүүлэлт ✓ Үйлдвэрлэлийн бодит салбарууд ✓ Инфляц ✓ Төсвийн орлого ✓ Төсвийн зардал ✓ Төсвийн алдагдал ✓ Экспорт ✓ Импорт ✓ Төлбөрийн тэнцэл ✓ Валютын ханш ✓ Мөнгөний өртөг, хүүний түвшин ✓ Засгийн газрын өр 	<ul style="list-style-type: none"> ✓ Банк ✓ Даатгал ✓ Үнэт цаасны зах зээл ✓ ББСБ ✓ Хадгаламж зээлийн хоршоо 	<ul style="list-style-type: none"> ✓ Хөдөлмөр эрхлэлт ✓ Өрхийн амжиргааны түвшин, ✓ Боловсрол ✓ Эрүүл мэнд ✓ Нийгмийн халамж, тэтгэмж ✓ Амьдрах орчин нөхцөл

Эх сурвалж: Судлаачийн нээтгэл

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1. ЦАР ТАХЛААС ШАЛТГААЛЖ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АМЬДРАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Цар тахал эдийн засагт дараах 4 үндсэн сувгаар нөлөө үзүүлж байна.³⁵⁰

- е) Халдварыг тогтоон барих Засгийн газрын арга хэмжээ нь жижиг бизнес болон өрхийн орлогод шууд сөргөөр нөлөөлж нэгэнт суларч байсан эдийн засгийн дотоод идэвхжилийг сааруулах
- ф) Хятадын эрэлт буурч, халдвараас шалтгаалан хил хаагдаж, түүхий эдийн үнэ унасны зэрэгцээ хөрөнгө оруулагчид эрсдэлээс болгоомжилсон явдал нь уул уурхайн салбарт үзүүлэх сөрөг нөлөө
- г) Цар тахлыг хязгаарлах арга хэмжээ нь Монголын эдийн засгийн 40 хувийг бүрдүүлдэг үйлчилгээний сектор (аялал жуулчлал, тээвэр ороод)-т үзүүлэх сөрөг нөлөө
- h) Төсвийн орлого тасалдаж эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зардал өсөн нэмэгдсэн нь төсвийн дарамтыг улам даамжруулах зэрэг болно.

2. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Хүснэгт 2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр (өссөн дүнгээр)

Үзүүлэлт	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
ДНБ	3,531,788	8,680,557	13,735,908	19,050,462	3,154,618	7,835,265	12,735,572	18,034,015	3,651,359
Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур	134,486	1,218,522	1,935,518	2,537,907	153,253	1,379,782	2,154,854	2,694,507	143,190
Уул уурхай, олборлолт	914,131	1,838,200	2,880,881	3,956,433	642,712	1,297,026	2,285,385	3,584,795	861,972
Боловсруулах үйлдвэрлэл	200,490	506,225	865,488	1,402,246	208,786	480,028	808,379	1,420,346	252,632
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	102,865	173,337	234,119	340,527	109,527	178,337	237,655	347,199	117,810
Барилга	42,253	216,333	358,295	703,179	47,276	202,884	335,752	651,283	44,252
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	424,733	995,578	1,586,614	2,310,401	382,053	862,271	1,379,345	2,053,451	406,178
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	242,983	483,331	856,088	1,400,988	168,585	325,290	643,736	1,119,438	177,992
Мэдээлэл, холбоо	102,396	225,900	348,613	451,759	102,705	226,671	350,056	453,419	106,489
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	933,941	1,880,168	2,924,493	3,853,588	940,400	1,875,786	2,941,254	3,821,475	960,723
Бүтээгдэхүүний цэвэр татвар	433,510	1,142,965	1,745,800	2,093,434	399,321	1,007,191	1,599,158	1,888,101	580,122


³⁵⁰ Монгол улсын эдийн засгийн тойм, 2021, 2 сар.

ДНБ	3,722,007	4,884,053	5,092,617	5,466,331	3,315,495	4,453,946	4,953,102	5,414,950	3,830,294
Эцсийн хэрэглээ	3,347,020	3,639,400	3,590,378	3,908,541	3,539,285	3,879,816	3,906,049	3,893,972	3,255,172
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	2,762,755	2,927,112	3,034,171	3,132,817	2,919,377	3,097,549	3,238,354	2,915,970	2,638,840
Төрийн байгууллагын хэрэглээ	584,265	712,288	556,207	775,724	619,908	782,267	667,695	978,002	616,332
Хөрөнгийн нийт хуримтлал	1,409,936	2,148,561	2,256,967	2,884,448	1,349,223	1,462,802	1,047,442	1,147,127	1,497,802
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,323,975	1,594,981	1,808,355	1,886,801	1,282,971	1,434,845	1,825,945	1,291,507	1,402,598
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	85,961	553,581	448,612	997,647	66,253	27,957	-778,502	-144,379	95,204
Цэвэр экспорт	-1,034,948	-903,909	-754,728	-1,326,658	-1,573,014	-888,672	-389	373,851	-922,680
Бараа, үйлчилгээний экспорт	3,834,960	4,462,934	5,112,485	4,434,366	2,450,062	4,340,609	5,561,398	5,477,768	4,317,888
Бараа, үйлчилгээний импорт	4,869,908	5,366,842	5,867,214	5,761,024	4,023,075	5,229,281	5,561,787	5,103,917	5,240,568

Эх сурвалж: 1212.mn

ДНБ-ний бууралтад уул уурхайн олборлох болон барилгын салбарын бууралт, үйлчилгээний салбарын агшилт түлхүү нөлөөлсөн болохыг зургаас харж болно. Тухайлбал үйлчилгээний салбарын төлөөлөл болсон аялал жуулчлалын салбар зогсонги байдалд орсоноос болж аялал жуулчлалын салбараас Улаанбаатар хотын ДНБ-ний 1.49-1.51%-тай тэнцүү хэмжээний алдагдал хүлээжээ.³⁵¹ Түүнчлэн үндсэн болон материаллаг эргэлтийн хөрөнгийн багасалт ДНБ-ний өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Зураг 1. ДНБ-ний динамик
GDP



Эх сурвалж: 1212.mn


³⁵¹ КОРОНАВИРУСЫН ХОРИО ЦЭЭРИЙН ҮЕИЙН УЛААНБААТАР ХОТЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НИЙТ АЛДАГДАЛ (joinme.mn)

Хүснэгт 3. Төсвийн орлого, зардал, алдагдал


Ангилал	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Нийт орлого ба тусламжийн дүн	2,433,093	3,115,676	3,107,894	3,279,976	2,224,565	2,134,140	2,958,008	3,085,363	2,876,092
Ирээдүйн өв сан	255,893	360,680	221,795	202,052	144,288	102,175	340,112	327,610	110,928
Тогтворжуулалтын сан	13,775	18,007	37,502	25,313	6,469	5,487	16,734	37,553	137,290
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	2,163,426	2,736,987	2,848,597	3,052,611	2,073,808	2,026,478	2,601,162	2,720,199	2,627,874.10
Татварын орлого	1,971,477	2,474,679	2,565,083	2,737,822	1,912,562	1,830,317	2,347,802	2,411,114	2,401,582
Татварын бус орлого	191,948	262,308	283,514	314,789	161,246	196,161	253,360	309,085	226,292
Нийтлэг татварын бус орлого	186,172	250,197	248,773	291,776	156,906	188,819	181,351	252,685	209,190
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	224	67	156	209	153	254	175	529	285
Тусламжийн орлого	5,553	12,044	34,585	22,804	4,187	7,089	71,834	55,871	16,818
Төсвийн зарлагын ангилал	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,969,076	2,629,311	2,665,987	4,165,018	2,349,798	3,948,501	3,142,424	4,520,065	2,724,147
Урсгал зардал	1,968,527	1,993,781	1,821,197	2,424,189	2,132,591	2,918,169	2,699,059	4,063,903	2,492,059
Хүү	171,101	265,709	190,316	233,856	185,312	239,926	153,512	380,664	132,388
Хөрөнгийн зардал	167,992	468,087	684,229	1,498,076	240,950	987,906	701,451	1,121,348	302,423
ЦЭВЭР ЗЭЭЛ	553	109,318	50,691	242,753	-23,742	42,426	-5,219	24,093	20,704
Төсвийн алдагдал	-194,350	-107,676	-182,610	1,112,407	275,990	1,922,023	541,262	1,799,866	96,273

Эх сурвалж: 1212.mn

Дотоодын нийт бүтээгдэхүүний бууралттай холбоотой нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын дийлэнх хэсгийг эзэлдэг татварын орлого 2020 онд багассан нь нэгдсэн төсвийн орлогын бууралтад гол нөлөө үзүүлжээ. Харин цар тахалтай холбоотой нэгдсэн төсвийн зардал өссөн нь төсвийн нийт зардлыг өсгөхөд нөлөө үзүүлсэн байна. Нэг талаас төсвийн орлого хумигдаж, нөгөө талаас төсвийн зардал өссөн нь төсвийн нийт алдагдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.



Зураг 2. Төсвийн орлого, зардал




Эх сурвалж: 1212.mn

Зураг 3. Засгийн газрын өр


Үзүүлэлтүүд	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Засгийн газрын нийт өр	22,350	22,686	22,694	23,915	24,552	25,940	26,267	27,895	27,333
Засгийн газрын дотоод өр (өрийн хэрэгслээр)	1,534	1,486	1,410	1,400	1,359	1,338	1,318	1,137	1,137
Үнэт цаас	1,534	1,486	1,410	1,400	1,359	1,338	1,318	1,137	1,137
Засгийн газрын гадаад өр1 (өрийн хэрэгслээр)	18,928	19,289	19,306	20,444	21,180	22,698	23,039	24,848	24,390
Үнэт цаас	7,631	7,708	7,736	7,927	8,050	8,187	8,277	8,354	8,354
Зээл	11,296	11,582	11,570	12,516	13,130	14,511	14,763	16,494	16,036
Засгийн газрын өрийн баталгаа	1,085	1,104	1,065	1,076	1,056	1,071	1,050	1,060	964
Барих- шилжүүлэх төрлийн концесс	804	806	913	996	957	833	860	850	842

Эх сурвалж: 1212.mn

Засгийн газрын өр өсөхөд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал шууд нөлөө үзүүлсэн байна.



Зураг 4. Засгийн газрын өр



Эх сурвалж: 1212.mn


Хүснэгт 4. Экспорт, импортын динамик

	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Экспорт	1493.545	2167.3	2007.1	1673.7	905.9	1792.5	2318.7	2429.3	1689.6
Импорт	1111.825	1608.1	1705	1528.6	1018.4	1298.5	1468	1365.8	1395

Эх сурвалж: 1212.mn

2020 оны III улирлаас эрдэс баялгийн бүтээгдэхүүний орлого нэмэгдсэнээр манай улсын экспортын хэмжээ өссөн байхад 2020 онд импортын хэмжээ буурсан нь гадаад худалдааны тэнцлийг ашигтай гаргахад нөлөөлсөн байна.

Зураг 5. Экспорт, импортын хэмжээ



Эх сурвалж: 1212.mn


Хүснэгт 5. Валютын ханш

Валют	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
АНУ-ын доллар, сарын дундаж	2,639	2,645	2,667	2,704	2,757	2,799	2,847	2,851	2,850
Евро, сарын дундаж	2,999	2,973	2,965	2,993	3,041	3,081	3,330	3,398	3,436
Рубль, сарын дундаж	40.0	41.0	41.3	42.5	41.7	38.7	38.6	37.3	38.3
Юань, сарын дундаж	391	388	380	384	395	395	412	430	440
Вон, сарын дундаж	2.35	2.26	2.24	2.30	2.31	2.30	2.40	2.55	2.56
Иен, сарын дундаж	24.0	24.1	24.9	24.9	25.3	26.0	26.8	27.3	26.9
Фунт, сарын дундаж	3,438	3,400	3,286	3,481	3,530	3,475	3,679	3,764	3,929

Эх сурвалж: 1212.mn

Гадаад валютын ханш ерөнхийдөө бага зэрэг өсчээ. Энэ нь жил бүр нэмэгдэж буй инфляц, мөнгөний нийлүүлэлтийн өсөлттэй холбоотой байна.

Зураг 6. Гадаад валютын ханш



Эх сурвалж: 1212.mn

Хүснэгт 6. Зээлийн хүү

Зээлийн хүү	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Төгрөгийн	17.13	17.27	17.00	16.90	16.77	16.40	16.23	15.53	15.40
Валютын	10.33	10.17	10.03	9.43	10.23	10.53	10.93	9.80	8.97

Эх сурвалж: 1212.mn

Зээлийн хүү ерөнхийдөө бууралттай байсан байна. Энэ нь зээлийн хүү ерөнхийдөө буурч байгаа, Монгол банкнаас бодлогын хүүг бууруулсан, зээлийн эрэлт багассан зэрэгтэй холбоотой.


Хүснэгт 8. Мөнгөний нийлүүлэлт

Үзүүлэлт	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Мөнгө M2	19,699.60	20,229.4	20,432.9	20,833.8	20,450.8	21,347.5	22,425.9	24,220.0	25,136.0
Мөнгө M1	3,666.60	4,104.5	3,804.3	3,904.2	3,465.2	3,576.6	3,560.5	4,197.4	4,328.0
Төгрөгийн харилцах	3,058	3,451.7	3,216.8	3,289.7	2,894.6	2,884.5	2,876.2	3,444.3	3,588.9
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	608.6	652.7	587.6	614.5	570.7	692.2	684.3	753.2	739.1
Бараг мөнгө	16,032.90	16,124.9	16,628.5	16,929.6	16,985.5	17,770.8	18,865.4	20,022.6	20,807.9
Төгрөгийн хадгаламж	11,147.80	10,936.4	10,780.8	11,119.7	10,720.5	11,053.5	11,643.5	13,398.3	14,171.4
Валютын хадгаламж	2,896.80	2,932.8	2,925.0	3,483.7	3,686.2	4,354.3	5,110.5	4,641.7	4,375.2
Валютын харилцах	1,988.30	2,255.7	2,922.8	2,326.2	2,578.9	2,363.0	2,111.4	1,982.6	2,261.4
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	897.8	937.1	889.8	897.4	847.8	987.3	950.1	991.5	1,006.0

Эх сурвалж: 1212.mn

Төгрөгийн болон валютын харилцах дансны мөнгөний хэмжээ нэмэгдсэн, эсрэгээрээ төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн нэмэгдсэн байна. Нийт дүнгээрээ M2 мөнгөний хэмжээ өссөн байгааг доорх зургаас харах боломжтой.

Зураг 9. Мөнгөний агрегатууд



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Нийгмийн салбарын үзүүлэлтүүд


Хүснэгт 9. Өрхийн орлого, зардал

Өрхийн орлого	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Нэг өрхийн сарын дундаж орлого (Нийт орлогын дүн)	1,260,167	1,356,714	1,390,382	1,375,080	1,508,677	1,484,800	1,512,688	1,424,598	1,450,065
Мөнгөн орлого - Бүгд	1,147,486	1,248,004	1,264,009	1,261,395	1,382,802	1,368,497	1,396,196	1,320,217	1,338,673
Цалин хөлс	615,344	679,265	694,841	685,874	759,606	750,722	774,175	712,925	687,108
Тэтгэвэр, тэтгэмж	216,293	229,225	226,797	230,336	254,525	271,633	304,103	315,432	361,999
Цалин, тэтгэврээс бусад мөнгөн орлого	315,849	339,514	342,371	345,185	368,671	346,142	317,918	291,860	289,566
Бусад орлого	112,681	108,710	126,373	113,685	125,875	116,303	116,492	104,381	111,392
Нэг өрхийн сарын дундаж зарлага	1,336,535	1,410,997	1,450,031	1,444,153	1,564,725	1,542,040	1,531,898	1,456,883	1,459,591

Эх сурвалж: 1212.mn


Өрхийн орлого нэрлэсэн дүнгээрээ ерөнхийдөө өссөн байгаа боловч орлогын тэгш бус байдлын үзүүлэлт болох Жинийн индекс нэмэгдсэн байна. Энэ нь цар тахлаас үүдэлтэйгээр ажилгүй иргэдийн тоо өссөнтэй холбоотой байна. Нөгөө талаас энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүн нэрлэсэн дүнгээрээ төдийлөн багасаагүйтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл мөнгөн агуулгаараа өрхийн орлого өссөн хэдий ч бодит баялгийн үйлдвэрлэл 2020 онд багассан, өргөн хэрэглээний бараа үйлчилгээнээс бусад бараа үйлчилгээний үнэ өссөн зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

Зураг 10. Өрхийн орлого, зардал



Эх сурвалж: 1212.mn

Зураг 11. Жилийн индекс



Эх сурвалж: Gini index worldwide 2020, by country | Statista

Жинийн индекс буурч байвал энэ нь орлогын тэгш бус байдал багасч байгаа болохыг харуулдаг. Тэгвэл 2020 онд орлогын тэгш бус байдал бага зэрэг нэмэгджээ.

Хүснэгт 10. Ажил эрхлэлтийн үзүүлэлт

Бүрэлдэхүүн	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Ажиллагчид буюу хөдөлмөр эрхлэгчид (Улсын хэмжээнд)	1,143,129	1,162,198	1,155,614	1,188,440	1,170,455	1,185,205	1,175,986	1,124,564	1,054,889
Ажиллах хүч	1,331,306	1,345,287	1,358,654	1,296,706	1,293,296	1,282,115	1,293,569	1,273,893	1,253,123
Ажиллагсдын ажиллах хүчинд эзлэх хувь	0.86	0.86	0.85	0.92	0.91	0.92	0.91	0.88	0.84

Эх сурвалж: 1212.mn


Зураг 12. Ажиллагсад



Эх сурвалж: 1212.mn

Дээрх зургаас хөдөлмөр эрхлэгчдийн тоо буурсан байгаа харж болно.

Зураг 13. Ажиллагсдын ажиллах хүчинд эзлэх хувь



Эх сурвалж: 1212.mn

Ажиллагсдын ажиллах хүчинд эзлэх хувь буурсан байна.


Хүснэгт 11. Төрөлт, нас баралт(өссөн дүнгээр)

Эрүүл мэнд	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Мянган хүнд ногдох төрөлт (улсын дүн)	5.6	11.7	17.8	24.3	5.6	11.4	17.2	23.2	5.3
Мянган хүнд ногдох нас баралт (улсын дүн)	1.3	2.6	3.9	5.2	1.2	2.4	3.6	4.8	1.1

Эх сурвалж: 1212.mn

2020 онд 1000 хүнд ногдох төрөлт, нас баралтын тоо үндсэндээ тогтвортой байсан байна.

Зураг 14. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт




Эх сурвалж: 1212.mn

3. ЦАР ТАХЛЫН УЛМААС ГАРСАН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АЛДАГДСАН БОЛОМЖИЙН ЗАРДАЛ

Ковидгүй үеийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн тооцоолол, тайлбар.

ДНБ: Сангийн яам³⁵² болон олон улсын судалгааны байгууллагуудын тооцож гаргасан Монгол Улсын ДНБ-ний 2020 оны прогнозыг ашиглаж тооцов. Олон улсын байгууллагууд манай улсын ДНБ-ний өсөлтийг ковидгүй үед 2020 онд 5.6 хувь хүрэх байсан гэж үзжээ.

Зураг 15.Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл



Эх сурвалж: 1. ДБ, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2018.

2. ОУВС, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв, 2018.

3. АХБ, Азийн хөгжлийн хэтийн төлөв, 2018.

4. АНУ, Хөдөө аж ахуйн яам, Олон улсын макро эдийн засгийн тоон өгөгдлийн сан, 2018.

Эх сурвалж: МУ-ын Дүнд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ ДНБ-ний өсөлтийн таамаглал

Инфляц: Монгол банкнаас инфляцын түвшинг дунд хугацааны зорилтот түвшин буюу 8 хувиас хэтрэхгүй түвшинд байгаа.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого: Төсвийн орлого нь ДНБ-тэй шууд хамааралтай байдаг. 2016-2019 оны улирал бүрийн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувиудын дунджийг тооцож, тооцож гаргасан хувиа ашиглаж жилийн дундаж хувийг олсноор ДНБ-ний 2020 оны хүрэх байсан түвшнээр үржүүлж тооцооллыг хийв.


Төсвийн зардал: Энэ нь ДНБ-тэй хамаарах хамаарлын хувьд төсвийн орлогоос харьцангуй бага байх тул түүнийг цаг хугацааны хүчин зүйлтэй түлхүү холбоотой байх боломжтой гэж үзээд энгийн шугаман регрессийн загварыг ашиглан тодорхойллоо.

Төсвийн алдагдал, засгийн газрын өр: Төсвийн орлогоос давсан зардлыг төсвийн алдагдал гэх бөгөөд үүнийг засгийн газар зээлээр санхүүжүүлдэг. Зээлийн санхүүжилтийг дайчилснаар Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгддэг. Иймд төсвийн зардал болон орлогын зөрүүг тооцож эдгээр хэмжигдэхүүнийг тооцож гаргалаа.

Экспорт, импорт: Эдгээр үзүүлэлтүүдийг цаг хугацааны хүчин зүйлтэй холбож, өмнөх буюу 2019 он хүртэлх цаг хугацааны динамикийн хэв шинж ерөнхийдөө хадгалагдана гэж үзсэнээр тооцоолов.

³⁵² Монгол улсын эдийн засгийн төлөв байдал - САНГИЙН ЯАМ (mof.gov.mn)

Зураг 16. Экспорт, импортын динамик



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Зээлийн хүү: Зээлийн хүү ерөнхийдөө буурах хандлагатай байгаа. Нөгөө талаас 2020 онд эдийн засаг харьцангуй сэргэлттэй, идэвхжилийн түвшин өндөртэй байх тул үүнийг түүхэн цаг хугацааны дундажтай ойролцоо байна гэж үзэв.


Ажил эрхлэлт: Ажил эрхлэлтийн прогнозыг хугацааны цувааны ARMA загварыг ашиглаж хийлээ.

Dependent Variable: EMP
 Method: Least Squares
 Date: 07/09/21 Time: 06:36
 Sample (adjusted): 2016Q1 2019Q4
 Included observations: 16 after adjustments

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	1112958.	23887.20	46.59221	0.0000
@TREND	32381.23	7939.231	4.078636	0.0015
(@TREND+1)^2	-1707.738	452.9480	-3.770275	0.0027
@SEAS(1)	-58817.90	20122.61	-2.922976	0.0128
R-squared	0.707731	Mean dependent var	1181439.	
Adjusted R-squared	0.634663	S.D. dependent var	56609.01	
S.E. of regression	34216.23	Akaike info criterion	23.93111	
Sum squared resid	1.40E+10	Schwarz criterion	24.12425	

$$EMP = 1112957.68918 + 32381.234425 * @TREND - 1707.73834015 * (@TREND + 1)^2 - 58817.9002616 * @SEAS(1)$$


Зураг 17. Ажил эрхлэлтийн ARMA загварын онолын болон ажиглалтын утга



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Ажилгүй иргэд: Ажилгүй иргэдийн прогнозыг мөн ARMA загварыг ашиглаж хийсэн бөгөөд энэ нь цаг хугацааны харилцан ялгаатай утгуудын онцлогийг тусгадгаараа давуу талтай.


Зураг 18. Ажилгүйдэл



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

$$UNEPM = 12281.3583038 * @SEAS(1) + [AR(1)=0.986028229202, UNCOND]$$


Зураг 19. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлт



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Өрхийн мөнгөн орлого:

Зураг 20. Өрхийн мөнгөн орлогын график



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Өрхийн мөнгөн орлогын 2020 оны утгыг ковидгүй байх үеийн төсөөллөөр прогнозлон тооцоходоо макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй холбосон болно. Учир нь өрхийн мөнгөн орлого хувь хүн өрх айлд тусгалаа олсон төр, засгийн газрын бодлогын үр нөлөөний цөм болж байдаг.

Өрхийн мөнгөн орлогын макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй хамаарлын ямар түвшинд байгаа болохыг сонирхвол үзүүлэлтүүд хоорондын корреляцийн утга дараах байдалтай байна.

$$NI = 0.000112489043287 * \text{LOG}(M2)$$

Хүснэгт 12. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамаарал

Үзүүлэлт	X	I	GD	NI	GDP	M2
X	1.000000	0.844939	0.751332	0.661262	0.648862	0.781433
I	0.844939	1.000000	0.686588	0.753538	0.659896	0.857707
GD	0.751332	0.686588	1.000000	0.805596	0.554819	0.863523
NI	0.661262	0.753538	0.805596	1.000000	0.358175	0.946717
GDP	0.648862	0.659896	0.554819	0.358175	1.000000	0.528073
M2	0.781433	0.857707	0.863523	0.946717	0.528073	1.000000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгтээс өрхийн мөнгөн орлого мөнгөний нийлүүлэлттэй хамгийн өндөр буюу 0.94 гэсэн утгаар холбогдсон байна.

Тэмдэглэгээ:

X	Экспорт
I	Импорт
GD	Төсвийн алдагдал
NI	Өрхийн мөнгөн орлого
GDP	ДНБ
M2	M2 мөнгөний нийлүүлэлт

Өрхийн орлогыг 2020 оны прогнозын тооцооллыг хийхдээ түүнийг ДНБ-тэй холбож авч үзэх нь онол, практикийн хувьд ач холбогдолтой юм. Ингэж тооцоход үр дүнгийн тэгшитгэл $NI = 0.00011459105818 * \text{LOG}(GDP)$ гэсэн хамаарлаар тодорхойлогдлоо. Хэмжигдэхүүний утгын хувьд өрхийн мөнгөн орлого нь ДНБ болон мөнгөний нийлүүлэлттэй харьцуулахад хавьгүй бага байгаа тул хэмжигдэхүүний зөрүүг арилгахын

тулд өрхийн орлогыг тэрбум төгрөгөд хувааснаас гадна мөнгөний нийлүүлэлт болон ДНБ-ний утгаас натурал логарифм авсан болно. Гаргаж авсан хоёр загвар дээрээ 2020 оны төсөөллөөрх ДНБ-ний утгыг орлуулж, дунджийг нь тооцооноор өрхийн мөнгөн орлогын утга ковидгүй байх үеийн түвшинд тодорхойлогдов. Ингээд дээрх тооцооллын үр дүнг нэгтгэвэл нэгтгэл нь дараах хүснэгтэд үзүүлсэн байдалтай байна.

Хүснэгт 13. Эдийн засаг, нийгмийн алдагдсан боломжийн зардлын тооцоолол

Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд	Ковидгүй үед	Ковидтой үед	Зөрүү буюу алдагдсан боломжийн зардал
ДНБ	39,368,568.5	36,958,550.1	2,410,018.42
Инфляц	8.0	2.3	5.70
Тэнцвэржүүлсэн орлого	10,481,740.9	9,421,647.3	1,060,093.61
Төсвийн зардал	13,415,216.0	13,960,787.5	-545,571.50
Төсвийн алдагдал	2,933,475.1	4,539,140.2	-1,605,665.11
Засгийн газрын өр	2,933,475.1	4,539,140.2	-1,605,665.11
Экспорт	23,819,105.0	20,948,882.7	2,870,222.32
Импорт	20,709,412.1	14,490,412.8	6,218,999.26
Валютын ханш	2,821.7	2,813.3	8.43
Зээлийн хүү_төг	16.3	16.2	0.04
Зээлийн хүү_ам.доллар	9.8	10.4	-0.56
Ажиллагчид буюу хөдөлмөр эрхлэгчид (Улсын хэмжээнд)	1,164,052.5	1,162,345.3	1,707.25
Ажилгүй иргэд (Улсын хэмжээнд)	105,699.7	129,104.5	-23,404.78
Өрхийн мөнгөн орлого	1,564,456.8	1,366,928.0	197,528.83

Эх сурвалж: Судлаачийн тооцооллын нэгтгэл

Тооцооллын үр дүнг нэгтгэсэн хүснэгтээс ойролцоогоор ДНБ 2.4 их наяд төгрөгөөр, засгийн газрын өрийн хэмжээ буюу төсвийн алдагдал 1.6 их наяд төгрөгөөр, экспорт 2.8 их наяд төгрөгөөр, импорт 6.2 их наяд төгрөгөөр, хөдөлмөр эрхлэгчдийн тоо 1700-аар одоо байгаа түвшнээс өндөр байх байжээ. Түүнээс гадна ажилгүй иргэдийн тоо 23 мянга орчмоор цөөн, өрхийн дундаж мөнгөн орлого 197.5 мянган төгрөгөөр ахиу байх байсан гэсэн үр дүн гарлаа.

4. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧНЫ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, НӨЛӨӨЛӨЛ

Засгийн газрын зүгээс Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргаа, орлогыг дэмжих, ажлын байрыг хадгалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. (2020.12.25)³⁵³

³⁵³ <https://mof.gov.mn/article/entry/covid-19>

Аж ахуй эрхлэх үйл ажиллагаа нь цар тахлаас болж саатсан, орлого нь 50-иас дээш хувиар буурсан 7.3 мянган ААН-ийн ажлын байрыг нь хадгалснаар 220 мянган ажилтанд нийтдээ 44.2 мянган төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгожээ. Цар тахлын үед төрийн шийдвэрээр үйл ажиллагааг нь зогсоосон, түүнчлэн борлуулалтын орлого нь өмнөх жилийн мөн үеэс 50 болон түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж үлдсэн аж ахуйн нэгжийн ажилтан бүрд сар бүр 200 мянган төгрөгийг 3 сарын хугацаанд олгосон нь өрхийн орлогыг нэмэгдүүлж, ажил олгогч ажилтныхаа ажлын байрыг хадгалахад тодорхой хувь нэмэр болсон байна.

Энэхүү арга хэмжээний үр дүнд: 2020 онд давхардсан тоогоор хувийн хэвшлийн 661 мянган ажлын байрыг хадгалж чадсан байна. НДШ-ийг 2020 оны 4 дүгээр сараас 10 дугаар сар хүртэл нийт 6 сарын хугацаанд бүрэн чөлөөлснөөр 38 мянган аж ахуйн нэгжийн 400 гаруй мянган ажлын байрыг, өөрөөс үл хамаарах шалтгаанаар үйл ажиллагаа нь зогссон болон борлуулалтын орлого нь 50 болон түүнээс дээш хувиар буурсан ААН-ийн ажилтнуудад гурван сарын туршид сар бүр 200 мянган төгрөг олгосноор 221 мянган ажлын байрыг тус тус хадгалан үлдэж чадсан байна.

Бизнесийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

Аж ахуйн нэгжүүд 2020 онд нийт 783 тэрбум төгрөгийн татвар, НДШ болон тэдгээрт ногдуулсан алданги, торгуулиас чөлөөлөгдсөн байна. Энэ хэмжээний мөнгөөр хувийн хэвшилд 52.2 мянган хүний нэг жилийн цалинг олгох боломжтой.

- ✓ Ажил олгогчийн төлөх НДШ-ийг 2020 оны 4-10 сар хүртэл зургаан сарын турш “тэглэх” болон оны үлдсэн гурван сард 5 хувь болгож хөнгөлөх шийдвэр гаргаснаар 38.6 мянган аж ахуйн нэгж 641.1 тэрбум төгрөгийг, жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой 104.4 мянган ААН-ийг орлогын албан татвараас 9 сарын хугацаанд чөлөөлснөөр 78.9 тэрбум төгрөгийг, түүнчлэн хуульд заасан хугацаанд тайлагнасан боловч төлж чадаагүй татвар, НДШ-ийн алданги, торгуулиас давхардсан тоогоор 462 мянган ААН-ийг 7 сарын хугацаанд чөлөөлснөөр 62.6 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжүүд өөртөө авч үлджээ.
- ✓ Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн түрээсийн төлбөрийн дарамт цар тахлын үед 18.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлжээ.

Энэхүү арга хэмжээний үр дүнд: 2020 онд 3.4 мянган түрээслэгчийн түрээс 18.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Мөн зарим төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүнд ногдуулах татварыг чөлөөлсөн нь хүнсний хангамжийг тогтворжуулах, хомсдол бий болохоос сэргийлэхэд эерэгээр нөлөөлсөн. 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл 15.0 мянган тонн элит үрийн улаан буудай, дотоодын гурилын үйлдвэрлэлд шаардагдах 160.0 мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тосыг 24.3 тэрбум төгрөгийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Түүнчлэн бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөөд байна.

Иргэд, ААН-үүдийг дэмжсэн арга хэмжээ

хугацаанд 870 гаруй мянган айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөхөөр шийдвэрлээсэн.

- ✓ Цахилгаан, дулааны эрчим хүчний төлбөрт 477.2 тэрбум төгрөг;
- ✓ Усны төлбөрт 108.2 тэрбум төгрөг;
- ✓ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрт 26.6 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

Түүнчлэн 2020 оны байдлаар 220 аж ахуйн нэгж, 99 иргэний импортолсон эм, эмнэлгийн хэрэгслийг 15 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн байна. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл Коронавируст халдвар /Ковид-19/-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр болсон.

5. ЦАР ТАХЛЫН ҮЕД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧНЫ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

1.Төсвийн болон мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм (2020.11.24-ний өдрийн байдлаар).³⁵⁴

ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Бодлогын хүүг 6 хувь болгож, 5 нэгж хувиар бууруулсан: 2020 он гарснаас хойш Мөнгөний бодлогын хорооны ээлжит болон ээлжит бус хурлын шийдвэрээр бодлогын хүүг нийт 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэв. Бодлогын хүүг бууруулах шийдвэр нь инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ юм.

Төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 4.5 нэгж хувиар бууруулсан: Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11 болон 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тогтоолоор төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг нийт 4.5 нэгж хувиар бууруулж, 6.0 хувь байхаар шийдвэрлэв. Энэхүү бодлогын арга хэмжээ нь 1) банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулж, үндэсний валютаар эх үүсвэр татахыг дэмжих, 2) банкуудын зээлд гаргах боломжтой эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах, улмаар эдийн засаг дахь санхүүгийн зуучлалыг дэмжих зорилготой.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад валютын своп хэлцлийг тогтмол хийж байна: Банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг зорилгоор Монголбанк төгрөг-ам.долларын своп хэлцлийг банкуудтай тогтмол хийж байна. Монголбанк оны эхнээс богино хугацаат репо санхүүжилтээр оны эхний 9 сарын байдлаар 2.4 их наяд төгрөг, гадаад валютын своп хэлцлээр 1.7 их наяд төгрөгийн нөөцийг банк хоорондын захад нийлүүлээд байна.

³⁵⁴ <https://www.mongolbank.mn/news.aspx?id=2663&tid=1>
<https://www.mongolbank.mn/news.aspx?tid=9>

Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацааны өөрчлөлт оруулсан: КОВИД-19 вирусийн тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч байгаатай холбогдуулан Монголбанкнаас дараах журмуудын тодорхой зохицуулалтыг доорх нөхцөлтэйгөөр түр хугацаагаар буюу 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл мөрдүүлэхээр шийдвэрлэв. Энэхүү зохицуулалтын хүрээнд 10-р сарын 1-ний байдлаар 3.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгдсэний 2.2 их наяд төгрөг нь бизнесийн зээл байна. Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу түр хугацаагаар мөрдүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэсэн.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг бууруулсан: Ковид-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк санаачлан 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг 20-100 хувь бууруулахаар болов. Энэхүү шийдвэр нь иргэдийг цахимаар төлбөр тооцоогоо гүйцэтгэхийг идэвхжүүлэх зорилготой. Нийлбэр дүнгээрээ 4 сарын 1-ээс 10-р сарын 1-ний хооронд 33 сая удаагийн гүйлгээгээр 1.46 тэрбум төгрөгийн банк хоорондын төлбөр, тооцооны шимтгэл хураамжийг хэрэглэгчдээс аваагүй чөлөөлөөд байна.

Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг сунгасан: Мөнгөний бодлогын хорооны ээлжит болон ээлжит бус хурлуудын шийдвэрээр эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргасан. Энэхүү арга хэмжээ нь 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл зээлдэгчдийн зээлийн сарын төлбөрийн дарамт буурч гар дээр үлдэх орлого нэмэгдсэнээр хувийн хэрэглээг урамшуулах, улмаар үүсээд буй өнөөгийн хүндрэлийг зөөлрүүлэх, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх нөлөөтэй юм. Энэ хүрээнд 10-р сарын 1-ний өдрийн байдлаар 1.5 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна.

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг түр хугацаагаар хойшлуулсан: Зээлдэгчийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгоод байгаа билээ. 10-р сарын 1-ний өдрийн байдлаар нийт 38,152 зээлдэгчийн 2.0 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг 6 сарын хугацаатайгаар хойшлуулсан.

Монголбанкнаас банкинд олгох барьцаат зээлийн журамд түр өөрчлөлт оруулсан: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 20¹ дүгээр зүйлийн 1 дэх заалтад Монголбанк банкны системийн эцсийн зээлдүүлэгчийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нь түр хугацааны хүндрэл үүссэн, өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг хүндрэлээс гарч, зээлийг хугацаанд нь эргэн төлөх боломжтой, төлбөрийн чадвартай банканд тодорхой нөхцөлийн дагуу барьцаатай зээл олгож болно хэмээн заасан байдаг. Засгийн газрын үнэт цаасны анхдагч захын арилжаа зогссон, Төв банкны үнэт цаасны төвлөрөл өндөр байгаа өнөөгийн нөхцөлд Ковид-19 вирусийн хурдацтай тархалтаас үүдэн эдийн засагт үүсэж болзошгүй аливаа эрсдэлээс сэргийлэх, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк барьцаат зээлийн журамд 2020 оны 7 сарын 31-ний өдөр хүртэл түр хугацааны өөрчлөлт орууллаа.

Үүнд:

- Барьцаат зээлийн хугацааг 90 хүртэл хоног байсныг 180 хүртэл хоногийн хугацаатай болгож өөрчлөв.
- Барьцаат зээлийн хүүг 16 хувь байсныг 11 хувь болгон бууруулав.
- Барьцаа хөрөнгийн жагсаалтыг өргөтгөлөө.

ОУВС-аас Монгол Улсыг “Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр”-т хамруул сан: Дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, төсөв болон төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран ОУВС-гийн шуурхай санхүүжилтийн хөтөлбөр (RFI)-т хамрагдаж, 99 сая ам.долларын санхүүжилтийг аваад байна. Монгол Улс ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд үүнийг дүгнэж “Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр”-т шилжээд байна.

Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихээр шийдвэрлэсэн: МБХ-ны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлаар жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргасан билээ. Улмаар МБХ-ны 12-р сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрээр жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 1-р улиралд 250 хүртэлх тэрбум төгрөгийг олгохоор тогтлоо.

Монгол Улсын Их Хурлаас “Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Тус хуульд банкны сектортой холбоотой дараах заалтууд хэрэгжиж эхэлсэн. Үүнд:

Банкны харилцах дансанд хүү тооцохгүй: 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон харилцах дансны үлдэгдэлд хүү тооцохгүй. Өөрөөр хэлбэл, банкнаас харилцагчид үзүүлж байгаа төлбөрийн үйлчилгээний гэрээ, хэлцэл нь уг хуульд нийцсэн байх шаардлагыг хангаж, хүчин төгөлдөр бус болох эрсдэлээс сэргийлэх шаардлагатай юм. Энэхүү арга хэмжээг харилцах дансыг хугацаагүй хадгаламжид хөрвүүлэхээс зайлсхийж, банкууд харилцан ойлголцож, нэгдсэн стандарт мөрдүүлэн хэрэгжүүлнэ.

Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй: хууль хэрэгжих хугацаанд гадаад валютын хадгаламж нь хадгаламжийн даатгалд хамаарахгүй буюу даатгалын тохиолдол бий болоход нөхөн төлбөр төлөхгүй. Харин Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйл хүчин төгөлдөр үйлчилж байгаа тул гадаад валютын хадгаламж нь хадгаламжийн даатгалын хураамжаас чөлөөлөгдөхгүй.

Иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх, гадаад валютын харилцах, хадгаламжийг зээлийн барьцаа болгохгүй: Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно. Түүнчлэн, гадаад валютын харилцах, хадгаламжийг зээлийн барьцаа болгохгүй байх нь валютын зах дээрх спекуляци эрэлтийг бууруулж, үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглээг дэмжинэ.


Монголбанкнаас банк, санхүүгийн салбарт Ковид-19 цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай арга хэмжээг дэлхийн улс орнуудын туршлага, банкны болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлж ирлээ. Энэхүү арга хэмжээний

хүрээнд банкууд нийт 181,783 зээлдэгчийн 5.3 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөх нөхцөлд өөрчлөлт оруулаад байна.

Ингэснээр банкуудад зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг нээлттэй үлдээлээ. Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг /90 хоног болгосон байгааг/ 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицуулсан байна.

2.Хөрөнгийн зах зээлийн тойм

Зураг 21. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: СЗХ

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ өнгөрсөн онтой харьцуулахад 12.5 хувиар өсөж 3,029.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин хувьцааны хөрвөх чадвар 3.2 нэгжээр буурч 1.8 хувьд хүрчээ.³⁵⁵ Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2020 онд буураагүй нь дийлэнх томоохон хувьцаат компаниуд борлуулалтын орлогоо жигд тогтвортой байлгаж чадсантай холбоотой. Харин цар тахлаас үүдэлтэйгээр хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх буюу хөрвөх чадвар суларсан байна. Цар тахлын үед СЗХ-ноос хөрөнгийн зах зээлтэй холбоотойгоор зохицуулалтын дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна.

1. Монголын хөрөнгийн биржийн арилжаа цахим горимоор хэвийн явагдаж байна. 2021.01.01-2021.05.20-ны өдрүүдэд нийт 616.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд энэ нь өмнөх мөн үетэй харьцуулахад 41.15 дахин өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгох чиглэлээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 347.7 тэрбум төгрөгийн бондын арилжаа голчлон нөлөөлсөн байна.

³⁵⁵ <http://www.frc.mn/>

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-ийн үүсгэн байгуулсан “НОСК нэг” ХХК-д түрээсийн орлогоор баталгаажсан буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгох, 15 жил хүртэл хугацаатай орон сууцны түрээсээр баталгаажсан *34.4 тэрбум төгрөгийн* үнийн дүн бүхий 343,580 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн бол СЗХ-ны 12 дугаар сарын хурлаар “НОСК хоёр” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож тус компанийн 447 иргэнд олгосон түрээслээд өмчлөх орон сууцны зээлийг багцалсан *39.6 тэрбум төгрөгийн* хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 2021 оны 02 дугаар сард бүртгэсэн.
3. Бондын зах зээлийн зохицуулалтын орчныг шинэчлэн сайжруулахтай холбоотойгоор хаалттай бондыг арилжаалах зах зээлийн зохицуулалтыг бий болгон, энэхүү зах зээлийг ил тод болгох чиглэлээр “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, батлуулав. Ингэснээр компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах эрх зүйн орчин бүрдэж, үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэхээс гадна хөрөнгө оруулагчийн зүгээс хаалттай өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл үүсэх, үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах, мэдээллийн ил тод байдал хангагдах зэрэг чухал ач холбогдолтой юм. Мөн нийтэд санал болгон гаргах үнэт цаасны шаардлага, шалгуурыг хангахад хүндрэлтэй байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох таатай нөхцөл бүрдсэн.
4. Зах зээлийн арилжаанд оролцоход гарах хэлцлийн зардлыг бууруулах, арилжаа хийгдэх шат дамжлагыг багасгах чиглэлээр дэд бүтцийн байгууллагуудад чиглэл өгөх, холбогдох дүрэм, журамд орсон өөрчлөлтүүдийг батламжлах ажлууд хийж байна. Үүний үр дүнд анхдагч, хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөрийн шимтгэл тус тус 0.24 хувь байсныг 50 хувиар бууруулж, тус тус 0.12 хувь болгосон.
5. Санхүүгийн зохицуулах хорооноос бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хүрээнд дараах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүдэд тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмуудад санал өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - ✓ 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 937 дугаар тогтоолоор “МУЦСК” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл
 - ✓ “Үнэт цаас санхүүжилтийн корпорац” ХХК-д 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 882 дугаар хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.
6. Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 758 дугаар тогтоолоор “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол улсад үнэт цаас гаргах, Монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-д хоёр биржийн хооронд иргэн, ААН өөрийн эзэмшлийн хувьцааг чөлөөтэй хөрвүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, дэд бүтцийн шийдэл, оролцогчдын эрх ашиг хамгаалагдах гэрээний харилцааг бий болгосон. Чөлөөтэй хөрвөх нөхцөл бүрдсэнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй 263,885,433 ширхэг хувьцааг бүртгэж, тухайн компанийн хувьцааг эзэмшиж буй Канад болон Монгол Улсын иргэн, ААН өөрсдийн эзэмшлийн хувьцааг хоёр биржийн хооронд чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах нөхцөлийг бүрдүүлсэн.

7. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхижүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгох чиглэлээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь дотоодын үнэт цаасны зах зээлд өрийн хэрэгсэл гаргахаар тусгагдсан. Үүний дагуу тус компаниас ирүүлсэн хүсэлтийг хянан Хорооны 2021 оны 96 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн олон нийтэд нээлттэй санал болгон гаргаж буй төгрөгийн болон ам.долларын хосолсон нийт 2.0 их наяд төгрөг бүхий өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, анхдагч зах зээлд арилжаалах зөвшөөрлийг олгосон.
8. Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийтэд санал болгож буй өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021.03.30-2021.04.09 өдрүүдэд амжилттай зохион байгуулж, нийт 973 хөрөнгө оруулагчдаас 347.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

3. Даатгалын зах зээлийн тойм (2021.05.20-ны өдрийн байдлаар):

1. Коронавирустэй холбогдох даатгалын 5 шинэ бүтээгдэхүүн Хороонд бүртгэгдэж, зах зээлд нэвтэрсэн бөгөөд нийт 17.3 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалд 14758 иргэн, албан хаагч (богино хугацааны үнэ төлбөргүй даатгалд хамрагдсан 84.0 мянга орчим иргэнийг оруулаагүй дүн) хамрагдаж, 609.5 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрсөн ба 181 даатгалын тохиолдолд 207.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон байна. Үүнд:
 - ✓ “Нэйшнл лайф даатгал” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд халдварын өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах зорилго бүхий 6 сарын хугацаатай “Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ыг гаргасан ба уг даатгалд 1527 төрийн албан хаагч хамрагдсан байна.
 - ✓ “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн иргэдийн амь нас, эрүүл мэндийн хамгаалалт бүхий “Ковид-19” эрүүл мэндийн даатгалын нийт үнэлгээ 5.9 тэрбум төгрөгт, даатгуулагчийн тоо 4476-д тус тус хүрч, 169.9 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрсөн ба 61 даатгалын тохиолдол гарч, 67 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.
 - ✓ “Мандал даатгал” ХК-ийн Ковид-19 өвчний халдвар авч, тусгаарлагдсаны улмаас орлого тасалдах эрсдэлийг хамгаалах зорилго бүхий “Ковид-19” хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнд төр, хувийн хэвшлийн 32 байгууллагын 4393 ажилтан, 683 хувь хүн, нийт 5076 иргэн даатгуулаад байгаа бөгөөд даатгалын үнэлгээ 6.2 тэрбум төгрөгт хүрч, 201.1 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрч, 100 даатгалын тохиолдолд 123.0 сая төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон байна. (Тус компани өөрийн харилцагч 82,000 даатгуулагчийг уг даатгалд 2020 оны 9-р сарыг дуусталх хугацаанд үнэ төлбөргүй хамруулсан байна.)
 - ✓ “Ард даатгал” ХК-ийн зайлшгүй ажиллах шаардлагатай, эрсдэлтэй нөхцөл байдалд ажиллаж байгаа ажилтнуудад зориулсан “Ковид-19, ажилтны нөхөн олговрын даатгал”-д төрийн өмчит болон хувийн хэвшлийн 20 байгууллагын 4947 ажилтан, албан хаагчид хамрагдсан ба нийт 4.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын гэрээг байгуулагдаж, 227.0 сая

төгрөгийн даатгалын хураамж төвлөрч, 17 даатгалын тохиолдолд 12.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон байна.

- ✓ “Миг даатгал” ХХК-ийн Ковид-19 өвчний халдвар авах, уг өвчний улмаас нас барсан тохиолдолд нөхөн төлбөр олгох “Вакцин даатгал”-д нийт 259 иргэн хамрагдсан ба нийт 1.0 тэрбум төгрөгийн даатгалын хамгаалалтын (үнэлгээ) хүрээнд тус компани 11.5 сая төгрөгийн хураамж төвлөрүүлж, 3 даатгалын тохиолдолд 5.0 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

2. Хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчдод тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн шинэчилсэн найруулгад бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах зохицуулалтуудыг тусгасан бөгөөд зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн бүртгэл, зөвшөөрлийн хүсэлтүүдийг цахимаар шийдвэрлэн ажиллаж байна. Даатгалын компаниуд даатгалын нөхөн төлбөрийн материалыг цахимаар бүрдүүлэн авах болон даатгалын гэрээ байгуулахдаа цахимаар болон аливаа дэвшилтэд технологи ашиглан хийж хэвшээд байна.

3. *Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор үүсэн нөхцөл байдал:* 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд даатгалын компанийн хувьд нийтдээ 21,906 даатгалын тохиолдол бүртгэж, 17,605 тохиолдлын 14,449.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бол одоогоор 4,231 даатгалын тохиолдол шийдвэрлэгдээгүй байна. Үүнийг даатгалын төрөл, хэлбэрээр ялгаж гаргавал дараах байдалтай байна.

а. Урт хугацааны даатгагчийн хувьд 617 тохиолдолд 346.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бол Давхар даатгагчийн хувьд даатгалын тохиолдол гараагүй;

б. Ердийн даатгалын компаниудын хувьд дээрх хугацаанд Гэнэтийн осол, эмчилгээний даатгалын 7,445 тохиолдол бүртгэгдэж 5,361 тохиолдолд 2,837.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг, Жолоочийн хариуцлагын даатгалын 6,710 тохиолдол бүртгэгдэж, 5,625 тохиолдолд 4,929.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг, Тээврийн хэрэгслийн даатгалын 5,297 тохиолдол бүртгэгдэж, 4,359 тохиолдолд 4,914.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг, Хөрөнгийн даатгалын 916 тохиолдол бүртгэгдэж, 809 тохиолдолд 1,076.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг, Хариуцлагын даатгалын 705 тохиолдол бүртгэгдэж, 657 тохиолдолд 281.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг, Ачааны даатгалын 49 тохиолдол бүртгэгдэж 44 тохиолдолд 61.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг, Зээлийн даатгалын 89 тохиолдол бүртгэгдэж, 55 тохиолдолд 394.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгоод байна.

Сүүлийн 5 жилийн даатгалын хураамжийн дундаж өсөлт 12.8 хувь байгаа бөгөөд цар тахалтай холбоотойгоор 2020 онд нийт хураамжийн өсөлт 2.5 хувь болж буурчээ.³⁵⁶ Даатгалын салбарын хөрөнгө, орлогын үзүүлэлтүүдийн өсөлтийн хувь буурсан хэдий ч нэрлэсэн дүн өсөлттэй гарсан байгаа нь даатгалын хураамжийн орлогын нэлээд хэсгийг заавал даатгуулах даатгал буюу жолоочийн хариуцлагын даатгал, жил тутам тоо нь нэмэгдэж байгаа авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамж эзэлж байгаатай холбоотой.

³⁵⁶ [2020 q4 negtgel.pdf \(frc.mn\)](#)

4.Банк бус санхүүгийн байгууллагын салбарын тойм (2021.05.20-ны өдрийн байдлаар):

1. Цар тахалтай холбогдуулан эдийн засгийн байдал хүндэрч, иргэд аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа доголдсонтой холбогдуулан иргэдийг чанаргүй зээлийн ангилалд шилжүүлэхээс урьдчилан сэргийлж ББСБ-уудад мөрдөгдөж буй “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, үйлчлэлийн хугацааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан. Ингэснээр 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй активын хэмжээ 14.3% байснаас 26.0% болж 164.8 тэрбум төгрөгийн зээлийн ангилал огцом буурахаар байсан тул салбарын эрсдэлийг бууруулах, зээлдэгчдийн зээлийн ангилал муудахаас сэргийлсэн чухал бодлогын шийдвэр болсон.
2. УИХ-ын 2020 оны Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай 32 дугаар тогтоолын дагуу Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 352 дугаар тогтоол, 2021 оны 65 дугаар тогтоолоор тус тус “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, журам”-д зохицуулалтын өөрчлөлтүүдийг оруулж 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөж ажиллаж байна. 2021 оны 4 дүгээр сарын 29-ний байдлаар нийт 51 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд 7.6 тэрбум төгрөгийн батлан даалттай 15.7 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна. Үүнээс 17 зээлдэгчийн 2.6 тэрбум төгрөгийн батлан даалттай 5.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна.
3. Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд цар тахалтай холбогдуулан ББСБ-уудын зээлийн эргэн төлөлт удааширч, үйл ажиллагаа нь доголдож хүндрэл үүссэнтэй холбогдуулан ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг 2022-2023 он хүртэл хойшлуулахаар шийдвэрлэсэн. Тухайлбал, 2021.02.10-ны дотор Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.9 тэрбум төгрөгт хүргэх байсныг 2022 оны 2 дугаар сарын 10 хүртэл, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор 2.5 тэрбум төгрөгт хүргэхээр шийдвэрлэлээ.
4. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн 7/1515 тоот албан бичгийн дагуу ББСБ-аас авсан зээл, хүүгийн төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй нөхцөл байдал үүссэн зээлдэгчийн зээлийн гэрээний хугацааг сунгасан, зээл, хүүгийн төлбөрийн нөхцөлд өөрчлөлт оруулсан болон бусад холбогдох мэдээллийг сар бүр тогтмол ирүүлж байна. 2021 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 307.7 мянган зээлдэгч 367.3 тэрбум төгрөгийн зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд 303 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 303.9 мянган зээлдэгчийн 333.3 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгасан байна.
5. Зээлийн батлан даалтын сан нь 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-

ний хүрээнд “Ажлын байрыг дэмжих зээл” зориулалтаар 77 зээлдэгчийн 21.6 тэрбум төгрөгийн зээлд 10.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

6. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн эх үүсвэр ББСБ-ын салбарт аливаа хэлбэрээр ББСБ-уудын эх үүсвэрт байршихаас сэргийлж “ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих түр журам”-ыг баталсан.

5.Хадгаламж, зээлийн хоршооны салбарын тойм (2021.05.20-ны өдрийн байдлаар):

1. “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нэмэлт оруулж, улмаар 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн. 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 154 ХЗХ-ноос судалгааг бөглөж ирүүлсэн бөгөөд нийт 11,617 зээлдэгч 46.5 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн гэж мэдээллэсэн ба үүнээс 7,535 зээлдэгчийн 24.3 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.
2. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулж 2020 оны 4 дүгээр улирлын байдлаарх тусгай зөвшөөрөлтэй 249 ХЗХ-ны 72,000 гаруй гишүүдийн бүртгэлийг цахимжуулах ажлыг эхлүүлсэн. 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар Зөвшөөрлийн цахим системд 99 ХЗХ-ны 18,000 гаруй гишүүдийн мэдээллийг бүртгээд байна.
3. Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллаж улсын бүртгэлд бүртгүүлсэн боловч тусгай зөвшөөрөл авахаар Хороонд хандаагүй, хандсан боловч нөхцөл шаардлага хангаагүйн улмаас тусгай зөвшөөрөл олгоогүй, эсхүл тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон 285 ХЗХ-ны бүртгэлийг хүчингүй болгосон.

ББСБ-ын статистик үзүүлэлтүүд


2021 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 17,339 хувь нийлүүлэгчдийн 530 ББСБ, 298 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, давхардсан тоогоор 3,481,431 харилцагч, 610,068 зээлдэгчид хүрч үйлчилж байна. Нийт *харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 58.0 хувиар өсөж* 3,481,431-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 43,3 хувиар өсөж 610,068-д хүрлээ. Энэ нь 1 ББСБ-ын харилцагчдийн тоо өмнөх оны мөн үеэс 4.4 дахин, оны эхнээс 6.4 дахин огцом өссөнтэй холбоотой.

Нийт харилцагчдын 93.1% буюу 3,241,570 нь, зээлдэгчдийн 70.2% буюу 428,002 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 6.9% буюу 239,861, зээлдэгчдийн 29.8% буюу 182,066 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 12,072 буюу нийт харилцагчдын 0.3 хувийг бүрдүүлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.8% буюу 150.2 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны I улирлын байдлаар 1,422.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 112.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,309.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 85.5 хувийг буюу 1,216.3 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 4.1 хувийг буюу 59.0 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 10.3 хувийг буюу 146.7 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр буурсан бол хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.2, 2.0 пунктээр тус тус өссөн байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 205.7 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 54.6%-д буюу 112.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ 2020 оны жилийн эцэст өнгөрсөн оны мөн үеэс 2.06 пунктээр өссөн бол 2021 оны I улирлын байдлаар 2020 оны жилийн эцсээс 0.04 пунктээр буурч 11.2 хувьд хүрэв.

Зураг 22. ББСБ-ын чанаргүй зээл



Эх сурвалж: ҮСХ, СЗХ

ХЗХ-ны статистик үзүүлэлтүүд

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 278,934,885.48 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувь буюу 49,400,139.63 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.7 хувьтай тэнцэж байна.


Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.1 хувь буюу 19,125,826.71 мянган төгрөгөөр өсөж 192,066,061.51 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,097,002.88 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 186,969,058.63 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувь буюу 448,371.85 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ- д нийт 126,185,391.48 мянган төгрөгийн зээл олгож, 101,692,341.05 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 192,066,061.51 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 72.8 хувь буюу 139,828,542.67 мянган төгрөгийг бусад, 8.8 хувь буюу 16,890,374.09 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 3.2 хувь буюу 6,145,518.46 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 5.8 хувь буюу 10,142,030.03 мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 2.2 хувь буюу 4,291,057.10 мянган төгрөгийн барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 8.0 хувь буюу 15,290,559.26 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.5 хувь буюу 179,521,742.67 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.9 хувь буюу 5,557,412.65 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.6 хувь буюу 6,986,906.18 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. 2021 оны 1 дүгээр улиралд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,544,318.84 мянган төгрөгийн үлдэгдэлд 40.6 хувь буюу 5,097,002.88 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

2021 оны 1 дүгээр улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 пунктээр өсөж 93.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.6 пунктээр буурч 2.9 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.7 пунктээр буурч 3.74 хувьд хүрсэн байна.

Зураг 23. ХЗХ-ны чанаргүй зээл



Эх сурвалж: ҮСХ, СЗХ


Банкуудын зээлийн статистик үзүүлэлтүүд (2021 оны 5 дугаар сарын байдлаар)

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өсч 18.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Тодруулбал өмнөх оны мөн үеэс хувийн байгууллагын зээл 4.6 хувиар өсч 8.5 их наяд төгрөгт, иргэдийн зээл 4.0 хувиар өсч 9.0 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн үлдэгдлийн 1.8 их наяд төгрөг буюу 10.0 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.

Өмнөх сартай харьцуулахад зээлийн үлдэгдэл 580.0 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар өсч, хувийн байгууллагын зээл 4.3 хувь, иргэдийн зээл 2.5 хувиар тус тус өсчээ. Харин банкуудаас МИК ОССК-д шилжүүлсэн иргэдийн ипотекийн зээлийг нэмж тооцвол нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, өмнөх сараас 2.7 хувиар нэмэгдсэн байна. Чанаргүй зээлийн 73.3 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 79.0 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл 2,016.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 30.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 10.9 хувь нь гадаад валютын зээл байна. Чанаргүй зээлийн 20.3 хувийг уул уурхай, 19.1 хувийг боловсруулах, 15.4 хувийг барилга, 10.1 хувийг үл хөдлөх, 7.9 хувийг цалин, тэтгэврийн зээл тус тус эзэлж байна.

Чанаргүй зээлийн хэмжээ 2021 оны I улирлын байдлаар 2020 оны жилийн эцсээс 0.04 пунктээр буурч 18.46 хувьд хүрэв.

Зураг 24. Арилжааны банкны чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 15. ХЗХ-ны үзүүлэлт

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, улирал бүрийн эцэст

Хадгаламж зээлийн хоршоодын үндсэн үзүүлэлт	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
Мөнгөн хөрөнгө	45220.9	45371.3	46383.3	57607.6	47228.3	59495	52971.4	77670.1	73619.9
Зээлийн өрийн үлдэгдэл	152782.9	151874.2	158215.9	152188.6	167970.2	160128.1	171180.1	162563.2	186969.1
Үүнээс: чанаргүй зээл	6047.6	6415.5	6186.8	6152.1	7410.3	7112.9	7277.7	7362.7	6986.9
Бусад актив	10086.9	9806.5	10178.2	8321.9	9837.7	14816.7	10129.8	15741.6	18345.9
Нийт актив	211670	210631.2	218356.9	222616.7	229534.7	234439.8	234281.3	255974.9	278934.9
Хадгаламж	150978.8	148355.6	154420.9	155803.3	159015.8	163394.1	163634.6	182183.8	201351.5
Банк, санхүүгийн байгууллагаас татсан хөрөнгө	14894.9	12547.2	10417.7	9280.1	10754.9	9778.6	9217.5	8940.9	7524.5
Бусад пассив	13500.7	13424.7	13659.1	14665.8	16524.4	15730.6	13954.1	15379	18970
Нийт пассив	179421.8	174327.5	178497.7	179749.2	186313.1	188903.2	186806.2	206503.7	227845.5
Өөрийн хөрөнгө	32248.2	36303.7	39859.2	42867.4	43221.6	45536.5	47475.1	49471.2	51089.4
Үүнээс: Хоршоологчдын өмч болон Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	15875.8	17505.3	17531.5	18014.2	18414.2	18225.4	18283.3	18470	21324
Хуримтлагдсан ашиг	7130.8	9508.5	12725.5	15143.6	13051.5	15110.8	17217.8	16161.8	12114.9
Нийт пассив	211670	210631.2	218356.9	222616.7	229534.7	234439.8	234281.3	255974.9	278934.9
Тайлант хугацааны эцэс дахь хадгаламж, зээлийн хоршоодын тоо	282	275	271	261	254	256	248	249	249
Үүнээс: УБ хотод үйл ажиллагаа эрхэлж буй	178	174	169	164	160	155	150	148	148
Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй	104	101	102	97	94	101	98	101	101
Гишүүдийн тоо	65913	67524	70121	70968	74701	70794	73183	72502	75002
ХЗХ-ны нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	3.96%	4.22%	3.91%	4.04%	4.41%	4.44%	4.25%	4.53%	3.74%

Эх сурвалж: СЗХ

Хүснэгт 16. Арилжааны банкны үндсэн үзүүлэлт

СЕКТОР: ИРГЭД ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ (сая төгрөг)

Үндсэн үзүүлэлт	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
ЗЭЭЛИЙН БҮГД ДҮН /сая төгрөгөөр/	9,070,554	9,382,464	9,277,316	9,266,388	8,477,331	8,673,587	8,759,743	8,531,551	8,852,434
Хугацаандаа байгаа зээл	8,615,494	8,903,344	8,748,272	8,753,382	7,899,458	8,020,839	8,089,781	7,783,624	8,061,019
1 хүртэл жилийн хугацаатай	1,837,752	1,261,196	1,020,799	1,008,658	987,171	935,694	864,865	741,081	976,673
1-5 хүртэл жилийн хугацаатай	4,390,595	5,027,036	5,238,515	5,165,781	4,498,424	4,533,792	4,646,258	4,316,704	4,357,398
5 ба түүнээс дээш жилийн хугацаатай	2,387,147	2,615,113	2,488,958	2,578,943	2,413,864	2,551,354	2,578,658	2,725,839	2,726,947
Хугацаа хэтэрсэн зээл	184,782	179,044	207,624	184,782	212,480	215,878	186,191	250,827	275,935
Хэвийн бус зээл	65,285	64,101	67,810	65,285	78,156	113,592	109,609	102,995	102,548
Эргэлзээтэй зээл	77,301	52,079	74,278	77,301	78,425	95,811	122,672	124,042	120,269
Муу зээл	185,637	183,897	179,332	185,637	208,812	227,467	251,490	270,064	292,664
Нийт чанаргүй зээл	328,224	300,076	321,420	328,224	365,393	436,870	483,771	497,100	515,481
Иргэдэд олгосон нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	2.1%	2.0%	1.9%	2.0%	2.5%	2.6%	2.9%	3.2%	3.3%

Эх сурвалж: СЗХ

Хүснэгт 17. Хувийн байгууллагын зээлийн эцсийн үлдэгдэл (сая төгрөг)

Үндсэн үзүүлэлт	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2020-I	2020-II	2020-III	2020-IV	2021-I
<i>ЗЭЭЛИЙН БҮГД ДҮН /сая төгрөгөөр/</i>	8,063,480.4	8,496,066.3	8,532,133.3	8,489,896.1	8,322,445.2	8,235,770.5	7,983,129.8	7,928,519.3	8,053,272.3
Хэвийн бус зээл	235,125.6	180,759.0	230,777.3	204,240.0	187,636.6	231,890.5	230,249.4	235,296.2	200,816.9
Эргэлзээтэй зээл	501,101.2	358,324.7	329,077.8	344,364.4	269,589.2	263,121.6	234,161.3	220,590.4	219,522.3
Муу зээл	846,124.1	1,061,398.9	1,066,207.3	925,581.7	984,408.9	962,856.9	999,640.2	1,036,774.1	1,065,901.5
Нийт чанаргүй зээл	1,582,350.9	1,600,482.6	1,626,062.4	1,474,186.1	1,441,634.7	1,457,869.0	1,464,050.9	1,492,660.7	1,486,240.7
Хувийн байгууллагад олгосон нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	20%	19%	19%	17%	17%	18%	18%	19%	18%

Эх сурвалж: СЗХ

6. НИЙГМИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, НӨЛӨӨЛӨЛ

Өрхөд чиглэсэн арга хэмжээ

2020 онд иргэдэд үзүүлсэн халамж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ 2.4 их наяд төгрөгт хүрсэн. Энэхүү дэмжлэгийн нийт хэмжээ нь 198 мянган төрийн албан хаагчдын 1.6 жилийн цалин, эсхүл аж ахуйн нэгжийн 156 мянган ажилтны бүтэн жилийн цалингийн сантай тэнцэхээр байгаа аж.

- ✓ Энэ хугацаанд хувийн хэвшилд ажиллаж байгаа 989 мянган ажилтан цалингийн орлогодоо суутгуулах байсан 198.0 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлжээ.
- ✓ Түүнчлэн 570 гаруй мянган даатгуулагч иргэдийн НДШ-д төлөх байсан 566.8 тэрбум төгрөгийг чөлөөлжээ. Ингэснээр нэг ажилтан сард дунджаар 241 мянган төгрөг, зургаан сарын хугацаанд нийт 1,446 мянган төгрөгийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлөх байснаас чөлөөлөгдсөн байна.

Цар тахлын үед өрх, иргэнд чиглэсэн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээнд 2020 онд нийт 1 их наяд 253 тэрбум 200 сая төгрөгийг төсвөөс зарцуулжээ. Үүнд;

- ✓ 1.2 сая хүүхдэд олгох мөнгийг 9 сарын турш 100 мянган төгрөгт хүргэн нэмэгдүүлж сар бүр олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1,060.4 тэрбум төгрөг,
- ✓ 59.3 мянган ахмад, 11 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 8 сарын турш 288 мянган төгрөгт хүргэн нэмэгдүүлж сар бүр олгосон халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 145.6 тэрбум төгрөг,
- ✓ Орлого багатай өрхийн 123.5 мянган том хүн, 118.4 мянган хүүхдэд хэмжээг нь 2 дахин нэмэгдүүлж 5-8 сарын хугацаанд олгосон хүнсний талонд 53.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.


Зорилтот бүлгийн өрх, иргэнд дэмжлэг үзүүлэх чиглэлээр: ХНХЯ улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой хүнсний дэмжлэг зайлшгүй шаардлагатай 43.2 мянган өрхөд хүнсний дэмжлэг, 13.4 мянган өрхөд хүнсний бус дэмжлэгийг үзүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын болон аж ахуйн нэгж байгууллагатай хамтран зохион байгуулсан байна. Мөн Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн нийгмийн халамжийн газар, Тавантолгой түлш ХХК-тай

Дэлхийн банкны судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харвал 2020 оны 12 сард тогтоосон хол хорионы үед ажил эрхлэлт хамгийн бага буюу 37.7 хувьтай байсан байна. Үйлчилгээний салбарын ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшин цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 2021 оны 04 сард 17 хувиар бага байна.

Үйлдвэрлэлийн салбарын ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал 2021 оны 4 сард өмнөх онтой харьцуулахад сэргэсэн хэдий ч цар тахлын өмнөх үеийн түвшиндээ хүрэх болоогүй байна. 2021 оны 04 сарын байдлаар хөдөө аж ахуйн хөдөлмөр эрхлэлтийн түвшин цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 10 хувиар бага байна.

Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны хүн амын нийт боломжит ажиллах хүч³⁵⁹

Зураг 27. Ажиллах хүч



Эх сурвалж: YCX

ӨРХИЙН ОРЛОГО


Олон үзүүлэлт бүхий түүврийн судалгааны үр дүнд 2020 оны 2 дугаар сараас хойш өрхийн сарын дундаж орлогод нэлээдгүй өөрчлөлт гарсан бөгөөд судалгаанд хамрагдсан иргэдийн 57 хувь нь орлого буурсан гэж хариулсан бол 43 хувь нь орлого буураагүй гэж хариулжээ. Сарын дундаж орлого буурсан өрхүүдийн хамгийн өндөр буюу 61 хувь нь цар тахлын үед ажиллах боломжгүй болсон, 21 хувь нь бизнесийн эрэлт буурсан, 10 хувь нь бизнес хаагдсан, 7 хувь нь ажлын цаг багассан, 6 хувь нь өөрийн бизнес хаагдсан, 9 хувь нь бусад шалтгаанаар орлого буурсан хэмээн хариулсан байна.

“Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-ны үр дүнгээр 2020 оны 12 дугаар сараас хойш нөхцөл байдал сайжрах шинж ажиглагдаж байгаа ч өрхийн нийт орлого цар тахлын өмнөх түвшинтэй харьцуулахад бууралттай хэвээр

³⁵⁹https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0400_006V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1&Indicator_select_all=0&IndicatorSingleSelect=_31&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_2021_01_202004_202003_202002_202001_201904_201903_201902_201901&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=columnchart

байна. Цар тахлын өмнөх үетэй харьцуулахад өрхийн орлого нь буурсан гэж хариулсан өрхүүдийн 30 хувь нь орлогынхоо 20-40 хувийг алдсан гэж хариулсан бол үлдсэн 58 хувь нь 40-өөс дээш хувийг алдсан гэж хариулсан байна. 2020 оны 12 сард тогтоосон хөл хорио нь өрхүүдийн хэрэглээний ялгаатай бүлгүүд болон оршин суугаа суурьшлаас үл хамааран орлогын өөрчлөлтөд хүчтэй нөлөөлсөн. Өрхийн бүлгүүдийн хувьд 35-39 хувийнх нь орлого 2020 оны 08 сараас 12 сар хүртэлх хугацаанд буурсан гэж хариулжээ. Дээрх хоёр судалгааны үд дүнгээс үзэхэд Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хол хорионы үед өрхийн орлого буурч эргэн сэргэхдээ удаашралтай байгааг харж болохоор байна.

Зураг 28. Хот хөдөөгийн нийт өрхийн жилийн дундаж орлого³⁶⁰



Эх сурвалж: YCX


НИЙГМИЙН ХАЛАМЖ

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх арга хэмжээнд өрхүүдийн 20 хувь нь хамрагдсан ч энэ чөлөөлөлт нь тухайн өрхүүдэд бодитой дэмжлэг болсон байна.

ЗГ-аас цар тахлын хариу арга хэмжээ болгож 2020 оны 4 сараас хувь хүнийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийт өрхийн бараг тал нь нийгмийн даатгал (сайн дурын эсвэл албан журмын) төлдөг бөгөөд тэдний 20 орчим хувь нь НДШ-ээс чөлөөлөгдөх хөтөлбөрт хамрагдсан байна.

³⁶⁰https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1900_001V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1&HSES1_select_all=0&HSES1SingleSelect=_11&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019_2018&viewtype=columnchart

Зураг 29. Засгийн газраас үзүүлсэн дэмжлэг




Эх сурвалж: Сангийн яам

Олон үзүүлэлт бүхий түүвэр судалгаанд Ковид-19 цар тахлын үед Засгийн газраас хэрэгжүүлсэн дэмжлэгүүдийг хамрагдсан өрхийн хувь, дэмжлэгийн төрөл, хот хөдөөгийн ангилал гэсэн үзүүлэлтүүдээр харуулжээ.

ЭРҮҮЛ МЭНД

Хөл хорионы үе буюу 2020 оны 12 сард эмчилгээ шаардлагатай болсон 3 өрх тутмын 1-ийнх нь хэн нэг гишүүн эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж 12 дугаар сараас сайжирсан ч хот, суурин газрын хувьд хүртээмж удаашралтай байна. Хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж 12 дугаар сараас 4 дүгээр сарын хооронд мэдэгдэхүйц сэргэсэн. Мөн Улаанбаатарт Ковид-19-ийн тархалт огцом нэмэгдсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бага зэрэг өсчээ.

Зураг 30. Коронавирусаар өвчлөгчид 2020 оны 2 сараас 2021 оны 5 сар хүртэл



Эх сурвалж: ЭМЯ

Эмнэлэг, тусгаарлан эмчлэх байрны орны мэдээлэл:

2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 5409 хүн эмнэлэг, тусгаарлан эмчлэх байранд хэвтэн эмчлүүлж байна.

Үүнээс:

- Төрөлжсөн эмнэлэгт – 537
- Ковидын үндсэн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүдэд –3067

- Ковидын халдвартай хөнгөн өвчтөн хэвтүүлэн эмчлэх эмнэлэг, сувилал -1055
- Алслагдсан 3 дүүргийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй – 277
- Тусгаарлан эмчлэх байранд хэвтэн эмчлүүлж буй – 473

Сул орны мэдээ:

- Төрөлжсөн эмнэлгүүдэд сул орны тоо – 28 энгийн, 18 эрчимт
- Ковидын үндсэн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүд – 34 энгийн, 4 эрчимт
- Ковидын халдвартай хөнгөн өвчтөн хэвтүүлэн эмчлэх эмнэлэг, сувилал- 26 энгийн,
- Алслагдсан 3 дүүргийн сул орны тоо – 16 энгийн, 7 эрчимт
- Тусгаарлан эмчлэх байрны сул орны тоо – 149 энгийн

Сүүлийн 24 цагт эмнэлгээс гарсан – 409, хэвтсэн – 476 хүн байна.

Хүснэгт 18. Засгийн газраас Ковид 19 цар тахлын үед хэрэгжүүлсэн нийгмийн даатгал, халамжийн арга хэмжээ (2021оны 4 сарын 1-ний байдлаар)

Нийгмийн даатгал халамжийн арга хэмжээ	2020 он (тэрбум төг)	2021 он (тэрбум төг)	Хэрэгжсэн хугацаа
Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгө олгох	1.060.4	720.0	2020.0401- 2021.07.01 (Сунгах)
НДШ-ийг үе шаттай бууруулах	715.5	218.7	2020.0401- 2021.07.01
Эрчим хүч хог, усны төлбөр төрөөс хариуцах	92.8	557.1	
Нийгмийн халамжийн тэтгэвэрийг 100000-төг өөр нэмэгдүүлэх	144.6	124.4	2021.12.1- 2021.07.01
Татварын алданги, тогуулиас чөлөөлөх	49.0	61.0	2020.0201- 2021.07.01
Бусад хөнгөлөлт чөлөөлөлт	464.5	45.7	2020.02.01- 2021.07.01

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 19.Засгийн газраас Ковид 19-ын үед иргэд аж ахуй нэгжүүдийг дэмжсэн арга хэмжээ

	Арга хэмжээнд багтсан хэрэглэгч (мян)	Мөнгөн дүн (тэрбум төг)	Хэрэгжсэн хугацаа
Айл өрхийн болон зарим ах ахуй нэгж байгууллагын цахилгаан болон дулааны эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцан төлөх	729	477.2	2020.12.01- 2021.07.01
Айл өрхийн болон зарим ах ахуй нэгж байгууллагын цэвэр, бохир уснд төлбөрийг төрөөс хариуцан төлөх	870.8	108.2	2020.12.01- 2021.07.01
Айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөх		26.6	2020.12.01- 2021.07.01

Эх сурвалж: Сангийн яам

Өрхөд чиглэсэн арга хэмжээ

- 989 мянган ажилтныг 198.0 тэрбум төгрөгөөр татвараас, 748.6 мянган даатгуулагчдыг 512.3 тэрбум төгрөгийн НДШ-ээс чөлөөлсөн.
- 1.2 сая хүүхдэд 1064.4 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон.
- Үйл ажиллагаа нь зогссон 7284 ААН-д 220.849 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон.
- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай 119352 хүүхэд, 123935 насанд хүрэгчдэд 44.6 тэрбум төгрөгийн хүнсний талон олгосон.
- Халамжийн тэтгэвэр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 70413 иргэнд 144.6 тэрбум төгрөг олгосон.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- The Tragedy of More Missed Opportunities 2020-0807.pdf
- Influence of CD19, Urugwai.pdf
- Global economic effect of Covid. 2021.6.pdf
- Eхnii 5 sariin tuswiin guitsetgel.pdf
- 2020-04-мон, нүүрсний статистик.pdf
- Bichil business-t uzuuleh nuluu, 2020.pdf
- ШИНЭ КОРОНА ВИРУС (COVID-19)-ИЙН УЛМААС САНХҮҮГИЙН САЛБАРТ үүссэн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ.pdf
- Өрхөд суурилсан судалгаа, 3 дахь шатны үр дүн.pdf
- Төрийн байгуулал судлал сэтгүүл #02, Цар тахал буюу тодорхой бус нөхцөл анхаарах зүйлс.pdf
- Улаанбаатар хот, 2021, 1, 20.pdf
- Цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл.pdf
- Вор-manual.pdf
- Монгол Улсын Сангийн яам (1212.mn)
- Монгол Улсын Сангийн яам (mof.gov.mn)
- Санхүүгийн зохицуулах хороо :: FRC.mn
- Даатгалын салбарын мэдээ, 2021, 5-р сар.pdf
- Монголбанк - Монгол Улсын Төв Банк. (mongolbank.mn)
- Кронувирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа 1-4 (2021)<https://www.worldbank.org/mn/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>
- Олон үзүүлэлт бүхий түүвэр судалгаа 2021
https://www.unicef.org/mongolia/mn/press_release/dissemination-workshop-key-findings-1st-and-2nd-waves
- <https://www.covidmongolia.mn/Default.aspx>
- <https://www.1212.mn/surveymn.aspx>
- <https://www.worldbank.org/mn/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>
- <https://academy.edu.mn/content/pandemics-human-rights-violation-mongolia/>
- [https://www.covidmongolia.mn/pdf/Rapid%20Assessment%20on%20the%20Impact%20of%20COVID-19%20on%20GBV%20Situation%20and%20Response%20\(Mon\).pdf](https://www.covidmongolia.mn/pdf/Rapid%20Assessment%20on%20the%20Impact%20of%20COVID-19%20on%20GBV%20Situation%20and%20Response%20(Mon).pdf)
- <https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/Global%20Education%20Monitoring%20Report%202020%20-%20Inclusion%20and%20education%20-%20All%20means%200all%20%5BMN%20Summary%5D.pdf>
- https://www.forum.mn/res_mat/2021/Corona&Education.pdf
- https://www.forum.mn/res_mat/2020/OSF_COVID-19_2.pdf
- <https://www.worldbank.org/mn/country/mongolia/brief/world-bank-groups-response-to-covid-19-coronavirus-in-mongolia>-Монгол улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Дэлхийн Банк Группээс үзүүлж буй хариу арга хэмжээ
- https://www.savethechildren.mn/uploads/publication/202010/Save_the_Children_RNA_MN_Final.pdf
- https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=covid_economy_2021.01.pdf&ln=Mn
- <https://www.kas.de/documents/268650/0/%D0%A2%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD+%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D0%BB+%D1%81%D1%83%D0%B4%D0%BB%D0%B0%D0%BB+%D1%81%D1%8>

D%D1%82%D0%B3%D2%AF%D2%AF%D0%BB+%2302.pdf/b633ec44-d086-2df3-58df-6526fc5b9f42?version=1.0&t=1611026606882

- https://cdnweb.gosmart.mn/mtSkBHbHIEeYsOPqdHaMAw/iis.admin/%D0%9C%D0%B8%D0%BD%D0%B8%D0%B9%20%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D1%83%D1%83%D0%B4/%D0%A1%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0-%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D-2020_1-IIA_1.pdf
- http://hdc.gov.mn/media/uploads/2020-08/2019-eruul_mendin_uzuulelt_MU_mail.indd_2020_____7__21final.pdf
- [https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=MNG_HF_phonesurvey_R4_mn_Final\(4\).pdf&ln=Mn](https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=MNG_HF_phonesurvey_R4_mn_Final(4).pdf&ln=Mn)
- <http://sdg.gov.mn/>
- https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2100_027V1
- https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L21&type=tables

